

Ли Хонжи

ЖУАНЬ ФАЛУНЬ

轉法輪

(Монгол орчуулга)

# ДАФА

(Лунь Юй)

Дафа бол Бүтээгчийн билэг ухаан билээ. Энэ бол тэнгэр газрыг бүтээсэн, сансар огторгуйг бий болгосон үндсэн суурь. Энэ нь хамгийн бичлийн туйлаас аугаа уудмын туйл хүртэлх бүхнийг багтаасан ба сансрын биетүүдийн янз бүрийн давхаргад өөр өөр байдлаар илэрдэг. Сансрын биетийн хамгийн бичлийн тодорхой нэг гүнээс хамгийн бичил бие бодь анх үүсэж гаран тоо томшгүй олон ширхгүүд болон давхаргаас давхаргад, жижгээс том руу үелэн өссөөр хүн төрөлхтний мэдэх гадаргуун давхаргын атом, молекул, од гаригс, галактик болон түүнээс ч том хэмжээнд хүрдэг. Янз бүрийн хэмжээт бие бодь нь янз бүрийн хэмжээт амь бодь болон уудам сансар огторгуйн биет даяар тархан орших янз бүрийн хэмжээт хорвоо ертөнцийг бүтээдэг. Өөр өөр давхаргын аливаа бие боднуд дээр орших амь боднудын хувьд дараах арай том давхаргын бие боднуд нь тэдний тэнгэрт орших од гаригс нь болдог, давхарга болгоны хувьд ийм байдаг. Орчлон ертөнцийн аль ч давхарга дахь амь боднудын хувьд энэ бол хязгааргүй. Цаг хугацаа, орон зай, амь бодийн үй түмэн хэлбэр, төрөл зүйлийг мөн Дафа бүтээсэн, оршин байгаа аливаа зүйл бүгд үүнд багтана, үүнээс гадуур үлдэх зүйл гэж үгүй. Энэ бол Дафа-гийн Жэнь, Шань, Рэнь мөн чанарын өөр өөр давхарга дахь бодит илрэл юм.

Хүн төрөлхтний орчлон ертөнц ба амь бодийг судлах арга хэдий хөгжсөн ч, танин мэдсэн нь доод давхаргын орчлон ертөнцөд оршин буй хүмүүний энэхүү орон зайн тодорхой хэсэгт л хязгаарлагддаг. Түүхийн өмнөх үеийн хүн төрөлхтний бий болгосон

олон удаагийн соёл иргэншлийн үеүдэд бусад од гаригсыг судалдаг байсан. Гэвч тэд хэднй өндөрт нисэж, хэр хол явсан ч хүмүүний орших орон зайнаас хэзээ ч гарч чадаагүй. Хүн төрөлхтөн хэзээ ч орчлон ертөнцийн үнэн байдлыг жинхэнэ утгаар нь танин мэдэх боломжгүй. Хэрэв хүн төрөлхтөн орчлон ертөнц, цаг хугацааны орон зай болон хүний бие махбодын нууцыг тайлъя гэвэл гагцхүү ариун Фа дагуу бясалгаж гэгээрэх, амь бодийн түвшнээ дээшлүүлэх нь цорын ганц зам юм. Бясалгалын явцад ёс суртахуун дээшилдэг, жинхэнэ нинжин ба харгис, сайн ба мууг ялгаж чаддаг болоход, мөн хүн төрөлхтний энэ давхаргаас гарахад, орчлон ертөнцийн үнэн бодит байдал болон өөр өөр давхаргын өөр өөр орон зайн амь бодийг харж, бас харилцаж чаддаг болно.

Хүн төрөлхтний судалгаа шинжилгээ нь “амьдралын нөхцөлийг сайжруулах” нэрийн доор явагдах технологийн өрсөлдөөн бөгөөд энэ нь ихэнх тохиолдолд Бурханыг үгүйсгэж, хүн төрөлхтөн өөрсдийгөө зөв барьж байх ёс суртахуунаа алдах үндэс нь болдог. Ийнхүү өмнөх үеийн хүн төрөлхтний соёл иргэншил олон удаа устгагдаж байсан. Судалгаа шинжилгээ нь зөвхөн энэ материаллаг ертөнцөд хязгаарлагддаг бөгөөд судалгааны арга нь зөвхөн тухайн зүйл танин мэдэгдсэний дараа л судлах замаар явагддаг. Мөн Бурхдыг үгүйсгэдэг нөлөөний улмаас хүмүүс хүн төрөлхтний энэ орон зайд харагддаггүй, мэдрэхүйд өртдөггүй боловч бодитоор оршин байдаг, энэ орчлон дэлхийд бодитоор илэрч байдаг үзэгдлийг, тухайлбал сүнслэг үзэл, сүсэг бишрэл, бурханлаг үг, ид шидийн гайхамшиг гэх мэтийн зүйлсийг хөндөж ер зүрхэлдэггүй.

Хэрэв хүн төрөлхтөн ёс суртахуун дээр суурилан өөрсдийн зан үйлдэл, үзэл бодлоо сайжруулж чадвал хүний нийгмийн соёл иргэншил урт удаан хутагаанд оршин тогтнож болох бөгөөд бурхны гайхамшиг хүмүүний нийгэмд дахин илэрнэ. Урьд өмнө хагас бурханлаг, хагас хүмүүнлэг соёл иргэншил хүн төрөлхтний нийгэмд удаа дараа оршиж байсан нь хүн төрөлхтний амь бодь ба орчлон ертөнцийн талаарх жинхэнэ ойлголтыг дээшлүүлдэг байсан. Энэ дэлхийд дэлгэрч буй Дафа-д хүн төрөлхтөн зохих дээдлэл хүндлэлтэй хандвал тэр хүмүүс, тэр үндэстэн эсвэл улс орон аз жаргал, алдар хүндийг хүртэх болно. Сансрын биет, орчлон ертөнц, амь бодь болон бүхий л зүйлсийг орчлон ертөнцийн Дафа бүтээсэн. Дафа-гаас гажсан аливаа амь бол жинхэнэ муудсан амь; Дафа-д нийцсэн аливаа хүн бол жинхэнэ сайн хүн, мөн түүнчлэн урт нас, удаан жаргалаар ивээгдэх болно. Бясалгагч хүний хувьд Дафа-д уусаж чадвал, тэр бол гэгээрэгч—Бурхан.

Ли Хонжи  
2015 оны 5 сарын 24

# Гарчиг

<b>НЭГДҮГЭЭР ЛЕКЦ.....</b>	<b>1</b>
Хүнийг дээд түвшин рүү жинхэнэ дагуулах нь.....	1
Өөр өөр түвшинд өөр өөрийн гэсэн Фа байдаг.....	8
Жэнь, Шань, Рэнь бол сайн, муу хүнийг цэгнэдэг цорын ганц шалгуур.....	13
Чийгон бол түүхийн өмнөх үеийн соёл.....	18
Чийгон бол бясалгал.....	24
Дасгалаар яагаад гон өсдөггүй вэ?.....	28
Фалунь Дафа-гийн онцлог.....	40
<b>ХОЁРДУГААР ЛЕКЦ.....</b>	<b>51</b>
Тэнгэрийн мэлхийн асуудал.....	51
Далдыг харах ер бусын чадвар.....	68
Өнгөрсөн ба ирээдүйг харах ер бусын чадвар.....	72
Таван махбодод үл орших ба Гурамсан ертөнцөөс гарах нь.....	79
Хүсэх асуудал.....	86
<b>ГУРАВДУГААР ЛЕКЦ.....</b>	<b>99</b>
Би бүх сурагчдаа шавиа гэж үздэг.....	99
Буддын системийн чийгон ба Буддын шашин.....	101
Зөвхөн нэг бясалгалаараа тууштай бясалгах.....	107
Ер бусын чадвар ба Гон хүч.....	112
Урвуу бясалгал ба Гон зээлдэх.....	113
Сүнс шүглэх.....	123
Сансрын хэл.....	133
Багш сурагчдаа юу өгдөг вэ?.....	136

Энергийн орон .....	146
Фалунь Дафа-гийн сурагч бясалгалыг яаж тараах вэ ..	148

**ДӨРӨВДҮГЭЭР ЛЕКЦ .....** 153

Алдах ба олох.....	153
Нүглийн хувиралт.....	156
Шиньшин-ээ дээшлүүлэх нь.....	170
Гуаньдин (Энергизэр адислах) .....	179
Шуаньгуань бүрэлдэн тогтох нь .....	184

**ТАВДУГААР ЛЕКЦ .....** 195

Фалунь дүрс .....	195
Чимэнь бясалгал .....	199
Буруу номоор бясалгах .....	202
Эр эм хос бясалгал .....	206
Амь бие, сэтгэлийн хос бясалгал .....	209
Фашэнь .....	211
Аравнайлах .....	213
Жү Ю Кэ (Ид шидийн анги зүйл) .....	224

**ЗУРГААДУГААР ЛЕКЦ.....**227

Бясалгалын солиорол .....	227
Бясалгахад буг чөтгөр үймүүлэх нь .....	241
Өөрийн сэтгэлээс чөтгөрийн үймүүлэл үүсэх нь.....	251
Эзэн бодол хүчтэй байх ёстой.....	259
Сэтгэл заавал зөв байх ёстой .....	260
Ушу чийгон .....	270
Гайхуулах сэтгэл.....	277

<b>ДОЛДУГААР ЛЕКЦ</b> .....	<b>283</b>
Амь хороох асуудал .....	283
Мах идэх асуудал .....	289
Атаархах сэтгэл .....	299
Өвчин эдгээх асуудал .....	307
Эмнэлгийн эмчилгээ ба чийгон эмчилгээ.....	315
<b>НАЙМДУГААР ЛЕКЦ</b> .....	<b>323</b>
Бигү мацаг .....	323
Чий хулгайлах .....	326
Чий хураах .....	330
Хэн бясалгана тэр гон олж авна .....	335
Тэнгэрийн эргүүлэг .....	345
Баярлах сэтгэл.....	360
Үг яриагаа бясалгах.....	363
<b>ЕСДҮГЭЭР ЛЕКЦ</b> .....	<b>367</b>
Чийгон ба биеийн тамир .....	367
Бодол.....	371
Цэвэр ариун сэтгэл .....	381
Төрөлхийн суурь.....	388
Ухамсар.....	392
Лугаа төрөлхийн суурьтай хүн .....	401
<b>ТАЙЛБАР</b> .....	<b>415</b>

# Нэгдүгээр лекц

## Хүнийг дээд түвшин рүү жинхэнэ дагуулах нь

Би, Фа болон бясалгал заах бүхий л явцдаа нийгэмд болон сурагчдадаа хариуцлагатай хандаж ирснээр гарсан үр дүн маань сайн байгаа бөгөөд нийгэмд бүхэлд нь үзүүлсэн үр нөлөө ч бас чамгүй сайн байгаа. Хэдэн жилийн өмнө нэлээд олон чийгон багш бясалгал заадаг байсан, тэдний заасан нь бүгд өвчин эдгээх, бие эрүүлжүүлэх түвшинд харьяалагдах зүйлүүд. Мэдээж тэдний бясалгалын аргыг муу гэж байгаа юм биш, би зөвхөн тэднийг дээд түвшний зүйлийг заагаагүй гэж хэлж байгаа юм. Би орон даяарх чийгон-ы байдлыг мэдэж байгаа. Одоо, дотоодод болон гадаадд жинхэнэ дээд түвшинд хүрэх чийгон-ыг би ганцаараа зааж байна. Дээд түвшинд хүрэх чийгон-ыг яагаад хэн ч заадаггүй байсан бэ? Учир нь энэ бол маш том ээдрээтэй асуудлыг, маш гүн түүхийн эх сурвалжийг, өргөн цар хүрээтэй маш хурц асуудлуудыг хамардаг. Үүнд олон чийгон бясалгалын зүйлс хөндөгддөг учраас ердийн хүн зааж чадахгүй. Ялангуяа манай олон чийгон бясалгагч өнөөдөр нэг бясалгалыг сурч, маргааш нь нөгөөг сурч өөрийн биеэ замбараагүй болгодог, цаашид дээш бясалгаж чадахгүй нь зайлшгүй. Бусад хүмүүс гол замаар дээш бясалгаж байхад тэд хажуугийн салаа замаар бясалгадаг, энийг бясалгахад нөгөө нь саад болно, нөгөөг бясалгахад энэ нь саад болдог. Энэ бүгд түүнд саад болж цаашид бясалгаж чадахаа болино.

Бид эдгээр асуудлыг бүгдийг нь цэгцэлж өгнө, сайныг нь үлдээж мууг нь хаяна, тэгснээр чамайг үүнээс хойш бясалгаж чадахыг чинь батална, гэхдээ



чи энэ Дафа-г чин сэтгэлээсээ сурахаар ирсэн байх ёстой. Хэрэв чи янз бүрийн зууралдсан сэтгэлтэй ирж ер бусын чадвартай болох, өвчнөө эдгээх, зүгээр онол сонсох, эсвэл ямар нэгэн муу зорилгоор ирсэн бол болохгүй. Учир нь энэхүү зүйлийг ганцхан би хийж байгаа гэж хэлсэн. Ийм боломж олон гарахгүй, би ч үргэлж ингээд заагаад байхгүй. Миний лекцэд биечлэн сууж сонссон хүн бол, би хэлбэл... чи энэ цаг үеийг туйлын үнэ цэнтэй байсныг ирээдүйд ойлгох болно. Мэдээж бид хувь тавиланд итгэдэг, энд байгаа хүн болгон хувь тавилангаараа сууж байгаа.

Та бүхэн боддоо, дээд түвшинд хүрэх бясалгалыг заах нь ямар асуудал вэ? Энэ нь хүнд аврал үзүүлж байгаа хэрэг биш гэж үү? Хүнд аврал үзүүлнэ гэдэг нь зөвхөн өвчин эдгээх, бие эрүүлжүүлэх гэсэн үг биш, харин чи жинхэнэ бясалгах юм. Тэгвэл жинхэнэ бясалгал нь сурагчдаас өндөр шиньшин-тэй байхыг шаарддаг. Энд сууж байгаа хэн бүхэн энэ Дафа-г сурахаар ирсэн, тэгвэл чи өөрийгөө жинхэнэ бясалгагч хэмээн үзэх ёстой, мөн чи зууралдсан сэтгэлээ хаях ёстой. Хэрэв чи янз бүрийн хүсэл зорилготойгоор дасгал болон энэ Дафа-г сурахаар ирсэн бол юу ч сурахгүй. Та бүхэнд үнэнийг хэлбэ: Бясалгагчийн хувьд, бясалгалын бүхий л явц нь тасралтгүйгээр хүний зууралдсан сэтгэлийг хаях явдал юм. Энгийн хүний нийгэмд хүмүүс хувийн ашиг сонирхлынхоо төлөө хоорондоо тэмцэлдэн булаалдаж, нэг нэгнийгээ хуурч мэхэлдэг, хохироодог. Ийм сэтгэлийг бүгдийг нь хая. Тэр тусмаа өнөөдөр бясалгал сурч байгаа хүн эдгээр сэтгэлийг бүр ч хаях ёстой.

Би энд өвчин эдгээх талаар ярихгүй, бид ч өвчнийг эдгээхгүй. Гэхдээ жинхэнэ бясалгагчийн хувьд, чи

өвчтэй биетэй бол бясалгаж чадахгүй. Би чиний биенийг ариусгаж өгнө. Биений ариусгалыг зөвхөн бясалгалыг жинхэнэ сурахаар, Фа-г жинхэнэ сурахаар ирсэн хүнд л хийж өгнө. Бид нэг зүйлийг онцолдог: Чи тэр сэтгэлээ, өвчний бодлоо орхиж чадахгүй бол бид юуг ч хийж өгч чадахгүй, мөн чамд туслах ямар ч арга байхгүй. Яагаад вэ? Яагаад гэвэл энэ орчлон ертөнцөд ийм нэг зарчим байдаг: Буддын номоор яривал, энгийн хүний асуудал нь бүгд хувь төөрөгтэй холбоотой байдаг, энгийн хүн бол төрөх, хөгшрөх, өвчлөх, үхэх жамаар оршдог. Урьдын хийсэн муу үйлээс үүссэн нүгэл нь өвчин, гай зовлонгийн шалтгаан болдог. Ийнхүү зовох нь үйлийн үрээ төлж байгаа хэрэг бөгөөд үүнийг хэн ч дураараа өөрчилж болохгүй, хэрэв өөрчилбөл өртэй байсан ч түүнийгээ төлөхгүй байж болно гэсэнтэй адил, бас үүнийг дураараа хийж болохгүй, тэгвэл муу зүйл хийсэнтэй адил болно.

Зарим хүн өвчтөнийг эдгээх, өвчнийг арилгах, биенийг эрүүлжүүлэхийг сайн зүйл хийж байна гэж үздэг. Миний харж байгаагаар энэ бүгд өвчнийг жинхэнэ эдгээдэггүй, зөвхөн хойшлуулдаг эсвэл хувиргаж өгдөг, үүнийг авч хаядаггүй. Үнэхээр энэ гай зовлонгоос салъя гэвэл нүглийг арилгах ёстой. Хэрэв хэн нэгэн өвчнийг бүрэн эдгээж эсвэл нүглийг бүрмөсөн арилгаж чадвал, жинхэнэ ингэж хийж чадвал энэ хүний түвшин нь доогуур биш юм. Тэр аль хэдийн нэг зарчмыг олж харсан: Энгийн хүний зарчмыг хамаагүй эвдэж болохгүй. Бясалгалын явцад, бясалгагч энэрэнгүй сэтгэлийн улмаас зарим сайн зүйл хийх, хүнд тусалж өвчнийг нь эдгээх, биенийг нь эрүүлжүүлэхийг бол зөвшөөрнө, гэхдээ хүмүүсийн өвчнийг бүрмөсөн эдгээж өгч болохгүй. Хэрэв энгийн нэг хүний өвчнийг

бүрмөсөн арилгаад өгөх юм бол, бясалгадаггүй энгийн хүн ямар ч өвчин эмгэггүй болоод гараад явна, тэр хүн үүдээр гараад л энгийн хүн хэвээрээ байна, тэр бас л энгийн хүнтэй адил хувийн ашгийн төлөө тэмцэлдэн булаалдана, яаж түүний нүглийг хамаагүй арилгаж өгч болох юм? Үүнийг огт зөвшөөрөхгүй.

Тэгвэл яагаад үүнийг бясалгаж байгаа хүнд хийж өгч болдог вэ? Яагаад гэвэл бясалгадаг хүн хамгийн нандин хүн, тэр бясалгах бодолтой, иймээс гарсан энэ бодол нь хамгийн нандин байдаг. Буддын шашинд Буддын мөн чанарыг ярьдаг, хүний Буддын мөн чанар гарч ирэхэд гэгээрэгчид түүнд тусалж болно. Энэ нь юу гэсэн үг вэ? Би дээд түвшний бясалгал зааж байгаа болохоор дээд түвшний зарчмуудтай холбогддог, түүнчлэн үүдэн гарах асуудал нь маш том гэж би хэлнэ. Бидний харж байгаагаар энэ орчлон ертөнцөд хүний амь энгийн хүний нийгэмд бий болсон юм биш. Хүний жинхэнэ амь орчлон ертөнцийн орон зайд үүссэн. Учир нь энэ орчлон ертөнцөд амийг бий болгодог янз бүрийн маш олон бие бодь оршдог, эдгээр бие боднуудын харилцан үйлчлэлийн дүнд амь үүсэж болдог, өөрөөр хэлбэл хүний хамгийн анхны амь орчлон ертөнцөөс эх сурвалжтай байдаг. Орчлон ертөнцийн орон зай нь угаасаа өгөөмөр энэрэнгүй бөгөөд Жэнь, Шань, Рэнь гэсэн мөн чанартай, хүн анх төрөхдөө орчлон ертөнцийн мөн чанартай ижил байдаг. Гэвч амь бодь их хэмжээгээр үүсэхэд нэг хэлбэрийн нийгмийн хамтын харилцаа бий болдог. Энэ дунд зарим нь магадгүй амиа хичээсэн сэтгэлтэй болж аажмаар тэдний түвшин унаж ирнэ, тэд энэ түвшиндээ байж чадахгүй болж доош унана. Гэвч дараагийн унасан тэр түвшиндээ дахин муу болж тэнд

мөн л байж чадахгүй үргэлжлэн доош унана, эцэст нь хүн төрөлхтний энэ түвшинд унаж ирдэг.

Бүх хүн төрөлхтний нийгэм нэг л түвшинд байдаг. Энд унаж ирсэн бол ер бусын чадвараар харахад, эсвэл аугаа гэгээрэгчийн үүднээс харахад, тэдгээр амь бодь уг нь устгагдах ёстой. Гэвч аугаа гэгээрэгчид нигүүлсэнгүй сэтгэлийн үүднээс тэдэнд дахин нэг боломж өгсөн, тэгээд ийм нэгэн онцгой орчин, өвөрмөц орон зайг бүтээсэн юм. Энэ орон зайны амь бодь орчлон ертөнцийн бусад орон зайн бүх амь бодитой ер адилгүй. Энэ орон зайн амь бодь бусад орон зайн амь бодийг харахгүй, орчлон ертөнцийн үнэн байдлыг харж чадахгүй, иймээс эдгээр хүмүүс төөрөгдөлд унасангай адил. Эдгээр хүмүүс өвчин, гай зовлонгоосоо салах, нүглийг арилгах бодолтой байвал заавал бясалгаад үүссэн эх үндсэндээ буцаж үнэнд хүрэх ёстой, янз бүрийн бясалгаад бүгд л ингэж үздэг. Хүн үүссэн эх үндсэндээ буцаж үнэнд хүрэх нь хүн болсны жинхэнэ зорилго юм. Тиймээс хүн бясалгахыг хүсэхэд л, түүний Буддын мөн чанар нь гарч ирсэн гэж үздэг. Ийм бодол хамгийн нандин байдаг, яагаад гэвэл тэр үүссэн эх үндсэндээ буцаж үнэнд хүрэхийг хүсэж байна, энгийн хүний энэ түвшнээс гарахыг хүсэж байна.

Магадгүй та бүгд Буддын шапинд ийм нэг үг байдгийг сонссон байх: “Буддын мөн чанар гарч ирэхэд, арван зүгийн хорвоог доргиодог.” Хэн ч харсан түүнд тусална, ямар ч нөхцөлгүйгээр тусална. Хүнийг аврахад Буддын система ямар ч нөхцөл ярьдаггүй, ямар ч хариу хардаггүй, ямар ч нөхцөлгүйгээр тусална, тиймээс бид сурагчдадаа маш олон зүйлийг хийж өгч болно. Харин энгийн

нэг хүний хувьд, зөвхөн энгийн хүн байх бодолтой, өвчнөө эдгээх хүсэлтэй бол болохгүй. Зарим хүн “Миний өвчин эдгэрвэл л би бясалгана” гэж боддог. Бясалгахад ямар ч нөхцөл ярьдаггүй, бясалгахыг хүсвэл зүгээр л бясалга. Гэвч зарим хүний бие өвчтэй, эсвэл бие дэх мэдээлэл нь их замбараагүй байдаг. Зарим хүн чийгон-оор ер хичээллэж үзээгүй байдаг, бас зарим нь хэдэн арван жилээр чийгон-оор хичээллэж ирсэн ч чий-н түвшиндээ эргэлдсээр л байдаг, дээш бясалгаж чадаагүй.

Тэгвэл яах вэ? Бид биеийг нь ариусгаж өгнө, түүнд дээд түвшин рүү бясалгах боломж олгоно. Хамгийн доод түвшинд бясалгахад ийм нэг явц байдаг, энэ нь чиний биеийг бүрэн дүүрэн ариусгах юм, чиний бодол санаанд байгаа бүх муу муухай зүйлийг, биеийн эргэн тойронд чинь байгаа нүглийн орныг, мөн чиний биеийг өвчлүүлж байгаа хүчин зүйлс бүгдийг цэвэрлэнэ. Цэвэрлэхгүй бол, ийм их бохирдсон хар биетэй, мөн муу бодол санаатай байхад яаж дээд түвшин рүү бясалгаж чадах юм? Бид энд чий-гээр хичээллэхгүй, доод түвшний иймэрхүү зүйлээр чи хичээллэх шаардлагагүй, бид чамайг дээш нь түлхэх болно, чиний биеийг өвчингүй байдалд хүргэнэ. Түүнчлэн бид доод түвшинд бий болгох ёстой бүх суурь зүйлийг бэлнээр нь биед чинь суулгаж өгнө, ингэснээр чи маш дээд түвшинд бясалгах болно.

Бясалгалд чий-г оролцуулан гурван түвшин байдаг. Гэхдээ жинхэнэ бясалгалд (чий-гээр хичээллэхийг оролцуулахгүйгээр) хоёр гол түвшин байдаг: Нэг нь Гурамсан ертөнцийн Фа (Шижиан Фа) бясалгал; нөгөөх нь Гурамсан ертөнцөөс гарсан Фа (Чу Шижиан Фа) бясалгал юм. Энэ Гурамсан ертөнцийн Фа болон

Гурамсан ертөнцөөс гарсан Фа бясалгал гэдэг нь хийдийн дотор яригддаг хүний орчлонгоос гаднах болон хүний орчлон доторх гэсэн онолын зүйлээс маш ялгаатай. Биднийх бол хүний биеийн бясалгалын хоёр гол түвшин дэх жинхэнэ өөрчлөлт юм. Яагаад гэвэл Гурамсан ертөнцийн Фа бясалгалын явцад хүний бие ариусна, тасралтгүйгээр цэвэршинэ, улмаар Гурамсан ертөнцийн Фа бясалгалын хамгийн дээд хэлбэрт хүрэхэд хүний бие дээд энергийн бие бодior бүрэн солигддог. Түүнчлэн Гурамсан ертөнцөөс гарсан Фа бясалгал нь үндсэндээ Буддын биеийн бясалгал болдог, энэ бие нь дээд энергийн бие бодior бүтдэг ба бүх ер бусын чадвар дахин шинээр гарна. Бидний ярьж байгаа нь энэ хоёр гол түвшин юм.

Бид хувь тавиланд итгэдэг, энд сууж байгаа хүн болгонд би энэ зүйлийг хийж өгнө. Энд одоо хоёр мянга гаруй хүн л байна, би үүнийг хэдэн мянга эсвэл түүнээс ч олон хүнд, тэр ч байтугай арван мянгаас дээш хүн байсан ч бүгдэд нь мөн хийж өгч чадна, өөрөөр хэлбэл чи доод түвшинд бясалгах шаардлагагүй болсон гэсэн үг юм. Би чиний биеийг ариусгаж өгсний дараа чамайг түлхэн дээшлүүлнэ, чиний биед бясалгалын цогц системийг суулгаж өгнө, чи шууд дээд түвшинд бясалгах болно. Гэхдээ үүнийг зөвхөн жинхэнэ бясалгах гэж ирсэн сурагчдад хийж өгнө, чи энд сууж байгаа ч чамайг бясалгадаг хүн гэж хэлж болохгүй. Чамайг үзэл бодлоо үндсээр нь өөрчилж чадвал бид үүнийг өгч болно, мөн үүгээр хязгаарлагдахгүй, би та бүгдэд ямар зүйл өгсөн бэ гэдгийг хожим та нар ойлгох болно. Бид энд өвчин эдгээхийг ярихгүй, харин бид сурагчдын биеийг нийтээр нь засаж өгнө, чамайг бясалгах боломжтой болгоно. Чиний бие өвчтэй бол, чамаас үндсэндээ гон гарахгүй, тиймээс та бүгд өвчнөө

эдгээх гэж над дээр ирэхийн хэрэггүй, би ч тийм зүйл хийхгүй. Миний гарч ирсэн гол зорилго бол хүнийг дээд түвшин рүү дагуулах, хүнийг дээд түвшин рүү жинхэнэ дагуулах явдал юм.

## **Өөр өөр түвшинд өөр өөрийн гэсэн Фа байдаг**

Урьд өмнө олон чийгон багш чийгон-д эхлэл шат, дунд шат, дээд шат байдаг гэж ярьдаг байсан. Тэр бүгд бол чий, бүгд чий-гээр хичээллэх тэр түвшний зүйл юм, гэвч үүнийг эхлэл шат, дунд шат, дээд шат гэж ангилсан. Жинхэнэ дээд түвшний зүйлийг манай ихэнх чийгон-оор бясалгагчид огт мэддэггүй, үндсэндээ ямар ч ойлголт байхгүй. Үүнээс хойш бидний тодорхой ярих зүйл бол дээд түвшний Фа юм. Би бас бясалгалын нэр хүндийг сэргээхийг хүсэж байна. Би хичээл дээр бясалгагчдын хүрээн дэх зарим муу үзэгдлийг ярина. Бид яаж үүнд хандах, яаж эдгээр үзэгдлийг авч үзэх талаар би бүгдийг нь ярина; түүнээс гадна дээд түвшинд бясалгалын арга болон Фа заахад өргөн цар хүрээтэй олон асуудлууд холбогддог, бүр маш хурц асуудлууд байдаг, эдгээр зүйлийг би бас ярихыг бодож байна. Зарим нь өөр орон зайнаас ирж бидний энгийн хүний нийгмийг үймүүлдэг, ялангуяа бясалгалын орчныг үймүүлдэг, би үүнийг бас ярина, түүнчлэн эдгээр асуудлыг сурагчдадаа шийдэж өгнө. Эдгээр асуудлыг шийдвэрлэхгүй бол чи бясалгаж чадахгүй. Эдгээр асуудлыг үндсээр нь шийдвэрлэнэ гэвэл, бид заавал та бүгдийг жинхэнэ бясалгадаг хүн гэж үзэх ёстой, тэгвэл хийж болно. Мэдээж чиний үзэл бодлыг гэнэт өөрчлөхөд амаргүй, үүнээс хойших хичээлийн явцад чи аажмаар өөрийнхөө үзэл бодлоо өөрчилнө, мөн та бүхнийг анхааралтай сонсохыг хүсэж байна. Миний бясалгал заах нь бусад бясалгал заадаг

хүнийхтэй адилгүй. Зарим хүн бясалгалаа заахдаа зөвхөн онолын хувьд товчхон ярина, дараа нь зайнаас мэдээлэл дамжуулна, тэгээд ямар нэг дасгал хөдөлгөөн заагаад л болчихдог. Хүмүүс ийм арга барилаар бясалгал заалгаад хэзээнээс дасчихсан байдаг.

Бясалгалыг жинхэнэ заахад Фа эсвэл Дао-г заах шаардлагатай. Арван удаагийн лекцээр би дээд түвшний зарчмуудыг тодорхой ярина, тэгвэл чи бясалгаж чадах болно; эс бөгөөс чи үндсэндээ бясалгах ямар ч арга байхгүй. Бусад хүмүүсийн зааж байгаа нь бүгд өвчин эдгээх, бие эрүүлжүүлэх тэр түвшний зүйлс байдаг, чи дээд түвшин рүү бясалгахыг хүсэвч, дээд түвшний Фа-гийн удирдамжгүйгээр бясалгаж чадахгүй. Чи сургуульд сурч байгаатай адил: Чи бага сургуулийн номыг дээд сургуульд үзвэл мөн л бага сургуулийн сурагч хэвээр байх болно. Зарим хүн маш олон бясалгалыг сурчихсан гэж үздэг, ийм ч бясалгал, тийм ч бясалгал гээд олон үнэмлэх гэрчилгээтэй болдог, гэхдээ түүний гон бас л дээшлээгүй байдаг. Тэд эдгээрийг чийгон-ы жинхэнэ утга нь, чийгон-ы бүх зүйл нь гэж үздэг, гэхдээ тийм биш юм, энэ нь чийгон-ы зөвхөн өнгөцхөн ойлголт, хамгийн доод түвшний зүйл. Чийгон бол зөвхөн эдгээр зүйл биш, энэ бол бясалгал, маш өргөн хүрээтэй гүн гүнзгий зүйлс, мөн өөр өөр түвшинд өөр өөрийн гэсэн Фа байдаг, иймээс бидний өнөөдрийн мэдэж байгаа чийг-гээр хичээллэх зүйлтэй адилгүй, чи үүнийг хэр их сурсан ч адилхан. Жишээлбэл, чи Английн бага сургуулийн хичээлийг сурсан ч; Америкийн бага сургуулийн хичээлийг сурсан ч; Японы бага сургуулийн хичээлийг сурсан ч; мөн Хятадын бага сургуулийн хичээлийг сурсан ч, бага сургуулийн сурагч хэвээрээ л байна. Чийгон-ы доод түвшний хичээлийг чи хэчнээн их сурах тусам,



улам ихээр мэдэх тусам чамд улам гай болно, чиний бие аль хэдийн замбараагүй байдалд орчихсон байна.

Би нэг асуудлыг онцлон хэлмээр байна, манай бясалгалд гон бясалгах арга болон Фа заах шаардлагатай. Зарим сүм хийд дэх лам хуврагууд, ялангуяа Зэн буддизмын лам хуврагууд өөр санаа бодолтой байж магадгүй. Фа-г яримагц тэд сонсох дургүй болдог. Яагаад вэ? Зэн буддизмд ингэж үздэг: Фа-г ярьж болохгүй, ярьчихвал энэ нь Фа биш болно, ярих Фа байхгүй, зөвхөн оюун санаагаараа олж мэдэх ёстой. Иймээс Зэн буддизмд өнөөдрийг хүртэл ямар ч Фа ярьж чадахгүй. Зэн буддизмын Бодьдарма, Шагжамүни-гийн хэлсэн нэгэн үгээр энэ зүйлийг үндэслэн заан тараасан. Шагжамүни, “Тогтсон Дарма байдаггүй” гэж ярьсан. Тэр Шагжамүни-гийн ярьсан энэ үгэнд үндэслэн Зэн буддизмыг үүсгэн байгуулсан. Бид бол энэ бясалгалын үүд мухардалд орсон гэж хэлнэ. Яагаад мухардалд орсон бэ? Анх Бодьдарма энэ үүдээр ороход түүнд өргөн юм шиг санагдсан; хоёр дахь хамба ороход тийм өргөн санагдаагүй; гурав дахь хамба дөнгөж багтаж орсон; дөрөв дэх хамбад аль хэдийн их нарийн болсон; тав дахь хамбад бараг орох нөхцөлгүй болсон; зургаа дахь хамба Хүйнэн нь мухрын эцэст хүрч цааш явах аргагүй болсон. Хэрэв чи өнөөдөр Зэн буддын шашинтан дээр очоод Дарма заалгана гэвэл юу ч битгий асуу, ямар нэг юм асуувал тэр эргээд чиний толгойн дээр саваагаар цохино, “савааны хашраа” гэнэ. Үүний утга нь чамайг битгий асуу, өөрөө ухамсарла гэсэн үг. Чи ингэж хэлнэ: “Би юу ч мэдэхгүй учраас энд сурах гэж ирсэн, юуг нь ухамсарлах юм? Яагаад намайг цохиж байгаа юм?!” Энэ бол мухарт тулсан гэсэн үг, цааш ярих юмгүй болсон. Бодьдарма хэлэхдээ, “Түүний номлол зөвхөн

зургаа дахь хамба хүртэл уламжлагдана, түүнээс цааш үйлчлэхгүй болно” гэсэн. Хэдэн зуун жил өнгөрлөө, гэхдээ одоо хүртэл зарим хүн Зэн Буддизмын номлолыг бодол санаанаасаа тавьдаггүй. Шагжамүнигийн “Тогтсон Дарма байдаггүй” гэсний жинхэнэ утга нь юу байсан бэ? Шагжамүнигийн түвшин нь Рулай (Татагата) түвшин байсан, түүнээс хойш олон лам хувраг Шагжамүнигийн хүрсэн түвшинд, түүний оюун санааны цар хүрээнд хүрч чадаагүй, түүний ярьсан Дарма-гийн жинхэнэ агуулгыг, хэлсэн үгийн үнэн утгыг тэд ойлгоогүй. Тиймээс дараа нь хүмүүс үүнийг ингэж ч нэг тайлбарлаж, тэгж ч нэг тайлбарлан маш замбараагүй болгосон, тэд “Тогтсон Дарма байдаггүй” гэж хэлснийг чи битгий ярь, ярьчихвал Дарма биш болно гэж ойлгосон. Үнэндээ тийм утгатай биш юм. Шагжамүни бодь модны доор гон нь нээгдэж гэгээрсний дараа, шууд Рулай түвшинд хүрээгүй. Тэр бүхэл 49 жилийн турш Дарма-гаа заан тараах явцад өөрийгөө үргэлж дээшлүүлж байсан. Тэр түвшин дээшлэх болгондоо эргэн харж, өөрийнх нь дөнгөж ярьсан Дарма нь буруу байсныг ойлгосон. Дахин дээшилсний дараа түүний ярьсан Дарма нь бас л буруу байсныг олж мэдсэн. Тэр дахин дээш ахихад энэ байдал давтагдсаар байсан. Бүх л 49 жилийн турш тэр ингэж тасралтгүйгээр дээшилсэн, түвшин нь дээшлэх болгонд өөрийнхөө урьд нь ярьж байсан Дарма-г танин мэдэхүйн хувьд маш доогуур түвшинд байсныг олж харсан. Мөн түвшин болгоны Дарма нь тухайн түвшиндээ л илрэх хэлбэр гэдгийг тэр олж мэдсэн, түвшин болгонд өөрийн гэсэн Дарма байдаг, гэвч тэдгээрийн аль нь ч орчлон ертөнцийн туйлын үнэн биш. Тухайн нэг түвшний Дарма-г түүний доодох түвшний Дарма-тай харьцуулахад орчлон ертөнцийн

мөн чанарт илүү ойр байдаг, тиймээс тэр “Тогтсон Дарма байдаггүй” гэж хэлсэн.

Эцэст нь Шагжамүни бас ингэж хэлсэн: “Би энэ насандаа ямар ч Дарма номлоогүй.” Зэн буддизмд үүнийг бас л ярих Дарма байхгүй гэж ойлгосон. Шагжамүни амьдралынхаа өгөл насанд Рулай түвшинд хүрсэн, тэр яагаад ямар ч Дарма номлоогүй гэсэн бэ? Тэр чухамдаа ямар асуудлыг үүгээр илэрхийлсэн бэ? Түүний хэлсэн үгийн утга нь: “Би энэ Рулай түвшинд хүрсэн атал, орчлон ертөнцийн хамгийн эцсийн Үнэн, хамгийн эцсийн Дарма юу болохыг харж чадаагүй.” Иймээс тэр хойч үеийнхэндээ өөрийнх нь хэлсэн үгийг туйлын үнэн, өөрчлөгдөшгүй үнэн гэж бүү үзээрэй гэсэн, эс бөгөөс хойч үеийнхнийгээ Рулай түвшинд эсвэл Рулай-гаас доош түвшинд хязгаарлаж, дээд түвшинд нэвтэрч чадахгүй байдалд хүргэнэ гэж үзсэн. Хожим хүмүүс энэ үгийн жинхэнэ утгыг нь ойлгож чадаагүй, хэрэв Дарма-г ярьчихвал энэ нь Дарма биш болно гэж ойлгосон. Үнэндээ Шагжамүнигийн ярьсан нь бол: Өөр өөр түвшинд өөр өөрийн гэсэн Дарма байдаг, түвшин болгоны Дарма орчлон ертөнцийн туйлын үнэн биш, гэхдээ тухайн түвшний Дарма тэр түвшиндээ удирдах нөлөөтэй байдаг. Тэр үнэндээ энэ зарчмыг л хэлсэн юм.

Урьд нь маш олон хүн, ялангуяа Зэн буддизмынхан ямагт ийм нэгэн өрөөсгөл ойлголттой, хэтэрхий туйлширсан үзэлтэй байсан юм. Чи заалгахгүйгээр бас удирдуулахгүйгээр яаж өөрөө бясалгах юм? Буддын шашинд маш олон Буддын домог түүх байдаг, магадгүй зарим хүн тэнгэрийн оронд очсон хүний тухай уншсан байх. Тэрээр тэнгэрийн оронд очоод тэндхийн “Очир эрдэнийн судар” -ын үг болгон нь доод газрын “Очир

эрдэнийн судар”-аас өөр байсныг, мөн утга нь ч бүхэлдээ өөр байсныг олж мэдсэн. Яагаад энэ “Очир эрдэнийн судар” хүний ертөнцийнхөөс өөр байсан бэ? Зарим хүн ингэж ярьдаг: “Сухавати диваажингийн судар нь доод газрынхтай юугаараа ч адилгүй, огт өөр болсон байдаг, зөвхөн үг нь адилгүй төдийгүй бас утга санаа, агуулга нь бүгд адилгүй, өөрчлөгдсөн байдаг.” Үнэндээ бол адилхан нэг Фа өөр өөр түвшинд өөр өөрөөр хувирах болон илрэх хэлбэртэй байдаг, мөн бясалгагчдыг өөр өөр түвшинд өөр өөрөөр удирдах нөлөөтэй.

Та бүгд мэднэ, Буддын шашинд “Сухавати диваажинд аялсан тэмдэглэл” гэдэг товхимол байдаг. Түүнд нэгэн хувраг бясалган сууж байхдаа сүнс (Юань-шэнь) нь Сухавати диваажинд очиж байдлыг нь харсан, тэр тэнд нэг өдөр болоод буцаж ирэхэд, хүний ертөнцөд аль хэдийн зургаан жил өнгөрсөн байсан. Тэр харж чадсан уу? Харсан, гэхдээ түүний харсан зүйл нь жинхэнэ үнэн байдал биш байсан. Яагаад вэ? Түүний түвшин хангалттай өндөр биш байсан учраас, тэр харсан байдал нь зөвхөн түүний байгаа түвшинд харуулах ёстой Буддын Фа-гийн илрэл байсан юм. Учир нь тийм нэг тэнгэрийн орон бол Фа-гийн бүтцийн илрэл байдаг, иймээс тэр жинхэнэ үнэн байдлыг харж чадаагүй. Миний ярьж байгаа энэ “Тогтсон Дарма байдаггүй” гэдгийн утга нь ийм л юм.

## **Жэнь, Шань, Рэнь бол сайн, муу хүнийг цэгнэдэг цорын ганц шалгуур**

Буддын шашинд хүмүүс Буддын Фа гэж юу болохыг үргэлж судалсаар ирсэн. Зарим хүн Буддын шашинд ярьсан Дарма-г Буддын Фа бүхлээрээ гэж үздэг, үнэндээ тийм биш юм. Шагжамүни-гийн 2500 жилийн

өмнө ярьсан Дарма нь зөвхөн маш доод түвшинд байсан энгийн хүмүүст буюу дөнгөж хүй нэгдлээс гарч ирсэн маш энгийн үзэл бодолтой хүмүүст зориулж ярьсан Дарма юм. Тэр Дарма-гийн төгсгөлийн үеийг ярьсан, энэ бол одоо үе. Орчин үеийн хүмүүс тэр Дарма-гаар аль хэдийн бясалгаж чадахгүй болсон. Дарма-гийн төгсгөлийн үед хүрээ хийдэд байгаа лам хуврагууд хүнд аврал үзүүлэх нь бүү хэл өөрсдийгөө аврахад ч хэцүү болсон. Шагжамүни-гийн тэр үедээ заасан Дарма нь тухайн үеийнхээ нөхцөл байдалд тааруулж заагдсан юм, мөн тэр өөрийнхөө байгаа түвшинд мэддэг Буддын Фа-г бүгдийг нь яриагүй, үүнийг өөрчлөхгүйгээр үүрд хадгалж үлдээнэ гэвэл бас боломжгүй.

Нийгэм хөгжихийн хэрээр хүн төрөлхтний бодол санаа улам бүр ээдрээтэй болж ирсэн учраас хүмүүс тэр замаар бясалгана гэдэг амаргүй болсон. Буддын шашны Дарма, Буддын Фа-г бүхэлд нь ерөнхийлж чадахгүй, энэ нь Буддын Фа-гийн зөвхөн өчүүхэн төдий хэсэг л юм. Буддын системд бас маш олон аугаа бясалгалууд хүмүүсийн дунд уламжлагдаж ирсэн, үеэс үед зөвхөн нэг л шавьд заан уламжилдаг. Өөр өөр түвшинд өөр өөрийн гэсэн Фа байдаг, өөр өөр орон зайд бас өөр өөрийн гэсэн Фа байдаг. Энэ бүгд бол өөр өөр орон зай, өөр өөр түвшин дэх Буддын Фа-гийн янз бүрийн илрэл юм. Шагжамүни, Будда-д бясалгах 84 мянган Номын үүд байдаг тухай ярьсан, харин Буддын шашинд Зэн буддизм, Ариун орон, Тианьтай, Хуэянь, Тантрын шашин гэх мэт зөвхөн арав гаруй Номын үүд л байдаг, эдгээр нь Буддын Фа-г бүхэлд нь ерөнхийлж чадахгүй. Шагжамүни өөрийнхөө Дарма-г бүгдийг нь заан тараагаагүй, зөвхөн тэр үеийн хүмүүсийн хүлээн

авах чадварт тааруулж тодорхой хэсгийг нь л заасан юм.

Тэгвэл Буддын Фа гэж юу вэ? Энэ орчлон ертөнцийн хамгийн үндсэн мөн чанар болох Жэнь, Шань, Рэнь бол Буддын Фа-гийн хамгийн дээд илрэл бөгөөд жинхэнэ үндсэн Буддын Фа юм. Буддын Фа өөр өөр түвшинд өөр өөрийн илрэх хэлбэртэй, өөр өөр түвшинд өөр өөрийн удирдах нөлөөтэй байдаг, түвшин нь улам доогуур байх тусам улам их ярвигтай хэлбэрээр илэрдэг. Агаарын элементүүд, чулуу, мод, шороо, төмөр ба ган, хүний бие болон бүх бие бодид Жэнь, Шань, Рэнь гэсэн мөн чанар оршдог; эрт дээр үед таван махбодыг орчлон ертөнцийн бүх зүйлсийг бий болгосон гэдэг байсан, мөн энэ бүгд бас Жэнь, Шань, Рэнь гэсэн мөн чанартай. Бясалгадаг хүн аль нэг түвшинд бясалгаад хүрвэл зөвхөн тэр түвшин дэх Буддын Фа-гийн бодит илрэлийг ойлгодог, энэ нь түүний бясалгасан Бүтээлийн орон, бясалгаж хүрсэн түвшин нь юм. Өргөн утгаар хэлбэл Фа бол маш их аугаа. Маш дээд түвшний үүднээс авч үзвэл энэ нь тун энгийн, яагаад гэвэл Фа пирамид хэлбэртэй төстэй байдаг. Хамгийн дээд түвшинд энэ нь зөвхөн гурван үгэнд хураангуйлагддаг: Жэнь, Шань, Рэнь. Энэ нь өөр өөр түвшинд илрэхдээ туйлын нарийн болдог. Хүнээр жишээ авч үзвэл, Бумбын системд хүний биеийг нэг жижиг орчлон ертөнц гэж үздэг. Хүн бодит биетэй, гэвч зөвхөн бодит биетэй байснаар бүрэн төгс хүн болчихгүй, заавал хүний зан ааш, хувийн зан чанар, онцлог шинж бас сүнс (Юань-шэнь)-тэй байх ёстой, тэгснээр бүрэн төгс биеэ даасан өөрийн гэсэн зан төлөвтэй хүн болж бүтдэг. Бидний энэ орчлон ертөнц ч бас адилхан, энэ нь Тэнгэрийн заадас галактик, бусад галактикууд, мөн амь ба устай байдаг, энэ орчлон

ертөнцийн бүх зүйлс бол материаллаг оршихуйн харагдах байдал юм; түүнчлэн үүнд бас Жэнь, Шань, Рэнь гэсэн мөн чанар оршдог. Аливаа бие бодийн бүх бичил ширхгүүд бүгд энэ мөн чанарыг агуулдаг, туйлын бичил ширхгүүд хүртэл энэ мөн чанарыг агуулдаг.

Жэнь, Шань, Рэнь энэ мөн чанар бол орчлон ертөнцийн сайн мууг цэгнэдэг шалгуур. Юу нь сайн, юу нь муу вэ? Үүгээр л цэгнэдэг. Бидний урьд нь ярьж байсан Дэ бас адилхан. Мэдээж өнөөдрийн хүн төрөлхтний нийгэм дэх ёс суртахууны шалгуурт аль хэдийн өөрчлөлт гарсан, ёс суртахууны шалгуур нь бүгд гажсан. Одоо, хэрэв хэн нэгэн Лэй Фэнгээс суралцвал, магадгүй түүнийг мэдрэлийн өвчтэй гэж хэлнэ. Харин тавь, жараад оны үед хэн түүнийг мэдрэлийн өвчтэй гэх юм? Хүн төрөлхтний ёс суртахууны хэм хэмжээ маш ихээр уруудсан, нийгмийн байдал өдөр тутамд доройтож байна, хүмүүс зөвхөн хувийн ашиг сонирхлын хойноос хөөцөлдөж өөрийн өчүүхэн ашиг хонжооны төлөө бусдыг хохироодог, тэд хоорондоо тэмцэлдэн булаалдахдаа ямар ч муу аргыг хамаагүй хэрэглэдэг. Та бүгд боддоо, ингэж цааш үргэлжлэхийг нь зөвшөөрөх юм уу? Хэн нэгнийг муу зүйл хийж байхад нь чи түүнд муу зүйл хийж байна гэж хэлбэл тэр үнэмшихгүй, тэр үнэндээ өөрийгөө муу зүйл хийж байна гэдэгтээ итгэхгүй; зарим хүн уруудсан ёс суртахууны шалгуураар өөрийгөө цэгнэдэг, өөрийгөө бусад хүнээс илүү сайн гэж үздэг, учир нь цэгнэдэг шалгуур нь өөрчлөгдсөн. Хүн төрөлхтний ёс суртахууны хэм хэмжээ яаж өөрчлөгдсөн ч энэ орчлон ертөнцийн мөн чанар өөрчлөгдөхгүй, энэ бол сайн муу хүнийг цэгнэдэг цорын ганц шалгуур юм. Тэгвэл бясалгаж байгаа хүний хувьд орчлон ертөнцийн энэ

мөн чанарын дагуу өөрийгөө шаардах ёстой, энгийн хүний шалгуурын дагуу өөртөө хандаж болохгүй. Хэрэв чи өөрийнхөө үүссэн эх үндсэндээ буцаж үнэнд хүрэх, бясалгаж дээшлэх хүсэлтэй байвал энэ шалгуурын дагуу хийх ёстой. Хувь хүний хувьд орчлон ертөнцийн Жэнь, Шань, Рэнь мөн чанарыг дагаж чадвал тэр бол сайн хүн, энэ мөн чанараас хазайвал жинхэнэ муу хүн юм. Ажлын газарт, нийгэмд зарим хүн чамайг муу гэж хэлж магадгүй, гэвч үнэндээ чи муу биш байж болно; зарим хүн чамайг сайн гэж хэлж магадгүй, гэвч үнэндээ чи сайн биш байж болно. Бясалгагчийн хувьд, энэ мөн чанарт өөрийгөө уусгавал чи Бумбыг олсон хүн, зарчим нь ийм л энгийн юм.

Бумбын системд Жэнь, Шань, Рэнь-ийг бясалгахдаа Жэнь (Үнэн) дээр голчлон бясалгадаг. Тиймээс Бумбын системд Жэнь-ийг бясалгаад мөн чанараа сайжруулах гэж ярьдаг; үнэн үг хэлэх, юмыг үнэнчээр хийх, үнэнч хүн болох, эх үндсэндээ буцаж үнэнд хүрэх, эцэст нь бясалгаад чин үнэн хүн болохыг зорьдог. Гэхдээ Рэнь (Гэвчээр) ч байна, Шань (Нинжин) ч байна, гол нь Жэнь (Үнэн)-ийг чухалчлан бясалгадаг. Буддын системд Жэнь, Шань, Рэнь-ийн гол нь Шань (Нинжин)-ийг онцлон бясалгадаг. Учир нь Шань-ийг бясалгахад аугаа нигүүлсэнгүй сэтгэл гардаг, нигүүлсэнгүй сэтгэл гарахад бүх амийг зовлонтой байгааг нь хардаг, иймээс бүх амийг аврах сэтгэл төрнө. Гэхдээ Жэнь ч байна, Рэнь ч байна, гол нь Шань-ийг чухалчлан бясалгадаг. Манай Фалунь Дафа орчлон ертөнцийн хамгийн дээд шалгуур болох Жэнь, Шань, Рэнь-ийг зэрэг бясалгана. Бидний бясалгал бол маш аугаа.



## Чийгон бол түүхийн өмнөх үеийн соёл

Чийгон гэж юу вэ? Их олон чийгон багш энэ талаар ярьдаг, миний ярьж байгаа нь тэдний ярьдагтай адилгүй. Олон чийгон багш энэ тухай өөрсдийнхөө түвшинд ярьдаг, миний ярьж байгаа нь дээд түвшин дэх чийгон-ы ойлголт юм, тэдний ойлгож байгаагаас эрс ондоо. Зарим чийгон багш чийгон-ыг манай оронд хоёр мянган жилийн түүхтэй гэж ярьдаг, бас зарим хүн гурван мянган жилийн түүхтэй гэдэг, зарим хүн таван мянган жилийн түүхтэй гэдэг, энэ нь бидний Хятад үндэстний соёл иргэншлийн түүхтэй бараг ойролцоо юм; бас зарим хүн үүнийг археологийн олдвороос үүдэн долоон мянган жилийн түүхтэй гэж ярьдаг, энэ нь Хятад үндэстний соёл иргэншлийн түүхээс маш хол давсан юм. Гэхдээ тэд үүнийг яаж ойлгосон ч бай, бүгд хүн төрөлхтний соёл иргэншлийн түүхээс тийм их хол хэтрээгүй. Дарвины хувьслын онолоор бол, хүн үүсэхдээ анх усны ургамлаас усны амьтан болж, дараа нь газар дээр, улмаар модон дээр гарч, дахин газар дээр бууж хүн дүрст сармагчин болсон. Эцэст нь соёлтой, ухамсартай орчин үеийн хүн төрөлхтөн болж хувьссан гэж бодвол, хүн төрөлхтний энэ соёл иргэншил эхэлснээс хойш 10 мянган жилээс хэтрээгүй юм. Түүнээс урагш харвал хүмүүс олс зангидан тэмдэглэл хийхийг ч мэдэхгүй, модны навч зүүж, түүхий мах иддэг байсан; түүнээс бүр ч өмнөхийг нь харвал магадгүй галтай яаж харьцахыг ч мэдэхгүй ерөнхийдөө зэрлэг, балар эртний хүмүүс байсан болж таарна.

Гэвч бид ийм нэг асуудлыг олж мэдсэн, дэлхийн олон газарт эртний соёлын маш олон ул мөр үлдсэн байдаг, тэдгээр нь бидний хүн төрөлхтний соёл иргэншлийн түүхээс хол давсан юм. Тэдгээр эртний үлдцүүд нь гар урлалын талаасаа маш дэвшилтэт

түвшинд хүрсэн; урлагийн талаас нь харвал бас нэлээд дээд зэргийн бүтээлүүд байсан. Орчин үеийн хүмүүс бол эртний хүмүүсийн урлагийг зүгээр л дуурайчихсан, харин тэдний урлаг гоо зүйн маш үнэ цэнтэй. Гэвч тэдгээр нь зуун мянга гаруй жилийн өмнөх, хэдэн зуун мянган жилийн өмнөх, хэдэн сая жилийн өмнөх тэр ч байтугай зуун сая гаруй жилийн өмнөх үлдэц юм. Та бүгд үүнийг боддоо, энэ нь өнөөдрийн түүхээр тохуурхаж байгаа юм биш үү? Үнэндээ энэ бол инээдэм биш, хүн төрөлхтөн өөрсдийгөө үргэлж боловсронгуй болгодог, үргэлж өөрсдийгөө шинээр таньж байдаг, нийгэм ингэж л хөгждөг, анхны танин мэдэхүй нь туйлын зөв байх албагүй.

Магадгүй олон хүн “Түүхийн өмнөх үеийн соёл”, өөрөөр хэлбэл “Түүхийн өмнөх үеийн соёл иргэншил” гэж сонссон байх, бид түүхийн өмнөх үеийн соёл иргэншлийн талаар ярьж. Дэлхий дээр Ази, Европ, Өмнөд Америк, Хойд Америк, далайн орнууд, Африк мөн Антарктид тивүүд байдаг, геологичид эдгээрийг ерөнхийд нь “Эх газрын хавтгай” гэж нэрлэдэг. Эх газрын хавтгай үүссэнээс өнөөдрийг хүртэл аль хэдийн хэдэн арван сая жилийн түүхтэй болсон. Тухайлбал, олон тивүүд далайн ёроолоос гарч ирсэн, мөн олон тивүүд далайн ёроолд живсэн, өнөөдрийн энэ тогтворжсон байдлаас хойш хэдэн арван сая жилийн түүхтэй болсон. Гэвч олон далайн ёроолд өндөр бөгөөд том хэмжээний эртний барилга байгууламж байгааг олж илрүүлсэн, тэдгээр барилгууд нь маш гоёмсог урлан бүтээгдсэн бөгөөд бидний өнөөгийн хүн төрөлхтний соёлын өв биш юм. Тиймээс тэдгээрийг далайн ёроолд живэхээс өмнө барьсан нь гарцаагүй. Тэгвэл хэн энэ хэдэн арван сая жилийн өмнөх тэр соёл иргэншлийг бий болгосон бэ?

Тэр үед манай хүн төрөлхтөн сармагчин ч байгаагүй, яаж ийм аугаа оюунлаг зүйлсийг бий болгосон байх юм? Археологичид энэ дэлхийд байсан “Гурамсан навчит хорхой” гэдэг шавжийг олж мэдсэн, энэ нь 600 сая жилээс 260 сая жилийн өмнө оршиж байсан юм. 260 сая жилээс хойш энэ организм утсан. Америкийн нэг эрдэмтэн “Гурамсан навчит хорхой”-н чулуужсан үлдэц нарүүлсэн, түүн дээр хүний хөлийн мөр зэрэгцэн гарсан байсан, тэр мөр нь гутлын маш тодорхой мөр байсан. Энэ нь түүхчдийг элэглэсэн биш гэж үү? Дарвины хувьслын онолоор авч үзвэл, 260 сая жилийн өмнө яаж хүн байх юм?

Перу Улсын Их Сургуулийн музейд хүний дүрс сийлэгдсэн чулуу байдаг, судалгаагаар тэр чулуун дээрх хүний дүрс нь 30 мянган жилийн өмнө сийлэгдсэн болох нь тодорхойлогдсон. Гэвч энэ хүний дүрс нь хувцас өмсчихсөн, малгайтай, гуталтай, мөн гартаа дуран авай бариад оддыг ажиглаж байгаа харагддаг. Гучин мянган жилийн өмнөх хүн яаж даавуу нэхэж хувцас хийж өмсөж чаддаг байсан бэ? Ухаан санаанд бүр оромгүй нь, тэрээр дуран авай бариад оддыг ажиглаж байгаа нь бас одон орны зохих мэдлэгтэй байсан гэсэн үг юм. Бид үргэлж Европын Галилеог дуран авайг анх бүтээсэн гэж үздэг, энэ нь одоогоос зөвхөн 300 гаруй жилийн өмнөх үеийн л түүхтэй, тэгвэл 30 мянган жилийн өмнө хэн дуран авайг бүтээсэн бэ? Бас тайлбарлаж чадаагүй маш олон нууцууд байдаг. Жишээлбэл Франц, Өмнөд Африк, Альпын нуруунд байдаг олон агуйн ханан дээр сийлэгдсэн зургууд байдаг, тэдгээр нь тов тодоор амьд юм шиг харагддаг. Тэнд сийлэгдсэн хүний дүрснүүд гайхалтай уран хийцтэй, мөн эрдэс бодисын будгаар будагдсан байдаг. Гэвч тэдгээр хүмүүс орчин үеийн хүний костюм шиг

хувцастай бас барну өмдтэй, зарим нь тамхины гаанс шиг зүйл барьсан, зарим нь гоёлын таягтай бас малгай өмсчихсөн байсан. Хэдэн зуун мянган жилийн өмнөх сармагчнууд яаж тийм өндөр соёлын түвшинд хүрсэн байх юм?

Бүр эртний үеийн өөр нэг жишээ дурдъя, Африк тивийн Бүгд Найрамдах Габон Улсад ураны хүдэр байдаг. Энэ орон буурай хөгжилтэй бөгөөд ураныг өөрөө гаргаж авах чадваргүй, тэд хүдрийг өндөр хөгжилтэй орон луу экспортолсон. 1972 онд Францын нэг үйлдвэр ураны хүдрийг нь импортолсон. Лабораторийн шинжилгээ хийсний дараа тэрхүү ураны хүдэр нь аль хэдийн боловсруулагдаад ашиглагдсан байсныг олж мэдсэн. Энэ нь маш гайхалтай санагдсан, тэгээд эрдэмтдийг судалгаа хийлгүүлэхээр явуулсан, олон орны эрдэмтэд судалгаа хийхээр очсон. Эцэст нь энэ ураны хүдрийн уурхай нь маш том цөмийн урвалын реактор байсныг баталсан, түүний зохион байгуулалт нь маш их зүй зохистой байсан, бидний орчин үеийн хүмүүс ч үүнийг бүтээх магадлал байхгүй. Тэгвэл энэ нь хэдийд байгуулагдсан байх уу? Энэ нь 2 тэрбум жилийн өмнө бүтээгдэж 500 мянган жилийн турш ажилласан байсан. Энэ бол ёстой одон орны тоо юм, Дарвины хувьслын онолоор үүнийг үндсэндээ тайлбарлах аргагүй, иймэрхүү зүйлс их олон байдаг. Одоогийн шинжлэх ухаан, технологийн салбарт олж мэдсэн зүйлүүд бидний өнөөдрийн сурах бичгийг өөрчлөхөд хангалттай байна. Хүн төрөлхтний хуучинсаг үзэл нь нэг хэвийн ажиллах, бодох арга барилыг бий болгосноос болж шинэ танин мэдэхүйг хүлээж авахад хэцүү байдаг. Үнэн зөв нь илчлэгдсэн ч хүмүүс үүнийг хүлээн авч зүрхэлдэггүй, өөрийн мэдэлгүй түүнээс татгалздаг. Хэвшсэн үзэл баримтлалын нөлөөллийн

улмаас өнөөдөр эдгээр зүйлсийг дэс дараатай система оруулан цэгцлэх хүн байхгүй байна. Иймээс хүний үзэл баримтлал нь хөгжлөөс үргэлж хоцорч байдаг, хэдийгээр тэдгээр зүйлс өргөн дэлгэрээгүй ч гэсэн аль хэдийн илэрчихсэн байдаг, чамайг эдгээр зүйлсийн талаар ярихад зарим хүн үүнийг мухар сүсэг гэнэ, хүлээн зөвшөөрч чаддаггүй.

Гадаад оронд олон зоригтой эрдэмтэд тэдгээрийг аль хэдийн түүхийн өмнөх үеийн соёл буюу бидний энэ хүн төрөлхтний өмнөх үеийн соёл иргэншил гэж нийтийн өмнө хүлээн зөвшөөрсөн, өөрөөр хэлбэл бидний хүн төрөлхтний энэ удаагийн соёл иргэншлээс өмнө бас өөр соёл иргэншлийн үе нэг бус удаа оршиж байсан юм. Археологийн олдвороос харахад бүгд нэг соёл иргэншлийн үеийнх биш байдаг. Тиймээс хүн төрөлхтний соёл иргэншил удаа дараагийн сүйрэлд автах бүрд зөвхөн цөөн тооны хүмүүс амьд гарч балар эртний байдлаар амьдардаг байсан, дараа нь аажим аажмаар шинэ хүн төрөлхтөн боллоо өсөн олширч шинэ соёл иргэншил эхэлдэг. Дараа нь дахин сүйрэлд автаж, дахин шинэ хүн төрөлхтөн үүсэн бий болдог, ингэж өөр өөр мөчлөгийн үеүд давтагдаж ирсэн. Физикчид бие бодийн хөдөлгөөн нь тодорхой зүй тогтлоор явагддаг гэж ярьдаг, бидний бүхэл орчлон ертөнцийн өөрчлөлтүүд ч бас зүй тогтлоор явагддаг.

Манай дэлхийн хөдөлгөөн энэхүү энгүй уудам орчлон ертөнцийн дунд, тэнгэрийн заадас галактикийн эргэлтэд үргэлж саадгүй жигд байх боломжгүй, магадгүй аль нэг гаригтай мөргөлдөнө эсвэл өөр ямар нэг асуудалтай тулгарч маш том гай гамшиг учирна. Бид ер бусын чадвараараа харахад бүгд яг тэгж зохицуулагдсан байдаг. Нэг удаа би үүнийг нарийвчлан

шинжиж үзэхэд хүн төрөлхтөн 81 удаа бүхэлдээ сүйрч байсныг олж харсан, зөвхөн цөөн тооны хүмүүс амьд гарч соёл иргэншлээсээ үлдсэн багахан хэмжээний зүйлстэйгээр дараачийн үедээ шилжин орж балар эртний байдлаар амьдардаг байсан. Хүн төрөлхтөн хангалттай өсөж олшроход соёл иргэншил дахин бий болдог. Ийм мөчлөгийн өөрчлөлт 81 удаа давтагдсан бөгөөд би үүнийг төгсгөлд нь хүртэл шалгаагүй. Хятад хүмүүс тэнгэрийн цаг үе, газрын ээлтэй нөхцөл, хүний эв нэгдлийг ярьдаг. Тэнгэрийн янз бүрийн өөрчлөлт, тэнгэрийн янз бүрийн цаг үе нь хүн төрөлхтний нийгэмд янз бүрийн нийгмийн байдлыг авчирч болно. Физикийн үүднээс авч үзвэл, аливаа бие бодийн хөдөлгөөн тодорхой зүй тогтлын дагуу явагддаг, орчлон ертөнцийн хөдөлгөөн ч мөн адил байдаг.

Саяны та бүгдэд ярьсан түүхийн өмнөх үеийн соёл иргэншил нь чийгон-ыг бидний өнөөгийн хүн төрөлхтөн бий болгоогүй гэдгийг харуулж байна, энэ нь маш өнө эртний үеэс уламжлагдан ирсэн бөгөөд бас нэг янзын түүхийн өмнөх үеийн соёл юм. Бид шашны судраас үүнтэй холбоотой зарим дүгнэлтийг бас олж болно. Шагжамүни тухайн үедээ, тэрээр олон зуун сая галавын өмнө бясалгаад гэгээрэлд хүрсэн гэж ярьсан. Нэг галавт хэдэн жил байдаг вэ? Нэг галавт олон зуун сая жил байдаг, ийм аугаа тоог төсөөлөхийн ч аргагүй. Хэрэв үнэн бол, энэ нь хүн төрөлхтний түүхтэй, бүх л дэлхийн өөрчлөлтүүдтэй таарч байгаа хэрэг биш үү? Мөн Шагжамүни өөрөөс нь өмнө бас өнө эртний үеийн зургаан Будда байсан, түүнд бас багш байсан гэх мэт, бүгд олон зуун сая галавын өмнө бясалгаж гэгээрэлд хүрсэн гэж ярьсан. Хэрэв эдгээр зүйлс бүгд үнэн гэвэл, бидний өнөөгийн нийгэмд тарсан тэдгээр уламжлалт, жинхэнэ арнун бясалгалуудын дунд ийм

бясалгах арга байгаа юу? Би үүнийг мэдээж байгаа гэж харнулна, гэхдээ тэд маш ховор үзэгддэг. Одоо үед хуурамч чийгон, зохиомол чийгон, мөн сүнс шүглэсэн хүмүүс зарим зүйлийг дураараа зохион гаргаж хүмүүсийг хууран мэхэлдэг, тэдний тоо жинхэнэ чийгон-оос олон дахин их байдаг. Аль нь үнэн, аль нь хуурамч гэдгийг ялгахад хэцүү. Жинхэнэ чийгон-ыг танихад хэцүү, бас тийм амар олдохгүй.

Үнэндээ зөвхөн чийгон нь эрт үеэс үлдсэн ганц зүйл биш. Тайжи, Хэту, Луошү, Жоуи, Найман төлөг гэх мэт нь бүгд түүхийн өмнөх үеэс уламжлагдаж үлдсэн юм. Иймээс бид өнөөдөр энгийн хүний байр сууринаас тэдгээрийг судалж танин мэдье гэвэл, яаж ч судлаад ойлгож чадахгүй. Энгийн хүний түвшин, байр суурь, үзэл баримтлалын хүрээнээс жинхэнэ зүйлсийг ойлгох боломжгүй.

## **Чийгон бол бясалгал**

Нэгэнт чийгон өнө удаан жилийн түүхтэй юм бол, энэ нь чухам юунд зориулагдсан юм бэ? Би та нарт хэлье, бидний Дафа бол Буддын системийн аугаа бясалгал болохоор мэдээж Буддад бясалгана; Бумбын системд мэдээж Бумбыг бясалгаад Бумбад хүрнэ. Би та бүхэнд хэлье, “Будда” бол мухар сүсэг биш. “Будда” бол эртний Энэтхэг хэл болох самгарьд үг юм. Хятад руу дамжин орж ирэх үед энэ үг хоёр ханзаас бүтсэн байсан, “Фо-Туо” гэж уншигдана, бас зарим нь үүнийг “Фу-Ту” гэж орчуулсан. Үг ам дамжин тархсаар Хятад хүмүүс нэг ханзыг нь орхиж зөвхөн “Фо” гэж хэлдэг болсон. Хятадаар энэ нь юу гэсэн утгатай вэ? Энэ нь “Тэгээрэгч” гэсэн үг, бясалгалаар гэгээрсэн хүн. Үүнд мухар сүсэг гэх юу байгаа юм?

Та бүгд боддоо, бясалгалаар ер бусын чадвар гардаг. Өнөөдөр дэлхий дээр зургаан төрлийн ер бусын чадвар нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, гэлээ ч үүгээр хязгаарлагдахгүй. Би жинхэнэ ер бусын чадварыг арван мянгаас дээш байдаг гэж хэлнэ. Хүн энд суугаад, гар хөлөө хөдөлгөхгүйгээр бусад хүмүүсийн гар хөлөөрөө ч хийж чадахгүй зүйлийг хийж чаддаг; орчлон ертөнцийн орон зай бүрийн жинхэнэ зарчмыг болон орчлон ертөнцийн үнэн байдлыг харж чадна; энгийн хүний харж чадахгүй зүйлсийг харж чаддаг. Энэ нь бясалгаад Бумбад хүрсэн биш гэж үү? Бас аугаа гэгээрэгч биш гэж үү? Энгийн хүнтэй адилтан үзэж болох юм уу? Бясалгаад гэгээрсэн хүн биш гэж үү? Гэгээрэгч гэж дуудаж болохгүй гэж үү? Эртний Энэтхэг хэлээр бол Будда. Үнэндээ бол ийм л юм, чийгон бол үүнд л зориулагдсан.

Чийгон-ы талаар ярихад, зарим хүн: “өвчин байхгүй бол хэн чийгон-оор хичээллэх юм?” гэдэг. Цаад утга нь чийгон-ыг өвчин эдгээхэд зориулагдсан гэж үздэг. Энэ бол маш өнгөцхөн, маш өнгөцхөн ойлголт юм. Энэ нь та нарын буруу биш, яагаад гэвэл олон чийгон багш нар өвчин эдгээх, бие эрүүлжүүлэх талын зүйлсийг хийдэг, бүгд өвчин эдгээх бие сайжруулахыг л ярьдаг, хэн ч дээд түвшний зүйл заагаагүй. Энэ нь тэдний бясалгалын аргыг муу гэж байгаа юм биш, тэдний үүрэг бол өвчин эдгээх, бие эрүүлжүүлэх түвшний зүйлийг зааж чийгон-ыг дэлгэрүүлэх явдал байсан юм. Олон хүн дээд түвшин рүү бясалгах хүсэлтэй байдаг, тэд ийм ч бодолтой, тийм ч хүсэлтэй байвч бясалгалын зөв арга замыг олдоггүй, улмаар маш их хүндрэлтэй тулгарч бас олон асуудал үүсдэг. Мэдээж бясалгалыг жинхэнэ дээд түвшинд заан тараахад маш гүн гүнзгий асуудлууд холбогддог. Иймээс бид нийгэмд болон



хүмүүст хариуцлагатай хандаж ирсэн, мөн бясалгалыг заан тараах бүхий л явцад гарсан үр дүн маань сайн байгаа. Зарим зүйлс үнэндээ маш гүн гүнзгий, ярихад мухар сүсэг мэт санагдаж магад, тийм ч гэсэн бид үүнийг аль болохуйц орчин үеийн шинжлэх ухаанаар тайлбарлая.

Бид зарим зүйлийг ярихад, хэн нэгэн мухар сүсэг гэж хэлдэг. Яагаад вэ? Ийм хүний баримталдаг чиг шугам бол шинжлэх ухаанд танин мэдэгдээгүй, өөрт нь хараахан тохиолдоогүй, эсвэл байж болшгүй гэж бодсон бүх зүйлсээ мухар сүсэг буюу хийсвэр зүйл гэж үздэг, энэ бол түүний өөрийнх нь үзэл баримтлал. Ийм үзэл баримтлал зөв үү? Шинжлэх ухаанд танин мэдэгдээгүй, тухайн хөгжлийн түвшинд хүрээгүй зүйлсийг мухар сүсэг бишрэл, хийсвэр зүйл гэж үзэж болох юм уу? Тэр өөрөө мухар сүсэг бишрэлд автсан биш гэж үү? Хийсвэр үзэлтэн биш гэж үү? Ийм үзэл баримтлалаар шинжлэх ухаан яаж хөгжиж, яаж дэвших юм? Хүн төрөлхтний нийгэм ч бас урагшаа хөгжиж чадахгүйд хүрнэ. Бидний шинжлэх ухаан технологийн хүрээнд нээсэн бүх зүйлс урьд нь байхгүй байсан зүйлс, бүгдийг нь мухар сүсэг бишрэл гэж үзвэл мэдээж хөгжих хэрэггүй болчихно. Чийгон бол ямар ч хийсвэр зүйл биш, маш олон хүн чийгон-ыг мэддэггүй, иймээс чийгон-ыг үргэлж хийсвэр гэж үздэг. Одоо шинжлэх ухааны тоног төхөөрөмжөөр чийгон багш нарын биед дэд авианы долгион, хэт авианы долгион, цахилгаан соронзон долгион, хэт улаан туяа, хэт ягаан туяа, гамма цацраг, нейтрон, атом, бичил металлын элементүүд болон бусад элементүүд байдгийг хэмжин тогтоосон, эдгээр нь бүгд материалаг оршиж байгаа зүйлс биш гэж үү? Эдгээр нь мөн л бие бодь юм. Аливаа зүйл бие боднос бүтсэн биш гэж үү? Бусад цаг хугацааны

орон зай болгон мөн л бие бодиос бүтсэн биш гэж үү? Яаж түүнийг мухар сүсэг бишрэл гэж хэлж болох юм? Нэгэнт чийгон нь Буддад бясалгахын тулд юм бол, зайлшгүй маш олон гүн гүнзгий асуудалтай уялдааг, бид бүгдийг нь ярина.

Чийгон үүнд зориулагдсан юм бол, бид яагаад чийгон гэж нэрлэдэг болсон бэ? Үүнийг үнэндээ чийгон гэж нэрлэдэггүй, тэгвэл юу гэж нэрлэх үү? “Бясалгал” гэдэг, бясалгал л юм. Мэдээж энэ нь өөр тодорхой нэртэй, ерөнхийд нь бясалгал л гэдэг. Тэгвэл яагаад чийгон гэж нэрлэсэн бэ? Та бүгд мэднэ, чийгон нийгэмд дэлгэрээд 20 гаруй жилийн түүхтэй болсон, “Соёлын их хувьсгал”-ын дунд үед дэлгэрч эхэлсэн, төгсгөл үед нь оргилдоо хүрсэн. Та бүгд боддоо, тэр үед хэт зүүний үзэл суртал ид хүчтэй байсан. Түүхийн өмнөх соёл иргэншлийн үеүдэд чийгон ямар, ямар нэршилтэй байсныг бид энд дурдахгүй, энэ удаагийн хүн төрөлхтний соёл иргэншил хөгжлийнхөө явцад феодалын нийгмийг дамжсан, тиймээс энэ нь гол төлөв феодалын өнгө аястай нэршилтэй болсон. Шашинтай холбоотой байсан бясалгалууд үргэлж шашны өнгө аяс бүхий нэртэй байдаг. Жишээлбэл: “Бумбын бясалгалын аугаа ном”, “Очир номлол”, “Архадын ном”, “Буддын бясалгалын аугаа ном”, “Есөн удаа хувирах алтан үрлийн увдис” гэх мэт нэртэй байсан. Хэрэв “Соёлын их хувьсгал”-ын үеэр эдгээр нэрсийг хэрэглэсэн бол чам руу дайрч давшлахгүй байсан гэж үү? Чийгон багш нарын чийгон-ыг заан тараах гэсэн хүсэл нь ариун, мөн ард иргэдийн өвчнийг арилгах, биенийг нь эрүүлжүүлэх, биенийн байдлыг нь сайжруулахад туслахыг зорьсон, энэ нь ямар сайн хэрэг байх билээ, тэгсэн ч болохгүй, хүмүүс хуучин нэрээр нь хэлж зүрхэлдэггүй байсан.

Тиймээс чийгон-ы олон багш нар чийгон-ыг заан дэлгэрүүлэхийн тулд “Даньжин” (Үрлийн ном), “Даозан” (Бумбын жаяг) гэсэн судруудаас хоёр ханзыг нь авч “Чийгон” гэж нэрлэсэн. Зарим хүн бас чийгон гэдэг нэр томьёог судалдаг, гэвч үүнийг судлах ямар ч зүйл байхгүй, урьд өмнө үүнийг зүтээр л бясалгал гэж нэрлэдэг байсан. Чийгон бол зөвхөн орчин үеийн хүмүүсийн үзэл сурталд нийцүүлэн гаргасан шинэ нэр томьёо л юм.

### **Дасгалаар яагаад гон өсдөггүй вэ?**

Дасгалаар яагаад гон өсдөггүй вэ? Маш олон хүн ийм бодолтой байдаг: “Би жинхэнэ чийгон бясалгалыг уламжилж аваагүй, хэрэв аль нэгэн багш надад хосгүй ур чадвараа өвлүүлэн тусгай арга барилаа зааж өгвөл миний гон өснө.” Одоо хүмүүсийн 95% нь ийм бодолтой байдаг, энэ нь надад их инээдтэй санагддаг. Яагаад инээдтэй гэж? Яагаад гэвэл чийгон бол энгийн хүний ур чадвар биш, энэ нь бүхэлдээ ер бусын зүйл юм, тиймээс дээд түвшний зарчмаар үүнийг цэгнэх ёстой. Би та бүгдэд хэлье, гон дээшлэхгүйн үндсэн шалтгаан нь гэвэл: Хүмүүс “бясалгал, дасгал” гэсэн хоёр үгний зөвхөн дасгалд л анхаарлаа хандуулаад бясалгахыг хайхардаггүй. Чи гаднаас хүсвэл, яаж хүсээд ч олохгүй. Чи энгийн хүний биетэй, энгийн хүний гар, энгийн хүний бодол санаатай байж дээд энергийн бие бодийг гон болгон хувиргаж бас гон-оо өсгөж чадна гэж үү? Энэ нь яаж тийм амар байх юм! Минийхээр энэ бол инээдтэй. Энэ нь гаднаас хүсэж байгаатай адил, гадна талаас хайж байна, хэзээ ч олдохгүй.

Энэ нь мөнгө төлөөд, эсвэл ямар нэгэн арга техник сураад олж авдаг энгийн хүмүүсийн ур чадвар шиг зүйл биш. Тийм биш юм, энэ нь энгийн хүний

түвшнээс давсан зүйл, тиймээс чамайг энгийн бус зарчмыг дагахыг шаардана. Тэгвэл яаж шаардах вэ? Чи өөрийнхөө дотогш бясалгах ёстой, гаднаас хайж болохгүй. Их олон хүн юмыг гаднаас хүсдэг, өнөөдөр энийг хүсдэг, маргааш нөгөөг хүсдэг, мөн зууралдсан сэтгэлдээ хөтлөгдөн ер бусын чадвартай болох гэж хөөцөлддөг, янз бүрийн зорилготой байдаг. Зарим хүн бүүр чийгон багш болж өвчтөн эдгээх замаар баяжихыг хүсдэг! Жинхэнэ бясалгахын тулд чи өөрийнхөө сэтгэлийг бясалгах ёстой, үүнийг шиньшин-ий бясалгал гэдэг. Жишээлбэл, бид хүн хүний хоорондох зөрчлийн дунд өөрийнхөө янз бүрийн хүсэл сэтгэлээ даруу барьж байх ёстой. Хувийн эрх ашгийнхаа төлөө булаацалдаж тэмцэлдэж байхдаа чи гон-оо дээшлүүлмээр байна гэж үү, яаж тийм байж болох юм! Чи энгийн хүнтэй адилхан болсон биш гэж үү? Чиний гон яаж өсөх юм? Тийм болохоор чи өөрийн шиньшин-ээ чухалчлан бясалгаснаар л гон чинь өснө, түвшин чинь ч дээшилнэ.

Шиньшин гэж юу вэ? Үүнд Дэ (нэг төрлийн бие бодь); тэвчээр; ухамсар; орхиж чадах—энгийн хүний янз бүрийн хүсэл ба зууралдсан сэтгэлээс ангижрах; зовлон бэрхшээлийг дааж чадах гэх мэт олон талын зүйлс багтдаг. Хүний шиньшин бүх талаараа дээшлэх ёстой байдаг, ингэснээр л чи жинхэнэ дээшилж чадна, энэ нь гон хүчийг (гонли) дээшлүүлэх гол хүчин зүйлсийн нэг юм.

Зарим хүн ингэж боддог: “Таны ярьж байгаа шиньшин-ий асуудал бол үзэл суртлын зүйл, хүний бодлын хүрээ талын зүйл, бидний бясалгаж байгаа гон-той ямар ч холбогдолгүй.” Яагаад холбогдолгүй гэж? Эртнээс философийн түүхийн туршид бие

бодь (матери) анхдагч уу эсвэл оюун санаа анхдагч уу гэсэн асуудал дээр үргэлж шүүн хэлэлцсээр, маргалдсаар ирсэн. Үнэндээ би та бүхэнд хэлье, бие бодь ба оюун санаа нь нэг бөгөөд адилхан. Хүн судлалын шинжлэх ухаанд одоогийн эрдэмтэд хүний тархинаас гардаг бодол нь бие бодь гэж үздэг. Тэгвэл энэ нь материаллаг орших зүйл юм бол, бас хүний оюун санааны зүйл биш гэж үү? Эдгээр нь адилхан биш гэж үү? Миний ярьж байгаа орчлон ертөнцтэй адил, энэ нь материаллаг байдлаар оршихоос гадна түүнд бас өөрийн гэсэн мөн чанар байдаг. Энгийн хүн Жэнь, Шань, Рэнь гэсэн орчлон ертөнцийн мөн чанар оршиж байгааг мэдэрдэггүй, яагаад гэвэл энгийн хүмүүс бүгд нэг түвшинд оршдог. Чи энгийн хүний энэ түвшнээс гарвал үүнийг мэдрэх болно. Яаж мэдрэх вэ? Орчлон ертөнцийн аливаа бие бодь, ертөнц даяар тархсан бүх бие бодь бүгд оюун ухаантай сүнслэг оршихуйд байдаг, бүгд орчлон ертөнцийн Фа-гийн янз бүрийн түвшинд орших хэлбэр юм. Тэд чамайг дээш гаргахгүй, чи дээшлэх хүсэлтэй байсан ч дээшилж чадахгүй, тэд чамайг яасан ч дээшлүүлэхгүй. Яагаад чамайг дээшлүүлэхгүй гэж? Яагаад гэвэл чиний шиньшин дээшлээгүй. Түвшин бүр өөр өөрийн гэсэн шалгууртай, хэрэв чи түвшнээ дээшлүүлэхийг хүсэж байвал заавал өөрийн муу үзэл бодол, арнун бус зүйлээсээ салах ёстой, тухайн түвшин дэх шалгуурын шаардлагад нийцэхэд чи дээшилнэ.

Чи өөрийнхөө шиньшин-ийг дээшлүүлэх тусам чиний биед том өөрчлөлтүүд гарна; шиньшин чинь дээшлэхэд чиний биен дэх бие бодид өөрчлөлт гарах нь дамжиггүй. Ямар өөрчлөлт гарах вэ? Чи хөөцөлдөж зууралддаг тэдгээр муу зүйлсээ хаяна. Жишээлбэл, нэг лонхыг бохир зүйлсээр дүүргэж сайн таглаад ус руу

шидэхэд ёроолд нь живнэ. Чи лонхон доторх бохир зүйлсийг гарга, улам ихээр гаргаж хаях тусам усанд улам дээш хөвнө; лонхыг бүр мөсөн хоосолбол бүүр дээш хөвөөд гараад ирнэ. Бидний бясалгалын явцад хүний биед орших янз бүрийн муу зүйлсийг хаяж байж л чи дээшилнэ, орчлон ертөнцийн энэ мөн чанар ийм үүрэг гүйцэтгэдэг. Чи өөрийнхөө шиньшин-ийг бясалгахгүй, ёс суртахуунаа дээшлүүлэхгүй, муу бодол, муу зүйлсээ хаяхгүй бол орчлон ертөнцийн мөн чанар чамайг дээшлүүлэхгүй. Чи хэлдээ, эдгээр нь яагаад адил чанартай биш гэж? Би наргиан болгож нэг зүйл хэлье, хэрэв энгийн хүний янз бүрийн хүсэл сэтгэлтэй нэг хүнийг дээшлүүлээд Будда болгоё гэж бодъё, та бүгд боддоо, ийм магадлал байх уу? Тэр магадгүй аугаа Бодьсадваг ямар үзэсгэлэнтэйг нь харчхаад түүнд ёс журамгүй бодол төрнө. Атаархах сэтгэлээ орхиогүйгээс Буддатай зөрчил үүсгэнэ, ийм зүйл байхыг зөвшөөрөх юм уу? Тэгвэл яах вэ? Чи энгийн хүмүүсийн дунд янз бүрийн муу бодол санаагаа заавал бүгдийг нь хаях ёстой, зөвхөн тэгвэл л чи дээшилж чадна.

Өөрөөр хэлбэл чи шиньшин-ээ чухалчилж бясалгах ёстой, орчлон ертөнцийн Жэнь, Шань, Рэнь гэсэн мөн чанарын дагуу бясалга, энгийн хүний хүсэл, муу санаа, муу үйл хийх бодлоосоо салах хэрэгтэй. Чиний үзэл бодол жаахан дээшлэх бүрд зарим муу зүйлс чиний биеэс хаягдана. Үүний зэрэгцээ чи бага зэрэг зовлон амсаж, бэрхшээл туулж, өөрийн нүглийг жаахан ч гэсэн багасга, тэгвэл чи бага зэрэг дээшилнэ, өөрөөр хэлбэл орчлон ертөнцийн мөн чанар чамайг барих нь тийм их биш болно. Бясалгал өөрөөс шалтгаална, гон багшаас шалтгаална. Багш нь чамд гон өсгөх нэг гон механизм өгнө, энэ гон механизм ажиллах болно, чиний биеийн гадна орших Дэ (цагаан бие бодь болох буян)-г гон

болгон хувиргана. Чи байнга өөрийгөө сайжруулж, тасралтгүйгээр дээш бясалгахад чиний гон багана бас тасралтгүйгээр дээш цойлох болно. Бясалгадаг хүний хувьд, энгийн хүмүүсийн орчинд өөрийгөө бясалгаж хатуужуулах ёстой, мөн аажмаар зууралдсан сэтгэл, янз бүрийн хүслээсээ ангижрах ёстой. Бидний хүн төрөлхтний сайн гэж үздэг зүйлсийг дээд түвшнээс харахад ихэнхдээ муу байдаг. Хүмүүсийн дунд илүү их ашиг олж, улам сайхан амьдрахыг энгийн хүмүүс сайн хэрэг гэж үздэг бол Лугаа гэгээрэгчдийн харснаар тийм хүн улам муу байдаг. Юу нь муу гэж? Тэр улам ихийг олох тусам, бусдыг улам их хохирооно, өөрт хүртэх ёсгүй зүйлийг авна, тэр өөрийн алдар нэр, эрх ашгийн төлөө зүтгэнэ, тэгснээр Дэ-гээ алддаг. Чи гон-оо өсгөхийг хүсэвч, шиньшин-ээ чухалчилж бясалгахгүй л бол чиний гон огт өсөхгүй.

Бясалгагчдын хүрээнд хүний сүнс (Юань-шэнь) үхдэггүй гэж ярьдаг. Урьд өмнө сүнсний талаар ярихад хүмүүс магадгүй мухар сүсэг гэж хэлдэг байсан. Та бүгд мэдэж байгаа, физикийн судлалаар хүний биед молекул, протон, электрон, мөн цаашилбал кварк, нейтрино гэх мэт байдгийг олж илрүүлсэн. Энд хүрсний дараа микроскопоор цааш харагдахгүй болдог. Гэвч энэ нь амины эх үүсвэр, бие бодийн эх сурвалжаас маш хол байна. Та бүгд атомын цөмийг задлахад их хүчтэй энергийн мөргөлдөөн, маш их хэмжээний халаат байх шаардлагатай гэдгийг мэднэ. Хүн үхэхэд бие доторх атомын цөм яаж тийм амархан устах юм? Тиймээс бид ингэж олж мэдсэн, хүн үхэхэд зөвхөн бидний энэ орон зайн хамгийн том молекулаас бүрдсэн хэсгүүд салж унадаг; харин бусад орон зайнуудад байдаг биес устахгүй үлддэг. Та бүгд боддоо, микроскопоор хүний биенийг харахад ямар байдаг вэ? Хүний бүхэл бие

хөдөлж байдаг, чи тэнд суугаад хөдлөхгүй байсан ч бүх бие чинь хөдөлгөөнд байдаг, эсүүд болон молекулууд хөдөлж байдаг, бүхэл бие элсээр хийгдсэн юм шиг сул байдаг. Микроскопоор хүний биенийг харахад ийм л байдаг, бидний махан нүдээр хардгаас тэс өөр юм. Учир нь хүний энэ хоёр нүд чамд хуурамч ойлголтыг өгдөг, чамд эдгээр зүйлсийг харуулдаггүй. Тэнгэрийн мэлмий нээгдэхэд юмыг томруулж харж чадна, үнэн хэрэгтээ энэ нь хүний төрөлх чадвар юм, одоо үүнийг ер бусын чадвар гэж нэрлэдэг, чи ер бусын чадвараа гаргахыг хүсвэл бясалгалаар үүссэн эх үндсэндээ буцаж үнэнд хүрэх ёстой.

Бид энэ Дэ-гийн талаар ярилцъя. Эдгээр нь хоорондоо ямар харилцан холбоотой байдаг вэ? Бид үүнийг дэлгэрэнгүй ярья. Хүн маш олон орон зай болгонд нэг, нэг биетэй оршдог. Бид одоо хүний биений бүтцийг авч үзэхэд хамгийн том бүрэлдэхүүн хэсэг нь эс байдаг, энэ бол хүний махан бие юм. Хэрэв чи эсүүд болон молекулуудын хооронд орших зайд юм уу эсвэл молекулуудын хооронд орших зайд орж чадвал, чи өөр орон зайд орсныг мэдэрнэ. Тэнд оршиж байгаа бие ямар хэлбэртэй байдаг вэ? Мэдээж чи үүнийг одоогийн энэ орон зайн ухагдахуунаар ойлгож болохгүй, чиний бие тухайн орон зайн орших хэлбэрийн шаардлагад нийцсэн байх ёстой. Өөр өөр орон зайд байдаг биес мэдээж томорч жижгэрч чаддаг, тэр үед чи тэр орон зайг мөн л зүйрлэшгүй агуу уудам болохыг олж мэднэ. Энэ бол өөр өөр орон зайнуудын нэг дор зэрэгцэн оршиж буй энгийн хэлбэр юм. Хүн бусад маш олон орон зай болгонд тодорхой тогтсон нэг, нэг биетэй байдаг, мөн нэг тусгай тогтсон орон зайд хүний биенийг хүрээлсэн нэг орон оршдог. Ямар орон бэ? Энэ орон бол бидний яринад байгаа Дэ (Буян)



юм. Дэ бол цагаан бие бодь, бидний урьд өмнө үздэг байсан шиг хүний оюун санаа, үзэл баримтлалын зүйл биш, харин энэ нь үнэхээр бодитгоор оршдог, иймээс дээр үеийн настай хүмүүс буян хураах, буянаа алдах гэж ярьдаг байсан нь тун зөв юм. Энэ Дэ (буян) хүний биений эргэн тойронд нэг орон болон үүсдэг. Урьд өмнө Бумбын системд багш шавийг хайдаг, харин шавь багшийг хайдаггүй гэж ярьдаг байсан. Энэ нь юу гэсэн утгатай вэ? Багш энэ шавийн биед байгаа Дэ хэр их болохыг хардаг, их байвал түүнд бясалгахад амар; их биш бол түүнд бясалгахад амаргүй, мөн дээд түвшин рүү гон-оо өсгөхөд түүнд маш хэцүү байх болно.

Мөн түүнчлэн хар бие бодь нэгэн зэрэг хамт оршдог, бид үүнийг “нүтэл” (карма) гэдэг, Буддын шашинд үүнийг бас “муу үйлийн үр” гэдэг. Цагаан бие бодь хар бие бодитой зэрэгцэн оршдог. Энэ хоёр бие бодь хоорондоо ямар харилцан хамааралтай оршдог вэ? Дэ гэх энэ бие бодийг бид зовлон амсаж, хүнд бэрхшээлийг тэвчин давснаар, сайн үйлсийг хийснээр олдог; харин хар бие бодь нь хүн муу хэрэг үйлдэхэд, муу зүйл хийхэд болон бусдыг дээрэлхэхэд хуримтлагдааг. Одоо үед зарим хүн зөвхөн ашиг хонжоо хөөцөлдөөд зогсохгүй, тэдэнд хийхгүй муу зүйл гэж байхгүй болсон, мөнгөний төлөө ямар ч муу зүйл хийдэг: хүний амь бүрэлгэх, захиалгат аллага үйлдэх, мөн ижил хүйстэн болох, хар тамхинд донтох гэх мэт янз бүрийн зүйл байдаг. Хүн муу зүйл хийхэд буянаа алддаг. Яаж буянаа алддаг вэ? Уур омгоороо нэгнийгээ дарангуйлж байгаа хүн өөрийгөө дийлсэнд тооцоход уур нь гардаг. Энэ орчлон ертөнцөд “Алдахгүй бол олдохгүй, олвол алдана” гэдэг зарчим үйлчилдэг, чи алдахыг хүсэхгүй ч чамайг хүчээр алдуулна. Хэн энэ үүргийг гүйцэтгэдэг вэ? Орчлон

ертөнцийн мөн чанар энэ үүргийг гүйцэтгэдэг, иймээс чи зөвхөн олохыг хүсвэл боломжгүй. Тэгвэл яадаг вэ? Хүнийг загнахад, дээрэлхэхэд түүнд буянаа өгдөг; нөгөө хүн гомдолтой талд, ямар нэг зүйлээ алдсан талд, зовсон талд харьяалагдах тул түүний хохирол ингэж нөхөгддөг. Тэр түүнийг загнаж байхад, загнахын хэрээр түүний өөрийнх нь орон зайн хүрэнээс хэсэг Дэ тасран гарч нөгөө хүний биед шилжинэ. Тэр түүнийг хэр их загнана, тэр хэмжээний Дэ-гээ түүнд өгнө. Мөн хүнийг цохих, дээрэлхэхэд бас адилхан. Тэр нөгөө хүнийг цохиход эсвэл өшиглөхөд, хэр хүчтэй цохино тэр хэмжээгээр өөрийнхөө Дэ-гээс түүнд өгдөг. Энгийн хүн энэ түвшин дэх уг зарчмыг хардаггүй, дээрэлхүүлсэн санагдахад тэр үүнийг тэвчиж чадахгүй: “Чи намайг цохисон болохоор би чамаас эргүүлээд харнугаа авна” гэж бодно. “Пад” хийтэл эргүүлээд нударга зөрүүлэхэд Дэ-г буцаагаад түлхэнэ, ингэхэд тэр хоёрын хэн нь ч алдаж олоогүй. Магадгүй тэр, “Чи намайг нэг цохисон, тэгвэл би чамайг харнуд нь хоёр цохино, тэгэхгүй бол уур гарахгүй” гэж бодно. Тэгээд тэр дахиад нэг цохиход, өөрөөсөө дахин нэг хэсэг Дэ-г нөгөө хүнд өгнө.

Яагаад энэ Дэ-г ийм чухалд үздэг вэ? Энэ Дэ-гийн хувиралтад ямар харилцан уялдаа байдаг вэ? Шашинд ингэж ярьдаг: “Дэ байвал, энэ насандаа олохгүй бол дараа насандаа олно.” Тэр юуг олох гэж? Дэ ихтэй хүн, магадгүй том албан тушаалтан болно, маш баян болно, юу хүссэнээ авч болно, энэ бол Дэ-гээрээ сольж олсон зүйл. Шашинд бас ингэж ярьдаг, “Хүнд ямар ч Дэ байхгүй бол, бие сүнс нь хоёул устана. Түүний сүнс устгагдана, тэр үхсэний дараа бүгд үгүй болно, юу ч үлдэхгүй.” Харин бидний бясалгагчдын хүрээнд авч үзвэл, Дэ шууд гон-д хувирч болно.

Бид Дэ яаж гон-д хувирдгийг ярья. Бясалгагчдын хүрээнд ийм нэг үг байдаг, “Бясалгал өөрөөс шалтгаална, гон багшаас шалтгаална.” Гэвч зарим хүн тогоо зуух тавиад эмийн ургамал найруулж үрэл гаргаж авах болон бодлын үйлийн талаар ярьдаг, тэд үүнийг маш чухалд үздэг. Би чамд хэлье, эдгээр нь ердөө чухал биш, чи энэ талаар их бодоод байвал энэ нь зууралдсан сэтгэл болно. Чи үүнийг их хүсээд байвал зууралдсан сэтгэлд автсан биш гэж үү? Бясалгал өөрөөс шалтгаалдаг, гон багшаас шалтгаалдаг. Чамд энэ хүсэл байхад л болоо. Гэхдээ энэ зүйлийг бодитоор хийж өгдөг нь Багш юм, чи үндсэндээ хийж чадахгүй. Чи энгийн хүний биетэй байж яаж үүнийг дээд энергийн бие боднор бүтсэн дээд зэргийн амь бодь болгон хувиргаж чадах юм? Энэ бол огт боломжгүй, бүтэшгүй зүйл. Өөр өөр орон зайд хүний биеийн хувирах явц нь тун ярвигтай, их нарийн байдаг, чи ийм зүйл хийж огт чадахгүй.

Багш нь чамд юу өгөх вэ? Чамд гон-ыг чинь өсгөх нэг гон механизмыг өгнө. Учир нь Дэ хүний биеийн гадна оршдог, хүний жинхэнэ гон Дэ-гээс үүсдэг. Хүний түвшин хэр өндөр байх нь, гон хүч хэр хүчтэй байх нь бүгд Дэ-гээс үүсдэг. Энэхүү гон механизм чиний Дэ-г гон болгон хувиргаж өгнө, энэ нь мушгиа хэлбэрээр дээш өснө. Хүний түвшний өндөр намыг жинхэнэ тодорхойлдог гон нь хүний биеийн гадна талаар мушгирсан хэлбэрээр өсдөг ба улмаар толгойн оройд хүрсний дараа дээш нэг гон баганыг үүсгэдэг. Хүний гон түвшин хэр өндөрт хүрснийг түүний гон баганын өндрөөр нэг хараад л мэдчихнэ. Энэ бол түүний хүрсэн түвшин юм, Буддын шашинд үүнийг бүтээлийн орон гэдэг. Зарим хүн бясалган сууж байхад сүнс нь биеэсээ гарч тодорхой өндөрт

хүрч чаддаг, түүнээс өндөрт гарахыг оролдсон ч тэр чадахгүй, дээшилж зүрхлэхгүй. Тэр өөрийнхөө гон баганад суугаад дээш гарч байгаа болохоор тийм л өндөрт хүрч чадна. Учир нь түүний гон багана тийм л өндөр, түүнээс өндөрт гарч чадахгүй, энэ бол Буддын шашинд ярьдаг бүтээлийн орон юм.

Шиньшин-ий түвшин хэр өндөр байгааг хэмжих бас нэг хэмжүүр байдаг. Энэ хэмжүүр болон гон багана нэг орон зайд хамт байдаггүй, харин зэрэгцэн оршдог. Жишээлбэл хэн нэгэн чамайг хүмүүсийн дунд загнахад, чи дуугараагүй маш тайван байсан бол чиний шиньшин-ий бясалгалд ахиц гарсан гэсэн үг; чамайг цохиход чи бас л дуугараагүй инээмсэглээд л өнгөрөөсөн бол чиний шиньшин аль хэдийн нэлээд өндөр болсон гэсэн үг юм. Тэгвэл бясалгагчийн хувьд чи юу олж авах ёстой вэ? Чи гон олж авах гэж байгаа биз дээ? Чиний шиньшин сайжрахад гон чинь бас өснө. Шиньшин-ий түвшин хэдий чинээ өндөр байна, гон төдий чинээгээр өндөр байдаг, энэ бол туйлын үнэн. Урьд нь зарим хүн цэцэрлэгт хүрээлэнд юм уу гэртээ нэлээд чармайн маш их сүжигтэйгээр бясалгалаар хичээллэдэг байсан. Гэвч гадагш гараад л шал өөр хүн болдог, өөрийнхөө замаар буцаад орно, энгийн хүмүүсийн дунд нэр ашгийн төлөө бусадтай өрсөлдөнө, тэмцэлдэнэ. Тэр ийм байхад гон нь өсөх үү? Ердөө ч өсөхгүй, мөн ийм шалтгаанаар өвчин нь ч эдгэрэхгүй. Яагаад зарим хүн удаан хугацааны турш дасгал хийсэн атал өвчин нь эдгэрдэггүй вэ? Чийгон бол бясалгал, ер бусын зүйл, энгийн хүний биенийн тамирын дасгал шиг биш, заавал шиньшин-ээ чухалчилснаар л өвчин эдгэрнэ, гон ч өснө.

Зарим хүн тогоо зуух тавиад эмийн ургамал найруулж үрэл (дань) гаргаж авахыг ярьдаг, тэрхүү үрлээ гон гэж үздэг, гэвч тийм биш юм. Энэ үрэл нь зөвхөн нэг хэсэг энергийг л агуулдаг, энергийг бүхэлд нь багтаадаггүй. Тэгвэл үрэл гэж ямар зүйл юм бэ? Та бүгд мэднэ, бидэнд бас амь биенийг бясалгах зарим зүйлс байдаг, биеэс гон чадвар болон маш олон арга урдист зүйлс гардаг. Ихэнх эдгээр зүйлс нь түгжигддэг, хэрэглэхийг нь зөвшөөрдөггүй. Маш олон ер бусын чадварууд байдаг, арван мянгаас дээш бий, үүсэх болгонд түгжигддэг. Яагаад тэдгээрийг ил гаргахыг зөвшөөрдөггүй вэ? Энэ нь чамайг энгийн хүний нийгэмд тэдгээрийг хамаагүй хэрэглүүлэхгүй байх зорилготой юм, энгийн хүний нийгмийг хамаагүй үймүүлж болохгүй, мөн хамаагүй энгийн хүний нийгэмд чиний чадварыг илрүүлж болохгүй, яагаад гэвэл энгийн хүний нийгмийн байдлыг бусниулна. Маш олон хүн ухамсраараа бясалгадаг, хэрэв чи тэдэнд чадвараа үзүүлбэл үнэнийг харж мэдчихээд бүгд ирж бясалгана, арван хар нүтэлтэй уучилж боломгүй хүн ч ирж бясалгана, үүнийг зөвшөөрөхгүй. Чамайг ингэж гайхуулахыг зөвшөөрөхгүй; чи бас хүмүүсийн хувь төөргийн харилцааг, юмны жинхэнэ учир шалтгааныг харж чадахгүйгээс амархан муу зүйл хийж мэднэ, чи өөрийгөө сайн зүйл хийж байна гэж бодно, гэвч энэ нь муу зүйл байж магадгүй, тийм учраас чамд тэдгээрийг хэрэглэхийг зөвшөөрөхгүй. Яагаад гэвэл муу зүйл хиймэгц түвшин доош унана, бясалгал чинь ч үр дүнгүй болно, иймээс маш олон ер бусын чадварууд түгжигддэг. Тэгвэл яах вэ? Гон нь нээгдэж гэгээрэх тэр өдөр, энэ үрэл нь тэсрэх бөмбөг шиг дэлбэрч бүх ер бусын чадварууд болон биен дэх бүх түгжээнүүд, бүх энергийн сүвнүүдийг бүгдийг нь нээнэ. “Пад” гээд

бүгдийг нь доргиож нээнэ, үрэл үүнд л хэрэглэгддэг. Лам хувраг нас барсны дараа цогцсыг нь чандарлахад “сарира” (сүвдан чулуунууд) үлддэг, зарим хүн үүнийг яс, шүд нь гэж ярьдаг. Яагаад энгийн хүнд энэ нь байдаггүй вэ? Энэ бол тэр үрэл дэлбэрсэн юм, түүний энерги нь гарч чөлөөлөгдсөн, тэдгээр нь дотроо өөр орон зайн их хэмжээний бодисыг агуулдаг, ямар боловч материалаг орших зүйлс юм, гэвч тэр нь ямар ч хэрэггүй. Одоогийн хүмүүс үүнийг их нарийн нандин зүйл гэж үздэг. Тэдгээр нь энергитэй, гялалзсан, маш хатуу, тийм л зүйл юм.

Гон өсөхгүй байхын бас өөр нэг учир шалтгаан байдаг, дээд түвшний Фа мэдэхгүй бол дээш бясалгаж чадахгүй. Энэ нь юу гэсэн үг вэ? Миний сая ярьсантай адил, зарим хүн их олон бясалгалаар хичээллэдэг, тэгвэл хэчнээн их сурсан ч нэмэргүй гэж би хэлье. Чи зөвхөн бага сургуулийн сурагч хэвээрээ л байна, бясалгалын бага сургуулийн сурагч гэсэн үг, тэдгээр нь бүгд доод түвшний зарчмууд юм. Чи доод түвшний зарчмаар дээд түвшин рүү бясалгахад энэ нь чамд ямар ч удирдах нөлөө үзүүлэхгүй. Хэрэв чи дээд сургуульд бага сургуулийн сурах бичгийг уншиж байгаа бол бага сургуулийн сурагч хэвээрээ л байна, хэчнээн их сурсан ч хэрэг болохгүй, харин ч бүр муу юм. Түвшин бүрд өөр өөрийн гэсэн Фа байдаг. Фа өөр өөр түвшинд өөр өөрийн удирдах нөлөөтэй байдаг учраас доод түвшний зарчим чамайг дээд түвшин рүү бясалгахад удирдаж чадахгүй. Цаашид бидний авч ярих зүйлс бол бүгд дээд түвшинд бясалгах зарчмууд, би өөр өөр түвшний зүйлүүдийг нэгтгэн ярьж байгаа, иймээс чиний цаашдын бясалгалд үргэлж удирдах нөлөөтэй байна. Надад хэд хэдэн ном, дуу болон дүрст бичлэгүүд байгаа, чи тэдгээрийг нэг удаа үзэж

эсвэл сонссоны дараа, хэсэг хугацаа өнгөрөөд дахин үзэхэд юм уу сонсоход чамайг бас л удирдах нөлөөтэй болохыг олж мэднэ. Чи бас өөрийгөө тасралтгүйгээр дээшлүүлж байгаа, мөн тэдгээр нь чамайг үргэлж удирдан чиглүүлэх болно, энэ бол Фа. Дээр дурсан зүйлс бол гон өсөхгүй байхын хоёр шалтгаан юм: Дээд түвшний Фа мэдэхгүй бол бясалгаж чадахгүй; дотогшоо бясалгахгүй буюу шиньшин-ээ бясалгахгүй бол гон өсөхгүй. Ийм л хоёр учир шалтгаантай.

### **Фалунь Дафа-гийн онцлог**

Манай Фалунь Дафа бол Буддын системийн 84 мянган бясалгалын үүдний нэг юм, бидний энэ удаагийн хүн төрөлхтний соёл иргэншлийн түүхэнд энэ нь нийтийн дунд хэзээ ч дэлгэрч байгаагүй, гэвч өнө эртний нэг үед дэлгэрч хүмүүсийг өргөнөөр аварсан. Би галавын төгсгөлийн хамгийн эцсийн энэ үед дахин үүнийг өргөнөөр тарааж байна, иймээс энэ нь туйлын нарийн нандин юм. Би Дэ шууд гон болж хувирах хэлбэрийг ярьсан. Гон-ыг үнэндээ дасгал хийж гаргадаг биш, харин бясалгалаар олж авдаг. Олон хүн гон-оо өсгөхийг хөөцөлддөг, гэхдээ зөвхөн яаж дасгал хийхийг л анхаардаг болохоос яаж бясалгахыг чухалчилдаггүй, үнэндээ гон бол шиньшин-ээ бясалгаснаар гардаг. Тэгвэл бид энд яагаад дасгал хийхийг бас заадаг вэ? Эхлээд лам хувраг яагаад дасгал хийдэггүй тухай ярь. Тэрээр гол нь бясалган сууна, ном судар уншина, шиньшин-ээ бясалгана, тэгээд гон нь өсдөг, түүний түвшин дээшлэхэд гон нь бас тэр өндөрт хүрнэ. Шагжамүни хорвоогийн бүх зүйлийг, тэр дундаа өөрийн бие махбодоо ч орхи гэж сургасан, иймээс биеийн дасгал хөдөлгөөн хэрэггүй болсон. Бумбын система

хамаг амьтныг аврах тухай ярьдаггүй. Тэдэнтэй янз бүрийн үзэл бодолтой болон түвшинтэй, зарим нь илүү хувиа хичээсэн, зарим нь арай гайгүй гэх мэт төрөл бүрийн хүмүүс учирдаггүй. Тэд өөрсдийн шавийг сонгодог, гурван шавь сонгосон бол тэдний зөвхөн нэгэнд нь л жинхэнэ уламжлан заана. Тухайн шавь нь өндөр ёс суртахуунтай, маш сайн тул асуудал гаргахгүй нь баттай байдаг. Тиймээс амь биеийг бясалгах арга барилын зүйлийг онцлон заана. Ер бусын чадвар, увдис гэх мэтийн зүйлсийг бясалгахад зарим дасгал хөдөлгөөн шаардлагатай байдаг.

Фалунь Дафа бол амь бие, сэтгэлийн хос бясалгал учраас дасгал хөдөлгөөн хийх шаардлагатай. Нэг талаар дасгал бол ер бусын чадварыг эрчимжүүлэхэд хэрэгтэй. Эрчимжүүлэх гэдэг нь ямар утгатай вэ? Энэ нь чиний ер бусын чадварыг өөрийн чинь хүчирхэг гон чадвараар хүчирхэгжүүлэх, улам бүр хүчтэй болгох юм; нөгөө талаар чиний биед бас маш олон амь бодийг хувиргаж гаргана. Дээд түвшинд бясалгахад, Бумбын системд мөнхийн нярай хүүхэд (Юань-инь) гардгийг ярьдаг, Буддын системд Очирваань сүйдэхгүй бие гэж ярьдаг, мөн их олон увдис чадварууд хувирч гарна. Эдгээр зүйлс бүгд дасгал хөдөлгөөний дүнд хувирч гардаг, дасгалын зорилго бол ийм л юм. Амь бие, сэтгэлийг хос бясалгах бүрэн цогц аргад бясалгах ч хэрэгтэй, бас дасгал хийх ч хэрэгтэй. Би та бүгдийг гон хэрхэн бий болдгийг ойлгосон байх гэж бодож байна, чиний түвшнийг жинхэнэ тодорхойлдог гон бол ердөө ч дасгалаар гардаггүй харин бясалгалаар гардаг. Чи бясалгалынхаа явцад энгийн хүмүүсийн дунд шиньшин-ээ дээшлүүлж, орчлон ертөнцийн мөн чанарт уусахад, орчлон ертөнцийн мөн чанар чамайг



хязгаарлахаа болиход чи дээшилнэ. Энэ Дэ гон-д хувирч эхэлнэ, шиньшин-ий шалгуур дээшлэх тусам гон дээшилдэг, ийм харилцан уялдаатай байдаг.

Бидний энэ цогц бясалгал бол жинхэнэ амь бие, сэтгэлийн хос бясалгалд харьяалагддаг, бидний бясалгаж гаргасан гон биеийн эс болгонд хадгалагдаад зогсохгүй мөн туйлын бичил түвшинд орших бие бодийн эх үүсвэр болсон хамгийн бичил ширхгүүд хүртэл бүгдэд нь энэ дээд энергийн бие бодь болох гон хадгалагддаг. Чиний гон хүч улам дээшлэхийн сацуу гон-ын нягтрал ба хүч нь улам нэмэгдэнэ. Энэ дээд энергийн бие бодь нь оюун сэтгэхүйтэй байдаг, энэ нь хүний биеийн эд эс бүрд хадгалагдахаас гадна амины эх үүсвэр хүртэл бүгдэд хадгалагдаж байдаг учраас аажмаар чиний биеийн эстэй адилхан хэлбэртэй болдог, молекулын үелэх дэс дараатай болон бүх атомын цөмүүдийн хэлбэртэй адилхан болдог. Гэхдээ мөн чанар нь өөрчлөгдөж, анхны махан биеийн эсээр бүтсэн бие байхаа больсон байна, чи таван махбодын хүрээнээс гарсан биш гэж үү? Мэдээж чиний бясалгал дуусаагүй байна, чи эгэл жирийн хүмүүсийн дунд бясалгасаар л байгаа болохоор гаднаа энгийн хүнтэй адил харагдана, ганц ялгаа нь гэвэл чи үе тэнгийнхнээсээ илүү залуу харагдана. Мэдээжийн хэрэг эхлээд чиний биен дэх муу зүйлсийг, тэр дундаа өвчнийг чинь авч хаях ёстой, гэвч бид энд өвчин эмчлэхгүй, бид чиний биеийг ариусгана, үүнийг өвчин эмчлэх гэж хэлдэггүй, биеийг ариусгах гэдэг, зөвхөн жинхэнэ бясалгадаг хүний биеийг ариусгаж өгнө. Зарим хүн зөвхөн өвчнөө эдгээх гэж ирдэг. Маш хүнд өвчтэй хүнийг бид хичээлд оруулахгүй, яагаад гэвэл тэд өвчнөө эдгээх гэсэн бодлоо орхиж чадахгүй, эсвэл өвчтэй гэсэн бодлоосоо салж чадахгүй.

Хүнд өвчтэй хүний бие нь их тавгүй байхад тэр энэ бодлоо орхиж чадах уу? Тийм хүн бясалгаж чадахгүй. Бид хүнд өвчтэй хүнийг хүлээж авахгүй гэж удаа дараа анхааруулж байсан, энэ бол бясалгал, тэдний бодож байгаагаас хэтэрхий хол юм, тэд өөр чийгон багшийг олоод энэ зүйлийг хийлгэж болно. Мэдээжийн хэрэг, маш олон сурагч өвчинтэй, чи жинхэнэ бясалгагч учраас бид чамд энэ зүйлийг хийж өгнө.

Бидний Фалунь Дафа-гийн сурагчид нэг хэсэг хугацаанд бясалгасны дараа гаднаас нь харахад их өөрчлөлт харагдана, арьс нь зөөлөрч, хацар нь ягаарч царай нь шингэрдэг, настай хүмүүсийн үрчлээс багасах болно, бүүр бага болдог, энэ бол нийтлэг үзэгдэл. Би энд байж болшгүй юм уу эсвэл санаанд багтамгүй зүйл ярьж байгаа юм биш, энд сууж байгаа манай олон хуучин сурагчид үүнийг бүгд мэднэ. Түүнчлэн настай эмэгтэйчүүдийн сарын тэмдэг ирэх болно, яагаад гэвэл амь бие, сэтгэлийн хос бясалгалд сарын юм ирэх нь амь биеийг бясалгахад хэрэгтэй. Сарын тэмдэг ирнэ, гэхдээ тийм их биш, энэ үе шатанд бага зэрэг байхад л хангалттай, энэ нь бас түгээмэл байдал юм. Эс бөгөөс, чи үүгээр дутвал яаж амь биеийг бясалгах юм? Эрэгтэй хүний хувьд хөгшин, залуугүй бүгд адилхан, бүх бие нь хөнгөрсөн мэт байдлыг мэдэрнэ. Жинхэнэ бясалгадаг хүний хувьд ийм өөрчлөлтийг мэдэрнэ.

Бидний энэ цогц дасгал маш аугаа зүйлсийг бясалгадаг, амьтдыг дуурайсан хөдөлгөөнтэй бусад олон дасгалуудаас маш их ялгаатай. Энэ дасгал асар том хүрээний зүйлсийг бясалгадаг. Шагжамүни болон Лаози нарын зааж байсан зарчмууд нь бүгд манай Тэнгэрийн заадас галактикийн хүрээн доторх зарчмууд л юм. Манай Фалунь Дафа юуг бясалгадаг вэ? Бидний

бясалгал орчлон ертөнцийн хувьслын зарчмын дагуу  
бясалгадаг, орчлон ертөнцийн хамгийн дээд мөн чанар  
болох Жэнь, Шань, Рэнь-ийн шалгуураар удирдуулан  
бясалгадаг. Бид ийм аугаа зүйлийг бясалгаж байгаа,  
орчлон ертөнцийг бясалгахтай адил юм.

Манай Фалунь Дафа бусад бүх бясалгалаас бас  
өөр нэгэн маш том онцлогтой. Одоо нийгэмд өргөн  
дэлгэрсэн чийгон бясалгалууд бүгд дань (үрэл)-ийг  
бясалгах замаар явдаг, дань-ийг бясалгадаг. Дань-ийг  
бясалгадаг чийгон нь энгийн хүмүүсийн дунд гон нь  
нээгдэж гэгээрэлд хүрэхэд маш хэцүү байдаг. Манай  
Фалунь Дафа дань-ийг бясалгах замаар явдаггүй,  
бидний энэ цогц бясалгал бол хэвлийн доод хэсэгт  
Фалунь-ийг бясалгадаг, би өөрөө лекцэд суугаа  
сурагчдад үүнийг суулгаж өгнө. Намайг Фалунь  
Дафа-г зааж байх зуур, бид та бүгдэд дараалан  
Фалунь-ийг суулгаж өгнө, зарим хүн үүнийг мэдэрнэ,  
зарим нь мэдрэхгүй. Ихэнх хүн мэдэрнэ, яагаад гэвэл  
хүн бүрийн биений байдал адилгүй. Бид Фалунь-  
ийг бясалгадаг, дань-ийг бясалгадаггүй. Фалунь бол  
орчлон ертөнцийн жижиг хувилбар, энэ нь орчлон  
ертөнцийн бүх уданс чадварыг агуулсан бөгөөд өөрөө  
автоматаар ажиллаж бас эргэж байдаг. Энэ нь чиний  
хэвлийд үүрд эргэж байх болно, чиний биед суулгасан  
цагаас хойш жилээс жилд ер зогсохгүй үүрд ингээд л  
эргэж байх болно. Тэр цагийн зүүний дагуу эргэхдээ  
орчлон ертөнцөөс энергийг автоматаар шингээж  
авахаас гадна өөрөө бас энергийг хувирган гаргаж  
чиний биений бүх хэсгийг хувьсан өөрчлөгдөхөд  
шаардлагатай энергиэр хангадаг. Мөн тэр цагийн  
зүүний эсрэгээр эргэхдээ энерги гаргана, биесэ  
хэрэгцээгүй бодисыг гадагшлуулах ба тэр нь биений  
эргэн тойронд сарниад алга болно. Тэрээр энергийг

гаргахдаа маш хол цацруулдаг, тэгээд шинэ энергийг дахин авчирна. Тэр цацарсан энерги нь чиний эргэн тойронд байгаа бүх хүмүүст ашигтай. Буддын система өөрийгөө аварна бас бусдыг аварна, бүх амийг аврахыг номлодог. Зөвхөн өөрийгөө бясалгаад зогсохгүй бас бүх амийг аварна гэдэг, бусдад ашиг тустай байдаг, чи санамсаргүйгээр өөр хүний биеийн хэвийн бус байдлыг нь засчихдаг, өвчнийг нь эдгээдэг гэх мэт. Мэдээж энерги алдагдахгүй, Фалунь цагийн зүүний дагуу эргэхдээ энергийг дахин хурааж авдаг, яагаад гэвэл энэ нь үргэлж зогсолтгүйгээр эргэдэг.

Зарим хүн, “яагаад энэ Фалунь зогсолтгүй эргэдэг юм бол?” гэж боддог. Зарим хүн надаас бас ингэж асуудаг, “Яаж тэр эргэлдэж чалдаг вэ? Түүний үндэслэл нь юунд байна?” Энергийн хуралтаар дань (үрэл) үүсдэг гэдгийг ойлгоход амархан, харин Фалунь-ий эргэлт нь ухаан санаанд багтамгүй гэдэг. Би та бүгдэд нэг жишээ хэлье, орчлон ертөнц хөдөлж байдаг, тэнгэрийн заадас галактик болон орчлон ертөнцийн бүх галактикууд бүгд хөдөлж байдаг, есөн гариг нарыг тойрон эргэдэг, дэлхий ч мөн тэнхлэгээ тойрон эргэж байдаг. Та бүгд боддоо, хэн тэдгээрийг түлхэж байна вэ? Хэн тэдгээрт хүч өгч байна вэ? Чи үүнийг энгийн хүний сэтгэхүйгээр ойлгож болохгүй, түүнд тийм л нэг эргэдэг механизм байдаг. Мөн бидний Фалунь бас адилхан, эргэдэг. Энгийн хүний амьдралын хэвийн нөхцөлд бясалгах асуудлыг шийдвэрлэж өгснөөр дасгал хийх хугацааг нэмэгдүүлж өгсөн. Үүнийг яаж нэмэгдүүлдэг вэ? Фалунь зогсолтгүйгээр эргэж байдаг учраас тасралтгүйгээр орчлон ертөнцөөс энергийг шингээн авч бас хувиргаж байдаг. Чи ажилтай байсан ч тэр чамайг бясалгаж байдаг. Мэдээж Фалунь-аас гадна бид чиний биед энергийн маш олон системийг,

механизмыг суулгаж өгнө, тэдгээр нь Фалунь-тай холбогдож автоматаар эргэн бас автоматаар хувиргаж байх болно. Иймээс энэ гон бол бясалгачний бүрэн автоматаар хувиргадаг, тэгэхлээр “гон хүнийг бясалгадаг” нийм нэг байдал үүсдэг, бас “Фа хүнийг бясалгадаг” гэдэг. Чи дасгал хийгээгүй байхад гон чамайг бясалгаж байдаг; дасгал хийж байхад гон бас л чамайг бясалгаж байдаг. Чи хоол идэж, унтаж, эсвэл ажил хийж байхад гон чамайг үргэлж хувиргаж байдаг. Тэгвэл чи юуны тулд дасгал хийж байгаа вэ? Чи дасгал хийж Фалунь-ийг эрчимжүүлж байгаа юм, мөн миний чамд суулгаж өгсөн тэдгээр систем болон энергийн механизмуудыг эрчимжүүлж өгдөг. Дээд түвшинд бясалгахад бүрэн үйлгүй (вүвэй) төлөв байдалд ордог, мөн дасгал хөдөлгөөн механизмын дагуу явагдана, ямар ч бодлоор удирдах, эсвэл амьсгалаа зохицуулах гэх мэтийн зүйлс байдаггүй.

Бид хэзээ, хаана дасгалаа хийхийг чухалчилдаггүй. Зарим хүн ингэж асуудаг, “Хэдэн цагт дасгалаа хийвэл хамгийн сайн бэ? Хулгана цагт уу, луу цагт уу, морь цагт уу?” Бид дасгал хийхэд ямар ч цагийн шаардлага тавьдаггүй. Чи хулгана цагт дасгал хийгээгүй байсан ч гон чамайг бясалгадаг; луу цагт дасгал хийгээгүй байсан ч гон бас чамайг бясалгадаг; чи унтаж байсан ч гон чамайг бясалгадаг; чи алхаж явсан ч гон чамайг бясалгадаг; ажлаа хийж байсан ч гон бас л чамайг бясалгаж байдаг. Энэ нь чиний бясалгах хугацааг их богиносгож өгсөн биш гэж үү? Та нарын олонх нь Бумбыг олох чин хүсэл эрмэлзэлтэй, энэ нь мэдээж бясалгалын зорилго. Бясалгалын эцсийн зорилго бол Бумбад хүрэх, гэгээрэх юм. Гэсэн хэдий ч зарим хүний амьдрах нас нь бага үлдсэн, амьдрах хугацаа нь бясалгал хийхэд магадгүй хүрэхгүй болсон байдаг, манай Фалунь

Дафа энэ асуудлыг шийдэж чадна, бясалгах явцыг богиносгоно. Түүнчлэн энэ нь амь бие, сэтгэлийн хос бясалгал учраас чи үргэлжлүүлэн бясалгавал амь насаа уртасгах болно, байнга бясалгах тусам амьдрах нас чинь үргэлж уртасна, төрөлхийн суурь сайтай настай хүмүүсийн хувьд үлдсэн хугацаа нь бясалгал хийхэд хүрэлцээтэй. Гэхдээ ийм нэг нөхцөл байдаг, чиний хувь тавилангийн амьдрах наснаас уртасгасан нас нь зөвхөн чиний бясалгалд зориулагдсан байдаг, хэрэв чиний бодол санаа жаахан л буруу хазайвал амь насны аюул гарна, яагаад гэвэл чиний амьдрах насны хугацаа аль хэдийн дуусчихсан байгаа. Гагцхүү Гурамсан ертөнцийн Фа-гийн бясалгалаас дээш гарсны дараа энэ хязгаарлалт байхгүй болно, тэр үед өөр нэг байдал гарна.

Бидэнд дасгал хийх зүг чигийн талаар болон дасгалаа яаж дуусгах талаар тавих шаардлага байдаггүй, яагаад гэвэл Фалунь үргэлж эргэж байдаг, үүнийг зогсоох боломжгүй юм. Хэрэв угас дуугарах юм уу хүн хаалга цохиход чи дасгалаа шууд зогсоогоод, очиж тэр зүйлийг хийж болно. Чи ямар нэг юм хийхээр дасгалаа зогсооход, Фалунь тэр дороо цагийн зүүний дагуу эргэж чиний биеэс гаргасан энергийг буцааж татаж авна. Хүн гараараа чийг-г толгойн орой руугаа оруулахад хэчнээн хичээсэн ч энэ нь алдагдана. Фалунь бол оюун сэтгэхүйтэй, тэр өөрөө эдгээр зүйлийг яаж хийхээ мэддэг. Бид бас зүг чигийг чухалд үздэггүй, яагаад гэвэл бүх орчлон ертөнц хөдөлж байдаг, тэнгэрийн заадас галактик хөдөлж байдаг, есөн гариг нарыг тойрон эргэдэг, дэлхий ч өөрөө эргэдэг. Бид орчлон ертөнцийн ийм аугаа зарчмын дагуу бясалгадаг. Хаана зүүн, өмнөд, баруун, эсвэл хойд зүг байдаг вэ? Хаана ч байхгүй. Аль ч зүг рүү харж дасгалаа

хийсэн бүх зүг рүү харж дасгалаа хийсэнтэй адилхан; аль зүг рүү ч харж хийсэн зүүн, өмнөд, баруун бас хойд зүг рүү зэрэг харж хийсэнтэй ялгаагүй. Бидний Фалунь Дафа сурагчдаа буруу хазайхаас хамгаална. Яаж хамгаалах вэ? Хэрэв чи жинхэнэ бясалгагч бол бидний Фалунь чамайг хамгаална. Миний үндэс орчлон ертөнцөд суурилсан, хэн чам руу халдаж чадна гэвэл тэр бас над руу халдаж чадна гэсэн үг, шулуухан хэлбэл тэр хүн орчлон ертөнцөд халдаж чадна гэсэн үг юм. Миний ярьсан зүйл төсөөлөхөд бэрх санагдаж магадгүй, гэхдээ чи цааш үргэлжлүүлэн суралцахад үүнийг ойлгох болно. Бас өөр маш гүн агуулгатай зүйлс бий, тэдгээрийг би хэлж болохгүй. Бид дээд түвшний Фа-г гүехнээс гүн рүү системтэйгээр дэлгэрэнгүй тайлбарлана. Чиний шиньшин зөв ариун байхгүй бол болохгүй, чи ямар нэг зүйлийг хүсвэл магадгүй асуудал гарна. Олон хуучин сурагчдын Фалунь гажсаныг би ажигласан. Яагаад вэ? Чи өөр зүйлүүдийг хольж хичээллэсэн, чи бусдын зүйлийг хүлээн зөвшөөрч авсан. Тэгвэл Фалунь яагаад чамайг хамгаалаагүй вэ? Чамд өгсөн бол энэ нь чиний зүйл, чиний бодол санаагаар захирагддаг. Чи юу хүсэж байна, түүнд хэн ч оролцохгүй, энэ бол орчлон ертөнцийн зарчим. Чи бясалгахыг хүсэхгүй бол хэн ч чамайг албадаж болохгүй, тэгвэл муу зүйл хийсэнтэй адил болно. Хэн чиний сэтгэлийг хүчээр өөрчилж чадах юм? Чи өөрөө өөртөө шаардлага тавих ёстой. Чи бясалгал болгоны сайн гэсэн бүхнийг сурна, хүн болгоны зүйлсийг хүлээж авна, өөрийнхөө өвчнийг арилгахын тулд өнөөдөр нэг бясалгалаар хичээллэж, маргааш нь нөгөөгөөр хичээллэнэ, чиний өвчин эдгэрсэн үү? Үгүй, өвчин зөвхөн хойшлогдсон. Дээд түвшинд бясалгахад нэг бясалгалдаа туушгтай байхыг шаарддаг,

түүндээ л бясалгана, ямар нэгэн бясалгалаар дагнавал тэр бясалгалаар төгс гэгээрэлд хүртлээ сэтгэлээ түүнд зориулах ёстой, зөвхөн үүний дараа л өөр бясалгалаар дахин бясалгаж болно, тэр нь өөр тогтолцооны зүйл байна. Яагаад гэвэл жинхэнэ уламжлагдан үлдсэн цогц зүйлс нь өнө эртний үеэс дамжин ирсэн байдаг, бүгд маш нарийн хувирах явцтай. Зарим хүн өөрийнхөө мэдрэмжээр бясалгадаг, чиний мэдрэмж гэж юу вэ? Юу ч биш. Жинхэнэ хувьсах явц нь өөр орон зайд явагддаг, энэ нь туйлын нарийн төвөгтэй бөгөөд гайхамшигтай, өчүүхэн ч алдаа гаргаж болохгүй, энэ нь нарийн тоног төхөөрөмжтэй адил, хэрэв чи дотор нь өөр хэрэгслийн сэлбэг тавьчихвал тэр дороо эвдэрнэ. Өөр орон зай болгонд байгаа чиний биест өөрчлөлт гарч байгаа, тэр нь ер бусын гайхамшигтай бөгөөд үүнд өчүүхэн ч алдаа гарч болохгүй. Би чамд бясалгал өөрөөс шалтгаалдаг, гон багшаас шалтгаалдаг гэж дээр хэлсэн. Бусад хүний зүйлийг чи дур мэдэн авч нэмбэл, гаднын мэдээлэл энэ бясалгалд саад болно, чи буруу зам руу орчихно, мөн энэ нь энгийн хүний нийгэмд илэрдэг, энгийн хүний төвөгтэй байдалд өөрийгөө оруулна, чи үүнийг өөрөө хүссэн учраас бусад нь хөндлөнгөөс оролцохгүй, энэ бол ухамсрын асуудал. Мөн нэмж оруулсан зүйлс чиний гон-ыг замбараагүй болгоно, чи цааш бясалгаж чадахгүй болно, ийм асуудал гардаг. Би та бүгдийг заавал Фалунь Дафа-г сур гэж байгаа юм биш. Чи Фалунь Дафа-г сурахгүй ч өөр чийгон бясалгалуудаас жинхэнэ уламжлан авбал би бас сайшаана. Гэхдээ би чамд хэлье, жинхэнэ дээд түвшин рүү бясалгахад нэг бясалгалдаа заавал туунштай байх ёстой. Би бас та нарт нэг зүйл хэлэх хэрэгтэй: Одоо надаас өөр жинхэнэ дээд түвшний бясалгал заан тарааж байгаа хоёрдогч хүн байхгүй. Миний чамд



юу хийж өгснийг чи хожим мэдэх болно, тиймээс чиний ухамсар битгий хэтэрхий дорой байгаасай гэж хүсэж байна. Маш олон хүн дээд түвшин рүү бясалгах хүсэлтэй байдаг, одоо энэ нь чиний өмнө бэлэн байна, харин чи үүнийг хараахан ухаараагүй байж мэднэ, чи Багш хайж хаа сайгүй явсан, их ч мөнгөө үрсэн, тэгээд ч олж чадаагүй. Өнөөдөр чиний үүдэнд хүргэж өглөө, чи магадгүй гадарлаа ч үгүй! Энэ бол ухамсарлах, ухамсарлахгүйн асуудал, бас өөрөөр хэлбэл аврагдах, аврагдахгүйн асуудал юм.

# Хоёрдугаар лекц

## Тэнгэрийн мэлмийн асуудал

Олон чийгон багш бас тэнгэрийн мэлмийн талаар ярьдаг, гэхдээ Фа өөр өөр түвшинд өөр өөрийн илрэх хэлбэртэй байдаг. Аль нэг түвшинд бясалгаж хүрсэн хүн зөвхөн тэр түвшнийхээ байдлыг л хардаг, түүнээс дээд түвшний үнэн байдлыг харж чадахгүй бас үнэмшихгүй, иймээс тэр зөвхөн өөрийнхөө түвшинд харсан зүйлийг л үнэн гэж үздэг. Түүний бясалгал дээд түвшинд хүрээгүй байхад тэдгээр зүйлийг оршдоггүй гэж үздэг, үнэмшихгүй. Энэ бол түвшнээс шалтгаалдаг, түүний бодол мөн дээшээ ахиж чадахгүй. Өөрөөр хэлбэл хүний тэнгэрийн мэлмийн талаар зарим нь ийм учиртай, зарим нь тийм учиртай гэж ярьдаг, улмаар будилаантуулсан, эцэст нь хэн ч үүнийг тодорхой тайлбарлаж чадаагүй, үнэндээ энэ тэнгэрийн мэлмийг доод түвшинд тодорхой ярих аргагүй. Урьд нь тэнгэрийн мэлмийн бүтэц нууцын нууцад харьяалагддаг байсан учраас энгийн хүмүүст үүнийг мэдүүлдэггүй байсан, тиймээс түүхийн туршид энэ талаар хэн ч хэзээ ч ярьж байгаагүй. Харин бид энд хуучны тэр онол дээр ярихгүй. Бид орчин үеийн шинжлэх ухаан болон хамгийн энгийн орчин үеийн хэллэгийг ашиглан үүнийг тайлбарлая, мөн үүний үндсэн асуудлыг ярья.

Бидний ярьж байгаа тэнгэрийн мэлмий нь үнэн хэрэгтээ хүний хоёр хөмсөгний дундаас жаахан дээш байрлах бөгөөд энэ нь тархины булцуут булчирхайтай холбогддог, энэ бол гол зам. Хүний биед бас маш олон нүд байдаг, Бумбын система 'чиао' болгоныг нэг нүд гэж ярьдаг. Бумбын система биен дээрх сүвийг

‘чиао’ гэж хэлдэг, харин Хятад эмчилгээнд үүнийг зүү эмчилгээний цэг гэдэг. Буддын системд арьсны нүх болгоныг нэг нүд гэж ярьдаг, иймээс зарим хүн чихээрээ юм уншиж чаддаг, гараараа юм уу дагзаараа харж чаддаг, бас зарим нь хөлөөрөө эсвэл гэдсээрээ хардаг. Энэ бүгд байж болно.

Тэнгэрийн мэлхийг ярихдаа, бид эхлээд хүний энэ хос махан нүдний талаар ярья. Одоо зарим хүн энэ хоёр нүдээр бидний энэ дэлхийн ямар ч бие бодийг, ямар ч биет зүйлсийг харж чаддаг гэж боддог. Иймээс зарим хүн зөвхөн энэ нүдээрээ харж чадах зүйлүүдийг л үнэн бодитой гэж үздэг зөрүүд үзэлтэй болсон; тэд харагдахгүй зүйлд итгэдэггүй. Урьд нь ийм хүнийг ухамсар дорой гэж үздэг байсан ч зарим хүн тэднийг яагаад ухамсар дорой гэж хэлж байгааг тодорхой тайлбарлаж чаддаггүй байсан. “Харагдахгүй бол итгэхгүй” гэсэн үгийг сонсоход зөв гэмээр. Гэхдээ арай дээд түвшнээс харахад энэ нь буруу байдаг. Цаг хугацааны орон зай болгон бүгд бие бодитор бүтээгдсэн байдаг, мэдээж өөр өөр цаг хугацааны орон зай болгон өөр өөрийн гэсэн бие бодийн бүтэцтэй ба янз бүрийн амь бодийн өөр өөрийн илрэх хэлбэртэй байдаг.

Би та бүгдэд нэг жишээ хэлье, Буддын пашинд хүн төрөлхтний нийгмийн бүх үзэгдлийг хуурмаг, бодит биш гэж үздэг. Яагаад хуурмаг үзэгдэл гэдэг вэ? Энд үнэхээр бодит биет байхад, хэн үүнийг хуурмаг зүйл гэнэ гэж? Бие бодийн орших хэлбэр нь ийм байдаг, гэхдээ түүний илрэх хэлбэр нь ийм байдаггүй. Бидний хоёр нүд энэ материаллаг орон зайнд байгаа биет зүйлсийг одоо бидний харж байгаа тогтворжуулсан байдлаар харагдуулдаг чадвартай. Үнэн хэрэгтээ эдгээр нь ийм байдалтай байдаггүй, бидний энэ орон зайд ч

бас ийм хэлбэрт байдаггүй. Жишээ нь микроскопоор хүний биеийг харвал ямар янзтай байх вэ? Бүх бие нь сийрэг сул, жижигхэн молекулуудаас тогтсон, яг элс шиг ширхэгтэй, хөдөлж байдаг, электрон атомын цөмийг тойрон эргэж байдаг, мөн бүх бие гүрвэлзэн хөдөлж байдаг. Биеийн гадаргуу нь өөгүй гөлгөр биш, бас жигд ч биш байдаг. Орчлон ертөнц дээрх бүх зүйлс, ган, төмөр мөн чулуу бүгд адилхан, тэдгээрийн доторх молекул элементүүд бүгд хөдөлж байдаг, чи тэр хэлбэрийг бүхэлд нь харж чадахгүй, үнэндээ тэр бүгд тогтвортой байдаггүй. Энэ ширээ гүрвэлзэн хөдөлж байгаа, гэвч чиний нүд үнэн байдлыг харж чадахгүй, энэ хоёр нүд хүнд ийм нэг буруу ойлголтыг өгдөг.

Бид бичил түвшний зүйлсийг харж чадахгүй гэж байгаа юм биш, хүнд ийм чадвар байхгүй гэсэн үг биш юм, харин хүн төрөлхийн ийм чадвартай байдаг, зохих бичил түвшин хүртэлх зүйлийг харж чаддаг. Бид энэ материалаг орон зайд ийм хоёр нүдтэй байгаа учраас энэ нь хуурамч дүрслэлийг өгдөг: үнэнийг харуулдаггүй. Иймээс урьд өмнө бясалгалын хүрээнд ярихдаа харж чадахгүй зүйлдээ итгэдэггүй хүнийг ухамсар дорой хүн, энгийн хүний хуурамч төсөөлөлд автсан, тэдний дунд төөрчихсөн хүн гэдэг байсан. Энэ бол шашинд үеэс үед яригдаж ирсэн үг, үүнийг бид бас үндэслэлтэй гэж үздэг.

Энэ хоёр нүд бидний энэ материалаг орон зайн зүйлсийг ийм тогтворжуулсан байдалд л харагдуулдаг, үүнээс өөр ямар ч онцын чадвар байхгүй. Хүн юм харахад тэр зүйл нүдэнд шууд дүрслэгддэггүй, нүд зургийн аппаратын линз шиг зөвхөн нэг хэрэгслийн үүрэгтэй юм. Холын юмыг харахад линз сунгагддаг шиг, бидний нүд ч гэсэн ийм нэг үүргийг гүйцэтгэдэг;

харанхуйд харахад хүүхэн хараа том болдог, аппаратаар харанхуйд зураг авахад түүний гэрлийн хаалт том онгойно, эс бөгөөс гэрэл цохилт хангалтгүй байвал хар зураг гарна; хүн гадагш их хурц гэрэлд гарахад хүүхэн хараа огцом агшдаг, үгүй бол нүд гялбаж юу ч тод харагдахгүй болно, зургийн аппарат бас ийм зарчмаар ажиллаж гэрлийн хаалт нь жижгэрдэг. Энэ нь дүрсийг татаж авах үүрэгтэй нэг хэрэгсэл л юм. Бид үнэн хэрэгтээ хүн юм уу аль нэг биетийн орших хэлбэрийг харахад тэр нь хүний тархинд дүрслэгддэг. Өөрөөр хэлбэл бидний нүдээрээ харж байгаа зүйлс тархины ард байрладаг булцуут булчирхайд харааны мэдрэлийн судлаар дамжин очиж тэнд дүрс болон тусгагддаг. Бодит тусгагдсан дүрс нь тархины булцуут булчирхайн энэ хэсэгт харагддаг гэсэн үг юм, орчин үеийн анагаах ухаан ч мөн үүнийг олж мэдсэн.

Бидний ярьж байгаа тэнгэрийн мэлмий нээгдэх гэдэг нь хүний харааны мэдрэлийн судлыг хэрэглэхийн оронд хүний хоёр хөмсөгний дунд нэг суваг нээгдэж булцуут булчирхай түүгээр шууд гадагш харахыг хэлнэ, үүнийг тэнгэрийн мэлмий нээгдэх гэдэг. Зарим хүн ингэж боддог: “Энэ бодитой биш байна, бидний энэ хоёр нүд ямар ч байсан нэг хэрэгслийн үүрэг гүйцэтгэдэг, энэ нь биетийн дүрсийг татан авч чаддаг, энэ нүд байхгүй бол бас боломжгүй.” Орчин үеийн анагаах ухааны задлан шинжилгээгээр булцуут булчирхайн урд хэсэг нь хүний нүдний бүрэн бүтцээс тогтсон болохыг нээсэн. Энэ нь хүний толгойн дотор байдаг учраас үүнийг ширгэсэн нүд гэж ярьдаг. Ширгэсэн нүд мөн үү биш үү гэдэгт бидний бясалгалын хүрээнд өөр тайлбар байдаг. Гэхдээ ямар боловч одоогийн анагаах ухаан аль хэдийн хүний тархины дунд хэсэгт нэг нүд байдгийг олж мэдсэн.

Бидний нээж өгдөг суваг нь яг энэ газар руу чиглэдэг, орчин үеийн анагаах ухаанд таньж мэдсэнтэй бүрэн нийцэж байгаа юм. Энэ нүд нь аливаа зүйлсийн болон бие бодийн үндсэн мөн чанарыг хардаг тул бидний энэ махан нүдтэй адил хуурамч дүрслэлийг хүнд өгдөггүй. Иймээс дээд түвшинд хүрсэн тэнгэрийн мэлмийтэй хүн бидний энэ орон зайг нэвтэрч өөр цаг хугацааны орон зайг хардаг, энгийн хүнд харагддаггүй тэр байдлыг харж чаддаг; доод түвшинд тэнгэрийн мэлмий нь нээгдсэн хүн нэвт харах чадвартай байдаг, хананы цаадах зүйлийг харах, хүний биенийг нэвт харах, ийм ер бусын чадвартай болдог.

Буддын системд тэнгэрийн мэлмий нээгдэхийг таван түвшинд хуваадаг: Махан нүд нээгдэх, Тэнгэрийн нүд нээгдэх, Билгийн нүд нээгдэх, Фа нүд нээгдэх, Буддын нүд нээгдэх. Энэ бол тэнгэрийн мэлмийн таван том түвшин бөгөөд түвшин болгон дотроо дээд, дунд бас доод гэж хуваагддаг. Бумбын системд есөн есийн наян нэгэн давхаргын Фа нүдний талаар ярьдаг. Бид та бүгдийн тэнгэрийн мэлмийг нээж өгнө, гэхдээ Тэнгэрийн нүдний нээгдэх түвшинд юм уу эсвэл түүнээс доогуур түвшинд нээж өгөхгүй. Яагаад вэ? Хэдийгээр чи энд бясалгал хийж эхэлсэн ч энгийн хүний түвшнээс дөнгөж эхэлж байгаа, бас маш олон энгийн хүний зууралдсан сэтгэлээсээ салаагүй байна. Хэрэв Тэнгэрийн нүдний нээгдэх түвшинд юм уу эсвэл түүнээс доод түвшинд нээж өгвөл энгийн хүний ер бусын чадвар гэж үздэг хананы цаадах зүйлийг харах, хүний биенийг нэвт харах чадвар чамд гарна. Хэрэв бид энэ ер бусын чадварыг өргөн хэмжээнд дэлгэрүүлж хүн бүрийн тэнгэрийн мэлмийг энэ түвшинд нээж өгвөл энгийн хүний нийгмийг ноцтойгоор үймүүлнэ, энгийн хүний нийгмийн

байдлыг эвдэнэ. Улсын нууцыг хадгалж чадахгүй; хүн хувцас өмссөн ч өмсөөгүйтэй адилхан; гэртээ байгаа хүнийг чи байшингийн гаднаас харчихна; гудамжинд явж байхдаа хонжворт сугалааны нэгдүгээр тохирлыг хараад сугалчихна. Ийм байж болохгүй! Та бүгд боддоо, нэг нэгээрээ бүгд Тэнгэрийн нүдний нээгдэх энэ түвшинд хүрвэл, үүнийг хүн төрөлхтний нийгэм гэх үү? Хүн төрөлхтний нийгмийг ноцтойгоор үймүүлэх байдал гарахыг огт зөвшөөрөхгүй. Би хэрвээ чиний тэнгэрийн мэлмийг энэ түвшинд үнэхээр нээж өгвөл, чи магадгүй тэр дороо чийгон багш болно. Зарим хүн урьд нь чийгон багш болохыг мөрөөддөг байсан, гэнэт тэнгэрийн мэлмий нь нээгдвэл хүний өвчнийг үзэж өгье гэнэ. Би тэгвэл чамайг буруу зам руу дагуулсан болох биш үү?

Тэгвэл би чамд ямар түвшинд нээж өгөх вэ? Би шууд Билгийн нүдний түвшинд нээж өгнө. Үүнээс дээд түвшинд нээж өгвөл чиний шиньшин хүрэхгүй, үүнээс доод түвшинд нээж өгвөл энгийн хүний нийгмийн байдлыг ноцтойгоор эвдэнэ. Билгийн нүдний түвшинд нээж өгвөл, чамд ханын цаадхыг юм уу хүний биеийг нэвт харах чадвар байхгүй, гэхдээ чи өөр орон зайнуудын орших байдлыг харж чадна. Энэ нь ямар давуу талтай вэ? Энэ нь чиний бясалгах итгэлийг бэхжүүлнэ, чи энгийн хүний харж чаддаггүй зүйлсийг харна, тэдгээр нь үнэхээр бодитоор оршдог болохыг ойлгоно. Одоо чи юмыг тодорхой харж чадсан ч, тодорхой харж чадахгүй ч чамд энэ түвшинд нээж өгнө, энэ нь чамд бясалгахад тустай. Дафа-гаар жинхэнэ бясалгаж байгаа хүн шиньшин-ээ дээшлүүлэх дээр өөртөө хатуу шаардлага тавьж хандах юм бол, энэ номыг уншсанаар адилхан үр дүнд хүрнэ.

Тэнгэрийн мэлмийн түвшнийг шийддэг зүйл нь юу вэ? Чамд тэнгэрийн мэлмий нээж өгсний дараа чи бүх юмыг харж чадна гэсэн үг биш, тийм биш юм, түүнд бас нэг түвшний ангилал байдаг. Тэгвэл энэ түвшнийг юугаар тодорхойлдог вэ? Гурван хүчин зүйл байдаг: Эхний хүчин зүйл нь хүний тэнгэрийн мэлмийд дотроос гадагшилсан заавал нэг орон байх ёстой, бид үүнийг охь чий гэдэг. Энэ нь ямар нөлөө үзүүлдэг вэ? Яг зурагтын дэлгэцтэй адил, хэрэв энэ нь фосфоргүй бол зурагт ассаны дараа зүгээр нэг чийдэнтэй адил зөвхөн гэрэл гаргана, дүрс байхгүй. Яагаад гэвэл фосфор байгаа болохоор дүрс тодрон гарч ирж байгаа юм. Мэдээжийн хэрэг, энэ жишээ тийм ч тохиромжтой биш, яагаад гэвэл бид юмыг шууд хардаг, зурагтад бол дүрс дэлгэцэн дээр гардаг, ерөнхийдөө ийм л утгатай юм. Энэ охь чий бол туйлын нандин, Дэ-гээс боловсорч гарсан бүр нарийн охь зүйлээс бүрддэг. Ер нь хүн болгоны охь чий өөр өөр байдаг, магадгүй арван мянган хүний дунд хоёр хүнийх л нэг түвшинд байгаа.

Тэнгэрийн мэлмийн түвшин бол бидний энэ орчлон ертөнцийн Фа-гийн шууд илрэл байдаг. Энэ бол ер бусын зүйл, хүний шиньшин-тэй салшгүй холбоотой, хүний шиньшин доогуур байвал, түүний түвшин бас доогуур байдаг. Шиньшин доогуур болсны улмаас хүний энэ охь чий их гээгдсэн байдаг; хэрэв энэ хүний шиньшин өндөр байвал, тэр бага наснаасаа эхлээд том болтлоо энгийн хүний нийгэмд алдар нэр, эд хөрөнгө, хүн хүний хоорондын зөрчил, хувийн ашиг хонжоо, хүний элдэв хүсэл сэтгэл энэ бүгдэд даруу ханддаг байснаас магадгүй түүний охь чий нь нэлээд сайн хадгалагдаж үлдсэн байдаг, иймээс тэнгэрийн мэлмий нь нээгдсэний дараа илүү тод харж чаддаг. Зургаагаас



доош насны хүүхдэд тэнгэрийн мэлмий нээгдвэл маш тод хардаг, бас нээгдэх нь их амархан, би нэг үг хэлэхэд л нээгдэнэ.

Энгийн хүн нийгмийн хүчтэй урсгалд бохирдох нь том будагтай торхонд орсонтой адил, хүмүүсийн зөв гэж үздэг зүйлс нь үнэндээ ихэнх нь буруу байдаг. Хүн болгон сайхан амьдрахыг хүсдэг биз дээ? Сайхан амьдрахын төлөө магадгүй бусдын эрх ашигт халдана, хувиа хичээсэн сэтгэлдээ автана, магадгүй бусдын ашиг орлогыг булаана, бусдыг дээрэлхэж бас хохирооно. Хувийн ашиг хонжооны төлөө энгийн хүмүүсийн дунд булаацалдаж тэмцэлддэг, энэ нь орчлон ертөнцийн мөн чанарын эсрэг болсон биш гэж үү? Тэгэхээр хүмүүсийн зөв гэж үздэг зүйлс нь зөв биш байж болно. Томчууд ер нь хүүхдийг сурган хүмүүжүүлэхдээ ирээдүйд энгийн хүний нийгэмд хөлийг нь олуулахын тулд багаас нь “Чи овжин байж сур” гэж сургадаг. Манай орчлон ертөнцийн жишгээс харвал “овжин байх” гэдэг нь хэзээнээс буруу юм, яагаад гэвэл бид байгалийн жамыг дага, хувийн ашгийг хөнгөн авч үз гэдэг. Тэр ингэж овжин байснаар, хувийн ашиг сонирхлынхоо төлөө зүтгэдэг. “Хэн чамайг дээрэлхэнэ, чи түүний багштай нь ярь, түүний эцэг эхтэй нь ярь”, “Газраас мөнгө олбол ав” гэж хүүхдэд сургадаг. Бага наснаасаа авхуулаад том болтлоо ийм зүйлийг их сурвал яваандаа түүний энгийн хүний нийгэмд амиа хичээсэн сэтгэл нь улам их болж бусдыг хонжиж Дэ-гээ алддаг.

Дэ, энэ бие бодийг алдахад устаж үгүй болдоггүй, харин өөр хүнд шилжин очдог, гэвч энэ охь чий алга болдог. Хэрэв хүн багаасаа насанд хүртлээ их овжин, үргэлж хувийн ашиг сонирхолд зууралдаж, зөвхөн

ашиг хонжоо хайдаг байсан бол, ер нь ийм хүний тэнгэрийн мэлмий нээгдсэн ч бараг л харахгүй, эсвэл тодорхой харж чадахгүй, гэхдээ үүнээс хойш энэ хэвээрээ байна гэж байгаа юм биш. Яагаад вэ? Яагаад гэвэл бид бясалгалын явцад үүссэн эх үндсэндээ буцаж үнэнд хүрэх гэдэг, тасралтгүйгээр бясалгаснаар охчий байнга нөхөгдөж, шинээр нөхөн сэргээгдэнэ. Иймээс шиньшин-дээ анхаарах ёстой, бид бүх талаараа дээшилж бүхэлдээ ахина гэдэг. Шиньшин дээшилбэл бусад бүх зүйлс дагаад дээшилнэ; шиньшин дээшлэхгүй бол тэнгэрийн мэлмийн охчий ч эргээд нөхөгдөхгүй, ийм л зарчимтай юм.

Хоёрдох хүчин зүйл нь хүн өөрөө бясалгахад, төрөлхийн суурь нь сайн байвал тэнгэрийн мэлмий нь нээгдэж болно. Ер нь зарим хүний тэнгэрийн мэлмий нээгдэнгүүт цочдог. Яагаад цочдог вэ? Яагаад гэвэл хүмүүс гол төлөв шөнө дундын үед, харанхуй нам гүм байхад дасгалаа хийдэг. Тэр бясалгаж байхдаа гэнэт нүднийх нь өмнө нэг том нүд байхыг хараад цочдог. Ингэж их айж цочсоноосоо болоод дахин бясалгал хийхээс зүрхшээдэг. Ямар аймаар юм бэ! Тийм нэг том нүд өөдөөс нь хараад анивчих нь маш тодорхой. Иймээс зарим хүн тэр нүдийг мангасын нүд гэдэг, бас зарим нь Буддын нүд гэх мэтээр хэлдэг, үнэндээ энэ бол чиний өөрийн нүд юм. Мэдээжийн хэрэг бясалгал өөрөөс шалтгаална, гон багшаас шалтгаална. Бясалгадаг хүний гон хувиргалтын бүхий л явц нь өөр орон зайнуудад маш нарийн төвөгтэй явагддаг, зөвхөн нэг орон зайд ч биш, харин бүх орон зайнуудад юм, орон зай болгоны биед өөрчлөлт гардаг. Чи үүнийг өөрөө хийж чадах уу? Хийж чадахгүй. Эдгээр зүйлсийг бүгдийг нь багш зохицуулдаг юм, үүнийг багш хийдэг, тийм ч учраас бясалгал өөрөөс шалтгаална,

гон багшаас шалтгаална гэж ярьдаг. Чи зөвхөн ийм хүсэлтэй, ингэж боддог байхад л болно, үнэндээ энэ зүйлийг багш хийж өгдөг.

Зарим хүн өөрсдөө бясалгаад тэнгэрийн мэлмийгээ нээдэг, бид үүнийг чиний нүд гэдэг, гэхдээ чи үүнийг өөрөө хувирган гаргаж чадахгүй. Зарим хүн багштай, багш чинь чиний тэнгэрийн мэлмий нээгдсэнийг хараад нэг нүдийг чамд хувиргаж гаргаж өгнө, үүнийг үнэн нүд гэдэг. Мэдээж зарим хүнд багш байхгүй, тэгэхдээ зам зуур тааралдсан багш байж болно. Буддын системд ингэж ярьдаг: Будда байхгүй газар гэж үгүй, хаа сайгүй байдаг, тэр хэмжээгээрээ олон байдаг. Зарим хүн бас ингэж хэлдэг: “Толгойноос гурван тохой өндөрт Бурхад байдаг”, энэ нь тэд тоололшгүй олон гэсэн үг. Замд таарсан нэгэн багш чамайг сайн бясалгаж тэнгэрийн мэлмий чинь нээгдсэн, гэхдээ нэг нүд байхгүй байгааг хараад чамд хувирган гаргаж өгнө, үүнийг мөн чамайг өөрөө бясалгаж гаргасанд тооцдог. Яагаад гэвэл хүнийг аврахад ямар ч болзол тавьдаггүй, үнэ өртөг асуухгүй, шан харамж авахгүй, алдар нэр хүсдэггүй, энгийн хүмүүсийн дундах үлгэр дуурайлтай хүмүүсийг бодвол хамаагүй өндөр ёс суртахуунтай байдаг, үүнийг бүхэлдээ нигүүлсэнгүй сэтгэлийн үүднээс үйлддэг юм.

Хүний тэнгэрийн мэлмий нээгдсэний дараа, ийм нэг байдал гардаг: Нүд гэрэлд их гялбаж цочром мэдрэмж төрдөг. Үнэндээ чиний нүдийг цочроосон юм биш, харин булцуут булчирхай цочирсноос чиний нүдэнд гялбах мэдрэмж төрдөг. Учир нь чамд энэ “нүд” хараахан байхгүй байгаа, чамд энэ нүдийг өгсний дараа, чиний нүд гялбахаа болино. Манай зарим бясаллагчид энэ нүдийг мэдэрдэг ба хардаг.

Энэ нь орчлон ертөнцтэй адил мөн чанартай учраас маш гэнэн цайлган, бас сонниуч байдаг, энэ нүд нь бас дотогшоо чиний тэнгэрийн мэлмий нээгдсэн үгүйг, юм харж чадах эсэхийг чинь магадалж хардаг, мөн дотогш чам руу хардаг. Энэ үед чиний тэнгэрийн мэлмий нээгдсэн юм, тэр чамайг харж байх үед гэнэт чи түүнийг хараад цочдог. Үнэндээ энэ бол чиний өөрийн нүд, чи үүнээс хойш энэ нүдээр юм харах болно, чамд энэ “нүд” байхгүй бол тэнгэрийн мэлмий нээгдсэн ч юм харж чадахгүй.

Гуравдах хүчин зүйл бол, түвшин дээшлэх тусам орон зай болгоны хооронд гарах ялгааны асуудал байдаг, энэ нь түвшнийг жинхэнэ тодорхойлдог зүйл юм. Хүнд юм харах гол сувгаас гадна бас олон дэд суваг байдаг. Буддын системд арьсан дахь хөлсний нүх бүрийг нүд гэдэг; Бумбын системд биенийн сүв (чиао) болгоныг нүд гэдэг, өөрөөр хэлбэл зүү эмчилгээний цэг болгоныг нүд гэж хэлдэг. Мэдээж тэдний ярьж байгаа нь Фа биен дээр хувирах нэг янзын хэлбэр учраас биенийнхээ аль ч хэсгээр харж болно.

Бидний ярьж байгаа түвшин үүнтэй адилгүй. Гол сувгаас гадна хөмсөг, зовхины дээгүүр, зовхины доогуур мөн шангэн цэг дээр хэд хэдэн гол дэд суваг бас байдаг. Эдгээр нь түвшин нэвтрэх асуудлыг шийддэг. Мэдээж ердийн бясалгадаг хүний хувьд энэ хэдэн газраар харж чадвал, энэ хүний түвшин аль хэдийн их өндөрт хүрсэн юм. Зарим хүн махан нүдээрээ бас харж чаддаг, тэр бас энэ хоёр нүдээ бясалгаж ер бусын чадварын янз бүрийн хэлбэртэй болгодог. Гэхдээ энэ нүдийг яаж сайн хэрэглэхийг мэдэхгүй бол, тэр үргэлж нэг юмыг харахдаа нөгөө юмыг хардаггүй, тийм байж бас болохгүй. Иймээс зарим хүн гол төлөв нэг нүдээрээ нэг

талыг, нөгөө нүдээрээ нөгөө талыг хардаг. Түүнчлэн энэ нүдний доогуур (баруун нүд) дэд суваг байдаггүй, яагаад гэвэл энэ бол Фа-тай шууд хамааралтай, хүмүүс муу зүйл хийхдээ баруун нүдээр харах дуртай, иймээс баруун нүдний доогуур дэд суваг байдаггүй. Энэ бол Гурамсан ертөнцийн Фа бясалгалын үед гардаг хэдэн гол дэд сувгууд юм.

Маш дээд түвшинд хүрэхэд буюу Гурамсан ертөнцийн Фа бясалгалаас гарсны дараа нэг янзын багц нүд бий болдог, өөрөөр хэлбэл нүүрний дээд хэсэгт нэг том нүд үүсдэг бөгөөд дотор нь тоолшгүй олон жижиг нүд байдаг. Зарим маш өндөр түвшний аугаа гэгээрэгчийн бясалгаж гаргасан нүд нь маш олон, нүүрээр нь дүүрэн байдаг. Бүх нүднүүд юмыг харахдаа том нүдээр дамжуулж хардаг, хүссэн бүхнээ харж чадна. Нэг харцаар л бүх түвшнийг бүгдийг нь хардаг. Одоогийн амьтан судлаачид болон шавж судлаачид ялаан дээр судалгаа хийдэг. Ялааны нүд маш том, микроскопоор харахад түүний дотор тоо томшгүй олон жижиг нүд байдаг, үүнийг багц нүд гэж нэрлэдэг. Маш өндөр түвшинд хүрэх үед ийм байдал гарч болно, Рулай түвшнээс олон дахин өндөрт хүрэхэд ийм байдал гарч болно. Гэхдээ энгийн хүн энэ нүдийг харж чадахгүй, ердийн түвшинд хүрсэн бясалгагч бас үүний оршин байгааг харж чадахгүй, тэр хүн зөвхөн энгийн хүнтэй адил харагддаг, яагаад гэвэл тэр нүд нь өөр орон зайд оршдог. Энэ нь түвшин нэвтрэхийг ярьж байгаа юм, өөрөөр хэлбэл өөр өөр орон зайд нэвтрэх асуудал юм.

Би тэнгэрийн мэлмийн бүтцийг ерөнхийд нь та бүгдэд ярилаа. Бид чиний тэнгэрийн мэлмийг гаднын хүчээр нээнэ, энэ нь хурдан бөгөөд амар. Намайг

тэнгэрийн мэлмийн талаар ярьж байх үед хүн болгоны духаар чангарч булчин нь агшиж дотогш татагдах мэт мэдрэмж төрнө. Ийм байдаг биз? Ийм л байдаг. Энд ирж чин сэтгэлээсээ Фалунь Дафа-г сурч байгаа хүн болгонд ийм мэдрэмж төрнө, дотогш дарах мэт гаднаас нөлөөлөх хүч нь нэлээд их. Би зориуд нэг гон гаргаж чиний тэнгэрийн мэлмийг нээж өгч байгаа, түүнчлэн бас Фалунь явуулж чиний тэнгэрийн мэлмийг засаж өгч байна. Би тэнгэрийн мэлмийн талаар ярьж байхдаа зөвхөн Фалунь Дафа-гаар бясалгадаг хүн болгонд нээж өгнө, гэхдээ хүн болгон тодорхой харж чадна гэж байгаа юм биш, бас хүн болгон харж чадна гэсэн үг биш, энэ нь чамаас өөрөөс чинь шууд хамаарна. Чи харж чадахгүй ч гэсэн зүгээр, аажим аажмаар бясалгаад л бай. Чи үргэлж түвшнээ дээшлүүлэх тусам аажмаар хардаг болно, бүдэг хардаг байснаа аажмаар тод хардаг болно. Гагцхүү чи бясалгаад л байвал, сэтгэл шулуудан бясалгаад л байх юм бол гээгдсэн бүхэн чинь нөхөн сэргээгдэх болно.

Чи өөрөө тэнгэрийн мэлмийг нээе гэвэл нэлээд хэцүү. Тэнгэрийн мэлмийг өөрөө нээх хэдэн хэлбэрийг ярья. Жишээлбэл та нарын зарим нь бясалган сууж байхдаа дух руугаа болон тэнгэрийн мэлмийгээ ажиглахад харанхуй, юу ч байхгүйг мэдэрдэг. Яваандаа тэр хүн духан дотор нь аажмаар цайрч байгааг мэдэрнэ. Нэг хэсэг хугацаанд бясалгасны дараа түүний дух нь аажмаар гэгээтэй болж байгааг мэдэрдэг, дараа нь улаан өнгөтэй болдог. Энэ үед тэр нь зурагтаар юм уу кинонд цэцгийн дэлбээ хоромхон зуур дэлгэрэхийг харуулдаг шиг дэлгэрнэ, ийм үзэгдэл гарах болно. Тэр улаан өнгө нэлэнхийдээ хавтгай байснаа гэнэт дунд нь товойж ирнэ, тэгээд үргэлжлэн дэлбээлнэ. Хэрэв чи үүнийг өөрөө бүрэн нээгдэж дуусахыг хүсвэл найм

эсвэл арван жил ч багадна, яагаад гэвэл тэнгэрийн мэлмий бүхэлдээ бөглөрсөн байдаг.

Зарим хүний тэнгэрийн мэлмий нь бөглөрөөгүй сувагтай байдаг, гэхдээ тэр бясалгал хийдэггүй учраас тэнд энерги байхгүй, иймээс тэр бясалгал хийхэд гэнэт нүдний нь өмнө нэг хар бөөрөнхий зүйл гарч ирнэ. Хэсэг хугацаанд бясалгасны дараа тэр аажмаар цагаарч дараа нь гэгээтэй болдог, эцэст нь гэгээ нь улам тодрон гэрэлтэж нүд гялбах мэт болдог. Зарим хүн, “Би нарыг харлаа” эсвэл “Би сарыг харлаа” гэдэг. Үнэндээ тэр нарыг ч хараагүй, сарыг ч хараагүй. Тэгвэл тэр юу харсан бэ? Энэ бол тэр суваг зам юм. Зарим хүний түвшин ахих нь харьцангуй хурдан байдаг, тэр нүдийг суулгаж өгсний дараа шууд харж чадна. Зарим хүний хувьд маш хэцүү, бясалгал хийхэд л түүнд нэг хонгилоор, эсвэл худаг шиг сувгаар гадагш гүйж байгаа юм шиг санагддаг, тэр ч байтугай унтаж байхдаа хүртэл гадагшаа гүйж байгаа мэт мэдэрдэг. Зарим нь морь унаад давхиж байгаа юм шиг, зарим нь нисэж байгаа мэт, заримд нь гүйж эсвэл машинаар давхиж байгаа юм шиг санагддаг, тэдэнд эцэст нь хүрч чадашгүй мэт байдаг, яагаад гэвэл өөрөө тэнгэрийн мэлмийг нээхэд маш хэцүү. Бумбын системд хүний биенийг нэг жижиг орчлон ертөнц гэж үздэг. Хэрэв нэг жижиг орчлон ертөнц юм бол та бүгд бодоод үз дээ, духнаас булцуут булчирхай хүртэл 108 мянган ли-гээс хол давна, тиймээс гадагшаа түвт давхисан ч эцэст нь хүрч чадашгүй мэт санагддаг.

Бумбын системд хүний биенийг нэг жижиг орчлон ертөнц гэж үздэг нь их утга учиртай. Гэхдээ бүтэц зохион байгуулалт нь орчлон ертөнцтэй төстэй гэсэн үг биш, мөн бидний энэ материаллаг орон

зайд байгаа биеийн орших хэлбэрийг ярьж байгаа юм биш. Орчин үеийн шинжлэх ухаанд танин мэдсэн бодит биеийн эснээс доош ямар төлөв байдал байдаг вэ гэдгийг бид ярья. Молекулын төрөл бүрийн бүрэлдэхүүн хэсгүүд байдаг, молекулаас жижиг бол атом, протон, атомын цөм, электрон мөн кварк байдаг, одоогийн судлагдсанаар хамгийн бичил ширхэг бол нейтрино. Тэгвэл хамгийн, хамгийн бичил ширхэг гэж юу байдаг вэ? Үүнийг судлахад маш хэцүү. Шагжамүни амьдралынхаа сүүлийн жилүүдэд ийм нэг үг хэлсэн байдаг: “Гадаргуу нь хязгаар үгүй уудам, доторх нь хязгаар үгүй бичил.” Утга нь юу вэ? Рулай түвшнээс харахад, том нь орчлон ертөнцийн зах нь харагдашгүй; жижиг нь бие бодийн хамгийн бичил ширхэг нь харагдашгүй, тиймээс тэр “Гадаргуу нь хязгаар үгүй уудам, доторх нь хязгаар үгүй бичил” гэж хэлсэн.

Шагжамүни бас гурван мянган хорвоо ертөнцийн тухай ярьсан. Тэрээр манай орчлон ертөнцөд, манай галактикт бидний хүн төрөлхтөнтэй адил бодит биетэй амь боднуд оршдог гурван мянган гаригс байдаг гэж хэлсэн. Тэр бас нэг элсний ширхэгт ийм гурван мянган хорвоо ертөнц байдаг гэж хэлсэн. Нэг ширхэг элс нь нэг орчлон ертөнцтэй адил, дотор нь бидэнтэй адил оюун ухаант хүмүүс амьдардаг төдийгүй од гаригс, уул ус, гол мөрөн оршдог. Энэ нь төсөөлшгүй мэт сонсогдож болох юм! Хэрэв тийм бол, та бүгд бодоод үз дээ, дотор нь бас элс байна биз дээ? Тэр элсний ширхэгт бас гурван мянган хорвоо ертөнц байна биз дээ? Тэгвэл тэр гурван мянган хорвоо ертөнцөд бас л элс байна биз дээ? Тэр элсний ширхэгт бас л гурван мянган хорвоо ертөнц байна биз дээ? Тиймээс Рулай түвшинд үүний төгсгөл нь харагдаагүй.



Молекулаас тогтсон хүний эсийн хувьд ч мөн адил. Хүмүүс орчлон ертөнц хэр том бэ гэж асуудаг, би та бүхэнд хэлье, энэ орчлон ертөнц өөрийн гэсэн зах хязгаартай, Рулай түвшинд үүнийг зах хязгааргүй, хэмжээлшгүй уудам гэж үздэг. Түүнчлэн хүний биеийн дотор тал нь молекулаас эхлээд бичил түвшин рүү, бичил ширхгүүд хүртэл энэ орчлон ертөнцтэй адил том байдаг, энэ нь төсөөлшгүй мэт сонсогдож болох юм. Хүн болон алив нэг амийг бүтээхэд түүний амины бүтцийн онцгой элементүүд болон үндсэн мөн чанар нь туйлын бичил түвшинд аль хэдийн бүрэлсэн байдаг. Иймээс бидний орчин үеийн шинжлэх ухаан энэ зүйлийг судлахад маш хол хоцорсон, орчлон ертөнц даяарх гаригууд дээр орших өндөр оюун ухаант амь бодигдтай харьцуулахад манай хүн төрөлхтний шинжлэх ухаан, технологийн түвшин маш их доогуур юм. Бид нэг газарт, нэгэн зэрэг оршиж буй өөр орон зайнуудыг танин мэдэж ч чадаагүй байхад харь гаригийн нисдэг тавгууд шууд өөр орон зайнуудын хооронд аялж орж гарч чаддаг, тэдний цаг хугацааны орон зайн ухагдахуун нь огт өөр байдаг, иймээс тэд хүссэн цагтаа хүний төсөөлшгүй хурдаар хэдийд ч ирж, буцаж чаддаг.

Бид тэнгэрийн мэлхийн талаар ярихад ийм нэг асуудал гарч ирдэг: чи хонгилоор гадагш гарц руу гүйхэд, чамд энэ нь хязгаар төгсгөлгүй мэт санагдана. Зарим хүн магадгүй өөр нэг байдлыг хардаг: тэдэнд хонгилоор гүйж байгаа юм шиг санагддаггүй, харин эцэс төгсгөлгүй урт замаар урагшаа гүйж байгаа мэт мэдэрдэг, замын хоёр талаар уул, ус бас хот сууринууд байдаг, үргэлж гадагш гүйгээд л байна, үүнийг сонсоход бүр ч төсөөлөхийн аргагүй байж магадгүй. Би нэг чийгөн багш ингэж хэлж байсныг санаж байна: Хүний

арьсан дахь хөлсний нүхэн дотор хот байдаг, тэнд галт тэрэг, машинууд явж байдаг гэж хэлсэн. Үүнийг сонссон хүнд гайхмаар төсөөлшгүй мэт санагддаг. Та бүгд бие бодийн бичил ширхгүүд болох молекул, атом, протон байдгийг мэднэ, цааш нь судалбал, хэрвээ чи түвшин болгонд тухайн түвшний давхаргыг, өөрөөр хэлбэл түүний аль нэг цэгийг биш бүхэл давхаргыг нь харж чадвал, молекулын түвшний давхаргыг, атомын түвшний давхаргыг, протон түвшний давхаргыг болон атомын цөмийн түвшний давхаргыг харвал, өөр өөр орон зайн орших хэлбэрүүдийг харах болно. Аливаа биет, тэр дундаа хүний бие, бүгд сансар ертөнцийн орон зайн түвшнүүдтэй холбогдон зэрэгцэн оршиж байдаг. Бидний орчин үеийн физикт бие бодийн бичил элементүүдийг судлахдаа зөвхөн нэг ширхэг бичил элементийг задлан шинжилдэг, атомын цөмийг хуваагдсаны дараа түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг судалдаг. Хэрэв энэ түвшний бүх атомын бүрэлдэхүүн хэсэг эсвэл молекулын бүрэлдэхүүн хэсгүүдийн оршихуйг бүхэлд нь харах боломжтой ямар нэгэн төхөөрөмж байвал, энэ дүр зургийг харж чадвал, чи энэ орон зайг нэвтэрч бусад орон зайнуудын орших үнэн байдлыг харах болно. Хүний бие нь гаднах орон зайнуудтай зохилдсон холбоотой байдаг, тэр бүгд ийм орших хэлбэртэй.

Өөрөө тэнгэрийн мэлмийг нээхэд өөр өөр байдал гардаг, бид хамгийн нийтлэг үзэгдлүүдийн талаар голчлон ярилаа. Зарим хүн тэнгэрийн мэлмий нь эргэж байна гэж хардаг, Бумбын системийн чийгон-оор бясалгагч тэнгэрийн мэлмий дотор нь ямар нэгэн зүйл эргэж байгааг байнга хардаг. Тайжи таваг “пад” хийн хагарсны дараа дүрс түүнд харагдана. Гэхдээ түүний толгой дотор Тайжи байгаа юм биш, түүний багш

анхнаасаа олон зүйлийг суулгаж өгсөн болохоор тэр юм, үүний нэг нь Тайжи. Багш нь түүний тэнгэрийн мэлмийг хаачихдаг, нээгдэх цаг нь болоход Тайжи хагарч нээгддэг. Багш үүнийг зориуд ингэж зохицуулж өгдөг, түүний толгойд анхандаа байсан зүйл биш юм.

Бас зарим хүн тэнгэрийн мэлмийг нээхээр хөөцөлддөг, гэвч их хичээх тусам нээгдэхгүй, учир нь юу вэ? Тэр өөрөө ч мэдэхгүй. Гол учир нь тэнгэрийн мэлмийг хүсэж болдоггүй юм, хүсэх тусам нээгдэхгүй. Үүнийг улам их хүсэх тусам тэр нээгдэхгүйгээс гадна бас түүний тэнгэрийн мэлмий дотроос хар ч биш цагаан ч биш нэг зүйл гарч тэнгэрийн мэлмийг нь бүрхдэг. Удаан үргэлжлэх тусам хүрээ нь томордог, улам их гарч улам ихээр хуримтлагдана. Тэнгэрийн мэлмий бүр ч нээгдэхгүй, их хүсэх тусам энэ зүйл нь улам ихээр урсан гарч эцэст нь түүний бүх биеийг бүрхэн их зузаан том орныг үүсгэдэг. Энэ хүний тэнгэрийн мэлмий үнэхээр нээгдсэн ч тэр харж чадахгүй, яагаад гэвэл түүний зууралдсан сэтгэлээс болж энэ нь таглагддаг. Гагцхүү тэр ирээдүйд үүнийг дахин бодохоо боливол, энэ зууралдсан сэтгэлээ бүрмөсөн орхивол тэр нь аажмаар арилна, гэхдээ маш зүдэрч урт хугацаанд бясалгаж байж үүнийг арилгана, ингэх хэрэг байхгүй. Зарим хүн үүнийг ойлгодоггүй, багш нь түүнд үүнийг хүсэж болохгүй, хөөцөлдөж болохгүй гэсээр байтал тэр итгэхгүй үргэлж хүссэн хэвээрээ л байна, эцэст нь үр дүн нь эсрэгээр эргэдэг.

### **Далдыг харах ер бусын чадвар**

Тэнгэрийн мэлмийтэй шууд холбоотой нэг ер бусын чадвар бол далдыг харах чадвар юм. Зарим хүн ингэж ярьдаг: “Би энд сууж байгаад Бээжингийн байдлыг, Америкийн байдлыг мөн дэлхийн нөгөө талыг харж

чадна.” Зарим хүн үүнийг ойлгодоггүй, бас шинжлэх ухааны үүднээс ч тайлбарлах боломжгүй юм, яаж ингэж хардаг вэ? Зарим хүн үүнийг ингэж ч нэг тайлбарлаж тэгж ч нэг тайлбарлаад учрыг нь хэлж чаддаггүй, хүн яаж ийм чадвартай болдог байна гэж гайхдаг. Энэ нь тийм биш юм, Гурамсан ертөнцийн Фа-гийн түвшинд бясалгаж байгаа хүнд ийм чадвар байхгүй. Түүний харж байгаа нь, далдыг харах болон бусад олон ер бусын чадваруудыг оролцуулан бүтд нэг тодорхой орон зайд үйлчилдэг. Цаад зах нь манай хүн төрөлхтний орших энэ материаллаг орон зайн хүрээнээс хэтрэхгүй, ер нь өөрийнхөө орон зайн хүрээнээс ч хэтрэхгүй.

Тодорхой нэг орон зайд хүний бие нэг хүрээтэй байдаг. Энэ хүрээ нь Дэ-гийн хүрээтэй адилгүй, нэг орон зайд оршдоггүй гэхдээ хүрээний хэмжээ нь ижилхэн. Энэ хүрээ нь орчлон ертөнцтэй зохилдсон холбоотой байдаг, орчлон ертөнцөд оршдог юм бүхэн түүний энэ хүрээнд тусгагдаж байдаг, бүх зүйлс тусгагдаж болно. Энэ бол нэг хэлбэрийн дүрс, гэхдээ бодит биш юм. Жишээлбэл Дэлхийд Америк улс байдаг, Вашингтон хот байдаг, түүний энэ хүрээн дотор Америк улс болон Вашингтон хот тусгагдана, тэгэхдээ тэдгээр нь зүгээр дүрс л юм. Хэдийгээр энэ нь тусгагдсан дүрс ч гэсэн бие бодийн орших нэг хэлбэр, тэнд болж байгаа өөрчлөлтийг даган тусгагдсан дүрс нь бас даган өөрчлөгддөг, иймээс зарим хүний ярьдаг далдыг харах ер бусын чадвар нь өөрийн орон зайн хүрээн доторх зүйлийг л харж байгаа хэрэг юм. Хүн Гурамсан ертөнцийн Фа бясалгалаас гарсны дараа ингэж харахгүй болно, тэр шууд харна, үүнийг Буддын Фа-гийн ер бусын чадвар гэдэг, тэр бол зүйрлэшгүй их сүр хүчтэй.

Гурамсан ертөнцийн Фа-д далдыг харах ер бусын чадвар гэж ямар учиртай вэ? Би та бүхэнд тайлбарлая: Энэ хүрээний орон зайд хүний духан дээр толь байдаг. Бясалгал хийдэггүй хүний толь өөр лүү нь харсан байдаг; харин бясалгал хийдэг хүний толь эсрэг харсан байдаг. Хүний далдыг харах ер бусын чадвар гарах гэж байх үед толь нь нааш цааш эргэдэг болно. Тасралтгүй жигд хөдөлгөөнтэй зураг гаргахын тулд киноны хальс секундэд 24 кадрын хурдтай эргэдэг гэдгийг та бүхэн мэднэ, хэрэв 24 кадраас бага хурдтай гаргавал дүрс үсчин харагддаг. Толины эргэх хурдны хэмжээ нь нэг секундэд 24 кадраас ч илүү байдаг бөгөөд тусгаж авсан дүрсээ эргүүлж чамд харуулдаг, дахин буцаж эргэхэд дүрс арчигдана. Дараа нь дахин тусгаж, дахин эргэж, дахин арилгана, ингэж тасралтгүйгээр эргэдэг учраас чиний харж буй зүйл хөдөлгөөнд байдаг, энэ нь чиний өөрийн орон зайн хүрээн доторх зүйлсийг тусгаж чамд харуулдаг, харин энэ орон зайд байгаа зүйлс нь том орчлон ертөнцтэй зохилдсон холбоотой байдаг.

Тэгвэл хүн биеийнхээ ард байгаа зүйлийг яаж харах вэ? Ийм жижигхэн толиор яаж биеийн эргэн тойрныг бүгдийг нь тусгаж чадах юм? Тэнгэрийн мэлмий нь тэнгэрийн нүд нээгдэх түвшнээс дээгүүр нээгдэж билгийн нүд нээгдэх түвшинд ойртоход бидний энэ орон зайг нэвтрэх байдалд ордгийг та бүхэн мэднэ. Яг энэ үед, энэ орон зайг нэвтрэхийн даваан дээр тэнгэрийн мэлмийд нэг өөрчлөлт гардаг: Бодит орших зүйлсийг харахад тэр бүгд алга болдог, хүмүүс болон хана алга болдог, бүх зүйлс байхгүй болдог, ямар ч материаллаг зүйлс оршихоо болино. Өөрөөр хэлбэл улам лавшруулж харахад энэ тусгай тогтсон орон зайд хүн оршдоггүй болохыг мэднэ, зөвхөн нэг толь л чиний орон зайн хүрээн дотор

босоогоор байдаг. Түүнчлэн чиний орон зайн хүрээн дэх энэ толь нь чиний бүхэл орон зайтай адилхан том хэмжээтэй, иймээс нааш цааш эргэхдээ бүх зүйлийг хаана ч байсан тусгаж байдаг. Энэ нь чиний орон зайн хүрээн дотор орчлон ертөнцөөс тусгагдсан бүгдийг чамд харуулж өгч чадна, энэ бол бидний ярьж байгаа далдыг харах ер бусын чадвар юм.

Хүний бие судлаачид энэ ер бусын чадварыг шалгаж тогтоохдоо үүнийг ер нь амархан үгүйсгэдэг. Үүнийг үгүйсгэдэг шалтгаан нь: жишээлбэл, хэн нэгний Бээжин дэх хамаатныг юу хийж байгааг нь асуухад, түүний нэр болон ерөнхий байдлыг хэлсний дараа тэр харна. Түүний байр нь ямар янзтай, үүдээр нь яаж ордог, өрөөн доторх тавилга нь ямар болохыг хэлсэн. Бүгдийг нь зөв хэлсэн. Тэр хүн одоо юу хийж байна? Тэр хүн юм бичиж байна гэсэн. Энэ хэлснийг батлахын тулд түүний хамаатан руу угасдаж асууна, “Чи одоо юу хийж байна?”, “Би хоол идэж байна.” Гэтэл энэ нь түүний харсантай таарахгүй байгаа юм биш үү? Урьд нь ийм шалтгаанаас болж энэ ер бусын чадварыг үгүйсгэдэг байсан, гэвч тэр орчин байдлыг нь огтхон ч алдаагүй хэлсэн. Яагаад гэвэл бидний энэ орон зай ба цаг хугацаа, бидний хэлдгээр цаг хугацааны орон зай нь ер бусын чадвар оршиж байгаа тэр орон зайнаас цаг хугацааны хувьд зөрөөтэй байдаг, хоёр талын цаг хугацааны ухагдахуун нь өөр байдаг. Тэр арай өмнөхөн юм бичиж байсан, одоо хоол идэж байна, ийм л цагийн зөрөөтэй. Иймээс хүний бие судлаачид энгийн онолын үүднээс харж одоогийн шинжлэх ухааны дагуу зүйчлэн бодож судалбал дахиад арван мянган жил болсон ч үр дүнд хүрэхгүй. Яагаад гэвэл эдгээр нь энгийн хүний зүйлээс давсан зүйл

учраас хүн үзэл баримтлалдаа эргэлт хийх хэрэгтэй, эдгээр зүйлсийг дахин ингэж ойлгож болохгүй.

## **Өнгөрсөн ба ирээдүйг харах ер бусын чадвар**

Тэнгэрийн мэлмийтэй шууд холбоотой бас нэг ер бусын чадвар байдаг, үүнийг өнгөрсөн ба ирээдүйг харах чадвар гэдэг. Одоо дэлхийд зургаан төрлийн ер бусын чадвар нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, үүнд тэнгэрийн мэлмий, далдыг харах, мөн өнгөрсөн ба ирээдүйг харах чадвар багтдаг. Өнгөрсөн ба ирээдүйг харах чадвар гэж юу вэ? Энэ нь хүний ирээдүйг болон өнгөрснийг мэдэх чадвар юм; энэ чадвар нь хүчтэй бол нийгмийн өсөлт болон уналтыг мэдэж чадна; бүр хүчтэй бол тэнгэрийн өөрчлөлтийн зүй тогтлыг ч харж чадна, энэ бол өнгөрсөн болон ирээдүйг мэдэх ер бусын чадвар юм. Яагаад гэвэл бие бодь тогтсон зүй тогтлын дагуу хөдөлдөг, онцгой нэг орон зайд аливаа бие бодийн бусад маш олон орон зай болгонд орших хэлбэрүүд нь байдаг. Жишээ хэлье, хүний бие хөдлөхөд биесийн эд эсүүд бүгд дагаад хөдөлдөг, мөн түүнчлэн бичил түвшин дэх бүх молекул, протон, электрон, маш бичил ширхгүүд болон бүх элементүүд бас дагаад хөдөлж байдаг. Гэхдээ тэдгээр нь өөрийн бие даасан орших хэлбэртэй байдаг, мөн өөр өөр орон зайд орших биесийн хэлбэрт ч бас өөрчлөлт явагддаг.

Бид бие бодийг устдаггүй гэж ярьсан биз дээ? Тусгай тогтсон нэг орон зайд хүний хийсэн зүйл, өөрөөр яривал гараа хөдөлгөж ямар нэгэн зүйл хийхэд, энэ бүгд нь материаллаг оршихуйтай байдаг, хийсэн бүхэн нь дүрс болон мэдээллийг үлдээдэг. Өөр орон зайд тэр устахгүй, үүрд тэнд үлддэг, ер бусын чадвартай хүн өнгөрсөн үеийн дүрс мэдээллийг хараад юу болсныг мэддэг. Ирээдүйд чи өнгөрсөн ба ирээдүйг мэддэг

чадвартай болсны дараа өнөөдөр миний энд лекц уншиж байгааг харахад энэ хэвээр оршсоор байх болно, энэ нь аль хэдийн тэнд зэрэгцэн оршиж байдаг. Хүн төрөхөд цаг хугацааны ухагдахуун байдаггүй нэг онцгой орон зайд түүний энэ насны амьдрал нь аль хэдийн зэрэгцэн оршиж байдаг, зарим хүний хувьд түүний нэг бус насны амьдрал нь тэнд оршиж байдаг.

Зарим хүн ингэж бодож магадгүй юм: Тэгвэл бид өөрсдийнхөө чармайлтаар өөрийгөө өөрчлөх шаардлагагүй болсон юм биш үү?! Тэд үүнийг хүлээн зөвшөөрч чаддаггүй. Үнэндээ өөрийн чармайлтаар амьдралын жижиг зүйлийг өөрчилж болно, зарим жижиг зүйлийг өөрийн тэмцлээр өөрчилж болно. Гэхдээ чи юмыг хүчилсний дүнд өөрчилсөн болохоор магадгүй энэ нь нүгэл болно, тийм биш бол нүгэл үйлдэх асуудал байхгүй болно, бас сайн үйл хийх, муу үйл хийх ч асуудал байхгүй болно. Хүн ингэж зүтгэснээр бусдын эрх ашгийг хохироож муу зүйл хийдэг. Иймээс бясалгалд үргэлж байгалийн жамыг дагахыг шаарддаг, ийм л зарчимтай, яагаад гэвэл өөрийнхөөрөө зүтгэснээс болж хүнийг хохирооно. Хэрэв чиний амьдралд анхнаасаа байхгүй, нийгэм дэх өөр хүнд хамааралтай зүйлийг авсан бол чи тэр хүнд өртэй болдог.

Энгийн хүн том үйл явдлыг үндсэндээ өөрчилж чадахгүй. Үүнийг өөрчлөх нэг зам бий, энэ нь тэр хүн үргэлж муу зүйл хийхэд, хийхгүй муу зүйл гэж байхгүй бол тэр өөрийнхөө амьдралын замыг өөрчилж болно, гэхдээ тэр хүн бүрмөсөн устахад хүрнэ. Дээд түвшний үүднээс авч үзвэл хүн нас барахад сүнс нь устдаггүй. Сүнс яагаад устдаггүй вэ? Үнэндээ бидний харснаар хүн нас барсны дараа шарил хадгалах газарт тавьсан



цогцос нь зөвхөн бидний энэ орон зайд байгаа хүний биений эсүүд л юм. Хүний дотоод эрхтнүүдийн эсүүд, биен доторх янз бүрийн эд эсүүд, хүний бүхэл бие болох энэ орон зайны эд эсүүд салан үлддэг. Харин молекул, атом, протон гэх мэт бүр бичил материалаг элементүүдээс тогтсон өөр орон зайн биес нь огт үхдэггүй, тэдгээр нь бусад орон зайнуудад болон бичил түвшний орон зайнуудад оршсоор байдаг. Мөн аль муу болгоныг хийдэг хүний бүх эс нь бүрмөсөн задран устахад хүрдэг, Буддын шашинд үүнийг бие, сүнс бүгд устах гэдэг.

Хүний амьдрах насыг өөрчлөх өөр нэг арга зам байдаг, энэ цорын ганц зам бол хүн энэ цагаас хойш бясалгалын замаар явах юм. Яагаад бясалгалын замаар явахад хүний амьдрах насыг өөрчилж болдог вэ? Ийм зүйлийг хэн тийм амархан өөрчилж чадна гэж? Учир нь энэ хүн бясалгалын замд орохыг хүссэн даруйд ийм бодол нэг гарахад л алт шиг гялалзаж арван зүгийн хорвоог доргиодог. Буддын систем дэх орчлон ертөнцийн ухагдахуунд арван зүгийн хорвоо гэсэн сургаал байдаг. Дээд төрлийн амь бодийн харснаар хүний амь нь зөвхөн хүн байхын тулд байдаггүй. Тэрээр хүний амь бол орчлон ертөнцийн орон зайд үүссэн, орчлон ертөнцтэй ижил мөн чанартай, энэрэнгүй бөгөөд Жэнь, Шань, Рэнь гэсэн бие боднос бүтсэн гэж үздэг. Гэхдээ амь бодигд бас нийгмийн харилцааг үүсгэдэг, олон нийтийн дунд нийгмийн харилцаа үүсэхэд зарим нь муу болж улмаар доод түвшин рүүгээ унадаг; тэр түвшиндээ дахин байж чадахгүй улам муу болоход, дахин доодох түвшин рүүгээ унадаг; тэд ийнхүү үргэлжлэн унан унасаар эцэст нь энгийн хүний энэ түвшинд унаж ирдэг.

Энэ түвшинд унасан хүн уг нь устгагдах ёстой, бүрмөсөн устдаг, гэхдээ тэдгээр аугаа гэгээрэгчид нигүүлсэнгүй сэтгэлийн үүднээс зориуд ийм нэгэн орон зайг бий болгосон, бидний хүн төрөлхтний нийгмийн энэ орон зай юм. Энэ орон зайд түүнд хүний нэмэлт нэг махан биенийг, мөн зөвхөн энэ материалааг орон зайн зүйлсийг харж чадах хязгаарлагдмал хос нүдийг өгсөн, өөрөөр хэлбэл төөрөгдлийн дунд унаж ирсэн хүнд орчлон ертөнцийн үнэн байдал болон бусад бүх орон зайд харагддаг зүйлсийг харуулахгүй. Төөрөгдлийн дунд ийм нөхцөлд түүнд нэг боломж өгсөн. Яагаад гэвэл төөрөгдлийн дунд байгаа учраас хамгийн ихээр зовлонтой байдаг, мөн ийм биетэй байхад хүнд зовлонг амсуулдаг. Хэрэв хүн энэ орон зайнаас дээш гарч буцаж чадвал, үүнийг Бумбын система ярьдгаар эх үндсэндээ буцаж үнэнд хүрэх гэдэг, түүнд бясалгах сэтгэл төрвөл Буддын чанар нь гарсан гэсэн үг, энэ сэтгэлийг маш их нандин гэж үздэг тул хүмүүс түүнд туслах болно. Энэ хүн ийм зовлонтой орчинд төөрчхөөгүй бас буцах хүсэлтэй байгаа учраас түүнд тусална, ямар ч болзолгүйгээр тусална, юугаар ч хамаагүй тусална. Яагаад бид энэ зүйлийг бясалгаж байгаа хүнд хийж болдог, харин энгийн хүнд хийж болдоггүй вэ гэдэг нь ийм учиртай юм.

Тэгвэл зөвхөн өвчнөө л эдгээх хүсэлтэй энгийн нэг хүнд бид юугаар ч тусалж чадахгүй, энгийн хүн бол энгийн л хүн, энгийн хүн энгийн хүний нийгмийн байдалд нийцсэн байх ёстой. Олон хүн Будда бүх амийг аварна, Буддын системд бүх амийг аварна гэж ярьдаг биз дээ гэдэг. Би чамд хэлье, чи Буддын бүх судрыг сөхөөд үз, энгийн хүний өвчнийг эдгээнэ гэдэг нь бүх амийг аварч байгаа хэрэг гэж хаана ч бичээгүй. Сүүлийн хэдэн жилүүдэд тэдгээр хуурамч чийгон

багш нар энэ зүйлийг бусниулсан. Тэдгээр анх зам тавьж өгсөн жинхэнэ чийгон багш нар бусад хүний өвчнийг эдгээ гэж ерөөсөө чамд хэлээгүй, тэд зөвхөн өөрөө дасгалаа хийгээд өвчнөө эдгээ, биеэ сайжруул гэж л заасан. Чи бол энгийн хүн, хэдхэн өдөр үүнийг заалгаад яаж өвчин эдгээж чаддаг болох юм? Энэ нь хүнийг залилж байгаа хэрэг биш үү? Зууралдсан сэтгэлийг чинь улам дэвэргэж байгаа юм биш үү? Энэ бол алдар нэр, ашиг сонирхол болон энгийн хүмүүсийн дунд гайхуулахын тулд ер бусын зүйлийг эрэлхийлэх явдал юм! Үүнийг огт зөвшөөрөхгүй. Иймээс зарим хүн юмыг хөөцөлдөх тусам түүнд улам олдохгүй, чамайг ингэхийг зөвшөөрөхгүй, чамайг бас энгийн хүний нийгмийн байдлыг хамаагүй эвдэхийг зөвшөөрөхгүй.

Энэ орчлон ертөнцөд ийм нэг зарчим байдаг, чи өөрийнхөө эх үндсэндээ буцаж үнэнд хүрэхийг хүсвэл бусад нь чамд тусална, тэд хүний амь бол энгийн хүмүүсийн дунд байхын тулд биш харин эх үндсэндээ буцах ёстой гэж үздэг. Хүн төрөлхтнийг элдэв өвчнөөс ангижруулж, ая тухтай амьдруулбал, чамайг Бурхан болооч гэсэн ч чи сонирхохгүй. Өвчин зовлонгүй, бас хүний хүссэн юм бүхэн нь байвал ямар сайхан байх бол, яг л Бурханы орон шиг. Гэхдээ чи муу болсноос энэ түвшинд унаж ирсэн, иймээс чи таатай байх боломжгүй. Хүн төөрөгдлийн дунд муу зүйл хийх нь амархан байдаг, Буддын шашинд үүнийг үйлийн үрийн хариу гэдэг. Тиймээс зарим хүнд гай зовлон, золгүй явдал тохиолдож байгаа нь тэд өөрсдийн үйлийн үрийн хариуны улмаас нүглээ төлж буй хэрэг юм. Буддын шашинд Будда нар хаа сайгүй байдаг гэдэг. Нэгхэн Будда гараа нэг далахад л бүх хүн төрөлхтний өвчнийг арилгаж чадна, энэ бол туйлын

боломжтой юм. Ийм олон Будда байдаг атал яагаад хэн нь ч үүнийг хийдэггүй вэ? Тэр хүн урьд нь муу зүйл хийсэн учраас энэ зовлон зүдүүрийг амсаж байгаа юм. Хэрэв чи түүнийг эдгээчих юм бол, энэ орчлон ертөнцийн зарчмыг эвдэж байгаатай адил бөгөөд хүн муу зүйл хийж бусдад өртэй болоод төлөхгүй байж болно гэсэнтэй ижил, тиймээс үүнийг зөвшөөрөхгүй. Хэн боловч энгийн хүний нийгмийн байдлыг сахин хамгаалдаг, хэн ч үүнийг эвддэггүй. Бясалгал бол өөрийгөө таатай өвчингүй байлгах, жинхэнэ ангижрах зорилгодоо хүрэх цорын ганц зам! Хүнийг ариун Фагаар бясалгуулах нь бүх амийг жинхэнэ утгаараа аварч байгаа хэрэг юм.

Зарим хүн, “Энэ олон чийгон багш нар өвчнийг яаж эдгээж чадаж байна вэ? Тэд яагаад өвчин эдгээх талаар ярьдаг вэ?” гэж боддог байж магадгүй, гэхдээ тэдгээр чийгон багш нарын ихэнх нь зөв замынх биш. Жинхэнэ чийгон багш бясалгалынхаа явцад хамаг амьтан зовж байгааг нь хараад энэрэнгүй сэтгэл, өрөвдөх сэтгэлийн улмаас бусдад тусалдаг, үүнийг бол зөвшөөрнө. Гэхдээ тэр өвчнийг эдгээж чадахгүй, өвчнийг зөвхөн түр зуур намдаадаг; эсвэл хойшлуулдаг, одоо өвчин байхгүй болсон ч хожим буцаж ирнэ, энэ өвчнийг хойшлуулдаг; эсвэл чиний төрөл төрөгсдийн биед шилжүүлдэг. Харин чиний энэ нүглийг бүрмөсөн арилгана гэвэл тэр хийж чадахгүй, энгийн хүнд үүнийг хамаагүй хийж өгөхийг зөвшөөрөхгүй, харин зөвхөн бясалгаж байгаа хүнд бол болно. Ийм л зарчимтай.

Буддын шашны сургаал дахь хамаг амьтныг аврах гэдэг үгийн утга нь: чамайг эгэл жирийн хүмүүсийн хамгийн зовлонтой байдлаас гаргаж дээд түвшинд хүргэх гэсэн үг юм, чи үүрд зовлон зүдүүр амсахгүй

болно, ангижирна, ийм л утгатай юм. Шагжамүни нирвааны нөгөө эргийн тухай ярьсан биз дээ? Энэ бол хамаг амьтныг аврах гэдгийн жинхэнэ утга нь юм. Чи энгийн хүмүүсийн дунд жаргалтай, маш их мөнгөтэй, ор нь хүртэл мөнгөөр дэвсгэгдсэн мөн ямар ч гай зовлонгүй байвал чамайг бурхан бол гэсэн ч чи үгүй гэнэ. Бясалгадаг хүний хувьд чиний амьдралын замыг өөрчилж өгч болно, зөвхөн бясалгавал л үүнийг өөрчилж өгнө.

Өнгөрснийг ба ирээдүйг харах ер бусын чадварын хэлбэр нь духандаа нэг телевизийн жижигхэн дэлгэцтэй байхын адил. Зарим хүнд энэ нь духан дээр нь; заримд нь духных нь ойролцоо байдаг; бас зарим хүний духан дотор нь байдаг. Зарим хүн нүдээ аньж юмыг хардаг; хэрэв энэ чадвар нь хүчтэй бол зарим хүн нүдээ анихгүйгээр юмыг харж чаддаг. Гэхдээ өөр хүнд харагдахгүй, энэ бол түүний орон зайн хүрээнд байгаа зүйлс юм. Өөрөөр хэлбэл энэ ер бусын чадвар гарсны дараа өөр орон зайнуудын үзэгдлийг тусгаж өгөх бас нэг зөөгчийн үүрэгтэй ер бусын чадвар байдаг учраас тэнгэрийн мэлмийд харагддаг. Хүний ирээдүйг болон өнгөрснийг маш тодорхой хардаг. Мэрэг төлгөөр яаж сайн үзсэн ч жижиг үйл явдлууд болон тэдгээрийн нарийвчлалыг хэлж чадахгүй, харин ийм хүн юмыг маш тодорхой хардаг, он жил цаг хугацааг хүртэл хэлж чаддаг. Өөрчлөлтийн нарийвчлалууд бүгд харагддаг, яагаад гэвэл түүний харж байгаа нь өөр өөр орон зай дахь хүний эсвэл аливаа зүйлсийн бодит тусгал юм.

Гагцхүү Фалунь Дафа-г бясалгах юм бол, тэнгэрийн мэлмийг хүн болгонд нээж өгнө. Тэгэхдээ бидний сүүлд ярьсан ер бусын чадваруудыг нээж өгөхгүй. Чиний түвшин тасралтгүй дээшлэхийн сацуу,

өнгөрснийг болон ирээдүйг харах ер бусын чадвар жамаараа гарч ирнэ, чиний цаашдын бясалгалын явцад энэ байдал гарна. Энэ чадвар бий болоход чи юу болж байгааг мэддэг болно. Иймээс бид энэ Фа болон зарчмуудыг ярилаа.

## **Таван махбодод үл орших ба Гурамсан ертөнцөөс гарах нь**

“Таван махбодод үл орших ба Гурамсан ертөнцөөс гарах” гэж юу гэсэн үг вэ? Энэ бол ярихад их хурц асуудал. Урьд нь олон чийгон багш энэ асуудлыг ярихад чийгон-д итгэдэггүй хүмүүсийн “Та нарын хэн нь бясалгаад таван махбодоос гарсан, хэн нь Гурамсан ертөнцөд оршихгүй болсон бэ?” гэсэн асуултад гацдаг байсан. Зарим хүн чийгон багш биш ч өөрсдийгөө чийгон багш гээд өргөмжилчихсэн байдаг. Тодорхой тайлбарлаж чадахгүй бол дуугүй байсан нь дээр, гэвч тэд энэ талаар ярьж зүрхэлдэг, тэгээд хүмүүсийн асуултад амаа таглуулдаг. Энэ нь бясалгалын хүрээнд их том хохирол учруулсан, маш том будилаан тарьсан, зарим хүмүүст энэ нь чийгон руу дайрах шалтаг болсон. Таван махбодод үл орших ба Гурамсан ертөнцөөс гарах гэдэг бол бясалгалын хүрээнд яригддаг, энэ нь шашнаас эх сурвалжтай, шашнаас гаралтай юм. Иймээс бид энэ асуудлыг түүхэн эх сурвалж болон тэр үеийн байдлаас салгаж ярьж болохгүй.

Таван махбодод үл орших гэдэг нь юу гэсэн үг вэ? Хятадын эртний физик болон орчин үеийн физикийн ухаанд хоёуланд нь Хятадын таван махбодын онолыг зөв гэж үздэг. Төмөр, мод, ус, гал болон шороо гэсэн таван махбодоос бидний орчлон ертөнцийн бүх зүйлс бүрэлдсэн гэдэг үнэн, тиймээс бид энэ таван махбодын онолын талаар ярья. Таван махбодоос гарсан хүн гэдэг

нь одоогийн хэллэгээр бол бидний энэ материалаг дэлхий ертөнцөөс гарсан гэсэн үг, сонсоход их учир битүүлэг. Та бүгд нэг асуудлыг бодоод үз, чийгон багш нарт гон байдаг. Би туршилтад оролцсон, бусад олон чийгон багш нар бас ийм туршилтад оролцож энергиэ хэмжүүлсэн. Гон-д байдаг материалаг элементүүдийг бидний өнөөгийн олон багаж төхөөрөмжөөр илрүүлж болдог, өөрөөр хэлбэл тийм багаж төхөөрөмж байвал чийгон багшаас гардаг элементүүд нь гон болохыг илрүүлж болдог. Орчин үеийн хэмжих багажууд хэт улаан туяа, хэт ягаан туяа, хэт нам дууны долгион, хэт өндөр дууны долгион, цахилгаан, соронзон хүч, гамма цацраг, атом болон нейтроныг илрүүлж чаддаг. Чийгон багш нарт эдгээр бие боднуд бүгд байдаг, бас чийгон багшаас гардаг зарим бодисыг хэмжин тогтоож чаддаггүй, яагаад гэвэл тийм багаж хэрэгсэл байхгүй. Тийм багаж хэрэгсэл байвал бүгдийг илрүүлж болно, чийгон багшийн гаргадаг бодисууд маш их баялаг болох нь тогтоогдсон.

Онцгой нэг соронзон орны нөлөөн дор чийгон багш их хүчтэй маш гоё аура (солонгон бүрхүүл)-г гаргаж чаддаг. Гон-ы хүч нь өндөр байх тусам гаргасан энергийн хүрээ нь улам том байдаг. Мөн энгийн хүнд бас аура байдаг, гэхдээ энэ нь маш бага хэмжээтэй, сул гэрэлтдэг. Дээд энергийн физикийн судалгааны эрдэмтэд энергийг нейтрон, атом гэх мэт бие боднос бүрддэг гэж үздэг. Олон чийгон багш бүгд хэмжүүлсэн, нэлээд нэртэй чийгон багш нар оролцсон. Намайг бас хэмжсэн, миний цацруулсан гамма туяа ба халуун нейтроны хэмжээ энгийн бодисын цацруулах хэмжээнээс 80-170 дахин их байсан. Энэ үед хэмжих багажийн зүү хамгийн дээд цэгтээ хүрээд зогссон, зүү нь эцэстээ тулсан болохоор эцсийн хэмжээг тогтоож

чадаагүй. Хүнд ийм их хүчтэй нейтрон байдаг гэдэгт үнэмшмээргүй! Хүн яаж ийм хүчтэй нейтроныг гаргаж чаддаг вэ? Энэ нь чийгон багш нар бидэнд гон оршдог, энерги байдаг гэдгийг баталж байна, шинжлэх ухаан технологийн хүрээнд нотлогдсон юм.

Таван махбодоос гарахад амь бие сэтгэлийн хос бясалгал байхыг шаарддаг, амь бие сэтгэлийн хос бясалгал биш бол зөвхөн хүрсэн түвшний өндөр намын дагуу гон-ыг өсгөдөг. Амь биеийг бясалгадаггүй бясалгалд энэ асуудал байхгүй, таван махбодоос гарах тухай ярихгүй. Амь бие, сэтгэлийн хос бясалгал хийхэд энерги биеийн бүх эсэнд хадгалагддаг. Бидний жирийн бясалгадаг хүн болон дөнгөж гон нь өсөж байгаа хүний гаргасан энергийн ширхгүүд нь том, хоорондоо их завсартай нягт биш байдаг, иймээс хүч нь маш сул. Түвшин өндөрсөх тусам энергийн нягт жирийн усны молекулуудаас зуу дахин, мянга дахин эсвэл зуун сая дахин их болох бүрэн боломжтой. Яагаад гэвэл түвшин өндөр болох тусам энерги улам нягтарч, улам нарийн ширхэгтэй болдог, мөн хүч нь ч улам ихэсдэг. Ийм байдал дор энерги биеийн эс болгонд хадгалагддаг, зөвхөн энэ материаллаг орон зайн бидний биеийн эс болгонд хадгалагдаад зогсохгүй мөн бусад орон зайнууд дахь бүх биед, молекул, атом, протон, электрон болон туйлын бичил эсүүдэд хүртэл бүгдэд нь энэ энерги хадгалагддаг. Лажимдаа хүний бие нь энэ дээд энергийн бие бодитор бүрэн дүүрдэг.

Энэхүү дээд энергийн бие бодь нь сүнслэг бөгөөд чадвартай. Энэ нь олширч улам нягтрах ба хүний биеийн бүх эсүүдэд дүүрсний дараа хамгийн чадваргүй эс болох хүний махан биеийн эсийг хязгаарладаг. Эсүүд хязгаарлагдмагц бодисын солилцоо явагдахгүй



болно, эцэст нь хүний махан биеийн эсүүд бүрмөсөн солигдоно. Мэдээж энэ нь ярихад амархан ч, энэ хүртэл бясалгахад удаан явцтай. Бясалгалын энэ үе шатанд хүрэхэд чиний биеийн бүх эсүүд энэ дээд энергийн бие боднор бүрэн солигдсон байна. Тэгвэл бодоод үз дээ, чиний бие таван махбодоос бүрдсэн хэвээр байна гэж үү? Энэ нь бидний энэ орон зайн бие бодь мөн хэвээр гэж үү? Тэр аль хэдийн бусад орон зайнуудаас цуглуулсан дээд энергийн бие бодиос бүрдсэн байдаг. Дэ-гийн элементүүд нь мөн өөр орон зайд оршдог бие бодь юм, тэдгээр нь бас бидний энэ орон зайн цаг хугацааны хүрээнд хязгаарлагдахгүй.

Одоогийн шинжлэх ухаан цаг хугацаанд орон оршдог гэж үздэг, хэрэв тухайн цаг хугацааны орон зайн хүрээн дотор байхгүй бол тэр цаг хугацаанд хязгаарлагдахгүй. Бусад орон зайн цаг хугацаа ба орны ухагдахуун нь биднийхтэй адилгүй, тиймээс эндхийн цаг хугацаа яаж өөр орон зайны бие бодийг хязгаарлах юм? Үндсэндээ ямар ч нөлөө байхгүй. Та бүгд бодоод үз дээ, энэ үед чи таван махбодод оршихгүй болсон юм биш үү? Чиний бие энгийн хүний бие хэвээр байна гэж үү? Огт тийм биш болно. Гэхдээ нэг зүйлийг хэлэхэд энгийн хүнд ямар ч ялгаа харагдахгүй. Түүний бие өөрчлөгдөөд ийм хэмжээнд хүрсэн ч бясалгал дуусаагүй байгаа, тэр бас үргэлжлүүлэн түвшнээ ахиулан дээш бясалгах хэрэгтэй, иймээс тэр энгийн хүмүүсийн дунд бясалгах ёстой, хүмүүст тэр харагдахгүй байж болохгүй.

Тэгвэл дараа нь яах вэ? Хэдийгээр бясалгалын явцад түүний молекулын эсүүд дээд энергийн бие боднор солигдсон ч атомуудын жагсах дэс дараалал, мөн молекулууд болон атомын цөмийн жагсах дэс

дараалал өөрчлөгдөхгүй. Эсийн молекулын жагсах дэс дараалал нь хүрэхэд зөөлөн; ясны молекулын жагсах дэс дараалал нь илүү нягт учраас хүрэхэд хатуу; цусны молекулын нягтрал нь бага учраас энэ нь шингэн байдаг. Энгийн хүн чиний өөрчлөлтийг гаднаас чинь хараад мэдэхгүй, эсийн молекулуудын бүтэц ба жагсах дэс дараалал хуучинтай адил, бүтэц нь өөрчлөгдөөгүй ч доторх энерги нь өөрчлөгдсөн, иймээс энэ хүн үүнээс хойш жам ёсоороо хөгшрөхгүй, түүний эд эсүүд нь үхэхгүй учраас тэр үүрд залуу хэвээр үлдэнэ. Бясалгалын явцад хүн залуу харагддаг эцэст нь тэнд нас нь тогтчихдог.

Мэдээж энэ бие нь машинд мөргүүлбэл магадгүй яс нь хугарна, хутгаар зүсвэл бас цус гарна. Яагаад гэвэл түүний молекулын жагссан дэс дараалал нь өөрчлөгдөөгүй, зөвхөн жам ёсоороо үхэхгүй, жам ёсоороо хөгшрөхгүй, бодисын солилцоо явагдахгүй, үүнийг бид “таван махбодоос гарах” гэж хэлдэг. Энд юуны мухар сүсэг байгаа юм? Шинжлэх ухааны зарчмаар ч үүнийг тайлбарлаж болно. Зарим хүн тодорхой тайлбарлаж чадахгүйгээс хамаагүй ярьдаг, тэгээд хүмүүс тэднийг мухар сүсгийг дэвэргэж байна гэдэг. Яагаад гэвэл энэ үг шашнаас гаралтай, бидний орчин үеийн чийгон-оос гарсан хэллэг биш.

Гурамсан ертөнцөөс гарах гэдэг нь юу гэсэн үг вэ? Би тэр нэг өдөр гон өсгөх гол түлхүүр бол бид шиньшин-ээ бясалгаж орчлон ертөнцийн мөн чанарт уусах явдал гэж хэлсэн, тэгвэл орчлон ертөнцийн мөн чанар чамайг хязгаарлахгүй болно, чиний шиньшин дээшлэхэд Дэ-гийн элемент гон болж хувирдаг. Энэ нь тасралтгүйгээр нэмэгдэж дээш өснө, улмаар дээд түвшинд хүрсний дараа гон багана үүсгэдэг. Энэ

гон багана хэр өндөр байна, чиний гон түвшин тэр өндөрт байна. Ийм нэг үг байдаг: Дафа (Аугаа Хууль) бол хязгааргүй, бясалгал бүхэлдээ чиний сэтгэлээс шалтгаална, чиний хэр өндөр бясалгаж чадах нь чиний тэвчээрээс, хүнд бэрхшээлийг даван туулах чадвараас чинь шалтгаална. Чи өөрт байгаа цагаан бие бодно бүрэн хувиргаж дуусвал, хар бие бодно зовлон туулах явцад бас цагаан бие бодь болгон хувиргаж болно. Тэр нь бас л хангалттай биш бол, чи бясалгал хийдэггүй найз нөхдийнхөө юм уу гэр бүлийнхнийхээ нүглийг нь даавал чиний гон бас өснө. Энэ бол маш өндөрт бясалгаж хүрсэн хүний тухайд ярьж байна. Чи энгийн нэг хүний хувьд бясалгаж байгаа болохоор ойр дотнынхоо хүний нүглийг даана гэсэн бодолтой байж болохгүй, тийм их нүгэлтэйгээр жирийн хүн бясалгаад үр дүнд хүрч чадахгүй. Би энд өөр өөр түвшний зарчмуудын талаар ярьж байна.

Шашинд яригддаг Гурамсан ертөнц гэдэг нь, тэнгэрийн есөн давхарга эсвэл гучин гурван давхаргын тэнгэр, өөрөөр хэлбэл тэнгэр, газар, газрын доорх нь Гурамсан ертөнцийн бүх амийг багтаадаг. Шашинд гучин гурван тэнгэрийн давхаргад орших бүх амь боднууд бүгд Самсара буюу хойд дүрийн зургаан замын тойргоор явдаг гэж номлодог. Самсара буюу зургаан замын тойрог гэдэг нь энэ насандаа хүн, дараагийн насандаа магадгүй амьтан болж төрнө. Буддын шашинд ингэж ярьдаг: Энэ амьдралынхаа хязгаарлагдмал цаг хугацааг алдалгүй сайн ашиглах хэрэгтэй, хэрэв чи одоо бясалгахгүй бол хэзээ бясалгах юм? Яагаад гэвэл амьтанд бясалгахыг зөвшөөрдөггүй, Фа сонсохыг зөвшөөрөхгүй, бясалгасан ч үр дүнд хүрч чадахгүй, гон нь өндөр болбол тэнгэр устгана. Чи хэдэн зуун жилдээ хүний биеийг олж чадахгүй байж мэднэ, мянган жилд

магадгүй ганц удаа хүний биетэй болсон, гэвч хүний биетэй болсон атал яаж нандигнахаа ч мэддэггүй. Хэрвээ чи нэг бул чулуу болж хойд төрлийг олсон бол арван мянган жилдээ ч гарч ирж чадахгүй, тэр чулуу бутарч няцрахгүй бол, салхи усанд элэгдэхгүй бол, чи үүрч түүнээс гарч чадахгүй. Хүний биетэй болох тун хэцүү! Дафа-г үнэхээр олж чадвал энэ хүн хамгийн аз завшаантай хүн. Хүний биеийг олоход хэцүү, энэ зарчмыг л ярьж байна.

Бид бясалгахдаа түвшний асуудлыг ярьдаг, ямар түвшинд хүрэх нь хүний өөрийн бясалгалаас шалтгаална, хэрэв чи Гурамсан ертөнцөөс гарахыг хүсвэл, бясалгаад гон баганаа маш өндөрт хүргэвэл чи Гурамсан ертөнцийг нэвтэрсэн биш гэж үү? Зарим хүн бясалган сууж байхдаа сүнс нь биеэсээ гараад маш өндөр түвшинд хүрч чаддаг. Нэг сурагч өөрт тохиолдсон явдалаа бичихдээ: Багшаа, би тэнгэрийн хэд хэдэн давхаргад гарч тэнд ямар байдалтайг нь харсан. Би түүнд улам дээш гардаа гэсэн. Тэр, “Би цааш дээшилж чадаагүй, зүрхлээгүй, дахин дээш гарч чадахгүй болсон” гэж хэлсэн. Яагаад вэ? Учир нь түүний гон багана тийм л өндөртэй, тэр өөрийнхөө гон баганад суугаад тэнд хүрсэн. Энэ бол Буддын шашинд ярьдаг бүтээлийн орон юм, тэр энэ бүтээлийн оронд бясалгаж хүрсэн. Гэхдээ бясалгаж байгаа хүний хувьд энэ нь түүний бүтээлийн орны хамгийн оргил нь биш. Тэр бас үргэлжлүүлэн дээшилнэ, тасралтгүйгээр дээш ахина, үргэлжлэн сайжирна. Чиний гон багана Гурамсан ертөнцийн хязгаарыг нэвтэрвэл, чи Гурамсан ертөнцөөс гарсан биш гэж үү? Бидний хэмжиж тогтоосноор шашинд яригддаг Гурамсан ертөнц бол зөвхөн бидний есөн том гаригийн хүрээнд байдгийг олж мэдсэн. Зарим хүн арван том гариг

байдаг гэж ярьдаг, би үүнийг огт байдаггүй гэж хэлнэ. Урьд өмнийн тэдгээр чийгон багш нарын заримынх нь гон багана маш өндөрт хүрснийг, тэнгэрийн заадаас галактикаас цааш хол давсан байсныг би харсан, тэд аль хэдийн Гурамсан ертөнцийг давсан. Миний сая ярьсан Гурамсан ертөнцөөс гарах нь үнэндээ түвшний асуудал юм.

## **Хүсэх асуудал**

Манай дасгалын газарт олон хүн ямар нэгэн юм хүсэх сэтгэлээр ирдэг. Зарим хүн ер бусын чадвартай болох хүсэлтэй, зарим нь онолын талаар сонсох хүсэлтэй, зарим нь өвчнөө эдгээлгэх хүсэлтэй, бас зарим хүн Фалунь-ийг авах гэж ирнэ, янз бүрийн бодол санаатай хүмүүс байдаг. Бас зарим хүн, “Манай гэрээс лекцэд ирж сууж чадаагүй хүн бас байгаа, би сургалтын төлбөрийг нь өгье, түүнд нэг Фалунь өгөөч” гэдэг. Бид маш олон үе дамжиж, асар урт хугацааг туулж байж, тоог нь хэлбэл почмоор урт удаан хугацаанд бий болгосон зүйл, чи хэдэн аравхан юань-аар Фалунь-ийг худалдаж авах гэж үү? Бид яагаад та бүгдэд үүнийг ямар ч болзолгүйгээр өгч байгаа вэ? Учир нь чи бясалгагч болохыг хүссэн, энэ сэтгэлийг ямар ч их мөнгөөр худалдаж авч чадахгүй, Буддын мөн чанар чинь гарч ирсэн болохоор бид ингэж хийж байгаа юм.

Чи хүсэх сэтгэлд зууралдсан байна, зөвхөн үүний төлөө энд ирсэн гэж үү? Чиний юу бодож байгааг өөр орон зайд байгаа миний Фашэнь бүгдийг мэднэ. Яагаад гэвэл хоёр цаг хугацааны орон зайн ухагдахуун адилгүй, өөр орон зайнаас харахад чиний бодол бүрдэх нь их удаан явцтай байдаг. Чиний бодол гарахаас өмнө тэр бүгдийг нь мэдчихдэг, иймээс чи өөрийнхөө буруу бодол санааг орхих хэрэгтэй. Буддын система хувь

тавиланг ярьдаг, та бүгд хувь тавилангаараа энд ирсэн, хэрэв чи үүнийг олсон бол чи магадгүй авах учиртай болоод л тэр, иймээс чи үүнийг нандигнах нь зүйтэй, ямар ч хүсэх сэтгэлд бүү зууралд.

Урьд үеийн пашны бясалгалд, Буддын система хоосон чанарыг номлодог байсан, энэ нь юу ч бодохгүй байх тэгээд хоосны үүдээр орно; Бумбын система үл оршихуйг номлодог, юу ч байхгүй, юуг ч хүсэхгүй, юугаар ч хөөцөлдөхгүй. Бясалгагч хүн гон олж авах сэтгэлгүй, харин бясалгах зүрх сэтгэлтэй байх гэж ярьдаг. Бясалгал болон дасгалаа хийхдээ үйлгүй (вүвэй) төлөв байдлаар бясалга, зөвхөн өөрийнхөө шиньшин-ээ бясалгахад анхаар, чиний түвшин ч дээшилнэ, хүртэх ёстой зүйлээ олж авах нь дамжиггүй. Хэрэв чи элдэв хүсэл сэтгэлээ орхиж чадахгүй бол энэ нь зууралдсан сэтгэл биш гэж үү? Бид энд шууд ийм дээд түвшний Фа зааж байна, мэдээж чиний шиньшин-д тавигдах шаардлага бас өндөр байх болно. Иймээс хүсэх сэтгэлээр ирж Фа-г сурч болохгүй.

Та бүгдэд хариуцлагатай хандахын тулд бид та нарыг зөв замаар дагуулж байгаа, энэ Фа-г чамд сайтар тайлбарлаж өгөх хэрэгтэй. Зарим хүн тэнгэрийн мэлмийг хүсэхэд энэ нь өөрөө бөглөрчихдөг, тэгээд чи өөрийгөө битүүмжилчихдэг. Үүнээс гадна та бүгдэд хэлье, Гурамсан ертөнцийн Фа-гийн бясалгалаар гарч ирдэг бүх ер бусын чадварууд энэ махан биений үндсэн бөгөөд төрөлхийн чадварууд юм, одоо бид үүнийг ер бусын чадвар гэж нэрлэдэг болсон. Эдгээр нь зөвхөн одоогийн байгаа энэ орон зайд буюу бидний энэ орон зайн дотор үйлчлэх бөгөөд энгийн хүмүүсийг хязгаарлаж чаддаг. Чи эдгээр жижиг чадвар, удвистай болохыг хөөцөлдөж яах юм? Хөөцөлдөж, хөөцөлдөж

Гурамсан ертөнцийн Фа бясалгалаас гарсны дараа энэ нь өөр орон зайнуудад үйлчлэхгүй. Гурамсан ертөнцийн Фа-гийн бясалгалаас гарах үед энэ бүх ер бусын чадварууд хаягдах ёстой байдаг, тэдгээр нь маш гүн орон зайд дарагдан хадгалагддаг, ирээдүйд чиний бясалгалын явцын тэмдэглэл болж үлдэнэ, зөвхөн ийм л жаахан нөлөөтэй.

Хүн Гурамсан ертөнцийн Фа-гаас гарсны дараа, дахин шинээр бясалгаж эхэлнэ. Тэр бие нь миний сая ярьсан таван махбодоос гарсан бие юм, тэр бол Будда бие. Тийм биенийг Будда бие гэж хэлж болохгүй гэж үү? Энэхүү Будда биенийг дахин шинээр бясалгаж эхлэх ёстой, мөн ер бусын чадварыг дахин шинээр гаргана, үүнийг ер бусын чадвар гэж хэлэхгүй, харин Буддын Фа-гийн ер бусын чадвар гэдэг. Түүний сүр хүч нь зүйрлэшгүй их, орон зай болгонд үйлчилдэг, энэ бол жинхэнэ нөлөө гаргаж чаддаг зүйл юм. Чи ер бусын чадварын хойноос хөөцөлдөх ямар хэрэгтэй юм? Аливаа ер бусын чадварыг хөөцөлддөг хүн энгийн хүмүүсийн дунд түүнийг хэрэглэх, өөрийгөө гайхуулах гэсэн бодолтой юм биш үү, тийм биш бол чи түүгээр яах юм? Тэдгээр нь үзэгдэхгүй бас тэмтрэгдэхгүй, ер нь гоёл чимэглэлийн зорилго нь хүртэл юмыг сайхан харагдуулахад байдаг! Чиний далд санаа үүнийг хэрэглэх зорилготой байгаа нь ойлгомжтой байна. Түүнийг энгийн хүний ур чадвар мэт үзэж хөөцөлдөж болохгүй, тэдгээр нь бүгд ер бусын зүйлс, чамайг энгийн хүмүүсийн дунд гайхуулахыг зөвшөөрөхгүй. Өөрийгөө гайхуулах нь маш хүчтэй зууралдсан сэтгэл, бас их муу сэтгэл, бясалгаж байгаа хүн үүнийг орхих ёстой. Чи үүнийг хэрэглэж мөнгө олох, эд хөрөнгөтэй болох, эсвэл энгийн хүмүүсийн дунд хувийн зорилгодоо хүрэх, тэмцэлдээ ашиглах санаатай бол

бүр ч болохгүй. Энэ нь дээд түвшний зүйл хэрэглэж энгийн хүний нийгмийг үймүүлнэ, энгийн хүний нийгмийг эвдэнэ гэсэн үг, энэ бодол нь бүр ч муу, ийм учраас үүнийг хамаагүй хэрэглэхийг зөвшөөрөхгүй.

Ер бусын чадвар гол төлөв хүүхэд болон настайчуудад гардаг. Ялангуяа настай эмэгтэйчүүд шиньшин-ээ барьж чаддаг, энгийн хүмүүсийн дунд зууралдсан сэтгэл бараг байдаггүй. Тэдэнд ер бусын чадвар гарсны дараа өөрийгөө амархан барьж чаддаг, гайхуулах сэтгэл байдаггүй. Яагаад залуу хүмүүст ер бусын чадвар гарахад хэцүү байдаг вэ? Ялангуяа залуу эрчүүд энгийн хүний нийгэмд ямар нэгэн зорилгодоо хүрэхийн төлөө тэмцэх бодолтой байдаг! Тэд ер бусын чадвартай болмогцоо өөрийнхөө хүсэл зорилгодоо хэрэглэнэ, зорилгоо биелүүлэх хэрэгсэл болгоно, ингэж хэрэглэхийг нь огт зөвшөөрөхгүй, иймээс түүнд ер бусын чадвар гардаггүй.

Бясалгал бол тоглоом биш, энгийн хүмүүсийн ур чадвар шиг ч зүйл биш, энэ нь маш нарийн асуудал. Чи бясалгах хүсэлтэй байх үгүй нь, эсвэл бясалгаж чадах эсэх нь чиний шиньшин яаж дээшлэхээс бүхэлдээ шалтгаална. Хэрэв хүн хүссэнээрээ ер бусын чадварыг үнэхээр олж авч болдог бол, сүйд болно. Түүнд бясалгах үгүй нь хамаагүй, энэ талаар бодох ч үгүй. Яагаад гэвэл түүний шиньшин энгийн хүний түвшинд байгаа, ер бусын чадвар хүссэнээрээ олбол тэр ямар ч муу зүйл хийж мэднэ. Банканд хангалттай их мөнгө байдаг, түүнээс жаахан зөөж авна; гудамжинд хонжворт сугалааны газар элбэг, тэр хамгийн дээд сугалааг нь хожно. Яагаад ийм зүйл гарахгүй байна вэ? Зарим чийгон багш, “Дэ-г эрхэмлэхгүй бол ер бусын чадвар гарсны дараа амархан муу зүйл хийнэ”



гэж ярьдаг. Минийхээр бол энэ нь буруу дүгнэлт, огт тийм байдаггүй. Чи Дэ-г эрхэмлэхгүй, эсвэл шиньшин-ээ бясалгахгүй байвал ер бусын чадвар огт гарахгүй. Зарим хүн шиньшин сайтай, аль нэг түвшинд ер бусын чадвар нь гарахад тэр өөрийгөө зөв барьж чадахгүйгээс хийх ёсгүй зүйлийг хийчихдэг, ийм байдал бас байдаг. Гэвч муу зүйл хиймэгц түүний ер бусын чадвар нь буурна эсвэл алга болно. Үүнийг алдвал үүрд алдана, үүнээс гадна хамгийн ноцтой нь хүнд зууралдсан сэтгэл үүсдэг.

Зарим чийгон багш нар, тэдний хичээлийг гурав юм уу таван өдөр заалгаад өвчнийг эдгээж чаддаг болно гэж ярьдаг, зар сурталчилгаа шиг, түүнийг чийгон-ы наймаачин гэж хэлбэл зохистой. Та бүгд бодоод үз дээ, чи бол нэг энгийн хүн, багахан чий-г гаргаад л өөр хүний өвчнийг эдгээж чадна гэж үү? Энгийн хүний биед бас чий байдаг, чамд ч байгаа, чи дөнгөж бясалгалаар хичээллэж эхэлсэн, зөвхөн алганы чинь лаогон сүв нээгдсэн болохоор чий-г авч, гаргаж чадна. Өвчтөний биед бас чий байгаа, чи түүнийг эмчлэхэд магадгүй түүний чий бас чамд нөлөөлнө! Чий хоорондоо яаж нэг нэгнээсээ давуу нөлөөтэй байж чадах юм? Чий өвчнийг эдгээж огт чадахгүй. Түүнчлэн чи хүний өвчнийг эмчлэхэд чамд өвчтэй хүнтэй холбогдсон нэг орон үүсдэг, тэр хүний биед байгаа өвчний чий бүгд чиний биед ордог, өвчний чий адил хэмжээтэй болно, гэхдээ үндэс нь тэр хүний биед байлаа ч өвчний чий ихэвэл чамд бас өвчин үүсдэг. Чи өвчнийг эдгээх чадвартай болсон гэж мэдмэгц өвчтөнд үүд хаалгаа нээн, ирсэн болгонд татгалзахгүй, чамд зууралдсан сэтгэл гарна. Хүний өвчнийг эдгээж чаддаг байх нь ямар бахдалтай юм! Яагаад эмчлэгдэж байгаа вэ? Чи энэ талаар бодож үзсэн үү, хуурамч

чийгон багш нарын биед бүгдэд нь сүнс эсвэл амьтан шүглэсэн байдаг, тэд чамайг итгүүлэхийн тулд багахан мэдээллээ өгдөг. Чамайг гурав, тав, найм юм уу арван өвчтөнийг эдгээсний дараа тэр нь хэрэглэгдээд дуусна. Энэ нь энергийн зарцуулалт бөгөөд үүнээс хойш тэр багахан энерги байхгүй болно. Чамд өөрийн гэх гон байхгүй, чи хаанаас гон авах юм? Чийгон багш нар бид хэдэн арван жилээр бясалгаж ирсэн, урьд нь Бумбад бясалгахад маш хэцүү байсан. Ариун Фа-гийн замаар бясалгахгүй хажуу замаар эсвэл жижиг замаар бясалгавал маш хэцүү.

Чийгон-ы зарим том багш нарыг нэлээд нэр хүндтэйг нь чи харсан байх, гэхдээ тэд хэдэн арван жилээр бясалгасан ч дөнгөж жаахан л гон-той болсон байдаг. Чи хэзээ ч бясалгаж байгаагүй, чийгон-ы нэг ангид суугаад л чамд гон гарах юм уу? Тийм зүйл гэж яаж байх вэ дээ? Чамд үүнээс хойш зууралдсан сэтгэл үүснэ. Зууралдсан сэтгэл нэг л гарчихвал, чи өвчнийг эдгээж чадахгүй бол бухимдана. Зарим хүн өөрийнхөө нэр хүндийг алдахгүйн тулд хүний өвчнийг эдгээхдээ юу гэж боддог гээч? Энэ өвчнийг надад тусгачих, түүнийг сайжруулчих гэнэ. Энэ нь энэрэнгүй сэтгэлийн үүднээс биш, харин түүний нэр ашгийн сэтгэл орхигдоогүйгээс юм, түүнээс огтхон ч энэрэнгүй сэтгэл гарахгүй. Тэр нэр хүндээ алдахаас айдаг, нэр хүндээ хадгалж үлдэхийн төлөө энэ өвчнийг өөртөө авахаас ч буцахгүй. Нэр хүндэд зууралдсан сэтгэл ямар хүчтэй юм бэ! Түүний энэ хүсэл гарахад тэр өвчин биед нь шууд шилждэг, үнэхээр ийм нөлөө гардаг. Тэр гэртээ өвчтэй харина, харин өвчтөн эдгэрсэн, хүний өвчнийг үзсэний дараа тэр гэртээ хариад бие нь тавгүйрхэнэ. Тэр өвчнийг эдгээсэн гэж бодсон, хүмүүс түүнийг чийгон багш гэж дуудахад тэр

баярлаж их сэтгэл ханамжтай байдаг. Энэ нь зууралдсан сэтгэл биш гэж үү? Өвчнийг эдгээж чадахгүй бол урам нь хугарч уруу царайлна. Энэ нь нэр алдар, хувийн ашиг хонжоонд зууралдсан сэтгэлээс л болсон юм биш үү? Мөн түүний эдгээсэн хүний өвчний чий бүгд түүний биед ирнэ. Тэдгээр хуурамч чийгон багш нар түүнд яаж үүнийг биеэсээ гадагшлуулахыг заасан ч би хэлье, огт гаргаж чадахгүй, жаахан ч гаргаж чадахгүй, яагаад гэвэл түүнд өөрт нь сайн муу чий-г ялгах чадвар байхгүй. Яваандаа бие доторх нь тэр чигтээ хар болно, тэр бол нүгэл.

Чи жинхэнэ бясалгахад нэлээд хүнд сорилтод орно, тэгвэл яах вэ? Чи хэр их зовлон туулж байж нүглийг цагаан бие бодид хувиргах вэ? Энэ бол маш хэцүү. Ялангуяа хүний төрөлхийн суурь нь сайн байх тусам энэ асуудалтай амархан тулгардаг. Зарим хүн дандаа өвчин эдгээхийг хөөцөлддөг. Чи хүсэх сэтгэлтэй байвал амьтанд харагдана, тэр ирж чамайг эзэмдэнэ, энэ бол сүнс шүглэлт юм. Чи өвчин эмчлэхийг хүсэж байгаа биз дээ? Тэр чамд үүнийг хийхэд тусална. Гэхдээ тэр чамд өвчин эдгээхэд чинь зүгээр туслахгүй, алдахгүй бол олдохгүй, энэ нь маш аюултай, эцэст нь чи түүнийг даллан ирүүлнэ, чи яаж бясалгалаа үргэлжлүүлэх юм? Бүх зүйл дуусна.

Зарим төрөлхийн суурь сайтай хүн өөрийнхөө сууриа бусдын нүглээр сольж байгаа юм. Тэр хүн өвчтэй, бас түүний нүгэл нь маш их, хэрэв чи хүнд өвчтэй нэг хүнийг эдгээчихвэл гэртээ харьсны дараа бие чинь тун таагүй болно! Урьд өмнө олон хүн өвчтөнийг үзсэнийхээ дараа ийм байдлыг мэдэрсэн, өвчтэй хүн эдгэрсэн, харин чи гэртээ хариад хүнд өвчилнө. Цаг хугацаа өнгөрөх тусам улам их нүгэл

чамд шилжинэ, чи хүнд Дэ-гээ өгөөд нүглээр сольж байгаа юм, алдахгүй бол олдохгүй. Чиний авсан нь өвчин байлаа ч нүглийг Дэ-гээрээ солих ёстой. Энэ орчлон ертөнцөд ийм нэг зарчим байдаг, чи өөрөө үүнийг хүсэж байвал хэн ч чамайг хорихгүй, мөн чамайг сайн гэж хэн ч хэлэхгүй. Энэ орчлон ертөнцөд ийм нэг тогтсон зүйл байдаг: энэ бол хэн их нүгэлтэй байна тэр бол муу хүн. Чи төрөлхийн сууриа бусдад өгч нүглээр сольж байгаа юм, чи улам их нүгэл хураавал яаж бясалгах юм? Тэр хүнээр чиний төрөлхийн суурь бүрмөсөн сүйтгэгдэнэ. Энэ нь аймшигтай биш гэж үү? Тэр хүний өвчин сайжирсан, таатай болсон, харин чи гэртээ хариад зовно. Чи хоёр хорт хавдартай хүнийг эдгээчих юм бол өөрөө тэдний оронд нас барна, энэ аюултай биш гэж үү? Ийм л байдаг, маш олон хүн энэ зарчмын цаадах учрыг мэддэггүй.

Зарим хуурамч чийгон багш нарыг хэр их нэр хүндтэйгээр нь битгий хар, нэр хүндтэй байх нь сайн мэддэгтэй гэсэн үг биш. Энгийн хүн юу мэдэх вэ дээ? Юмыг сүр дуулиан болгонгуут түүнд үнэмшчихдэг. Чи тэдний ингэж хийж байгаагаар нь битгий хар, энэ нь бусдад хор хөнөөл учруулаад зогсохгүй бас өөрсдөдөө ч хор хөнөөл учруулж байгаа юм, нэг хоёр жилийн дараа тэдэнд юу болохыг нь чи харна, бясалгалыг ингэж сүйтгэхийг зөвшөөрөхгүй. Бясалгал бол өвчнийг эдгээж чадна, тэгэхдээ өвчнийг эдгээх зорилготой биш. Энэ бол ер бусын зүйл, энгийн хүний мэргэжил чадвар шиг биш, үүнийг хамаагүй сүйтгэхийг туйлаас зөвшөөрөхгүй. Одоогийн зарим хуурамч чийгон багш нар эмх замбараагүй байдал үүсгэсэн, чийгон-ыг нэртэй болох, баян болох аргаа болгосон, тэд хорлонт бүлэглэлүүдийг үүсгэж нөлөөллөө улам тэлж байна, жинхэнэ чийгон багш нараас тэдний тоо олон дахин

илүү, энгийн хүмүүсийн ингэж ярьж хийж байгаад нь чи үнэмшчихсэн үү? Чи чийгон-ыг ийм л байдаг гэж болдог, гэвч тийм биш. Миний яриад байгаа зүйл бол жинхэнэ зарчим юм.

Энгийн хүмүүсийн дунд янз бүрийн нийгмийн харилцаа үүсэхэд зарим хүн хувийн ашиг сонирхлынхоо төлөө муу зүйл хийдэг, бусдад өртэй болдог, хүн өрөө төлөхийн тулд зовох болно. Жишээлбэл чи хүссэнээрээ өвчнийг эдгээдэг гэж бодъё, үнэхээр өвчнийг эдгээчихдэг юм бол, үүнийг зөвшөөрнө гэж үү? Будда нар хаа сайгүй байдаг. Ийм олон Будда байдаг ага! Яагаад энэ зүйлийг хийдэггүй вэ? Будда хүн төрөлхтнийг өвчин зовлонгүй болгочихвол ямар сайхан бэ! Тэр яагаад үүнийг хийдэггүй вэ? Хүн өөрийнхөө нүглийг өөрөө төлөх ёстой, хэн ч энэ зарчмыг эвдэж зүрхлэхгүй. Хүн бясалгалынхаа явцад энэрэнгүй сэтгэлийн улмаас хааяа хүмүүст тусалж болно, тэгэхдээ тэр нь өвчнийг зөвхөн хойшлуулдаг. Чи одоо өвдөж зовохгүй ч хожим нь зовно, эсвэл чамайг өвчин тусахын оронд мөнгө алдах юм уу эсвэл өөр гай зовлон тохиолдохоор өөрчилж өгнө, магадгүй ийм байж болно. Хүний нүглийг жинхэнэ арилгаж өгөхийн хувьд зөвхөн бясалгагч хүнд хийж өгч болно, харин энгийн хүнд бол болохгүй. Би энд зөвхөн өөрийнхөө бясалгалын зарчмыг яриагүй байна, би бүхэл орчлон ертөнцийн үнэнийг, бясалгалын хүрээн дэх бодит байдлын талаар ярьж байна.

Бид энд өвчин эдгээхийг чамд заах гэж байгаа юм биш, бид чамайг аугаа замаар, ариун замаар дагуулж байна, чамайг дээшлүүлж байна. Иймээс би өөрийнхөө лекц дээр Фалунь Дафа-гийн сурагчдад өвчин эмчлэхийг зөвшөөрөхгүй гэж дандаа хэлдэг,

чи өвчин эмчлэх юм бол Фалунь Дафа-гийн сурагч биш. Яагаад гэвэл бид ариун зам руу чамайг дагуулж байгаа, Гурамсан ертөнцийн Фа бясалгалын явцад чиний бие дээд энергийн бие бодитор бүрэн хувирах хүртэл үргэлж ариусаж байх болно. Чи биедээ тэдгээр хар зүйлийг цуглуулаад байвал яаж бясалгах юм? Тэр бол нүгэл шүү дээ! Чи бясалгах ямар ч боломжгүй болно. Хэтэрхий их нүгэлтэй болбол чи дааж чадахгүй, хэтэрхий их зовлонд унавал бясалгаж чадахгүй болно, ийм л учиртай юм. Би энэ Дафа-гийн нийтэд дэлгэрүүлсэн, чи магадгүй миний юу заасныг мэдэхгүй байж болно. Энэ Дафа нэгэнт дэлгэрсэн болохоор үүнийг хамгаалах арга замууд бий. Чи хүний өвчнийг эмчлэх юм бол миний Фашэнь чиний биед өгсөн бясалгалын бүх зүйлсээ буцааж авна. Бид чамд нэр хүнд, хувийн ашгийн төлөө ийм нандин зүйлийг хамаагүй сүйтгэхийг зөвшөөрөхгүй. Чи Фа шаардлагын дагуу явахгүй бол Фалунь Дафа-гийн сурагч биш, биеийг чинь энгийн хүний хуучин байдалд нь оруулна, чамд муу зүйлсийг чинь буцаагаад өгнө, яагаад гэвэл чи энгийн хүн байхыг хүссэн.

Өчигдрийн хичээлээс хойш та нарын олонх нь бүх биеэ хөнгөрснийг мэдэрсэн. Гэхдээ цөөн тооны хүнд өвчтэй хүмүүсийн бие нь өчигдрөөс таагүй болж эхлэхийг мэдэрсэн. Өчигдөр би та бүгдийн биеэс муу зүйлийг чинь авч хаясны дараа ихэнх хүмүүсийн бүхэл бие нь хөнгөрч их таатай болсныг мэдэрсэн. Гэхдээ бидний энэ орчлон ертөнцөд ‘алдахгүй бол олохгүй’ гэдэг зарчим үйлчилдэг, бид чамаас бүх муу зүйлийг чинь авч хаяж болохгүй, чамайг жаахан ч зовлон амсахгүй байхыг огт зөвшөөрөхгүй. Өөрөөр хэлбэл бид чиний биеийг муу болгож байгаа, өвчин үүсгэж байгаа үндсэн шалтгааныг арилгасан ч чамд өвчний

орон байсаар байна. Тэнгэрийн мэлмий нь их доогуур түвшинд нээгдсэн хүн чиний биен дэх бөөгнөрсөн хар чий, булингартсан өвчний чийг харж чадна, энэ нь бас өтгөрсөн, их нягтралтай хар чийн бөөгнөрөл бөгөөд тэлэх юм бол чиний бүх биеэр тархана.

Өнөөдрөөс эхлээд зарим хүмүүсийн бие хүнд ханиад туссан мэт бүх бие нь жихүүцэж байгааг мэдэрнэ, магадгүй яс нь хүртэл янгинана. Ихэнх хүний хаа нэг газар нь тавгүйрхэнэ, хөл чинь өвдөж толгой чинь эргэх гэх мэт мэдрэмж төрж магад. Өмнө нь, чийгон дасгалаар эсвэл аль нэгэн чийгон багшаар эдгээгдсэн гэж бодож байсан өвчин чинь дахин сэдэрэн гарна. Яагаад гэвэл тэр чамайг эдгээж чадаагүй, өвчнийг чинь зөвхөн хойшлуулсан, тэндээ байсаар байгаа, одоо илрэхгүй ч хожим дахиад гарч ирнэ. Бид үүнийг бүгдийг нь ухаж гаргаж хаяна, үндсээр нь бүрмөсөн арилгана. Ингэвэл магадгүй чиний өвчин дахин сэдэрсэн мэт болдог, энэ бол нүглийг үндсээр нь арилгаж байгаа хэрэг юм, тиймээс чамд цочрол нөлөө гарна, зарим хүний бие нь янз бүрийн байдлаар эвгүйрхэж энд тэнд нь тавгүй болж магад, энэ бүгд бол хэвийн зүйл юм. Би та бүгдэд хэлье, ямар ч тавгүй байсан тэвчээрэй, хичээлдээ ирж тууштай үргэлжлүүлэн сонс, хичээлийн энэ танхимд орж ирэнгүүт чиний өвчний бүх зовууриуд алга болно, ямар ч аюул гарахгүй. Та бүгдэд дахин онцолж хэлэхэд, чи ‘өвчин’-өөсөө болоод ямар их зовлонтой байлаа ч үргэлжлүүлэн ирэхийг чинь хүсэж байна, Фа олж авах хэцүү. Чамд их таагүй мэдрэмж төрж байгаа нь юм туйлдаа хүрээд эргэж байгаагийн шинж. Чиний бүх биеийг ариусгах болно, заавал бүрэн ариусгагдах ёстой. Өвчний уг үндэс нь авч хаягдсан, зөвхөн багахан хэмжээний хар чий үлдсэн, энэ нь өөрөө гадагшлахдаа

чамайг жаахан өвтгөнө, зовооно. Чи үүнийг жаахан ч гэсэн тэвчихгүй байж болохгүй.

Чи энгийн хүний нийгэмд нэр алдар, хувийн ашгийнхаа төлөө бусадтай өрсөлдөн тэмцэлдээд сайн унтаж, идэж ч чадахгүй, өөрийнхөө биенийг их муутгасан, өөр орон зайнаас чиний биенийг харахад яс чинь хүртэл хар байдаг. Ийм янзын биенийг гэнэт чамд ариусгаж өгөхөд ямар нэгэн мэдрэмж гарахгүй байх аргагүй, иймээс чамд цочир үйлчлэл гарна. Зарим хүн бөөлжинө, гүйлгэнэ. Олон газрын сурагчид надад өөрсдөдөө тохиолдсон явдлаас бичихдээ: “Багш аа, би таны хичээлд суусны дараа гэртээ харих замдаа бие засах газар хайсаар байгаад очсон.” Яагаад гэвэл бүх дотор эрхтэн ариусгагдах ёстой. Бас зарим цөөн тооны хүмүүс унтдаг, намайг хичээл ярьж дуусахад сэрдэг. Яагаад вэ? Учир нь тэд тархи толгойн өвчтэй, тэдэнд засал хийх хэрэгтэй. Толгойн өвчнийг нь оролдвол тэд тэсвэрлэж чадахгүй, иймээс заавал мэдээ алдуулах байдалд оруулах ёстой, тэр мэдэхгүй. Гэлээ ч зарим хүний сонсгол нь ямар ч асуудалгүй, тэд их бөх унтах боловч нэг ч үг гээлгүй бүгдийг нь сонссон байдаг, дараа нь тэд их цовоо сэргэг болдог, хоёр өдөр унтахгүй байсан ч нойрмоглохгүй. Янз бүрийн байдал гардаг, тэр бүгдийг засах хэрэгтэй, чиний биенийг бүхэлд нь ариусгаж өгнө.

Фалунь Дафа-гаар жинхэнэ бясалгадаг хүн өөрийнхөө алив сэтгэлээс ангижирч чадвал, энэ үеэс эхлээд бүгдэд нь цочир үйлчлэл гарч эхэлнэ. Аливаа сэтгэлээ орхиж чадахгүй байгаа хүмүүс үүнээсээ салсан гэх боловч үнэн хэрэг дээрээ тэд салж чаддаггүй, иймээс тэр байдалд хүрэхэд маш хэцүү. Бас нэг хэсэг хүмүүс миний ярьсан хичээлийн агуулгыг хожим нь ойлгодог,



тэд сэтгэлээ орхиж эхэлнэ, тэгээд бие нь ариусгагдана, бусад хүмүүсийн бие нь аль хэдийн хөнгөрсөн байхад ийм хүмүүсийн өвчин нь дөнгөж арилж эхэлж байдаг, бие нь тавгүйрхэнэ. Анги болгонд ухамсар нь арай доогуур ийм хоцрогсад байдаг, тиймээс чамд ямар ч байдал гарсан бүгд хэвийн юм. Өөр газруудад лекц унших болгонд ийм асуудал гардаг байсан, зарим хүний бие их тавгүйрхэнэ, сандал дээрээ тэгнэж хэвтээд босохгүй, намайг индрээс бууж ирээд түүнийг эдгээхийг хүлээдэг. Би эдгээж өгөхгүй. Чи иймхэн сорилтыг ч давж чадахгүй бол—цаашид чи өөрөө бясалгахад олон том бэрхшээлүүд тулгарах болно— иймхэн зүйлийг давж чадахгүй бол яаж бясалгах гэж байгаа юм? Ийм өчүүхэн зүйлийг давж чадахгүй гэж үү? Бүгд давж чадна. Тэгэхээр үүнээс хойш та бүгд өвчнөө эдгээх гэж над дээр битгий ирж бай, би ч өвчнийг эдгээхгүй, чамайг 'өвчин' гээд л ярингуут би сонсох хүсэлгүй болно.

Хүнийг аврах маш хэцүү байдаг, лекц болгонд хүмүүсийн 5-10 хувь нь бусдаасаа хоцордог. Хүн болгон Бумбын мөрийг олох боломжгүй, тууштай бясалгаж чадах хүн байсан ч, чамайг бясалгаад амжилтад хүрч чадах эсэхийг чинь харна, мөн зоримог шийдэмгий бясалгаж чадах эсэхийг чинь харна. Хүн болгон Будда болох боломжгүй. Дафа-гаар жинхэнэ бясалгаж буй хүн энэ номыг уншихад бас адилхан байдал гарах болно, мөн хүртэх ёстой бүхнээ олж авна.

# Гуравдугаар лекц

## Би бүх сурагчдаа шавиа гэж үздэг

Та бүгд миний хийж байгаа зүйл юу болохыг мэдэж байна уу? Би сурагч бүрийг шавиа гэж авч үзэн дагуулдаг, өөрөө бие даан сурч жинхэнэ бясалгаж байгаа хүн үүнд бас багтана. Дээд түвшинд бясалгалыг заан тараахад ингэж чамайг дагуулахгүй бол болохгүй, тэгэхгүй бол хариуцлагагүй хандаж хуумгай зүйл хийсэнтэй адил болно. Бид чамд ийм их зүйл өгсөн, чамд энгийн хүний мэдэх ёсгүй олон зарчмыг мэдүүлсэн, би чамд энэ Дафа-г уламжилсан, бас чамд олон зүйлийг өгөх болно. Чиний биеийг ариусгаж өгч байгаа, мөн зарим өөр асуудлууд ч бас холбогддог, иймээс чамайг шавиа гэж үзэн дагуулахгүй бол үндсэндээ болохгүй. Энгийн хүнд ийм их тэнгэрийн нууцыг хамаагүй задруулахыг зөвшөөрдөггүй юм. Гэхдээ онцлох нэг зүйл бий, одоогийн цаг үе өөрчлөгдсөн, бид мөргөх, залбирах хэлбэрийн зан үйлийг хийхгүй. Тэр зан үйл нь онцын ач холбогдолгүй, шашны зан үйл мэт, бид ингэж хийхгүй. Хэрэв чи үүдээр гараад л өөрийнхөө урьдын зангаар хүссэн болгоноо хийгээд л энгийн хүмүүсийн дунд өөрийн нэр алдар, ашгийн төлөө өрсөлдөж тэмцэлдэх юм бол багшид мөргөх, залбирах энэ зан үйл юунд хэрэгтэй юм? Чи магадгүй миний далбаан дор Дафа-гийн нэр хүндийг ч гутааж мэднэ!

Жинхэнэ бясалгал бол яаж сэтгэлээ бясалгахаас чинь бүрэн шалтгаална, чи бясалгаж л байх юм бол, бясалгалаа тууштай шамдангуй үргэлжлүүлж чадаж байвал бид чамайг шавиа гэж үзэн дагуулна, чамайг ингэж авч үзэхгүй бол болохгүй. Гэвч зарим хүн өөрийгөө жинхэнэ бясалгагч гэж үзэн бясалгалаа

үргэлжлүүлж чадахгүй байж мэднэ, зарим хүнд энэ нь боломжгүй юм. Гэхдээ олон хүн жинхэнэ бясалгаж чадна. Чи бясалгасаар л байх юм бол бид чамайг шавиа гэж үзэн дагуулна.

Өдөр болгон зөвхөн энэ хэдэн дасгалын хөдөлгөөнийг л хийгээд байвал Фалунь Дафа-гийн шавь гэж үзэж болох уу? Тэгвэл магадгүй болохгүй. Яагаад гэвэл жинхэнэ бясалгахад бидний ярьсан шиньшин-ий шалгуурын дагуу байх ёстой, өөрийнхөө шиньшин-ийг жинхэнэ дээшлүүлэх ёстой, тэгвэл энэ нь жинхэнэ бясалгал болно. Чи зөвхөн дасгалыг л хийгээд шиньшин-ээ дээшлүүлэхгүй бол, бүх зүйлийг эрчимжүүлдэг хүчирхэг энерги байхгүй бол үүнийг бясалгал гэж хэлж болохгүй, бид чамайг Фалунь Дафа-гийн шавь гэж үзэж болохгүй. Чи үргэлж ийм байвал, дасгалаа хэчнээн их хийсэн ч бидний Фалунь Дафа-гийн шаардлагыг хангахгүй, шиньшин-ээ дээшлүүлэхгүй, энгийн хүмүүсийн дунд байдаг янзаараа л байвал магадгүй чамд өөр гай зовлон тохиолдоно, тэр ч байтугай Фалунь Дафа-г бясалгаснаас болж буруутлаа гэж чи хэлж магадгүй, ийм байдал гарч магад. Иймээс чи бидний шиньшин-д тавигддаг шаардлагыг жинхэнэ дагах ёстой, тэгвэл чи жинхэнэ бясалгадаг хүн. Би та бүгдэд тодорхой хэллээ, тиймээс та бүгд мөргөж залбирч багшийн барилдлага хийх гэж над дээр битгий ирж бай, чи зөвхөн жинхэнэ бясалгах юм бол, би ингэж л чамд хандана. Миний Фашэнь аль хэдийн тоолж баршгүй олон болсон, энд байгаа сурагчдаас гадна хэчнээн их хүн байсан ч би бүгдийг нь харж хандаж, хариуцаж чадна.

## **Буддын системийн чийгон ба Буддын шашин**

Буддын системийн чийгон бол Буддын шашин биш, би энэ зүйлийг та бүхэнд тодорхой хэлж өгье, үнэндээ Бумбын системийн чийгон бас Бумбын шашин ч биш. Манай зарим хүн үүнийг сайн ойлгодоггүй. Зарим хүн хийдийн лам хуврагууд, зарим нь сүсэгтнүүд байдаг, тэд өөрсдийгөө Буддын шашны талаар арай илүү мэддэг гэж боддог, тэгээд манай сурагчдад Буддын шашны талаар их идэвхтэй сурталчилдаг. Би чамд хэлье, чи ийм юм хийж болохгүй, яагаад гэвэл энэ бол өөр бясалгалын зүйл. Шашин бол шашны зан үйлийн хэлбэртэй, бид энд өөрсдийнхөө бясалгалын нэг хэсгээс зааж байна, Фалунь Дафа-гийн мэргэшсэн бясалгагчдаас бусад нь шашны зан үйлийг баримталж болохгүй, тиймээс бидний бясалгал Дарма-гийн төгсгөлийн үеийн Буддын шашин биш.

Буддын шашны Дарма бол Буддын Фа-гийн зөвхөн нэг өчүүхэн хэсэг юм, түүнчлэн бас олон төрлийн аугаа номын бясалгалууд байдаг, түвшин бүрд өөр өөрийн гэсэн Фа байдаг. Шагжамүни наян дөрвөн мянган Номын үүд байдаг гэж ярьсан. Буддын шашинд ердөө хэдхэн төрлийн Номын үүд байдаг. Үүнд Тианьтай, Хуаянь, Зэн буддизм, Ариун Орон болон Тантризм гэх мэт ердөө ийм хэдхэн урсгал байдаг, эдгээр нь тун ялыгүй зүйлс! Тиймээс Буддын шашин Буддын Фа-г бүхэлд нь илэрхийлж чадахгүй, энэ нь зөвхөн Буддын Фа-гийн өчүүхэн хэсэг л юм. Бидний Фалунь Дафа бол наян дөрвөн мянган Номын үүдний нэг бөгөөд анхны Буддын шашинтай болон Дарма-гийн төгсгөлийн үеийн Буддын шашинтай ямар ч хамааралгүй төдийгүй одоогийн шашнуудтай ч бас ямар ч хамааралгүй.

Буддын шашныг 2500 жилийн өмнө эртний Энэтхэгт Шагжамүни үүсгэн байгуулсан. Шагжамүнигийн гон нь нээгдэж гэгээрсний дараа урьд нь бясалгасан зүйлээ санасан, тэгээд түүнийгээ заан тарааж хүмүүсийг аварсан. Түүний Дарма-гийн хэчнээн мянган боть судар гарсан ч, үнэндээ энэ нь гуравхан үгнээс бүрддэг, түүний Дарма-гийн онцлог шинж нь “сахил, самади, билиг ухаан” юм. Сахил нь энгийн хүний бүх дур хүслийг цээрлэнэ, хүчээр чамайг хувийн ашиг сонирхлыг чинь орхиулна, энгийн хүний бүх зүйлээс таслах гэх мэтчилэн. Ингэхлээр хүний сэтгэл нь хоосорч юуны ч талаар бодохгүй болно, тэгээд самади-д орж чадна. Эдгээр нь хоорондоо ийм уялдаа холбоотой. Самади-д орсны дараа завилан суугаад жинхэнэ бясалгана, самади-ийн хүчээр дээш бясалгана, энэ бол тэр номын үүдний жинхэнэ бясалгалын хэсэг юм. Үүнд дасгал хийхгүй бас өөрийн бие (бэньти)-ийг ч өөрчилдөггүй. Тэр зөвхөн түүний түвшний өндрийг тодорхойлдог гон-ыг бясалгана, иймээс тэр зөвхөн шиньшин-ээ бясалгана, амь биеэ бясалгадаггүй учраас гон хувиргах асуудал байхгүй. Мөн бясалгалаар самади-д орох чадвараа улам хүчтэй болгоно, завилаж суухын зовлонг тэвчиж өөрийнхөө нүглийг хөнгөлнө. Билиг ухаан гэдэг нь хүний аугаа оюун билиг нь нээгдэж гэгээрэх гэсэн үг. Орчлон ертөнцийн жинхэнэ үнэнийг, орчлон ертөнцийн өөр өөр орон зайн бодит байдлыг харж чадна, бурханлаг ер бусын чадвар нь гарч ирнэ. Билиг ухаан нээгдэх буюу гэгээрэхийг бас гон нээгдэх гэж хэлдэг.

Шагжамүни Дарма-г үүсгэх үед Энэтхэгт найман төрлийн шашин бас зэрэг дэлгэрч байсан. Тэдгээрийн нэг нь бат бөх суурьтай Брахман шашин юм. Шагжамүни амьдралынхаа туршид үргэлж бусад

шашинтай үзэл суртлын тэмцэл хийдэг байсан. Яагаад гэвэл Шагжамүни-гийн заасан Дарма арнун ном, иймээс түүний дэлгэрүүлсэн Буддын Дарма бүхий л явцдаа улам бүр өргөн тархсан. Харин бусад шашин улам бүр суларсан төдийгүй бат бөх суурьтай Брахман шашин хүртэл мөхлийн ирмэгт тулж ирсэн. Гэхдээ Шагжамүни нирваалсны дараа бусад шашин ялангуяа Брахман шашин дахин цэцэглэн хөгжиж эхэлсэн. Харин Буддын шашинд ямар байдал гарсан бэ? Зарим лам хуврагууд өөр өөр түвшинд гон нь нээгдэж гэгээрсэн, гэхдээ тэдний гэгээрсэн түвшин нь нэлээд доогуур байсан. Шагжамүни Рулай (Гатагата) түвшинд хүрсэн ч олонх лам хуврагууд энэ түвшинд хүрч чадаагүй.

Буддын Фа өөр өөр түвшинд өөр өөр байдлаар илэрдэг, гэхдээ түвшин өндөр болох тусам улам үнэнд ойртоно, түвшин доогуур байх тусам үнэнээс улам хол байдаг. Тиймээс доогуур түвшинд гон нь нээгдэж гэгээрсэн тэдгээр лам хуврагууд өөрсдийнхөө түвшинд харсан орчлон ертөнцийн илрэл, ойлгосон байдал, ухамсарласан зарчмууддаа суурилан Шагжамүни-гийн ярьсан үгийг тайлбарласан. Өөрөөр хэлбэл зарим лам хуврагууд Шагжамүни-гийн ярьсан Дарма-г янз бүрээр тайлбарласан, зарим нь өөрсдийн ухаарч ойлгосон зүйлийг Шагжамүни-гийн үг болгон ярьсан, Шагжамүни-гийн хэлсэн үндсэн үгээр ярихгүй болсон. Ийнхүү Буддын шашны Дарма танихын аргагүй болтлоо өөрчлөгдсөн, Шагжамүни-гийн заасан Дарма огтоос биш болж, эцэст нь Буддын шашны Дарма Энэтхэгт байхгүй болоход хүрсэн. Энэ бол түүхэн том сургаж юм, хожим Энэтхэгт Буддын шашин ч байхгүй болсон. Буддын шашин байхгүй болохоос өмнө тэр нь олон удаа өөрчлөгдөж шинэчлэгдсээр

эцэст нь Брахман шашинтай холилдож Энэтхэгт одоогийн байгаа Хиндү шашин үүссэн юм. Энэ нь ямар ч Буддыг тахин шүтэхгүй харин өөр зүйлийг тахин шүтдэг, иймээс Шагжамүни-д итгэх бишрэл үгүй болсон, ийм л нөхцөл байдалтай болсон юм.

Буддын шашны хөгжлийн явцад хэд хэдэн томоохон өөрчлөлтүүд гарсан. Үүний нэг нь Шагжамүни өөд болсны дараахан хэн нэгэн Шагжамүни-гийн ярьсан дээд түвшний зарчмууд дээр үндэслэн Их хөлгөн (Махаяана)-ий шашныг үүсгэн байгуулсан явдал юм. Түүнчлэн Шагжамүни-гийн олон нийтэд ярьсан Номыг энгийн хүмүүст сонгох, өөрийгөө ангижруулах ба Архад бүтээлийн оронд хүрэхэд зориулагдсан гэж үздэг, хамаг амьтныг аврахыг ярьдаггүй, тиймээс энэ нь Бага хөлгөн (Хинаяана)-ий шашин гэж нэрлэгдсэн. Зүүн өмнөд Азийн орнуудын лам хуврагууд Шагжамүни-гийн үеийн анхны бясалгалын аргыг хадгалж үлдсэн, Хятадад үүнийг Бага хөлгөний шашин гэж нэрлэдэг. Мэдээжийн хэрэг тэд үүнийг хүлээн зөвшөөрдөггүй, харин өөрсдийгөө Шагжамүни-гийн анхны зүйлийг тэр хэвээр нь уламжлан авч үлдсэн гэж үздэг. Энэ бол үнэхээр тийм, тэд үндсэндээ Шагжамүни-гийн үеийн бясалгалын аргыг уламжлан авч үлдсэн юм.

Энэ засварлагдсан Их хөлгөн шашин Хятад оронд орж ирсний дараа тогтож үлдсэн, энэ нь одоогийн Хятадад тархсан энэ Буддын шашин юм. Гэхдээ Шагжамүни-гийн үеийн Буддын шашнаас тэс өөр болсон, өмсгөлөөс авхуулан ухамсарлах байдал болон бясалгалын явц нь бүхэлдээ өөрчлөгдсөн. Эртний Буддын шашинд зөвхөн Шагжамүни-ийг анхны үндэслэгч гэж тахин шүтдэг байсан бол одоо Буддын шашинд олон Будда, аугаа Бодьсадва нар гарч

ирсэн, мөн Буддын олон шүтлэгтэй болсон. Олон Рулай (Татагата) Буддыг шүтдэг, олон Буддыг шүтдэг Буддын шашин болсон. Жишээлбэл Будда Амитаба, Оточ Манал Бурхан, Их Наран Татагата гэх мэт Будда нараас гадна олон аугаа Бодьсадва нар гарч ирсэн. Ийм байдлаар Буддын шашин бүхэлдээ Шагжамүнигийн үүсгэн байгуулсан үеэс огт өөр болсон.

Энэ хугацаанд бас өөр нэгэн өөрчлөлт гарсан нь Нагаржуна Бодьсадва бясалгалын нэг нууц аргыг тараасан. Энэ нь Энэтхэгээс Афганистанд дамжиж, улмаар Шинжнан мужаар дамжин Хятадад орж ирсэн, энэ үе нь Тан гүрний үе байсан тул түүнийг Тан Тантризм гэж нэрлэсэн. Күнзийн сургаалын нөлөөлөл их байснаас Хятадын ёс суртахууны үнэт зүйлс бусад үндэстнийхээс ялгаатай байсан. Энэ нууц бясалгалын аргад эр эм хосоороо бясалгах зүйлүүд байсан тул тухайн үеийн нийгэм үүнийг хүлээн зөвшөөрөөгүй, иймээс Хуйчаан жилийн Тан хаант гүрний үед Буддын шашин хавчигдаж байх үед арчигдан үгүй болсон, ингэж Тан Тантризм Хятадад байхгүй болсон. Одоогийн Японд байдаг Зүүний Тантризм нь тэр үед Хятадаас орж ирсэн, гэхдээ түүнд адислах зан үйл (гуаньдин) хийгдээгүй. Тантризмын ёсоор бол, хэн нэгэн адислах ёс үйлдэхгүйгээр Тантризм сурвал Дарма-г хулгайлсанд тооцогддог, түүнийг биечлэн суралцсан гэж хүлээн зөвшөөрдөггүй. Өөр нэг хэсэг нь Энэтхэгээс Непалаар дамжин Түвдэд орж ирсэн, үүнийг Түвдийн Тантризм гэдэг ба өнөөг хүртэл уламжлагдаж үлдсэн. Үндсэндээ энэ бол Буддын шашны байгаа байдал юм, би үүний үүсэл хөгжил болон хувьслын талаар маш товчхон дурдлаа. Буддын шашны хөгжлийн бүхий л явцад Бодьсарма-гийн үүсгэн байгуулсан Зэн буддизм, Арнун Орны шашин,



Хуаянь шашин гэх мэт зарим урсгалууд гарч ирсэн, эдгээр нь бүгд Шагжамүни-гийн тухайн үед ярьсан зүйлээс ойлгож авсан дээр үндэслэн байгуулагдсан юм, эдгээр нь бүгд өөрчлөгдсөн Буддын шашинд харьяалагддаг. Буддын шашинд ийм л арав гаруй бясалгалын арга байдаг, тэд бүгд шашны хэлбэртэй учраас Буддын шашинд харьяалагддаг.

Энэ зуунд үүссэн шашнууд, зөвхөн энэ зуунд ч биш бас өмнөх зуунуудад дэлхий даяар үүссэн олон шинэ шашнуудын ихэнх нь хуурамч. Лугаа гэгээрэгчид бүгд хүнийг аврах өөрийн гэсэн диваажинтай байдаг, тухайлбал Шагжамүни, Будда Амитаба, Их Наран Татагата гэх мэтчилэн эдгээр Рулай Будда нар хүнийг аврах өөрийн гэсэн диваажинтай. Бидний энэ тэнгэрийн заадас галактикт ийм зуу гаруй диваажин байдаг, бидний Фалунь Дафа ч бас Фалунь диваажинтай.

Тэдгээр хуурамч бясалгалууд хүнийг аврахдаа хаашаа аваачих юм? Тэд хүнийг аварч чадахгүй төдийгүй тэдний заасан нь Фа биш. Мэдээжийн хэрэг зарим хүн шашныг анх үүсгэхдээ ариун шашныг сүйтгэх буг чөтгөр болно гэж санаагүй. Тэд янз бүрийн түвшинд гон нь нээгдэж гэгээрсэн, зарим нэг зарчмыг харсан, гэхдээ тэдний түвшин хүн аварч чадах гэгээрэгчдээс маш хол, мөн маш доогуур юм. Тэрээр зарим зарчмуудыг олж хардаг, энгийн хүний хийдэг зарим зүйл буруу гэдгийг олж мэдсэн, мөн хэрхэн сайн үйл хийхийг хүмүүст хэлж өгдөг, эхэндээ тэд бусад шашныг эсэргүүцээгүй. Хүмүүс эцэст нь тэднийг тахин шүтэж, хэлсэн үгийг нь үндэслэлтэй гэж үздэг болж, яваандаа улам бүр итгэдэг болсон, улмаар хүмүүс тэдэнд залбиран мөргөдөг болж шашныг шүтэхээ больсон. Тэдэнд нэр алдар,

ашиг сонирхлын сэтгэл гарахад, олон нийтээс өөрт нь өргөмжлөл нэр өгөхийг хүснэ, дараа нь тэд шинэ шашин үүсгэнэ. Би та бүгдэд хэлье, энэ бүгд бол буруу шашин юм. Тэд хүмүүст илт хор хөнөөл учруулахгүй ч гэсэн буруу шашин. Яагаад гэвэл тэд хүмүүсийн ариун шашин шүтэх итгэл үнэмшилд саад болдог, ариун шашин хүнийг аварч чадна харин тэд чадахгүй. Аажмаар дэлгэрэх явцдаа далдуур муу зүйл хийдэг. Сүүлийн үед ийм янзын олон зүйлс Хятадад орж ирсэн, Гуанинь урсгал бол тэдгээрийн нэг юм. Тиймээс та бүгд сэрэмжтэй байгаарай, зүүн Азийн нэг оронд хоёр мянга гаруй төрлийн зүйлс байдаг, Зүүн өмнөд Азийн болон барууны зарим орнуудад зүсэн бүрийн шүтлэг байдаг, нэг оронд буг чөтгөрийн шашин бүр ил тод байдаг. Эдгээр зүйлс бүгд Дарма-гийн төгсгөлийн үед гарч ирсэн буг чөтгөрүүд юм. Дарма-гийн төгсгөлийн үе нь зөвхөн Буддын шашинд хамааралтай биш, тодорхой хэмжээний их өндөр түвшнээс дооших маш олон орон зайнууд бүгд сүйрлийн доройтолд орсон. Дарма-гийн төгсгөл нь зөвхөн Буддын шашны Дарма-гийн төгсгөл биш юм, бас хүн төрөлхтний нийгэмд ёс суртахууныг сахин барих “сэтгэл зүрхний хууль” гэж байхгүй болсон.

### **Зөвхөн нэг бясалгалаараа тууштай бясалгах**

Бид зөвхөн нэг бясалгалаар тууштай бясалгахыг заадаг, чи яаж ч бясалгасан өөр зүйлийг нэмж оруулан хольж замбараагүй бясалгаж болохгүй. Зарим сүсэгтнүүд Буддын шашны зүйлээр ч бясалгадаг, бас бидний Фалунь Дафа-гийн зүйлээр ч бясалгадаг. Би чамд хэлье, эцэст нь чи юу ч олохгүй, хэн ч чамд юу ч өгөхгүй. Бид бүгд Буддын системийнх, гэсэн ч энд шиньшин-ий асуудал байдаг, мөн нэг бясалгалдаа

тууштай байх асуудал яригдана. Чи зөвхөн нэг л биетэй, чиний биед аль номын үүдний гон гарах юм? Чамд яаж хувиргаж өгөх юм? Чи хаашаа явах гэсэн юм? Чи ямар номын үүдээр орж бясалгана, чи тэнд л очно. Чи Ариун орны Буддын шашнаар бясалгавал Будда Амитаба-гийн диваажинд очно, Оточ Манал Бурхны номоор бясалгавал чи Лиули диваажинд очно, шашинд ингэж л ярьдаг, үүнийг хоёргүй номын үүд гэдэг.

Бидний энд ярьж байгаа бясалгал, гон хувиргах бүхэл явц нь бүгд өөрийн гэсэн Номын үүдний бясалгал дагуу явагддаг. Чи хаашаа явахаа хэл дээ? Хэрэв чи хөлөө хоёр завин дээр зэрэг тавивал юуг ч олж авахгүй. Чийгон бясалгалыг хийдийн доторх Буддын бясалгалтай хольж болохгүй төдийгүй, бясалгалыг хооронд нь, чийгон-ыг хооронд нь, мөн шашныг хооронд нь бас хольж болохгүй. Хэдийгээр нэг шашин ч дотор нь багтах хэд хэдэн бясалгалын номыг бас хольж бясалгаж болохгүй, зөвхөн нэг бясалгалын номыг сонгох ёстой. Чи Ариун орны шашинд бясалгавал зөвхөн Ариун орны шашинд; Тантризмд бясалгавал зөвхөн Тантризмд; Зэн буддизмд бясалгавал зөвхөн Зэн буддизмд бясалга. Хэрэв чи хоёр завин дээр зэрэг гишгэсэнтэй адил энийг ч, тэрийг ч зэрэг бясалгах юм бол юуг ч олж авч чадахгүй. Өөрөөр хэлбэл Буддын шашинд хүртэл хоёргүй номын үүд гэж ярьдаг, чамайг хольж бясалгахыг зөвшөөрөхгүй. Буддын шашинд мөн адил бясалгаж гон гаргана, үүнд гон үүсэх бүхэл явц нь өөрийн номын дагуу бясалгах, мөн хувиргах замаар явагддаг. Өөр орон зайд бас гон хувирах явц байдаг, энэ явц нь маш нарийн бөгөөд их гайхамшигтай, үүнд хамаагүй өөр зүйлийг хольж бясалгаж болохгүй.

Зарим сүсэгтнүүд манай сурагчдыг Буддын системийн бясалгал хийдэг гэж сонсчихоод хийд рүү аваачиж шашинд орох сахил хүртээлгэхийг оролддог. Би энд сууж байгаа сурагч болгонд хэлэхэд хэн ч битгий тийм зүйл хийгээрэй. Тэгвэл чи бидний Дафа-г болон Буддын шашны дэг жаягийг эвдэнэ, мөн түүнчлэн сурагчдад саад болж тэднийг юут ч олж авч чадахгүй байдалд хүргэнэ, ингэж болохгүй. Бясалгал бол нарийн асуудал, заавал тууштай байх ёстой. Манай энгийн хүмүүсийн дунд зааж байгаа энэ хэсэг шашин биш ч гэсэн бясалгалын зорилго нь адилхан, бүгд гоньг нээх, гэгээрэлд хүрэх, бясалгалынхаа төгс төгөлдөрт хүрэх нэгэн зорилготой.

Шагжамүни ингэж хэлсэн, “Дарма-гийн төгсгөлийн үед сүм хийд дэх лам хуврагууд өөрсдийгөө аврахад хэцүү болох төдийгүй Бурхан номтой сүсэгтнүүдийг харж хандах хэн нэгэн бүр ч байхгүй болно.” Чи хэн нэгэнд шавь орсон ч, тэр багш өөрөө бас бясалгадаг хүн, тэр жинхэнэ бясалгадаггүй бол ямар ч нэмэр байхгүй, зүрх сэтгэлээ бясалгахгүй бол хэн ч дээшилж чадахгүй. Сахил хүртэх бол энгийн хүмүүст байдаг зан үйлийн хэлбэр, сахил хүртээд л Буддын номын шавь болчих юм уу? Тэгээд Будда чамайг харж хандах юм уу? Тийм юм гэж байхгүй. Чи өдөр болгон духаа шалбаргал мөргөөд ч, багц багцаар хүж арц уугиулж өргөсөн ч нэмэргүй, чи өөрийн зүрх сэтгэлээ үнэнээр, жинхэнэ бясалгах хэрэгтэй. Дарма-гийн төгсгөлийн үе ирээд байна, орчлон ертөнцөд маш том өөрчлөлт гарсан. Шашин шүтлэгийн газрууд хүртэл доройтсон, тэдгээр ер бусын чадвартай хүмүүс (түүний дотор лам хуврагууд) ч энэ байдлыг бас олж мэдсэн. Одоо дэлхий даяар зөвхөн би ганцаараа ариун Фа-г нийтэд зааж байна, урьд нь хэн ч хийж байгаагүй зүйлийг би хийж

байна, мөн Дарма-гийн төгсгөлийн үед энэ үүдийг өргөн нээсэн. Үнэндээ ийм боломж мянган жилд юм уу эсвэл арван мянган жилд ч тохиолдохгүй, гэхдээ чиний аврагдаж чадах үгүй нь өөрөөр хэлбэл бясалгаж чадах чадахгүй нь чамаас өөрөөс чинь шалтгаална, миний ярьсан бол аугаа орчлон ертөнцийн зарчим юм.

Би чамайг заавал миний Фалунь Дафа-г сур гэж байгаа юм биш, миний ярьж байгаа зүйл бол зарчим. Хэрэв чи бясалгахыг хүсвэл, зөвхөн нэг бясалгалдаа тууштай байх ёстой, тэгэхгүй бол чи огт бясалгаж чадахгүй. Мэдээж, чи бясалгахыг хүсэхгүй бол бид чамайг харж хандахгүй. Фа-г жинхэнэ бясалгах хүнд л заана, сонсоно, тиймээс зөвхөн нэг бясалгалдаа тууштай байх ёстой, өөр бясалгалын бодлыг ч оруулж болохгүй. Би бодлын үйлийг заадаггүй, бидний Фалунь Дафа-д бодлын ямар ч үйл байхгүй, иймээс та бүгд ямар ч бодлын зүйлийг нэмж оруулж болохгүй. Үүнийг сайн санаж явах ёстой, үндсэндээ бодлын ямар ч үйл байхгүй. Буддын системд хоосон чанарыг, Бумбын системд үл оршихуйг номлодог.

Би нэг удаа өөрийнхөө бодлыг маш өндөр түвшний дөрөв таван аугаа гэгээрэгч, аугаа Дао нартай холбосон. Тэдний түвшний өндрийг хэлбэл энгийн хүмүүст төсөөлөхийн аргагүй өндөр. Тэд намайг зүрх сэтгэлдээ юу бодож байгааг мэдэхийг хүссэн. Би ийм олон жил бясалгасан, өөр хүмүүс миний бодлыг мэдэх ямар ч боломжгүй, бусдын ер бусын чадвар огт нэвтрэн орж чадахгүй. Хэн ч намайг мэдэх боломжгүй, тэд ч миний юу бодож байгааг мэдэж чадахгүй, тэд миний бодол санааг мэдэхийг хүссэн, тэгээд миний зөвшөөрснөөр бодлоо миний бодолтой хэсэг хугацаанд холбосон.

Холбогдсоны дараа надад бага зэрэг хэцүү санагдсан, яагаад гэвэл миний түвшин хэр өндөр, нам байх нь хамаагүй, би энгийн хүмүүсийн дунд байгаа, үйлтэй зүйл хийж байна, өөрөөр хэлбэл хүн аврах үйл юм, миний зүрх сэтгэл хүн аварч байна. Харин тэдний сэтгэл ямар амгалан байсан гээч? Тэд аймшигт гүн амгаланд байсан. Нэг хүн тийм хэмжээнд гүн амгаланд ороход бол яах вэ, харин дөрөв таван хүн бүгд ийм гүн амгаланд суухад, энэ нь огт хөдөлгөөнгүй үхмэл цөөрөм мэт байсан, би тэднийг мэдрэхийг хүссэн боловч болоогүй. Тэр хэдэн өдрүүдэд миний сэтгэл их таагүй байсан, тийм нэг мэдрэмжтэй байсан. Энгийн хүн үүнийг төсөөлж мэдрэхийн аргагүй, энэ бол ямар ч үйлгүй, хоосон байсан.

Маш өндөр түвшинд бясалгахад бодлын ямар ч үйл байдаггүй, яагаад гэвэл энгийн хүний түвшинд байгуулагдах цогц суурь нь аль хэдийн чамд суугдсан. Дээд түвшний бясалгалд хүрэхэд, ялангуяа бидний бясалгалын систем үндсэндээ автоматаар явагдана, бясалгал бүрэн автоматаар явагддаг. Чи өөрийнхөө шиньшин-ийг дээшлүүлж л байвал чиний гон өснө, тэр ч байтугай чамд ямар ч хөдөлгөөн хийх шаардлага байхгүй. Бидний дасгал бол энэ автомат механизмыг бэхжүүлэхийн тулд юм, яагаад Буддын бясалгалд сууж бясалгахад үргэлж хөдөлгөөнгүй завилж суудаг вэ? Энэ нь ямар ч үйлгүй (вүвэй) төлөв байдалд ордог. Чи Бумбын бясалгалд ийм ч дасгал, тийм ч хөдөлгөөн, мөн бодлын үйл эсвэл бодлоор удирдах гэж ярьдгийг ажигласан байх. Би чамд хэлэхэд, Бумбын системийн бясалгалд чий-н түвшнээс гарсны дараа юу ч байхгүй болно, энэ тэр бодлын талаар огт ярихгүй. Иймээс өөр чийгон-оор хичээллэж байсан зарим хүн амьсгалаа зохицуулах, бодлоор удирдах гэх мэтийн зүйлээ

орхиж чаддаггүй. Би тэдэнд дээд сургуулийн зүйлийг зааж байхад тэд надаас дандаа бодлоо яаж удирдах, яаж бодлын хөдөлгөөнөөр хийх гэх мэтийн бага сургуулийн зүйлийг асуугаад байдаг, тэд хэзээнээс ийм арга барилд дасчихсан, чийгон-ыг ийм байдаг гэж боддог, үнэндээ ийм байдаггүй.

## **Ер бусын чадвар ба Гон хүч**

Олон хүн чийгон-ы нэр хэллэгийн талаар тодорхой мэддэггүй, зарим хүн үүнд байнга төөрөлдөж байдаг. Тэд ер бусын чадварыг гон хүч, гон хүчийг ер бусын чадвар гэж ярьдаг. Бид өөрсдийн шиньшин-ийг бясалгаснаар олж авдаг гон нь орчлон ертөнцийн мөн чанарт ууссанаар өөрийн Дэ гон болж хувирахад гардаг. Энэ бол тэр хүний түвшний өндөр намыг, гон хүчний их багыг, түүний бүтээлийн орны өндөр намыг тодорхойлдог, энэ бол хамгийн гол гон юм. Бясалгалын явцад хүнд ямар байдал гардаг вэ? Үүний нэг байдал нь гэвэл хүнд зарим онцгой чадварууд гардаг, бид үүнийг товчоор ер бусын чадвар гэдэг. Миний сая дурдсан өөрийн түвшнийг дээшлүүлдэг гон-ыг гон хүч гэж нэрлэдэг. Түвшин өндөр байх тусам гон хүч нь улам их, ер бусын чадвар нь ч улам хүчтэй байдаг.

Ер бусын чадвар нь зөвхөн бясалгалын явцад дагалдан гардаг зүйл юм, тэр нь түвшнийг илэрхийлэхгүй, хүний түвшний өндөр намыг, гон хүчний их багыг илэрхийлэхгүй, зарим хүнд энэ нь их гардаг бол зарим хүнд бага гардаг. Түүнчлэн ер бусын чадвар бол бясалгалын гол зорилго болгон хөөцөлдсөний дүнд олж авдаг зүйл биш. Хүн жинхэнэ бясалгая гэж шийдэх тэр үед түүний ер бусын чадвар нь гардаг, үүнийг бясалгалынхаа гол зорилго болгож болохгүй.

Чи эдгээр зүйлийг юуны тулд бясалгаж байгаа юм бэ? Зүгээр л энгийн хүмүүсийн дунд хэрэглэх гэж үү? Чамайг энгийн хүмүүсийн дунд хамаагүй хэрэглэхийг огт зөвшөөрөхгүй, тиймээс чи үүнийг хүсэх тусам улам олж авахгүй. Яагаад гэвэл чи хүсэж байна, хүсэх бол өөрөө зууралдсан сэтгэл. Бясалгалд чухамдаа зууралдсан сэтгэлийг л хаях ёстой байдаг.

Их олон хүн маш өндөр түвшинд бясалгаж хүрсэн ч ер бусын чадваргүй байдаг. Багш нь үүнийг түгждэг, түүнийг өөрийгөө сайн барьж чадахгүйгээс муу зүйл хийж мэднэ гэж болгоомжилдог, иймээс ямагт түүнийг ер бусын чадварыг ил гаргуулахгүй, ийм хүмүүс нэлээд олон байдаг. Ер бусын чадвар нь хүний бодлоор захирагддаг. Хүн унтаж байхдаа зүүдэндээ өөрийгөө зөв барьж чадахгүйгээс маргааш өглөө нь магадгүй тэнгэр газрыг хөмрүүлчихсэн байж мэднэ, ийм юм болохыг зөвшөөрөхгүй. Яагаад гэвэл энгийн хүмүүсийн дунд бясалгаж байгаа, иймээс аливаа аугаа ер бусын чадвар хэрэглэхийг зөвшөөрөхгүй, ихэнх нь түгжигддэг, гэхдээ үргэлж ийм байхгүй. Сайн бясалгасан хүн их олон бий, тэд өөрсдийгөө сайн барьж чаддаг учраас зарим ер бусын чадвартай байхыг нь зөвшөөрдөг. Чи тийм хүмүүсээс ер бусын чадвараа үзүүлээч гэж гуйсан ч тэд яасан ч үзүүлэхгүй, тэд өөрсдийгөө барьж чаддаг.

## **Урвуу бясалгал ба Гон зээлдэх**

Зарим хүн өмнө нь чийгон-оор хичээллэж байгаагүй, эсвэл аль нэгэн чийгон-ы хичээлд сууж хэдэн хөдөлгөөн л заалгадаг, гэхдээ тэр бүгд нь өвчнийг арилгах бие сайжруулах зүйлд л харьяалагддаг, бясалгал биш. Өөрөөр хэлбэл тийм хүн жинхэнэ уламжлан аваагүй, гэхдээ нэг шөнө түүнд гэнэт гон ирсэн. Бид энэ гон яаж ирснийг ярья, ийм хэдэн хэлбэр байдаг.



Нэг хэлбэр нь урвуу бясалгалд харьяалагддаг. Урвуу бясалгал гэж юу вэ? Энэ бол нэлээд настай зарим хүн бясалгах хүсэлтэй байдаг, гэхдээ эхнээс нь бясалгахад амжихгүй болсон. Чийгон дэлгэрч байсан оргил үед тэд бас бясалгахыг хүссэн, тэд чийгон-оор хичээллэхэд бусдад сайн зүйл хийж өгч болно, мөн өөрийгөө ч дээшлүүлж болно гэдгийг мэдсэн, тэдэнд ийм нэг хүсэл, дээшлэх бодол, бясалгах сэтгэл байсан. Хэдэн жилийн өмнө чийгон-ы оргил үед тэдгээр чийгон багш нар бүгд чийгон-ыг дэлгэрүүлж байсан боловч хэн ч жинхэнэ дээд түвшний зүйлийг зааж байгаагүй. Өнөөдрийг хүртэл бүх нийтэд чийгон-ыг жинхэнэ дээд түвшинд заахыг би ганцаараа хийж байна, хоёрдогч хүн байхгүй. Урвуу бясалгалаар яваа алив хүн, бүгд тавиас дээш настай, нэлээд ахимаг настай хүмүүс байдаг, төрөлхийн суурь нь маш сайн, биен дэх зүйлүүд нь ч бас их сайн, эдгээр хүмүүсийн ихэнх нь багш нарын шавиа болгомоор, залгамжлагч нь болж болмоор хүмүүс байдаг. Гэтэл эдгээр хүмүүс нэлээд өндөр настай учраас бясалгахыг хүссэн ч тийм амар биш! Хаанаас багш олох юм? Гэхдээ тэд бясалгахыг хүсэхэд, энэ сэтгэл нь гармагц алт шиг гялалзаж арван зүгийн хорвоог доргионо. Хүмүүс Буддын мөн чанарын талаар ярьдаг, энэ бол Буддын мөн чанар нь гарч ирсэн гэсэн үг юм.

Дээд түвшнээс харахад хүний амь бол хүн байхын тулд байдаггүй. Яагаад гэвэл хүний амь бол орчлон ертөнцийн орон зайд үүссэн, орчлон ертөнцийн Жэнь, Шань, Рэнь гэсэн мөн чанарт ууссан байдаг, уг чанар нь нинжин бөгөөд энэрэнгүй. Гэхдээ амь боднуд өсөж олшироход нийгмийн харилцаа үүсдэг, тэгээд тэдний дунд зарим нь хувиа хичээж, эсвэл муу болж их өндөр түвшинд байх боломжгүй болдог,

тэд доош тодорхой нэг түвшин рүү унаж ирдэг. Тэр түвшиндээ бас муу болж дахиад доош унадаг, энэ байдлаар үргэлжилсээр эцэст нь энгийн хүний энэ түвшинд унаж ирдэг. Энэ түвшинд унаж ирсэн бол тэд бүрмөсөн устгагдах ёстой, гэхдээ тэдгээр аугаа гэгээрэгчид нигүүлсэнгүй сэтгэлийн үүднээс хамгийн зовлонтой энэ орчинд хүнд дахин нэг боломж өгөхөөр шийдсэн, тиймээс ийм нэгэн орон зайг бүтээсэн юм.

Бусад орон зайн хүмүүст ийм бие байдаггүй, тэд дээш хөөрч чаддаг төдийгүй бас том, жижиг болон хувирч чаддаг. Харин энэ орон зайн хүнд ийм нэгэн биенийг өгсөн, бидний энэ махан бие бодь юм. Ийм биетэй болсноос хойш даарах, халууцах, ядрах эсвэл өлсөж, цангахыг тэсвэрлэхэд бэрх, яадаг ч байсан зовлонтой. Өвдөхөд чи зовдог, түүнчлэн төрөх, хөгшрөх, өвчлөх, үхэх оршиж буй нь чамаар зовлонг туулуулж нүглийг чинь төлүүлж байгаа юм, чамайг буцаж чадах эсэхийг чинь харах гэж дахин нэг боломж өгдөг, иймээс хүн төөрөгдлийн дунд унаж ирдэг. Энд унаж ирсний дараа чамд ийм хоёр нүдийг бүтээж өгсөн, чамд бусад орон зайнууд болон бие бодийн үнэн байдлыг харуулахгүй. Чи буцаж чадна гэвэл, хамгийн хүнд зовлон хамгийн нандин байх болно, төөрөгдлийн дунд ухамсраараа бясалгаад буцъя гэвэл маш их зовлонтой байдаг, гэхдээ буцахад хурдан. Хэрэв чи дахин муу болбол чиний амь устгагдана, иймээс тэдний харснаар хүний амь бол хүн байхын тулд биш, энэ нь чамайг үүссэн эх үндсэндээ буц, үнэнд хүр, харь гэсэн үг. Энгийн хүн үүнийг ухаарч чаддаггүй, энгийн хүн бол энгийн хүний нийгэмд яаж өөрийгөө хөгжүүлэх, яаж сайхан амьдрах тухай л боддог, тэр бол энгийн хүн. Тэр улам сайхан амьдрах тусам улам хувна хичээнэ, улам их

шунана, тэгээд орчлон ертөнцийн мөн чанараас улам бүр хазайна, улмаар тэр мөхөл рүүгээ явна.

Чи өөрийгөө урагшлан ахиж байна гэж бодовч дээд түвшнээс харахад үнэндээ хойш ухран явж байгаа юм. Хүн төрөлхтөн шинжлэх ухаан хөгжиж дэвшил гарч байна гэж боддог боловч үнэндээ энэ бол зөвхөн орчлон ертөнцийн зүй тогтлын дагуу явагдаж байгаа юм. Найман гэгээрэгчийн нэг Жан Гуолао ар нуруугаараа харж илжиг унадаг байсан, яагаад түүнийг ар нуруугаараа харж илжиг унадаг байсныг мэддэг хүн маш ховор. Тэрээр урагшаа явах нь хойшпоогоо ухарч байна гэж олж мэдсэн, тэгээд тэр буруу харж илжгээ унадаг байсан. Тиймээс зарим хүн бясалгахыг хүсэхэд гэгээрэгчид энэ сэтгэлийг нь маш нандин гэж үздэг, түүнд болзолгүйгээр тусалж болно. Өнөөдөр энд сууж байгаа сурагчидтай адил, хэрэв чи бясалгахыг хүсвэл би чамд ямар ч болзолгүйгээр тусалж болно. Гэхдээ чи энгийн хүний адил өвчнөө үзүүлэх, энэ тэр юм хүсэх бодолтой байвал болохгүй, чамд тусалж чадахгүй. Яагаад вэ? Учир нь чи энгийн хүнээрээ байх бодолтой, энгийн хүн бол төрөх, хөгшрөх, өвчлөх, үхэх жамаар явдаг, ийм л байх ёстой, бүх зүйл үйлийн үрийн барилдлагатай байдаг, үүнийг бусниулж болохгүй. Чиний амьдралд бясалгах асуудал анхнаасаа байгаагүй, харин одоо чи бясалгахыг хүсэж байна, тэгвэл чиний хойшдын амьдралын замыг шинээр зохицуулж өгөх хэрэгтэй, тиймээс чиний биенийг засаж өгч болно.

Тэгвэл хүн бясалгахыг хүсэхэд, энэ хүсэл гарахад аугаа гэгээрэгчид үүнийг хараад маш нандин гэж үздэг. Гэхдээ яаж түүнд туслах вэ? Энэ дэлхийн хаанаас багшийг олох юм? Тэр бас тавь гарсан настай, аугаа гэгээрэгчид түүнд зааж болохгүй, яагаад гэвэл хэрэв

тэд илэрч гарч ирээд чамд Фа болон дасгал заавал тэнгэрийн нууцыг задалсан болно, тэд өөрсдөө доош унах болно. Хүн өөрөө муу зүйл хийснээс энэ төөрөгдлийн дунд унаж ирсэн, төөрөгдлийн дунд ухамсраараа бясалгах ёстой, иймээс гэгээрэгчид зааж болохгүй. Хэрэв Будда хүмүүсийн нүдэн дээр бодитоор илэрч гарч ирээд чамд Фа болон дасгал зааж байгааг харвал уучилшгүй арван хар нүгэлтэй хүн ч ирж сурна, хэн ч итгэнэ, тэгвэл юуг нь ухамсарлах юм, ухамсарлах асуудал байхгүй болно. Хүн өөрөөсөө болоод энэ төөрөгдлийн дунд унасан, уг нь устгагдах ёстой, гэхдээ чамд төөрөгдлийн дунд бясалгаад буцах дахин нэг боломжийг өгсөн. Чи буцаж чадна гэвэл буц, буцаж чадахгүй бол үргэлжлүүлэн зургаан замын тойрогт дахин төрөл олох замаар явна, эсвэл устана.

Ямар замаар явах нь хүний өөрийн хэрэг байдаг, хэрэв хүн бясалгахыг хүсвэл яах вэ? Тэд нэг арга бодож олсон, тэр үед чийгон оргил үедээ байсан, энэ бас нэг янзын тэнгэрийн өөрчлөлт юм. Иймээс гэгээрэгчид энэ тэнгэрийн байдалд нийцүүлэх үүднээс тэр хүний шиньшин-ий хэмжээнд тааруулан гон өгнө, нэг уян хоолойг түүний биед байрлуулдаг, энэ нь усны гоожуур шиг онгойлгоход энерги ирдэг. Тэр хүн гон гаргахыг хүсэх үед гон ирнэ, тэгэхдээ жирийн үед түүний биед гон байдаггүй, ийм л байдаг. Үүнийг урвуу бясалгал гэж нэрлэдэг, дээрээс доошоо бясалгаад гэгээрэх юм.

Бид ер нь бясалгахдаа, доороос дээшээ гон нээгдэж төгс гэгээрэлд хүртлээ бясалгана. Энэ урвуу бясалгал нь доороос дээш бясалгахад амжихгүй болсон настай хүмүүсийн хувьд юм, иймээс дээрээс доош бясалгахад хурдан байдаг, энэ бол тэр үед гарсан нэг байдал юм. Ийм хүний шиньшин заавал их өндөр байх ёстой,

түүнчлэн түүний шиньшин-ий түвшинд тохирсон хэмжээний энергийг өгдөг. Үүний зорилго нь юу вэ? Нэг зорилго нь бол тэр үеийн тэнгэрийн байдал нийцүүлэх явдал юм, тэр хүн сайн зүйл хийхийн зэрэгцээ зовлон амсана. Яагаад гэвэл энгийн хүмүүстэй нүүр тулна, энгийн хүний янз бүрийн сэтгэл чамайг үймүүддэг. Чи хэн нэгний өвчнийг эдгээж өгсөн, гэвч тэр үүнийг ойшоож үзэхгүй, чи түүний өвчнийг эдгээхдээ биеэс нь олон муу зүйлийг авч хаясан ч, хэр их эдгээсэн ч тухайн үедээ магадгүй мэдэгдэхүйц өөрчлөлт харагдаагүй. Гэвч түүний сэтгэл хангалуун биш, чамд ер талархахгүй, харин тэр магадгүй чамайг загнаж өөрийг нь залилсан гэж буруутгана! Иймэрхүү асуудалтай тулгарахад энэ орчин нь чиний сэтгэлийг хатуужуулдаг. Гон өгсөн зорилго бол түүнийг бясалгуулж дээшлүүлэхэд юм. Сайн үйл хийхийн зэрэгцээ өөрийнхөө ер бусын чадварыг хөгжүүлж бас гон-оо өгсөнө, гэхдээ зарим хүн энэ зарчмыг мэддэггүй. Ийм хүнд Фа зааж болохгүй гэж би хэлсэн биз дээ? Ухамсарлаж чадвал ухамсарла, ухамсарлаж чадахгүй бол ямар ч арга байхгүй, энэ бол ухамсрын асуудал.

Зарим хүнд гон ирэхэд, нэг шөнө унтаж байхдаа гэнэт халууцаад хөнжил ч нөмөрч чадахгүй болдог, өглөө босож ирээд гараа юунд л хүргэнэ тог цохилно. Тэр гон ирснийг мэдсэн, хэн нэгний бие хаа нэгтэй өвдөхөд тэнд нь гараараа нэг илээд л зүгээр болгоно, нэлээд сайн үйлчилнэ. Тэр үүнээс хойш гон-той болсноо мэдээд чийгон багш болж пайз өлгөнө, тэр өөрийгөө чийгон багш гэж нэрлээд ажлаа эхэлнэ. Эхэндээ энэ хүн нэлээд сайн байсан учраас хүний өвчнийг эдгээж өгөхөд түүнд өгсөн мөнгө эсвэл гарын бэлгийг тэр магадгүй авахгүй, татгалзана. Гэвч

тэр энгийн хүний нийгмийн будагтай том торхноос бохирдохгүй гарч чадахгүй, яагаад гэвэл эдгээр урвуу бясалгалаар яваа хүмүүс жинхэнэ шиньшин-ий бясалгал хийгээгүй, тэдэнд өөрийнхөө шиньшин-ийг барихад хэцүү. Аажмаар жижигхэн бэлгийг хүлээн авч эхэлнэ, дараа нь том бэлэг өгсөн ч авдаг болно, эцэст нь бага юм өгөхөөр чамладаг болно. Бүүр эцэст нь тэр, ийм олон хэрэгтэй, хэрэггүй юм өгч яах юм? Мөнгө өгчих! гэж хэлнэ. Бага мөнгө өгвөл бас чамлана. Тэр жинхэнэ уламжлагдсан чийгон багшийг хүртэл үл тоомсорлоно, түүний чих нь өөрийг нь их чадвартай гэж хэлсэн хүмүүсийн магтаалаар дүүрнэ. Хэн нэгэн түүнийг муулбал дургүй нь хүрнэ, нэр хүнд ашгийн сэтгэл нь бүгд гарч ирнэ, тэр өөрийгөө бусдаас гарамгай чадалтай, мундаг гэж үзнэ. Түүнд чийгон багш болог, баян болог гэж гон өгсөн гэж буруугаар ойлгосон, үнэндээ бол түүнийг бясалга гэж өгсөн юм. Нэр алдар, ашгийн сэтгэл гарахад түүний шиньшин үнэндээ уначихдаг.

Шиньшин хэр өндөр байна, гон түвшин тэр хэмжээгээр өндөр байна гэж би хэлсэн. Шиньшин унаж ирвэл түүнд тийм их гон өгөхгүй болно, яагаад гэвэл шиньшин-ий дагуу өгөх ёстой, шиньшин нь хэр өндөр байна, гон тэр хэмжээгээр өндөр байна. Энэ нэр, ашгийн сэтгэлийг улам чухалд үзэхэд энгийн хүмүүсийн дунд улам доош унана, түүний гон бас дагаад доош унадаг. Эцэст нь тэр бүр мөсөн унахад түүнд ямар ч гон өгөхгүй болно, ямар ч гон байхгүй болно. Хэдэн жилийн өмнө нэлээд олон ийм хүн гарч ирсэн, тавь гаруй насны эмэгтэйчүүд нэлээд байсан. Настай эмэгтэйг чийгон-оор хичээллэж байхыг нь харсан байх, гэхдээ тэр жинхэнэ уламжилж аваагүй, аль нэгэн чийгон-ы ангид өвчин эдгээх, бие эрүүлжүүлэх

хэдхэн дасгал хөдөлгөөнийг сурсан байж болно, нэг өдөр түүнд гэнэт гон ирсэн. Шиньшин нь муудахад нэр алдар, ашгийн сэтгэлд автаж доош унасан, эцэст нь тэр одоо хэн ч биш болсон, гон ч байхгүй болсон. Одоо ийм урвуу бясалгалаар унасан хүн олон байдаг, тэднээс зөвхөн цөөхөн хэд нь л үлдсэн. Яагаад вэ? Энэ нь түүнийг бясалгуулах гэж өгснийг ухаараагүй тэр өөрийгөө энгийн хүмүүсийн дунд баян болог, нэрд гараг, мөн чийгон багш болог гэж өгсөн гэж буруу ойлгосон, үнэндээ энэ бол түүнд бясалгах боломж өгөх гэсэн хэрэг юм.

Гон зээлэх гэж юу вэ? Үүнд насны хязгаар байхгүй, гэхдээ нэг шаардлага бий, тухайн хүн маш сайн шиньшин-тэй байх ёстой. Тэр хүн чийгон-оор бясалгаж болно гэдгийг мэддэг, бас бясалгах хүсэлтэй. Бясалгах сэтгэлтэй байсан ч тэр хаанаас багш олох юм? Хэдэн жилийн өмнө жинхэнэ чийгон багш нар чийгон-ыг зааж байсан, гэхдээ тэдний заасан нь бүгд өвчин эдгээх бие сайжруулах зүйлс л байсан, хэн ч дээд түвшний зүйлийг зааж байгаагүй, заах ч үгүй.

Гон зээлэхийг ярингаа би бас өөр нэг асуудлыг авч ярья. Хүнд Эзэн сүнснээс (Жу Юань-шэнь) (Эзэн бодол), гадна бас Дэд сүнс (Фу Юань-шэнь) (Дэд бодол) байдаг. Зарим хүнд нэг, хоёр, гурав, дөрөв, бас таван Дэд сүнс байдаг. Энэ Дэд сүнсний хүйс нь тухайн хүнийхтэй магадгүй адилхан биш, зарим нь эрэгтэй бас зарим нь эмэгтэй байдаг, бүгд адилгүй. Үнэндээ Эзэн сүнсний хүйс нь бас махан биеийнхтэй адил байх албагүй, яагаад гэвэл одоогийн маш олон эрэгтэй хүн эм Эзэн сүнсстэй, маш олон эмэгтэй хүн эр Эзэн сүнсстэй гэдгийг бид олж мэдсэн. Энэ нь Бумбын система ярьдагаар одоо арга, билиг эсрэгээр эргэсэн

буюу билиг нь мандаж арга нь буурсан гэх тэнгэрийн байдалтай яг таарч байгаа юм.

Хүний Дэд сүнс нь Эзэн сүнсийг бодвол гол төлөв арай дээд түвшнээс ирдэг, ялангуяа зарим хүний Дэд сүнс маш өндөр түвшнээс ирсэн байдаг. Дэд сүнс бол биед шүтлэсэн сүнс биш, тэр чиний эхийн хэвлийгээс чамтай хамт зэрэг төрсөн, тэр чамтай адил нэртэй, чиний биеийн нэг хэсэг юм. Жирийн үед хүмүүс ямар нэг юм бодох, эсвэл ямар нэг зүйл хийхэд Эзэн сүнсний шийдвэрээр болдог. Дэд сүнс гол нь хүний Эзэн сүнсийг аль болох муу зүйл хийлгэхгүй байхыг хичээдэг, гэхдээ Эзэн сүнс их гэжүүд байхад Дэд сүнс яаж ч чадахгүй. Дэд сүнс энгийн хүний нийгэмд төөрөлддөггүй, харин Эзэн сүнс энгийн хүний нийгэмд амархан төөрдөг.

Зарим Дэд сүнс маш өндөр түвшнээс ирсэн байдаг, магадгүй бясалгалаар гэгээрлийн хутагт хүрэхийн даваан дээр байж болно. Дэд сүнс бясалгах хүсэлтэй байдаг, гэхдээ Эзэн сүнс бясалгах бодолгүй бол түүнд ямар ч арга байхгүй. Чийгон өргөн дэлгэрч байсан оргил үед Эзэн сүнс нь нэг өдөр чийгон-оор хичээллэхийг бодсон, дээд түвшинд бясалгахыг хүссэн, тэр бодол нь мэдээж маш энгийн бөгөөд цайлган байсан, нэр алдар ашиг гэх мэтийн зүйлээр хөөцөлдөх бодол байгаагүй. Дэд сүнс их баярласан, “Би бясалгахыг хүсдэг, гэхдээ миний хүслээр болдоггүй, чи бясалгах бодолтой болсон нь яг миний хүсэлтэй нийцэж байна.” Гэвч хаанаас багш олох вэ? Дэд сүнс нэлээд чадвартай, тэр биеэс гараад урьд насандаа мэддэг байсан аугаа гэгээрэгчийг олохоор явна. Зарим Дэд сүнсний түвшин их өндөр учраас биеэс гарч явж чадна, тэнд очоод тэр бясалгах хүсэлтэй



байгаагаа, гон зээлэхээр ирснээ хэлнэ. Аугаа гэгээрэгч түүнийг боломжийн сайн болохыг хараад бясалгахад нь дуртайяа тусална, ингээд Дэд сүнс нь гон зээлж аваад ирнэ. Энэ гон ихэнхдээ цацарсан энергитэй бөгөөд хоолойгоор дамжуулагддаг; зарим зээлдсэн гон нь бэлэн хэлбэрээр ирдэг, бэлэн хэлбэртэй зүйл нь гол төлөв ер бусын чадвартай дагалдаж ирдэг.

Ийм байдлаар тэр бас ер бусын чадвартай болж болно, энэ хүн миний дөнгөж сая ярьсан шиг нэг шөнө унтаж байхдаа бас их халууцна, маргааш өглөө нь босож ирэхэд гон ирсэн байна. Хаана ч хүрсэн тог цохилохыг мэдэрнэ, мөн хүний өвчнийг эдгээж чаддаг болсон, тэр гон-той болсноо ойлгоно. Энэ нь хаанаас ирсэн бэ? Тэр мэдэхгүй. Тэр үүнийг орчлон ертөнцийн орон зайнаас ирсэн гэдэг л бүрхэг таамаглалтай, гэхдээ яг яаж ирснийг тэр мэдэхгүй, Дэд сүнс түүнд хэлэхгүй, яагаад гэвэл Дэд сүнс л бясалгаж байгаа, тэр зөвхөн өөрийгөө гон-той болсноо л мэднэ.

Гон зээлэхэд гол төлөв насны хязгаар байдаггүй учраас залуу хүмүүс нэлээд олон байсан, тиймээс хэдэн жилийн өмнө хорин хэдтэй, гучин хэдтэй бас дөч гаруй насны хүмүүс байсан, ахимаг настай хүмүүс ч бас байсан. Залуу хүнд өөрийгөө барихад илүү хэцүү байдаг, энгийн хүний нийгэмд ямар ч чадваргүй байхдаа ийм хүн ер нь нэлээд сайн юм шиг харагддаг, нэр алдар хувийн ашиг сонирхолд даруу ханддаг. Харин тэр жаахан нэр цуутай болмогц ихэвчлэн нэр алдар, ашгийн үймүүлэлд амархан автдаг, тэр бас амьдралын урт зам өмнө нь байна гэж боддог, тэгээд энгийн хүмүүсийн зорьдог зарим зүйлд хүрэхийн тулд янз бүрээр чармайна. Иймээс ер бусын чадвар гарахад, зарим увдистай болонгуут тэр үүнийг ихэнхдээ энгийн

хүний нийгэмд хувийн зорилгодоо хүрэх хэрэгсэл болгон ашиглана. Тэгвэл болохгүй, ингэж хэрэглэхийг зөвшөөрөхгүй, тэр их хэрэглэх тусам гон нь улам багасна, эцэст нь түүнд юу ч үгүй болно. Ингэж унаж ирсэн хүн бүр ч олон байдаг, миний харснаар одоо ийм хүн нэг ч үлдээгүй.

Миний сая ярьсан гон гарах энэ хоёр тохиолдол нь нэлээд сайн шиньшин-тэй хүмүүст гардаг, энэ гон-ыг тэд өөрсдөө бясалгаж гаргасан биш, харин аугаа гэгээрэгчээс ирсэн болохоор уг гон нь өөрөө сайн юм.

### **Сүнс шүглэх**

Бясалгагчдын хүрээнд, магадгүй та нарын олонх нь үнэг, үен, зараа, могой гэх мэтийн амьтдын сүнс шүглэх тухай сонссон байх. Энэ нь чухам ямар учиртай вэ? Зарим хүн чийгон-оор хичээллээд ер бусын чадвартай болдог гэж ярьдаг, үнэндээ ер бусын чадварыг бий болгодог юм биш, харин тэдгээр нь хүний төрөлхийн чадвар юм. Хүн төрөлхтний нийгэм хөгжихийн хэрээр, хүмүүс бидний энэ материаллаг орон зайн бодит зүйлсийг улам ихээр чухалчлан үздэг болж, улмаар орчин үеийн тоног төхөөрөмжөөс улам хамааралтай болох болсон, иймээс хүний төрөлх чадварууд нь улам бүр буурсан, эцэст нь эдгээр чадварууд нь бүрмөсөн алга болсон.

Ер бусын чадвартай болохыг хүсвэл бясалгаж өөрийнхөө үүссэн эх үндсэндээ буцаж үнэнд хүрэх хэрэгтэй, үүнийг бясалгалаар олно. Харин амьтанд ийм төвөгтэй бодол байдаггүй, тэр орчлон ертөнцийн мөн чанартай холбоотой байдаг учраас төрөлхийн зөн совинтой. Зарим хүн, амьтныг бясалгаж чаддаг, үнэг “үрэл”-ийг бясалгаж чадна, могой гэх мэт амьтад

бясалгахыг мэддэг гэж ярьдаг. Тэр амьтад бясалгахыг мэддэг юм биш, анхандаа тэд бясалгал гэж юу болохыг ч огт мэддэггүй, зөвхөн төрөлх зөн совинтой л байдаг. Тэгээд онцгой нөхцөл байдалд, тодорхой орчинд удаан хугацаа өнгөрсний дараа магадгүй үр нөлөө нь гардаг, мөн тэр амьтан гон-той болж ер бусын чадвар гаргаж чаддаг болно.

Ийм байдлаар амьтан зарим чадвартай болдог, бидний урьд ярьснаар удист энерги (линчи) ба чадвартай болсон юм. Энгийн хүн харахад амьтад их айхтар, хүнийг эрхшээлдээ амархан оруулж чаддаг. Үнэндээ би тэднийг айхтар биш, жинхэнэ бясалгагчийн өмнө тэд бол юу ч биш гэж хэлнэ, тэр нь мянга орчим жил бясалгасан ч бай түүнийг няцлахад чигчий хуруу ч элбэг хангалттай. Амьтад төрөлхийн ийм зөн совинтой байдаг, тэдэнд зарим чадвар гарч болно гэж бид хэлсэн. Гэхдээ манай орчлон ертөнцөд нэг зарчим байдаг, энэ нь амьтдыг бясалгаад үр дүнд хүрэхийг нь зөвшөөрөхгүй. Иймээс хэдэн зуун жил тутамд, их гамшигт эсвэл бага сүйрэлд амьтад устгагддаг болохыг та нар эртний номуудаас олж уншиж болно. Амьтад нэг тодорхой хугацаанд гон нь өсөхөд тэднийг аянгаар ниргэж юм уу өөр байдлаар устгана, бясалгахыг нь зөвшөөрөхгүй. Яагаад гэвэл тэдэнд хүний мөн чанар байхгүй, тэд хүн шиг бясалгаж чадахгүй, тэдэнд хүнтэй адил шинж чанар байхгүй, хэрэв тэд бясалгаад үр дүнтэй болбол гарцаагүй буг чөттөр болно, тиймээс бясалгаад үр дүнтэй болохыг нь зөвшөөрөхгүй, тэнгэр тэднийг ниргэнэ, тэд ч бас үүнийг мэддэг. Гэхдээ би хэлсэн, одоо хүн төрөлхтний нийгэм маш ихээр доройтсон, зарим хүнд хийхгүй муу зүйл гэж байхгүй болсон, ийм үе шатанд тулж ирсэн нь хүн төрөлхтний нийгэм аюулд орсон биш гэж үү?

Юмс үзэгдэл туйлдаа хүрэхэд хувьсал гарах нь зайлшгүй! Түүхийн өмнөх үеүдэд, хүн төрөлхтний нийгэм удаа дараалан устгалд орох бүрд, энэ нь хүн төрөлхтний ёс суртахуун туйлын ихээр доройтсоноос болж гардаг байсныг бид олж мэдсэн. Одоо хүн төрөлхтний оршиж байгаа орон зай болон бусад олон орон зайнууд бүгд туйлын аюултай нөхцөл байдалд байна, энэ түвшний бусад орон зайнууд ч мөн адил, амьтад зугтах гэж яарч байна, дээд түвшин рүү гарахыг хүсэж байна, тэд дээд түвшинд гарвал зугтаж чадна гэж боддог. Гэхдээ яаж тийм амархан байх юм? Бясалгаа гэвэл заавал хүний биетэй байх ёстой, иймээс энэ нь зарим чийгон бясалгагчдад сүнс эсвэл амьтан шүглэх байдал гардгийн нэг учир нь юм.

Зарим хүн ингэж боддог, “Ийм олон аугаа гэгээрэгчид болон өндөр түвшинд хүрсэн багш нар байдаг атал яагаад үүнд арга хэмжээ авахгүй байна вэ?” Манай энэ орчлон ертөнцөд бас ийм нэгэн зарчим байдаг: “Чиний өөрөө хүссэн эсвэл авах бодолтой зүйлд бусад хүмүүс хөндлөнгөөс оролцох дургүй.” Энд бид та бүгдэд зөв замаар явахыг зааж байна, мөн түүнчлэн Фа-г дэлгэрэнгүй тайлбарлан өгч байна, чамаар өөрөөр чинь ухамсарлуулна, сурах сурахгүй нь чиний өөрийн хэрэг. Багш чамайг үүдээр оруулж өгнө, харин бясалгал бол өөрөөс шалтгаална. Хэн ч чамайг албадаж бясалгуулахгүй, бясалгах бясалгахгүй нь хувь хүний хэрэг, өөрөөр хэлбэл чи ямар замаар явах, юуг хүсэж юуг олж авахад чинь хэн ч оролцохгүй, бид хүмүүст зөвхөн сайн хүн байхыг зөвлөнө.

Чи зарим хүнийг чийгон-оор хичээллэж байгааг нь харсан, үнэндээ бясалгасан гон-ыг шүглэсэн сүнс нь авдаг. Яагаад тэд сүнсийг эсвэл амьтныг

өөртөө татсан бэ? Бүх орон даяар хэчнээн чийгон бясалгагчдын ар талд нь шүглэсэн сүнс байгаа вэ? Хэрэв би энэ тоог хэлбэл маш олон хүн чийгон-оор хичээллэхээс зүрхшээх болно, энэ тоо бол аймшигтай их! Тэгвэл яагаад ийм байдал үүссэн бэ? Эдгээр зүйлс энгийн хүний нийгэмд төвөг учруулж байна, яагаад ийм ноцтой үзэгдэл гарсан бэ? Үүнийг бас хүмүүс өөрсдөө өдөөсөн, яагаад гэвэл хүн төрөлхтөн улам бүр доройтож байна, мөн буг чөтгөрүүд хаа сайгүй байна. Ялангуяа тэдгээр хуурамч чийгон багш нарын биед бүтэд нь шүглэсэн сүнс байгаа, тэд бясалгал заахдаа үүнийг л дамжуулдаг. Хүн төрөлхтний түүхэнд амьтад хүний биед гарах нь хориотой байсан, тэд гарвал устгагддаг, хэн ч харсан үүнийг зөвшөөрөхгүй. Гэвч өнөөдрийн манай нийгэмд зарим хүн тэднээс юм гуйдаг бас тэднийг хүсдэг, тахин шүтдэг. Зарим хүн ингэж бодож магадгүй, “Би яг түүнийг хүсээгүй шүү дээ!” Чи түүнийг хүсээгүй, гэхдээ чи ер бусын чадвартай болохыг хүсэж байна, ариун номоор бясалгасан гэгээрэгч чамд үүнийг өгөх юм уу? Хүсэх бол энгийн хүний зууралдсан сэтгэл, энэ сэтгэлийг хаях ёстой. Тэгвэл хэн чамд үүнийг өгөх вэ? Зөвхөн өөр орон зайны буг чөтгөрүүд болон янз бүрийн амьтад чамд өгч болно, тэгвэл тэднээс гуйсантай адил болно биз дээ? Тэгээд тэд ирнэ.

Хэр олон хүн зөв бодолтойгоор чийгон-оор хичээллэдэг вэ? Чийгон-оор хичээллэхэд Дэ-г эрхэмлэж, сайн үйл хийж, сайхан сэтгэлтэй байхыг шаарддаг, бүх зүйлд болон ямар ч нөхцөлд өөртөө ингэж хандах ёстой. Цэцэрлэгт хүрээлэнд болон гэртээ хичээллэгчдээс хэр олон хүн ингэж боддог вэ? Зарим хүн ямар янзын чийгон-оор хичээллээд байгаа нь ч мэдэгдэхгүй, нэг нь биеэрээ найган дасгал хийнгээ

амандаа үглэнэ: “Хм, манай бэр надад ачлал халамжгүй; хадам ээж бол ёстой зэвүүн!” Зарим нь ажлын газраас авхуулаад улсын хэрэг хүртэл хов жив ярина, тэдэнд ярихгүй зүйл гэж үгүй, тэдний үзэл бодолтой нь санал нийлэхгүй бол ихэд уурлана. Үүнийг чи чийгон бясалгал гэх үү? Мөн зарим нь зогсоо дасгал хийж байхдаа хөл нь ядраад чилэн чичирч байсан ч тархи нь завгүй ингэж бодно: “Одоогийн юмны үнэ хэтэрхий үнэтэй байна, юмны үнэ өсөөд л байх юм, ажлын газар ч цалингаа тавьж чадахгүй, надад яагаад ер бусын чадвар гарахгүй байгаа юм болоо? Хэрэв би ер бусын чадвартай болбол би ч бас чийгон багш болоод баян чинээлэг болно, өвчтөнийг үзэж өгөөд мөнгөтэй болно.” Тэр өөр хүнд ер бусын чадвар гарсныг нь харчхаад улам яарна, тэр ер бусын чадварын хойноос хөөцөлдөнө, тэнгэрийн мэлмийг хүснэ, мөн өвчин эдгээх чадвартай болохыг хүснэ. Та бүгд боддоо, энэ нь манай орчлон ертөнцийн Жэнь, Шань, Рэнь мөн чанараас ямар хол байна аа! Энэ нь бүхэлдээ эсрэгээрээ явж байна. Ноцтойгоор хэлбэл, энэ хүн буруу номоор бясалгаж байна! Гэвч тэр үүнийг өөрийн мэдэлгүй хийж байгаа. Тэр ингэж бодох тусам түүнээс гарах бодол нь улам муу болдог. Энэ хүн Фа олж аваагүй төдийгүй Дэ-г эрхэмлэхээ мэдэхгүй байна, зүгээр дасгал хийгээд л гон-той болно бас хүссэн юм болгоноо хөөцөлдөж олж авч болно гэж боддог, тэр ингэж л боддог.

Түүний бодол зөв биш учраас өөртөө муу зүйлийг дууддаг. Харин амьтан үүнийг нь хардаг: “Энэ хүн бясалгаад баяжих хүсэлтэй юм байна; тэр хүн нэрд гарах мөн ер бусын чадвартай болохыг хүсэж байна. Ээ дээ, түүний бие нь дажгүй шүү, биед нь байгаа зүйлс бас нэлээд сайн юм байна, харин түүний бодол

үнэхээр муу юм, тэр ер бусын чадварыг хөөцөлдөж байна! Магадгүй тэр багштай байх, гэхдээ түүнд багш байсан ч би айхгүй.” Ариун номын багш түүнийг ингэж ер бусын чадвартай болохыг хөөцөлдөж байгааг нь хараад хүсэх тусам нь түүнд огт өгөхгүй, энэ бол яг хаях ёстой зууралдсан сэтгэл гэдгийг амьтан сайн мэднэ. Тэр энэ бодлоосоо салахгүй бол түүнд ер бусын чадварыг огт өгөхгүй, тэр үүнийг бүр ч ухамсарлахгүй, хөөцөлдөх тусам бодол нь улам муудна. Эцэст нь энэ хүнд огт найдвар байхгүй болсныг багш нь хараад, санаа алдан түүнийг орхин явна. Зарим хүнд багш байдаггүй, гэхдээ магадгүй замд тааралдсан нэг багш түүнийг харж хандана. Яагаад гэвэл орон зай болгонд их олон гэгээрэгч байдаг, нэг гэгээрэгч энэ хүнийг ажиглаад нэг өдөр дагана, тэгээд түүнийг тийм сайн биш болохыг нь хараад орхиод явна; дараа нэг өдөр өөр нэг нь түүнийг сайнгүй болохыг нь хараад бас яваад өгнө.

Түүнд багш байсан ч эсвэл замд тааралдсан багш байсан ч, түүний хөөцөлдөж байгаа зүйлийг багш нь өгч болохгүй гэдгийг амьтан мэднэ. Амьтад аугаа гэгээрэгч байдаг орон зайг харж чадахгүй учраас тэд айхгүй, энэ боломжийг ашигладаг. Манай орчлон ертөнцөд ийм нэг зарчим байдаг, хүн юу хөөцөлдөнө, юуг өөрөө хүснэ, ер нь бусад хүмүүс үүнд хөндлөнгөөс оролцож болохгүй. Амьтад үүнийг ашиглах шалтгаа болгоно: “Тэр хүсэж байна, би түүнд өгье, миний түүнд туслах нь буруу биш биз дээ?” Ингээд амьтан түүнд өгнө. Амьтан анхандаа хүний биен дээр гарч зүрхлэхгүй, тэр эхлээд түүнд жаахан гон өгөөд үзнэ. Нэг өдөр гэнэтхэн тэр хүн хүсэж байсан гон-той болсноо мэдсэн, мөн өвчнийг ч эдгээж чаддаг болсон. Амьтан үүнийг дажгүй сайн болж байгааг хараад

хөгжмийн оршил тоглолт шиг л: “Нэгэнт энэ хүн авах дуртай байгаа болохоор биен дээр нь гарчихъя, тэгвэл илүү их зүйлийг өгч чадна, хийхэд ч амар болно. Чи тэнгэрийн мэлмий хүссэн биз дээ? Одоо чамд бүхнийг өгнө”, тэгээд тэр биен дээр нь гарчихна.

Тэр бодолдоо эдгээр зүйлээр хөөцөлдөж байхад тэнгэрийн мэлмий нь нээгдсэн, тэр ч байтугай гон гаргаж чаддаг болсон, бас бага зэрэг ер бусын чадвартай болсон. Тэр маш их баярласан, өөрийнхөө зүтгэлээр мөн дасгалынхаа үр дүнгээр хүссэн зүйлдээ хүрлээ гэж бодно, үнэн хэрэгтээ тэр юуг ч бясалгаж гаргаагүй. Тэр өөрийгөө хүний биенийг нэвт харж, өвчин байгаа газрыг нь илрүүлж чаддаг болсон гэж бодсон. Үнэндээ түүний тэнгэрийн мэлмий огт нээгдээгүй, тэр амьтан түүний тархийг эзэмдэн өөрийнхөө нүдээр харсан зүйлийг түүний тархинд тусгахад тэр өөрийнх нь тэнгэрийн мэлмий нээгдсэн гэж бодсон. “Гон гаргамаар байна уу? Тэг тэг”, тэр гараа сунгаад гон гаргахад нөгөө амьтны жижиг сарвуу нь түүний араас бас сунаж гарна; тэр гон гаргахад могойны амнаас хэл нь гарч ирээд өвчтэй хэсгийг, хавдсан газрыг долооно. Иймэрхүү явдал их олон байдаг, эдгээр хүмүүс өөрсдөө хөөцөлдсөний улмаас шүглэсэн сүнстэй болцгоосон.

Энэ хүн баян болох, нэрд гарахыг хүссэн, үүний хойноос хөөцөлдсөн. За одоо тэр ер бусын чадвартай болчихлоо, өвчин эдгээж чаддаг болсон, мөн тэнгэрийн мэлмийгээр ч бас харж чаддаг болсон, энэ бүгдэд тэр их баярласан. Амьтан үүнийг хараад, “Чи баян болохыг хүссэн биз дээ? За, би чамайг баян болгоё.” Энгийн хүний бодлыг удирдах нь их амархан байдаг. Тэр амьтан олон хүнийг түүн дээр эмчлүүлэхээр ирүүлж чадна, олноороо тэд ирнэ. Өө



бас болоогүй! Түүнийг энд хүн эмчилж байхад нөгөө амьтан цаагуур нь хэвлэлийн газрын сурвалжлагчаар түүнийг сонин дээр гаргаж сурталчилна. Тэр энгийн хүмүүсийг удирдаж ийм зүйлийг хийлгэдэг, хэн нэгэн хүн ирж өвчнөө үзүүлээд бага мөнгө өгвөл болохгүй, толгойг нь өвтгөнө, ямар ч байсан заавал их мөнгө өгүүлнэ. Тэр нэр алдар, эд хөрөнгө хоёуланг нь олоо, их мөнгөтэй боллоо, нэрд ч гарчихлаа, тэгээд бас чийгон багш болсон. Ер нь ийм хүн шиньшинийг эрхэмлэдэггүй, юу ч гэж хэлэхээс эмээхгүй, тэр өөрийгөө зөвхөн тэнгэрийн дараа тавина, мөн тэнгэрийн Дарь эх, эсвэл Хурмаст тэнгэрийн хаан хүний орчлонд бууж ирсэн дүр гэж хэлж зүрхэлдэг, тэр өөрийгөө бүр Будда гэж хэлж зүрхэлнэ. Тэр жинхэнэ шиньшин-ий бясалгал дагуу яваагүй учраас дасгал хийж ер бусын чадвартай болохыг хөөцөлдсөн, эцэст нь сүнс эсвэл амьтныг өөртөө шүглүүлдэг.

Зарим хүн магадгүй ингэж боддог: “Ингэсний муу гэж юу байгаа юм? Мөнгө олж баян болж л байвал боллоо, бас нэрд гарч болно”, нэлээд олон хүн ингэж боддог. Би та бүгдэд хэлье, үнэндээ тэр амьтан бол өөрийн гэсэн зорилготой, учир шалтгаангүйгээр чамд юуг ч зүтээр өгөхгүй. Энэ орчлон ертөнцөд “алдахгүй бол олохгүй” гэсэн зарчим байдаг. Тэр юу олж авдаг вэ? Би дөнгөж сая энэ асуудлын талаар ярьсан биз дээ? Тэр хүний хэлбэрээр бясалгахын тулд чиний бие дэх амин охийг авахыг хүсдэг, тиймээс хүний биеэс охийг нь авдаг. Хүний биед зөвхөн нэг л хувь амин охь байдаг, хүн бясалгахыг хүсвэл ийм л нэг хувьтай. Чи үүнийг амьтанд алдвал бясалгах талаар мартсан нь дээр, чи юугаараа бясалгах юм? Чамд юу ч үлдэхгүй, чи бясалгах ямар ч боломжгүй болно. Зарим хүн магадгүй ингэж хэлнэ: “Надад угаасаа бясалгах бодол байхгүй,

би зөвхөн мөнгөтэй болох л хүсэлтэй, мөнгөтэй болж л байвал болоо, тэр надад ямар хамаатай юм!” Би та бүгдэд хэлье, чи баян болох хүсэлтэй байлаа ч би чамд нэг зарчмыг хэлсний дараа чи тэр бодлоо орхих болно. Яагаад вэ? Хэрэв тэр чиний биеэс эрт гараад явбал чиний дөрвөн мөч тамиргүй болно. Үүнээс хойш чи үлдсэн насандаа энэ хэвээрээ хоцорно, яагаад гэвэл тэр чиний хамаг амин охийг аваад явчихна; хэрэв тэр чиний биеэс орой гарч явбал чи шалбайсан нэг ургамал шиг болж үлдэнэ, зөвхөн нэг амьсгаатай, үлдсэн насаа хэвтэрт барна. Чи мөнгөтэй байлаа гээд хэрэглэж чадах юм уу? Нэр цуутай болсон ч сэтгэлийн таашаал авч чадах юм уу? Энэ аймаар биш гэж үү?

Ялангуяа одоогийн бясалгагчдын дунд ийм тохиолдлууд түгээмэл гарах болсон, нэлээд их байдаг. Амьтад зөвхөн хүний биед шүглээд зогсохгүй бас хүний Эзэн сүнснийг алж болно, тэр тэгээд хүний Ниван ордонд ороод эзлэн суудаг. Харахад тэр хүн шиг, гэхдээ хүн биш, одоо үед бүр ийм байдал гардаг болсон. Яагаад гэвэл хүн төрөлхтний ёс суртахууны шалгуур өөрчлөгдсөн, хэн нэгэн хүн буруу зүйл хийж байхад нь чи түүнд буруу юм хийж байна гэж хэлбэл тэр үнэмшихгүй. Тэр мөнгө олох, мөнгөний хойноос хөөцөлдөх, баяжихыг олны ёс орчлонгийн зүй гэж боддог, үүнийг зөв гэж үздэг, иймээс тэр хүмүүст хор учруулна, хохирооно, мөнгөний төлөө ямар ч нүгэл үйлдэнэ, юу ч хийхээс буцахгүй. Тэр амьтан алдахгүй бол олж чадахгүй, тэр чамд зүгээр юм өгнө гэж үү? Тэр биед чинь байгаа зүйлсийг авах хүсэлтэй байдаг. Мэдээж бид хэлсэн, хүн буруу үзэл бодол, ариун бус сэтгэлээсээ болж өөртөө гай авчирдаг.

Бид Фалунь Дафа-г зааж байна. Манай номын үүдний бясалгалд, чи өөрийнхөө шиньшин-ийг сайн барьж чадаж байвал, нэг зөв бодол зуун мууг дардаг учраас чамд ямар ч асуудал гарахгүй. Чи шиньшин-ээ сайн барьж чадахгүй ийм ч зүйл, тийм ч зүйлийн хойноос хөөцөлдөөд байвал лав өөртөө гай авчирна. Зарим хүн урьд нь хичээллэж байсан зүйлээ орхиж чаддаггүй, бид нэг бясалгалын замаар хичээллэхийг шаарддаг, жинхэнэ бясалгалд нэг сэтгэлээр тууштай байх ёстой. Зарим чийгон багш нарыг ном бичсэнээр нь битгий хар, би чамд хэлэхэд, тэдгээр номд байгаа элдэв янзын зүйлүүд нь тэдний бясалгадаг зүйлүүдтэй адилхан, тэдгээр нь могой, үнэг, үен гэх мэт юм. Чи ийм номыг уншихад тэдгээр амьтад үгнүүдээс нь үсрэн гарч ирнэ. Хуурамч чийгон багш нар жинхэнэ чийгон багш нараас хэд дахин олон байдаг гэж би хэлсэн, гэхдээ чи тэднийг ялгаж чадахгүй, иймээс та бүгд өөрийгөө сайн барих ёстой. Би энд чамайг завал Фалунь Дафа-гаар бясалга гэж байгаа юм биш, чи аль хүссэн номоороо хичээллэж болно. Гэхдээ хуучны ийм нэг үг байдаг: “Ариун номыг мянган жилд олж чадахгүй байлаа ч, тэрсүүд номыг нэг өдөр ч сурахгүй.” Иймээс өөрийгөө заавал сайн барь, жинхэнэ ариун номоор бясалгахад янз бүрийн зүйлийг хольж бясалгаж болохгүй, тийм бодол санааг ч бүү оруул. Зарим хүний Фалунь-ий хэлбэр нь гажсан байсан. Яагаад гажсан бэ? Тэд өөр чийгон-оор хичээллээгүй гэж хэлдэг, гэхдээ тэд дасгал хийхдээ хуучин хичээллэж байсан зүйлээ бодолдоо нэмж оруулдаг, тэдгээр зүйлсийг бясалгалдаа хольж оруулсан биш гэж үү? Бид сүнс шүглэх талаар энэ хүртэл л ярья.

## Сансрын хэл

Сансрын хэл гэж юу вэ? Энэ нь хүн гэнэт ямар нэг үл ойлгогдох үгээр ярьж эхэлдэг, тэр ойлгомжгүйгээр шулганан ярина, өөрөө юу ярьж байгаагаа ч мэдэхгүй. Бусдын бодлыг унших ер бусын чадвартай хүн ерөнхий санааг нь гадарлаж чадна, гэхдээ тэр юуны тухай ярьж байгааг нь тодорхой хэлж чадахгүй. Мөн зарим хүн өөр олон янзын хэлээр ярьж чаддаг. Зарим хүн үүнийг их гайхширмаар юм гэж боддог, ур чадвар эсвэл ер бусын чадвар гэж үздэг. Энэ бол ер бусын чадвар биш, бас бясалгагчийн ур чадвар ч биш, энэ нь хүний түвшнийг илэрхийлэхгүй. Тэгвэл энэ нь ямар учиртай вэ? Энэ бол чиний бодол гаднын сүнсэнд удирдагдсан хэрэг, чи үүнийг дажгүй сайн гэж бодно, дуртайяа хүлээж авна, мөн баяртай байна, чамайг үүнд улам тааламжтай байх тусам тэр чамайг улам хүчтэй эзэмдэнэ. Жинхэнэ бясалгадаг хүний хувьд, чи яаж түүний эрхшээлд орж болох юм? Түүнээс гадна энэ нь их доод түвшнээс ирдэг, иймээс жинхэнэ бясалгаж байгаа хүний хувьд иймэрхүү бэрхшээл өөртөө бүү учруул.

Хүн бол хамгийн нандин нь байдаг, түмэн амь бодийн сүнс сүлд нь атал чи өөрийгөө иймэрхүү зүйлээр эзэмдүүлж яаж болох юм? Чи өөрийнхөө биенийг эзэнгүй хаявал ямар харамсалтай гээч! Тэдгээрийн зарим нь хүний биед шүтлэсэн, зарим нь бие дээр нь гараагүй, хүнээс зайтай байдаг, гэхдээ тэд чамайг удирдан захирч чадна. Чамайг ярихыг хүсвэл тэр чамайг шулганан яриулна. Энэ нь бас өөр хүнд дамжиж болдог, хэн сурмаар байна зоригтой амаа нээхэд тэр бас ярьж эхэлнэ. Үнэндээ эдгээр зүйлс нь бас хэсэг бүлгээрээ байдаг, чи ярихыг хүсвэл нэг нь чам дээр гараад яриулна.

Яагаад ийм байдал гардаг вэ? Би хэлсэн, тэд өөрсдийнхөө түвшнийг дээшлүүлэх хүсэлтэй байдаг, гэвч тэнд зовлон бэрхшээл байдаггүй учраас бясалгаж өөрсдийгөө дээшлүүлж чадахгүй. Тэд үүнээс гарах арга зам хайсан, тэгээд хүмүүст сайн зүйл хийж туслах санаа олсон, гэхдээ яаж туслахаа мэддэггүй. Харин гаргасан энерги нь хүний өвчнийг түр намжаах нөлөөтэй байдгийг мэднэ, өвчтөний зовлонг тухайн үед хөнгөлдөг, тэгэхдээ бүрмөсөн сайжруулж чадахгүй, хүний амаар дамжуулж энерги гаргахад ийм нөлөө гардгийг тэд мэддэг, ийм л учиртай юм. Зарим хүн үүнийг “тэнгэрийн хэл” гэдэг, зарим нь үүнийг “Буддын хэл яриа” гэдэг, энэ бол Будда-г гүтгэж байна. Би үүнийг ёстой дураараа ярьж байна гэж хэлнэ!

Будда тэр болгон ярьдаггүй гэдгийг хэн бүхэн мэднэ. Хэрэв манай энэ орон зайд юм яривал хүн төрөлхтөнд газар хөдлөж мэднэ, ямар аймаар юм болно гэж санана! Хүчтэй тэнгэр нүргэлэх мэт дуу гарна. Зарим хүн ингэж хэлдэг: “Би тэнгэрийн мэлмийгээрээ Будда надтай ярьж байхыг харсан.” Тэр чамтай ярьсан юм биш. Зарим хүн бас миний Фашэнь ярьж байхыг харсан гэдэг, чамтай бас ярьсан юм биш, түүний гаргасан бодол нь стерео дуутай байдаг, чамд тэр юм ярьж байгаа мэт сонсогддог. Тэр голдуу өөрийнхөө орон зайд ярьдаг, гэхдээ дуу нь энд нэвтэрч ирэхэд чи түүний ярьж байгааг тодорхой сонсож чадахгүй. Яагаад гэвэл хоёр орон зайны хоорондох цаг хугацаа ба орон зайн ухагдахуун нь өөр байдаг, манай энэ орон зайн нэг шичэнь одоогийн хоёр цагтай тэнцүү. Харин тэр том орон зайд манай нэг шичэнь тэндхийн нэг жилтэй тэнцүү, тэдний цаг хугацаанаас удаан.

Ийм нэг хуучны үг байдаг: “Тэнгэрт нэг өдөр болоход дэлхийд мянган жил өнгөрдөг”, энэ бол орон зай, цаг хугацааны ухагдахуун байдаггүй нэгж орон юм, өөрөөр хэлбэл аугаа гэгээрэгчид байдаг орон. Жишээлбэл Сухавати диваажин, Лунли диваажин, Фалунь диваажин, Лянхуа диваажин гэх мэт тэдгээр орнууд юм. Харин тэр том орон зайн цаг хугацаа нь манайхаас хурдан, хэрэв чи хүлээж авч чадах юм бол түүний ярьж байгааг сонсоно, зарим хүний “тэнгэрийн чих” нь нээгдэж ер бусын сонсох чадвартай болдог, түүний ярьж байгааг сонсох боловч тод биш. Юу ч сонссон чамд шувууны шулганаан мэт эсвэл пянз тоглуулагчийг хурдан дээр нь сонсож байгаа юм шиг байдаг, юу ярьж байгаа нь ойлгогдохгүй. Мэдээж зарим хүн хөгжим болон яриа сонсдог. Гэхдээ ер бусын чадвараар дамжуулж цаг хугацааны зөрүүг арилгах ёстой, дуу авиа чиний чихэнд хүрэхэд чи тодорхой сонсох болно, ийм л байдаг. Зарим хүн үүнийг Буддын хэл яриа гэж хэлдэг, гэвч ердөө ч тийм биш юм.

Хоёр гэгээрэгч хоорондоо уулзаад нэг инээмсэглэхдээ л бүрэн ойлголцдог. Энэ нь дуугүйгээр бодлыг алсаас мэдрэх онцгой чадвар бөгөөд хүлээж авдаг нь стерео дуутай байдаг. Тэд инээмсэглэхэд бодол санаагаа хэдийн солилцож дууссан байдаг. Энэ бол тэдний хэрэглэдэг ганц арга биш, заримдаа бас өөр арга хэрэглэдэг. Та бүгд Тантрын шашинд Түвдийн лам нар гар хурууны онцлог ур хөдөлгөөн хийдгийг мэднэ, гэхдээ чи тэр ламаас үүнийг юун гарын хөдөлгөөн бэ? гэж асуувал тэр чамд энэ бол дээд иог гэнэ. Энэ нь чухам юу вэ? Тэр ч мэдэхгүй. Үнэндээ энэ бол аугаа гэгээрэгчийн хэл яриа юм. Олон хүнтэй байхад, тэр гарын том ур хөдөлгөөнийг хийдэг, тэдгээр нь их гоё бөгөөд гарын янз бүрийн том

ур хөдөлгөөнүүд байдаг; цөөн хүнтэй байхад гарын жижиг ур хөдөлгөөн хийдэг, бас их гоё бөгөөд гарын янз бүрийн жижиг ур хөдөлгөөн байдаг, эдгээр нь их нарийн бөгөөд их баялаг, яагаад гэвэл энэ бол хэл яриа юм. Урьд нь энэ бол тэнгэрийн нууц байсан, одоо бид үүний нууцыг тайллаа. Түвдэд хэрэглэдэг нь дасгалын зөвхөн цөөн хэдхэн хөдөлгөөн л юм, тэд үүнийг төрөлжүүлж ангилсан. Тэдгээр нь зөвхөн бясалгалын нэг хэл бөгөөд хэдхэн төрлийн дасгалын хэлбэрүүд юм, жинхэнэ гарын ур хөдөлгөөн бол маш нарийн байдаг.

### **Багш сурагчдадаа юу өгдөг вэ?**

Зарим хүн надтай уулзаад гар бариад тавьдаггүй. Тэднийг надтай гар барьж байгааг харчхаад бусад нь бас ирж гар барина. Би тэдний дотроо юу бодож байгааг нь мэднэ. Зарим хүн багштай гар барьсандаа их баяртай байдаг; зарим нь жаахан мэдээлэл авах санаатай гар барьчхаад тавихгүй. Бид та бүгдэд хэлье, жинхэнэ бясалгал бол чиний өөрийн хэрэг, бид энд хүний өвчнийг эдгээх, бие сайжруулах эсвэл чамд жаахан мэдээлэл өгөөд чиний өвчнийг эдгээхийн тулд байгаа юм биш, бид иймэрхүү зүйл ярихгүй. Чиний өвчнийг арилгахыг би өөрөө хийнэ, дасгалын газруудад миний Фашэнь хийж өгнө, миний номыг уншаад өөрсдөө Дафа-гаар бие даан хичээллэж байгаа сурагчдын өвчнийг бас миний Фашэнь арилгаж өгнө. Чи миний гарыг барихад гон чинь өснө гэж бодож байгаа юм уу? Энэ нь инээдтэй биш гэж үү?

Гон бол өөрийнхөө шиньшин-ийг яаж бясалгахаас шалтгаалдаг. Чи жинхэнэ бясалгахгүй бол гон өсөхгүй, яагаад гэвэл үүнд шиньшин-ий шалгуур байдаг. Чиний гон өсөхийн хэрээр, чиний зууралдсан сэтгэл

болон бие бодь арилж байгаа нь, мөн чиний толгой дээрх хэмжүүр өсөж байгаа нь дээд түвшнийхэнд харагддаг. Энэ хэмжүүр нь гон багана шиг хэлбэрээр оршдог, хэмжүүр хэр өндөр байна гон багана төдий өндөрт байна, энэ нь чиний бясалгаж гаргасан гон-ыг илэрхийлдэг, мөн чиний шиньшин-ий өндөр намыг илэрхийлдэг. Өөр хүн чамд үүнийг яаж ихээр нэмье ч гэсэн бүтэхгүй, жаахан нэмлээ ч гэсэн энэ нь тэнд тогтохгүй уначихна. Би чамайг дор нь “гурван цэцэг толгой дээр цуглах (саньхуа жудин)” байдалд хүргэж чадна, гэхдээ чамайг үүдээр гарангуут л гон чинь доош уначихна. Энэ бол чинийх биш, чиний бясалгалаар гараагүй учраас тэнд тогтохгүй, яагаад гэвэл чиний шиньшин-ий түвшин тэнд хүрээгүй байгаа, хэн ч үүнийг чамд нэмж өгье гэсэн боломжгүй, энэ нь бүхэлдээ өөрийн бясалгалаар буюу сэтгэлээ бясалгаж байж гардаг. Чи гон-оо ул суурьтайгаар дээш өсгөж, өөрийгөө тасралтгүйгээр дээшлүүлж, орчлон ертөнцийн мөн чанарт уусаж байж л дээшилнэ. Зарим хүн надаас гарын үсэг авахыг хүсдэг, би зурах дургүй. Зарим нь багш надад гарын үсгээ үлдээсэн гэж гайхуулна, тэд багшийнхаа мэдээллээр хамгаалуулахыг хүсдэг. Энэ нь бас зууралдсан сэтгэл биш гэж үү? Бясалгал өөрөөс шалтгаалдаг, мэдээллийн талаар ярих хэрэг байна уу? Чи дээд түвшний бясалгалд ийм зүйлээр яах гэсэн юм? Тэр юу вэ? Тэр бол зөвхөн өвчин эдгээх бие сайжруулахад л яригддаг.

Чиний бясалгаж гаргасан гон маш бичил түвшинд түүний бүх бичил ширхгүүд дээрх нь чиний дүрстэй яг адилхан харагддаг. Гурамсан ертөнцийн Фа-гаас гарахад чи Буддын биенийн бясалгал хийж эхэлнэ. Гон-ы бүх бичил ширхгүүд нь бүгд Буддын дүрстэй, тэдгээр нь маш үзэсгэлэнтэй бөгөөд бадамлянхуа



цэцгэн дээр суусан байдаг. Амьтдын гон-ы хувьд, маш бичил түвшин дэх бичил ширхгүүд нь бүгд жижигхэн үнэг, могой гэх мэт байдаг. Бас мэдээлэл гэгч зүйл байдаг, зарим хүн цай хандлаад чамд уулгана, тэрийг бас гон гэнэ. Энгийн хүн өвчнөө зөвхөн түр зуур намдаах, хойшлуулж дарахыг боддог, энгийн хүн бол энгийн л хүн, тэр биеэ яаж муу болгож байгаад нь бид оролцохгүй. Бид бол бясалгаж байгаа хүмүүс, тиймээс би чамд эдгээр зүйлийг мэдүүлээ. Үүнээс хойш та бүгд эдгээр зүйлийг бүү хийгээрэй, ийм тийм “мэдээлэл” гэх иймэрхүү зүйлсийг хэзээ ч битгий хүс. Зарим чийгон багш ингэж хэлдэг: “Би та нарт мэдээлэл явуулъя, та нар орон даяар хаанаас ч хүлээн авч болно.” Юу хүлээж авах гэж? Би чамд хэлэхэд эдгээр зүйлс нь онцын нөлөөгүй. Хэрвээ энэ нь ашиг тустай байлаа гэхэд, зөвхөн өвчин эдгээх бие сайжруулахаас цаашгүй. Харин бясалгаж байгаа хүний хувьд гон өөрийн бясалгалаар гардаг, бусад хүн ямар ч гон мэдээлэл явуулсан байсан түвшнийг чинь дээшлүүлж чадахгүй, зөвхөн энгийн хүний өвчнийг л дарна. Заавал өөрийнхөө сэтгэлийг зөв байлгах ёстой, хэн ч бусдын өмнөөс бясалгаж өгч чадахгүй, зөвхөн чи өөрөө жинхэнэ бясалгавал түвшнээ дээшлүүлж чадна.

Тэгвэл би та нарт юу өгдөг вэ? Та бүгд мэднэ, манай бясалгагчдын олонх нь чийгон-оор хичээллэж байгаагүй, бие нь өвчтэй байдаг; нэлээдгүй хүн чийгон-оор олон жил хичээллэсэн ч чийг-н түвшиндээ эргэлдсээр л байдаг, ямар ч гон байхгүй. Мэдээж зарим нь хүний өвчнийг эдгээдэг, гэхдээ яаж эдгээснээ ч мэдэхгүй. Би сүнс шүглэх асуудлын талаар ярьж байхдаа Дафа-гаар жинхэнэ бясалгаж байгаа хүний биед шүглэсэн сүнснийг, ямар зүйл байсан ч аль хэдийн зайлуулсан, биеийн бүх муу зүйлийг дотор гаднагүй

бүгдийг нь авч хаясан. Мөн Дафа-г өөрөө бие даан сурч, жинхэнэ бясалгаж байгаа хүний биенийг би бас цэвэрлэж өгнө, үүнээс гадна танай гэрийн орчин ч бас цэвэрлэгдэх ёстой. Чи урьдын үнэг, үен тахисан сахиусаа нэн даруй хаях хэрэгтэй, тэдгээр нь байхгүй болсон, бүгдийг нь арилгасан. Яагаад гэвэл чи бясалгах хүсэлтэй, бид чамд хамгийн тохиромжтой үүдийг нээж өгч болно, эдгээр зүйлсийг чамд хийж өгнө, эдгээр зүйлсийг зөвхөн жинхэнэ бясалгах хүнд л хийж өгнө. Мэдээж зарим хүн бясалгах хүсэлгүй, энэ нь юу болохыг одоо ч ойлгоогүй байдаг, тиймээс бид ч тэднийг харж хандахгүй, харин жинхэнэ бясалгадаг хүнийг л харж хандана.

Ийм нэг төрлийн хүн байдаг, урьд нь түүнийг шүглэсэн сүнстэй гэж ярьдаг байсан, тэр өөрөө ч мэдэрдэг. Хэдий тэр зүйлийг биеэс нь авч хаясан ч, түүний санаа нь бас л зовсон хэвээр байдаг, тэр байдал байсаар байгаа мэт түүнд санагддаг, тэр үүнийг байсаар байна гэж боддог, энэ нь аль хэдийн нэг төрлийн зууралдсан сэтгэл болсон юм, эргэлзэх сэтгэл гэдэг. Яваандаа сүнсийг өөртөө дахин ирүүлж болзошгүй. Чи өөрөө энэ сэтгэлийг орхих ёстой, уг нь шүглэсэн сүнс аль хэдийн байхгүй болсон. Бидний урьдын лекцэд зарим хүнд эдгээр асуудлыг шийдэж өгсөн, би аль хэдийн эдгээр зүйлийг хийж өгсөн, бид нь шүглэсэн сүнсийг бүгдийг нь авч хаясан.

Бумбын системийн доод түвшний бясалгалд зарим суурь тавих шаардлагатай байдаг, тэнгэрийн эргүүлэг, дань-тиань (үрлийн талбай) болон өөр зарим зүйлүүдийг бий болгох хэрэгтэй. Энд бид чамд Фалунь, энергийн механизм, бясалгалын бусад төрлийн механизмууд гэх мэтчилэн маш олон зүйлийг, арван

мянга гаруй зүйлийг, энэ бүгдийг чамд өгнө, чиний биед үр шиг суулгаж өгнө. Чиний өвчнийг арилгасны дараа хийх ёстой зүйлсийг бүгдийг нь хийж өгнө, өгөх ёстой зүйлсийг бүгдийг нь чамд өгнө, тэгвэл л чи бидний энэ Фа-гаар жинхэнэ бясалгаж үр дүнд хүрэх болно. Тэгэхгүй бол, чамд юу ч өгөхгүй бол энэ нь зөвхөн өвчин арилгах бие сайжруулах талын л зүйл болно. Шуудхан хэлэхэд, зарим хүн шиньшин-ээ чухалчилдаггүй, тэгвэл биеийн тамирын дасгал хийсэн нь дээр.

Жинхэнэ бясалгана гэвэл бид чамд харуцлагатай хандах ёстой, тэдгээр бие даан бясалгаж байгаа хүмүүс ч гэсэн адилхан олж авна, гэхдээ тэд заавал жинхэнэ бясалгадаг байх шаардлагатай, бид эдгээр зүйлийг жинхэнэ бясалгадаг хүнд л өгнө. Би чамайг үнэхээр шавиа гэж үзэн дагуулна гэж хэлсэн. Үүнээс гадна, чи дээд түвшний Фа-г маш сайн сурах ёстой, мөн яаж бясалгахаа мэддэг байх ёстой; таван багц дасгалыг нэг мөсөн сурч, хийж чаддаг болох ёстой. Ирээдүйд чи маш өндөр түвшинд хүрч болно, чи тэр түвшний өндрийг төсөөлж ч чадахгүй, гэгээрлийн хутгийг олоход бол асуудалгүй. Чи бясалгаад л байвал, би энэ Фа-г заахдаа өөр өөр түвшинд уялдуулан ярьсан байгаа, хойшид чи өөр өөр түвшинд бясалгахдаа үүнийг үргэлж удирдах нөлөөтэй болохыг олж мэдэх болно.

Бясалгадаг хүний хувьд үүнээс хойш чиний амьдралын зам өөрчлөгдөх болно, миний Фашэнь чамд шинээр зохицуулж өгнө. Хэрхэн зохицуулах вэ? Тухайн хүнд хэр удаан наслах хугацаа үлдсэн байгаа вэ? Тэр өөрөө ч мэдэхгүй; зарим хүн магадгүй нэг жил эсвэл хагас жилийн дараа хүнд өвчин тусна, тэр

нь хэдэн жил ч үргэлжилж болно; зарим хүн магадгүй тархинд нь цус харвах эсвэл өөр өвчин тусаад хөдөлж чадахгүй болно. Үлдсэн насандаа чи яаж бясалгах юм? Бид энэ бүгдийг чамд арилгаж өгнө, эдгээр зүйлийг гаргуулахгүй. Гэхдээ бид ийм зүйлийг зөвхөн жинхэнэ бясалгадаг хүнд хийж өгнө гэдгээ эртхэн хэлэх ёстой, энгийн хүнд хамаагүй хийж өгч болохгүй, тэгвэл муу зүйл хийсэнтэй адил болно. Энгийн хүний хувьд төрөх, хөгшрөх, өвчлөх, үхэх бол бүгд хувь тавилангийн холбоотой байдаг, үүнийг хамаагүй эвдэж болохгүй.

Бид бясалгадаг хүнийг хамгийн нандин хүн гэж үздэг, иймээс зөвхөн бясалгаж байгаа хүнд хийж өгч болно. Яаж хийж өгдөг вэ? Хэрэв багш аугаа их Дэ-тэй бол, өөрөөр хэлбэл багшийн гон хүч нь маш өндөр байвал тэр чиний нүглийг арилгаж өгч чадна. Багшийн гон өндөр байвал чиний их хэмжээний нүглийг арилгаж өгч чадна, харин багшийн гон доогуур байвал зөвхөн бага зэрэг нүглийг л арилгаж өгч чадна. Нэг жишээ авч үзье, чиний ирээдүйн амьдралд үлдсэн янз бүрийн нүглийг бүхэлд нь авч үзвэл түүний нэг хэсгийг юм уу эсвэл хагасыг нь арилгана. Үлдсэн талыг нь чи давж чадахгүй, яагаад гэвэл тэр нь уулнаас ч өндөр. Тэгвэл яах вэ? Магадгүй чи ирээдүйд Бумба-д хүрэхэд, маш олон хүнд ашиг тусаа хүртээх болно. Ингэвэл маш олон хүн чиний нүглээс хуваалцан даана. Мэдээж тэдний хувьд энэ нь юу ч биш. Чи бясалгалаар биедээ маш олон амь бодийг гаргана, мөн чиний Эзэн сүнс, Дэд сүнснээс гадна өөр олон чи байгаа, тэд бүгд хуваалцах болно. Чамд гай зовлон туулах багахан хэмжээний нүгэл үлдсэн. Жаахан үлдсэн ч гэсэн тэр бас л их, чи бас л давж чадахгүй, тэгвэл яах вэ? Үүнийг маш олон хэсэг болгон хуваагаад чиний бясалгалын

янз бүрийн түвшинд байрлуулна, тэдгээрийг ашиглаад чиний шиньшин-ийг дээшлүүлнэ, чиний нүглийг хувиргахад болон чиний гон-ыг өсгөхөд хэрэглэнэ.

Түүнээс гадна, хүн бясалгахыг хүсвэл энэ нь тийм амар зүйл биш. Энэ бол маш нарийн асуудал гэж би хэлсэн, энгийн хүний асуудлаас давсан зүйл бөгөөд энгийн хүний аливаа зүйлээс илүү хэцүү байдаг. Энэ нь ер бусын зүйл биш гэж үү? Иймээс чамд энгийн хүний ямар ч асуудлаас дээгүүр шаардлага тавигдана. Хүмүүс бид нарт Юань-шэнь (сүнс) байдаг, Юань-шэнь бол үхэшгүй. Хэрэв Юань-шэнь үхэшгүй юм бол та бүгд боддоо, чиний Юань-шэнь урьд насандаа нийгмийн харилцааны явцад муу зүйл хийсэн байж болох уу? Энэ нь тун болзошгүй. Магадгүй амь хөнөөсөн, хэн нэгэнд өр тавьсан эсвэл хэн нэгнийг дээрэлхэх мөн хохироох гэх мэт муу зүйлс хийсэн байж болно. Хэрэв тийм бол чамайг энд бясалгаж байхад, нөгөө талд тэр чамайг тодорхой харж байдаг. Хэрэв чи өвчнөө арилгах, биеэ сайжруулах гэж байвал тэр чамайг зөвхөн өрөө хойшлуулж байна гэж үзэх тул тоохгүй, чи одоо төлөхгүй бол ирээдүйд төлнө, ирээдүйд төлөхөд бүр ч хүндэрнэ. Иймээс хэдийгээр чи одоо өрөө төлөхгүй байсан ч тэр үл тооно.

Харин чи бясалгана гэвэл тэр чамайг хийлгэхгүй гэнэ, “Чи бясалгах гэж байна, явах гэж байна, чи гонтой болчихвол би чамайг барьж авч чадахгүй, чамд хүрч ч чадахгүй болчихно,” тэр үүнийг зөвшөөрөхгүй. Янз бүрийн байдлаар чамд саад хийж бясалгал хийлгэхгүйг оролдоно, тиймээс тэр саад хийх янз бүрийн арга хэрэглэнэ, тэр ч байтугай чамайг үнэхээр алах гэж ирнэ. Мэдээж чамайг энд суугаад бясалгаж байхад толгойг чинь цавчихгүй нь ойлгомжтой,

ийм байх боломжгүй юм, яагаад гэвэл энгийн хүний нийгмийн байдалд нийцэх ёстой. Магадгүй чи гэрээсээ гараад машинд дайруулах ч юм уу, байшингаас унах эсвэл өөр ямар нэгэн аюулд орж болно, иймэрхүү зүйлс гарч болзошгүй бөгөөд нэлээд аюултай байх болно. Жинхэнэ бясалгал бол чиний төсөөлж байгаа шиг амар зүйл биш, чи бясалгах хүсэлтэй л бол бясалгаж чадна гэж бодож байна уу? Чи жинхэнэ бясалгахыг хүсмэгц чиний амь нас тэр дорхноо аюулд учирна, шууд энэ асуудалтай тулгарна. Олон чийгөн багш хүнийг дээд түвшин рүү дагуулах бясалгал зааж зүрхэлдэггүй. Яагаад вэ? Тэд энэ асуудлыг шийдэж чадахгүй, мөн чамайг тэд хамгаалж чадахгүй.

Урьд өмнө Дао-г заадаг олон хүн байсан, тэд зөвхөн нэг л шавьд заадаг, нэг л шавийг харж хамгаалж дөнгөдөг байсан. Харин ердийн нэг хүн ийм өргөн хэмжээнд заан тараахыг зүрхлэхгүй. Гэхдээ энэ зүйлийг би хийж чадна гэж та бүхэнд хэлсэн, яагаад гэвэл надад тоолшгүй олон Фашэнь байгаа, тэдгээр нь миний зүйрлэшгүй хүчтэй бурханлаг ер бусын чадварыг агуулсан байдаг, аугаа ер бусын чадвар болон Фа-гийн асар их хүч чадлыг гаргаж чадна. Гэвч бидний өнөөдөр хийж байгаа энэ үйл хэрэг гаднаас нь харахтай адил тийм амар биш, би үүнийг хийхээр зүгээр сэтгэлийн хөөрлөөр гарч ирсэн юм биш. Би чамд энэ үйл явдлыг маш олон аугаа гэгээрэгчид ажиглан харж байгаа гэдгийг хэлье, энэ бол бид Дарма-гийн төгсгөлийн үед хамгийн сүүлчийн удаа ариун Фа-г зааж байгаа юм. Үүнийг хийхдээ бид гажуудуулахыг зөвшөөрөхгүй, бясалгалын ариун замаар үнэхээр замнаж чадвал чамд хэн ч дур зоргоороо муу юм хийж зүрхлэхгүй, үүнээс гадна миний Фашэнь чамайг хамгаалж байгаа, ямар ч аюул гарахгүй.

Өр тавьсан бол төлөх ёстой, иймээс бясалгалын замд зарим аюултай зүйл тохиолдож болзошгүй. Гэхдээ ийм зүйл тохиолдоход чи айхгүй, тэгээд ч чамд жинхэнэ аюул учруулахгүй. Би та бүхэнд хэдэн жишээ хэлье. Намайг Бээжинд лекц уншиж байхад нэг сурагч дугуйгаа унаад зам хөндлөн гарч байсан, түүнийг замын уулзвараар эргэж байтал нэг тансаг суудлын машин огцом эргэхдээ манай энэ сурагчийг мөргөсөн, тавь гаруй насны эмэгтэй сурагч байсан. Машин түүнийг огцом их хүчтэй мөргөсөн, тэрээр толгойгоороо саван машины дээд талыг чанга гэгч нь дуутай цохисон. Тэр үед хөл нь дугуйныхаа дөрөөнөөс ч салаагүй, тэр толгойгоороо мөргөсөн ч өвдөлт мэдрээгүй. Толгой нь өвдөөгүй төдийгүй цус ч гараагүй бас хавдаа ч үгүй байсан. Тэр жолооч их айсан, машинаасаа үсэрч бууж ирээд түүнээс гэмтсэн эсэхийг яаран асуусан, эмнэлэгт хүргэж өгөх үү гэсэн. Тэрээр зүгээр ээ гэж хариулсан. Мэдээж энэ сурагчийн шиньшин их өндөр, хүнд төвөг учруулахыг хүсээгүй. Тэр зүгээр ээ гэж хэлсэн ч мөргөснөөс болж машин дээр том хонхорхой үлдсэн байсан.

Иймэрхүү явдал амь насыг авахаар ирдэг, гэхдээ аюул гарахгүй. Сүүлд намайг Жилинь их сургуульд лекц уншиж байх үед манай нэг сурагч их сургуулийн гол хаалгаар дугуйгаа түрээд гарч явсан, тэр замын яг голд орж ирэхэд гэнэт хоёр машины дунд хавчигдангаа алдаж бараг дайруулах шахсан, гэвч тэр ердөө ч айгаагүй. Бид иймэрхүү байдалд орохдоо ер нь айдаггүй, яг тэр агшинд машинууд зогссон, аюулд оролгүй өнгөрсөн.

Бээжинд бас ийм нэгэн явдал болсон. Өвөл эрт харанхуй болдог, хүмүүс эрт унтацгаадаг. Гудамжинд

хэн ч байхгүй ямар ч анир чимээгүй нам гүм байсан. Манай нэг сурагч дугуйгаа унаад гэр лүүгээ яаран явж байхад өмнө нь зөвхөн нэг жийп машин явж байсан, тэр машин явж байгаад гэнэт тоормослон зогссон. Тэр үүнийг анзааралгүй, толгойгоо тонгойсон хэвээр урагш жийсээр байсан. Тэгтэл нөгөө машин гэнэт хойшоо ухарсан, их хурдтай ухарсан, ийм хоёр талын хүчийг мөргөлдүүлж амийг нь авахаар ирсэн. Тэднийг яг мөргөлдөхийн даваан дээр нэг хүч түүний дугуйг хагас метр гаруй хойш нь гэнэт татсан, мөн жийп түүний дугуйг тулаад тоормосоо чахруулан зогссон, магадгүй жолооч ард нь хүн байгааг мэдсэн байх. Энэ сурагч тэр үед бас айгаагүй, иймэрхүү тохиолдолд орсон ихэнх хүнд айдас төрдөггүй, гэхдээ болоод өнгөрсний дараа магадгүй айна. Хамгийн түрүүнд түүнд орж ирсэн бодол нь: “Хөөх! Хэн намайг хойш нь татав? Би түүнд талархах хэрэгтэй.” Эргэж хараад баярласнаа хэлэх гэтэл гудамжинд хэн ч байгаагүй, эргэн тойронд нь нам гүм байсан. Тэр шууд ойлгосон, “Багш намайг хамгаалжээ!”

Бас нэг тохиолдол Чанчунь хотод болсон. Нэг сурагчийн гэрийн хажууд барилга баригдаж байсан, одоогийн барилгууд их өндөр баригдаг болсон, барилгын угсардаг шатнууд таван сантиметрийн диаметртай, дөрвөн метрийн урттай төмөр трубануудаар хийгдсэн. Энэ сурагч гэрээсээ гараад холгүй явж байтал нөгөө өндөр барилгын дээрээс нэг төмөр труба эгцээрээ түүний толгой дээрээс нь унаад ирсэн, замаар явж байсан хүмүүс бүгд зогтусаж мэлэрсэн. Тэр, “Хэн намайг алгадав?” гэсэн, хэн нэгэн түүний толгой дээр алгадсан гэж бодсон. Яг энэ агшинд тэр дээш харахад толгой дээр нь нэг том Фалунь эргэж байсан, төмөр труба толгойных нь хажуугаар доош



гулсан унасан. Газарт эрчээрээ зоогдсон. Хэрэв энэ нь хүний биед зоогдсон бол та нар боддоо, тийм хүнд жинтэй төмөр труба түүнийг яг шорлог шиг нэвт сүлбэх байсан, маш аюултай юм болох байсан!

Иймэрхүү тохиолдол маш их байдаг, үүнийг тоочих аргагүй олон, гэхдээ хэнд ч жинхэнэ аюул гараагүй. Хүн болгонд иймэрхүү зүйл тохиолдохгүй гэхдээ зарим нэг хүнд ийм аюул тулгарна. Чамд ийм юм тохиолдсон ч бай үгүй ч бай ямар ч аюул гарахгүйг батална, би үүнийг баттай хэлж чадна. Зарим сурагчид шиньшин-ий шаардлагын дагуу явдаггүй, тэд шиньшин-ээ бясалгадаггүй зөвхөн дасгалаа л хийдэг, тэд бясалгаж байгаа хүнд тооцогдохгүй.

Багш юу өгдөг вэ гэвэл би та бүхэнд эдгээр зүйлсийг өгнө. Миний Фашэнь чамайг өөрийгөө хамгаалж чаддаг болтол чинь хамгаална, тэр үед чи Гурамсан ертөнцийн Фа бясалгалаас дээш гарсан байх болно, мөн чи аль хэдийн Бумба-д хүрсэн байх болно. Гэхдээ чи өөрийгөө заавал жинхэнэ бясалгадаг хүн гэж авч үзэх ёстой, тэгвэл чи үүнд хүрнэ. Нэг хүн гудамжинд миний номыг гартаа барьчхаад хашхирч байсан: “Ли багш намайг хамгаална, би машинд дайруулахаас айхгүй.” Энэ бол Дафа-г сүйтгэж байгаа хэрэг юм. Ийм хүнийг хамгаалахгүй, үнэндээ жинхэнэ бясалгадаг шавь ийм зүйл хийхгүй.

## **Энергийн орон**

Бид бясалгал, дасгал хийж байхад бидний эргэн тойронд нэг орон үүсдэг. Энэ ямар орон бэ? Зарим хүн үүнийг чий орон, соронзон орон, мөн цахилгаан орон гэж хэлдэг. Үнэндээ чи үүнийг ямар ч орон гэж хэлсэн буруу, яагаад гэвэл энэ оронд оршдог бие бодь нь маш

их баялаг байдаг. Бидний орчлон ертөнцийн орон зай болгоныг бүрдүүлсэн бараг бүх бие бодь энэ гон дотор байдаг, бид үүнийг энергийн орон гэж хэлбэл арай зохистой, иймээс бид үүнийг ерөнхийдөө энергийн орон гэж нэрлэдэг.

Тэгвэл энэ орон ямар нөлөөтэй вэ? Та бүгд мэднэ, манай ариун Фа-гийн бясалгагчдад ийм нэг мэдрэмж байдаг: Энэ нь ариун Фа-гийн бясалгалаас үүсдэг учраас энэрэнгүй бөгөөд орчлон ертөнцийн Жэнь, Шань, Рэнь мөн чанарт ууссан байдаг. Тиймээс манай сурагчид энэ энергийн оронд сууж байхад бодол нь муу бодлоос ангид байдгийг мэдэрдэг, мөн манай олон сурагчид энд сууж байхад тамхи татах ч бодол төрдөггүй, ариун амгалан орчныг мэдэрдэг, их тааламжтай сайхан байдаг, энэ бол ариун Фа-гаар бясалгадаг хүнд байдаг энерги юм, энэ орны хүрээн дотор ийм нөлөө гардаг. Энэ лекцэд суусны дараа манай ихэнх хүн гон-той болно, жинхэнэ гон гарна, миний чамд заасан бол ариун Фа-гийн бясалгалын зүйл, чи өөрийгөө бас энэ шиньшин-ий шалгуурын дагуу шаардах ёстой. Чи үргэлжлүүлэн хичээллэж бидний шиньшин-ий шаардлагын дагуу бясалгахад аажимдаа чиний энерги улам хүчтэй болно.

Бид өөрсдийгөө болон бусдыг, бүх амь бодийг аврахыг ярьдаг, тиймээс Фалунь дотогшоо эргэхдээ өөрийгөө аварна, гадагш эргэхдээ бусдыг аварна, гадагш эргэхдээ энерги гаргана, энэ нь бусдад ашиг тустай, иймд чиний энергийн орны хүрээн доторх хүнд ашигтай, түүнд магадгүй их тааламжтай мэдрэмж төрнө. Чи гудамжинд явж байсан ч, ажил дээрээ байсан ч, эсвэл гэртээ байсан ч, хаана ч байсан ийм нөлөө үзүүлж болно. Чиний орны хүрээн дотор байгаа

хүний бие санаандгүйгээр засагдаж болно, яагаад гэвэл энэ орон бүх буруу төлөв байдлыг засаж чаддаг. Хүний бие өвчтэй байх ёсгүй, өвчтэй байвал буруу төлөв байдалд орсных юм, тэр орон энэ буруу төлөв байдлыг засаж чадна. Муу бодолтой хүнд буруу санаа төрөхөд чиний орны хүчтэй нөлөөнд түүний бодол өөрчлөгдөж болно, магадгүй тэр үед муу зүйл бодохоо болино. Магадгүй нэг хүн хэн нэгнийг загнах бодолтой байснаа гэнэт болино, загнах хүсэлгүй болно. Зөвхөн ариун Фа-гийн бясалгалаас гарсан энергийн орон ийм нөлөө үзүүлж чадна. Тиймээс Буддын шашинд урьд өмнө ийм нэг үг байсан, “Буддын туяа даяар гийхэд зүй бус бүхэн засагдана”, ийм л угтатуй юм.

### **Фалунь Дафа-гийн сурагч бясалгалыг яаж тараах вэ**

Манай олон сурагчид хичээлд суугаад харьсныхаа дараа энэ бясалгалыг их сайн болохыг мэдэрдэг, тэгээд төрөл төрөгсөд, найз нөхдөдөө дамжуулахыг хүсдэг. Болно, та нар үүнийг хэнд ч дамжуулж болно. Гэхдээ нэг зүйлийг бүгдэд анхааруулах ёстой, бид та бүхэнд ийм олон зүйлийг өгсөн, энэ нь ямар ч үнэ цэнээр хэмжигдэшгүй. Яагаад үүнийг та бүгдэд өгч байгаа вэ? Чамайг бясалгуулахын тулд юм, зөвхөн бясалгах л юм бол чамд эдгээр зүйлийг өгч болно. Өөрөөр хэлбэл та нар ирээдүйд бясалгал тараахдаа эдгээр зүйлээр нэр алдар, хувийн ашиг сонирхол хөөцөлдөж болохгүй, тиймээс та нар над шиг курс зохион байгуулж төлбөр авч болохгүй. Яагаад гэвэл бид ном, материал хэвлүүлэх хэрэгтэй, мөн энд тэнд очиж бясалгал заана, зардлаа олох хэрэгтэй. Бидний авдаг төлбөр бол улс орон даяар хамгийн бага, гэхдээ бид хамгийн их зүйлийг өгдөг. Бид хүнийг жинхэнэ дээд түвшин рүү дагуулж

байгаа, үүнийг та бүгд өөрсдөө ч мэдэрч байгаа. Фалунь Дафа-гийн сурагчийн хувьд чи ирээдүйд бясалгалыг тараахад бид чамд хоёр шаардлагыг тавина:

Эхний шаардлага бол төлбөр авч болохгүй. Бид чамд ийм их зүйлийг өгсөн, чамайг баян бол, нэртэй бол гэсэн үг биш, харин чамайг аврахын тулд, чамайг бясалгуулахын тулд юм. Хэрэв чи төлбөр авбал миний Фашэнь чамд өгсөн бүх зүйлээ буцааж авна, мөн үүнээс хойш чи манай Фалунь Дафа-гийн сурагч гэж тооцогдохгүй, чиний тараасан нь бидний Фалунь Дафа-гийн зүйл биш болно. Та нар бясалгал тараахдаа алдар нэр, хувийн ашиг сонирхлоор хөөцөлдөж болохгүй, сайн дураараа хүнд үйлчил. Бүх орон даяарх сурагчид бүгд ингэж хийж байгаа, бас бүх газрын зааварлагчид өөрсдөөрөө үлгэр жишээ харуулж байгаа. Хэрэв чи манай бясалгалыг сурах хүсэлтэй бол ирж сурч болно, бид чамд хариуцлагатай хандана, мөн чамаас ямар ч мөнгө авахгүй.

Хоёр дахь шаардлага бол Дафа-д өөрийнхөө зүйлийг хольж оруулж болохгүй. Өөрөөр хэлбэл дасгал заах явцад чиний тэнгэрийн мэлмий нээгдсэн ч бай, чи ямар ч юм хардаг бай, чамд ямар ер бусын чадварууд гарсан ч бай хамаагүй чи өөрийнхөө харсан байдлаар бидний Фалунь Дафа-г ярьж болохгүй. Чиний өөрийнхөө түвшинд харсан тэр өчүүхэн зүйл бол юу ч биш, бидний ярьж байгаа Фа-гийн жинхэнэ утгаас маш хол байдаг. Ирээдүйд чи бясалгал, дасгал тараахдаа энэ асуудал дээр их болгоомжтой хандах ёстой, зөвхөн ингэж хийвэл бидний Фалунь Дафа-гийн эх зүйлс өөрчлөгдөхгүй гэдгийг батална.

Түүнчлэн над шиг ийм хэлбэрээр бясалгал, дасгал зааж болохгүй, мөн миний хийдэг шиг том хэмжээний

лекц хэлбэрээр Фа ярихыг зөвшөөрөхгүй, чи Фа ярьж чадахгүй. Яагаад гэвэл миний ярьж байгаа зүйлүүд маш гүн утга агуулгатай, дээд түвшний зүйлүүдтэй уялдаа холбоотой. Та нар өөр өөр түвшинд бясалгаж байгаа, ирээдүйд чиний түвшин дээшилсний дараа эргээд энэ бичлэгийг сонсвол чи мөн л үргэлжлэн дээшилнэ, чи үргэлж сонсоход байнга шинэ зүйл ойлгож авна, шинэ зүйл олж авна, номыг уншихад энэ нь бүр илүү. Миний ярьдаг зүйлс маш гүн гүнзгий зүйлсийг уялдуулдаг тул чи энэ Фа-г ярьж чадахгүй. Чи миний хэлсэн үгийг өөрийнхөө үг болгож ярихыг зөвшөөрөхгүй, тэгвэл Фа-г хулгайлсан хэрэг болно. Чи зөвхөн миний үгийг тэр хэвээр нь иш татан Багш ингэж хэлсэн, номд ингэж бичсэн гэж ярьж болно. Яагаад гэвэл чамайг ингэж хэлэхэд үүнд Дафа-гийн хүч оршино. Чи өөрийнхөө мэддэг зүйлийг Фалунь Дафа-гийн зүйл болгон тарааж болохгүй, тэгвэл чиний тараасан нь Фалунь Дафа биш, бидний Фалунь Дафа-г эвдэж байгаатай адил. Чи өөрийнхөө бодол санааны дагуу яривал тэр бол Фа биш, хүнийг аварч чадахгүй, бас ямар ч нөлөө байхгүй, иймээс хэн ч энэ Фа-г ярьж чадахгүй.

Та нар бясалгалыг тараахдаа дасгалын талбайд юм уу хичээллэдэг газарт сурагчдад дууны эсвэл дүрсг бичлэгийг тавьж өгөх, дараа нь зааварчлагч тэдэнд дасгал зааж өгч болно. Та нар хоорондоо ойлгосноо хуваалцах, хамтдаа санал бодлоо солилцох хэлбэрээр явуулж болно, бид та нарыг ингэж хийхийг шаардана. Мөн Фалунь Дафа-г тарааж байгаа сурагч (шавь)-ийг багш эсвэл их багш гэх мэтээр дуудаж болохгүй, Дафа-гийн Багш ганц л байдаг. Бясалгалд эхэлж орсон хүн, дараа нь орж ирсэн хүн ялгаагүй бүгд шавь нар юм.

Та нар бясалгалыг тараахдаа зарим нь магадгүй ингэж бодно: “Багш Фалунь-ийг суулгаж мөн хүний биенийг засаж өгч чадна, бид нар тэгж чадахгүй.” Зүгээр, би та бүгдэд сурагч болгоны ард миний Фашэнь байгаа гэж дээр хэлсэн, энэ нь бас нэг ч биш, иймээс миний Фашэнь эдгээр зүйлийг хийж өгнө. Чи хүнд зааж өгөхөд, хэрэв тэр хүн хувь тавилантай байвал тэр даруй Фалунь-ийг авна. Хувь тавилан нь тийм сайнгүй бол бие нь засагдаж бясалгал, дасгал хийж байх явцдаа яваандаа авч болно, миний Фашэнь түүнд тусалж биенийг нь засаж өгнө. Үүнээс гадна би чамд хэлье, хэрэв чи миний номуудыг уншиж, миний лекцийн дүрст бичлэгийг үзэж, эсвэл миний лекцийн дуу бичлэгийг сонсож Фа болон дасгалыг сурахдаа өөртөө жинхэнэ бясалгагч хүн гэж хандвал, чи хүртэх ёстой зүйлсээ мөн адил олж авах болно.

Бид сурагчдыг хүний өвчнийг үзэж өгөхийг зөвшөөрөхгүй, Фалунь Дафа-гийн сурагчдад хүний өвчнийг эмчилж өгөхийг туйлаас хориглоно. Бид чамд дээш бясалгахыг зааж байгаа, чамд янз бүрийн зууралдсан сэтгэл гаргуулахгүй бас өөрийнхөө биенийг муутгах зүйл хийлгэхгүй. Бидний дасгал хийдэг газар бусад ямар ч чийгон дасгалын газраас илүү сайн, чи бидний тэр газар очиж дасгал хийх нь өөрөө өвчнөө эдгээх гэж янз бүрийн арга хэрэглэж явснаас хавьгүй дээр. Тэнд миний Фашэнь-ууд тойрч суусан байгаа, дасгалын талбай дээгүүрээ хамгаалах бүрхүүлтэй, дээр нь том Фалунь байдаг, том Фашэнь энэ бүрхүүлийн дээгүүр хамгаалж байдаг. Энэ бол энгийн газар биш, энгийн чийгон дасгалын газар ч биш, энэ бол бясалгалын газар. Манай ер бусын чадвартай олон сурагчид Фалунь Дафа-гийн газрыг улаан туяан

бүрхүүлтэй байдгийг харсан, нэлэнхийдээ улаанаар туяарсан байдаг.

Миний Фашэнь сурагчдад шууд Фалунь суулгаж өгч болно, гэхдээ бид зууралдсан сэтгэлийг дэмжихгүй. Чамайг түүнд дасгал зааж байхад, тэр: “Хөөх, би Фалунь-тай болчихлоо” гэнэ. Чи өөрөө түүнийг өгсөн мэт бодож магад, гэхдээ тийм биш. Би үүнийг ярьж байгаагийн учир бол та нарт тийм зууралдсан сэтгэл гаргуулахгүйн тулд юм, энэ бүгдийг миний Фашэнь хийдэг. Бидний Фалунь Дафа-гийн шавь нар ингэж л бясалгалыг тараах хэрэгтэй.

Хэн нэгэн Фалунь Дафа-гийн дасгалыг өөрчлөн засварлах юм бол тэр хүн Дафа-г эвдэж байна, энэ бясалгалын үүдийг эвдэж байна гэсэн үг. Зарим хүн дасгалын зааварчилгааг толгой холбох үгс болгон өөрчилсөн, үүнийг туйлаас зөвшөөрөхгүй. Жинхэнэ бясалгалын аргууд нь бүгд түүхийн өмнөх үеэс, маш өнө эртний үеэс уламжлагдан ирсэн байдаг, мөн тоолшгүй олон аугаа гэгээрэгчид амжилттай бясалгаж гарсан. Хэн ч тэдгээрийг жаахан ч өөрчилж зүрхлээгүй. Ийм байдал зөвхөн Дарма-гийн төгсгөлийн энэ үед гарч байна. Түүхийн аль ч үед ийм зүйл хэзээ ч гарч байгаагүй, та бүхэн энэ асуудалд заавал анхааралтай байгаарай.

# Дөрөвдүгээр лекц

## Алдах ба олох

Бясалгалын хүрээнд үргэлж алдах ба олохын харилцааг ярьдаг, энгийн хүмүүсийн дунд бас алдах ба олохын харилцаа яригддаг. Бид бясалгаж байгаа хүний хувьд “алдах ба олох”-д яаж хандах ёстой вэ? Энэ бол энгийн хүмүүсийнхээс ялгаатай, энгийн хүмүүсийн хүсдэг зүйл нь хувийн эрх ашиг болон яаж сайхан, тав тухтай амьдрах тухайд л байдаг. Манай бясалгагчид ингэхгүй, харин яг эсрэгээрээ энгийн хүний хүсдэг зүйлийг бид эрэлхийлэхгүй, харин бидний олох зүйлийг энгийн хүн хүссэн ч олж авч чадахгүй, гагцхүү бясалгалаар олно.

Бидний ярьдаг алдах бол жижиг хүрээн дэх алдалт биш. Алдах талаар ярихад зарим хүн мөнгөөр хандив өргөх, хэн нэгнийг хэцүү байдалд байгааг нь хараад гар сунгах эсвэл гудамжны гуйлгачинд өглөг өгөх тухай боддог. Энэ ч бас нэг хэлбэрийн өглөг бас нэг хэлбэрийн алдалт, гэвч энэ нь зөвхөн иймэрхүү асуудал дээр буюу мөнгө эсвэл эд материалын тал дээр хөнгөн харж байгаа явдал юм. Хөрөнгө мөнгөний өглөг бол мэдээж нэг талын алдалт, бас нэлээд чухал тал. Харин бидний ярьж байгаа алдах нь ийм жижиг хүрээнд биш, бид бясалгах явцдаа бясалгаж байгаа хүний хувьд хаях ёстой сэтгэл маш олон байдаг. Гайхуулах сэтгэл, атаархах сэтгэл, тэмцэлдэх сэтгэл, баярлах сэтгэл гэх мэт маш олон янзын зууралдсан сэтгэлийг бүгдийг хаях ёстой. Бидний ярьж байгаа алдалт бол өргөн утгатай, бүхий л бясалгалын явцад энгийн хүний бүх зууралдсан сэтгэл, янз бүрийн хүслийг хаях ёстой.



Магадгүй зарим хүн ингэж бодно, “Бид энгийн хүмүүсийн дунд бясалгаж байгаа, бүгдийг нь хаявал бид лам хувраг эсвэл гэлэнмаа нартай адил болох юм биш үү? Бүгдийг нь хаяна гэвэл боломжгүй мэт санагдаж байна.” Манай бясалгалын энгийн хүмүүсийн дунд бясалгах хэсэгт чамайг энгийн хүний нийгэмд, энгийн хүний байдалд аль болох боломжийн хэрээр нийцэж бясалгахыг шаарддаг, материаллаг зүйл дээр чамайг үнэн хэрэгтээ алдуулах гээд байгаа юм биш. Чиний хэр дээгүүр албан тушаалд байх, ямар их мөнгө хөрөнгөтэй байх нь хамаагүй, хамгийн гол нь чи энэ сэтгэлээ орхиж чадах, чадахгүйн асуудал юм.

Бидний бясалгал шууд хүний сэтгэл рүү чиглэдэг, хувь хүний ашиг сонирхол болон хүн хүний хоорондын зөрчил дунд эдгээр зүйлд хөнгөн хандаж чадах эсэхэд асуудлын гол нь байгаа юм. Сүм хийдэд болон зэлүүд уулс, ойн гүнд хийдэг бясалгалууд бол чамайг энгийн хүний нийгмээс бүрэн тусгаарлана, энгийн хүний сэтгэлийг чинь хүчээр орхиулна, аливаа эд материалын ашиг чамд олуулахгүй, ингэж чамайг алдуулна. Энгийн хүмүүсийн дунд бясалгаж байгаа хүн энэ замаар явахгүй, энгийн хүний амьдралын орчинд үүнийг хөнгөн харахыг шаардана, мэдээж энэ нь маш хэцүү, гэхдээ энэ бол манай бясалгалын хамгийн гол зүйл юм. Иймээс бидний ярьж байгаа алдах нь нэг явцуу хүрээнд биш харин өргөн утга агуулгатай. Сайн үйл хийх, эд мөнгөний өглөг өгөх талаар ярьв, гудамжинд байгаа одоогийн зарим гуйлгачид мэргэжсэн, тэд магадгүй чамаас их мөнгөтэй. Бид үл ялих зүйл дээр анхаарахын оронд өргөн хүрээнд харах ёстой. Бясалгалын хувьд, өргөн хүрээнд нээлттэй, эрхэм сайн чанарыг барин бясалгах хэрэгтэй. Бидний

алдах явцад, бидний алдаж буй нь үнэн хэрэгтээ муу зүйлс юм.

Хүмүүс ер нь өөрсдийнхөө хөөцөлддөг юм болгоныг сайн зүйл гэж үздэг, үнэндээ дээд түвшнээс харахад, энэ бүгд энгийн хүмүүсийн дунд олсон тэр жаахан хувийн ашигтаа сэтгэл ханахад байдаг. Шашинд ингэж ярьдаг: Чи хэчнээн ч их мөнгөтэй байсан, ямар ч том албан тушаалд байсан энэ нь зөвхөн хэдэн арван жилд л нөлөөтэй, төрөхдөө хамт авчирч чадахгүй, үхэхдээ хамт аваад явж чадахгүй. Энэ гон яагаад ийм нандин байдаг вэ? Яагаад гэвэл тэр шууд чиний Юань-шэнь (сүнс)-ий бие дээр өсдөг, төрөхдөө авч ирдэг, үхэхдээ аваад явдаг, түүнчлэн гон чиний бясалгалаар хүрэх бүтээлийн орныг шууд тодорхойлодог учраас бясалгахад амаргүй байдаг. Өөрөөр хэлбэл, чиний алдсан нь муу зүйл юм, ингэснээр чи үүссэн эх үндсэндээ буцаж үнэнд хүрч чадна. Тэгвэл юу олж авах вэ? Чиний түвшин дээшилнэ, эцэст нь гэгээрлийн хутгийг олно, төгс гэгээрч үндсэн асуудал шийдэгдэнэ. Мэдээж бид энгийн хүний янз бүрийн дур хүслийг орхиж жинхэнэ бясалгагч хүний жишигт хүрнэ гэвэл, бүгдийг нэг дор хийнэ гэвэл тийм амар биш, үүнийг аажим аажмаар хийнэ. Намайг үүнийг аажмаар хий гэж хэлэхийг сонсоод, багш бидэнд аажмаар хий гэж хэлсэн, тэгвэл аажмаар хийе гэнэ. Тэгвэл болохгүй! Чи өөртөө хатуу шаардлагатай байх ёстой, гэхдээ бид чамайг аажмаар дээшлэхийг зөвшөөрнө. Гэнэт өнөөдөр энэ бүгдийг хийж чадвал, чи өнөөдөр Будда болчихно, иймээс энэ нь бодит биш, чи үүнд аажмаар л хүрнэ.

Бидний алдсан нь үнэндээ бол муу зүйл юм, энэ нь юу вэ? Энэ бол нүгэл, тэр нь хүний янз бүрийн

сэтгэлтэй нягт уялдаа холбоотой байдаг. Жишээлбэл энгийн хүнд янз бүрийн муу бодол санаа байдаг, хүн хувийн эрх ашгийнхаа төлөө янз бүрийн муу үйл хийдэг, тэгээд энэ хар бие бодь болох нүглийг олж авдаг. Энэ нь бидний өөрийн сэтгэлтэй шууд холбоотой, энэ муу зүйлийг устгахын тулд чи хамгийн түрүүнд өөрийнхөө сэтгэлийг өөрчлөх ёстой.

## **Нүглийн хувиралт**

Цагаан бие бодь ба хар бие бодийн хооронд хувирах явц байдаг. Хүн хүний хооронд зөрчил гарсны дараа энэ хувирах явц гардаг. Сайн үйл хийхэд цагаан бие бодь болох Дэ (буян)-г олж авдаг, муу үйл хийхэд хар бие бодь болох нүгэл (карма) ирдэг. Мөн уламжлан дамжиж ирэх явц бас байдаг, зарим хүн ингэж ярьдаг: “Залуу насандаа муу зүйл хийснээс болдог уу?” Энэ нь бүхэлдээ тийм байх албагүй, яагаад гэвэл хүний нүгэл зөвхөн нэг амьдралын туршид хуримтлагддаг юм биш. Бясалгалын хүрээнд сүнс устдаггүй гэж ярьдаг. Хэрэв сүнс устдаггүй юм бол тэр хүн өмнөх амьдралдаа нийгмийн харилцаанд байсан байж таарна, тэгвэл тэр урьд насандаа магадгүй хэн нэгэнд өр тавьсан, хэн нэгнийг дээрэлхсэн, эсвэл ямар нэг муу зүйл хийсэн, амь хороох гэх мэт зүйл хийсэн байж болно, тэгвэл энэ нь нүглийг бий болгодог. Эдгээр зүйлс өөр орон зайд хуримтлагддаг, үргэлж хамт явдаг, цагаан бие бодийн хувьд бас адилхан, зөвхөн эдгээр хэлбэрийн эх үүсвэрт хязгаарлагдахгүй, бас өөр байдал байдаг, гэр бүлийн удам угсаагаар, өвөг дээдсээс хойч үедээ дамжиж болно. Урьд өмнө хөгшчүүл ингэж ярьдаг байсан: “Буян хураа, буян хураа, өвөг дээдэс буян хурааж ирсэн; энэ хүн буянаа алдаж байна, буянаа гээж байна.” Энэ бол маш үнэн үг. Өнөөгийн энгийн хүмүүс энэ

үгийг хүлээж авахаа больсон, чи тэдгээр залуучуудад буянаа алдах, буянаа гээх гэж ярихад тэд үүнийг ердөө ойшоож сонсохгүй. Үнэндээ үүний утга нь маш гүн гүнзгий юм, энэ нь зөвхөн өмнөх зууны хүмүүсийн үзэл суртал болон оюун санааны хэмжүүр биш, харин жинхэнэ бодитоор оршдог зүйл бөгөөд бидний хүний биед ийм хоёр төрлийн бие бодь байдаг.

Зарим хүн, “Хар бие бодь ихтэй хүн дээд түвшин рүү бясалгаж чадахгүй юу?” гэж асуудаг. Тэгж хэлж болно, хар бие бодь ихэсвэл хүний ухамсарт нөлөөлдөг. Яагаад гэвэл энэ нь чиний биеийн гадуур бүрхүүл үүсгэдэг, чамайг яг голдоо ороогоод орчлон ертөнцийн Жэнь, Шань, Рэнь мөн чанараас тусгаарладаг, тиймээс ийм хүний ухамсар нь магадгүй муу байдаг. Хүмүүс бясалгал болон чийгон-ы талаар ярихад тэр хүн үүнийг мухар сүсэг гэж үздэг, ердөө ч итгэхгүй, түүнд инээдтэй санагддаг. Ер нь ийм байдаг, гэхдээ бас дандаа ийм байхгүй. Ийм хүн бясалгахад маш хэцүү юу? Өндөр гон-той болох боломжгүй гэсэн үг үү? Энэ нь бас тийм биш, бид Дафа бол хязгааргүй, энэ нь чиний бясалгах сэтгэлээс бүрэн шалтгаална гэж хэлнэ. Багш чамайг бясалгалын үүдээр оруулж өгнө, цаашдын бясалгал чамаас өөрөөс чинь шалтгаална, чиний яаж бясалгахаас хамаарна. Чиний бясалгаж чадах үгүйг чинь, тэвчиж чадах үгүйг чинь, өөрийгөө зориулж чадах үгүйг чинь, бэрхшээлийг даван туулж чадах үгүйг чинь харна. Хэрэв чи бясалгахаар хатуу шийдсэн бол ямар ч бэрхшээл чамайг зогсоож чадахгүй, тэгвэл асуудалгүй гэж би хэлнэ.

Хар бие бодь ихтэй хүн цагаан бие бодь ихтэй хүнийг бодвол гол төлөв илүү хүч хөдөлмөр гаргах шаардлагатай болдог. Цагаан бие бодь орчлон

ертөнцийн Жэнь, Шань, Рэнь мөн чанарт ууссан байдаг тул тэр хүн зөвхөн шиньшин-ээ дээшлүүлэхэд, зөрчлийн дунд өөрийгөө дээшлүүлэхэд түүний гон нь өснө, ийм л хялбар. Дэ ихтэй хүний ухамсар нь өндөр, бас бие сэтгэлийн хүнд бэрхшээлийг туулж чадааг, тэр хүн биеэрээ илүү зовлон амсаж сэтгэл санааны бага зэрэг зовлон үзсэн ч түүний гон ялгаагүй өснө. Хар бие бодь ихтэй хүний хувьд бол тийм биш, тэр эхлээд заавал ийм нэгэн явцыг туулах ёстой: Эхлээд хар бие бодийг цагаан бие бодиор хувиргах ёстой, энэ дамжлага бол тун их зовлонтой. Иймээс ухамсар муутай хүн гол төлөв илүү зовлон амсаг, их нүгэлтэй бас ухамсар муутай бол бясалгахад бүр ч хэцүү.

Нэг бодит жишээн дээр ярья, тэр хүний яаж бясалгаж байгааг нь харъя. Бясалган суухад хөлөө удаан хугацаагаар завилж суух шаардлагатай байдаг, ингэж завилж суухад хөл өвдөнө, бадайрна, удаан суухад сэтгэл хэцүүдэж эхэлнэ, байж сууж ядна. Бие сэтгэлээр зовоход бие ч таагүй сэтгэл ч таагүй. Зарим хүн завилж суух өвдөлтөөс болоод хөлөө тэнийлгэдэг, үргэлжлүүлж тэвчихийг хүсдэггүй. Бас зарим хүн жаахан удаан завилж суусныхаа дараа тэвчихгүй хөлөө тэнийлгэхэд дасгал нь үр дүнгүй болно. Мөн завилж суугаад хөл нь өвдөнгүүг тэнийлгэн хэсэг амраагаад дахиад үргэлжлүүлэн завилж суухад бидний харснаар дасгал нь ямар ч үр дүнгүй болдог. Яагаад гэвэл хүний хөл өвдөхөд хар бие бодь хөл рүү давшилдгийг бид харсан. Хар бие бодь бол нүгэл, үүнийг зовлон эдэлснээр арилгаж Дэ болгон хувиргана. Өвдөж эхэлмэгц нүгэл арилж эхэлнэ, нүгэл их орж ирэх тусам хөлийн өвдөлт улам ихэснэ, тиймээс хөлийн өвдөлт учир шалтгаангүй гардаг юм биш. Завилж суугаад бясалгахад хөлийн өвдөлт гол төлөв үе үеэр давтагдааг,

нэг хэсэг өвдөөд маш таагүй байна, өвдөлт өнгөрсний дараа хэсэг намжиж байгаад дахин өвдөж эхэлнэ, ер нь ийм л байна.

Нүгэл хэсэг хэсгээр арилдаг тул нэг хэсэг нь арилсны дараа хөл арай гайгүй болно. Удалгүй дараагийн хэсэг ирэхэд дахиад өвдөж эхэлнэ. Хар бие бодь арилсны дараа хийсэж алга болохгүй, устаж үгүй болдоггүй, шууд цагаан бие бодь болон хувирна, энэ цагаан бие бодь бол Дэ. Яагаад ингэж хувирч болдог вэ? Яагаад гэвэл энэ хүн зовлон амссан, бие сэтгэлээ зориулсан, мөн зовлонг тэвчиж давсан. Бид өөр дээрээ зовлон бэрхшээлийг тэсвэрлэн давж туулснаар, сайн зүйл хийснээр Дэ-г олж авдаг гэж хэлсэн, иймээс бясалган сууж байхад ийм байдал гардаг. Зарим хүн хөл нь өвдөж эхлэнгүүт хөлөө тэнийлгэн хөдөлгөж амраагаад дахин үргэлжлүүлдэг, ингэж хийвэл ямар ч үр дүнгүй болно. Зарим хүн “Багана зогсолт” дасгал хийхдээ гар нь чилэхэд тэвчиж чадахгүй гараа буулгадаг, тэгэхэд бас ямар ч үр дүнгүй. Ийм жаахан зовлон юу ч биш биз дээ? Хүн бясалгахдаа гараа өргөж зогсоод бясалгалын эцэст хүрдэг бол энэ нь хэтэрхий амархан гэж би хэлнэ. Энэ бол хүн завилж суугаад бясалгахад гардаг байдал юм.

Бидний бясалгал ерөнхийдөө ийм байдлаар явагдахгүй ч гэсэн зарим тал дээр бас ийм нөлөө гардаг. Нүгэл хувирах ихэнх байдал хүн хүний хоорондын шиньшин-ий зөрчил дунд явагддаг, үргэлж ийм байдлаар илэрнэ. Хүн хүний хоорондын зөрчлдөөн, сөргөлдөөн дунд тэвчин байх нь биеэр амсах зовлонгоос ч хэцүү. Минийхээр бол, биеэр үзэх зовлонг давахад хамгийн амархан, шүүдээ зуугаад л

өнгөрөөчихнө. Хүмүүс хоорондоо бие биеэ чадахад, сэтгэлээ барих нь хамгийн хэцүү байдаг.

Жишээ ярья, нэг хүн ажилдаа дөнгөж орж ирээд байж байтал хоёр хүн түүнийг их муухайгаар ярьж байхыг нь сонссон, түүний уур дүрсхийсэн. Гэхдээ бид хэлсэн, бясалгагч хүний хувьд цохиулсан ч эргэж цохихгүй, загнуулсан ч эргэж хэрэлдэхгүй, өөрийгөө дээд шалгуурын дагуу барих ёстой. Тэр хүн багшийн хэлсэн “Бид бясалгагч хүмүүс, бусад хүнтэй адил байж болохгүй, өндөр ёс суртахуунтай байх ёстой” гэсэн үгийг санасан. Тэр нөгөө хоёр хүнтэй хэрэлдээгүй. Гэхдээ ер нь зөрчил гарахад, тэр нь хүний сэтгэлийг цочроож чадахгүй бол тооцогдохгүй эсвэл нэмэргүй, дээшилж чадахгүй. Иймээс сэтгэл нь тайвширч чадахгүй түүнийг шаналгана, энэ сэтгэл толгойноос нь салахгүй өөрийг нь муулсан хоёр хүнийг эргэж хармаар санагдаад болохгүй. Эргээд харахад нөгөө хоёр хүний царай нь их заналтай харагдана. Тэдний яриаг тэсэхийн аргагүй болсон тул, энэ агшинд түүний тэвчээр алдарч уур нь гэнэт дүрэлзэн магадгүй тэдэнтэй шууд хэрэлдэнэ. Хүн хүний хооронд зөрчил гарахад сэтгэлээ барих нь хамгийн хэцүү. Хэрэв завилж суугаад бүхнийг давдаг бол энэ нь ёстой амар гэж би хэлнэ, гэхдээ үргэлж ийм байхгүй.

Иймээс чиний цаашдын бясалгалд янз бүрийн саад бэрхшээл чамд тохиолдоно. Тэдгээр бэрхшээл байхгүй бол чи яаж бясалгах юм? Хүн болгон нэг нэгэндээ сайн, хоорондоо ашиг сонирхлын зөрчилгүй, сэтгэл санааны үймүүлэл байхгүй бол, чи зүгээр сууж байгаад шиньшин-ээ дээшлүүлэх юм уу? Энэ бол боломжгүй. Хүн бодит байдлаар өөрийгөө жинхэнэ хатуужуулах ёстой, ингэснээр л дээшилж чадна. Зарим хүн ингэж

асуудаг: “Бясалгахад бидэнд яагаад саад бэрхшээл үргэлж тохиолддог юм бэ? Энгийн хүмүүсийнхтэй бараг ялгаа байхгүй.” Яагаад гэвэл чи энгийн хүмүүсийн дунд бясалгаж байгаа, чамайг гэнэт толгойгоор чинь доош харуулан агаарт дүүжлэн зовоохгүй нь лавтай, тэгэхгүй. Бүх юм энгийн хүний байдлаар явагдана, өнөөдөр хэн нэгэн чамайг өдөж болно, хэн нэгэн чамайг уурлуулна, хэн нэгэн чамд зохисгүй хандана, эсвэл гэнэт хэн нэгэн чамтай бүдүүлэг харьцана, чамайг эдгээр асуудалд яаж хандахыг чинь харна.

Яагаад ийм асуудалтай тулгардаг вэ? Тэр бүгд бол чиний хийсэн нүглээс болж гардаг, бид чиний нүглийн тоолшгүй олон хэсгийг аль хэдийн арилгаж өгсөн. Үүнээс үлдсэн зөвхөн жаахан хэсгийг чиний шиньшин-ийг дээшлүүлэхийн тулд, сэтгэлийг чинь хатуужуулахын тулд, чиний янз бүрийн зууралдсан сэтгэлийг хаяулахын тулд өөр өөр түвшинд туулах саад бэрхшээл болгон хуваасан. Энэ бүгд бол чиний өөрийн гай зовлон, үүнийг бид чиний шиньшин-ийг дээшлүүлэхийн тулд ашигладаг, чамд тэдгээрийг даван туулж чадах байдлаар зохицуулж өгнө. Чи шиньшин-ээ дээшлүүлээд л байвал тэдгээрийг давж чадна, чи давах хүсэлгүй бол давж чадахгүй, давах хүсэлтэй байвал давна. Иймээс үүнээс хойш чамд ямар нэгэн зөрчил тохиолдоход чи түүнийг санамсаргүй зүйл гэж битгий үз. Зөрчилдөөн санаандгүй байтал гэнэт гарна, гэхдээ энэ нь санамсаргүй тохиолдлын зүйл биш, энэ бол чиний шиньшин-ийг дээшлүүлэхийн тулд юм. Чи өөрийгөө бясалгагч хүн гэж үзэн хандвал үүнийг зөвөөр зохицуулж чадна.

Мэдээж саад бэрхшээл, зөрчил гарахыг чамд урьдчилан хэлэхгүй, бүгднийг нь хэлчихвэл чи яаж



бясалгах юм? Тэгвэл тэр нь ямар ч нөлөөгүй болно. Эдгээр нь гол төлөв гэнэт тохиолдоно, ингэснээр хүний шиньшин-ийг шалгадаг, шиньшин-ийг жинхэнэ дээшлүүлэх боломж олгоно, шиньшин-ээ сайн барьж чадах үгүйг чинь харна, ингэж л харагддаг, иймээс зөрчил гарах нь санаандгүй болдог юм биш. Бүхий л бясалгалын явц дахь нүглийн хувиралтад ийм асуудал гардаг, энэ нь жирийн хүний төсөөлдөг яс махаараа амсах зовлонгоос ч илүү хэцүү. Чи дасгалаа жаахан удаан хугацаагаар гараа өргөж хийгээд чилэхэд, хөл чинь зогсоод ядрахад гон чинь өснө гэж үү? Дасгалаа хэдэн цаг илүү хийгээд л гон чинь өсөх юм уу? Дасгал бол түвшнийг дээшлүүлэх нөлөө үзүүлэхгүй, зөвхөн чиний бие (бэньти)-ийг хувиргах нөлөөтэй, бас үүнийг хүчирхэгжүүлэх энерги хэрэгтэй. Сэтгэлээ хатуужуулах нь жинхэнэ түвшинээ дээшлүүлэх гол түлхүүр юм. Зөвхөн биеэрээ зүдрээд дээшилж болдог бол хятадын тариачид хамгийн ихээр ядарч зовдог гэж би хэлнэ, тэд бүгдээрээ том чийгон багш нар болчих юм уу? Чи биеэрээ яаж ч их зүдэрсэн тэднийг гүйцэхгүй, тэд өдөр болгон тариалангийн талбайд халуун наранд шарагдан махран ажиллана. Энэ бол тийм амар асуудал биш. Иймээс жинхэнэ дээшлэх хүсэлтэй байвал чи сэтгэлдээ жинхэнэ ахиц гаргах хэрэгтэй гэж бид хэлсэн. Зөвхөн тэгвэл л жинхэнэ дээшилнэ.

Нүгэл хувирах явцад өөрийгөө барьж чаддаг байхын тулд, мөн энгийн хүнтэй адил асуудалд буруу хандахгүйн тулд бид ердийн үед ч үргэлж энэрэнгүй, тайван сэтгэлтэй байх хэрэгтэй. Гэнэт ямар нэг асуудалтай тулгарахад чи түүнд зүй зохистой хандаж чадна. Чи үргэлж нинжин, энэрэнгүй сэтгэлтэй байвал гэнэт асуудал гарах үед чамд түүнийг намжаах боломж,

бодох хугацаа байх болно. Хүнтэй байнга өрсөлдөх бодолтой, тэмцэлдэх сэтгэлтэй бол асуудал гарах бүрд ч хүнтэй тэрсэлдэнэ гэдгийг би баттай хэлнэ. Иймээс ч имар нэгэн зөрчилтэй тулахад, энэ нь чиний хар бие бодийг цагаан бие бодь, Дэ болгон хувиргах явдал юм гэж би хэлнэ.

Бидний хүн төрөлхтөн өнөөгийн ийм хэмжээнд хүртлээ хөгжсөн тул бараг хүн бүр үйлийн үр дээр хураагдсан үйлийн үртэй төрдөг болсон, хүн болгоны бие маш их нүгэлтэй. Тийм учраас нүгэл хувирахад ийм байдал гардаг, чиний гон өсөхөд, шиньшин дээшлэхэд нүгэл бас зэрэг арилж, хувирч байдаг. Зөрчилдөөн гарахад, магадгүй хүн хүний хоорондын шиньшин-ий мөргөлдөөнөөр илэрнэ, хэрэв ч тэвчиж чадвал чиний нүгэл арилна, чиний шиньшин дээшилнэ, чиний гон бас дээш өснө, энэ бүгд зэрэг явагдана. Урьд өмнөх үеийн хүмүүс буян ихтэй, тэдний шиньшин угийн их өндөр, жаахан зовлон амсахад л гон нь өсдөг байсан. Өнөөгийн хүмүүс бол тийм биш болсон, бага зэргийн зовлон үзэхэд л бясалгах хүсэлгүй болдог, түүнээс гадна хүмүүс улам бүр ухамсарлахгүй болсноор бясалгах нь бүр ч хэцүү болж байна.

Бясалгалын явцад бодит зөрчилдөөнтэй тулгарах үед, эсвэл хүмүүс чамд муугаар хандах үед, хоёр янзын байдал байж болно: Нэг нь, чи магадгүй урьд насандаа тэр хүнд муугаар хандаж байсан, чи сэтгэлдээ үүнийг шударга бус байна гэж үзнэ, “Яагаад надад ингэж хандаж байгаа юм бол?” Тэгвэл чи урьд нь тэр хүнд яагаад тэгж хандсан юм бэ? Тэр үед чи үүнийг мэдээгүй гэж хэлж магадгүй, энэ насанд урьд насны зүйл хамаагүй гэж хэлнэ, тэгвэл болохгүй. Бас өөр нэг байдал бол зөрчилдөөнд нүгэл хувирах асуудал холбогддог,

тнймээс бид бодиг зөрчилдөөнд хандахдаа өндөр ёс суртахууны дагуу байх ёстой, энгийн хүн шиг байж болохгүй. Ажлын газарт болон бусад ажлын орчинд адилхан, мөн хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн хувьд бас адилхан, хүн хүний хоорондын харьцаа байдаг, нийгмийн харилцаанд орохгүй байх аргагүй, наад зах нь хөрш хоорондын харилцаа байдаг.

Нийгмийн харилцаанд янз бүрийн зөрчилтэй тулгардаг. Энгийн хүмүүсийн дунд бясалгаж байгаа энэ хэсэгт чи хэчнээн ч их мөнгөтэй байх нь, ямар ч өндөр албан тушаалтай байсан, хувиараа хөдөлмөр эрхэлдэг эсвэл компани удирддаг, ямар ч төрлийн бизнес эрхэлдэг байх нь хамаагүй чи шударга арилжаатай бай, зөв шулуун сэтгэлтэй бай. Хүний нийгэмд янз бүрийн ажил төрөл байх ёстой, энэ нь хүний ямар ажил төрөл хийхээс илүүтэй хүний сэтгэл зөв бишээс болдог. Ийм нэг хуучны үг байдаг, “Арван наймаачнаас ес нь зальхай”, энэ бол энгийн хүмүүсийн яриа, хүний сэтгэлийн асуудал гэж би хэлнэ. Хэрэв хүний сэтгэл нь зөв, арилжаа нь шударга байхад чи илүү зүтгэл гаргавал илүү мөнгө олох нь зүй ёсны хэрэг, энэ нь чи энгийн хүмүүсийн дунд илүү зүтгэл гаргасны үр дүн, алдахгүй бол олохгүй, чиний олсон нь хөдөлмөрөөр олсон зүйл. Нийгмийн янз бүрийн давхаргад чи сайн хүн байж болно, өөр өөр нийгмийн давхаргад өөр өөр зөрчил байдаг. Нийгмийн дээд давхаргад тухайн давхаргын зөрчил байдаг, энэ бүгдийг зөвөөр зохицуулж болно, аль нэг давхаргад сайн хүн байхын тулд янз бүрийн хүсэл, зууралдсан сэтгэлд хөнгөн ханд. Янз бүрийн давхаргад сайн хүн байж болно, хэн ч өөрийнхөө байгаа нийгмийн давхаргад бясалгаж болно.

Өнөө үед Хятадад, улсын компанид ч бай бусад аж ахуйн салбарт ч бай ялгаагүй хүмүүс хоорондын зөрчил их хурцадсан. Бусад улс оронд ба түүхэнд хэзээ ч ийм байдал гарч байгаагүй, иймээс хувийн ашиг сонирхлын зөрчилдөөн нэн ширүүссэн, бие биеэ чадах, жаахан эд ашгийн төлөө тэмцэлдэхээс гарсан бодол, хэрэглэдэг арга нь маш муухай, сайн хүн байхад ч гэсэн хэцүү болсон. Жишээлбэл чамайг ажилдаа ирэхэд ажлын уур амьсгал таагүй байгаа нь мэдрэгдсэн. Сүүлд нь чи нэгнээс нь хэн нэгэн чиний талаар их муухай цуурхал дэгдээж, даргад хүртэл муулж нэр хүндийг чинь гутаасан тухай сонссон. Бусад хүмүүс чам руу сонин харцаар харна. Жирийн хүн яаж ийм байдлыг тэвчих юм? Ийм доромжлолыг яаж хүлээж авах юм? “Тэр намайг чадсан бол би ч түүнийг бас чадна. Түүний талынхан байвал миний талынхан ч бас байна, үзэлцье” гэнэ. Энгийн хүмүүсийн дунд ингэвэл, тэд чамайг мундаг хүчтэй гэнэ. Гэхдээ бясалгадаг хүний хувьд бол ёстой муухай. Чи энгийн хүнтэй адил өрсөлдөж тэмцэлдвэл энгийн хүн л гэсэн үг, хэрэв чи түүнээс давж гарах юм бол, чи тэр энгийн хүнээс ч дор гэсэн үг.

Бид ийм асуудалд яаж хандах вэ? Ийм зөрчилтэй тулгарах үед, бид юуны өмнө уужуу тайван байх ёстой, түүнтэй адил хандаж болохгүй. Мэдээж бид асуудлыг эелдэг байдлаар тайлбарлаж болно, учир шалтгааныг тодруулахад буруу юм байхгүй, тэгэхдээ чи үүнд хэтэрхий зууралдаж бас болохгүй. Хэрэв бид ийм маргаантай асуудалтай тулгарвал бусадтай адил өрсөлдөн тэмцэлдэж болохгүй. Хүн чамд яаж хандана, чи бас тэгж хандана гэвэл чи энгийн хүнтэй адил болсон биш гэж үү? Чи түүнтэй адил өрсөлдөн тэмцэлдэхгүй төдийгүй бас сэтгэлдээ тэр хүнийг занаж

болохгүй, үнэхээр занаж болохгүй. Чи түүнийг занаж байвал чи уурласан биш гэж үү? Чи тэвчээрийг дагаж мөрсөнгүй. Бид Жэнь, Шань, Рэнь дагуу бясалгадаг байтал чамд жаахан ч нинжин сэтгэл алга. Иймээс чи түүнтэй адил байж болохгүй, хэдийгээр тэр чамайг нүүрээ хийх газаргүй болтол дээр дооргүй муулсан ч чи үнэндээ түүнд уурлаж болохгүй. Чи түүнд уурлахын оронд харин ч эсрэгээрээ баярлах ёстой, чин сэтгэлээсээ талархах хэрэгтэй. Энгийн хүн бол ингэж бодно: “Тэгвэл яг А-Кю-тай адилхан болох юм биш үү?” Би чамд хэлэхэд, энэ бол тийм биш.

Та бүгд бодоод үз, чи бол бясалгадаг хүн, чамайг дээд шалгуураар шаардах ёстой биз дээ? Энгийн хүний зарчмаар шаардаж болохгүй. Бясалгадаг хүний хувьд чиний олж байгаа нь дээд түвшний зүйлүүд биш гэж үү? Тэгвэл чамайг дээд түвшний зарчмаар шаардана. Тэр хүнтэй адил харьцвал чи түүнтэй адилхан болсон биш гэж үү? Тэгвэл яагаад түүнд баярлах ёстой вэ? Боддоо, чи юу олж авах гэж байгаа билээ? Энэ орчлон ертөнцөд “алдахгүй бол олохгүй” гэсэн зарчим байдаг, олно гэвэл алдана. Тэр хүн чамайг энгийн хүмүүсийн дунд их хэцүү байдалд оруулсан, тэгвэл тэр олж авсан талд тооцогдоно, тэр ашиг хүртсэн. Тэр чамайг их муулах тусам улам дуулиан дэгдээнэ, чи тэр хэрээр тэсвэрлэх болно, тэр буянаа бүр ихээр алдана, энэ буян нь бүгд чамд ирнэ. Чи энэ бүгдийг тэвчиж байхдаа магадгүй сэтгэлдээ үүнийг хүндээр хүлээж аваагүй, юм санаагүй.

Энэ орчлон ертөнцөд бас ийм нэг зарчим байдаг: Чи маш их зовлон даасан болохоор биен дэх нүгэл (карма) чинь бас хувирах болно. Яагаад гэвэл чи зовлонг даан тэвчсэн, хэдий их хэмжээгээр даана төдий

чинээгээр хувирна, бүгд Дэ болж хувирна. Энэ Дэ бол бясалгагч хүний хүсдэг зүйл биз дээ? Чиний нүгэл бас арилсан тул чи хоёр талын ашиг оллоо. Тэр чамд ийм нэг байдал үүсгээгүй бол чи хаана очиж шиньшин-ээ дээшлүүлэх юм? Чи ч сайн, би ч сайн эв найртай суугаад байвал гон дээш өсөх юм уу, тийм зүйл гэж байх юм уу? Тэр хүн энэ зөрчлийг бий болгосон нь чамд шиньшин-ээ дээшлүүлэх боломж өгсөн юм, чи үүний дунд өөрийнхөө шиньшин-ийг дээшлүүлж чадсан, чиний шиньшин дээшилсэн биш гэж үү? Чи гурван талын ашиг оллоо. Чи бол бясалгагч, чиний шиньшин дээшилсэн болохоор гон чинь бас өснө биз дээ? Чи нэг дор дөрвөн талын ашиг оллоо. Чи тэр хүнд баярлах ёсгүй гэж үү? Түүнд чин сэтгэлээсээ талархах хэрэгтэй, үнэндээ бол ийм л байдаг.

Мэдээж түүнээс гарсан сэтгэл нь муу, эс бөгөөс чамд Дэ-гээ өгөхгүй, гэхдээ тэр үнэндээ чиний шиньшин-ийг дээшлүүлэх боломж олгосон. Өөрөөр хэлбэл бид заавал шиньшин-ээ бясалгахыг чухалд үзэх ёстой, шиньшин-ээ бясалгахад нүгэл хамт арилж Дэ болж хувирна, тэгээд чиний түвшин дээшилнэ, ийм харилцан уялдаатай. Дээд түвшнээс харахад, эдгээр зарчмууд бүгд өөрчлөгддөг. Энгийн хүн үүнийг ойлгож чадахгүй, чи дээд түвшнээс энэ зарчмыг харахад бүгд өөр байдаг. Чи энгийн хүмүүсийн дунд байхдаа ямар нэг зарчмыг зөв гэж үзнэ, гэвч тэр нь үнэндээ зөв байдаггүй. Зөвхөн дээд түвшнээс харсан нь жинхэнэ зөв юм, ер нь ийм байдаг.

Би та бүгдэд энэ зарчмуудыг тодорхой ярьж өглөө, зарчмуудыг энд хэдийнээ ил тод болгосон болохоор үүнээс хойш хүн бүр өөрийгөө бясалгагч гэж үзэн жинхэнэ бясалгана гэдэгт найдаж байна. Энгийн

хүмүүсийн дунд амьдарч байгаагийн хувьд магадгүй зарим хүн энгийн хүний материаллаг бодит ашгийг хараад түүнийг илүүд үзнэ. Энгийн хүний урсгал дунд тэр өөрийгөө дээд шалгуурын дагуу шаардаж чаддаггүй. Үнэндээ энгийн хүмүүсийн дунд сайн хүн байхын тулд баатар, гарамгай хүмүүсээс үлгэр дуурайлал авч болно, гэхдээ тэд бол энгийн хүмүүсийн л үлгэр дуурайлал юм. Хэрэв чи бясалгагч болохыг хүсэж байвал сэтгэлээ яаж бясалгахаас чинь шалтгаална, чиний ухамсраас шалтгаална, ямар ч үлгэр дуурайлал гэж байхгүй. Ашгүй бид өнөөдөр Дафа-г нийтэд дэлгэрүүллээ, урьд өмнө чи бясалгахыг хүссэн ч заах хүн байгаагүй. Чи Дафа-гийн дагуу замнаж чадвал магадгүй илүү сайн хийнэ, бясалгаж чадах чадахгүй нь, болох болохгүй нь, ямар түвшинд хүрэх нь бүгд чамаас өөрөөс чинь шалтгаална.

Мэдээж нүгэл хувирах хэлбэр нь миний сая ярьсантай дандаа адил байхгүй, өөр байдлаар бас илэрдэг. Нийгэмд болон гэр бүлд ч илэрдэг. Гудамжинд явж байхад эсвэл нийгмийн өөр орчинд магадгүй зарим төвөгтэй асуудалтай тулгарна. Энгийн хүмүүсийн дунд салж чадахгүй байгаа сэтгэлийг чинь бүгдийг нь хаяулна. Чамд ямар л зууралдсан сэтгэл байна бүгдийг нь янз бүрийн орчинд шаталж байхгүй болгоно. Чамайг унагана, ийм байдлаар ухамсарлуулна, ингэж л бясалгалыг туулна.

Нэлээд түгээмэл гардаг ийм нэг байдал байдаг: Манай олонх хүн бясалгалынхаа явцад ер нь чийгон-оор хичээллэхэд эхнэр эсвэл нөхөр нь их дургүй байдаг, чамайг дасгалаа хийж эхлэнгүүт л тэр чамд уурлаж, хэрэлдэж эхэлнэ. Чамайг өөр зүйл хийж байвал хань чинь тоохгүй. Маажон тоглоод хэр их

цаг заваа үрсэн ч тэр дургүй байж магад гэхдээ чамайг чийгон-оор хичээллэхэд чинь уурладаг шиг байхгүй. Чи чийгон дасгал хийхэд түүнд төвөг болохгүй, биеэ сайжруулахын тулд хийж байгаа, уг нь бол сайн зүйл, чи түүнд садаа ч болохгүй. Гэхдээ чамайг чийгон дасгал хийж эхлэнгүүт тэр чам руу юм шидэлнэ, хэрэлдэж эхэлнэ. Зарим хосууд бясалгал хийснээс болж хэрэлдээд гэр бүл салах сарних дээрээ тулдаг. Олон хүн яагаад ийм нөхцөл байдал гардаг талаар бодож үздэггүй, өнгөрсөн хойно нь чи түүнээс асуухад: “намайг чийгон дасгал хийхэд яагаад тэгж их уурладаг юм бэ?” Тэр юу ч хэлж чадахгүй, үнэхээр хэлэх үг байдаггүй: “Тийм шүү, яагаад би тэгж их уурласан юм бол оо, тэр үед л тэгж их уурлачихлаа” гэнэ. Чухамдаа ямар учиртай вэ? Бясалгал хийхэд нүгэл хувирах ёстой байдаг, алдахгүй бол олохгүй, чиний алдсан нь муу зүйл, чи ямар нэгэн зүйл гаргах ёстой.

Магадгүй чамайг дөнгөж гэрийнхээ үүдээр орж ирэнгүүт хань чинь чам руу нүүр нүдгүй дайрч хэрүүл өднө, хэрэв чи үүнийг тэвчиж өнгөрөөвөл өнөөдрийн бясалгал чинь талаар болохгүй. Бясалгахад Дэ-г чухалчлах ёстой гэдгийг зарим хүн бас мэднэ, тиймээс тэр жирийн үед ханьтайгаа эвтэй байдаг. Тэр ингэж бодно, “Ер нь намайг юм хэлэхэд тэр эсэргүүцдэггүй байсан, харин өнөөдөр толгой дээр гарч байна.” Тэр уураа барьж чадахгүй хэрэлдэж эхэлнэ, ингэснээр өнөөдрийн бясалгал талаар болно. Яагаад гэвэл нүгэл тэнд байна, тэр чамд үүнийг арилгахад туслах гэхэд чи хүлээж аваагүй, харин түүнтэй хэрэлдсэн, тиймээс нүгэл арилахгүй. Иймэрхүү байдал их гардаг, манай олон сурагчдад тохиолдож байсан, гэвч яагаад ийм асуудал гарч байгааг бодож үздэггүй. Чамайг өөр зүйл хийж байхад тэр тоохгүй, чийгон-оор хичээллэх нь



сайн хэрэг гэхдээ тэр чамайг үргэлж тайван байлгахгүй. Үнэндээ тэр чамд нүглийг чинь арилгахад тусалж байгаа юм, гэхдээ тэр өөрөө үүнийг мэдэхгүй. Тэр зөвхөн гаднаа чамд уурлаад дотроо сайн хэвээр байгаа юм биш, тийм байдаггүй, тэр үнэн сэтгэлээсээ чамд уурлаж байгаа юм. Яагаад гэвэл нүгэл хэн дээр бууна түүнд таагүй болно, ийм байх нь гарцаагүй.

### **Шиньшин-ээ дээшлүүлэх нь**

Урьд өмнө олон хүн шиньшин-ээ зөв барьж чаддаггүй байснаас болж маш их асуудал гарсан, тодорхой нэг түвшинд хүрсний дараа дээш ахиж чадахгүй болдог. Зарим хүний шиньшин угаасаа сайн, бясалгалын явцад гэнэт тэнгэрийн мэлмий нь нээгдэж ямар нэг түвшинд хүрдэг. Яагаад гэвэл энэ хүний төрөлхийн суурь нь нэлээд сайн, шиньшин нь их өндөр, тиймээс түүний гон бас хурдан дээшилдэг. Түүний шиньшин-ий байгаа байранд хүрэхэд гон нь бас тэр өндөрт өсдөг, тэр өөрийнхөө гон-ыг цааш үргэлжлүүлэн өсгөхийг хүсвэл зөрчил бас улам хурцадна, шиньшин-ээ улам дээшлүүлэх шаардлагатай болдог. Ялангуяа төрөлхийн суурь сайтай хүн өөрийнхөө гон-ыг сайн өсөж байгааг, мөн бясалгал нь нэлээд сайн явж байгааг мэдэрдэг, тэгтэл яагаад гэнэт ийм их асуудал гараад ирэх? Бүх юм нь бүтэхээ болино, хүмүүс түүнд зохисгүй авирлана, дарга нь бас түүнийг үнэлэхээ болино, гэр бүлийн байдал нь гэнэт хурцадсан. Яагаад гэнэт ийм их асуудал гарч ирэх болов? Тэр өөрөө үүний учрыг ухамсарлахгүй байж болно. Яагаад гэвэл түүний төрөлхийн суурь сайн учраас тухайн нэг түвшинд хүрсэн, тэгээд ийм байдал гарах болсон юм. Гэхдээ энэ нь яаж бясаллагч хүний гэгээрэлд хүрэх эцсийн шалгуур болж чадах юм?

Энэ нь бясалгалын эцэст хүрэх хаа ч байсан юм! Чи үргэлжлүүлэн өөрийгөө дээшлүүлэх ёстой. Чи муугүй төрөлхийн суурьтайн хүчинд ийм байдалд хүрсэн, цаашид улам дээшилье гэвэл, тавигдах шалгуур ч бас өндөрсөх ёстой болдог.

Зарим хүн ингэж хэлдэг: “Би ахиухан шиг мөнгөтэй болоод гэрийнхнийгээ сайн төвхнүүлчхээд дараа нь санаа зовох юмгүй бясалгая.” Үүнийг би чиний хийсвэр мөрөөдөл гэнэ, чи өөр хүний амьдралд хөндлөнгөөс оролцох боломжгүй. Өөрийнхөө эхнэр хүүхэд, эцэг эх, ах дүү нарын болон бусад хүмүүсийн хувь тавиланг өөрчилж чадахгүй, чиний санаснаар болох юм уу? Түүнчлэн хэрэв чамд хойшдын ямар ч зовох зүйл, бэрхшээл байхгүй бол чи яаж бясалгах юм? Чи дасгалаа таатай, амар тайван хиймээр байна гэж үү? Тийм зүйл гэж хаана байх вэ дээ? Энэ бол чиний энгийн хүний байр сууринаас харж байгаа бодол.

Бясалгал бол саад бэрхшээлийн дунд явагдах ёстой, тэгснээр чамайг хүний янз бүрийн хүсэл, сэтгэлээ орхиж чадах эсэхийг чинь, даруу харж чадах үгүйг чинь сорино. Хэрэв чи эдгээр зүйлд зууралдаад байвал, бясалгаад амжилтад хүрч чадахгүй. Бүх зүйлд учир шалтгааны холбоо байдаг, хүн яагаад хүн байж чаддаг вэ? Яагаад гэвэл хүнд сэтгэл байдаг, хүн үүний тулд л амьдардаг. Төрөл садны сэтгэл, эр эм хоорондын сэтгэл, эцэг эхийн сэтгэл, сэтгэл хөдлөл, найрсаг сэтгэл, юм хийхэд найз нөхөрлөл харах гэх мэт бүх зүйлс энэ сэтгэлтэй холбоотой, юу хийх дуртай дургүй нь, баяр хөөр ба уйтгар гуниг, хайр ба хорсол, бүхэл хүн төрөлхтний нийгэмд болдог бүх зүйлс энэ сэтгэлээс үүддэг. Энэ сэтгэлийг орхихгүй бол чи бясалгаж чадахгүй. Хүн энэ сэтгэлээс чөлөөлөгдөж

чадвал хэн ч чамайг хөдөлгөж чадахгүй, энгийн хүний сэтгэл чамд нөлөөлж чадахгүй, эдгээр сэтгэл нь энэрэнгүй сэтгэлээр солигдоно, энэ нь эрхэм дээд зүйл юм. Мэдээжийн хэрэг, энэ бүгдийг тэр дор нь тасална гэвэл тийм амар биш, бясалгал бол удаан явцтай, аажмаар өөрийн зууралдсан сэтгэлийг орхих явц юм, гэхдээ чи өөртөө хатуу шаардлагатай байх ёстой.

Бясалгагчдын хувьд зөрчил гэнэт гарна. Яах ёстой вэ? Чи ердийн үед үргэлж энэрэнгүй, сэтгэлийн амгалан байдлыг сахидаг бол асуудал тулгарах үед сайнаар давж чадна, яагаад гэвэл энэ нь чамд асуудлыг зөөлрүүлэх боломж олгоно. Чи бусдад үргэлж энэрэнгүй сайхан сэтгэлээр хандаж, ямарваа нэгэн юм хийхдээ үргэлж бусдыг эхлээд боддог, ямар нэгэн асуудал гарахад энэ хэргийг бусад хүн хүлээн авч чадах эсэхийг, бусдад муугаар нөлөөлөхгүй байх эсэхийг эхлээд бодож үздэг байх хэрэгтэй, тийм байвал ямар ч асуудал гарахгүй. Иймээс чи бясалгахдаа дээд шалгуурын дагуу, бүр дээд шалгуурын дагуу өөрийгөө шаард.

Зарим хүн ер ухамсарладаггүй. Тэр хүний Тэнгэрийн мэлхий нээгдэхэд Будда-г хардаг, гэртээ хариад Будда-д залбиран, сэтгэлдээ: “Яагаад намайг харж хандахгүй байгаа юм бэ? Надад энэ бэрхшээлтэй асуудлыг шийдэж өгч туслаач!” Будда мэдээж шийдэж өгөхгүй, энэ бэрхшээлтэй асуудлыг тэр бэлдсэн, зорилго нь бол чиний шиньшин-ийг дээшлүүлэх, зөрчлийн дунд чамайг дээшлүүлэх явдал юм. Тэр чамд шийдэж өгөх юм уу? Чамд огт шийдэж өгөхгүй, шийдвэрлээд өгчихвөл чи яаж гон-оо өсгөх юм, яаж шиньшин болон түвшнээ дээшлүүлэх юм? Энэ нь чиний гон-оо өсгөх гол түлхүүр байдаг. Лугаа гэгээрэгчдийн хувьд, хүн болж амьдрах нь зорилго биш, хүний амь бол хүн

байхын тулд биш, харин үүссэн эх үндсэндээ буцахын тулд гэж үздэг. Хүн хэчнээн их зовлон зүдүүр туулах нь хамаагүй, их зовлон туулах тусмаа сайн, өрөө хурдан төлнө гэж үздэг, тэд ингэж л боддог. Зарим хүн үүнийг ухамсарлахгүй, тэгээд залбирал нь бүтэхгүй болохоор Будда-д гомдоллоно: “Яагаад надад туслахгүй байгаа юм бэ? Би өдөр болгон хүж бариад өлмийд тань мөргөдөг.” Үүнээс болж зарим хүн Буддын хөргийг авч чулуудсан, түүнээс хойш Будда-г буруутгаж загнадаг болсон. Ингэж буруутгаж загнаснаас болоод түүний шиньшин унасан, бас гон нь ч байхгүй болсон. Тэр бүх зүйл байхгүй болсныг мэдээд Будда түүнийг хохироосон гэж үзэн Будда-г улам занана. Тэр энгийн хүний зарчмаар Буддын шиньшин-ийг цэгнэсэн, яаж ингэж харьцуулж болох юм? Тэр дээд түвшний зүйлийг энгийн хүний шалгуураар цэгнэсэн, яаж ингэж болох вэ дээ? Хүмүүс өөрсдийн амьдрал дахь зовлон зүдүүрийг шударга бус байна гэж үздэг, иймээс иймэрхүү асуудал байнга гардаг, маш олон хүн ингэж доош унасан.

Сүүлийн жилүүдэд олон том чийгон багш нар, тэр дундаа их нэр цуутай байсан багш нар хүртэл доош унасан. Мэдээж жинхэнэ чийгон багш нар өөрсдийнхөө түүхийн үүргийг гүйцэтгээд буцсан. Зөвхөн зарим нь ард хоцорч энгийн хүмүүсийн дунд төөрөлдөж шиньшин нь унасан, тэд хүмүүсийн дунд одоог хүртэл идэвхтэй хэвээр байдаг боловч тэдэнд аль хэдийн гон байхгүй болсон. Урьд нь нэрд гарч байсан цөөн хэдэн чийгон багш одоо ч нийгэмд идэвхтэй хэвээр байгаа, багш нь түүнийг энгийн хүмүүсийн дунд унаж, алдар нэр, хувийн ашиг сонирхолд автаж түүнээс салах найдваргүй болсныг, аль хэдийн болохгүй болсныг нь хараад дэд сүнснийг нь дагуулаад явсан, бүх

гон нь дэд сүнсний бие дээр байдаг. Иймэрхүү жишээ нэлээд олон бий.

Манай бясалгалд ийм тохиолдлууд харьцангуй цөөн байдаг, байсан ч мэдэгдэхүйц биш. Шиньшин-ээ дээшлүүлэх тал дээр маш олон онцолмоор жишээнүүд байдаг. Шаньдун мужийн нэг хотод нэхмэлийн үйлдвэрт ажилладаг нэг сурагч Фалунь Дафа-гаар хичээллэж эхэлсний дараа ажлынхандаа бас бясалгал зааж өгсөн, үүний үр дүнд үйлдвэрийн байдалд шинэ хандлага гарсан. Тэр өмнө нь нэхмэлийн үйлдвэрийн үлдэгдэл алчуураас гэр лүүгээ авч явдаг байсан, бусад ажилчид ч мөн адил авдаг байсан. Тэр Фалунь Дафа-гаар хичээллэж эхэлснээс хойш гэр лүүгээ юм зөөхөө больсон төдийгүй урьд нь гэртээ аваачсан зүйлсээ буцааж үйлдвэртээ авчирсан. Бусад нь түүний энэ байдлыг хараад хэн нь ч гэр лүүгээ юм зөөхөө больсон, зарим ажилчид өөрсдийнхөө урьд нь авсан зүйлүүдийг үйлдвэртээ бас буцааж авчирч өгсөн, үйлдвэр даяар ийм байдал гарсан.

Нэг хотын Дафа-гийн дадлагажуулах төвийн зааварлагч нэгэн үйлдвэрийн Фалунь Дафа-гийн сурагчдын бясалгалын явцтай танилцахаар очсон, үйлдвэрийн дарга нь биечлэн түүнийг хүлээн авч уулзаад: “Манай ажилчид танай Фалунь Дафа-гаар хичээллэж эхэлснээс хойш ажилдаа эрт ирж орой буудаг болсон, тэд их идэвх зүтгэлтэй ажиллаж, өгсөн ямар ч үүрэг даалгаврыг ялгалгүй биелүүлдэг, бас хувийн ашиг сонирхлын төлөө тэмцэлдэхээ больсон. Тэд ингэж ажиллах болсноор үйлдвэрийн нүүр царайг бүхэлд нь өөрчилсөн, мөн үйлдвэрийн эдийн засгийн үр ашиг сайжирсан. Та нарын энэ бясалгал ямар хүчирхэг юм бэ, танай багш хэзээ ирэх вэ? Би

бас лекцэд нь суумаар байна” гэж хэлсэн. Манай Фалунь Дафа бясалгалын гол зорилго бол хүмүүсийг дээд түвшин рүү дагуулах юм, ийм зүйл хийх зорилго тавиагүй ч гэсэн нийгэм дэх соён гэгээрэлд маш том нөлөө үзүүлдэг. Хэрэв хүн болгон дутагдлаа өөрөөсөө хайж, хүн болгон биеэ хэрхэн зөв авч явахад анхаарваас нийгмийн байдал тогтворжиж хүн төрөлхтний ёс суртахууны хэм хэмжээ буцаад дээшилнэ гэж би хэлнэ.

Би Тайноань хотод Фа болон дасгал зааж байх үед нэг тавь гаруй насны сурагч нөхөртэйгөө лекцэд суусан. Нэг удаа тэднийг замаар гарч байхад хажуугаар нь их хурдтай зөрсөн машин толиороо эмэгтэйн хувцаснаас гогодсон. Тэр машинд арав гаруй метр хол чирүүлээд газарт падхийн унасан, машин хориод метр явж байж зогссон. Жолооч нь машинаасаа үсрэн бууж ирээд ууртайгаар хэлсэн: “Хөөе, чи замаа харж явахад яадаг юм.” Одоо үед хүмүүс ингэж авирладаг болсон, асуудал гарахад өөрийнх нь буруу мөн ч бай, биш ч бай хамгийн түрүүнд хариуцлагаас зайлсхийхээ боддог. Машин дотор явсан хүн, “гэмтэж үү үгүй юу хараадах, эмнэлэгт хүргэж өгье” гэсэн. Жолооч дөнгөж ухаарч сандран асуусан: “Яаж байна, эгч ээ? Та гэмтсэн үү? Эмнэлэгт очиж үзүүлье.” Тэр сурагч газраас аажуухан босож ирээд: “Зүгээрээ, та нар яв даа.” Шороогоо гөвчхөөд, нөхрөө сугадаад яваад өгсөн.

Тэр лекцэд орж ирээд надад энэ болсон явдлаа ярихад би ч баярласан. Манай сурагчдын шиньшин үнэхээр дээшилсэн байсан. Тэр надад: “Багшнаа, би одоо Фалунь Дафа-гаар хичээллэж байна, хэрэв би Фалунь Дафа-гаар бясалгадаггүй байсан бол өнөөдрийн осолд ингэж хандахгүй байсан” гэж хэлсэн. Та бүгд боддоо, тэтгэвэрт гарсан хүний хувьд одоогийн юмны үнэ

ийм өндөр, ямар ч нийгмийн хангамжийн тэтгэмж байхгүй, тавь гаруй насны хүн машинд ийм хол чирүүлээд газарт унасан. Гэмтэж болох байсан уу? Хаа сайгүй гэмтэнэ, тэр газар хэвтээд босож ирэхгүй байх байсан. Эмнэлэгт очих уу? Тэгье. Эмнэлэгт хэвтээд гарч ирэхгүй байж мэдэх байсан. Энгийн хүн бол магадгүй тэгнэ. Гэхдээ тэр бол бясалгадаг хүн учраас тэгээгүй. Бид, сайн муу үр дагавар гарах нь хүний анхны бодлоос шалтгаалдаг гэж ярьсан. Тухайн үед гарсан бодол нь өөр өөр үр дагавар дагуулдаг. Тийм настай хүн, энгийн хүн байсан бол яаж гэмтэхгүй байх юм? Гэхдээ түүний арьс нь ч шалбараагүй. Сайн, муу үр дагавар гарах нь тухайн агшинд гарсан бодлоос шалтгаалдаг. Хэрэв тэр тэнд хэвтээд: “Ёо ёо, би болохоо байлаа, энд ч гэмтсэн байна, тэнд ч өвдөөд байна” гэсэн бол магадгүй түүний шөрмөс нь тасарч, яс нь хугарч мөн саа ч тусч болох байсан. Түүнд хэр их мөнгө төлсөн ч насаараа эмнэлэгт хэвтээд босож ирж чадахгүй бол, тэр ая тухтай байж чадах уу? Хөндлөнгөөс харсан хүмүүст хүртэл хачирхалтай санагдсан, тэр настай эмэгтэй жолоочийг сүрдүүлэн мөнгө нэхээгүйд гайхсан. Одоогийн хүмүүсийн ёс суртахууны хэм хэмжээ гажсан. Жолооч хурдтай явж байсан ч санаатайгаар хүн шүргэе гэж бодох уу? Тэр санамсаргүйгээр л хийсэн биз дээ? Харин одоогийн хүмүүс ийм л болсон, түүнээс мөнгө салгаж аваагүйд сонирхон харж байсан хүмүүсийн сэтгэл нь таагүй байсан. Би одоогийн хүмүүс сайн мууг ялгаж чадахаа больсон гэж хэлсэн, нэг нь нөгөөдөө чи муу юм хийж байна гэж хэлбэл тэр итгэхгүй. Яагаад гэвэл хүний ёс суртахууны хэм хэмжээ өөрчлөгдсөн, зарим хүн хувийн ашиг сонирхлын хойноос л хөөцөлддөг, мөнгө олж л байвал юу ч хийхээс буцахгүй. “Хүн өөрийнхөө төлөө

байхгүй бол, тэнгэр газар ч өршөөхгүй” гэсэн үгийг хэзээнээс уриагаа болгосон!

Бээжингийн нэг сурагч оройн хоолныхоо дараа хүүхдээ дагуулаад Чинанмэнь талбай руу салхинд алхахаар гарсан. Тэнд нэгэн худалдааны машинаас хонжворт сугалаа зарлаж байхыг харсан. Хүүхэд нь сонниучлан сугалаа авъя гэж гуйсан. Тэр хүүхдэдээ нэг юань өгөөд сугалаа сугалуулсан, тэгтэл хоёрдугаар зэргийн хонжвор нь таарч хүүхдийн тансаг унадаг дугуй хожсон, хүүхэд нь бөөн баяр хөөр болсон. Лавынх нь толгойд гэнэт нэгэн бодол зурсхийн орж ирсэн, “Би бясалгагч хүн, яаж ийм зүйлийг авч болох юм? Буруу аргаар олсон зүйлийнхээ хариуд хэр их Дэгээ өгөх бол?” Хүүхдэдээ тэр хэлсэн: “Үүнийг авахаа больё. Чи авмаар байвал бид өөрсдөө худалдаж авъя.” Хүүхэд нь ундууцан, “Би танаар авхуулья гэхэд та авч өгөөгүй, одоо би өөрөө сугалаагаар хожиж байхад та намайг авхуулахгүй юм” гээд уйлж бархираад л, тэр аргаа бараад дугуйг гэр лүүгээ авч явсан. Гэртээ харьсныхаа дараа бодох тусам түүнд улам хэцүү санагдсан, буцаж очоод мөнгийг нь тэр хүмүүст өгье гэж бодсон. Эргээд бодоход, “хонжворын сугалаа ч дууссан, би мөнгө аваачиж өгсөн ч гэсэн тэд өөрсдөө хуваагаад авчих юм биш үү? Би энэ мөнгийг ажлын газартаа хандивласан нь дээр” гэж бодсон.

Аз болоход түүний ажлын газарт Фалунь Дафайгийн сурагчид цөөнгүй байсан, дарга нь бас түүнийг ойлгоно. Хэрэв нэг энгийн орчинд юм уу, нэг жирийн ажлын газарт чи өөрийгөө бясалгадаг хүн гэж хэлээд сугалаагаар хожсон дугуйгаа зүгээр авахгүй, мөнгийг нь ажлын газартаа хандивлая гэвэл дарга чинь хүртэл чамайг сэтгэцийн өвчтэй юм уу гэж бодно. Бусад



хүмүүс ч гэсэн шүүмжлэн ярилцана: “Энэ хүн чийгон-оор хичээллээд жаахан юмтай болчихсон юм байх даа, бясалгаад солирсон юм болов уу?” Би ёс суртахууны хэм хэмжээ гажсан гэж хэлсэн. Тавь, жараад оны үед ийм явдал бол ердийн л зүйл байсан, хэн ч үүнд гайхахгүй.

Бид ингэж ярьдаг, хүн төрөлхтний ёс суртахуунд хэр их өөрчлөлт гарсан ч орчлон ертөнцийн энэ мөн чанар болох Жэнь, Шань, Рэнь үүрд өөрчлөгдөхгүй. Зарим хүн чамайг сайн гэж хэлнэ, чи үнэндээ сайн биш байж болно; зарим хүн чамайг муу гэж хэлнэ, чи үнэндээ муу биш байж болно, яагаад гэвэл сайн мууг цэгнэх шалгуур нь гажсан. Зөвхөн орчлон ертөнцийн энэ мөн чанартай нийцсэн бол, тэр бол сайн хүн, энэ бол сайн муу хүнийг цэгнэх орчлон ертөнцөд хүлээн зөвшөөрөгдсөн цорын ганц шалгуур. Чи хүн төрөлхтний нийгэмд хэр том өөрчлөлт гарсныг нь битгий хар, хүн төрөлхтний ёс суртахууны хэм хэмжээ үлэмж ихээр унасан, хүний ёс суртахуун өдрөөс өдөрт доройтож байна, хувийн ашиг хонжоо хөөцөлдөх нь ганц тэмүүлдэг зүйл нь болсон, гэхдээ орчлон ертөнцийн өөрчлөлт нь хүн төрөлхтний өөрчлөлтийг дагаж өөрчлөгдөхгүй. Бясалгагч хүний хувьд энгийн хүний шалгуураар өөрийгөө шаардаж болохгүй. Энгийн хүн энэ зүйлийг зөв гэхэд чи дагаж хийвэл болохгүй. Энгийн хүний сайн гэж хэлсэн зүйл нь магадгүй сайн биш; энгийн хүний муу гэж хэлсэн нь магадгүй муу биш байж болно. Ёс суртахууны шалгуур гажсан энэ эрин үед нэг хүн муу зүйл хийхэд чи түүнд муу зүйл хийж байна гэж хэлбэл тэр үнэмшихгүй! Бясалгагч хүний хувьд орчлон ертөнцийн мөн чанарын дагуу өөрийгөө цэгнэх ёстой, тэгвэл юу нь жинхэнэ сайн, юу нь жинхэнэ муу гэдгийг ялгаж чадна.

## Гуаньдин (Энергиэр адислах)

Бясалгагчдын хүрээнд ийм нэг үзэгдэл байдаг, үүнийг гуаньдин гэдэг. Гуаньдин бол Буддын Тантрын (тарнийн) шашны бясалгалын зан үйл юм. Зорилго нь гуаньдин хийлгэснээс хойш энэ хүн өөр номын бясалгалд орж болохгүй, энэ номын бясалгалын жинхэнэ шавь гэж хүлээн зөвшөөрөгдөнө. Одоо үүний юу нь хачирхалтай байна вэ? Шашны иймэрхүү зан үйл чийгон бясалгалд бас гарч ирсэн, үүнийг зөвхөн Тантрын шашинд хэрэглээд зогсохгүй бас Бумбын бясалгалд хийдэг болсон. Би хэлсэн, аливаа Тантрын шашны нэрээр нийгэмд зааж байгаа бясалгалууд нь бүгд хуурамч. Яагаад ингэж хэлж байна вэ? Яагаад гэвэл манай оронд Тан Тантрын шашин мянга гаруй жилийн өмнө байхгүй болсон, энэ нь бүрмөсөн оршихоо больсон; хэлний бэрхшээлээс болоод Түвдийн Тантрын шашин Хан газар нутагт бүрэн орж ирээгүй. Ялангуяа энэ бол нууцлаг шашин учраас заавал сүм хийдэд нууцаар бясалгах ёстой байдаг, мөн багш нь заавал нууцаар заах шаардлагатай, шавиа лагуулж нууцаар бясалгуулна. Ингэж хийхгүй бол хэрхэвч дэлгэрүүлж болохгүй.

Олон хүн ийм нэг зорилгоор чийгон сурахаар Түвдэд очдог, тэд ирээдүйд чийгон багш болж нэрд гарах, баян болохын тулд багш олж Түвдийн тарнийн аргын шашинд суралцахыг хүсдэг. Та бүгд боддоо, жинхэнэ уламжилж авсан гэгээнтэн лам их хүчтэй ер бусын чадвартай байдаг, чийгон сурахаар ирсэн хүний бодлыг хараад л мэднэ. Тэр юуны тулд энд ирсэн бэ? Лам түүний бодлыг нэг уншаад л дор нь мэднэ: “Чи энд ирж, бясалгал сурч гараад чийгон багш болоод баяжих, алдар нэрд гарах гэсэн хүсэлтэй юм байна, энэ номын үүдний Будда-д бясалгах аргыг чамаар эвдүүлнэ

гэж үү.” Будда-д бясалгах ийм нарийн бясалгалыг, чамайг чийгон багш болгож, нэр ашиг хөөцөлдүүлж хамаагүй эвдэхийг зөвшөөрнө гэж үү? Чи ямар санаатай байна вэ? Иймээс үндсэндээ түүнд заахгүй, жинхэнэ уламжлахгүй. Мэдээж сүм хийдүүд олон байгаа, магадгүй зарим нэг өнгөцхөн зүйлийг сурна. Хэрэв сэтгэл нь зөв биш байвал чийгон багш болоод муу юм хийхэд биедээ сүнсийг даллаж ирүүлнэ. Шүглэсэн амьтад бас энергитэй байдаг, гэхдээ Түвдийн Тантрын шашных биш. Чин сэтгэлээсээ Дарма-гийн мөр хөөж Түвдэд очсон хүн магадгүй тэндээ суурьшин үлдэнэ, тэр бол жинхэнэ бясалгадаг хүн.

Одоо Бумбын олон бясалгалд бас гуаньдин-ийг үйлддэг болсон нь хачирхалтай. Бумбын бясалгалд энерги судлаар явдаг, гуаньдин хийх ямар хэрэг байна? Миний мэдэж байгаагаар, намайг өмнөд хэсэгт бясалгал зааж байхад, ялангуяа Гуаньдон мужид нэлээд олон, арав гаруй төрлийн замбараагүй бясалгалд гуаньдин хийж байсан. Зорилго нь юу вэ? Тэр чамд гуаньдин хийсэн бол чи түүний шавь нь болно, өөр бясалгал сурч болохгүй, хэрэв тэгвэл тэр чамайг шийтгэнэ, тэр ийм л зүйл хийдэг. Энэ нь гаж буруу зүйл хийж байгаа биш гэж үү? Түүний зааж байгаа нь өвчин эдгээх, бие сайжруулах талын л зүйлс, хүмүүс эрүүд биетэй байхыг хүсдэг учраас л үүнийг сурдаг. Ингэж хийх нь ямар хэрэгтэй юм бэ? Зарим хүн, хэрэв түүний чийгон-оор хичээллэх юм бол бусад бясалгалаар хичээллэж болохгүй гэдэг. Тэр хүнийг төгс аварч чадах юм уу? Хүмүүсийн ахиц дэвшилд саад учруулж байгаа юм биш үү? Маш олон хүн ингэж хийдэг.

Бумбын системд ийм зүйл заадаггүй, гэхдээ одоо бас гуаньдин хийх явдал гарсан. Их сүр дуулиантайгаар

гуаньдин хийж байсан нэгэн чийгон багшийн гон багана хэр өндөр байсан гээч? Ердөө хоёр, гурван давхар байшингийн өндөртэй чацуу байсан, нэлээд нэртэй том чийгон багш, түүний гон нь унаад хөөрхийлөлтэй болсныг нь би харсан. Зуу зуун хүмүүс гуаньдин хийлгэхээр дараалан зогссон, тэр хүмүүст гуаньдин хийж байсан. Түүний гон тийм л хэмжээний өндөр, тун удахгүй гон нь унаад юу ч үгүй болно, тэгвэл юугаараа хүнд гуаньдин хийж өгөх юм? Хүмүүсийг тэр хуурч байгаа юм биш үү? Өөр орон зайд харахад жинхэнэ гуаньдин-ийг хийхэд хүний ясыг толгойноос нь хөл хүртэл цагаан хаш шиг болгодог. Энэ бол гон-оор буюу дээд энергийн бие бодior хүний бие толгойноосоо хөл хүртлээ ариусгагдаж байгаа юм. Энэ чийгон багш үүнийг хийж чадах уу? Тэр хийж чадахгүй. Тэр юу хийж байгаа вэ? Мэдээж тэр шашны зан үйл хийж байгаа юм биш, зорилго нь түүний бясалгалд суусан хүнийг өөрийн болгоход юм, чи ангид нь сууж түүний зүйлийг сурах ёстой болдог. Зорилго нь чиний мөнгийг авахад юм, хэн ч түүний бясалгалыг сурахгүй бол тэр мөнгө олж чадахгүй.

Фалунь Дафа-гийн шавь нарт бусад Буддын бясалгалын шавь нартай адил, их Багш нар олон удаа гуаньдин хийж өгдөг, гэхдээ чамд мэдүүлэхгүй. Ер бусын чадвартай хүн магадгүй мэдэрнэ, эсвэл мэдрэмтгий хүн бас мэдэрч болно, унтаж байхад юм уу эсвэл ямар нэгэн үед гэнэт халуун урсгал толгойн оройноос эхлэн доош бүх биеэр нэвтэрдэг. Гуаньдин хийх зорилго нь чамд өндөр гон өгөхөд биш юм, гон бол чиний өөрийн бясалгалаар гардаг. Гуаньдин бол нэг янзын адислах арга, энэ нь чиний биеийг ариусгана, мөн биеийг чинь цаашид улам бүр цэвэршүүлнэ. Олон удаа гуаньдин хийгдэх болно, чиний биеийг түвшин

болгонд цэвэршүүлж өгнө. Яагаад гэвэл бясалгал өөрөөс шалтгаална, гон багшаас шалтгаална, иймээс бид гуаньдин хийх зан үйл хийдэггүй.

Зарим хүн бас багшид шавь орох зан үйл хийдэг. Үүнээс үүдээд би нэг зүйлийг хэлмээр байна, олон хүн намайг багшаа болгохыг хүсдэг. Манай өнөөгийн түүхэн үе бол Хятадын феодалын нийгмээс ялгаатай, өвдөг сөгдөн мөргөснөөр багшаа болгох гэж үү? Бид ийм зан үйл хийдэггүй. Олон хүн ингэж боддог: “Би хүж бариад Будда-д мөргөж чин сэтгэлээсээ сүсэглэвэл миний гон өснө.” Би үүнийг үнэхээр инээдтэй гэж хэлнэ. Жинхэнэ бясалгал бол өөрөө яаж бясалгахаас бүхэлдээ шалтгаална, юунд ч мөргөөд нэмэр байхгүй. Чи Будда-д мөргөж, хүж барих албагүй, жинхэнэ бясалгагч хүний шаардлагын дагуу бясалгавал Будда чамайг хараад баяртай байх болно. Чи гадуур элдэв янзын муу зүйл хийгээд байвал, чи түүнд хүж бариад мөргөсөн ч тэр чамайг хараад эгдүүцнэ, энэ үнэн биш гэж үү? Жинхэнэ бясалгал бол хүнээс өөрөөс нь шалтгаалдаг. Чи өнөөдөр багшид мөргөж шавь орох зан үйл хийсэн ч үүдээр гараад л өөрийнхөө юу хүссэн болгоноо хийх юм бол энэ нь ямар хэрэгтэй юм? Бид ийм зан үйлийн талаар огт ярьдаггүй. Чи миний нэр төрийг ч гугааж мэднэ!

Бид та нарт ийм их зүйлийг өгч байгаа, хүн бүр жинхэнэ бясалгавал, мөн өөрийгөө Дафа-гийн дагуу хатуу шаардаж байвал би чамайг шавиа гэж үзэн дагуулна, чи зөвхөн Фалунь Дафа-гаар бясалгана гэвэл бид чамд шавиа гэж хандана. Чи бясалгахгүй бол бидэнд ямар ч арга байхгүй. Чи бясалгахгүй бол миний цуврал лекцэд суусан анхны ээлжийн сурагч, эсвэл цуврал лекцэд суусан хоёр дахь ээлжийн сурагч

гэх мэтийн нэр зүүх ямар хэрэг байгаа юм? Энэ хэдэн дасгалыг хийгээд л чи бидний шавь болчих юм уу? Чи бидний шиньшин-ий шалгуурын дагуу жинхэнэ бясалгах ёстой, ингэснээр чи эрүүл биетэй болохоос гадна, үнэхээр дээд түвшинд хүрч чадна. Тиймээс бид эдгээр зан үйлд ач холбогдол өгдөггүй, чи бясалгаж л байвал манай номын бясалгалын хүн. Миний Фашэнь бүхнийг мэднэ, тэр чиний бодолд байгаа бүхнийг мэднэ, тэр бүхнийг хийж чадна. Чи бясалгахгүй бол тэр чамайг харж хандахгүй, бясалгана гэвэл тэр чамд эцэст нь хүртэл тусална.

Зарим чийгон бясалгалын сурагчид, багшийнхаа барааг хараагүй байсан ч тодорхой зүг рүү харж мөргөөд хэдэн зуун юань төлөөд л болоо гэж ярьдаг. Энэ нь өөрийгөө болоод бусдыг хуурч байгаа хэрэг биш үү? Тэд үүндээ сэтгэл ханамжтай, нэлээд дуртай байдаг, үүнээс хойш тэр бясалгал болон багшийгаа их идэвхтэй өмгөөлж хамгаалдаг болно, тэд бас хүмүүст өөр бясалгалыг битгий сур гэж хэлнэ. Надад энэ бол тун инээдтэй санагддаг. Зарим хүн бас адис өгдөг, хүний толгойд хүрэх нь ямар нөлөө байх вэ дээ.

Тантрын шашны нэрээр бясалгал заан тарааж байгаа хүмүүс хуурамч төдийгүй, мөн Буддизмын нэрээр зааж байгаа бүх чийгон бясалгалууд бас хуурамч. Та бүгд боддоо, хэдэн мянган жилийн туршид Буддын шашин дахь бясалгалын арга нь тодорхой хэдэн хэлбэртэй байсан. Хэрэв хэн нэгэн үүнийг өөрчилбөл, яаж Буддын шашин хэвээр байх юм? Будда-д бясалгадаг бясалгалын арга бол маш нарийн, гүн бөгөөд гайхамшигтай байдаг, жаахан өөрчлөхөд л замбараагүй болно. Яагаад гэвэл гон-ы хувирах явц нь маш нарийн байдаг, хүний мэдрэхүй бол юу ч

биш, мэдрэхүйд тулгуурлан бясалгаж болохгүй. Лам хувраг нарт байх шашны хэлбэр нь бясалгалын арга юм, жаахан өөрчлөхөд л тэр номын үүдний зүйл биш болно. Номын үүд бүрийг хариуцсан аугаа гэгээрэгч байдаг, мөн түүгээр олон аугаа гэгээрэгчид бясалгаж гардаг, хэн ч тэр Номын үүдний бясалгалын аргыг дураараа өөрчилж зүрхэлдэггүй. Нэг өчүүхэн чийгон багшийн хувьд ямар агуу буянтай гэж багшийгаа мэхэлж, Буддын бясалгалын аргыг өөрчилж зүрхэлнэ вэ? Хэрэв үнэхээр өөрчилж болдог бол, урьдын тэр номын бясалгал хэвээр байх уу? Хуурамч чийгон-ыг ялгаж болно.

### **Шуаньгуань бүрэлдэн тогтох нь**

“Нууцлаг гарц бүрэлдэн тогтох нь” (шуаньгуань шөвэй)-г бас “Нууцлаг нэгэн сүв” (шуаньгуань и чиао) гэж нэрлэдэг. Эдгээр хэллэгийг “Үрлийн ном” (Даньжин), “Бумбын жаяг” (Даозань), болон “Зан авир, амийг удирдах” (Шиньмин Гүйжи) гэсэн номуудаас олж үзэж болно. Тэгвэл энэ нь ямар учиртай вэ? Олон чийгон багш үүнийг тодорхой тайлбарлаж чаддаггүй. Яагаад гэвэл ердийн чийгон багшийн түвшинд үндсэндээ харах боломжгүй, бас түүнд харахыг ч зөвшөөрөхгүй. Бясалгагч хүн үүнийг харахыг хүсвэл билгийн мэлмийн дээд түвшинд болон түүнээс дээш түвшинд хүрсэн байх ёстой, жирийн чийгон багш энэ түвшинд хүрч чадахгүй, тиймээс харж чадахгүй. Түүхийн туршид, бясалгалын хүрээнд шуаньгуань гэж юу вэ? Тэр нэгэн сүв хаана байдаг вэ? Мөн шуаньгуань хэрхэн бүрэлдэн тогтодог талаар судалсаар ирсэн. “Үрлийн ном”, “Бумбын жаяг”, “Зан авир, амийг удирдах” номуудад үүний талаар бүгд онолын хүрээнд авч үзсэн байдаг, харин гол учир утгынх нь талаар огт

хөндөөгүй орхисон. Янз бүрээр тайлбарлаж толгойг чинь эргүүлдэг, тодорхой тайлбарладаггүй, яагаад гэвэл жинхэнэ зүйлийг энгийн хүнд мэдүүлдэггүй.

Түүнээс гадна, та бүгд Фалунь Дафа-гийн шавь учраас би нэг зүйл хэлмээр байна, би та нарт ингэж хэлье: Тэдгээр замбараагүй чийгон номуудыг хэзээ ч битгий унш, дээр дурдсан эртний номуудыг ярьж байгаа юм биш, харин одоогийн хүмүүсийн бичсэн хуурамч чийгон номуудыг хэлж байна, чи сөхөж үзсэний ч хэрэггүй. Чиний бодолд: “За, энэ үг нь зүйтэй юм байна”, гэсэн бодол гарангуут л номд шүглэсэн сүнс чиний биед асна. Маш олон ном шүглэсэн сүнсний удирдлагын дор хүний нэр, ашгийн сэтгэлийг турхиран бичигдсэн байдаг. Хуурамч чийгон номууд зөндөө байдаг, маш олон, их олон хүн хариуцлагагүй ханддаг, зарим нь шүглэсэн сүнс болон замбараагүй зүйлсийн талаар бичдэг. Ер нь дээр дурдсан эртний хэдэн номуудыг болон бусад эртний бясалгалтай холбоотой номуудыг уншихгүй байсан нь дээр, энд нэг л бясалгалдаа туушгтай байх асуудал байдаг.

Хятадын чийгон нийгэмлэгийн нэгэн удирдагчийн надад хэлсэн нэг зүйл үнэхээр инээд хүргэсэн. Бээжинд чийгон-ы хичээлүүдэд байнга суудаг нэг хүн байсан гэсэн, тэр их олон лекцэд суусны дараа чийгон-ыг түүний сонссон зүйлс л гэж бодсон. Яагаад гэвэл бүгд нэг түвшнийх учраас ижил зүйлүүдийг л ярьдаг. Тэр бусад хуурамч чийгон багш нарын нэгэн адил, чийгон-ы утга агуулга нь эдгээр зүйл гэж бодсон! Тэгээд тэр чийгон-ы талаар мөн ном бичихээр шийдсэн. Та бүгд боддоо, бясалгадаггүй хүн чийгон-ы ном бичнэ гэнэ, одоогийн чийгон номууд бол нэг нэгнээсээ хуулж бичигдсэн байдаг. Тэр бичиж байгаад



шуаньгуань-ий асуудалд хүрээд гацсан. Шуаньгуань гэж юу болохыг хэн мэдэх юм? Жинхэнэ чийгон багш нараас ч мэддэг хүн цөөхөн. Тэрээр нэгэн хуурамч чийгон багшаас очиж асуусан. Тэр түүнийг хуурамч гэдгийг нь мэдээгүй, өөрөө ч чийгон-ыг ямар ойлгодог биш. Хэрэв тэр хуурамч чийгон багш асуултад нь хариулахгүй бол хүмүүс түүнийг хуурамч гэдгийг нь мэдчихнэ биз дээ? Иймээс тэр санаанаасаа зохиож, “шуаньгуань нэгэн сүв” бол эр хүний бэлэг эрхтний үзүүрт байдаг гэж хэлсэн. Үнэндээ сонсоход их инээдтэй. Инээгээд яах вэ, энэ ном нь хэвлэгдээд аль хэдийн нийтийн дунд гарчихсан. Өөрөөр хэлбэл одоогийн чийгон номууд ийм инээдтэй хэмжээнд хүрсэн, иймэрхүү номуудыг унших нь ямар хэрэгтэй юм. Ямар ч хэрэг байхгүй, зөвхөн л гай болно.

Шуаньгуань бүрэлдэн тогтох гэдэг нь юу гэсэн үг вэ? Хүн Гурамсан Ертөнцийн Фа бясалгалын дунд түвшнээс дээш гарахад, өөрөөр хэлбэл Гурамсан ертөнцийн дээд түвшинд бясалгахад хүний биед Юань-инь (мөнхийн нярай хүүхэд) бүрэлдэж эхэлнэ. Юань-инь болон бидний ярьдаг Инь-хай (бясалгасан нярай хүүхэд) бол хоёр өөр зүйл юм. Инь-хай бол бяцхан, мөн их хөдөлгөөнтэй, дүрсгүй. Юань-инь бол хөдөлдөггүй, Юань-шэнь (сүнс) нь түүнийг удирдахгүй бол тэр хөлөө завилаастай, гарын мутрын барилтай (жиэ-инь) бадамлянхуа цэцгэн дээр хөдөлгөөнгүй сууна. Юань-инь дань-тиань (үрлийн талбай)-д үүсдэг бөгөөд түүнийг зүүний үзүүрээс ч бага хэмжээтэй бичил түвшинд байхад нь харж болно.

Түүнээс гадна нэг асуудлыг тодруулах хэрэгтэй, жинхэнэ дань-тиань нэг л байдаг, тэр нь хэвлийн хөндийн доод хэсэгт байрлах тиань (талбай) юм. Энэ

нь хүний биеийн доторх хүйен сүвнээс дээхнэ буюу хэвлийн доохно байрладаг. Их олон төрлийн гон, ер бусын чадварууд, арга уданс, Фашэнь, Юань-инь, Инь-хай, мөн маш олон амь бодь бүгд энэ тиань-аас үүсдэг.

Урьд өмнө Бумбын зарим бясалгагч дээд дань-тиань, дунд дань-тиань, доод дань-тиань гэж ярьдаг байсан, би үүнийг буруу гэж хэлнэ. Зарим хүн тэдний багш нь ингэж заадаг, энэ нь олон үе дамжин уламжлагдаж ирсэн, номд бас ингэж бичсэн байдаг гэдэг. Би та бүгдэд хэлье, хаяхаар зүйлс эрт дээр үеэс ч байсаар ирсэн, зарим зүйлс олон жилээр уламжлагдан ирсэн ч гэсэн зөв байх албагүй. Дэлхийн жижиг бясалгалын арга замууд хүний нийгэмд үргэлж уламжлагдсаар ирсэн, гэхдээ тэдгээрээр бясалгаж чадахгүй, тэдгээр нь юу ч биш юм. Тэрээр дээд, дунд, доод дань-тиань гэж нэрлэсэн нь, тэднийхээр бол дань (үрэл) үүсдэг газрыг дань-тиань гэж үздэг. Энэ нь инээдтэй биш гэж үү? Хүний бодол биеийн аль нэг газарт удаанаар төвлөрөхөд энергийн бөөгнөрөл бий болох ба дань үүсдэг. Чи үнэмшихгүй байвал гаран дээрээ бодлоо дандаа төвлөрүүл, үргэлж ингэж удаан хугацаагаар төвлөрүүлэхэд дань үүснэ. Иймээс зарим хүн энэ байдлыг харчхаад дань-тиань бол хаа сайгүй байдаг гэж ярьдаг, энэ нь сонсоход бүр инээдтэй, тэд дань үүсдэг газар болгоныг дань-тиань гэж боддог. Үнэндээ тэр бол дань гэхдээ тиань (талбай) биш. Чи дань бол хаа сайгүй байдаг эсвэл дээд, дунд, мөн доод дань гэж яривал болно. Харин тоолшгүй олон Фа-г үүсгэдэг жинхэнэ тиань бол ганцхан байдаг, энэ нь хэвлийн доод хэсэгт байдаг. Иймээс дээд, дунд, доод дань-тиань гэж ярих нь буруу. Хүний бодол аль нэг хэсэгт удаан хугацаагаар төвлөрөхөд тэнд дань үүсдэг.

Юань-инь хэвлийн доод хэсэг дэх энэ дань-тиань-д үүсдэг, аажмаар өссөөр улам томорсоор байна. Ширээний теннисний бөмбөгний дайтай болоход бүх биеийн хэлбэр нь тодорно, хамар болон нүд бүгд бүрэлддэг. Ширээний теннисний бөмбөгний хэмжээтэй болоход түүний хажууд нэг жижиг бөмбөлөг зэрэгцэн үүсдэг. Үүссэний дараа Юань-инь-ий өсөлтийг дагаж бөмбөлөг бас томорно. Юань-инь 4 цун (13см орчим) өндөр болж өсөхөд бадамлянхуа цэцгийн нэг дэлбээ гарч ирнэ, 5-6 цун (16-19см орчим) өндөр болж өсөхөд бадамлянхуа цэцгийн эхний давхарга дэлбээлж дуусаад алт шиг гялалзсан Юань-инь хүүхэд алтлаг бадамлянхуа цэцгэн тавцан дээр суугаад маш үзэсгэлэнтэй харагдана. Энэ бол мөнх орших Очирваань бие, Буддын системд үүнийг “Буддын бие” гэж нэрлэдэг; Бумбын системд “Юань-инь” гэж нэрлэдэг.

Манай бясалгалд аль алиных нь биеийг хоёуланг бясалгана, өөрийн бие (бэньти)-ийг бас хувиргана. Та нар Буддын бие энгийн хүмүүсийн дунд илэрч гарч болохгүй гэдгийг мэднэ, маш их чармайхад энэ нь өөрийнхөө хэлбэр дүрс, туяаг энгийн хүний нүдэнд харагдуулж болно. Гэвч энэ махан бие хувирсны дараа энгийн хүмүүсийн дунд жирийн хүний бие шиг л харагдана, энгийн хүн хараад ялгахгүй гэхдээ энэ бие өөр өөр орон зайнуудын хооронд орж гарч чадна. Юань-инь 4-5 цун өндөр болж өсөхөд хоосон бөмбөлөг нь бас тийм өндөртэй болно, энэ нь үлээсэн шаар шиг тунгалаг. Юань-инь завилан хөдөлгөөнгүй сууж байдаг. Энэ үед хийн бөмбөлөг дань-тиань-аас гарна. Энэ нь өсөж боловсорсон болохоор дээшилж эхэлнэ. Дээшлэх явц нь их аажим, гэхдээ өдөр болгон хөдөлж байгааг нь ажиглаж болно. Тэр аажмаар дээш

явна, улам дээшээ өгсөнө. Хэрэв бид анхааралтай ажвал түүний оршин байгааг нь мэдэрч болно.

Бөмбөлөг дээш явсаар хүний таньжон сүвд хүрээд тэндээ нэг хэсэг хугацаанд байна. Яагаад гэвэл энд хүний биеийн охь болон маш олон зүйлс (зүрх бас энд) байдаг, энэ бүгд бөмбөлөг дотор нэгэн цогц зүйл бүрдүүлнэ. Тэдгээр охь зүйлүүд бөмбөлөг дотор орж баяжуулна. Нэг хэсэг хугацааны дараа тэр дахиад дээш ахина. Энэ нь хоолойгоор өнгөрөх үед судаснууд бөглөрч хүзүү хөөгөөд хоолой боогдсон мэт тааламжгүй мэдрэмж төрдөг, энэ байдал ганц хоёр өдөр болоод өнгөрнө. Тэр толгойн оройд гарна, бид үүнийг ниван-д хүрэх гэж нэрлэдэг. Бид үүнийг ниван-д хүрсэн гэж хэлж байгаа боловч үнэндээ тэр чиний бүхэл тархи шиг том байдаг, чиний толгой хөөсөн юм шиг санагдана. Ниван бол хүний амины маш чухал хэсэг учраас, бөмбөлөг дотор бас үүний охь зүйлс бүрдэх ёстой байдаг. Дараа нь бөмбөлөг тэнгэрийн мэлмийн сувгаар гадагшлах гэж чихнэ, энэ мэдрэмж бас маш их эвгүй. Тэнгэрийн мэлмий хөөж хөндүүрлэнэ, чамархай хөөж нүд хонхойсон мэт санагдана. Ийм мэдрэмж түүнийг шахагдан гаргал үргэлжилнэ, гадагш гараад духны урд унжина. Үүнийг шуаныгуань бүрэлдэн тогтох гэдэг, тэнд дүүжлэгдэн байна.

Тэнгэрийн мэлмий нь нээгдсэн хүн энэ үед харж чадахгүй болно. Яагаад гэвэл Буддын болон Бумбын системийн бясалгалд шуаныгуань доторх зүйлс бүрэлдэхийг хурдасгахын тулд үүд нь хаагддаг. Үүнд урд талын хоёр хаалга, бас арын хоёр хаалга байдаг, бүгд хаагдана. Бээжин дэх Тиананьмэн-ий хаалга шиг, тал болгонд хоёр том хаалгатай. Шуаныгуань-ийг

хурдан бүрэлдүүлж баяжуулахын тулд маш онцгой байдал гарахгүй л бол хаалганууд нь онгойхгүй, тэнгэрийн мэлмийгээр урьд нь хардаг хүн энэ үед харж чадахгүй болно, харуулахгүй. Бөмбөлөг тэнд дүүжлэгдэн байхын зорилго нь юу вэ? Бидний биен дэх зуу зуун энергийн сувгууд энд нийлдэг, энэ үед сувгууд шуаньгуань-ийг тойрч өнгөрөөд гарна, бүгд шуаньгуань-аар дамжиж гардаг, зорилго нь үүн дотор зарим суурь тавьж нэг цогц зүйлийг бүрэлдүүлнэ. Яагаад гэвэл хүний бие нь нэг жижиг орчлон ертөнц юм, түүн дотор жижиг хорвоо ертөнц үүснэ, хүний биений бүх охь зүйлс бүгд түүн дотор бий болно. Гэхдээ энэ нь бүрэн ашиглахад бэлэн болоогүй зөвхөн нэг цогц төхөөрөмжтэй адил юм.

Чимэнь бясалгалд шуаньгуань онгорхой байдаг. Шуаньгуань тавигдан гадагш гарахдаа цилиндр хэлбэртэй адил байна, гэхдээ аажмаар бөөрөнхий болно, үүний хоёр талын хаалга нь нээлтэй байдаг. Яагаад гэвэл Чимэнь бясалгалд Буддаг ч бясалгадаггүй, Бумбыг ч бясалгадаггүй болохоор тэр өөрөө өөрийгөө хамгаалдаг. Буддын болон Бумбын системд олон багш байдаг, тэд бүгд чамайг хамгаалж чадна, чамд юм харах шаардлага байхгүй, тэгсэн ч ямар ч асуудал гарахгүй. Харин Чимэнь бясалгалын хувьд бол тийм биш, өөрөө өөрийгөө хамгаалах ёстой, тиймээс тэр заавал харах чадвартай байх хэрэгтэй. Тэр үед тэнгэрийн мэлмийгээр юмыг харахад яг дурангаар харж байгаа мэт байдаг. Үүнд цогц зүйл бүрэлдэж дуустал сар гаруй болоод дараа нь бөмбөлөг буцаад дотогшоо орно. Толгой дотор буцаж орохыг “шуаньгуань байрлалаа сольж байна” гэдэг.

Буцаж дотогшоо ороход толгой хөөсөн мэт таагүй мэдрэмж бас төрнө, дараа нь тэр хүний юүжэн сүвнээс шахагдаж гарна. Тэр шахалт нь толгой задарч байгаа мэт их таагүй мэдрэмж бас төрүүлдэг. Шуаньгуань гадагшлангуут тэр дороо бие хөнгөрнө. Гарсны дараа тэр маш гүн орон зайд дүүжлэгдэн байдаг, маш гүн орон зайн биенийн хэлбэр дээр оршдог учраас унтаж байхдаа түүнийг үрэхгүй. Гэхдээ нэг зүйл бий, шуаньгуань анхны удаа бүрэлдэн тогтоход нүдний урд мэдрэгдэнэ, тэр нь өөр орон зайд байгаа ч гэсэн өөрт нүдний өмнө ямар нэгэн зүйл бүрэлзээд нүднийг халхалж байгаа юм шиг тааламжгүй байдаг. Юүжэн сүв бол бас нэг гол гарц учраас бас хойд талд нэг цогц зүйл бүрдүүлэх шаардлагатай, тэгээд тэр дахин буцаж орно. Шуаньгуань-ий нэг сүв гэж ярьдаг ч үнэндээ энэ нь нэг сүвд байрладаггүй, тэр олон удаа байрлалаа сольдог. Тэр Ниван руу буцсаны дараа бууж эхэлнэ, биенийн дотуур доошоо минмэнь сүв хүртэл бууж ирнэ. Минмэнь сүвд хүрээд тэр дахин гадагшилна.

Хүний биенийн минмэнь сүв бол маш чухал гол том сүв юм. Бумбын системд үүнийг сүв гэдэг, бид гарц (гуань) гэдэг. Энэ бол гол том гарц, тэр ёстой төмөр хаалга шиг, тоолшгүй олон давхар төмөр хаалга шиг байдаг. Та бүгд хүний бие маш олон давхаргатай байдгийг мэднэ, бидний махан биенийн эсүүд нь нэг давхарга нь юм, доторх молекулууд бас нэг давхарга нь. Атом, протон, электрон, маш бичил ширхгүүд, түүнээс ч бүр бичил ширхгүүд, хязгааргүй бичил ширхгээс туйлын бичил ширхэг хүртэл давхарга болгонд хаалга байрлуулсан байдаг. Иймээс маш олон ер бусын чадварууд, маш олон арга удвисын зүйлүүд давхарга бүрийн хаалганы цаана түгжээтэй байдаг. Бусад бясалгалуудад бол дань (үрэл)-ийг

үүсгэдэг. Дань дэлбэрэхэд минмэнь сүв доргиалтын хүчинд эхлээд онгойх ёстой, хэрэв энэ нь доргиалтод нээгдэхгүй бол ер бусын чадварууд чөлөөлөгдөн гарч чадахгүй. Шуаньгуань Минмэнь сүвэнд энэ цогц зүйлсийг бүрэлдүүлсний дараа дахиад биеийн дотогш орно. Тэгээд хэвлийн доод хэсэгт буцаж ирнэ, үүнийг “шуаньгуань байрандаа буцаж ирэх” гэдэг.

Шуаньгуань байрандаа буцсаны дараа анхныхаа байршилд эргэж ордоггүй. Энэ үед Юань-инь өсөж нэлээд том болсон байна, хийн бөмбөлөг Юань-инь-ийг бүрхдэг, түүнийг хүрээлчихдэг. Юань-инь өсөхөд, тэр бас дагаж өснө. Бумбын системд Юань-инь бараг зургаа, долоон настай хүүхдийн хэмжээтэй болоход түүнийг биеэс гарахыг зөвшөөрнө, үүнийг “Юань-инь төрөх” гэдэг. Хүний Юань-шэнь (сүнс)-ий удирдлага дор тэр биеэс гарч хөдөлгөөнд орно. Хүний бие тогтуун хөдөлгөөнгүй суухад Юань-шэнь (сүнс) гарч ирнэ. Ер нь Буддын системд Юань-инь бясалгаад өөртэй нь адилхан том болоход аюулгүй болно. Ихэвчлэн энэ үед түүнийг биеэс гарахыг зөвшөөрнө, энэ биеэс гарч ирж болдог. Тэр үед Юань-инь энэ хүнтэй өөртэй нь адил том болсон байна, бүрхүүл бас адилхан томорно, энэ бүрхүүл нь аль хэдийн биеийн гадуур тэлж өргөссөн байдаг, энэ бол шуаньгуань юм. Юань-инь ийм том болж өссөн учраас шуаньгуань мэдээж биеийн гадуур тэлж өргөснө.

Та нар магадгүй сүм хийдийн доторх Буддын хөргийг харсан байх, Буддын хөрөг үргэлж нэг хүрээн дотор байдаг, ялангуяа зурмал Буддын хөрөгт үргэлж нэг хүрээ байдаг, дотор нь Будда сууж байдаг. Маш олон Буддын хөрөг ийм байдаг, ялангуяа эртний хийдүүд дэх Буддын хөрөг бүгд ийм байдаг. Яагаад хүрээн дотор

сууж байдаг вэ? Хэн ч үүнийг тодорхой тайлбарлаж чаддаггүй. Би та бүхэнд хэлэхэд энэ бол шуаныгуань юм. Гэхдээ одоо түүнийг шуаныгуань гэж нэрлэхгүй, түүнийг диваажин гэж нэрлэдэг, гэхдээ одоохондоо яг диваажин гэж нэрлэхэд бас хараахан болоогүй. Энэ нь зөвхөн иж бүрэн тоног төхөөрөмжтэй үйлдвэртэй адил юм, гэхдээ үйлдвэрлэл явуулах хүчин чадалгүй. Үйлдвэрлэл явуулахын тулд заавал эрчим хүч, түүхий эд байх шаардлагатай. Урьд хэдэн жилийн өмнө олон бясалгагчид: “миний гон Бодьсадва-гаас өндөр, миний гон Будда-гаас өндөр” гэж хэлдэг байсан, бусдад энэ нь төсөөлөхийн аргагүй байсан. Үнэндээ тэдний хэлсэн нь төсөөлөхийн аргагүй зүйл биш, хүний ертөнцөд бясалгахад гон нь үнэхээр их өндөр түвшинд хүрэх ёстой байдаг.

Тэгвэл яагаад ийм байдал гарсан бэ, тэд бясалгаад Будда-гаас өндөр түвшинд хүрсэн гэж үү? Үүнийг өнгөцхөн байдлаар ойлгож болохгүй, ийм хүний гон үнэхээр маш өндөр байдаг. Учир нь тэрээр бясалгаад маш өндөр түвшинд хүрсний дараа төгс гэгээрэх үед түүний гон нь үнэхээр маш өндөр байна. Төгс гэгээрэлд хүрэхийн босгон дээр түүний гоны аравны найман хувь нь түүний шиньшин-ий түвшинтэй хамт таслагдах болно. Энэ энерги нь түүний диваажин орныг төгөлдөржүүлэхэд зарцуулагдана, энэ бол түүний өөрийнх нь диваажин орон юм. Бясалгагчийн гоноос гадна ялангуяа шиньшин-ий шалгуур нь амьдралдаа хэмжээлшгүй их зовлон зүдүүрийг туулж, хүнд хэцүү орчинд зовлон амсаж байж бясалгалаар гардаг гэдгийг та бүгд мэднэ, иймээс тэр бол туйлын нандин юм, энэ үнэт зүйлийн аравны найман хувь нь түүний диваажинг төгөлдөржүүлэхэд хэрэглэгддэг. Иймээс ирээдүйд түүний бясалгал үр дүнтэй болоход



гараа нэг сунгаад л хүссэн бүхнээ авч болно, хүссэн бүхнээ хийж чадна, мөн түүний диваажин оронд юм бүхэн байна. Энэ бол түүний бэрхшээл зовлонг даван туулж байж бясалгалаар олсон аугаа Дэ нь юм.

Түүний энэ энерги хүссэнээр нь ямар ч зүйлийг хувирган гаргаж чадна. Иймээс Будда юу авах хүсэлтэй, юу идэх хүсэлтэй, юугаар наадах хүсэлтэй байна, түүнд бүх зүйл байна, энэ бүхэн бол түүний бясалгалын үр дүнд бий болсон юм, энэ бол Буддын бүтээлийн орон (фовэй), үүнгүйгээр тэр бясалгаад үр дүнд хүрч чадахгүй. Одоо үүнийг өөрийнх нь диваажин гэж нэрлэж болно, харин түүнд гон-ы зөвхөн аравны хоёр хувь үлдсэн байгаа, үүгээр төгс гэгээрч Бумбад хүрнэ. Түүнд гон-ы зөвхөн аравны хоёр хувь үлдсэн ч гэсэн бие нь түгжигдээгүй, тэр энэ биеийг орхиж эсвэл авч явж болно. Харин энэ бие нь аль хэдийн дээд энергийн бие бодиор хувирсан, энэ үед түүнд эгнэшгүй ер бусын чадвар гарч ирнэ, сүр хүч нь зүйрлэшгүй их. Гэхдээ энгийн хүмүүсийн дунд бясалгахад үргэлж түгжээтэй байдаг, тийм агуу чадвар байдаггүй, гон хэчнээн өндөр байсан ч хязгаарлагдсан хэвээр байдаг, харин одоо бол өөр хэрэг.

# Тавдугаар лекц

## Фалунь дүрс

Бидний Фалунь Дафа-гийн билэг тэмдэг бол Фалунь. Ер бусын чадвартай хүн энэ Фалунь эргэж байдгийг хардаг, бидний жижиг тэмдэг дээрх Фалунь бас адилхан эргэж байдаг. Бид орчлон ертөнцийн мөн чанар болох Жэнь, Шань, Рэнь-ийн дагуу удирдуулан бясалгадаг. Орчлон ертөнцийн хувьслын зарчим дагуу бясалгадаг, тиймээс бидний бясалгал бол маш аугаа. Өөрөөр хэлбэл, энэ Фалунь дүрс бол орчлон ертөнцийн хураангуй дүрс. Буддын системд дөрвөн зүг найман зовхистой арван зүгийн хорвоог орчлон ертөнц гэж үздэг, зарим хүн Фалунь-ий дээд доод талд босоо гон багана оршиж байгааг харсан байх, иймээс дээд доод зүгийг нийлүүлбэл яг арван зүгийн хорвоо болдог, энэ орчлон ертөнцийг бүрдүүлдэг, энэ нь Буддын системийн орчлон ертөнцийн хураангуйллыг илэрхийлдэг.

Мэдээж энэ орчлон ертөнцөд тоолшгүй олон галактик байдаг, үүнд бидний тэнгэрийн заадас галактик бас орно. Бүх орчлон ертөнц хөдөлж байдаг, түүн доторх галактикууд бас бүгд хөдөлж байдаг, иймээс энэ дүрс доторх Тайжи ба жижиг 卐 (хас) тэмдгүүд бас эргэдэг. Фалунь бүхэлдээ эргэж байдаг, мөн дунд талын том 卐 тэмдэг бас эргэдэг. Өөр нэг утгаар бол энэ нь бидний тэнгэрийн заадас галактикийг бэлгэддэг, бид Буддын системийнх учраас голд нь байгаа тэмдэг бол Буддын системийн тэмдэг, гаднах байдал нь ийм л юм. Янз бүрийн бие боднуд бүгд өөр өөр орон зайд орших хэлбэртэй, тэдгээр нь бусад орон зайд маш баялаг бөгөөд туйлын нарийн

хувьсах явцтай, мөн оршихуйн хэлбэртэй байдаг. Энэ Фалунь дүрс бол орчлон ертөнцийн хураангуй дүрс, энэ нь бас бусад орон зай болгонд орших өөрийн гэсэн хэлбэртэй ба хувьсах явцтай байдаг, иймээс би үүнийг замбуулин хорвоо гэдэг.

Фалунь цагийн зүүний дагуу эргэхдээ орчлон ертөнцөөс энергийг автоматаар татаж авдаг; цагийн зүүний эсрэгээр эргэхдээ энергийг гаргадаг. Дотогшоо (цагийн зүүний дагуу) эргэхдээ өөрийгөө авардаг, гадагшаа (цагийн зүүний эсрэг) эргэхдээ бусдад аврал үзүүлдэг, энэ бол манай бясалгалын онцлог. Зарим хүн ингэж асуудаг: “Бид Буддын системийнх байтал яагаад Тайжи тэмдэг бас байгаа юм бэ? Энэ Тайжи Бумбын системийнх биз дээ?” Яагаад гэвэл бидний бясалгаж буй зүйлс бол маш аугаа, бүхэл орчлон ертөнцийг бясалгаж байгаатай адил. Тэгвэл та бүгд боддоо, энэ орчлон ертөнцөд үндсэн хоёр том систем байдаг. Буддын ба Бумбын гэсэн хоёр систем юм. Аль нэгийг нь хасвал бүхэл бүтэн орчлон ертөнцийг бүрдүүлж чадахгүй, бүхэл бүтэн орчлон ертөнц гэж нэрлэж болохгүй, иймээс үүнд бас Бумбын зүйлс багтдаг. Зарим хүн, Бумбын системээс гадна бас Христосын шашин, Күнзийн шашин, мөн бусад шашин байдаг биз дээ гэдэг. Би та бүхэнд хэлье, Күнзийн шашинд бясалгаад маш өндөр түвшинд хүрэхэд Бумбын системд харьяалагддаг; Барууны олон шашинд бясалгаад өндөр түвшинд хүрсний дараа Буддын системд харьяалагддаг. Ийм л хоёр үндсэн систем байдаг.

Тэгвэл яагаад Тайжи дүрсний хоёр нь дээрээ улаан, доороо цэнхэр, нөгөө хоёр нь дээрээ улаан, доороо хар байдаг вэ? Бидний мэддэг Тайжи бол хар цагаан

хоёр бие бодиос бүтдэг, арга билиг хоёр чий юм. Энэ бол маш доод түвшний ойлголт, харин Тайжи нь өөр өөр орон зайд өөр өөрөөр илэрдэг. Хамгийн өндөр түвшинд илрэхдээ түүний өнгө нь ийм байдаг. Бидний нийтлэг мэдэх Бумба-д дээд хэсэг нь улаан, доод хэсэг нь хар өнгөтэй байдаг. Жишээлбэл бидний тэнгэрийн мэлмий нээгдсэн зарим хүн энгийн нүдэнд харагддаг улаан өнгийг зэрэгцээ орон зайд харахад ногоон өнгөтэй болдог. Алтан шар өнгө өөр орон зайд ягаан өнгөтэй харагддаг, ийм нэг ялгаа гардаг, өөрөөр хэлбэл өөр өөр орон зайд өнгө нь бас өөр өөрөөр өөрчлөгддөг. Дээд хэсэг нь улаан доод хэсэг нь цэнхэр Тайжи нь анх үүссэн Аугаа Бумбын системд хамаарагдах бөгөөд үүнд мөн Чимэнь бясалгал багтдаг. Дөрвөн жижиг **卍** тэмдэг Буддын системийнх, эдгээр нь голд нь байгаатай адил бүгд Буддын системийнх. Энэ Фалунь-ий өнгө харьцангуй тод харагддаг болохоор бид үүнийг Фалунь Дафа-гийн билэг тэмдэг болгон авсан.

Бидний тэнгэрийн мэлмийд харагддаг Фалунь ийм өнгөтэй байх албагүй, түүний дэвсгэр өнгө өөрчлөгддөг, гэхдээ хэлбэр дүрс нь өөрчлөгдөхгүй. Чиний хэвлийн доод хэсэгт миний суулгаж өгсөн Фалунь эргэхийг чи тэнгэрийн мэлмийгээрээ харахад тэр нь магадгүй улаан, ягаан, ногоон, эсвэл өнгөгүй ч байж болно. Улаан, улбар шар, шар, ногоон, цэнхэр, хөх мөн ягаанаар түүний дэвсгэр өнгө нь байнга өөрчлөгдөж байдаг, иймээс чиний харсан нь өөр өөр өнгөтэй байж болно, гэхдээ доторх **卍** тэмдэг болон Тайжи-гийн өнгө, дүрс нь өөрчлөгдөхгүй. Бид энэ дүрсний дэвсгэр өнгийг нэлээд аятайхан харагдаж байна гэж үзсэн тул үүн дээр тогтсон. Ер бусын

чадвартай хүн энэ орон зайг нэвтэрч их олон зүйлсийг харж чаддаг.

Зарим хүн: “Энэ **卍** тэмдэг Гитлерийн зүйлтэй адилхан юм шиг харагдаж байна” гэдэг. Та бүгдэд хэлэхэд энэ тэмдэг өөрөө нийгмийн ямар ч ангийн ухагдахуун илэрхийлдэггүй. Зарим хүн: “Үүний өнцөг нь ийшээ хазайвал Гитлерийн тэмдэг болчих юм байна” гэдэг. Энэ бол тийм биш, яагаад гэвэл энэ нь хоёр тийшээ эргэдэг. Бидний хүн төрөлхтний нийгэмд энэ тэмдгийг 2500 жилийн өмнөх Шагжамүни-гийн үеэс эхлэн өргөн мэддэг болсон. Дэлхийн 2-р дайны үеэс одоог хүртэл дөнгөж хэдэн арван жил л өнгөрч байна, Гитлер энэ тэмдгийг хулгайлж ашигласан, гэхдээ өнгө нь манайхтай адилгүй, хар өнгөтэй, өнцөг нь дээш чиглэсэн, мөн босоо хэлбэрээр хэрэглэдэг байсан. Би энэ Фалунь-ий талаар энэ хүртэл л ярьж, үүний зөвхөн гаднах хэлбэрийг л дурдлаа.

Тэгвэл энэ **卍** тэмдгийг манай Буддын система юу гэж үздэг вэ? Зарим хүн үүнийг өлзий хутгийн бэлгэдэл гэдэг, энэ бол эгэл хүмүүсийн тайлбар. Би та бүгдэд хэлье, энэ **卍** тэмдэг бол Буддын түвшнийг илэрхийлдэг, зөвхөн Буддын түвшинд хүрэхэд бий болдог. Бодьсадва, Архадад байхгүй, харин аугаа Бодьсадва нарт, дөрвөн их Бодьсадвад бүгдэд нь байдаг. Бид эдгээр аугаа Бодьсадва нарыг жирийн Буддын түвшнээс хол давсныг нь харсан, тэр ч байтугай Рулай (Гатагата)-гаас ч өндөр. Рулай түвшнээс давсан Будда тоолшгүй олон байдаг. Рулай зөвхөн нэг л **卍** тэмдэгтэй, Рулай-гаас дээш түвшинд хүрэхэд энэ **卍** тэмдэг нь олон болдог. Рулай-гаас хоёр дахин өндөр түвшинд хүрсэн Буддад хоёр **卍** тэмдэг байна, түүнээс улам өндөр түвшинд хүрэхэд тэдэнд гурав, дөрөв, тав гэх мэтчилэн байдаг, бүр ихэсвэл биеэр нь дүүрэн

болдог. Толгой, мөр, өвдгөн дээр гардаг; багтах зайгүй болбол гарын алга, хурууны өндөг, хөлийн ул, хөлийн хуруунууд дээр мөн гардаг. Түвшин дээшлэх тусам 卐 тэмдэг улам нэмэгдэнэ, иймээс 卐 тэмдэг нь Буддын түвшнийг илэрхийлдэг, Буддын түвшин өндөр байх тусам 卐 тэмдэг улам ихэснэ.

## **Чимэнь бясалгал**

Буддын ба Бумбын системийн бясалгалаас гадна бас нэг Чимэнь гэдэг бясалгалын арга байдаг, тэд үүнийгээ Чимэнь бясалгал гэдэг. Бясалгалын талаар энгийн хүмүүст ийм нэг ойлголт байдаг: Эртний Хятадын үеэс өнөөг хүртэл хүмүүс Буддын болон Бумбын системийн бясалгалыг уламжлалт бясалгал гэж үздэг, эдгээрийг арнун номын бясалгал гэдэг. Энэ Чимэнь бясалгал олон нийтийн дунд хэзээ ч дэлгэрч байгаагүй, маш цөөхөн хүн үүний оршиж байгааг мэддэг, зөвхөн урлагийн бүтээлээс сонссон байдаг.

Чимэнь бясалгал гэж байдаг уу? Байдаг. Би бясалгалынхаа явцад, ялангуяа сүүлийн хэдэн жилд Чимэнь-ий өндөр түвшинд хүрсэн гурван их мастертай тааралдаж байсан, тэд өөрсдийн энэ бясалгалын охь зүйлийг надад дамжуулсан, энэ нь маш онцгой бөгөөд их сайн зүйл байсан. Тэдний зүйлс их онцлог учраас бясалгаж гаргасан зүйлс нь их өвөрмөц, жирийн хүнд ойлгогдохгүй. Мөн түүнчлэн ийм нэг зүйл яригддаг, өөрсдийгөө Будда ч биш Бумба ч биш, Буддад ч бясалгадаггүй, Бумбад ч бясалгадаггүй гэдэг. Хүмүүс тэднийг Буддад ч бясалгадаггүй Бумбад ч бясалгадаггүй гэдгийг дуулаад үүнийг “Хажуугийн үүд ба Болхи замын (панмэнь зуодао)” гэж нэрлэсэн, тэд өөрсдөө Чимэнь бясалгал гэж нэрлэдэг. Хажуугийн үүд ба Болхи замын гэдэг нь үл ойшоосон утгатай үг,

гэхдээ энд буруу номын гэж хэлсэн эсрэг утга байхгүй, энэ бол баттай юм. Үгийн утгаар нь ойлгоход буруу номын гэсэн санаа байхгүй. Түүхэнд Буддын бясалгал, Бумбын бясалгалыг ариун номын бясалгал гэж нэрлэж ирсэн, хүмүүс энэхүү бясалгалыг ойлгохгүй болохоор үүнийг хажуу үүдний ба салаа замын ариун бус бясалгал гэж хэлдэг. Тэгвэл “зуодао” гэдэг нь юу гэсэн үг вэ? Энэ нь болхи, мулгуу аргын гэсэн утгатай. Эртний Хятад хэллэгээр голдуу мунхаг гэсэн утгатай байсан, “Панмэнь зуодао” гэдэг нь ийм л утгатай юм.

Яагаад энэ нь буруу ном биш вэ? Яагаад гэвэл тэр бас шиньшин-д хатуу шаардлага тавьдаг, түүнчлэн орчлон ертөнцийн мөн чанарын дагуу бясалгадаг. Энэ нь орчлон ертөнцийн мөн чанар, орчлон ертөнцийн зүй тогтлыг зөрчдөггүй, муу зүйл хийлгэдэггүй учраас үүнийг буруу ном гэж хэлж болохгүй. Бидний энэ орчлон ертөнцийн мөн чанар Буддын, Бумбын хоёр системийн бясалгалын аргад нийцсэндээ биш, харин Буддын, Бумбын хоёр системийн бясалгалын арга нь орчлон ертөнцийн мөн чанарт нийцдэг учраас ариун номын бясалгал болсон юм. Чимэнь бясалгал орчлон ертөнцийн мөн чанарт нийцдэг юм бол энэ нь буруу номын бясалгал биш, адилхан ариун номын бясалгал юм. Яагаад гэвэл сайн мууг, нинжин харгисыг цэгнэдэг шалгуур нь орчлон ертөнцийн мөн чанар байдаг. Тэр нь орчлон ертөнцийн мөн чанарын дагуу бясалгадаг учраас бас ариун замынх, харин тэдний шаардлагын онцлог нь Буддын ба Бумбын системтэй адилгүй. Тэр олон шавьд өргөнөөр заадаггүй, маш цөөхөн хүнд л заадаг. Бумбын системд олон шавьд заадаг, гэхдээ зөвхөн нэг л шавьд жинхэнэ уламжилдаг; Буддын системд бүх амийг аврахыг ярьдаг, хэн бясалгаж чадна тэр бясалгана.

Чимэнь бясалгал нь хоёр хүнд уламжилж болдоггүй, түүхийн урт хугацаанд зөвхөн нэг л хүнийг сонгож уламжилдаг, иймээс энэ зүйл нь энгийн хүнд ердөө үзэгдэж байгаагүй. Мэдээж чийгон-ыг ид дэлгэрч байх үед энэ бясалгалын цөөн хүмүүс бас гарч ирж зааж байсныг би харсан. Гэхдээ тэд зааж явцдаа болохгүй болохыг ойлгосон, яагаад гэвэл багш нь зарим зүйлийг олны дунд тараахыг хориглосон. Чи бясалгалаа зааж бодолтой байвал сурагчдыг шилж сонгож болохгүй, суралцахаар ирсэн хүмүүс янз бүрийн түвшний шиньшин-тэй байдаг. Янз бүрийн үзэл баримтлалтай хүмүүс суралцахаар ирдэг, янз бүрийн хүмүүс байдаг тул чамд шавийг сонгох арга байхгүй. Тийм ч учраас Чимэнь бясалгалыг нийтэд дэлгэрүүлж болохгүй, амархан аюул гарна, яагаад гэвэл тэдний зүйл их өвөрмөц.

Зарим хүн ингэж боддог, Буддын системд Буддад бясалгадаг, Бумбын системд Бумбад бясалгадаг, тэгвэл Чимэнь бясалгалаар төгс үр дүнд хүрвэл юу болох вэ? Тэр бол чөлөөтэй аялагч бурхан, түүнд энэ орчлон ертөнцөд тогтсон хүрээ байдаггүй. Та бүгд мэднэ, Рулай бурхан Шагжамүни Саха диваажинтай; Будда Амитаба Сухавати диваажинтай; Яуши Будда Лиули диваажинтай; Рулай болгон, аугаа Будда болгон өөрийн гэх диваажинтай. Аугаа гэгээрэгч болгон өөрийн бүтээсэн Тэнгэрийн оронтой байдаг, түүний олон шавь нар нь тэнд амьдардаг. Харин Чимэнь бясалгалын хувьд өөрийн гэх тогтсон орчлон ертөнцийн хүрээ байдаггүй, тэр зөвхөн нэг чөлөөтэй аялагч бурхантай адил.



## Буруу номоор бясалгах

Буруу номоор бясалгах гэж юу гэсэн үг вэ? Ийм хэдэн хэлбэр байдаг: зарим хүн зорнуд буруу номоор бясалгадаг, яагаад гэвэл энэ зүйлийг үеэс үед уламжлан заадаг хүн байдаг. Яагаад энэ зүйлийг уламжилдаг вэ? Яагаад гэвэл тэд энгийн хүмүүсийн дунд нэр хүнд, хувийн ашиг сонирхол, баяжихын төлөө хөөцөлддөг, тэд үүнийг л хүсдэг. Мэдээж тийм хүний шиньшин өндөр биш, гон олж авч чадахгүй. Тэр юу олж авдаг вэ? Нүгэл. Хүний нүгэл ихэдвэл бас нэг янзын энерги бий болдог. Гэхдээ түүнд бясалгалын түвшин байхгүй, түүнийг бясалгагч хүнтэй харьцуулшгүй, гэхдээ энгийн хүнтэй харьцуулбал энгийн хүнийг захирч чадна. Яагаад гэвэл энэ зүйл бас энергийн илрэл юм, нягтрал нь маш их болоход хүний ер бусын чадварыг хүчтэй болгож чадна, ийм нөлөө бас гардаг, иймээс түүхийн туршид зарим хүн энэ зүйлийг уламжлан зааж ирсэн. Тэр ингэж ярьдаг: “Би муу зүйл хийснээр, хүн загнаснаар миний гон өснө.” Тэр гон-оо өсгөж байгаа юм биш, үнэндээ бол энэ хар бие бодийн нягтралыг нэмэгдүүлж байгаа юм, яагаад гэвэл муу юм хийхэд хар бие бодь болох нүглийг олдог. Иймээс түүнд байгаа төрөлхийн үл ялих ер бусын чадвар нь энэ нүглээр хүчтэй болж болно, бас бага зэрэг ер бусын чадвар гаргадаг, гэхдээ ямар ч том зүйл хийх чадваргүй. Ийм хүн муу зүйл хийж бас гон-оо өсгөж болдог гэж үздэг, тэр ингэж л ярьдаг.

Зарим хүн Бумба нэг тохойгоор өндөр байхад буг чөтгөр арван тохой илүү өндөр гэж ярьдаг. Энэ бол энгийн хүмүүсийн дунд яригдадаг ташаа үг юм, буг чөтгөр Бумбаас хэзээ ч өндөр байж чадахгүй. Ийм нэг байдал байдаг, бидний хүн төрөлхтний мэдэх орчлон ертөнц нь тоо томшгүй олон орчлон

ертөнцийн дундах нэг жижигхэн орчлон ертөнц юм, бид үүнийг товчхондоо орчлон ертөнц гэж нэрлэдэг. Манай орчлон ертөнц маш олон жилийн мөчлөг үеийг туулах бүрд орчлон ертөнцийн том сүйрэлд удаа дараалан ордог. Энэ сүйрэлд орчлон ертөнцийн бүх зүйлс, үүнд од гаригс, бүх амь бодь устдаг. Орчлон ертөнцийн хөдөлгөөн бас зүй тогтолтой, бидний энэ удаагийн орчлон ертөнцөд зөвхөн хүн төрөлхтөн муу болсон юм биш, өнөөгийн цаг үеийн хувьд энэ орчлон ертөнцийн орон зайд аль эрт том дэлбэрэлт болсныг, ийм нөхцөл байдал гарсныг олон амь бодь аль хэдийн ажиглаж мэдсэн. Өнөөдөр одон орон судлаачид үүнийг харж чадахгүй, яагаад гэвэл хамгийн хүчирхэг дурангаар бидний харж чадах нь одоогоос 150 мянган гэрлийн жилийн өмнөх зүйл юм. Одоо тэдгээр тэнгэрийн эрхсийн өөрчлөлтийг харахыг хүсвэл 150 мянган гэрлийн жилийн дараа л харагдана. Энэ бол маш урт хугацаа.

Эдүгээ бүх орчлон ертөнц даяар аль хэдийн маш том өөрчлөлт гарсан, ийм өөрчлөлт гарах болгонд бүхэл орчлон ертөнцийн амь бодь бүгд устгах байдалд хүрдэг, бүрэн сүйдэх байдал тулгардаг. Ийм нөхцөл байдал тохиолдох бүрд орчлон ертөнцийн урьд оршиж байсан мөн чанар ба доторх бүх бие бодь бүгд тэсрэлтэд устдаг, ихэвчлэн бүгд дэлбэрэлтэд үхдэг, гэхдээ удаа дараагийн ийм тэсрэлт болгонд нэг бүрчлэн устдаггүй. Маш өндөр түвшний аугаа гэгээрэгчид шинэ орчлон ертөнцийг дахин бүтээсний дараа дотор нь дэлбэрэлтэд үхээгүй зарим амь бодь үлддэг. Аугаа гэгээрэгчид энэ орчлон ертөнцийг өөрсдийн мөн чанар, өөрсдийн шалгуурын дагуу бүтээдэг, иймээс өмнөх үеийн орчлон ертөнцийн мөн чанартай адилгүй.

Дэлбэрэлтээс амьд үлдэгсэд энэ орчлон ертөнцөд өмнөх мөн чанар ба зарчмын дагуу аливаа үйлийг хийдэг. Шинээр бүтээгдсэн орчлон ертөнц нь үйл хөдлөлдөө шинэ орчлон ертөнцийн мөн чанар, зарчмыг дагадаг. Иймээс дэлбэрэлтээс үлдэгсэд нь шинэ орчлон ертөнцийн зарчмыг үймүүлэх буг чөтгөр болдог. Гэхдээ тэд тийм ч бас муу биш, тэд зөвхөн өмнөх үеийн орчлон ертөнцийн мөн чанарын дагуу үйлийг хийдэг, энэ бол хүмүүсийн хэлдэг тэнгэрийн буг чөтгөр юм. Гэхдээ тэд энгийн хүмүүст аюул занал хийхгүй, хор хөнөөл ч учруулахгүй, тэд зөвхөн өөрсдийн зарчмаар л үйлийг хийдэг. Урьд өмнө үүнийг энгийн хүнд мэдүүлэхийг зөвшөөрдөггүй байсан, би Рулай түвшнээс их өндөрт гарсан Будда маш олон байдаг гэж хэлсэн, харьцуулж харахад тэдгээр буг чөтгөрүүд юу ч биш, маш өчүүхэн. Хөгшрөх, өвчлөх, үхэх нь буг чөтгөрийн бас нэг хэлбэр юм, гэхдээ энэ ч гэсэн орчлон ертөнцийн мөн чанарыг сахин хамгаалахын тулд үүссэн.

Буддын шашинд самсара буюу зургаан замын тойрогт төрөл олох гэж номлодог, үүнд Асурын талаар яригддаг, үнэндээ энэ нь өөр өөр орон зайнуудын амь бодигч юм, гэхдээ тэдэнд хүний мөн чанар байхгүй. Лугаа гэгээрэгчдийн харснаар тэд маш доод түвшнийх бөгөөд ямар ч чадваргүй байдаг, гэхдээ энгийн хүний нүдэнд аймаар харагддаг, тэд тодорхой хэмжээний энергитэй, энгийн хүмүүсийг амьтантай адил үздэг, тиймээс хүнийг идэх дуртай. Сүүлийн жилүүдэд тэд бас чийгон захаар гарч ирсэн. Тэд юу гээч зүйлс вэ, тэд хүнтэй адилхан харагдаж яаж чадах юм? Тэд их аймаар харагддаг, тэдний зүйлсийг сурах юм бол тэдэнтэй явж төрөлд нь орох болно. Зарим хүн чийгон-оор хичээллэхдээ буруу бодолтой байдаг, тэр бодол нь

тэдний үзэл бодолтой нийцэхэд тэд ирж түүнд заана. Нэг зөв бодол зуун мууг дарж чаддаг, чи хөөцөлдөхгүй байхад хэн ч чамайг оролдож зүрхлэхгүй. Чамаас муу бодол гарвал, муу зүйлийн хойноос хөөцөлдвөл тэд чамд туслахаар ирнэ, чи бясалгаад буг чөтгөрийн замд орчихно. Ийм асуудал гарч болно.

Өөр нэг асуудал байдаг, үүнийг “санаандгүйгээр буруу номоор бясалгах” гэдэг. Санаандгүйгээр буруу номоор бясалгах гэж юу вэ? Энэ бол хүн буруу номоор бясалгаж байгаагаа өөрөө мэддэггүй. Энэ нь их түгээмэл бөгөөд маш их гардаг. Нэлээд олон хүн чийгон-оор хичээллэхдээ буруу санаа бодолтой байдаг гэж би өмнө нь хэлсэн. Багана зогсолт дасгал хийж байхад гар хөл нь чилэн чигирч байсан ч түүний бодол нь завгүй байдаг. Тэр ингэж бодно: “Юмны үнэ өсөж байна, дэлгүүр явах хэрэгтэй, би дасгалаа дуусахаар очиж юм худалдаж авъя, тэгэхгүй бол үнэ нь улам өсчихнө.” Өөр нэг хүн ингэж бодно: “Ажлын газраас одоо байр хуваарилж өгч байгаа, надад байр оногдох болов уу, байр хуваарилж байгаа хүн надтай таарамжгүй.” Тэр энэ талаар их бодох тусам уур нь улам хүрнэ, “Тэр надад байр өгөхгүй нь гарцаагүй, би яаж түүнтэй үзэлцвэл дээр бол...” Элдэв янзын бодол гарч ирдэг. Миний хэлсэн шиг тэд гэр бүлийн асуудлаас улсын хэрэг хүртэл хов жив ярина, тэд уураа хүрсэн асуудлаар улам их ярьж өөрсдийгөө бүр ихээр бухимдуулна.

Бясалгахад Дэ-г чухалчлах ёстой, дасгалаа хийж байхдаа чи сайн зүйлийн талаар боддоггүй юм гэхэд ядаж муу зүйлийн талаар битгий бод, юу ч бодохгүй байх нь хамгийн сайн. Яагаад гэвэл доод түвшинд бясалгахад суурь тавигдах хэрэгтэй байдаг, энэ суурь нь маш чухал үүргийг гүйцэтгэдэг, яагаад гэвэл хүний

бодлын үйл ихээхэн нөлөө үзүүлдэг. Та бүгд энэ талаар бодоод үз дээ, чи гон дотроо ямар зүйл нэмээд байна вэ? Чиний бясалгаж гаргасан зүйл сайн байж чадах уу? Тэр зүйл хар биш гэж үү? Хэр олон хүн ийм бодолтойгоор чийгон-оор хичээллэдэг гээч? Чи бясалгаад байхад яагаад чиний өвчин эдгэрэхгүй байна вэ? Дасгалын газар зарим хүн тийм муу юм бодоогүй ч гэсэн ямагт ер бусын чадвартай болох, энэ тэрийг хөөцөлдөх, янз бүрийн сэтгэлтэйгээр, янз бүрийн хүчтэй хүсэлтэйгээр дасгалаа хийдэг. Үнэндээ тэд аль хэдийн санаандгүйгээр буруу номын бясалгалд орсон юм, чи түүнийг буруу номоор бясалгаж байна гэж хэлбэл тэр дургүйцнэ, “Би нэртэй чийгон багшаар заалгасан” гэнэ. Гэхдээ тэр нэртэй чийгон багш чамайг Дэ-г эрхэмлэ гэж сургасан. Чи тэгж хийсэн үү? Чи чийгон-оор бясалгахдаа үргэлж муу бодлыг оруулдаг бол, чи хэл дээ, чи яаж сайн зүйл бясалгаж гаргах юм? Асуудал үүнд л байгаа юм, үүнийг санаандгүйгээр буруу номоор бясалгах гэдэг, маш түгээмэл байдаг.

### **Эр эм хос бясалгал**

Бясаллагчдын хүрээнд ийм нэг бясалгалын арга байдаг, үүнийг эр эм хос бясалгал гэдэг. Та нар магадгүй Түвдийн Тантрын шашны бясалгалд сийлбэрлэсэн Буддын баримал эсвэл хөрөг зургуудаас эрэгтэй нь эмэгтэйтэй тэврэн бясалгаж байгааг харсан байх. Эрэгтэйн бие нь заримдаа Будда хэлбэртэй, нүцгэн эмэгтэйтэй тэвэрсэн байдаг; зарим нь магадгүй Буддын хувирсан дүртэй, үхэр толгой адуун нүүртэй Очирваань дүрд хувираад нүцгэн эмэгтэйн биений тэвэрсэн байдаг. Яагаад ийм байдаг вэ? Бид эхлээд та бүгдэд энэ асуудлыг тайлбарлая, манай дэлхий дээр зөвхөн Хятадад Күнзийн сургаал нөлөөлсөн юм биш,

хэдэн зууны өмнө бидний бүхий л хүн төрөлхтний ёс суртахууны үзэл баримтлал бараг бүгд ижилхэн байсан. Иймээс энэ бясалгалын арга үнэндээ манай дэлхийгээс эх сурвалжтай биш юм, энэ нь өөр гаригаас ирсэн, гэхдээ энэ аргаар үнэхээр бясалгаж болно. Энэ бясалгал тухайн үед Хятадад орж ирэхэд үүнд эр эм хосоор бясалгадаг арга, мөн зарим нууцаар бясалгах зүйл байсан учраас Хятад хүмүүс үүнийг хүлээж авч чадаагүй, иймээс үүнийг Тан гүрний хаан Хуйчань цаг үед Хан нутаг дэвсгэрт тараахыг хориглосон. Хан нутагт заан тараахыг зөвшөөрөөгүй, тэр үед үүнийг Тан Тантризм гэдэг байсан. Гэхдээ энэ нь Түвдийн нэг онцгой орчинд, тусгай бүс нутагт уламжлагдан ирсэн. Яагаад ингэж бясалгадаг вэ? Эр эм хос бясалгал нь билгийг цуглуулж аргыг нөхөх, аргыг цуглуулж билгийг нөхөх замаар харилцан дэмжиж, харилцан бясалгаж арга билиг хоёрыг тэнцвэржүүлэх зорилготой юм.

Буддын системд болон Бумбын системд, ялангуяа Бумбын арга билигийн онолд хүний биед төрөлхөөс арга билиг оршдог гэдгийг та бүгд мэднэ. Хүний биед арга билиг оршдог болохоор хүний бие бясалгалаар янз бүрийн ер бусын чадвар, Юань-инь, Инь-хай, Фашэнь гэх мэт амь боднудыг гаргаж болно. Арга билиг байгаа учраас маш олон амь боднийг бясалгаад гаргаж болно. Эрэгтэй, эмэгтэй хүний бие ялгаагүй бясалгалаар дань-тиань-д бүгдийг үүсгэж гаргадаг, энэ онол нь үнэхээр үндэслэлтэй юм. Бумбын системд ер нь биесийн дээд хэсгийг арга, доод хэсгийг билиг гэж үздэг; зарим нь биесийн ар талыг арга, урд талыг билиг гэдэг; зарим нь биесийн зүүн талыг арга, баруун талыг билиг гэдэг. Хятадад “эр зүүн, эм баруун” гэсэн яриа байдаг, энэ нь бас үүнээс үүдэлтэй бөгөөд их учир

зүйтэй юм. Хүний биед угаасаа арга билиг оршдог болохоор арга билгийн харилцан нөлөөллийн дүнд бие нь өөрөө арга билгийг тэнцвэржүүлж чадна, мөн маш олон амь бодийг үүсгэн гаргаж болдог.

Энэ нь юуг хэлж байна вэ гэвэл, бид эр эм хос бясалгалын аргыг хэрэглэхгүйгээр бясалгалын маш өндөр түвшинд мөн адил хүрч чадна гэсэн үг. Хэрэв эр эм хос бясалгалын аргыг зүй бусаар хэрэглэх юм бол буг чөтгөрийн нөлөөлөлд орж энэ нь буруу номын бясалгал болно. Тантризмд маш өндөр түвшинд эр эм хос бясалгалыг хэрэглэх юм бол энэ лам хувраг заавал бясалгалын маш өндөр түвшинд хүрсэн байх ёстой байдаг. Тэр үед багш нь түүнийг удирдаж ийм бясалгал хийлгэдэг, яагаад гэвэл түүний шиньшин нь маш өндөр, тэр өөрийгөө сайн барьж чадна, гажуу зүйлд орохгүй. Харин шиньшин-ий түвшин нь доогуур хүн энэ аргыг хэрэглэж хэрхэвч болохгүй, хэрэглэх юм бол энэ хүн буруу номын бясалгал руу орох нь дамжиггүй. Шиньшин-ий түвшин хангалтгүй, энгийн хүний дур хүсэл, шунал тачаалаа орхиогүйн улмаас түүний шиньшин-ий хэмжээ тэнд л байгаа учраас хэрэглэх юм бол гай зэтгэр болох нь гарцаагүй. Иймээс бид үүнийг доод түвшинд хамаагүй дэлгэрүүлэх юм бол буруу ном тараасан болно гэж хэлсэн.

Сүүлийн жилүүдэд нэлээд олон чийгон багш эр эм хос бясалгалыг зааж байгаа. Хачирхалтай нь юу вэ? Бумбын системд бас эр эм хос бясалгах арга үзэгдэх болсон, гэхдээ энэ нь саяхнаас гарсан биш, Тан хаант төрийн үеэс эхэлсэн. Бумбын системд яагаад эр эм хос бясалгах арга гарах болсон бэ? Бумбын систем дэх Тайжи номлолын дагуу бол хүний биеийг жижиг орчлон ертөнц гэдэг, төрөлхийн арга билигтэй

байдаг. Жинхэнэ ариун ном болгон маш эрт дээр үеэс уламжлагдан ирдэг, үүнийг өөрийн үзэмжээр өөрчилж, дур зоргоороо хамаагүй зүйл нэмж оруулбал тухайн номын бясалгалыг замбараагүй болгоод зогсохгүй бясалгалаар гэгээрэх зорилгод хүрэх боломжгүй болно. Тийм болохоор тухайн бясалгалд эр эм хос бясалгах зүйл байхгүй л бол түүнийг бясалгалдаа бүү оруул, оруулбал гажуудаж асуудал гарна. Ялангуяа манай Фалунь Дафа-гийн номд эр эм хос бясалгал гэж байхгүй, тэгээд ч энэ нь бидэнд хэрэггүй. Энэ асуудлыг бид ингэж л үздэг.

### **Амь бие, сэтгэлийн хос бясалгал**

Амь бие, сэтгэлийн хос бясалгалын талаар та бүгдэд урьд нь тайлбарласан. Амь бие, сэтгэлийн хос бясалгал гэдэг нь шиньшин-ийг бясалгахаас гадна амь биеэ бясалгадаг, өөрөөр хэлбэл энэ бодит бие (бэньти) өөрчлөгддөг. Өөрчлөгдөх явцад хүний эсүүд нь аажмаар дээд энергийн бие бодиор солигдох ба хөгшрөлт удааширна. Хүний бие аажмаар залуужна, аажмаар хувирна, эцэст нь дээд энергийн бие бодиор бүрэн солигдоход, хүний бие аль хэдийн өөр төрлийн бие бодиос тогтсон бие болж хувирсан байх болно. Тэр бие нь миний дээр хэлсэнчлэн таван махбодоос гарсан байх болно, таван махбодод оршихоо больсон байх тул энэ хүний бие цаашид муудахгүй.

Сүм хийдэд бясалгахад зөвхөн сэтгэлийг бясалгадаг, иймээс дасгал заадаггүй, амь биенийг бясалгадаггүй, үүнд зөвхөн нирвааныг ярьдаг. Шагжамүни-гийн заасан арга бол нирваан байсан, үнэндээ Шагжамүни-д өөрийнх нь аугаа дээд түвшний Дарма байсан, өөрийнхөө биенийг дээд энергийн бие бодид бүрэн хувиргаад авч явж чадах байсан. Гэхдээ ийм бясалгалын аргыг



үлдээхийн тулд тэр өөрөө нирвааны замаар явсан. Тэр яагаад ингэж заасан бэ? Хүний зууралдсан сэтгэлийг болон бүхнийг хамгийн дээд хэмжээгээр орхиулах, эцэст нь махан биеийг хүртэл орхиулахын тулд хийсэн, энэ нь бүх сэтгэлийг үгүй болгоход оршдог. Хүмүүст үүнийг хамгийн дээд хэмжээгээр орхиулахын тулд тэр нирвааны замыг сонгосон, иймээс үеийн үед лам хувраг нар нирвааны замаар явах болсон. Нирваан гэдэг нь лам хувраг нас барахдаа махан биеэ орхиж сүнс (Юань-шэнь) нь гон-тойгоо дээш явахыг хэлдэг.

Бумбын системд амь биеийг бясалгахыг илүүд анхаардаг, бүх амийг аврахыг ярьдаггүй, шавийг сонгож авдаг учраас маш сайн сурагчидтай байдаг, тиймээс үүнд арга увдисын зүйлийг болон амь биеийг яаж бясалгахыг заадаг. Харин Буддын системийн бясалгалын тогтсон аргад, ялангуяа Буддын пашны бясалгалын аргад үүнийг заадаггүй. Гэхдээ бүгд огт заадаггүй юм биш, Буддын системийн дээд бясалгалын олон аугаа номд заадаг, манай бясалгалд ч бас заадаг. Манай Фалунь Дафа-д өөрийн бие (бэньти)-ийг ч бясалгана, Юань-инь-ийг ч бясалгана, энэ хоёр бол ялгаатай. Юань-инь бас нэг янзын дээд энергийн бие боднор бүтээгдсэн бие юм, гэхдээ тэр бидний энэ орон зайд хамаагүй илэрч болохгүй, энэ орон зайд урт хугацаагаар энгийн хүний төрх хэлбэртэй байхын тулд бид заавал өөрийн бие (бэньти)-тэй байх ёстой. Иймээс энэ бие (бэньти) хувирсны дараа түүний эсүүд нь дээд энергийн бие боднор солигддог ч гэсэн түүний молекулын жагсах дэс дараалал өөрчлөгдөхгүй, иймээс энгийн хүний биеэс тийм их ялгаатай харагдахгүй. Гэхдээ бас ялгаатай, тухайлбал энэ бие өөр орон зайнуудад орж чаддаг.

Амь бие, сэтгэлийг хос бясалгадаг бясалгалууд нь хүний гаднах төрхийг их залуу харагдуулдаг, хүн өөрийнхөө жинхэнэ наснаас их хол зөрөөтэй харагддаг. Нэг удаа надаас нэгэн эмэгтэй асуусан: “Багшаа, та намайг хэдэн настай гэж бодож байна?” Үнэндээ, тэр дал хүрч байсан гэхдээ дөнгөж дөч гарам настай юм шиг харагдаж байсан. Нүүр нь бараг үрчлээгүй, гэрэлтсэн цагаан царайтай, улаа бутарсан хацартай, түүнийг дал хүрсэн гэмээргүй. Манай Фалунь Дафа-гийн бясалгагчдад ийм байдал гардаг. Жаахан наргиан болгож хэлэхэд, залуу охид нүүр царайгаа цагаан сайхан байлгах гэж дандаа оо энгэсэг хэрэглэх дуртай. Би хэлбэл, хэрэв чи амь бие, сэтгэлийн хос бясалгалаар туушгтай явбал жамаараа тийм байдалд хүрнэ, чамд оо энгэсэг хэрэглэх шаардлагагүй болно. Бид өөр иймэрхүү жишээг дурдахаа больё. Урьд өмнө янз бүрийн мэргэжилд ихэнхдээ ахимаг настай хүмүүс зонхилдог байсан, намайг залуу хүнд тооцдог байсан, одоо үед арай дээр болж байна, мэргэжил болгонд залуучуудын эзлэх хувь харьцангуй нэмэгдлээ. Үнэндээ би ч тийм залуу биш болсон, би одоо 43 хүрчихлээ, тавин нас руу явж байна.

## **Фашэнь**

Буддын хөрөгт яагаад нэг орон байдаг вэ? Олон хүн үүнийг тайлбарлаж чаддаггүй, зарим хүн ингэж ярьдаг: “Лам хувраг Буддын хөрөг, барималд ном судар уншсанаас тэдгээрт нэг орон бий болдог.” Өөрөөр хэлбэл лам хувраг тэдгээрийн өмнө бясалгаснаас энэ орон үүсдэг гэсэн үг. Лам хувраг ч бай өөр хэн ч бай бясалгахад гарсан энерги нь нэг зүгт биш харин эргэн тойронд тархах ёстой, хийдийн доторх шал, тааз болон бүх хананд ижил орон үүсэх ёстой. Тэгвэл

яагаад зөвхөн Буддын хөрөг дээрх орон тийм хүчтэй байдаг вэ? Ялангуяа агуйд болон алслагдсан уулс дахь хадан дээр сийлэгдсэн Буддын хөрөг, зурган дээр гол төлөв ийм орон оршдог. Яагаад ийм орон байдаг вэ? Зарим хүн үүнийг ингэж ч нэг, тэгж ч нэг тайлбарладаг ч тодорхой тайлбарлаж чаддаггүй. Үнэндээ Буддын хөрөг ийм оронтой байдаг учир нь түүн дээр гэгээрэгчийн Фашэнь байдаг. Гэгээрэгчийн Фашэнь тэнд байгаа учраас түүнд энерги оршдог.

Шагжамүни ч бай Бодьсадва Гуанинь ч бай, хэрэв тэд үнэхээр түүхэнд байсан юм бол та бүгд бодоод үз дээ, тэд бясалгаж байх хугацаандаа бас л бясаллагчид байгаагүй гэж үү? Хүн Гурамсан ертөнцийн Фа-гаас гараад маш өндөр түвшинд бясалгахад түүнд Фашэнь үүсдэг. Фашэнь хүний дань-тиань-д үүсдэг, энэ нь Фа болон гон-оор бүтдэг, мөн өөр өөр орон зайд илэрдэг. Фашэнь-д тэр хүний асар их сүр хүч байдаг, гэхдээ Фашэнь-ий бодол санаа нь эзэн биед захирагддаг. Тийм ч гэсэн Фашэнь өөрөө бүрэн төгс, бие даасан жинхэнэ бодит оршихуй юм, тэр өөрөө ямар ч зүйлийг бие даан хамааралгүйгээр хийж чадна. Фашэнь-ий хийж байгаа зүйл нь хүний Эзэн бодол (Жу-иши) тухайн зүйлийг яаж хийхийг хүссэнтэй яг адилхан. Хэрэв тэр аливааг ямар нэг байдлаар хийнэ гэвэл, түүний Фашэнь бас тэр байдлаар нь адилхан хийнэ, энэ бол бидний ярьж байгаа Фашэнь юм. Би ямар нэгэн зүйл хийе гэхэд, жишээлбэл жинхэнэ бясалгаж байгаа шавь нарынхаа биенийг засаж өгөх гэх мэт зүйлийг, бүгдийг нь миний Фашэнь хийдэг. Фашэнь энгийн хүнийх шиг биетэй байдаггүй, энэ нь өөр өөр орон зайд илэрдэг. Түүний бие өөрчлөгддөггүй тогтмол бие биш, харин том жижиг болж чаддаг. Заримдаа энэ нь маш том болдог, толгой нь бүгнээрээ харагдахааргүй том болдог;

заримдаа маш жижиг болдог, эсний хэмжээнээс ч жижиг болдог.

## Аравнайлах

Үйлдвэрт бүтээсэн Буддын хөрөг, баримал бол зөвхөн нэг урлагийн бүтээл юм. Аравнайлах гэдэг нь Буддын Фашэнь-ийг Буддын хөрөг, баримал дээр залан ирүүлж энгийн хүмүүсийн дунд бодит биетэй болгон тахин шүтэх явдал байдаг. Бясалгадаг хүн ийм сүсэг бишрэлтэйгээр бясалгахад Буддын хөрөг, баримал дээрх Фашэнь түүний төлөө Фа-г сахин хамгаалж, түүнийг ивээлдээ авч харж хамгаалдаг, энэ бол аравнайлахын жинхэнэ зорилго юм. Үүнийг зүй ёсны зан үйлийн дагуу зөв ариун бодол гаргаж байж л хийнэ, эсвэл маш өндөр түвшний аугаа гэгээрэгч, эсвэл бясалгалын маш өндөр түвшинд хүрсэн ийм чадвартай хүн л энэ зүйлийг хийж чадна.

Сүм хийдэд Буддын хөрөг, баримлыг аравнайлах ёстой гэдэг, аравнайлагдаагүй Буддын хөрөг баримал нь увдистүй гэж ярьдаг. Одоогийн сүм хийдийн лам хуврагуудын дотор жинхэнэ их багш үлдээгүй, бүгд өөд болцгоосон. “Соёлын их хувьсгал”-аас хойш жинхэнэ уламжлагдсан ном заалгаагүй залуу лам хуврагуудын зарим нь одоогийн хийдүүдийн тэргүүн хамба нар болцгоосон, маш олон зүйлс уламжлагдан үлдээгүй. Хэрэв түүнээс “аравнайлахын зорилго юу вэ?” гэж асуувал “аравнайлсны дараа Буддын хөрөг, баримал увдистай болно” гэж л хариулна. Энэ нь яаж увдистай болдгийг тэр тодорхой тайлбарлаж чадахгүй. Иймээс тэр зөвхөн ёс төдий зан үйл хийнэ. Буддын хөрөг, баримал дотор жижиг судар хийж цаасаар нааж битүүмжлээд судар уншаад л аравнайлчихлаа гэнэ. Гэхдээ аравнайлаж чадсан юм уу, үгүй юу? Энэ

нь түүний яаж ном уншихаас шалтгаална. Шагжамүни зөвт бодлыг сургадаг, санаа сэтгэлээ төвлөрүүлэн түүний бясалгаж байгаа номын үүдний оронд цуурайтгал судар уншвал гэгээрэгчийг залан ирүүлж болно. Гэгээрэгчийн Фашэнь-уудын нэг нь Буддын хөрөг, баримал дээр ирэхэд л аравнайлах зорилго үр дүнд хүрнэ.

Зарим лам хувраг ном уншиж байхдаа: “Аравнайлж дууссаны дараа надад хэдийг өгөх бол?” гэж бодож суудаг. Эсвэл номоо уншингаа “тэр, тэр хүмүүс надад их муу хандах юм” гэж бодно. Тэр бас далдуур явуулга хийнэ, бусадтай зөрчилдөнө. Одоо бол Дарма-гийн төгсгөлийн үе, ийм үзэгдэл гарч байгааг үгүйсгэх аргагүй. Бид энд Буддын шашиныг шүүмжилж байгаа юм биш, Дарма-гийн төгсгөлийн үед зарим хийдүүд ариун биш болсон. Толгойд нь иймэрхүү бодол байхад, ийм муу муухай бодол төрж байхад тэр гэгээрэгч ирэх юм уу? Аравнайлах зорилгодоо хүрч огтхон ч чадахгүй. Гэхдээ бүгд тийм биш, зарим цөөн тооны сайн сүм хийдүүд болон Бумбын сүм дутанууд байдаг.

Би нэг хотод нэгэн хуврагийг харсан, хав хар гартай. Тэр Буддын баримал дотор судар хийгээд хайхрамжгүй битүүмжилж байсан, аман дотроо хэдэн үг бувтнаад л аравнайлж дууслаа гэсэн. Дахиад нэг Буддын баримал аваад хэдэн үг бувтнасан, аравнайлах болгондоо дөчин юань авч байсан. Одоогийн лам хуврагууд аравнайлахыг ашиг хонжоо олох хэрэгслээ болгосон. Миний харснаар аравнайлах нь үр дүнтэй болоогүй, тэр ерөөсөө ч үүнийг хийж чадахгүй. Одоогийн лам хуврагууд бүүр ийм юм хийдэг болжээ. Намайг өөр бас юу харсан гээч? Хийд дотор Буддын

сүсэгтэн гэмээр нэг хүн Буддын баримлыг аравнайлж байгаа бололтой, тэр нэг толь бариад нарны гэрлийг Буддын баримал дээр тусгаад аравнайлж боллоо гэсэн. Бүр ийм инээдэмтэй хэмжээнд хүрчихсэн! Өнөөдөр Буддын шашин ийм болтлоо хөгжсөн бөгөөд энэ нь маш түгээмэл үзэгдэл юм.

Нанжин хотод нэг том Буддын хүрэл хөшөөг бүтээж Хонг Конг-ийн Лантау арал дээр босгосон, маш том Буддын хөшөө. Дэлхийн өнцөг булан бүрээс маш олон лам хуврагууд хөшөөг аравнайлахаар ирцгээсэн, тэдний нэг нь толь бариад нарны туяаг Буддын хөшөөний нүүрэн дээр тусгаад аравнайлж байна гэсэн. Тийм том ёслолын сүрлэг үйл ажиллагаанд хүртэл ийм зүйл хийдэг болсон, надад тун харамсалтай санагдсан! Шагжамүни “Дарма-гийн төгсгөлийн үед лам хуврагууд бусдад аврал үзүүлэх нь бүү хэл өөрсдийгөө ч аврахад хэцүү болно” гэж хэлсэнд нь гайхах юм алга. Түүнээс гадна их олон лам хуврагууд Буддын ном судрыг өөрсдийнхөө өнцгөөс тайлбарлаж хөрвүүлсэн, Си Ванму хатан эхийн судар хүртэл хийдийн дотор орчихсон байдаг, Буддын үндсэн номын биш зүйлүүд ч бас хийдийн дотор нэвтрэн орсон, эх захгүй байдал үүсгэсэн, одоо маш эмх замбараагүй байдалтай болсон. Мэдээж жинхэнэ бясалгаж байгаа лам хуврагууд ч бас байдаг, тэд нэлээд сайн. Аравнайлах гэдэг нь үндсэндээ гэгээрэгчийн Фашэнь-ийг залж Буддын хөрөг дээр ирүүлэхийг хэлдэг, энэ бол аравнайлал юм.

Буддын хөрөг, баримлыг аравнайлаагүй бол тахиж болохгүй, тахивал маш ноцтой үр дагавар гарна. Ямар ноцтой үр дагавар гарах вэ? Өнөөгийн хүний бие судлаачид хүний тархины үйл ажиллагаа ба бодол нь нэг төрлийн бие бодь үүсгэдгийг илрүүлсэн. Бид

их өндөр түвшнээс харахад энэ нь үнэхээр бие бодь болохыг олж мэдсэн, гэхдээ энэ нь бидний өнөөгийн судалгаа шинжилгээнд илэрсэн шиг тархины цахилгаан долгион хэлбэртэй биш, харин энэ нь хүний бүхэл бүтэн тархины хэлбэртэй байдаг. Ер нь энгийн хүн аливаа зүйлийн талаар бодоход түүнээс тархины хэлбэртэй зүйл гардаг ба энэ нь энергигүй учраас гарангуутаа удалгүй замхарч алга болдог, харин бясалгадаг хүний энерги халгалагдан үлдэх хутацаа нь хавьгүй удаан байдаг. Буддын хөрөг баримал үйлдвэрт бүтээгдсэний дараа оюун ухаантай болдог гэсэн үг биш. Тийм байдаггүй. Зарим Буддын хөрөг аравнайлагдаагүй байдаг, баримлыг хийдэд авчирсны дараа аравнайлсан ч үр дүнд хүрээгүй байдаг. Хэрэв ямар нэгэн хуурамч чийгон багшаар эсвэл буруу номын хүнээр хийлгэвэл бүр ч аюултай, үнэг эсвэл үен дээр нь гарчихна.

Хэрэв чи аравнайлагдаагүй Буддын хөрөг баримлыг тахин шүтвэл маш аюултай. Энэ нь хэр аюултай вэ? Би хэлсэн, хүн төрөлхтөн өнөөдрийг хүртэл хөгжиж ирэхдээ бүх зүйл нь доройтож ирсэн, бүхэл нийгэм дэх болон бүхэл орчлон ертөнц даяарх бүх зүйлс хойно хойноосоо дараалан доройтож байна, бидний энгийн хүмүүст учирч буй бүх асуудал өөрсдөөс нь үүдэлтэй. Ариун номыг олъё, зөв замаар явъя гэсэн ч их хэцүү, тал талаас үймүүлдэг. Буддад залбирч гуйж мөргөө гэсэн ч аль нь Будда юм? Гуйж мөргөө гэсэн ч маш хэцүү. Итгэхгүй байгаа бол би тайлбарлаж өгье: Аравнайлагдаагүй Буддын хөрөг, барималд эхний хүн залбирч мөргөхөд л хэрэг бишиднэ. Одоо үед хэр олон хүн Буддад залбирч гэгээрлийн хутагт хүрэхийг хүсэж мөргөдөг вэ? Тийм хүн тун цөөн. Буддад мөргөж байгаа ихэнх хүмүүсийн зорилго юу байдаг вэ? Тэд гай

зовлонгоо арилгах, аливаа асуудлаа шийдэх, хөрөнгө мөнгөтэй болохыг л гуйдаг. Буддын пашны сударт ийм зүйл байдаг юм уу? Ийм зүйл огт байхгүй.

Мөнгөний хойноос хөөцөлдөж буй Буддын сүсэгтэн Буддын хөрөг, барималд эсвэл Бодьсадва Гуанинь юм уу Рулай бурхны хөрөг, барималд мөргөж “Мөнгөтэй болоход минь туслаач” гэлээ гэж бодъё. За тэгээд нэг бүрэн бодол үүсчихнэ. Буддын барималд хандсан бодол байсан болохоор тэр даруй Буддын хөрөг дээр бууна. Үүний өөр орон зайн оршихуй нь том жижиг болон хувирч чаддаг, түүнд энэ бодол буухад Буддын хөрөг тархитай болно, бодох чадвартай болно, гэхдээ түүнд бие байхгүй. Өөр хүмүүс бас очиж мөргөнө, энэ мэтээр олон хүн мөргөсөөр түүнд хэсэг энерги өгдөг. Ялангуяа бясалгаж байгаа хүн залбирвал бүр ч аюултай, залбирахад л түүнд аажмаар энерги өгсөөр бодит хэлбэртэй бие үүсгэдэг, гэхдээ энэ бие нь өөр орон зайд үүсдэг. Энэ нь үүссэнийхээ дараа өөр орон зайд орших бөгөөд орчлон ертөнцийн зарчмуудыг бага зэрэг мэддэг болно, иймээс тэр хүний төлөө бага зэрэг зүйл хийнэ, улмаар түүнд багахан гон гардаг, гэхдээ тэр хүмүүст өртөгтэй, болзолтойгоор тусална. Өөр орон зайд тэр чөлөөтэй хөдөлж, энгийн хүмүүсийг хялбархан удирдаж чаддаг. Энэ бодит бие нь Буддын хөрөг, баримлын хэлбэртэй яг адилхан байдаг, хүний залбирал мөргөл нь ингэж хуурамч Бодьсадва Гуанинь, дуураймал Рулай бурхныг бий болгодог, тэдгээр нь Буддын хөрөг, баримлын хэлбэр дүрстэй яг адилхан байдаг. Гэхдээ хуурамч Будда, хуурамч Бодьсадва-гийн бодол нь маш муу, мөнгө хөөцөлддөг. Тэд өөр орон зайд үүсдэг, мөн сэтгэн бодох чадвартай бөгөөд орчлон ертөнцийн зарчмыг бага зэрэг мэднэ, тэр нэг их том муу зүйл хийж зүрхлэхгүй, гэхдээ бага



зэрэг муу зүйл хийчихнэ. Заримдаа бас хүнд тусална, тэгэхгүй тэр чигтээ муу байвал устгагдана. Хүмүүст яаж тусалдаг вэ? Нэг хүн ингэж залбирна, “Будда надад туслаач, манай гэрт нэг маань өвчтэй байна.” За чамд тусалъя. Түүний бодол нь мөнгөний төлөө учраас тэр чамаар хандивын хайрцагт мөнгө хийлгүүлнэ. Хандивын хайрцагт ахиухан мөнгө хийвэл өвчин хурдан эдгэнэ. Тэр тодорхой хэмжээний энергитэй учраас өөр орон зайнаас энгийн хүнийг удирдаж чадна. Ялангуяа гон-той хүн очиж залбирвал бүр ч аюултай. Бясалгагч хүн юу хүсэх гэж? Мөнгө. Та бүхэн боддоо, бясалгаж байгаа хүн мөнгөний хойноос явах ямар хэрэгтэй юм? Гэр бүлийнхээ хүний гай барцад, өвчнийг арилгахын төлөө гуйж залбирах нь гэр бүлийн сэтгэлд зууралдсан болно. Чи бусад хүмүүсийн хувь тавиланд нөлөөлөхийг хүсэж байна гэж үү? Хүн бүр өөрийн гэсэн хувь тавилантай! Чи түүнд мөргөж амандаа бувтнана: “Намайг мөнгөтэй болоход туслаач”, за тэгээд тэр чамд тусална, тэр чамайг улам их мөнгө гуйхыг тэсэж ядан хүлээнэ, чи хэр их мөнгө хүснэ, төдий чинээгээр тэр чамаас улам их зүйлийг авч чадна. Энэ бол тэнцвэртэй солилцоо. Хандивын хайрцагт хүмүүсийн хийсэн хангалттай мөнгө байгаа, тэр энэ мөнгөнөөс чамд өгнө. Яаж өгөх вэ? Үүдээр гарч яваад магадгүй мөнгөтэй түрүүвч олно эсвэл ажлын газар чинь мөнгөн шагнал өгнө, тэр чамайг ямар нэгэн байдлаар мөнгөтэй болгоно. Тэр болзолгүй бол юу гэж чамд туслах юм? Алдахгүй бол олохгүй, түүнд гон хэрэгтэй учраас чиний гон-ыг авна, эсвэл тэр чиний бясалгаж гаргасан үрлийг авна. Тэр үүнийг л авдаг.

Эдгээр хуурамч Будда нар заримдаа маш их аюултай. Тэнгэрийн мэлмий нь нээгдсэн манай олон бясалгагчид Будда-г харсан гэж боддог. Нэг нь

ингэж ярина, өнөөдөр энэ хийдэд хэсэг Будда ирсэн, энэ хэсгийг тийм нэртэй Будда тэргүүлж явсан. Тэр бас өчигдрийн ирсэн хэсэг ямархуу байсан, өнөөдөр ирсэн хэсэг ямар байгааг дүрслэн ярина, мөн нэг хэсэг нь явангуут дараагийнх нь удахгүй ирдэг гэдэг. Тэд нар хэн бэ? Тэд зөвхөн энэ төрөлд харьяалагдана. Тэд жинхэнэ Будда нар биш, тэд бол хуурамч, ийм төрлийнх нэлээд олон байдаг.

Хэрэв хийдийн дотор ийм байдал гарвал бүр ч аюултай. Лам хуврагууд түүнд мөргөвөл, тэднийг тэр удирдана: “Чи надад мөргөж байгаа юм биз дээ? Чи надад тов тодорхой байдлаар мөргөлөө! За, чи бясалгах хүсэлтэй байгаа биз дээ? Би чамайг харж хандъя, би чамд яаж бясалгахыг зааж өгье” гэнэ. Тэр чамд үүнийг зохицуулж өгнө, хэрэв чи бясалгаад дууслаа гэхэд хаашаа явах юм? Бясалгал түүгээр зохицуулагдсан болохоор дээд аль ч Номын үүд чамайг хүлээж авахгүй. Тэр чамд зохицуулж өгсөн болохоор чи хойшид түүнийг л дагах ёстой болно. Чи хий дэмий бясалгасан биш гэж үү? Одоо хүн төрөлхтөн бясалгаад гэгээрлийн хугтийг олно гэвэл маш хэцүү гэж би хэлсэн. Ийм байдал маш түгээмэл байдаг, бидний их олон хүн Буддын туяаг нэртэй уулуудаар, том голын хөвөөгөөр харсан байдаг, тэдний ихэнх нь бүгд энэ төрлийнх, тэд энергитэй, илэрч гарч ирж чаддаг. Жинхэнэ аугаа гэгээрэгчид өөрсдийгөө хамаагүй ил гаргадаггүй.

Урьд өмнө нь тэднийг газрын Будда, газрын Бумба гэж нэрлэдэг байсан, харьцангуй цөөн байсан, харин одоо бол тэд маш олон болсон. Тэд муу зүйл хийхэд дээгүүр бас тэднийг устгана, тэр үед тэд зугтаж Буддын хөрөг, баримал дээр гардаг. Энгийн хүний зарчимд аугаа гэгээрэгчид тэр болгон оролцоод байдаггүй,

аугаа гэгээрэгчийн түвшин өндөр байх тусам энгийн хүмүүсийн зарчмыг бүр ч эвдэхгүй, жаахан ч оролцохгүй. Тэд яадаг ч байсан Буддын хөрөг, баримлыг аянгаар гэнэт ниргэхгүй, ийм зүйл хийхгүй, иймээс тэд Буддын хөрөг, баримал дээр гарвал дээд амь боднуд оролдохгүй зүгээр орхино. Түүнийг устгах болоход тэр мэдээд зугтахыг оролдоно. Тэгэхээр чиний харсан Бодьсадва Гуанинь, жинхэнэ Бодьсадва Гуанинь мөн үү? Чиний харсан Будда, жинхэнэ Будда мөн үү? Хэлэхэд тун хэцүү.

Та нарын олонх нь ийм нэг асуудлын талаар бодож магадгүй: “Бид гэртээ байгаа Буддын баримлыг яах вэ?” Магадгүй олон хүн намайг санасан. Сурагчдынхаа бясалгалд туслахын тулд би чамд ингэж хийж болохыг хэлье: Чи миний номыг аваад (учир нь миний фото зураг номд байгаа) эсвэл миний фото зургийг гаргаад, гаргаа Буддын баримлаа том лянхуа цэцгийн мутрын барилт хийж бариад надаас гуйж байгаатай адил аравнайлж өгөхийг Багшаасаа хүс. Хагас минутын дотор энэ нь шийдэгдэнэ. Та нарт хэлэхэд үүнийг зөвхөн манай бясалгагчдад хийж өгч болно, аравнайлах нь танай хамаатан саданд болон найз нөхдөд үйлчлэхгүй, бид зөвхөн бясалгаж байгаа хүнийг л харж хандана. Зарим хүн багшийнхаа фото зургийг хамаатан садан, найз нөхдийнхөө гэрт тавьж муу сүнснийг зайлуулах гэдэг, би энд энгийн хүмүүст муу сүнснийг зайлуулж өгөхийн тулд байгаа юм биш. Энэ бол Багшийгаа тун үл хүндэтгэсэн явдал юм.

Газрын Будда, газрын Бумбын талаар ярья. Бас өөр нэг байдал байдаг, эртний Хятадад их олон хүн алс ууланд, ой хөвчид бясалгадаг байсан. Яагаад одоо алга болсон бэ? Үнэндээ алга болсон юм биш, харин

энгийн хүмүүст мэдүүлэхгүй, тэд жаахан ч цөөрөөгүй, тэдгээр хүмүүс бүгд ер бусын чадвартай. Сүүлийн жилүүдэд тэд алга болсон юм биш, бүгд тэнд байсаар л байгаа. Одоо дэлхий дээр хэдэн мянгаараа байдаг, манай оронд харьцангуй олон байдаг. Ялангуяа тэдгээр нэртэй том уулс, гол мөрний дагуу байдаг, зарим өндөр уулнуудад ч бас байдаг. Тэд агуйнхаа үүдийг ер бусын чадвараар хаадаг, тэгэхээр чамд тэдний байгаа нь харагдахгүй. Тэдний бясалгалын явц нь их удаан, арга нь харьцангуй болхи, бясалгалын гол үндсийг барьж авч чадаагүй. Харин бид шууд хүний сэтгэл рүү чиглэдэг, орчлон ертөнцийн хамгийн дээд мөн чанарын дагуу бясалгадаг, орчлон ертөнцийн хэлбэрт тохируулан бясалгадаг, мэдээж гон их хурдан өснө. Ягаад гэвэл бясалгалын арга нь пирамид хэлбэртэй адил байдаг, зөвхөн төвийн зам нь гол зам юм. Тэдгээр хажуугийн буюу жижиг замаар бясалгахад шиньшиний түвшин заавал өндөр байх албагүй, бясалгаад өндөрт хүрээгүй байхад гон нь нээгдэж болно, гэхдээ тэр нь жинхэнэ бясалгалын гол замаас маш хол.

Тэд бас шавьд уламжлан заадаг, тэдний шиньшиний хэмжээ тийм л хэмжээнд хязгаарлагдмал учраас бясалгалаар зөвхөн тэр л түвшинд хүрч чадна, тиймээс уламжлан авсан шавь нар нь бас бясалгаад зөвхөн тийм л өндөрт хүрнэ. Дэлхийн жижиг замын бясалгалууд зах руугаа ойртох тусам улам их ярвигтай болдог, бясалгалын арга нь бас төвөгтэй, голыг нь барьж бясалгаж чаддаггүй. Хүн бясалгахад гол нь шиньшинийг бясалгах хэрэгтэй, тэд үүнийг ойлгодоггүй, бэрхшээл зовлон туулж байж бясалгана гэж үздэг. Иймээс тэд их урт хугацааны дараа буюу хэдэн зуун жилээр, мянга гаруй жил бясалгаж байж бага зэрэг гон олж авдаг. Үнэндээ тэд зовлон туулснаар гон олж авсан

гом биш, тэд яаж гон-той болсон бэ? Жирийн хүнтэй адил, залуудаа янз бүрийн зууралдсан сэтгэлд автсан байдаг; он жилүүд өнгөрч хөгшрөх тусам ирээдүйдээ найдах итгэлгүй болно, зууралдсан сэтгэлүүд нь аяндаа орхигдож сэмрэн алга болдог, тэдгээр хажуу замын бясалгалууд бас энэ аргыг хэрэглэдэг. Тэд ховсдолын байдалд бясалган сууж, зовлон зүдүүрийг туулан дээш бясалгахад бас гон нь өсдөг гэж олж мэдсэн. Гэвч тэдний энгийн хүний зууралдсан сэтгэл нь урт удаан, хүнд хэцүү он жилүүдийн туршид аажмаар сэмрэн алга болсноос, эсвэл тэдгээр сэтгэл нь аажмаар хаягдсанаас гон нь өссөн гэдгийг мэддэггүй.

Бидний бясалгал бол хүний зууралдсан сэтгэл рүү шууд чиглэдэг, тухайн сэтгэлийг нь жинхэнэ зааж өгдөг, тэр сэтгэлийг орхисноор бясалгал маш хурдан болно. Би зарим газраар явж байхдаа олон жилээр бясалгасан тийм хүмүүстэй их тааралддаг байсан. Тэд, “Биднийг энд байгааг хэн ч мэдэхгүй, таны хийж байгаа зүйлд бид оролцохгүй, саад болохгүй” гэдэг. Эдгээр хүмүүс харьцангуй сайн талд харьяалагддаг.

Бас зарим муу талынхан ч байдаг, мууд нь бид бас арга хэмжээ авна. Жишээлбэл би Гүйжоу хотод анх удаа хичээл зааж байхад нэг хүн намайг хайж ирээд түүний өвгөн багш нь надтай уулзахыг хүсэж байна гэсэн. Тэр өвгөн багшийнхаа хэн болохыг, түүний хэр олон жил бясалгасан талаар ярьсан. Надад тэр хүн билиг чий-тэй, зэвхий царайтай хүйтэн харагдсан. Надад түүнтэй уулзах зав алга байна гэж хэлээд буцаасан. Улмаар түүний өвгөн багш нь их дургүйцэж надад төвөг учруулж эхэлсэн, өдөр болгон намайг үймүүлдэг болсон. Би хүнтэй тэмцэлдэх дургүй, түүнтэй тэмцэлдэх ч шаардлага байхгүй. Тэр муу зүйл

авчрах болгонд би зүгээр л түүнийг нь арилгаад лекцээ үргэлжлүүлдэг байсан.

Мин гүрний үед Бумбын нэг бясалгагч байсан, түүнийг бясалгаж байх үед могойн сүнс биед нь шүглэсэн. Сүүлд нь тэр бясалгаад үр дүнд хүрч чадалгүй нас барсан, тэр могой энэ Бумбын бясалгагчийн биенийг эзэмдээд хүний дүрээр бясалгасан. Нөгөө хүний өвгөн багш нь хүн хэлбэртэй тэр могой байсан. Түүний мөн чанар нь өөрчлөгдөөгүй учраас тэр аварга могой болж хувираад намайг үймүүлсэн. Надад тэр дэндүү хэтэрч байгаа санагдсан, тэгээд түүнийг гартаа барьж аваад “хайлуулах гон” гэдэг маш хүчтэй гон хэрэглэж доод биенийг нь ус болгон хайлуулсан, түүний дээд бие нь зугтсан.

Нэг өдөр манай Гүйжоу хот дахь дадлагажуулах төвийн зааварлагчтай тэр хүний шавь нь ирж уулзаад, түүний өвгөн багш тэр эмэгтэйтэй уулзахыг хүсэж байна гэсэн. Зааварлагч уулзахаар очсон, агуй руу ороход хав харанхуйд сууж байгаа ногооноор гэрэлтсэн нүдтэй хүний дүрснээс өөр юу ч харагдаагүй, түүний нүд нээгдэхэд агуй нь гэрэлтэж, нүдээ анихад нь агуй харанхуй болж байсан. Тэр нутгийн хэллэгээр ярьсан: “Ли Хонжи дахин ирэх болно, энэ удаа бидний хэн нь ч түүнд төвөг учруулахгүй, би буруу юм хийсэн, Ли Хонжи хүмүүст аврал үзүүлэхээр ирсэн.” Түүний шавь: “Өвгөн багшаа бос доо, хөл чинь яасан бэ?” гэж асуусан. Тэр, “Би босож чадахгүй болсон, миний хөл гэмтсэн” гэж харуулсан. Яагаад гэмтсэнийг асуухад тэр өөрийнхөө хэрхэн саад болж төвөг учруулсан тухайгаа ярьсан. Бээжингийн 1993 оны Дорно дахины эрүүл мэндийн үзэсгэлэн яармаг дээр тэр дахин надад саад болсон. Тэр үргэлж муу юм хийж, намайг

Дафа-г заахад саад учруулсан учраас би түүнийг бүрмөсөн устгасан. Түүнийг устгасны дараа, түүний хамсаатнууд нь хөгшин залуугүй, эрэгтэй эмэгтэйгүй цөм ирж тэмцэлдэхийг хүссэн. Тэр үед би тэдэнд хэдэн үг хэлсэн. Тэд бүгд цочин айж хэн нь ч юу ч хийж зүрхлээгүй, тэд юу болсныг ойлгосон. Тэдний дунд зарим нь их удаан хугацаанд бясалгасан ч бүрэн энгийн хүн хэвээрээ байсан. Аравнайлах асуудалтай холбогдуулан энэ хэдэн жишээг авч ярилаа.

### **Жү Ю Кэ (Ид пидийн анги зүйл)**

“Жү Ю Кэ” гэж юу вэ? Бясалгалын хүрээнд маш олон хүн чийгөн заах явцдаа үүнийг ч бас бясалгалын нэг зүйл болгон заадаг, үнэндээ энэ бол бясалгалын хүрээний зүйл биш. Энэ бол арга барил, тарни, мэргэжил уламжилж байгаатай адил юм. Тэд үүнийг дүрс тэмдэг зурах, хүж уугиулах, цаас шатаах, тарни унших, шившлэг хийх гэх мэтийн хэлбэрээр хийдэг, энэ нь өвчнийг эдгээж чадна, өвчин эдгээх арга нь маш их өвөрмөц. Жишээлбэл нүүрэн дээр нь хатги гарсан хүн байвал тэр бийрээ улаан шунханд дүрээд газар дээр тойрог зурна, тойргийн голд загалмай хэрээс зурна, энэ хүнийг тойргийн дунд зогсоогоод тэр тарни уншиж эхэлнэ. Дараа нь бийрээ улаан шунханд дүрээд түүний нүүрэн дээр тойргууд зурна, зурангаа тарни уншина, зурсаар хатгин дээр очиж нэг цэг тавина, тарниа ч уншиж дуусна, одоо зүгээр болсон гэж хэлнэ. Нөгөө хүн хатгиа тэмтэрч үзэхэд үнэхээр жижгэрч өвдөхгүй болсон байна, үр дүн гарсан. Тэр хөнгөн өвчнийг эдгээж чадна харин хүнд өвчнийг бол чадахгүй. Гар өвдвөл яах вэ? Тэр тарни уншиж эхлэнгээ чамайг гараа алдал гэнэ, нэг гарын чинь хэгү сүвэнд үлээнэ, нөгөө гарын хэгү сүвээр гаргана, чи

хөнгөн салхи сэвэлзэхийг мэдэрнэ, гараа бариад үзэхэд урьдынх шиг өвдөхөө больсон байна. Мөн зарим нь цаас шатаах, дүрс тэмдэг зурах, дүрс тэмдэг наах гэх мэтийн арга хэрэглэдэг, тэд ниймэрхүү л зүйл хийдэг.

Бумбын системийн дэлхийн жижиг замд бясалгахад амь биеийг бясалгахыг ярьдаггүй. Тэд мэрэг төлөг үзэх, фэнг-шүй шинжих, муу сүнсийг зайлуулах, мөн өвчин эдгээхийг л хийдэг. Эдгээр аргуудыг ихэвчлэн дэлхийн жижиг замын урсгалд хэрэглэдэг. Тэр нь өвчнийг эдгээж чадна, гэхдээ тэдний хэрэглэдэг арга нь сайн биш. Бид тэдний өвчин эдгээхдээ юу хэрэглэдгийг яриад яах вэ, манай Дафа-гийн бясалгагчид тэдгээрийг хэрэглэж болохгүй, яагаад гэвэл тэдгээр нь их доод түвшнийх ба маш муу мэдээлэл агуулдаг. Эртний Хятадад эмчилгээний аргуудыг анги зүйл болгон хуваадаг байсан. Жишээ нь: Яс барих арга, зүү төөнүүр, массаж, бариа засал, цэг дарах, чийгөн эмчилгээ, эмийн ургамлаар эдгээх гэх мэт олон ангилалд хуваадаг. Өвчин эдгээх арга болгоныг нэг анги зүйл гэдэг, энэ “Жү Ю Кэ” арван гуравдугаарт ордог учраас түүний бүтэн нэрийг “Жү Ю Ши Сан Кэ” гэж нэрлэдэг. “Жү Ю Кэ” бол манай бясалгалын хүрээнд харьяалагдах зүйл биш, тэр нь бясалгалаар гаргасан гон биш, харин энэ бол нэг төрлийн арга удвдсын зүйл юм.





# Зургаадугаар лекц

## Бясалгалын солиорол

Бясалгалын хүрээнд бясалгалын солиорол гэдэг нэг яриа байдаг, энэ нь нийтэд нэлээд хүчтэй нөлөөлсөн. Ялангуяа зарим хүмүүс энэ талаар хэт дэгсдүүлж цуурхал тарааснаас болж зарим хүн чийгон-оор хичээллэхээс айдаг болсон. Хүмүүс чийгон-оор хичээллэхэд бясалгалын солиорол болдог гэж сонсчихоод бясалгахаас зүрхшээдэг. Би та бүгдэд хэлэхэд үнэндээ бясалгалын солиорол гэж огт байдаггүй.

Нэлээд олон хүний сэтгэл нь зөв биш байдгаас сүнс ба амьтдыг өөртөө татдаг. Тэдний Эзэн бодол нь өөрийгөө удирдаж чадаагүй, харин үүнийг тэд гон гэж андуурдаг. Биед нь шүглэсэн сүнс тэднийг эзэмдэж, ухаан мэдрэлийг нь үймүүлж орилж хашхируулна. Хүмүүс чийгон-оор хичээллэхэд ийм болдог гэж хараад бясалгал хийхээс зүрхшээдэг. Олон хүн үүнийг чийгон гэж боддог, гэхдээ үүнийг яаж чийгон бясалгал гэх юм? Энэ бол зөвхөн өвчин эдгээх, бие сайжруулах талын хамгийн доод хэлбэр, гэвч энэ нь маш их аюултай. Чи өөрөө ингэж хийгээд хэвшвэл чиний Эзэн бодол өөрийгөө байнга удирдаж чадахгүй болно, тэгээд чиний бие магадгүй Дэд бодлоор, гадны мэдээллээр, шүглэсэн сүнс ба амьтан гэх мэтээр эзэмдүүлнэ, чи магадгүй зарим аюултай үйлдэлд автаж бясалгагчдын хүрээнд том хор хохирол учруулна. Энэ бол хүний бодол санаа зөв биш байснаас, өөрийгөө гайхуулах сэтгэлд автсанаас болдог, энэ бол бясалгалын солиорол биш. Зарим хүнийг яаж чийгон багш болсныг нь мэдэхгүй юм, тэд ч бас бясалгалын солиорлыг ярьдаг. Үнэндээ чийгон-

оор хичээллэхэд бясалгалын солинорол гэж гардаггүй, ихэнх хүн энэ үгийн талаар уран зохиол, ушу-гийн ном гэх мэтээс мэдэж авсан байдаг. Үнэмшихгүй бол чи эртний номуудаас эсвэл бясалгалын номуудаас хайж үзэж болно, ийм зүйл тэнд байхгүй. Бясалгалын солинорол гэж яаж байх юм? Үндсэндээ ийм зүйл гарах боломжгүй.

Хүмүүс бясалгалын солиноролыг хэд хэдэн хэлбэртэй байдаг гэж үздэг, миний сая дурдсан бол эдгээр хэлбэрийн нэг нь юм. Хүн буруу бодол санаанаасаа болж сүнс болон амьтныг өөртөө шүтгүүлдэг, мөн ямар нэгэн чийгон байдал хөөцөлдөж өөрийгөө гайхуулах гэх мэт янз бүрийн сэтгэлтэй байдаг. Зарим нь шууд ер бусын чадвартай болохын хойноос хөөцөлддөг, эсвэл хуурамч чийгон-оор хичээллэдэг, тэд чийгон-оор хичээллэхдээ өөрийнхөө Эзэн бодлыг сул тавиад сурчихсан байдаг, юу болж байгаагаа ч мэдэхгүй болж биеэ бусдад өгнө. Тэдний оюун санаа нь баларч бие нь тэдний Дэд бодлоор эсвэл гаднын мэдээллээр эзэмдүүлж зарим хэвийн бус зан авир гаргадаг. Тэр хүнийг байрнаас үсэр гэвэл тэр үсэрнэ, түүнийг ус руу үсэр гэвэл тэр ус руу үсрээд орно. Тэр өөрөө амьдрахыг ч хүсэхгүй болж бусдад биеэ өгчихдөг. Энэ бол бясалгалын солинорол биш, харин буруу замаар чийгон-оор хичээллэснийх, эхэндээ санаатайгаар ингэж хийдэг байснаас болсон. Олон хүн өөрийн мэдэлгүй биеэрээ ганхан савлаж байхыг чийгон дасгал гэж үздэг, хэрэв үнэхээр ийм байдалтайгаар дасгал хийх юм бол маш ноцтой үр дагаварт хүргэнэ. Энэ бол чийгон дасгал биш, харин энгийн хүний зууралдсан сэтгэл буюу хөөцөлдөх сэтгэлээс үүдэлтэй.

Чийгон-оор хичээллэхэд гардаг өөр нэг байдал бол, чий нь биений хаа нэгтээ түгжрэхэд юм уу эсвэл чий толгойн оройд гараад бууж өгөхгүй болоход хүн айдаг. Хүний бие бол нэг жижиг орчлон ертөнц, ялангуяа Бумбын системийн бясалгалд, чий гарц дундуур нэвтрэхэд ийм төвөгтэй байдал гарч болно, нэвтэрч чадахгүй бол чий тэндээ эргэлдсээр байдаг. Зөвхөн толгойн оройд ч биш биений бусад хэсэгт бас ийм байдал гардаг, гэхдээ хүний хамгийн мэдрэмтгий газар бол толгойн орой юм. Чий толгойн оройд гарч ирээд дараа нь доош буухдаа гарцаар нэвтэрч чадахгүй үед түүний толгой нь хүнд оргиж хөөсөн мэт санагдана, зузаан чий-н малгай өмссөн юм шиг мэдрэмж төрдөг. Гэхдээ чий бол юунд ч нөлөөлөхгүй, ямар ч хүндэрл бэрхшээл учруулахгүй, мөн ямар нэгэн өвчин үүсгэх шалтгаан болохгүй. Зарим хүн чийгон-ы талаарх үнэнийг мэддэггүй, тэд учир битүүлэг тайлбар хийж замбараагүй байдал үүсгэсэн. Хүмүүс чий толгойн оройд гараад бууж ирэхгүй бол бясалгалын солноролд ордог, замаа алддаг гэх мэтээр ойлгодог, эцэст нь олон хүн үүнээс болж айдаг болсон.

Чий толгойн оройд гараад буухгүй бол энэ нь зөвхөн түр зуурын байдал юм, зарим хүний хувьд энэ нь их удаан хугацаагаар үргэлжилж болно, хагас жил болсон ч бууж ирэхгүй байж мэднэ. Хэрэв тийм байвал жинхэнэ чийгон багш олоод буулгуулж болно. Тэгвэл бид бясалгал хийхэд аливаа чий гарцаар нэвтэрч чадахгүй байвал, чий нь бууж ирэхгүй бол өөрийнхөө шиньшин-ээс шалтгааныг нь хай, аль нэг түвшинд хэтэрхий удаанаар гацсан юм биш үү, шиньшин-ээ дээшлүүлэх хэрэгтэй! Чи шиньшин-ээ үнэхээр дээшлүүлэх юм бол чий доош буухыг үзнэ. Чи нэг л хэвээрээ биедээ гон хувиргахыг чухалчлаад

шиньшин-ээ сайжруулахад анхаарахгүй байвал тэр нь чиний шиньшин дээшлэхийг хүлээж байдаг, тэгсэн цагт л бүхэлдээ өөрчлөлт гарна. Хүний чий хаагдаж саатсанаас болж ямар ч асуудал үүсэхгүй, энэ нь ихэнхдээ бидний өөрсдийн сэтгэл санаанаас болдог, мөн хуурамч чийгон багш нар чий толгойн оройд гараад гацвал байдал бишиднэ гэж хэлэхийг нь сонсоод зарим хүн айдаг. Ингэж айвал түүнд үнэхээр гай болж магад. Чи айж байвал энэ нь айх сэтгэл, энэ нь зууралдсан сэтгэл биш гэж үү? Чамд зууралдсан сэтгэл гарч ирэхэд түүнийг хаях ёстой биш гэж үү? Айх тусам энэ нь улам өвчин мэт болно, энэ зууралдсан сэтгэлийг заавал орхих шаардлагатай. Чи энэ сургамжаас суралцсанаар айх сэтгэлээ орхиж дээшилнэ.

Бясалгач хүн цаашдын бясалгалдаа таатай байж чадахгүй, учир нь түүний биед олон янзын гон гарна, бүгд маш их хүчтэй зүйлс байдаг, чиний бие дотуур ийш тийш хөдлөхдөө чамайг ингэж ч нэг эвгүйцүүлж тэгж ч нэг эвгүйцүүлнэ. Чиний таагүй байгаа учир нь чи өөрийгөө үргэлж ямар нэгэн өвчин туссан байх гэж айдгаас юм. Үнэндээ чиний биед маш хүчирхэг зүйлс гарч ирсэн, тэдгээр нь бүгд гон, ер бусын чадварууд юм, мөн олон амь бодиуд гардаг. Тэд хөдлөхөд чиний бие загатнана, өвдөнө, тавгүйрхэнэ гэх мэт. Мэдрэлийн төгсгөлүүд маш мэдрэмтгий байдаг тул янз бүрийн байдал гарч болно. Чиний бие дээд энергийн бие бодиор бүрэн хувираагүй л бол чамд ийм мэдрэмжүүд байх болно, уг нь бол энэ нь сайн зүйл юм. Бясалгадаг хүний хувьд, хэрэв чи өөрийгөө үргэлж энгийн хүн шиг үзэж, юм л болбол өвчин гэж бодоод байвал яаж бясалгах юм? Бясалгалын явцад саад бэрхшээл тохиолдоход чи өөрийгөө энгийн хүнтэй адил үзсэн хэвээр байвал, би үүнийг чиний шиньшин тэр үед

энгийн хүний түвшинд унасан гэж хэлнэ. Хамгийн наад захын энэ асуудал дээр чи энгийн хүний түвшинд унасан.

Бид жинхэнэ бясалгаж байгаа хүний хувьд асуудалд их өндөр түвшнээс хандах хэрэгтэй, энгийн хүний байр сууринаас харж болохгүй. Чи өөрийгөө өвчтэй байна гэж бодоход энэ нь өвчинд хүргэж болзошгүй юм. Учир нь чи өвдсөн гэж бодсон даруйд, чиний шиньшин энгийн хүнийхтэй адил болно. Чийгон дасгалд болон жинхэнэ бясалгалд, ялангуяа ийм байдал нь өвчин үүсгэдэггүй. Та бүгд мэдэж байгаа, үнэндээ хүний өвчний 70 хувь нь сэтгэл санааных, 30 хувь нь бие махбодынх байдаг. Ер нь хүн сэтгэл санаагаар эхлээд унаж сэтгэлийн тэвчээр нь алдрахад, сэтгэл санааны хүнд дарамтад орж шаналдаг, улмаар өвчний байдлыг огцом хүндрүүлдэг, ер нь ийм л байдаг. Нэг жишээ дурдахад, урьд өмнө нэг хүнийг ортой нь хүлээд гарыг нь барьж байгаад, зүсэж цусыг нь гоожуулна гэж түүнд хэлсэн. Тэгээд нүдийг нь боогоод бугуйн дээр нь юмаар зурсан (түүний гарыг зүсэж цусыг нь гоожуулаагүй), тэгээд усны гоожуурыг онгойлгоод түүнд ус дуслахыг сонсгоход тэр өөрийнх нь цус дусалж байна гэж бодсон, тэгээд тэр хүн удалгүй нас барсан. Үнэндээ түүнээс жаахан ч цус гараагүй, гоожуурын ус л дусалж байсан, түүний сэтгэл санаа үхэлд хүргэх шалтгаан нь болсон. Чи өөрийгөө үргэлж өвчтэй гэж бодоод байвал, магадгүй чи өөрийгөө өвчинд хүргэнэ. Яагаад гэвэл чиний шиньшин энгийн хүний түвшинд унасан, тэгвэл энгийн хүн мэдээж өвчин тусна.

Бясалгадаг хүн үүнийг үргэлж өвчин гэж бодоод байвал үнэндээ чи хүсэж байгаатай адил, чи өвчин

хүсвэл чиний биед өвчин ирнэ. Бясалгагчийн хувьд чиний шиньшин-ий түвшин өндөр байх хэрэгтэй. Чи үүнийг өвчин гэж битгий санаа зов, өвчин гэж айвал энэ нь бас зууралдсан сэтгэл юм, чамд мөн адил гай авчирч мэднэ. Бясалгалд нүглийг арилгах хэрэгтэй, нүглийг арилгахад зовно, ая тухтай байдлаар гон-оо өсгөнө гэж байхгүй! Өөрөөр хэлбэл чи зууралдсан сэтгэлээсээ яаж салах юм? Би та нарт Буддын шашны нэгэн түүхийг ярь: Урьд өмнө нэг хүн маш их чармайж бясалгасны эцэст Архад түвшинд хүрсэн. Тэрээр бясалгалынхаа төгс үр дүнд хүрч Архад болох гэж байхад яаж баярлахгүй байх билээ? Гурамсан ертөнцийн хязгаарыг давж гарах гэж байна! Гэсэн хэдий ч энэ хөөрөх сэтгэл нь бас зууралдсан сэтгэл, баярлах сэтгэл юм. Архадад бол үйлгүй, сэтгэл хөдлөлгүй болсон байх ёстой, гэвч тэр унасан, үр дүнгүй бясалгасан. Үр дүнгүй бясалгасан учраас дахиж шинээр эхлэх хэрэгтэй болсон, тэр дахин бясалгаж маш их чармайсны эцэст буцаад дээшилсэн. Энэ удаад тэр айж өөртөө сануулсан: “Би баярлаж болохгүй, тэгвэл дахиад унана.” Ингэж айснаас болоод тэр дахиад л унасан. Айх бол бас нэг төрлийн зууралдсан сэтгэл юм.

Өөр нэг байдал нь, хүн сэтгэл мэдрэлийн өвчин тусвал түүнд бясалгалын солинорол гэсэн нэр зүүчихдэг. Зарим хүн бас намайг түүний сэтгэл мэдрэлийн өвчнийг эдгээхийг хүлээдэг! Би сэтгэл мэдрэлийн өвчнийг өвчин биш гэж хэлнэ, надад ч ийм зүйлд гаргах цаг зав байхгүй, яагаад вэ? Яагаад гэвэл сэтгэл мэдрэлийн өвчтэй хүнд ямар ч вирус байхгүй биед нь ямар ч өвчин эмгэг байхгүй, үрэвсэл ч байхгүй, минийхээр бол энэ нь өвчин биш. Сэтгэл мэдрэлийн өвчин бол хүний Эзэн бодол (Жу-иши) хэтэрхий

суларснаас болдог. Ямар хэмжээнд хүртлээ сулардаг вэ? Хүн өөртөө эзэн болж чадахгүйтэй адил, сэтгэл мэдрэлийн өвчтэй хүний Эзэн сүнс нь яг л ийм байдаг. Энэ нь өөрийнхөө биед эзэн байх хүсэлгүй болдог, тэр үргэлж мансуурсан байдалд байдаг, сэргэг байж чаддаггүй. Энэ үед Дэд бодол (Фу-иши) нь эсвэл гаднын мэдээлэл түүнийг үймүүлнэ. Орон зай болгонд маш олон давхарга байдаг, янз бүрийн мэдээллүүд түүнийг үймүүлнэ. Түүнээс гадна Эзэн сүнс урьд амьдралууддаа зарим муу зүйлс хийсэн байж магадгүй, бас авлагатай хүн магадгүй түүнийг хорлоно, янз бүрийн асуудал гарч болно. Би сэтгэл мэдрэлийн өвчин ийм л учиртай гэж хэлнэ. Би яаж чамайг эдгээх юм? Жинхэнэ сэтгэл мэдрэлийн өвчин ингэж л тусдаг. Тэгвэл яах вэ? Энэ хүнийг хүмүүжүүлнэ, түүнийг сэргэг болгоно, гэхдээ үүнийг хийхэд маш хэцүү. Сэтгэл мэдрэлийн эмнэлэгт эмч гартаа цахилгаан бороохой барингуут тэр айж дорхноо дэмий юм ярихаа больдгийг харж болно. Яагаад вэ? Тэр үед түүний Эзэн сүнс нь сэргэг болдог, тэр цахилгаанаар цохнулахаас айна.

Ер нь хүн бясалгалын замаар орсон бол үргэлжлүүлэхийг хүсдэг, хүн болгонд Буддын мөн чанар байдаг, мөн Бумбад бясалгах сэтгэл байдаг, тиймээс нэгэнт бясалгалд суралцвал маш олон хүн насан туршдаа бясалгах болно. Тэд бясалгаад үр дүнд хүрч чадах чадахгүй нь, Фа-г олж авах үгүй нь хамаагүй, ямар ч байсан Бумбын замаар замнах сэтгэлтэй, бясалгахыг үргэлж хүсдэг. Хүмүүс түүнийг чийгон-оор хичээллэдэг гэдгийг мэднэ, түүний ажлын газрынхан нь мэднэ, ойр орчныхон нь, бас хөршүүд нь ч бүгд мэднэ. Гэхдээ та нар энэ талаар боддоо, хэдэн жилийн өмнө жинхэнэ бясалгалыг хэн хийж байсан бэ? Хэн ч хийж байгаагүй, зөвхөн жинхэнэ бясалгахад



л түүний амьдралын замыг өөрчилж өгч болно. Харин энгийн хүний хувьд тэр зөвхөн өвчнөө эдгээх, бие сайжруулахын тулд чийгон-оор хичээллэж байгаа, хэн түүний амьдралын замыг нь өөрчилж өгөх юм? Энгийн хүн учраас хэзээ нэгэн цагт өвчин тусна, хэзээ нэгэн цагт ямар нэгэн гай зовлонтой учирна, хэзээ нэгэн цагт магадгүй сэтгэл мэдрэлийн өвчтэй болно эсвэл үхнэ, энгийн хүний бүхэл амьдрал ийм л байдаг. Чи түүнийг цэцэрлэгт хүрээлэнд чийгон-оор хичээллэж байхыг харсан, үнэн хэрэгтээ тэр жинхэнэ бясалгаж байгаа юм биш, хэдийгээр тэр дээд түвшин рүү бясалгах хүсэлтэй байсан ч ариун Фа олж авахгүй л бол тэр чадахгүй. Түүнд дээд түвшин рүү бясалгах хүсэл л байдаг гэхдээ тэр өвчин арилгах, бие сайжруулах доод түвшний бясалгагч хэвээрээ. Хэн ч түүний амьдралын замыг өөрчилж өгөхгүй, тэгвэл тэр өвчин тусна. Дэ-г эрхэмлэхгүй бол өвчин эдгэрэхгүй, чийгон-оор хичээллэх л юм бол хүн өвдөхгүй гэсэн үг биш.

Хүн жинхэнэ бясалгах хэрэгтэй, өөрийнхөө шиньшин-д анхаарах ёстой, зөвхөн жинхэнэ бясалгалаар л хүний өвчин арилж болно. Яагаад гэвэл чийгон бясалгал бол биений тамирын дасгал биш харин энгийн хүний түвшнээс давсан зүйл юм, тиймээс бясалгагчдад тавигдах зарчим болон шалгуур нь бүр өндөр байх ёстой. Үүнийг чанд даган мөрдсөнөөр зорилгодоо хүрнэ. Гэхдээ маш олон хүн ингэж хийдэггүй, тэгвэл энгийн хүн хэвээрээ л үлдэнэ, тиймээс цаг нь болоход тэр өвчин тусна. Энэ хүн магадгүй нэг өдөр толгойд нь цус харвана, гэнэт ямар нэгэн өвчин тусна, эсвэл нэг өдөр сэтгэл мэдрэлийн өвчтэй болно. Хүмүүс түүнийг чийгон-оор хичээллэдэг гэдгийг нь мэднэ, түүнийг сэтгэл мэдрэлийн өвчтэй

болмогц бясалгалын солиорол туссан гэж хэлнэ, тийм нэр зүүчихдэг. Та бүгд боддоо, ингэж хэлж болох юм уу? Хөндлөнгийн хүн учрыг нь мэдэхгүй, мэргэжлийн хүнд болон бясалгадаг олон хүмүүст үүний үнэн учир шалтгааныг мэдэхэд хэцүү байдаг. Хэрэв энэ хүн гэртээ сэтгэл мэдрэлийн өвчтэй болсон бол, бас ч гэж яах вэ, гэхдээ л хүмүүс бас чийгон бясалгалаас болсон гэж ярина; хэрэв тэр дасгалын газар сэтгэл мэдрэлийн өвчин тусвал сүйд болно, түүнд муу нэр зүүнэ, арилгах аргагүй. Чийгон-оор хичээллээд бясалгалын солиорол туссан гээд сонин дээр хэвлэгдэнэ. Зарим хүн учрыг нь мэдэхгүйгээр чийгон-ыг эсэргүүцдэг: “Хардаа, саяхан энд чийгон дасгал хийгээд зүв зүгээр байсан хүн одоо ийм болчихлоо” гэнэ. Энгийн хүний хувьд түүнд юу л тохиолдох ёстой байсан тохиолдоно. Тэр магадгүй өөр өвчин тусна, эсвэл өөр гай зовлонтой учирна, бүгдийг чийгон бясалгалаас болсон гэж буруутгах нь үндэслэлтэй гэж үү? Энэ нь эмнэлгийн эмчтэй адилхан юм, эмч болсон болохоор бүх насаараа өвдөх учиргүй, ингэж ойлгож болох юм уу?

Иймээс маш олон хүн чийгон-ы үнэн байдлыг ойлгохгүйгээс, цаадах учрыг нь мэдэхгүйгээс хамаагүй ярьдаг гэж хэлж болно. Ямар нэгэн асуудал гарангуут чийгон-д янз бүрийн муу нэр тохдог. Чийгон нийгэмд өргөн дэлгэрээд удаагүй байна, олон хүн гэжүүд үзэл бодолтойгоос үүнийг үргэлж хүлээн зөвшөөрдөггүй, гүтгэж үгүйсгэдэг. Тэдгээр хүмүүсийг ямар янзын сэтгэцийн байдалтайг нь мэдэхгүй юм, энэ нь тэдэнд ямар нэгэн байдлаар хамаатай юм шиг чийгон-ыг эгдүүцдэг, чийгон-ы талаар дурдангуут л тэд үүнийг хийсвэр үзэл гэдэг. Чийгон бол шинжлэх ухаан, бүр дээд зэргийн шинжлэх ухаан юм. Тэдний үзэл бодол

нь хэтэрхий гэжүүд, мэдлэгийн хүрээ нь хэтэрхий хязгаарлагдмал учраас ийм байдал гардаг.

Бас өөр нэг байдал байдаг, бясалгагчдын хүрээнд үүнийг “чийгон байдал” гэдэг, ийм хүний оюун санаа нь орон гаран юм шиг байдаг, гэхдээ тэр бол бясалгалын солиорол биш, ийм хүн их бодлоготой байдаг. Би эхлээд чийгон байдал гэж ямар учиртайг ярьв. Та бүхэн мэднэ, чийгон-оор хичээллэхэд хүний төрөлхийн суурийн асуудал яригддаг. Дэлхийн бүх улс оронд шашин шүтлэгтэй хүмүүс байдаг, Хятадад хэдэн мянган жилийн турш Буддын шашин, Бумбын шашныг хүмүүс шүтсээр ирсэн, тэд сайн үйл хийхэд сайн хариу ирдэг, муу үйл хийхэд хариу шийтгэл ирдэг гэдэгт итгэдэг. Гэхдээ зарим хүн үүнд итгэдэггүй. Ялангуяа Соёлын их хувьсгалын үед үүнийг шүүмжилж мухар сүсэг гэдэг байсан. Зарим хүн өөрсдийн ойлгодоггүй бүх зүйлсийг, сурах бичиг дээр байхгүй, одоогийн шинжлэх ухаанаар багтаагдаагүй зүйлсийг, мөн танин мэдэгдээгүй байгаа зүйлсийг мухар сүсэг гэж үздэг. Хэдэн жилийн өмнө ийм хүмүүс их олон байсан, харин одоо арай цөөрсөн. Хэдийгээр чи зарим үзэгдлүүдийг хүлээн зөвшөөрөхгүй байлаа ч тэдгээр нь манай энэ орон зайд аль хэдийн илэрчихсэн байдаг. Чи үүнийг хүлээн зөвшөөрч зүрхэлдэггүй ч, хүмүүс одоо энэ талаар зоригтой ярьдаг болсон, тэд бас чийгон бясалгалын талаарх зарим бодит байдлыг чихээрээ сонсож нүдээрээ үзсэн зүйлсээсээ мэдэж авсан байдаг.

Зарим хүн ийм хэмжээнд хүртлээ гэжүүд болсон: чийгон-ы талаар ярихад чамайг үнэн голоосоо дотроо шоолно, тэр чамайг мухар сүсэгт автсан, ёстой инээдтэй гэнэ. Чи чийгон бясалгалын талаар

ярингуут тэд чамайг харанхуй, боловсролгүй гэж үзнэ. Хэдийгээр ийм хүн гэжүүд байдаг ч түүний төрөлхийн суурь нь муугүй байж болно. Хэрэв түүний төрөлхийн суурь нь сайн, тэгээд чийгон-оор хичээллэхийг хүсвэл түүний тэнгэрийн мэлмий нь их өндөр түвшинд нээгдэж, бас ер бусын чадвар гарч магадгүй. Тэр чийгон-д итгэдэггүй, гэхдээ өвчин тусахгүй гэсэн баталгаа байхгүй. Тэр өвчин тусвал эмнэлэгт очиж үзүүлнэ, барууны эмчилгээгээр яваад эмчлэгдэхгүй бол Хятад эмчилгээгээр явна, Хятад эмчилгээгээр ч бас өвчин нь эдгэрэхгүй өөр ямар ч эм тан үйлчлэхгүй бол одоо түүний санаанд чийгон орно. Тэр ингэж бодно: “Чийгон миний өвчнийг эдгээж үнэхээр чадах болов уу, би азаа үзээд алдъя.” Тэр их эргэлзэж байгаад очно. Түүний төрөлхийн суурь сайн учраас чийгон-оор хичээллэж эхлэнгүүт түүнд маш сайн үр дүн гарна. Магадгүй аль нэг багш түүнийг сонгоно, өөр орон зайд байгаа энэ дээд амь бодь түүнд тусална. Түүний тэнгэрийн мэлмий нь гэнэт нээгдэнэ эсвэл тэр хагас гэгээрлийн байдалд орно. Тэнгэрийн мэлмий нь их өндөр түвшинд нээгдэхэд тэр ертөнцийн зарим үнэн байдлыг гэнэт харна, мөн ер бусын чадвар нь гарч ирнэ. Чи боддоо, тийм хүн ийм байдлыг харахад түүний тархи нь хүлээн авч чадах уу? Чи түүнийг сэтгэл санааны ямар байдалд орно гэж бодож байна? Урьд нь мухар сүсэг гэж үздэг, туйлаас байж болшгүй гэж боддог, энэ талаар бусдын ярих болгонд шоолж инээдэг байсан зүйлс нь түүний нүдний өмнө бодитоор илэрсэн, мөн үүнтэй бодитоор холбогдсон. Тэгэхэд энэ хүний тархи үүнийг хүлээж авч чадахгүй, оюун санааны их дарамтад ордог, түүний хэлж ярьж байгааг бусад хүмүүс ойлгохгүй, гэхдээ түүний ухаан санаа саруул, тэр зөвхөн хоёр талын харьцааг зөв

зохицуулж чаддаггүй. Тэрээр хүн төрөлхтний хийдэг зүйл буруу байдаг, харин нөгөө талд үргэлж зөв байдаг гэдгийг олж мэднэ. Юмыг нөгөө талд хийдэг байдалаар хийвэл хүмүүс түүний хийж байгааг буруу гэнэ. Хүмүүс түүнийг ойлгохгүй, иймээс энэ хүнийг бясалгалын солиоролд автсан гэдэг.

Үнэндээ тэр бясалгалын солиорол биш юм, чийгон-оор хичээллэдэг ихэнх хүмүүст ийм байдал огтхон ч гарахгүй, зөвхөн тэдгээр гөжүүд үзэлтэй хүмүүст л энэ чийгон байдал гардаг. Энд суугаа хүмүүс дунд тэнгэрийн мэлмий нь нээгдсэн хүн олон бий, нэлээд олон. Тэд үнэхээр өөр орон зайн зүйлсийг бодитоор хардаг, гэхдээ гайхширдаггүй, тэдэнд сайхан мэдрэмж төрдөг, тархи нь цочирддоггүй бас тийм чийгон байдал ч гарахгүй. Чийгон байдалд орсон хүн их бодлоготой болдог, үг нь их гүн гүнзгий утгатай, юмыг их учир зүйтэй ярьдаг. Гэвч түүний хэлсэн үгэнд энгийн хүн үнэмшдэггүй. Тэр магадгүй хэн нэгэн нас барсан хүнийг харсан, тэр түүнд ямар нэгэн зүйл хий гэж хэлсэн гэж ярина. Энгийн хүн үүнд яаж үнэмших юм? Сүүлд нь тэр эдгээр зүйлсийг дотроо хадгалах ёстой, ярьж болохгүй гэж ойлгосон, хоёр талын харьцааг зөв зохицуулсны дараа бүх юм хэвэндээ орно. Ер нь ийм хүмүүс гол төлөв ер бусын чадвартай байдаг, гэхдээ энэ нь бясалгалын солиорол биш.

Өөр нэг “жинхэнэ солиорол” хэмээх байдал гардаг бөгөөд энэ нь маш ховор үзэгддэг. Бидний ярьж байгаа “жинхэнэ солиорол” гэдэг бол үнэхээр ухаан солиорсон гэсэн үг биш, тийм утгатай биш харин үнэнд бясалгах гэсэн санаа агуулдаг. Жинхэнэ солиорол гэж юу вэ? Магадгүй бясалгагчдын дунд зуун мянган хүнд нэг л тохиолдож болно, маш ховор

тохиолддог гэж би хэлнэ. Тиймээс энэ нь түгээмэл биш, нийгэмд ямар ч нөлөөгүй.

“Жинхэнэ солиорол”-д үргэлж нэг урьтал нөхцөл байдаг, энэ нь тэр хүний төрөлхийн суурь нь маш сайн, мөн өндөр настай байх ёстой. Өндөр настай болсон болохоор бясалгаж амжихгүй. Тэдгээр маш сайн төрөлхийн суурьтай хүмүүс дээд түвшнээс ихэвчлэн үүрэгтэй ирдэг. Хэн боловч энгийн хүний нийгэмд ирэхээс айдаг, ой санаж нь арчигдсаны дараа тэр хэнийг ч танихгүй болно. Энгийн хүний нийгмийн орчинд орж ирэхэд хүмүүс түүнийг үймүүлнэ, түүнийг нэр алдар, ашиг хонжооны хойноос хөөцөлддөг болгоно, эцэст нь доош унана, тэндээс үүрд гарч чадахгүй, тиймээс хэн ч энд ирэхийг зүрхэлдэггүй, үүнээс айдаг. Хэдий тийм ч ийм хүн ирсэн, ирээд энгийн хүмүүсийн дунд үнэхээр өөрийгөө барьж чадаагүй, тэр доош унахад хүрсэн, амьдралынхаа туршид их олон муу зүйл хийсэн. Хүн хувийн ашиг сонирхлынхоо төлөө тэмцэн амьдрахдаа маш их муу зүйл хийж бусдад их өр тавьдаг. Багш нь түүнийг доош унах гэж байгааг харсан, гэхдээ тэр урьд нь бүтээлийн оронтой байсан болохоор түүнийг тийм амархан доош унагахгүй! Тэгвэл яах вэ? Түүний багш их санаа зовно, түүнийг бясалгуулах арга байхгүй, тэр үед хаанаас багш олох юм? Тэр буцахын тулд бүр анхнаас нь эхэлж бясалгах ёстой. Гэхдээ энэ нь яаж тийм амар байх юм? Өндөр настай болсон тул бясалгахад амжихгүй болсон, тэр амь бие, сэтгэлийн хос бясалгалыг хаанаас олох юм?

Төрөлхийн суурь маш сайн хүнд, энэ маш онцгой нөхцөлд түүнийг солиоруулах аргыг хэрэглэж болно. Өөрөөр хэлбэл ямар ч найдваргүй болсон, өөрөө буцаж

чадахгүй байдалд хүрэхэд энэ аргыг хэрэглэж түүнийг ухаан солиотой болгоно, түүний тархины зарим үйл ажиллагааг түгждэг. Жишээлбэл хүмүүс бид хүйтнээс болон заваанаас айдаг, тэгвэл тархины хүйтнээс айдаг, заваанаас айдаг тэр хэсгийг нь түгждэг. Эдгээр хэсгийг түгжсэний дараа тэр хүн сэтгэл мэдрэлийн согогтой харагдана, мөн жинхэнэ солирсон хүн шиг болно. Гэхдээ тийм хүн ер нь муу зүйл хийдэггүй, хүнийг загнах ч үгүй цохих ч үгүй харин ихэвчлэн сайн үйл хийдэг. Гэхдээ тэр өөртөө маш харгис ханддаг. Учир нь тэр хүйтнийг мэдрэхгүйгээс өвөл цасан дээгүүр хөл нүцгэн гүйнэ, нимгэн хувцас өмсөнө, түүний хөл хөлдсөнөөс хагарч цус гоожно; тэр заваанаас сэжиглэхгүй учраас баас идэж шээс ууж ч зүрхэлнэ. Би урьд нь ийм нэг хүнийг мэддэг байсан, тэр адууны хөлдүү хомоолыг амтархан мэрдэг байсан, жирийн хүн эрүүл ухаантайгаар тэвчихийн аргагүй тийм зовлонг тэр амссан. Төсөөлөөд үз дээ, ухаан нь солиорсноор тэр хүн ямар их зовлонг туулав, мэдээж тийм хүн ихэнхдээ ер бусын чадвартай байдаг, гол төлөв настай эмэгтэй хүн байдаг. Урьд нь эмэгтэй хүний хөлийг жижиг байлгахын тулд боодог байсан, гэсэн ч тийм нэг эмэгтэй хоёр метр өндөр хашаан дээгүүр төвөггүй үсрээд гардаг байсан. Гэрийнхэн нь түүний ухаан солирсныг хараад, үргэлж гарч гүйгээд байхаар нь гэртээ цоожилдог болсон. Гэрийнхэн нь явсны дараа тэр цоож руу хуруугаараа нэг заагаад л онгойлгочихно, тэгээд гараад явна. Дараа нь түүнийг төмөр гинжээр хүлсэн, гэрийнхэн нь явсны дараа, гинжийг амархан сэгсрээд л тайлчихна. Түүнийг тогтоон барих аргагүй болсон, ингээд тэр маш их зовлон амсана. Түүний туулсан зовлон маш их, мөн нэлээд ширүүн байсан болохоор муу зүйл хийсэн үйлийн үр нь хурдан

төлөгдөнө. Энэ нь дээд тал нь гурван жилд юм уу ер нь нэг хоёр жилд л өнгөрнө, маш хүнд зовлон амсдаг. Энэ бүгд өнгөрсний дараа тэр гэнэт ойлгоно, түүний бясалгал дууссанд тооцогдох учраас гон нь тэр дороо нээгдэж янз бүрийн ер бусын чадвар гарч ирдэг. Ийм тохиолдол их ховор үзэгддэг ч түүхэнд байдаг. Жирийн суурьтай хүнд ийм байдал гаргуулахгүй. Та бүгд мэднэ, түүхэнд солиорсон лам хуврагууд болон солиорсон Бумбын бясалгагчид байсан тухай тэмдэглэгдсэн байдаг. Жишээ нь солиорсон хувраг Чин Хуйг хийдээс шүүрээр хөөж гаргасан тухай болон солиорсон Бумбын бясалгагчдын тухай иймэрхүү домог яриа их олон байдаг.

Бид бясалгалын солиорол гэж байдаггүй болохыг баттай хэлж чадна. Хэрэв хүн гал гаргаж чаддаг бол, үнэхээр тийм байвал би тэр хүнийг гоц гойд гэнэ. Амнаасаа галаар үлээнэ, гараа сунгаад л гал гаргана, хуруугаараа нэг заагаад л тамхи асаана, би үүнийг ер бусын чадвар гэнэ!

### **Бясалгахад буг чөтгөр үймүүлэх нь**

Бясалгахад буг чөтгөр үймүүлэх гэж юу вэ? Бид чийгон-оор хичээллэхэд үймүүлэл амархан гардаг. Чийгон бясалгал хийхэд яагаад буг чөтгөрийг өдөөдөг вэ? Хүн бясалгахыг хүсвэл маш хэцүү, жинхэнэ бясалгахад миний Фашэнь-ий хамгаалалтгүйгээр үндсэндээ үр дүнд хүрч чадахгүй, чи үүдээр гарангуут л амь насны аюултай тулгарч магад. Хүний сүнс үхдэггүй, тэгвэл чи өмнөх амьдралууддаа нийгмийн харилцаанд магадгүй хэн нэгэнд өр тавьсан, хэн нэгнийг дээрэлхсэн, эсвэл ямар нэгэн муу зүйл хийсэн байж болно, тэгээд тэдгээр хохирогчид чамайг хайж ирнэ. Буддын шашинад, хүн үйлийн үрийг хариулахын



тулд амьдардаг гэдэг. Чи хэн нэгэнд өртэй бол тэр авлагаа авахаар чамайг хайж олно, өрөө илүү авчихвал дараа чамд буцааж төлөх болдог. Хүү нь эцэг эхдээ муу хандаж байсан бол дараагийн удаа тэдний байр эсрэгээр солигдоно, энэ янзаар ээлжилсээр байдаг. Гэхдээ бид үнэхээр буг чөтгөрүүд хүнийг чийгон бясалгал хийлгүүлэхгүйн тулд үймүүлдгийг харсан, энэ бүгд үйлийн үрийн харьцаанаас гардаг, учир шалтгаангүй зүйл биш юм, учир шалтгаангүй байсан бол ийм байхыг зөвшөөрөхгүй.

Хамгийн түгээмэл байдаг буг чөтгөр үймүүлэх хэлбэр нь, чамайг чийгон-оор хичээллэж эхлэхээс өмнө чиний эргэн тойрны байдал харьцангуй нам тайван байдаг. Чи чийгон сурсан болохоор үргэлж бясалгал хийх дуртай байна, харин чамайг завилж суугаад бясалгаж эхлэнгүүт орчин гэнэт чимээ шуугиантай болно. Машины сигнал, хонгилд гарах хөлийн чимээ, хүмүүсийн яриа, хаалга савах чимээ, мөн гаднаас радио сонсогдох гэх мэтээр тэр даруй нам тайван биш болно. Чамайг чийгон-оор хичээллээгүй байхад орчин харьцангуй нам гүм байдаг, харин чийгон хийж эхлэнгүүт ийм болдог. Чухам ямар учиртай болохыг нь бидний ихэнх хүмүүс тунгаан бодож байгаагүй, зөвхөн ямар хачин юм бэ гэж бодоод өнгөрнө, чийгон-оор хичээллэж чадахгүй байгаадаа урам нь хугарна. Тэр “ямар хачин юм бэ” гээд хийхээ болино, энэ нь буг чөтгөр чамд саад хийж байгаа хэрэг юм, хүмүүсийг удирдаж чамайг үймүүлдэг. Энэ бол үймүүллийн хамгийн энгийн хэлбэр бөгөөд тэр чамайг бясалгал хийлгэхгүй байх зорилгодоо хүрнэ. Чи бясалгаад Бумба-д хүрчих юм бол чиний тавьсан төлөгдөөгүй өрийг яах вэ? Тэр үүнийг зөвшөөрөхгүй, тиймээс чамайг бясалгуулахгүй. Гэхдээ энэ нь тодорхой нэг

түвшин дэх илрэл юм, хэсэг хугацаа өнгөрсний дараа ийм байдал гарахыг цаашид зөвшөөрөхгүй, өөрөөр хэлбэл тэдгээр өр нь үеэ өнгөрөөсний дараа тэднийг дахин үймүүлэхийг зөвшөөрөхгүй. Яагаад гэвэл Фалунь Дафа-гаар бясалгадаг хүмүүс хурдан ахидаг, түвшин нь нэлээд хурдан дээшилдэг.

Буг чөтгөрийн өөр бас нэг хэлбэрийн үймүүлэл байдаг. Та бүгд мэднэ, бид чийгон-оор хичээллэхэд тэнгэрийн мэлмий нээгдэж болно, зарим хүн тэнгэрийн мэлмий нь нээгдсэний дараа гэртээ бясалгал хийж байхдаа зарим аймаар байдал эсвэл аймшигтай зүс царайг хардаг. Зарим нь сэгснйсэн урт үстэй, зарим нь чамтай тулалдахыг завдана, янз бүрийн аймаар хөдөлгөөн хийнэ, их аймшигтай. Зарим үед бясалгал хийж байхад цонхны цаана тэдний ширтэж байгаа нь аймаар харагдана. Яагаад ийм байдал гардаг вэ? Энэ бол буг чөтгөрийн үймүүлж байгаа хэлбэр юм. Гэхдээ манай Фалунь Дафа-гийн бясалгалд ийм үзэгдэл гарах нь маш ховор, зуугаас нэгд л тохиолдож магад, ихэнх хүнд ийм байдал гарахгүй. Энэ нь бидний бясалгалд ямар ч ач холбогдолгүй учраас тэдгээрийг ийм байдлаар чамайг үймүүлэхийг зөвшөөрөхгүй. Бусад ердийн бясалгалуудад ийм янзын үймүүлэл их түгээмэл байдаг, мөн нэлээд удаан үргэлжилдэг. Зарим хүн үүнээс болж айгаад дасгалаа хийж чаддаггүй. Хүмүүс дасгалаа хийхдээ гол төлөв шөнийн нам гүм үеийг сонгодог, гэнэт өмнө чинь хүн ч биш, чөтгөр ч биш амьтан зогсож байхыг харвал айгаад чийгон-оор хичээллэж зүрхлэхгүй болно. Манай Фалунь Дафа-д ер нь ийм байдал гарахгүй, гэхдээ маш ховор тохиолдоно, зарим хүний нөхцөл байдал их онцгой байдаг.

Бас нэг төрлийн бясалгал болох дотоод, гадаад хос бясалгал гэж байдаг, энэ нь Ушу болон дотоод бясалгалыг хамт хийдэг, ийм төрлийн бясалгал Бумбын системд нэлээд түгээмэл байдаг. Хүн энэхүү бясалгалаар хичээллэхэд үргэлж нэг янзын буг чөтгөрийн үймүүлэлтэй тулгардаг. Жирийн бясалгалд тааралдахгүй, зөвхөн дотоод, гадаад хос бясалгалд болон Ушу-гаар хичээллэдэг бясалгалд байдаг, энэ нь хүмүүс түүнтэй үзэлцэх гэж хайж ирнэ. Дэлхийд Бумба-д бясалгадаг маш олон хүн байдаг, тэдний олонх нь Ушу-гаар хичээллэдэг, дотоод болон гадаад бясалгадаг. Ушу-гаар хичээллэдэг хүнд бас гон өсөж болдог. Яагаад вэ? Тэр алдар нэр, ашиг хонжоо хөөцөлдөх гэх мэт сэтгэлээсээ салбал түүний гон бас өснө. Гэхдээ түүнд тэмцэлдэх сэтгэлээ орхиход цаг хугацаа орно, үүнээсээ их удаан сална, тиймээс тэр иймэрхүү зүйлийг амархан хийнэ, энэ нь тодорхой түвшинд үргэлж давтагддаг. Тэр хүн ховсдолын байдалд орж бясалган сууж байхдаа хэн дасгал хийж байгааг мэднэ, сүнс нь биеэсээ гарч хэн нь Ушу-гаар илүү болохоо үзэлцэхээр нөгөө хүнийг хайж очно, тулаан болно. Өөр орон зайд бас ийм байдал гардаг, хэн нэгэн түүн дээр ирж тулалдана, тэр тулалдахаас татгалзвал нөгөө хүн түүнийг үнэхээр алж мэднэ, тэгээд тэд хоорондоо тулалдаж эхэлнэ. Түүнийг унтахад хэн нэгэн ирж түүнтэй тулалдана, тэгээд шөнөжингөө амарч чадахгүй. Үнэндээ энэ үед түүний тэмцэлдэх сэтгэлийг орхиулах гэж байгаа юм, тэр тэмцэлдэх сэтгэлээ орхихгүй бол үргэлж ийм байх болно, тэр энэ янзаараа байвал хэдэн жилийн дараа ч энэ түвшинээсээ дээш ахиж чадахгүй. Энэ хүн чийгон-оор үргэлжлүүлэн бясалгаж чадахгүйд хүрнэ, маш их эрч хүч нь барагдаж түүний махан бие ч дийлэхгүй болно, тэгээд ямар ч

тусгүй дуусна. Иймээс дотоод, гадаад хос бясалгалд ийм асуудал гарч болзошгүй бөгөөд энэ нь их түгээмэл байдаг. Бидний дотоод бясалгалд ийм асуудал байхгүй, түүнийг гарахыг ч зөвшөөрөхгүй. Миний саяны ярьсан ийм хэдэн хэлбэр нэлээд түгээмэл байдаг.

Бас буг чөтгөр үймүүлэх өөр нэг хэлбэр байдаг, тэр нь бясалгаж байгаа хүн бүрд тохиолдоно, бидний бясалгалд бас хүн болгонд тохиолдоно, энэ бол шунал тачаалын шулам юм. Энэ зүйл маш их ноцтой. Энгийн хүний нийгэмд гэр бүлийн амьдрал байдаг, хүн төрөлхтний хойч үе өсөж үрждэг. Хүний үндэс угсаа ингэж л хөгждөг, мөн хүний нийгэмд сэтгэл гэж байдаг, тэгэхээр ийм зүйл энгийн хүнд байх нь зүй ёсны юм. Хүнд сэтгэл байдаг болохоор, уурлах нь сэтгэл, баярлах нь сэтгэл, хайрлах нь сэтгэл, үзэн ядах нь сэтгэл, хийх дуртай зүйл дургүй зүйл, таалагдах хүн таалагдахгүй хүн, сонирхолтой зүйл сонирхолгүй зүйл гээд бүгд сэтгэл юм, энгийн хүн үүний тулд л амьдардаг. Тэгэхээр бясалгагч хүн, ер бусын хүний хувьд ийм хандлагаар юмыг цэгнэж болохгүй, үүнээс нэвтэрч гарах хэрэгтэй. Энэ сэтгэлээс маш олон янзын зууралдсан сэтгэл үүдэн гардаг, иймд бид үүнийг хөнгөн авч үзэх хэрэгтэй, эцэст нь бүрэн орхих ёстой. Дур хүсэл, шунал тачаал мэтийн зүйлс бол хүний зууралдсан сэтгэл юм, энэ бүтдийг хаях хэрэгтэй.

Энгийн хүмүүсийн дунд бясалгаж байгаа бясалгагчдын хувьд, манай бясалгал чамайг лам хувраг эсвэл гэлэнмаа бол гэж байгаа юм биш, манай залуучууд гэр бүлтэй болцгооно. Тэгвэл энэ асуудалд яаж хандах вэ? Манай бясалгал бол хүний сэтгэл рүү чиглэсэн гэж би хэлсэн, материаллаг ашиг сонирхлын хувьд үнэндээ чамайг алдуулах гээд байгаа юм биш. Харин эсрэгээрээ

энгийн хүмүүсийн энэ материаллаг ашиг дээр чиний шиньшин-ийг хатуужуулна, жинхэнэ дээшилж байгаа нь чиний шиньшин юм. Чи энэ сэтгэлээсээ салж чадвал юуг ч орхиж чадна, материаллаг ашиг сонирхлоо орхи гэвэл чи орхиж чадна. Чи сэтгэлээ орхиж чадахгүй бол юуг ч орхиж чадахгүй, иймээс бясалгалын жинхэнэ зорилго бол сэтгэлээ бясалгах юм. Сүм хийдэд бясалгахад чамайг энэ сэтгэлээс чинь салгахын тулд эдгээр зүйлсийг хүчээр орхиулна, чамайг энэ талаар бодохгүй байлгаж тэдгээрээс бүрмөсөн татгалзуулах албадлагын арга хэрэглэдэг. Харин бид тийм байхыг чамаас шаардахгүй, чамайг материаллаг ашиг сонирхол дээр хөнгөн авч үзэхийг шаардана, иймээс манай бясалгалаар бясалгаж гарсан хүн хамгийн баг бөх суурьтай байх болно. Чамайг лам хувраг, гэлэнмаа бол гэж байгаа юм биш. Бид энгийн хүмүүсийн дунд бясалгадаг, ирээдүйд манай бясалгал улам өргөн дэлгэрнэ, хүн бүр лам хувраг биш байтлаа лам хувраг шиг болж болохгүй, Фалунь Дафагаар бясалгадаг хүн болгон ийм болж болохгүй. Бид бясалгалын явцад хүн бүрээс дараах зүйлийг шаардана: Чи бясалгадаг ч чиний гэр бүлийн хүн бясалгадаггүй бол, та нар бясалгалаас болж гэр бүлээсээ салж сарнихдаа хүрч болохгүй. Өөрөөр хэлбэл бид энэ асуудлыг хөнгөн авч үзэх хэрэгтэй, чи үүнийг энгийн хүний адил чухалчилж болохгүй. Ялангуяа одоогийн нийгэмд бэлгийн харьцаа чөлөөтэй болж, садар самуун зүйлс хүмүүсийг үймүүлж байна. Зарим хүн иймэрхүү зүйлийг их сонирхдог, бясалгагч хүний хувьд бид эдгээрийг хөнгөн авч үзэх ёстой.

Дээд түвшнээс харахад энгийн хүмүүс нийгэмд ёстой шавар шавхайн дунд наадаж байна, бохир заваан гэж санах ч үгүй шороон дээр шавраар наадаж байна

гэдэг. Бид чамайг энэ асуудлаас болоод гэр бүлдээ эв зүйгээ олохгүйд хүрч болохгүй гэж хэлсэн, иймээс чи одоогийн шатанд үүнийг хөнгөн хар, гэр бүлийн амьдралаа эв зүйтэй хэвийн байлгавал хангалттай, ирээдүйд чи тодорхой нэг түвшинд хүрэхэд тэр түвшний байдал гарна, одоогийн нөхцөл байдал ийм байх хэрэгтэй, хэрэв чи энэ шаардлагад нийцвэл хангалттай. Мэдээж чи одоогийн нийгэм дэх ийм байдлыг дагаж болохгүй, тэгж хэрхэвч болохгүй!

Энэ асуудалд өөр нэг хүчин зүйл байдаг, та бүгд манай бясалгагчдын бие энергитэй гэдгийг мэднэ. Одоо энэ лекцийг дуусахад та нарын 80-90 хувь нь өвчингүй болохоос гадна, бас гон гарна, иймд чиний бие маш хүчтэй энергитэй болно. Чамд байгаа гон чиний одоогийн шиньшин-ий түвшинтэй адил харьцаатай биш. Чиний гон түр өндөр болсон, огцом дээшлүүлж өгсөн, одоо шиньшин-ээ дээшлүүлэх хэрэгтэй. Аажмаар түүнд гүйцэж хүрнэ, энэ хэсэг хугацаанд гүйцэж хүрэх нь дамжиггүй, иймээс бид үүнийг урьдчилгаад хийсэн, өөрөөр хэлбэл чи зохих энергитэй болсон. Ариун Фа-гаар бясалгаж гарсан энерги нь ариун нигүүлсэнгүй байдаг, иймээс энд суугаа хүн болгон амгалан нигүүлсэнгүй орчныг мэдэрдэг. Би өөрөө энэ замаар бясалгасан болохоор тийм зүйлс надад бий. Энд суугаа хүн болгон эв эеийг мэдэрдэг, муу санаа бодол байхгүй, тэр ч байтугай тамхи татах ч бодол төрдөггүй. Ирээдүйд чи манай Дафа-гийн шаардлага дагуу хийхэд чиний бясалгаж гаргасан гон мөн адил ийм байх болно. Чиний гон хүч тасралтгүй өсөх тусам биед чинь агуулагдах гон-оос цацрах энергийн хэмжээ бас нэлээд хүчтэй болно. Тийм хүчирхэг биш байсан ч чиний энэ орны хүрээнд байгаа энгийн хүнийг эсвэл чи гэртээ

байхдаа бас бусдыг хязгаарлаж чадна. Танай гэр бүлийнхэнд нөлөөлж болно. Яагаад вэ? Чи хийх гэж бодох ч хэрэггүй, яагаад гэвэл энэ бол ариун амгалан, нигүүлсэнгүй бөгөөд зөвт бодлын орон юм. Тиймээс хүмүүс тийм амархан муу юм бодож, муу зүйл хийхгүй, ийм нөлөө үзүүлж болно.

Буддын туяа даяар гийхэд зүй бус бүхэн засагдана гэж би хэлсэн. Өөрөөр хэлбэл бидний биеэс цацрах энерги нь бүх буруу байдлыг засаж чадна. Тэгвэл энэ орны нөлөөнд чи эдгээр зүйлийг бодохгүй бол санаандгүйгээр гэр бүлийн хүндээ бас нөлөөлнө. Чи энэ талаар бодохгүй, чамд ийм бодол төрөхгүй бол чиний ханьд ч бас санаанд нь орохгүй. Гэхдээ үргэлж ийм байхгүй, одоогийн нөхцөлд зурагтаа асаагаад л үзэхэд юу л бол юу гардаг, хүний хүслийг амархан өдөөдөг. Гэхдээ жирийн үед чамд ийм хязгаарлах нөлөө байдаг. Ирээдүйд чи дээд түвшинд бясалгаад хүрэхэд надаар хэлүүлэлгүй ямар байхаа өөрөө мэддэг болно, тэр үед өөр байдал гарна, эв зүйгээр амьдарч байхад л болно. Иймээс чи үүнд их санаа зовох хэрэггүй, хэтэрхий санаа зовоод байвал энэ нь бас зууралдсан сэтгэл юм. Эхнэр нөхрийн хооронд шунал тачаалын асуудал байхгүй, харин хүсэл л байдаг, чи үүнийг хөнгөн харж, сэтгэлээ тэнцвэртэй байлгахад л болно.

Тэгвэл ямар янзын шунал тачаалын шуламтай таарах вэ? Хэрэв сэтгэлээ барих чадвар чинь хүчгүй бол, чиний зүүдэнд үзэгдэнэ, чамайг унтаж байхад эсвэл бясалган сууж байхад гэнэт гардаг: Чи эрэгтэй бол царайлаг хүүхэн гарч ирнэ; эмэгтэй бол чиний мөрөөдлийн эр гарч ирнэ, гэхдээ тэд нүцгэн байна. Чиний сэтгэл хөдлөнгүүт дур хүслээ тавиад бодит болчихно. Та

бүхэн боддоо, манай бясалгалд биеийн охь ба цусны чийг амь биеийг бясалгахад хэрэглэдэг, чи үүнийг үргэлж ингээд алдаад байж болохгүй. Түүнчлэн чи энэ хүсэл тачаалын давааг давсангүй, тийм байж яаж болох юм? Тэгэхлээр энэ асуудал хүн болгонд тааралдана гэж би хэлье, тааралдах нь дамжиггүй. Би Фа заахдаа та нарын тархи руу их хүчтэй энерги дамжуулдаг. Чи үүдээр гараад миний юу хэлснийг тодорхой санахгүй байж мэднэ, гэхдээ чи энэ асуудалтай тулгарахад миний юу гэж хэлснийг санана. Чи өөрийгөө бясалгадаг хүн гэж үзвэл тэр агшинд толгойд чинь орж ирэх бөгөөд өөрийгөө барина, тэгээд энэ сорилтыг давж чадна. Хэрэв анхны сорилтыг давж чадаагүй бол дараагийн сорилтыг давахад хэцүү байх болно. Гэхдээ бас анхны удаа тэвчиж чадаагүй унасан бол сэрсний дараа маш их гутарч магад, ийм сэтгэл зүйн төлөв байдал нь чиний сэтгэл санаанд гүн нөлөөлж дахиад ийм асуудал тааралдахад чи өөрийгөө барьж чадна, давж чадна. Хэрэв зарим хүн даваагүй ч гэсэн тоохгүй өнгөрөөвөл дараа өөрийгөө барихад бүр ч хэцүү байх болно, ийм байх нь гарцаагүй.

Чөтгөр шулмын үймүүлэх ийм янзын хэлбэр байдгаас гадна, мөн багш нэг юмыг өөр зүйл болгон хувиргаж чамайг туршиж байж болно, ийм хоёр янзын хэлбэр байдаг, яагаад гэвэл хүн болгон энэ давааг давах ёстой. Бид энгийн хүн байхаасаа бясалгаж эхэлдэг, анхны алхам бол энэ даваа, хүн болгонд тааралдана. Би та нарт нэг жишээ хэлье: Ухань хотод лекц уншиж байхад манай ангид нэг сурагч байсан, гучин настай залуу. Намайг энэ лекцийг уншсаны дараа тэр гэртээ хариад бясалгахаар суусан, тэрээр дорхноо гүн амгаланд орсон. Гүн амгаланд орсных нь дараа гэнэт түүний нэг талд нь Будда Амитаба, нөгөө талд нь Лаози гарч ирэхийг



харсан. Тэр үүнийг туршлага хуваалцахдаа өгүүлсэн юм. Тэд гарч ирснийхээ дараа түүн рүү хараад юу ч дугараагүй тэгээд алга болцгоосон. Дараа нь Бодьсадва Гуанинь гарч ирсэн, гартаа нэг ваар барьсан, түүнээс нь цагаан утаа гарч ирсэн. Тэр бясалган сууж байхдаа энэ бүгдийг маш тодорхой хараад баярласан. Гэнэт тэр утаа нь үзэсгэлэнтэй тэнгэрийн дагинас болон хувирсан, тэдгээр тэнгэрийн нисдэг дагинас үнэхээр үзэсгэлэнтэй. Тэд түүнд зориулж уран гоёмсоор бүжиглэсэн. Тэр, “намайг энд бясалгаж байгааг хараад Бодьсадва Гуанинь урамшуулж тэнгэрийн дагинасыг гарган бүжүүлж байна” гэж бодон баярлаж суутал тэдгээр дагинас гэнэт нүцгэн болж янз бүрээр хөдөлгөөн хийж хүзүү бэлхүүсээр нь тэвэрч эхэлсэн. Манай сурагчийн шиньшин маш хурдан дээшилсэн байсан тул тэр дороо энэ залууд сэрэмж төрсөн, тэр хамгийн түрүүнд, “би энгийн хүн биш, би бясалгадаг хүн, та нар надад ингэж хандаж болохгүй, би бол Фалунь Дафа-гийн бясалгагч” гэж бодсон. Энэ бодол гарангуут тэд гэнэт алга болсон, тэгээд ч бүгд хувирч гарч ирсэн болохоор тэр дороо байхгүй болсон. Дараа нь Будда Амитаба болон Лаози дахин гарч ирсэн. Лаози залууг заагаад Будда Амитаба-д инээмсэглэн хэлсэн: “Энэ хүүг сургаж болно.” Өөрөөр хэлбэл, энэ залуу сайн байна, түүнд зааж болно гэсэн үг.

Түүхийн үеэс үед эсвэл дээд түвшний орон зайнуудаас харахад хүний бясалгаж чадах үгүйг тодорхойлохдоо хүсэл болон шунал тачаалын асуудалд яаж хандахыг нь маш чухалд хардаг, тиймээс бид үнэхээр эдгээр асуудлыг хөнгөн авч үзэх ёстой. Гэхдээ бид энгийн хүмүүсийн дунд бясалгаж байгаа, чамайг үүнийг бүрмөсөн боль гэж шаардаагүй, та нар үүнийг одоогийн шатанд наад зах нь хөнгөн авч

үз, урьдын байсан шигээ байж болохгүй. Бясалгаж байгаа хүний хувьд ч ийм л байх хэрэгтэй. Чийгон бясалгалын явцад аливаа хэлбэрийн үймүүлэл гарах болгонд шалтгааныг өөрөөсөө хай, чамд орхиж чадаагүй өөр юу байгааг олж хар.

### **Өөрийн сэтгэлээс чөтгөрийн үймүүлэл үүсэх нь**

Өөрийн сэтгэлээс чөтгөрийн үймүүлэл үүсэх гэж юу вэ? Хүний бие орон зай болгонд нэг, нэг материаллаг оронтой байдаг. Онцгой нэг орон зайд, орчлон ертөнцийн бүх зүйл чиний орон зайн тэр хүрээнд сүүдэр мэт тусдаг. Хэдийгээр тэдгээр нь сүүдэр боловч материаллаг оршихуй юм. Чиний орон зайн хүрээн доторх бүх зүйлс чиний тархинаас гарах бодолд захирагддаг, өөрөөр хэлбэл чи юу ч бодохгүйгээр тэнгэрийн мэлмийгээрээ тайван харах юм бол тэр харагдсан зүйл нь үнэн. Харин жаахан бодол гарах үед чиний харсан зүйл хуурмаг болно, үүнийг “өөрийн сэтгэлээс чөтгөрийн үймүүлэл үүсэх” буюу санаа дагаж хувирах гэдэг. Учир нь зарим бясалгагчид өөрийгөө бясалгагч гэж үзэж чаддаггүй, өөрийгөө барьж чаддаггүй, ер бусын чадвартай болохын хойноос хөөцөлддөг, мөн жижигхэн арга увдист зууралддаг, тэр ч байтугай өөр орон зайнуудаас сонссон зүйлд автагддаг, тэд эдгээр зүйлсийн хойноос явдаг, ийм хүмүүст өөрийн бодлоос чөтгөрийн үймүүлэл үүсэх, доош унах нь тун амархан байдаг. Хэр өндөр түвшинд бясалгасан ч хамаагүй ийм асуудал гарахад шууд ёроол руу унана, бүрмөсөн сүйрнэ. Энэ бол маш ноцтой асуудал. Энэ нь бусад тал дээр шиньшин-ий сорилтыг давж чадахгүй унаад дахин босож ирээд үргэлжлүүлэн бясалгаж болдогтой адилгүй. Харин өөрийн сэтгэлээс чөтгөрийн үймүүлэл үүсэх асуудал гарвал тэгэх

боломжгүй, түүний энэ насны амьдрал нь сүйднэ. Ялангуяа бясалгаад тэнгэрийн мэлмий нь тодорхой өндөрт нээгдсэн хүнд ийм асуудал амархан гардаг. Зарим хүний бодол нь үргэлж гаднын мэдээллээр үймүүлэгддэг, гаднын мэдээлэл юу хэлнэ түүнд итгэдэг хүмүүст ийм асуудал бас гардаг. Тиймээс тэнгэрийн мэлмий нь нээгдсэн манай зарим хүн тал бүрийн мэдээлэлд үймүүлэгддэг.

Бид та нарт нэг жишээ ярья. Доод түвшинд бясалгахад хүн сэтгэлээ хөдөлгөхгүй барьж байх тун хэцүү. Чи багшийгаа ямар дүр төрхтэйг тодорхой харж чадахгүй байж мэднэ. Гэнэт нэг өдөр чам дээр нэг өндөр, том Бурхан ирснийг харсан. Тэр чамайг хэдэн үгээр магтсан тэгээд ямар нэгэн зүйл чамд заана, чи түүнийг нь хүлээж авбал чиний гон замбараагүйтнэ. Чиний сэтгэл хөөрч түүнийг багшаа хэмээн хүлээн зөвшөөрөн дагаад сурна, гэхдээ тэр ч гэсэн жинхэнэ гэгээрлийн хутаг олоогүй, тухайн орон зайд түүний бие том жижгээр хувирч чаддаг. Энэ бүгд чиний нүдний өмнө илэрч том Бурхан байхыг хараад чиний сэтгэл маш их догдолно, баярлах сэтгэл гарахад түүнийг даган сурахгүй гэж үү? Бясалгадаг хүн өөрийгөө зөв барьж чадахгүй бол аврагдахад тун хэцүү, тэр өөрийгөө амархан сүйтгэнэ. Тэнгэрийн хүмүүс бүгд Бурхад байдаг, гэхдээ тэд ч бас жинхэнэ гэгээрлийн хутаг олоогүй учраас мөн адил самсара буюу зургаан замын тойргоор явна. Чи хамаагүй түүнийг багшаа болгон дагавал тэр чамайг хаана хүртэл дагуулах юм? Тэр өөрөө ч жинхэнэ гэгээрлийн хутаг олоогүй, чи хий дэмий бясалгасан болох юм биш үү? Эцэст нь чиний гон аль хэдийн замбараагүй болсон байх болно. Хүн сэтгэлээ барих хэцүү байдаг. Би та бүгдэд хэлье, энэ бол маш ноцтой асуудал, ирээдүйд та нарын олонход

энэ асуудал гарна. Би та нарт Фа заалаа, өөрийгөө зөв барьж чадах чадахгүй нь чамаас шалтгаална, миний энэ ярьсан бол нэг янзын байдал юм. Өөр бясалгалын ямар ч гэгээрэгчийг харсан сэтгэлээ хөдөлгөхгүй зөвхөн нэг номоороо л бясалга. Ямар ч Будда, Бумба, Бурхан эсвэл ямар ч бут чөтгөр миний сэтгэлийг хөдөлгөж чадахгүй гэвэл чамд амжилтад хүрэх найдвар байгаа нь дамжиггүй.

Өөрийн сэтгэлээс бут чөтгөрийн үймүүлэл үүсэх нь бас өөр байдлаар илэрдэг: магадгүй нас барсан төрөл садны хүний үймүүлэл байдаг, тэр уйлаад л чамайг энэ тэр зүйлийг хийж өгөхийг гуйна, ямар ч зүйл тохиолдож магадгүй. Чиний сэтгэл хөдлөхгүй байж чадах уу? Чи өөрийнхөө хүүхдэд дэндүү хайртай бас эцэг эхдээ их хайртай байсан, эцэг эх чинь аль хэдийн нас барсан, тэд чамайг юу юу... хийхийг гуйна, бүгд хийж болохгүй зүйлс, чи хийчихвэл буруутна, бясалгагч хүн байх ийм л хэцүү. Хүмүүс Буддын шашныг замбараагүй болсон гэж ярьдаг, Күнзийн шашны зүйлс хүртэл Буддын шашинд орсон, эцэг эхдээ ачлал элбэрэлтэй байж хүндлэх, үр хүүхдээ хайрлах сэтгэл гэх мэт зүйлс орсон, Буддын шашинд ийм ухагдахуун байгаагүй. Энэ нь юу гэсэн үг вэ? Хүний жинхэнэ амь Эзэн сүнс байдаг учраас чиний Эзэн сүнсийг төрүүлсэн эх бол чиний жинхэнэ эх юм. Харин чи самсара буюу зургаан замын тойргоор явахад, чиний эх хүн ч байсан бас хүн биш ч байсан, тэднийг тоолохын аргагүй олон байдаг. Төрлөөс төрөлд чиний хүүхдүүд хэр олон байсан нь мөн тоолшгүй. Аль нь чиний ээж юм? Аль нь чиний хүүхэд юм? Нас барсны дараа хэн нь ч хэнийгээ танихгүй, чи тавьсан өрөө ямар ч байсан төлөх болно. Хүн төөрөгдлийн дунд байдаг тул эдгээр зүйлийг орхиж чаддаггүй.

Зарим хүн хүүхдээ гэсэн сэтгэлээ орхиж чаддаггүй, ямар сайн хүүхэд байлаа, тэр маань нас барчихлаа; ямар сайн ээжтэй байлаа, бас нас барчихлаа гэж ярина, энэ хүн үхтлээ гашуудаж үлдсэн насандаа хойноос нь явмаар санагдана. Чи энэ талаар бодож үзсэн үү? Энэ нь чамайг шаналган зовоож байгаа биш гэж үү? Ийм хэлбэрээр чамайг тайван амьдруулахгүй.

Энгийн хүн үүнийг ойлгохгүй байж магадгүй, чи эдгээр зүйлд зууралдаад байвал ер бясалгаж чадахгүй, тиймээс Буддын шашинд ийм ухагдахуун байхгүй. Чи бясалгах хүсэлтэй бол хүний сэтгэлээ орхих ёстой. Мэдээж бид энгийн хүний нийгэмд бясалгахын зэрэгцээ эцэг эхээ харж хандана, үр хүүхдээ сурган хүмүүжүүлэх ёстой, бид ямар ч орчинд бусадтай элддэг харьцаатай байх хэрэгтэй, тэр тусмаа гэр бүлийнхэнтэйгээ. Бид хэнд ч адилхан хандана, эцэг эх, үр хүүхдэдээ сайн хандана, мөн юм болгон дээр бусдыг эхлээд бодно, энэ бол хувиа хичээх сэтгэлээс ангид, харин энэ бол нинжин, энэрэнгүй сэтгэл юм. Сэтгэл бол энгийн хүний зүйл, энгийн хүн үүний тулд л амьдардаг.

Олон хүн өөрийгөө сайн барьж чаддаггүйгээс бясалгалдаа хүндрэл учруулдаг. Зарим хүн Будда түүнд ямар нэгэн зүйл хэлсэн гэдэг. Хэн нэгэн чамд өнөөдөр ямар нэгэн гай барцад тохиолдоно, ямар нэгэн хэрэг явдал учирна, түүнээс хэрхэн тойрч гарахыг хэлнэ. Эсвэл чамд хонжворын дээд сугалааны дугаарыг хэлж өгөн очиж ав гэнэ. Чамд амь насны аюул учрахад түүнээс яаж зайлж гарахыг хэлснээс бусад энгийн хүний нийгэмд аливаа ашиг хонжоо яаж олохыг хэлж өгсөн нь бүгд буг чөтгөрүүд юм. Хэрэв чи энгийн хүмүүсийн дунд үргэлж өөрийнхөө тааваар байж энэ

сорилтыг давахгүй бол дээшилж чадахгүй. Чи энгийн хүмүүсийн дунд маш тав тухтай сайхан амьдарвал яаж бясалгах юм? Чиний нүгэл яаж хувирах юм? Тэгвэл чамд яаж шиньшин-ээ дээшлүүлэх, нүглээ хувиргах орчин нөхцөл байх юм? Та бүхэн үүнийг заавал санаж яваарай. Буг чөтгөр чамайг бас магтаж болно, чиний түвшнийг их өндөр гэнэ, чамайг аугаа Будда эсвэл аугаа Бумба гэнэ, чамайг их мундаг гэнэ, энэ бүгд бол хуурамч. Дээд түвшин рүү жинхэнэ бясалгадаг хүн янз бүрийн сэтгэлээ орхих ёстой, ийм асуудал гарахад та бүгд сонор сэрэмжтэй байх хэрэгтэй!

Бясалгалын явцад тэнгэрийн мэлмий нээгдэнэ. Тэнгэрийн мэлмий нээлттэй бясалгахад хэцүү тал байдаг, тэнгэрийн мэлмий хаалттай бясалгахад ч хэцүү тал байдаг, аль ч тохиолдолд бясалгахад амаргүй. Тэнгэрийн мэлмий нээгдсэний дараа янз бүрийн мэдээлэл чамайг үймүүлэх үед өөрийгөө барих үнэхээр хэцүү байдаг. Бусад орон зайн бүх зүйлс гялалзам гоё, маш үзэсгэлэнтэй сайхан харагддаг, бүгд чиний сэтгэлийг булааж болно. Сэтгэл чинь үүнд автахад чи магадгүй үймүүлэлд орж чиний гон замбараагүй болно, ер нь ийм л байдаг. Иймээс өөрийн сэтгэлээс буг чөтгөрийн үймүүлэл үүссэн хүн өөрийгөө барьж чадахгүй бол бас ийм байдал гарч болно. Жишээлбэл хүнд нэг л буруу бодол үүсвэл энэ нь маш их аюултай. Нэг өдөр түүний тэнгэрийн мэлмий нээгдсэн, юмыг маш тодорхой хардаг болсон. Тэр ингэж бодсон: “Дасгал хийдэг энэ газарт миний л тэнгэрийн мэлмий хамгийн сайн нээгдсэн, магадгүй би энгийн хүн биш байх аа? Би Ли багшийн Фалунь Дафа-г сурч чадсан, би хэн бүхнээс илүү маш сайн сурсан, магадгүй би бас жирийн хүн биш байх аа.” Энэ бодол нь аль хэдийн буруутсан юм. Тэр, “магадгүй би бас Будда

байх аа, өөрийгөө нэг хараадахъя байз” гэж бодно. Тэр өөрийгөө харахад үнэхээр нэгэн Будда харагдана. Яагаад тэр вэ? Яагаад гэвэл түүний биений эргэн тойрны орон зайн хүрээн доторх бүх бие бодь түүний бодлын дагуу хувирдаг, үүнийг “санаа даган хувирах” гэдэг.

Орчлон ертөнцөөс тусгагдаж буусан бүх зүйлс өөрийн бодлын дагуу хувирдаг. Учир нь хүний орон зайн хүрээн доторх бүх зүйлс өөрийн удирдлага дор байдаг, тусгагдаж буусан дүрс мөн адил материаллаг оршихуйтай байдаг, тэр ингэж бодно, “би Будда байх аа, миний өмссөн магадгүй Буддын орхимж байх.” Тэр өөрийгөө харахад үнэхээр Буддын орхимжтой байна. “Хөөх, би үнэхээр Будда юм байна.” Түүний сэтгэл их хөөрсөн. “Магадгүй би нэг жижиг Будда ч биш байх”, дахиад нэг өөрийгөө харахад том Будда харагдана. “Магадгүй би Ли Хонжигоос ч илүү дээгүүр байх!” Дахиад харснаа, “Хөөх, би үнэхээр Ли Хонжигоос илүү дээгүүр юм байна.” Бас зарим хүний чихэнд ингэж сонсогдоно, буг чөтгөр түүнийг үймүүлж хэлнэ: “Чи Ли Хонжигоос илүү дээгүүр, чи Ли Хонжигоос хэчнээн өндөр гээч.” Тэр үүнд мөн үнэмшинэ. Чи цаацдаа яаж бясалгах вэ гэж бодож үзсэн үү? Чи ер нь бясалгасан юм уу? Хэн чамд бясалгал заасан юм бэ? Жинхэнэ Будда ч гэсэн ямар нэгэн зорилготойгоор бууж ирэхдээ мөн эхнээс нь бясалгах ёстой байдаг, урьдынх нь гон-ыг өгөхгүй, зөвхөн бясалгал нь нэлээд хурдан явцтай байна. Тиймээс энэ хүн ийм байдалд ороход өөрийгөө татан авахад маш хэцүү, зууралдсан сэтгэл дорхноо гардаг. Түүнээс хойш тэр юу ч гэж хэлж зүрхэлнэ: “Би бол Будда, та нар бусдаас сурах хэрэггүй, би Будда болохоор та нарт юу хийх, яахыг чинь зааж өгье.” Тэр иймэрхүү зүйл хийж эхэлнэ.

Чанчуньд ийм хүн байгаагүй гэж үү? Анхандаа тэр нэлээд сайн хүн байсан, дараа нь ийм асуудал гарсан. Тэр өөрийгөө Будда болсон гэж бодсон, эцэст нь тэр өөрийгөө хэн бүхнээс дээгүүр тавьсан, энэ нь тэр өөрийгөө барьж чадахгүй зууралдсан сэтгэлд автсанаас болсон. Яагаад ийм байдал гардаг вэ? Буддын шашинд, чи юу ч харсан бай битгий тоо, бүгд буг чөтгөрийн хуурмаг үзэгдэл, чи зөвхөн өөрийгөө самади-д оруулж дээш бясалга гэж заадаг. Яагаад чамд үзүүлэхгүй, чамайг тэдгээр зүйлд зууралдуулахгүй гэж байгаа вэ? Учир нь ийм асуудал гарахаас болгоомжилж байгаа юм. Буддын шашны бясалгалд ямар ч эрчимт бясалгалын арга гэж байдаггүй, мөн сударт үүнээс хэрхэн зайлах талаар заасан зүйлс байхгүй. Шагжамүни тухайн үедээ тийм Дарма заагаагүй, өөрийн сэтгэлээс буг чөтгөрийн үймүүлэл үүсэх, санаа дагаж хувирах асуудлаас зайлуулахын тулд бясалгалын дунд харсан бүх байдлыг чөтгөрийн хуурмаг үзэгдэл гэж хэлсэн. Тиймээс хүнд зууралдсан сэтгэл гарахад чөтгөрийн хуурмаг үзэгдэл үүсдэг, үүнээс салахад тун хэцүү. Энэ хүн үүнийг зөвөөр шийдвэрлэхгүй л бол сүйднэ, буг чөтгөрийн замаар орно. Тэр өөрийгөө Будда гэж хэлж байгаа учраас аль хэдийн буг чөтгөрийн замаар орсон юм, эцэст нь түүнд магадгүй сүнс шүглэж эсвэл өөр зүйлтэй учирч бүрмөсөн дуусна. Түүний сэтгэл буруутсанаас бүрмөсөн доош унасан. Ийм хүн нэлээд олон байдаг. Одоо энэ ангид хүртэл өөрийгөө нэлээд дажгүй сайн гэж үздэг, дээгүүр зангаар ярьдаг хүмүүс байдаг. Өөрийгөө чухам ямар учиртай байгаагаа ч мэдэхгүй, Буддын шашинд ийм зүйлийг маш их цээрлэдэг. Миний сая ярьсан бол буг чөтгөр үймүүлэх өөр нэгэн хэлбэр бөгөөд үүнийг өөрийн сэтгэлээс буг чөтгөр үүсэх буюу санаа дагаж хувирах гэж хэлдэг.



Бээжинд ийм сурагчид байдаг, мөн зарим газарт ч бас гарсан, бясалгагчдыг маш ихээр үймүүлж байна.

Нэг хүн надаас “Багшаа, та яагаад ийм байдлыг арилгахгүй байгаа юм бэ?” гэж асуусан. Та бүгд боддоо, хэрэв бид чиний бясалгалын зам дээрх бүх саад бэрхшээлийг арилгаж өгөөд байвал чи яаж бясалгах юм? Буг чөтгөрийн үймүүлэл дор чамайг бясалгалаа үргэлжлүүлж чадах үгүйг, Бумбыг үнэхээр ухамсарлаж чадах эсэхийг, үймүүлэлд автах автахгүйг, бясалгалынхаа энэ номд баттай зогсож чадах үгүйг чинь харна. Бясалгал бол том давллагаа элсийг шигшихтэй адил, эцэст нь тунаж үлдэх нь шижир алт. Иймэрхүү үймүүлэл байхгүй бол бясалгал хэтэрхий амархан болно гэж би хэлнэ, миний харж байгаагаар чиний бясалгал хэтэрхий амархан байна. Дээд түвшний аугаа гэгээрэгчид үүнийг шударга бус байна гэж үздэг: “Чи юу хийгээд байна вэ? Хүнийг ингэж авардаг юм уу? Бясалгалын замд ямар ч саад тохиолдохгүй шууд эцэст нь хүрвэл үүнийг бясалгал гэх үү? Бясалгах тусам улам тав тухтай болж, ямар ч үймүүлэх зүйл байхгүй болбол, үүнийг яаж зөвшөөрч болох юм?” Энд л асуудал нь байгаа юм, би бас энэ талаар бодож байгаа. Эхний үед би маш олон ийм буг чөтгөрийг дарсан. Миний бодлоор, хэрэв би үргэлж ингэж хийгээд байвал бас болохгүй. Тэд надад ингэж хэлсэн: “Чи тэдний бясалгалыг хэтэрхий амархан болгож байна. Хүмүүс зөвхөн ялихгүй бэрхшээл зовлонтой, хүн хоорондын өчүүхэн төдий асуудалтай. Харин тэдэнд салж чадахгүй байгаа зууралдсан сэтгэл маш их байна! Төөрөгдөл, үймүүлийн дунд чиний Дафа-г ойлгож чадах уу үгүй юу гэдэг нь асуулт хэвээр үлдэж байна!” Ийм асуудал байдаг учраас үймүүлэл, сорилтууд байх болно. Энэ бол буг чөтгөр үймүүлэх нэг янзын хэлбэр

гэж би хэлсэн. Хүнийг жинхэнэ аврахад маш хэцүү, харин хүнийг сүйтгэхэд тун амархан. Сэтгэл чинь нэгэнт буруутвал, чи даруй сүйднэ.

### **Эзэн бодол хүчтэй байх ёстой**

Хүний төрөл төрөлдөө үйлдсэн муу үйл нь хүнд гай зовлонг бий болгодог, бясалгагч хүнд нүглийн саад бий болдог, иймээс төрөх, хөгшрөх, өвчлөх, үхэх оршдог. Энэ бол ердийн үйлийн үр юм. Бас өөр нэг хэлбэрийн маш хүчтэй нүгэл байдаг, энэ нь бясалгадаг хүнд маш их нөлөөлдөг, үүнийг бодлын нүгэл гэдэг. Хүн амьд л байгаа цагт юм боддог. Хүн энгийн хүмүүсийн дунд төөрсний улмаас толгойд нь үргэлж нэр алдар, ашиг хонжоо, хүсэл тачаал, уур хилэнгийн гэх мэт бодол байнга орж ирж байдаг, яваандаа ийм бодлууд нь хүчтэй бодлын нүгэл үүсгэдэг. Өөр орон зайнуудад бүх зүйлс амьтай байдаг, нүгэл ч бас адилхан. Хүн ариун номоор бясалгаж эхлэхэд нүглээ арилгах ёстой. Нүглээ арилгах гэдэг нь нүглийг устгах, хувиргах юм. Мэдээж нүгэл эсэргүүцнэ, тиймээс хүнд гай зовлон, саад бэрхшээл тохиолддог. Гэвч бодлын нүгэл хүний тархийг шууд үймүүлж чаддаг, тийм учраас бодоод Багшийг болон Дафа-г зандарсан, муу бодол санаа, хүнийг харааж зүхсэн үгнүүд орж ирдэг. Тэгэхэд зарим бясалгагч ямар учиртайг нь мэдэхгүй, тийм бодол өөрөөс нь гарсан гэж боддог. Мөн зарим хүн үүнийг шүтлэсэн сүнс гэж боддог гэхдээ энэ нь тийм биш юм, харин бодлын нүгэл хүний тархинд туссанаас болдог. Зарим хүний эзэн бодол хүчгүй байдаг, бодлын нүглийг дагаад муу зүйл хийдэг, ийм хүн сүйрнэ, доош унана. Гэхдээ ихэнх хүмүүс өөрийн хүчтэй бодлоор (хүчтэй Эзэн бодлоор) үүнийг зайлуулж, эсэргүүцэж чаддаг. Ийм байвал тэр хүн аврагдах боломжтой, сайн мууг ялгаж

чадна, өөрөөр хэлбэл ухамсар нь сайн, миний Фашэнь энэ бодлын нүглийн ихэнх хэсгийг арилгаж өгнө. Ийм байдал нэлээд их гардаг. Ийм байдал гарахад чамайг өөрөө энэ муу бодлыг ялан дийлж чадах эсэхийг чинь харна, туушгай бат зогсож чадаж байвал нүгэл арилна.

### **Сэтгэл заавал зөв байх ёстой**

Зөв бус сэтгэл гэж юу вэ? Энэ нь тухайн хүн өөрийгөө үргэлж бясалгагч гэж үзэж чаддаггүй. Бясалгагч хүн бясалгалын явцад бэрхшээл зовлонтой тулгарна, энэ бэрхшээл гарахдаа магадгүй хүн хүний хоорондын зөрчлөөр илэрдэг, бие биеэ чадах гэх мэт зүйл гарна, шууд чиний шиньшин-д нөлөөлнө. Ийм тохиолдол нэлээд их байдаг. Бас өөр юу тааралдах вэ? Бидний бие гэнэт таагүй болдог, яагаад гэвэл үйлийн үрээ төлөх нь янз бүрийн байдлаар илэрдэг. Тодорхой нэг хугацаанд чамд үнэн ч юм шиг, хуурамч ч юм шиг санагдана, чамд гон байгаа юм уу үгүй юу, бясалгаж чадах юм уу үгүй юу, үндсэндээ дээш бясалгаж болох юм уу үгүй юу, эсвэл Будда байдаг юм уу үгүй юу, үнэн юм уу худал юм уу гэсэн эргэлзэх асуудал гарна. Ирээдүйд чамд ийм байдал ахин дахин гарна, чамд ийм хуурамч сэтгэгдэл төрүүлнэ, энэ бүгдийг оршдоггүй худал мэт санагдуулна—энэ нь чиний бясалгалдаа баттай байж чадах эсэхийг харах явдал юм. Чи өөртөө гуйвшгүй баттай зогсох ёстой гэж хэлнэ, тэр үед ийм сэтгэлтэйгээр үнэхээр гуйвшгүй, баттай байж чадвал чи үүнийг жамаараа сайн хийнэ, яагаад гэвэл чиний шиньшин аль хэдийн дээшилсэн байх болно. Гэхдээ чи одоохондоо тийм тогтвортой биш байгаа, хэрэв чамд энэ бэрхшээл зовлонг одоо шууд гаргавал чи үндсэндээ ухамсарлаж чадахгүй, бясалгаж огт чадахгүй болно. Тал бүрийн саад бэрхшээл гарч ирж магадгүй.

Бясалгалын явцад хүн ингэж л дээш бясалгана. Иймээс бидний зарим нь биенийхээ аль нэг газар таагүй болонгуут л өөрийгөө өвчин туссан гэж боддог, үргэлж өөртөө бясалгагч хүн гэж хандаж чаддаггүй, ийм зүйл тохиолдоход үүнийг өвчин гэж үздэг. “Яагаад ийм их бэрхшээл гардаг юм бол оо?” гэж боддог. Чамд хэлье, эдгээрийг чиний замаас аль хэдийн маш ихээр арилгаж өгсөн, чиний гай зовлон маш бага болсон. Чамд ингэж арилгаж өгөөгүй бол чи энэ гай зовлонтой учирвал магадгүй нас барах байсан, эсвэл орноосоо хэзээ ч өндийж чадахгүй болох байсан. Чамд үл ялих зүйл тохиолдонгуут л чи таагүй болчих юм, тийм таатай зүйл гэж хаана байх юм? Нэг жишээ хэлье, намайг Чанчуньд лекц уншиж байхад маш сайн төрөлхийн суурьтай нэг хүн байсан, үнэхээр ирээдүйтэй хүн байсан, надад ч бас энэ хүн таалагдсан. Тиймээс би түүний төлөх зовлонг жаахан хурдасгасан, үйлшин үр нь хурдан төлөгдөөд гон нь нээгдэг гэж төлөвлөсөн. Нэг өдөр түүнд гэнэт тархины цус харвалтын шинж тэмдэг илэрч газарт унасан, түүний дөрвөн мөч нь мэдээгүй мэт болж бие нь хөдөлж чадахгүй болсон, түүнийг эмнэлэгт яаралтай хүргэсэн. Дараа нь тэр удалгүй явж чаддаг болсон. Та бүгд боддоо, тархинд нь цус харвасан хүн яаж тийм хурдан сайжраад, гар хөлөө хөдөлгөөд явж чаддаг болох юм? Харин тэр эсрэгээр Фалунь Дафа-г сураад түүнийг ийм байдалд хүргэсэн гэж хэлсэн. Тархины цус харвалтаас яагаад ийм хурдан сайжрав гэж ер бодоогүй. Өнөөдөр тэр Фалунь Дафа-г сураагүй байсан бол тэр нэг унаад шууд нас барж мэдэх байсан, эсвэл үнэхээр тархины цус харвалт өгч, үлдсэн насандаа саажилттай болж мэдэх байсан.

Тийм болохоор хүнийг аврах ийм л хэцүү, өөрийнх нь төлөө хэчнээн их зүйл хийсэн ч тэр ухамсарлаагүй, харин ийм юм ярьж байдаг. Зарим хуучин сурагч ингэж асуудаг, “Багш аа, яагаад миний энд тэнд таагүй байгаа юм болоо? Би эмнэлэгт үзүүлж тариа хийлгэсэн ч тус болохгүй, эм уусан ч бас үйлчлэхгүй юм.” Тэр надад ингэж хэлэхээсээ ч зовохгүй! Мэдээж тус болохгүй шүү дээ. Тэдгээр нь өвчин биш, ямар нэмэр болох билээ дээ? Чи яваад биеэ үзүүлж болно. Бүх зүйл хэвийн боловч чиний бие нэг л тийм зовуурьтай байна. Манай нэг сурагч эмнэлэгт очиж тариулахдаа хэдэн зүүг тахийлгасан, эцэст нь дахиад хатгахад зүү нь бас ороогүй тариа нь шахагдаж асгарсан. Тэр ойлгосон: “Өө, би чинь бясалгагч хүн, тариа хийлгэх шаардлагагүй.” Тэр тариа хийлгэх хэрэггүй гэдгээ дөнгөж л ухаарсан. Иймээс чамд гай зовлон тохиолдох бүрд заавал энэ асуудал дээр анхаар. Зарим хүн намайг тэднийг эмнэлэгт очиж үзүүлэхийг зөвшөөрөхгүй байна гэж ойлгодог, тэгээд ингэж бодно: “Та намайг эмнэлэгт очиж үзүүлэхийг зөвшөөрөхгүй байгаа бол би чийгон багш олж үзүүлнэ.” Тэр үүнийг бас л өвчин гэж үзсэн хэвээр, тэр чийгон багш олж үзүүлнэ гэнэ. Хаанаас жинхэнэ чийгон багш олох гэж байгаа юм? Хуурамч дээр нь очвол тэр чамайг дор нь сүйдэлчихнэ.

Бид хэлсэн, тэр чийгон багшийг жинхэнэ үү хуурамч уу гэдгийг чи яаж ялгах юм? Олон чийгон багш өөрсдөдөө энэ нэрийг өгдөг. Намайг эрдэм шинжилгээний байгууллагаас хэмжин тогтоосон гэрчилгээ, бичиг баримтууд энд байна. Олон чийгон багш хуурамч, тэд өөрсдөдөө нэр өргөмжилчихсэн, иймэрхүү хууран мэхлэгчид хаа сайгүй байдаг. Тийм хуурамч чийгон багш бас өвчнийг эдгээж чадна. Яаж эдгээдэг вэ? Түүнд сүнс шүглэсэн байдаг, үүнгүйгээр

тэр хүнийг залилж чадахгүй! Тэр шүглэсэн сүнс гон гаргаж бас өвчнийг эдгээж чаддаг, энэ нь нэг төрлийн энергийн оршихуй бөгөөд энгийн хүмүүсийг маш амархан хязгаарладаг. Гэхдээ би хэлсэн, “Тэр шүглэсэн сүнс чамайг эдгээхдээ чиний биед ямар зүйл өгөх вэ?” Маш бичил түвшинд харахад энэ нь шүглэсэн сүнсний дүрстэй байдаг, үүнийг чиний бие дээр гаргавал яах бол гэж чи бодож байна? “Сүнс даллахад амархан, зайлуулахад хэцүү.” Энгийн хүмүүсийн талаар бид ярихгүй, тэд зөвхөн энгийн хүнээрээ байх хүсэлтэй, түр зуурын тааламжтай байдлыг л хүсдэг. Гэхдээ чи бясалгаж байгаа хүн, биеэ тасралтгүйгээр ариусгах хэрэгтэй биз дээ? Энэ зүйл чиний бие дээр гарвал хэзээ чи түүнийг биеэсээ зайлуулж чадах юм? Мөн тэр бас тодорхой хэмжээний энергитэй. Зарим хүн ингэж боддог, “Фалунь яагаад түүнийг оруулсан бэ? Багшийн Фашэнь биднийг хамгаалдаг биз дээ?” Манай энэ орчлон ертөнцөд нэг зарчим байдаг: Чи өөрөө ямар нэгэн зүйлийг хүсэж байвал, хэн ч хөндлөнгөөс оролцохгүй, чи юунд тэмүүлнэ, хэн ч чиний тэр хэрэгт оролцохгүй. Миний Фашэнь чамайг болнулах гэж дохио сануулга өгнө, гэхдээ чи үргэлж хүссэнээрээ зүтгээд байвал чамайг харж хандахаа болино, хүнийг хүчээр бясалгуулна гэж хаана байх юм? Чамайг хүчилснээр, шахсанаар чи бясалгадаг болохгүй. Жинхэнэ дээшлэхийн тухайд чамаас өөрөөс чинь шалтгаална, чи өөрийгөө сайжруулах хүсэлгүй бол хэнд ч ямар ч арга байхгүй. Чамд энэ зарчмыг мэдүүлээ, чамд Фа заалаа, чи өөрийгөө дээшлүүлэхийг хүсэхгүй байвал хэнийг буруутгах юм? Чи юу хүснэ, түүнд Фалунь оролцохгүй, миний Фашэнь ч оролцохгүй, энэ бол гарцаагүй. Бүүр зарим хүн, өөр чийгон багш нарын хичээлд хүртэл суусан

байдаг, тэгээд гэртээ хариад бие нь эвгүйтсэн. Тэр бол мэдээж. Тэгвэл Фашэнь яагаад чамайг хамгаалаагүй вэ? Чи юуны тулд тийшээ очсон юм бэ? Юм сонсохоор очсон, энэ нь чи ямар нэг юм хүсэж очсон биш гэж үү? Чи чихээрээ оруулаагүй бол тэр чиний биед яаж орж чадах юм? Зарим хүн өөрийнхөө Фалуньийг гажуудуулсан. Би чамд хэлье, энэ Фалунь бол чиний аминаас илүү үнэтэй. Тэр бол дээд зэргийн оршихуй, дур зоргоороо түүнийг сүйтгэж болохгүй. Одоо хуурамч чийгон багш нар маш олон болсон, зарим нь бүүр их нэрд гарсан байдаг. Би Хятадын чийгон судлалын нийгэмлэгийн удирдагчидтай уулзаж байхдаа эрт дээр үед байсан бага хатан Дажин хааны ордонд ямар их гай барцад тарьсан тухай ярьсан, тэр үнэг хорон муу зүйл их хийсэн ч одоогийн хуурамч чийгон багш нарын орон даяар учруулсан гай гамшигтай дүйцэхгүй. Хэр олон хүнд гай тарьсан гээч?! Гаднаас нь харахад энэ нь чамд нэлээд сайн юм шиг харагдаж магад, гэхдээ хэчнээн олон хүн биедээ тэдгээр зүйлсийг тээж яваа вэ? Хэрэв тэр чамд өгвөл чам руу орчихно, энэ нь хэтэрхий газар авсан учраас энгийн хүмүүст тэдгээрийг гаднаас нь хараад танихад хэцүү.

Зарим хүн, “Өнөөдөр энэ чийгон лекцэд сууж Ли Хонжи-гийн ярихыг сонсоод чийгон бол маш өргөн бөгөөд гүн гүнзгий юм байна гэдгийг ойлголоо! Би дараагийн удаа өөр чийгон лекцүүдийг бас очиж сонсох хэрэгтэй юм байна” гэж бодож магад. Би чамайг хэрхэвч тийшээ бүү оч гэж хэлмээр байна, муу зүйл сонсвол чихээр чинь орно. Хүнийг аврахад маш хэцүү, чиний бодол санааг өөрчлөхөд маш хэцүү, чиний биеийг засахад бас маш хэцүү байдаг. Хуурамч чийгон багш нар их олон байдаг, жинхэнэ

уламжлагдсан чийгон багш байлаа ч тэр үнэндээ цэвэр гэж үү? Зарим амьтад маш айхтар, тэдгээр зүйлс түүний биед гарч чадахгүй байсан ч тэр тэднийг бас зайлуулж чадахгүй. Түүнд эдгээр зүйлсийг өргөн хэмжээнд шийдвэрлэх чадвар байхгүй, тэр тусмаа түүний сурагчдад бүүр ч байхгүй, тэр тэнд гон гаргахад дотор нь янз бүрийн зүйлс холилсон байдаг. Хэдий тэр багш өөрөө ёс журамтай байлаа ч түүний сурагчид нь зөв зүйтэй биш, янз бүрийн шүтлэсэн сүнс болон эсэн бусын зүйлтэй байдаг.

Чи үнэхээр Фалунь Дафа-гаар бясалгах хүсэлтэй бол битгий очиж сонс. Фалунь Дафа-гаар бясалгахыг хүсэхгүй, юм болгоноор хичээллэх сонирхолтой бол чи очиж болно. Би чамайг боль гэхгүй, чамайг бас Фалунь Дафа-гийн шавь гэж үзэхгүй, ямар нэгэн асуудал гарвал чи Фалунь Дафа-г бясалгаснаас боллоо гэж бүү яриарай. Чи шиньшин-ий шалгуурын дагуу явж, Дафа-гийн дагуу бясалгах юм бол жинхэнэ Фалунь Дафа-гийн сурагч. Зарим хүн ингэж асуудаг: “Би өөр чийгон-оор хичээллэдэг хүнтэй харилцаж болох уу?” Би чамд хэлье, тэд бол зөвхөн чийгон-оор хичээллэдэг, чи бол Дафа-гаар бясалгадаг, энэ лекцийг дуусахад чиний түвшин тэднийг төсөөлшгүй хол орхино, энэ Фалунь бол олон үеийнхний бясалгаж бүтээсэн зүйл, мөн зүйрлэшгүй хүчирхэг юм. Мэдээж чи тэдэнтэй харьцахдаа ямар нэгэн зүйл хүлээж авахгүй, зүгээр энгийн найз нөхдийн хувьд бол асуудалгүй. Гэхдээ тэдний биед үнэхээр юм байвал маш муу, тэдэнтэй харьцахгүй байсан нь дээр. Эхнэр нөхрийн хувьд хэн нэг нь өөр чийгон бясалгал хийдэг бол энэ нь бас нэг их асуудалгүй гэж би бодож байна. Гэхдээ нэг зүйл бий, чи ариун Фа-гаар хичээллэдэг учраас чиний бясалгал бусдад ашиг тустай. Хань чинь буруу



нoмooр хичээллэдэг бол, магадгүй биен дээр нь буруу номын зүйлс байж болно, чиний аюулгүй байдлын үүднээс түүнийг бас цэвэрлэнэ. Өөр орон зайд юу ч байсан чамд цэвэрлэж өгнө, гэрийн чинь орчныг бас цэвэрлэнэ. Орчин чинь цэвэрлэгдээгүй, янз бүрийн зүйл чамайг үймүүлээд байвал чи яаж бясалгах юм?

Гэхдээ нэг тохиолдолд миний Фашэнь цэвэрлэж өгөхгүй. Нэг өдөр миний Фашэнь гэрт нь ирэхийг манай нэгэн сурагч харсан, тэр их баярласан, “Багшийн Фашэнь ирлээ, Багш аа та орооч.” Миний Фашэнь: “Чиний өрөө тун замбараагүй байна, олон зүйлс байна” гэж хэлээд яваад өгсөн. Ихэвчлэн өөр орон зайд олон сүнс байвал миний Фашэнь чамд арилгаж өгнө. Гэхдээ түүний өрөөнд янз бүрийн замбараагүй чийгон номууд дүүрэн байсан. Тэр үүнийг ойлгоод тэдгээрийг шатаахыг нь шатааж, зарахыг нь зарж цэвэрлэсэн. Дараа нь миний Фашэнь буцаж ирсэн. Үүнийг тэр сурагч надад ярьсан юм.

Бас мэрэгч төлөгч дээр очиж үзүүлдэг хүмүүс байдаг. Нэг хүн надаас асуусан: “Багш аа, би Фалунь Дафагаар хичээллэдэг. Би Жоун эсвэл мэрэг төлөг үзэх талын зүйлд их сонирхолтой, би урьдын адил үзэж байж болох уу?” Би үүнийг ингэж хэлье, хэрэв чи тодорхой хэмжээний энергитэй бол, чиний хэлсэн үг нөлөөтэй. Хэрэв тийм учиргүй байтал, чи түүнд тийм гэж хэлээд бодит болгочихвол магадгүй муу зүйл хийчихнэ, энгийн хүн бол их сул дорой байдаг, түүний мэдээлэл нь тогтвортой биш, өөрчлөгдөж болох талтай. Чи хүнд ямар нэгэн зүйл шууд хэлнэ, магадгүй тэр гай зовлон нь биеллээ олно. Хэрэв тэр хүн маш их нүгэлтэй, түүнийгээ төлөх ёстой байтал чи түүнд дандаа сайн зүйл тохиолдоно гэж хэлээд байвал

тэр нүглээ төлж чадахгүйд хүрнэ, нүглээ төлөхгүй байж болох юм уу? Чи хүнийг хохироож байгаа юм биш үү? Зарим хүн энэ зүйлээсээ салж чаддаггүй зууралдаад л байдаг, өөрийгөө их чадвартай юм шиг үздэг, энэ нь зууралдсан сэтгэл биш гэж үү? Чи үнэхээр мэдэж байсан ч бясалгагчийн хувьд шиньшин-ээ сахих хэрэгтэй, бас хамаагүй тэнгэрийн нууцыг энгийн хүнд задалж болохгүй, энэ бол зарчим. Жоуи-гээр яаж үзсэн ч зарим зүйл аль хэдийн өөрчлөгдсөн байдаг. Мэргэлээд байхад зарим зүйл үнэн, зарим нь худлаа байдаг, энгийн хүний нийгэмд мэрэг төлөг үзэх зүйл байхыг зөвшөөрдөг. Чи бол жинхэнэ гон-той хүн, би хэлбэл, жинхэнэ бясалгадаг хүн дээд түвшний шалгуураар өөрийгөө шаардах хэрэгтэй. Гэтэл зарим бясалгагч өөр хүнээр мэргэлүүлдэг, “би хэр явна, миний хувь төөргийг үзээд өгөөч? Миний бясалгал ямаршуу байна? Эсвэл надад ямар нэгэн гай зовлон тохиолдох уу?” Тэд хүнээр ийм зүйл мэргэлүүлэхээр очдог. Хэрэв тэр тохиолдох зовлон бэрхшээлийг үзээд хэлчихвэл чи яаж өөрийгөө дээшлүүлэх юм? Бясалгагч хүний үлдсэн амьдрал нь шинээр зохицуулагддаг. Алганы хээ, царайны шинж байдал, төрсөн өдрийн төөрөг, мөн биеийн бүх мэдээллүүд нь урьдынхтай аль хэдийн таарахгүй болсон, өөрчлөгдсөн. Чи мэрэгч төлөгч дээр очвол түүнд итгэнэ, итгэхгүй бол үзүүлэх гэж очих уу? Түүний хэлсэн зүйл нь өнгөцхөн, чиний өнгөрсөн үеийн зүйлүүдийг л хэлж өгнө, гэвч үнэн хэрэгтээ энэ нь аль хэдийн өөрчлөгдсөн. Тэгвэл та бүгд бодоод үз дээ, чи түүгээр мэргэлүүлсэн, чи сонсоод итгэсэн биз дээ? Тэгвэл энэ нь чамайг сэтгэл санааны дарамтад оруулахгүй гэж үү? Энэ нь сэтгэлийн дарамт үүсгэнэ, чи үүнийг байнга бодоод байвал зууралдсан сэтгэл биш гэж үү? Тэгвэл энэ зууралдсан сэтгэлийг яаж

арилгах юм? Чи өөртөө нэмэлт бэрхшээл учруулсан юм биш үү? Энэ зууралдсан сэтгэлээс салахын тулд бас илүү зовлон амсах болно биз дээ? Сорилт болгон эсвэл гай зовлон болгон нь бясалгалдаа дээш ахих уу эсвэл доош унах уу гэсэн асуудалтай холбоотой. Энэ зам нь угаасаа хэцүү, гэтэл чи үүнийг бас улам хүндрүүлээд байвал яаж үүнийг давах юм? Магадгүй үүнээс болоод чамд өөр гай зовлон, төвөгтэй асуудал тулгарна. Чиний өөрчлөгдсөн замыг өөр хүмүүсээр үзүүлэхийг зөвшөөрөхгүй. Хэрэв энэ нь бусдад харагддаг, хэн нэгэн чамд хэзээ ямар гай зовлон тохиолдохыг хэлж өгөөд байвал чи яаж бясалгах юм? Иймээс хэнд ч үзэхийг зөвшөөрөхгүй. Өөр аль ч номын бясалгагчдад үзэхийг зөвшөөрөхгүй, нэг номын бясалгалын шавь нар байсан ч нэг нэгнийгээ үзэхийг зөвшөөрөхгүй, хэн ч үүнийг зөв хэлж чадахгүй. Яагаад гэвэл энэ насны амьдрал нь өөрчлөгдсөн, энэ бол бясалгалд л зориулагдсан амьдрал юм.

Надаас нэг хүн өөр пашны болон чийгон-ы ном уншиж болох уу гэж асуусан. Бид хэлсэн, пашны номуудын тухайд гэвэл, ялангуяа Буддын пашны номууд бол бүгд шиньшин-ийг хэрхэн бясалгахыг хүмүүст заасан байдаг. Бид бас Буддын системийнх, уг нь бол асуудалгүй. Гэхдээ нэг зүйл бий, олон сударт зарим зүйлс орчуулах явцад утга нь алдагдсан байдаг. Түүнээс гадна, олон судар номыг янз бүрийн түвшнээс тайлбарласан, мөн дураараа томьёолсон байдаг, энэ бол Дарма-г сүйтгэж байгаа хэрэг юм. Ном судрыг хамаагүй тайлбарласан хүн Буддын түвшний хүрээнээс хэтэрхий хол, жинхэнэ ухагдахууныг нь ер ойлгоогүй байдаг, иймээс ойлголт нь зөрөөтэй. Судруудыг бүрэн дүүрэн ойлгоно гэвэл тун хэцүү, чи өөрөө ухаж ойлгоно гэвэл чадахгүй. Гэхдээ чи, “би ном сударт

сонирхолтой” гээд л үргэлж ном судар уншаад байвал тэр номын үүдэнд бясалгасан болно, учир нь сударт тэр номын үүдний гон болон Фа нэгдмэл байдаг, нэг л сурах юм бол чи тэр номоор бясалгасан болно, ийм асуудал байдаг. Хэрэв чи түүнд гүнзгий ороод тэр дагуу бясалгавал магадгүй тэр номын үүдэнд бясалгасан болно, манай бясалгалынх биш болно. Түүхийн туршид, бясалгалд “зөвхөн нэг бясалгалаар туушгтай бясалгах” гэсэн зарчмыг хэзээнээс баримталж ирсэн, хэрэв чи үнэхээр тухайн номын үүдэнд бясалгахыг хүсвэл тэр номын үүднийхээ судрыг л унших хэрэгтэй.

Чийгон номуудын тухайд гэвэл, чи бясалгахыг хүсэж байвал тэдгээрийг бүү унш. Ялангуяа өнөө үед гарсан чийгон-ы номуудыг битгий үз. “Хуанди Нэйжин” (Шар хааны дотоод эмчилгээний ном), “Шинмин Гүижиг” (Зан авир, амийг удирдах) эсвэл “Дао Зань” (Бумбын жаяг) эдгээр номын тухайд гэвэл бас адилхан, битгий хар. Хэдийгээр эдгээрт муу мэдээлэл байхгүй боловч, дотроо бас янз бүрийн түвшний мэдээлэл агуулдаг. Тэдгээр нь бас бясалгалын аргууд юм, нэг уншихад л чамд ямар нэгэн зүйл орж ирэн үймүүлнэ, ямар нэгэн өгүүлбэр нь чамд зүйтэй мэт санагдангуут л ямар нэгэн зүйл чам дээр ирнэ. Энэ нь муу зүйл биш боловч чиний гон-д гаднын ямар нэгэн зүйл гэнэт нэмэгдвэл чи яаж цааш бясалгах юм? Бас асуудал гарахгүй гэж үү? Хэрэв чи телевиз дотор хамааралгүй нэг сэлбэг нэмчихвэл яах бол гэж бодож байна? Энэ нь дорхноо эвдэрнэ, ийм л зарчимтай юм. Түүнчлэн одоогийн маш олон чийгон номууд хуурамч төдийгүй янз бүрийн мэдээлэл агуулсан байдаг. Манай нэг сурагч чийгон номын хуудсыг эргүүлж байтал дотроос нь нэг том могой гэнэт үсрэн гарч ирсэн. Би энэ талаар дэлгэрэнгүй яримааргүй байна. Миний саяны дурдсан

бол бясалгагч хүн өөртөө зөв хандаж чадаагүйн улмаас зарим нэг гай зовлон, өөрөөр хэлбэл сэтгэл зөв бишээс зовлон бэрхшээлийг үүсгэдэг. Цаашид ийм асуудал гаргахгүйн тулд бид тэдгээрийг онцолж, яаж үүнд хандах, тэдгээрийг хэрхэн ялгах талаар та бүхэнд мэдүүлж буй нь ашиг тустай юм. Саяны миний ярьсныг ач холбогдолгүй гэж бүү бодоорой, хүн бүр үүнийг анхаарч үзэх хэрэгтэй, ийм зүйл дээр ихэвчлэн асуудал гардаг, үүнийг тойрсон асуудал байнга гардаг. Бясалгал бол туйлын хэцүү бөгөөд маш нарийн байдаг, хэрэв чи жаахан л хайхрамжгүй хандвал доош унаж тэр дороо сүйдэж болно, тиймээс чиний сэтгэл заавал зөв байх ёстой.

## **Ушу чийгон**

Дотоод бясалгалын аргаас гадна Ушу чийгон байдаг. Би Ушу чийгон-ы талаар ярихдаа нэг асуудлыг чухалчилъя, өдгөө бясалгалын хүрээнд маш олон чийгон-ы талаар ярьдаг болсон.

Одоо дүрслэх урлагийн чийгон, хөгжмийн чийгон, уран бичгийн чийгон, бүжгийн чийгон гээд янз бүрийн төрлүүд гарч ирсэн, эдгээр нь бүгд чийгон гэж үү? Надад их хачирхалтай санагдаж байна. Би хэлбэл, энэ нь чийгон-ыг эмх замбараагүй болгож байна, чийгон-ыг эмх замбараагүй болгож байгаагаас гадна, чийгон-ыг зүгээр л сүйтгэж байна. Тэдгээрийн онолын үндэслэл нь юу вэ? Зураг зурах, дуулах, бүжиглэх эсвэл үсэг бичиж байхдаа ховсдолын байдалд буюу тэдний хэлдгээр чийгон байдалд ороход чийгон болчих юм уу? Үүнийг ийм байдлаар ойлгож болохгүй. Энэ нь чийгон-ыг бусниулж байгаа хэрэг биш гэж үү? Чийгон бол хүний биеийн бясалгалын өргөн бөгөөд гүн гүнзгий эрдэм юм. Ховсдолын байдалд орвол чийгон

болчих юм уу? Тэгвэл бид ийм байдалтайгаар бие засах газар орвол үүнийг юу гэж хэлэх вэ? Энэ нь чийгон-ыг бусниулж байгаа юм биш үү? Би үүнийг чийгон-ыг сүйтгэж байна гэж хэлнэ. Хоёр жилийн өмнө Дорно дахины эрүүл мэндийн үзэсгэлэнд уран бичлэгийн чийгон гэгч зүйл байсан. Уран бичлэгийн чийгон гэж юу вэ? Би тэнд очиж харахад нэг хүн бийрээр юм бичсэн, тэр бичсэнийхээ дараа үсэг болгон дээр гараараа чий гаргаж байсан, гаргасан нь бүгд хар чий. Ухаан санаа нь мөнгө, алдар нэрээр дүүрэн байхад яаж түүнд гон байх юм? Түүний чий ч гэсэн сайн биш. Тэдгээрийг хананд өлгөөд нэлээд үнэтэй зарж байсан, гэхдээ дандаа гадаадынхан түүнээс авсан. Тэдгээрийг худалдаж аваад гэртээ аваачсан хүнд сайн юм болохгүй гэж би хэлнэ. Хар чий яаж сайн байх юм? Тэр хүний царай нь тэр чигтээ хар бараан, тэр мөнгөний шуналд автсан, үргэлж л мөнгө бодоод байхад яаж гон байх юм? Гэсэн хэдий ч түүний нэрийн хуудсан дээр “Олон улсын уран бичлэгийн чийгон мастер” гэх мэтчилэн зөндөө цол хэргэм бичээстэй байсан. Иймэрхүү зүйлсийг яаж чийгон гэж хэлж болох юм?

Та бүхэн боддоо, манай энэ лекцэд суусны дараа та нарын нааяс ерэн хувь нь өвчнөөсөө салаад зогсохгүй бас гон гарна, жинхэнэ гон. Чиний биед байгаа зүйлс аль хэдийн ердийн биш болсон. Чи өөрөө бясалгах юм бол, бүх насаараа бясалгаад ч тэдгээрийг гаргаж чадахгүй. Залуу хүн одоогоос бясалгаж эхлээд, түүнд бас жинхэнэ сайн багш заасан ч миний өгсөн зүйлүүдийг энэ насандаа бясалгаад гаргаж чадахгүй. Бид их олон үеийн туршид энэ Фалунь болон эдгээр механизмыг бүтээсэн, эдгээр зүйлүүдийг бүгдийг нь чамд нэгэн зэрэг суулгаж өгсөн. Тийм болохоор та бүгд үүнийг бигтийг амархан олдсон гээд амархан

алдчихаарай гэж захья. Эдгээр нь туйлын үнэ цэнтэй, мөнгөөр хэмжишгүй. Энэ ангийг төгсөөд чи жинхэнэ гон-той болно, энэ бол дээд энергийн бие бодь. Чи гэртээ хариад хэдэн үг бич, чиний бичгийн хэв ямар байх нь хамаагүй, энэ нь гон-той! Тэгвэл бидний энэ лекцэд суусан хүн болгон “Багш” нэр зүүгээд бүгд уран бичлэгийн чийгон багш болж болох уу? Би үүнийг тэгж ойлгож болохгүй гэж хэлнэ. Яагаад гэвэл жинхэнэ гон-той хүн, энергитэй хүн үүнийг зориуд санаатайгаар гаргах гэсний шаардлага байхгүй, чи хүрсэн юм болгондоо энерги үлдээнэ, бүгд гялалзан гэрэлтэх болно.

Би нэг сэтгүүл дээр уран бичлэгийн чийгон-ы анги эхлэх гэж байгаа тухай олж харсан. Би үүнийг яаж заах талаар товчхон уншив. Түүнд бичихдээ: Эхлээд амьсгалаа авах гаргахаа зохицуулна, дараа нь 15-30 минут дань-тиань дахь чий дээр бодлоо төвлөрүүлж суугаад бодлоороо энэ дань-тиань-ий чий-г гарын шуруу явуулна, тэгээд бийрээ авч бэхэнд дүрээд чий-г бийрийн үзүүрт шилжүүлнэ. Бодол нь тэнд хүрэхэд үсэг бичиж эхэлнэ. Энэ нь хүнийг мэхэлж байгаа хэрэг юм биш үү? Өө тэгвэл, чий-г нэг газраас нөгөө рүү шилжүүлбэл чийгон болчих юм уу? Тийм бол бид хоол идэхийнхээ өмнө хэсэг зуур завилж суугаад савхаа бариад чий-гээ савхны үзүүрт шилжүүлж хоолоо идье, тэгвэл үүнийг хоол идэх чийгон гэж нэрлэе, тэгж болох уу? Идсэн нь харин бүгд энерги, би энэ асуудал дээр зүгээр л санаагаа хэлж байна. Би үүнийг чийгон-ыг гутааж байна гэж хэлнэ, тэд чийгон-ыг ийм өнгөцхөн байдлаар боддог, иймээс үүнийг ингэж ойлгож болохгүй.

Гэхдээ Ушу чийгон бол аль эртнээс бие даасан чийгон гэж явдаг. Яагаад гэвэл энэ нь хэдэн мянган жилийн уламжлалтай, бүрэн цогц бясалгалын онол ба бясалгалын аргатай, тиймээс үүнийг бүрэн цогц зүйлд тооцож болно. Хэдий тийм боловч Ушу чийгон бол дотоод бясалгалын аргын хамгийн доод түвшинд харьяалагддаг. Хатуу чийгон бол нэг төрлийн материаллаг энергийн бөөгнөрөл бөгөөд зөвхөн гар тулаанд хэрэглэдэг. Та бүхэнд нэг жишээ хэлье, Бээжингийн нэг сурагч манай Фалунь Дафогийн ангид суусны дараа гараараа юм дарж болохгүй болсон. Тэр дэлгүүрт хүүхдийн тэрэг үзэж байгаад бат бөхийг нь шалгах гээд гараараа дартал тэрэг тасхийгээд хугарсан, тэр их гайхсан. Гэртээ хариад сандал дээр суухдаа гараараа дарж болохгүй, дарах л юм бол сандал нь хугараад уначихна. Тэр надаас, энэ ямар учиртай юм бол оо гэж асуусан. Би түүнд зууралдсан сэтгэл гаргахгүйн тулд тайлбарлаагүй. Энэ бүгд бол хэвийн зүйл, болж л байг, битгий тоо, энэ бол сайн зүйл гэж хэлсэн. Хэрэв энэ ер бусын чадварыг сайн эзэмших юм бол гараараа чулууг нэг базахад буталж чадна. Энэ нь хатуу чийгон биш гэж үү? Гэхдээ тэр хатуу чийгон-оор хичээллэж үзээгүй. Дотоод бясалгалд эдгээр ер бусын чадварууд гарч болдог, гэхдээ хүн шиньшин-ээ барихад хэцүү учраас ер бусын чадвар гарсан ч хэрэглэхийг нь зөвшөөрөхгүй. Ялангуяа бясалгалын түвшин нь доогуур байгаа, шиньшин нь хараахан дээшлээгүй байгаа хүнд доод түвшинд гардаг тэдгээр ер бусын чадваруудыг огтхон ч өгөхгүй. Яваандаа чиний түвшин дээшлэх тусам эдгээр зүйлсийн хэрэг гэж байхгүй болно, үүнийг гаргах ч шаардлагагүй болно.



Ушу чийгон-оор чухам яаж хичээллэдэг вэ? Ушу чийгон-оор хичээллэхэд чий-г гүйлгэх ёстой байдаг, гэхдээ эхэндээ чий-г гүйлгэхэд амаргүй, хэдийгээр чий-г гүйлгэхийг хүссэн ч хийж чадахгүй байж магадгүй, тэгвэл яах вэ? Өөрийнхөө гар, цээжний хоёр тал, хөлийн тавхай, хөл, гарын шуу болон толгойгоо дасгалжуулах хэрэгтэй. Яаж дасгалжуулдаг вэ? Зарим хүн гараараа юм уу алгаараа мод цохино. Зарим нь гараараа чулуун хавтанг пад пад хийтэл алгодна. Ясаараа цохивол ямар их өвдөх бол, жаахан хүчтэй цохивол цус гарна, чий-г гүйлгэж чадахгүй хэвээр байна. Тэгвэл яах вэ? Тэр гараа эргүүлэхэд цус нь доош шахагдана, тэгээд гар нь хөөж эхэлнэ. Үнэндээ бол хавдсан юм, дараа нь тэр чулууг алгадахад яс нь зөөлөвтэй болж чулуунд шууд хүрэхгүй, тийм их өвдөхгүй болно. Тэр үргэлжлүүлэн хичээллэхэд багш нь түүнд заана, аажмаар чий-г гүйлгэж сурна. Гэхдээ зөвхөн чий-г гүйлгэж сурах нь хангалтгүй, жинхэнэ гар тулаанд өрсөлдөгч түүнийг хүлээхгүй. Мэдээж хүн чий-г гүйлгэж сурвал цохилтыг даана, бүдүүн саваагаар цохилсан ч магадгүй өвдөхгүй, чий-г гүйлгэж хөөлгөнө. Гэхдээ чий бол эхэн үеийн хамгийн анхны зүйл, тасралтгүй сургуулилсны дүнд энэ нь дээд энергийн бие бодид хувирч болно. Дээд энергийн бие бодид хувирахад энэ нь аажмаар их нягтралтай энергийн бөөгнөрлийг үүсгэнэ. Энэ энергийн бөөгнөрөл нь оюун сэтгэхүйтэй, иймээс тэр бас ер бусын чадвартай бөөгнөрөл бөгөөд нэг төрлийн ер бусын чадвар юм. Гэхдээ энэ нь цохилт өгөх, цохилтоос хамгаалахад л чиглэсэн ер бусын чадвар юм, үүнийг өвчин эдгээхэд хэрэглэвэл үйлчлэхгүй. Яагаад гэвэл энэ дээд энергийн бие бодь нь өөр орон зайд оршдог, манай энэ орон зайд дамждаггүй,

иймээс цаг хугацаа нь биднийхээс хурдан. Чи цохилт хийхдээ чий-г гүйлгэх юм уу бодлоо төвлөрүүлэх ч шаардлагагүй, гон аль хэдийн хэрэгтэй газраа хүрчихсэн байна. Хүний цохилтыг хаахад мөн адил гон хэрэгтэй газраа түрүүлээд бас ирчихнэ. Чи ямар ч хурдтай цохилт хийсэн гон чамаас хурдан, хоёр талын цаг хугацааны ухагдахуун өөр байдаг. Ушу чийгон-оор хичээллэхэд “Төмөр элсэн алга”, “Шунх улаан алга”, “Очирваань хөл” мөн “Архад тавхай” хэмээн нэрлэгдэх чадваруудыг гаргаж болно, энэ бол энгийн хүнээс гардаг чадвар юм. Энгийн хүн сургуулилсны дүнд ийм хэмжээнд хүрч чадна.

Ушу чийгон ба дотоод бясалгах арга хоорондын хамгийн том ялгаа нь бол: Ушу чийгон нь хөдөлгөөн дунд хичээллэхийг шаарддаг, иймээс чий нь арьсан доогуур гүйдэг. Хөдөлгөөн дунд хичээллэх учраас амгалан байдалд орохгүй, мөн чий дань-тиань-д бас орохгүй, чий арьсан доогуур болон булчингаар дамжин гүйнэ, тиймээс амь биенийг бясалгахгүй мөн дээд түвшний чадваруудыг гаргаж чадахгүй. Манай дотоод бясалгал амгалан байдалд хийхийг шаардана. Жирийн бясалгалд чий дань-тиань-д буюу хэвлийн доод хэсэгт орохыг ярьдаг, тэд амгалан байдалд бясалгах, бие (бэньти)-э хувиргахыг шаарддаг, амь биенийг бясалгаж болно, бясалгаад бүүр дээд түвшинд хүрч болно.

Та нар магадгүй уран зохиолын номоос Алтан хонх хуяг, Төмөр цамц, мөн Зуун алхмын зайнаас Улиас модыг нэвт цохих гэх мэтийн чадвар байдгийг уншсан байх. Хөнгөн гон-той хүн өндөрт нааш цааш дүүлж чадна, тэр ч байтугай зарим хүн өөр орон зайд орж чаддаг. Ийм чадвар байдаг уу? Тиймээ байдаг, энэ бол

батгай юм, гэхдээ энгийн хүмүүсийн дунд байхгүй. Ийм дээд зэргийн кунфу-г бясалгаж гаргасан хүн гайхуулж болохгүй. Яагаад гэвэл ийм хүн жирийн Ушу-гаар хичээллэдэггүй бөгөөд тэр нь энгийн хүний түвшнээс давсан зүйл учраас энэ хүн заавал дотоод бясалгалын аргын дагуу бясалгах ёстой. Тэр хүн шиньшин-ээ эрхэмлэж шиньшин-ээ дээшлүүлэх ёстой, материалаг сонирхол гэх мэтийн зүйлийг хөнгөн авч үзэх хэрэгтэй. Тэр хэдийгээр иймэрхүү кунфу бясалгаж гаргасан ч хойшид түүнийгээ энгийн хүмүүсийн дунд хамаагүй хэрэглэж болохгүй. Харин хүнгүй газар өөрөө хэрэглэж үзэж болно. Тэдгээр зохиолуудыг уншихад, тийм хүн илдээр тулалдах гарын авлага, алт эрдэнэс эсвэл хүүхний төлөө алалдаж, тулалдаж гардаг. Хүн болгон их чадвартай, ид шидийн байдлаар ирж явдгаар дүрслэгдсэн байдаг. Та бүгд боддоо, жинхэнэ ийм кунфу чадвартай хүн үүнийг дотоод бясалгалаар гаргасан биш гэж үү? Тэд шиньшин-ээ чухалчлан бясалгаж байж тийм чадвартай болдог. Алдар нэр, эд материалын болон янз бүрийн хүсэл сонирхолд хөнгөн ханддаг, тэд яаж хүн алах юм? Тэд алт мөнгө хөрөнгийг тийм чухалд үзнэ гэж үү? Огтхон ч тэгэхгүй, тэдгээр нь зөвхөн уран сайхны хэтрүүлэг юм. Хүмүүс сэтгэлийн таашаалыг хөөцөлддөг, хүслээ тайлахын тулд юу ч хийхээс буцахгүй. Зохиолчид эдгээр зүйлсийг онцлон барьж, чиний хүсэл сонирхолд нийцүүлэхийн тулд, мөн чамд таашаагдахын тулд чадлаараа бичдэг. Сонирхол татсан зүйлс их бичих тусам уншигчдыг илүү татна, тэр бүгд зөвхөн урлагийн хэтрүүлэг юм. Жинхэнэ тийм кунфу чадвартай хүмүүс ийм үйлдэл хийхгүй, ялангуяа нийтийн дунд тэдгээрийг бүр ч үзүүлэхгүй.

## Гайхуулах сэтгэл

Манай олон сурагч энгийн хүмүүсийн дунд бясалгаж байгаа болохоор янз бүрийн сэтгэлээсээ салж чаддаггүй, тэдгээр нь аль хэдийн зуршил болсон мэт байдаг, тэд өөрсдөө ч мэдэрдэггүй. Гайхуулах сэтгэл нь ямар ч тохиолдолд гардаг, сайн зүйл хийхэд бас гайхуулах сэтгэл илэрдэг. Ердийн үед хүн нэр хүнд, хувийн ашиг сонирхлын төлөө байдаг ч, жаахан ашиг олохоороо, “би их чадвартай, хүчтэй” гэж онгирдог, өөрийгөө гайхуулдаг. Бидэнд бас ийм байдал байдаг, арай сайн бясалгаснаараа, тэнгэрийн мэлмий нь илүү тод хардгаараа, дасгал хөдөлгөөнөө арай эвсэлтэй хийдгээрээ гайхуулдаг.

Нэг нь магад ингэж хэлнэ, “би Ли багшийн ярьсан нэг зүйлийг сонссон.” Хүмүүс түүнийг хүрээлэн юу хэлэхийг нь сонсоно, тэр өөрийнхөө ойлгосноор нэмж хачирлан ярина. Зорилго нь юу вэ? Энэ нь өөрийгөө л гайхуулж байгаа юм. Зарим хүн ам дамжсан цуурхал тараадаг, нэг нэгэндээ амтархан яриад л, тэр л ганцаараа мэдээлэл сайтай юм шиг. Манай энэ олон сурагчдаас хэн ч түүн шиг ойлгодоггүй, түүнээс илүү мэддэггүй юм шиг ярина, энэ нь түүнд аль хэдийн зуршил болсныг өөрөө ч анзаардаггүй. Түүнд өөрийгөө гайхуулах далд сэтгэл байдаг, тийм биш бол ийм цуурхал тараах хэрэг байна уу? Бас зарим хүн Багш хэзээ уул руугаа буцах тухай цуу яриа тараадаг. Би уулнаас ирээгүй, ямар уул руугаа буцах юм? Бас зарим нь намайг тэр үед хэн нэгэнд тэгж хэлсэн, эсвэл хэн нэгнийг онцгой харж үзсэн гэж ярина. Иймэрхүү зүйл тараах нь ямар ашиг тустай юм бэ? Ямар ч ашиггүй, гэхдээ энэ бол бидний харснаар тэдний зууралдсан сэтгэл, гайхуулах сэтгэл юм.

Зарим хүн миний гарын үсгийг авах гэж ирдэг. Зорилго нь юу вэ? Бас л энгийн хүний зүйл, гарын үсгийг дурсгал болгон авна гэнэ. Чи бясалгахгүй бол миний гарын үсэг чамд ямар ч хэрэг болохгүй. Миний номын үг болгонд миний дүр болон Фалу нь байгаа, мөн өгүүлбэр болгон нь миний хэлсэн үг, миний гарын үсгийг авах хэрэг байгаа юм уу? Зарим хүн гарын үсэг авбал Багшийн мэдээлэл намайг хамгаална гэж боддог. Тэд бас л мэдээлэл гэгчийн зүйлийг чухалчилсан хэвээр байх юм, бид мэдээллийг онцолдоггүй. Энэ ном бол аль хэдийн үнээр цэгнэшгүй болсон. Чи өөр юу хүсэж байна вэ? Энэ бүгд бол тэдгээр зууралдсан сэтгэлийн илрэл юм. Бас зарим хүн, намайг дагалдан явдаг сурагчдыг хараад тэдний дадал зуршлыг нь сайн муу ч гэж ялгалгүйгээр дуурайж сурдаг. Үнэндээ хэн ямар байх нь хамаагүй, зөвхөн нэг л Фа байгаа, зөвхөн энэ Дафа-гийн дагуу явбал тэр бол жинхэнэ шалгуур. Би хажууд ажилладаг хүмүүсээ тусгай харж үзсэн юм байхгүй, та бүгдтэй адилхан, тэд зөвхөн Судалгааны нийгэмлэгийн ажилтнууд юм, ийм сэтгэл бүү гарга. Ийм сэтгэл гарахад чи санамсаргүйгээр Дафа-г эвдэх нөлөө үзүүлнэ. Чиний гаргасан дуулиантай цуу ярианаас болж зөрчил ч гарч болно, сурагчдын Багштай ойр байж илүү зүйл мэдэх гэсэн зууралдсан сэтгэлийг өдөөж болно, энэ мэт зүйлс бүгд асуудал биш гэж үү?

Энэ гайхуулах сэтгэл бас өөр ямар үр дагаварт хүргэж болох вэ? Би бясалгал зааж эхлээд хоёр жил болж байна, манай Фалу нь Дафа-д бясалгадаг хуучин сурагчдаас зарим хүний гон магадгүй удахгүй нээгдэнэ; зарим нь аажим гэгээрэх байдалд орно, гэнэт аажим гэгээрэх байдалд орно. Яагаад эдгээр ер бусын чадвар эрт гараагүй вэ? Яагаад гэвэл би чамайг гэнэт тийм

өндөр түвшинд түлхэж гаргасан, чиний энгийн хүний зууралдсан сэтгэл орхигдоогүй байгаа учраас үүнийг зөвшөөрөхгүй. Мэдээж чиний шиньшин аль хэдийн их дээшилсэн, гэвч бас маш олон зууралдсан сэтгэлээ орхногүй байна, иймээс тэдгээр ер бусын чадварыг чамд гаргуулахгүй. Энэ хэсэг хугацаа өнгөрч чамайг баг гуйвшгүй болоход чамайг тэр даруй аажим гэгээрэх байдалд хүргэнэ. Ийнхүү аажмаар гэгээрэх байдал ороход чиний тэнгэрийн мэлмий маш өндөр түвшинд нээгдэнэ, чамд их олон ер бусын чадвар гарна. Үнэндээ би та бүхэнд хэлэхэд, жинхэнэ бясалгахад дөнгөж эхлээд л олон ер бусын чадвар гардаг, чи аль хэдийн тийм өндөр түвшинд хүрсэн, иймээс маш олон ер бусын чадвартай байна. Ойрын үед бидний олон хүнд магадгүй ийм байдал гарна. Бас зарим хүн өндөр түвшин рүү бясалгаж чадахгүй, түүний биед байгаа зүйлс, түүний тэвчих чадвар нь хамтдаа тогтоогдсон байдаг. Иймээс зарим хүн маш доод түвшинд гон нь нээгдэх ба гэгээрнэ, бүрмөсөн гэгээрнэ, ийм хүмүүс гарна.

Би энэ асуудлыг хэлдэг учир нь, нэг өдөр тийм хүн гарч ирэхэд та нар түүнийг гайхалтай нэгэн, гэгээрсэн хүн гэж битгий үзээрэй. Энэ бол бясалгал дахь маш ноцтой асуудал. Зөвхөн Дафа-гийн дагуу явбал аливааг зөв хийж чадна. Чи хэн нэгний ямар нэгэн ер бусын чадвар, увдис, зарим зүйлийг нь харчхаад түүний үгийг сонсон, дагаж болохгүй. Чи ч түүнийг хохирооно, түүнд баярлах омогших сэтгэл гарахад тэр бүх зүйлээ алдана, хаагдчихна, эцэст нь доош унана. Гон нь нээгдсэн хүн бас доош унаж болдог, өөрийгөө сайн барьж чадахгүй бол гэгээрсэн байлаа ч мөн доош унадаг. Энгийн хүмүүсийн дунд бясалгаж байгаа та нар битгий хэл, Будда хүртэл өөрийгөө сайн барьж

чадахгүй бол доош унана! Иймээс хэр их ер бусын чадвар, ямар их сүр хүчтэй гон чадвар гарсан ч бай, эсвэл чиний увдис чадвар ямар ч ихээр илэрсэн байсан чи заавал өөрийгөө бариарай. Ойрын үед бидний дунд сууж байгаа зарим хүн алга болоод хэсэг байж байгаад гарч ирдэг болсон, ийм л байдаг, үүнээс ч бүр илүү увдис чадвар гарах болно. Чи ирээдүйд яах вэ? Манай сурагчид, шавь нарын хувьд ийм зүйл ирээдүйд чамд гарсан ч бай бусдад гарсан ч бай, битгий түүнийг шүтэн бишрээрэй, бүү үүнийг хүсээрэй. Чиний сэтгэл нэг л буруутвал дорхноо дуусна, чи доошоо унана. Магадгүй чи тэднээс дээгүүр, гэхдээ зөвхөн чиний ер бусын чадвар хараахан гараагүй байж болно. Чи наад зах нь тухайн энэ асуудал дээр уначихна, иймээс хүн бүр энэ асуудал дээр тун анхааралтай хандах хэрэгтэй. Бид үүнийг маш чухал асуудалд авч үзэж байна, яагаад гэвэл ийм байдал удахгүй гарах болно, ийм зүйл гарахад чи өөрийгөө сайн барьж чадахгүй бол асуудал үүснэ.

Бясалгагч хүнд гон гарахад буюу гон нээгдэхэд, эсвэл жинхэнэ гэгээрвэл өөрийгөө онцгой нэгэн гэж үзэж болохгүй, түүнд харагдсан зүйлс тэр хүний түвшинд хязгаарлагддаг. Яагаад гэвэл бясалгаад тэр түвшинд хүрсэн, түүний ухамсар нь тэнд хүрсэн, түүний шиньшин-ий шалгуур бас тэнд хүрсэн, түүний билиг ухаан тэр хэмжээнд хүрсэн. Иймээс бүр дээд түвшний зүйлд тэр итгэхгүй байж магадгүй. Итгэхгүй учраас өөрийнхөө харж байгаа зүйлийг туйлын гэж боддог, зөвхөн тийм зүйлс л байдаг гэж үздэг. Түүний түвшин дөнгөж л энд байна, тиймээс үнэнээс тун хол байна.

Зарим хүний гон нь тодорхой нэг түвшинд нээгдэнэ, түүнээс цааш бясалгая гэсэн ч бясалгаж чадахгүй,

тиймээс зөвхөн тэр түвшинд гон нь нээгдэж гэгээрнэ. Бидний дундаас бясалгаж гарсан хүн, зарим нь дэлхийн жижиг замд гэгээрнэ, зарим нь янз бүрийн түвшинд гэгээрнэ, мөн зарим нь гэгээрлийн хутагт хүрнэ. Гэгээрлийн хутагт хүрсэн бол хамгийн өндөрт гэгээрсэн гэсэн үг, тиймээс янз бүрийн түвшин дэх байдлыг харж мөн янз бүрийн түвшинд илэрч чадна. Дэлхийн жижиг замын хамгийн доод түвшинд гэгээрсэн ч гэсэн зарим орон зай болон гэгээрэгсдийг харж бас тэдэнтэй харилцаж чадна. Тэр үед чи сэтгэл ханаж болохгүй, яагаад гэвэл чиний гон дэлхийн жижиг замын доод түвшинд нээгдсэн болохоор гэгээрлийн хутагт хүрч чадахгүй, энэ бол гарцаагүй. Тэгвэл яах вэ? Тэр зөвхөн энэ түвшинд л үлдэнэ. Дээд түвшин рүү бясалгах нь ирээдүйн хэрэг болно. Түүний бясалгал зөвхөн тийм л өндөрт хүрч чадна, тэгэхлээр гон-ыг нь түгжээд байх хэрэг байна уу? Чи өөрөө энэ янзаараа цааш бясалгаад байсан ч түүнээс илүү ахиж чадахгүй, чиний бясалгал эцэстээ хүрсэн учраас гон чинь нээгдэнэ, ийм хүмүүс олон гарах болно. Ямар ч байдал гарсан шиньшин-ээ сайн барих хэрэгтэй, зөвхөн Дафа-гийн дагуу хийвэл жинхэнэ зөв. Чи ер бусын чадвартай болсон ч бай, гон чинь нээгдсэн ч бай, энэ бүгдийг чи Дафа-гаар бясалгаж байж олж авсан. Хэрэв чи Дафа-г хоёрдугаарт тавьж өөрийнхөө увдис, ер бусын чадварыг тэргүүнд тавивал, эсвэл гэгээрээд өөрийнхөө таньж мэдсэнийг л зөв гэж үзвэл, тэр ч байтугай өөрийгөө агуу гэж үзвэл, мөн өөрийгөө Дафа-гаас дээгүүр тавивал, чи аль хэдийн доош унаж эхэлсэн гэж би хэлнэ, энэ бол маш аюултай, цаашлах тусам улам дордоно. Тэр цагт чи жинхэнэ хүнд байдалд орно, хий дэмий бясалгасан болно, аливааг



зөв хийхгүй бол доош унаж бясалгал чинь талаар болно.

Би бас та нарт нэг зүйлийг хэлье: энэ номын агуулга нь миний хэд хэдэн лекцээр заасан Фа-гаар нэгтгэгдсэн. Бүгд миний зааснаар, өгүүлбэр болгон нь миний хэлснээр байгаа, үг болгоныг дуу бичлэгийн хальснаас буулгаж үг үгээр нь хуулан бичсэн. Миний шавь нар, сурагчид надад тусалж хураасан бичлэгээс бүгдийг буулгаж бичсэн, дараа нь би ахин дахин хянасан. Энэ бүгд бол миний Фа, миний заасан бол зөвхөн энэ л Фа юм.

# Долдугаар лекц

## Амь хороох асуудал

Амь хороох нь маш эмзэг асуудал юм, бясалгаж байгаа хүний хувьд бид амь хороож болохгүй гэсэн хатуу шаардлага тавьдаг. Буддын систем, Бумбын систем эсвэл Чимэнь бясалгал аль нь ч байсан, ямар бясалгал байхаас үл хамааран энэ нь ариун номын бясалгал л бол энэ асуудлыг туйлаас зөвшөөрөхгүй, амь хороохыг цээрлэнэ, энэ бол гарцаагүй. Яагаад гэвэл амь хороосноос болж маш том асуудал үүсдэг, бид энэ талаар тодорхой авч ярих хэрэгтэй. Анхны Буддын шашинд амь хороох асуудал дээр гол нь хүний амь хороохыг авч үздэг байсан, энэ нь хамгийн ноцтой үйлдэл. Дараа нь том биетэй амийг, бод малыг эсвэл харьцангуй том амьтдыг хороохыг бас их ноцтойд үздэг болсон. Бясалгагчдын хүрээнд яагаад амь хороох асуудлыг үргэлж их ноцтойд авч үздэг вэ? Урьд өмнө Буддын шашинд ярихдаа үхэх болоогүй амийг хороовол орох оронгүй өнчин сүнс болно гэдэг байсан. Урьд нь тийм хүмүүсийн сүнсийг энэ зовлонгоос гэтэлгэх зан үйл хийдэг байсан. Энэ зан үйлийг хийхгүй бол тэдгээр аминууд идэж уух юмгүй маш хэцүү зовлонг байдал орно, эртний Буддын шашинд ингэж л ярьдаг байсан.

Нэг нь нөгөөдөө муу зүйл хийвэл хариуд нь их хэмжээний Дэ (буян)-гээр төлөх ёстой болдог гэж бид ярьдаг, энд гол нь хэн нэгний юмыг авах гэх мэтийн зүйлийг л ярьж байна. Харин гэнэт нэг амийг бүрэлгэвэл, тэр нь амьтан ч бай, эсвэл өөр амь бодь ч бай маш том нүгэл үүсгэнэ. Урьд өмнө амь бүрэлгэхийг гол нь хүн дээр ярьдаг байсан, тэр нь нэлээд том нүгэл

болно. Гэхдээ бусад жирийн амьтны амийг хорооход багагүй нүгэлд тооцогддог, шууд их хэмжээний нүгэл үүсгэдэг. Ялангуяа бясалгагч хүний хувьд, бясалгалын явц дахь түвшин болгонд чамд зарим бэрхшээл зовлонг хуваарилж өгдөг, тэр бүгд бол чиний өөрийн нүглээс үүдэлтэй бөгөөд чиний өөрийн гай зовлон юм, чамайг дээшлүүлэхийн тулд тэдгээрийг чиний янз бүрийн түвшинд хувааж тавьдаг. Чи зөвхөн шиньшин-ээ дээшлүүлэхэд давж чадна. Гэхдээ гэнэт тийм их нүгэл ирвэл, чи яаж түүнийг давах юм? Чиний шиньшин-ий хэмжээнд түүнийг даван туулах ямар ч арга байхгүй, энэ нь чамайг бясалгах ямар ч аргагүй байдалд оруулж магадгүй юм.

Хүн төрөхөд энэ орчлон ертөнцийн орон зайнуудын тодорхой хүрээнд түүний маш олон биес нэгэн зэрэг төрдөг болохыг бид олж мэдсэн, тэд бүгд хоорондоо адилхан харагдана, нэг ижил нэртэй мөн тэдний хийж байгаа зүйлс нь төстэй, тиймээс тэднийг тухайн хүний бүтэн биеийн нэг хэсэг гэж хэлж болно. Үүнээс үүдэн ийм асуудал гардаг, хэрэв тэдний нэг нь (өөр том амьтны амь бас адилхан) гэнэт үхвэл өөр орон зайнуудад орших бусдынх нь урьдын оноосон амьдралын зурлага нь дуусаагүй, бас олон жил амьдрах хугацаа үлдсэн байдаг. Тэгвэл тэр үхсэн хүн орчлон ертөнцийн орон зайд хоргодох газаргүй тэнүүчлэн явах болно. Урьд цагт ийм өнчин сүнс идэж уух юмгүй өлсөж цангаж, их шаналан зовдог гэдэг байсан, ийм байж магадгүй юм. Гэхдээ бид тийм хүн үнэхээр маш аймшигтай байдалд ордгийг харсан, өөр орон зайнуудад байгаа түүний бусдынх нь амьдралын явц дуусах хүртэл тэр хүлээсээр л байх болно, зөвхөн түүний дараа л тэд хамтдаа цаашдынхаа тавилант газраа очдог. Удаан хүлээх тусам улам их зовлон

амсана. Тэр их зовж шаналах тусам үүнээс үүдэн гарах нүгэл нь түүнийг алсан хүний биед нэмэгдсээр байх болно, тэгвэл боддоо, чи хэр их нүгэл хураах вэ? Бид үүнийг ер бусын чадвараараа харсан юм.

Бид бас ийм нэг байдлыг харсан: Хүн төрөхөд, тусгай нэг орон зайд түүний энэ насны бүхэл амьдралын зураг төөрөг нь оршдог, өөрөөр хэлбэл энэ амь хэдийд юу хийх ёстой нь бүгд тэнд байдаг. Хэн түүний амьдралыг урьдчилан төлөвлөсөн бэ? Энэ нь мэдээж дээд зэргийн амь энэ бүхнийг хийсэн байж таарна. Жишээлбэл манай энгийн хүний нийгэмд хүн төрснийхөө дараа тодорхой нэг гэр бүлд өснө, тухайн нэг сургуульд сурна, мөн том болоод ямар нэгэн ажлын газарт ажиллана, тэр ажил амьдралынхаа замаар янз бүрийн нийгмийн харилцаанд орно, өөрөөр хэлбэл бүхэл нийгэм дэх зүй тогтолт ингэж төлөвлөгдсөн байдаг. Гэтэл энэ амь гэнэт үхсэн учраас энэ бүгд урьдын зохицуулсны дагуу явагдахгүй, өөрчлөлт гарна. Тэгвэл хэн үүнийг будилаантуулсан, түүнийг дээд түвшний амь өршөөхгүй. Та бүхэн боддоо, бид бясалгагч хүний хувьд дээд түвшин рүү бясалгахыг хүсдэг, тэр дээд түвшний амь бодь түүнийг уучлахгүй, чи хэлдээ, тэр хүн яаж бясалгах юм? Зарим багш нарын түвшин энэ төлөвлөлтийг хийсэн дээд түвшний амь бодийн хэмжээнд ч хүрэхгүй. Тэгэхээр тэр хүний багш бас шийтгэгдэнэ, түүнийг доош унагана. Чи боддоо, энэ жирийн асуудал гэж үү? Тэгэхээр ийм зүйл хийсэн хүн бясалгахад маш их хэцүү.

Фалунь Дафа-гийн бясалгагчдын дунд зарим нь дайны жилүүдэд байлдаж явсан хүмүүс байж магадгүй. Тэдгээр дайнууд нь тэнгэрийн том өөрчлөлтөөс үүдэн гарсан нэг янзын байдал бөгөөд чи бол зөвхөн

тэр төлөв байдлын нэг элемент нь юм. Тэнгэрийн өөрчлөлт болоход хүмүүс оролцохгүй бол ийм байдал энгийн хүний нийгэмд нөлөөлөхгүй, мөн түүнийг тэнгэрийн өөрчлөлт гэж хэлэхгүй. Тэдгээр үйл явдлууд том өөрчлөлтийн дагуу гарсан болохоор тэр бүгднийг чамд тохож болохгүй. Энд бидний яриад байгаа зүйл бол хувийн ашиг хонжоо хөөцөлдөж, өөрийн хувийн ашиг сонирхлоо хангах үүднээс эсвэл өөрийн чинь зүйлд хэн нэгэн нөлөөлснөөс болж муу зүйл хийсний үр дүнд үүсдэг нүгэл юм. Энэ нь бүхэл бүтэн том орон зайн өөрчлөлтүүдийг хамарсан бол, эсвэл нийгмийн томоохон нөхцөл байдлын өөрчлөлтүүдтэй холбоотой гарсан бол чамд хамаарах асуудал биш.

Амь хороох нь маш их нүглийг бий болгодог. Зарим хүн ингэж бодож магадгүй: “Амь хороож болохгүй болчихлоо, би гэрийнхнийхээ хоолыг бэлддэг, амь алахгүй бол манай гэрийнхэн юу идэх юм?” Ийм тодорхой асуудлыг би авч хэлэлцэхгүй, би бясалгач хүнд Фа зааж байна, зүгээр энгийн хүнд яаж амьдрахыг нь хэлж өгч байгаа юм биш. Бодит асуудалд яаж хандах дээр Дафа-гийн дагуу цэгнэ, чи яаж хийвэл зохистой гэж үзнэ, тэгж хий. Энгийн хүн бол хүссэн болгоноо л хийнэ, энэ нь тэдний хэрэг, хүн болгон жинхэнэ бясалгах боломжгүй. Бясалгадаг хүний хувьд бол дээд шалгуурын дагуу өөрийгөө шаардах хэрэгтэй, тиймээс би энд бясалгачдад энэ нөхцөлийг тавьж байна.

Хүн ба амьтнаас гадна ургамал ч гэсэн амьтай. Бусад орон зайнуудад орших аливаа бие бодь бүхэн амьтай байдаг. Чиний тэнгэрийн мэлмий Фа нүдний түвшинд нээгдэхэд чулуу, хана болон юм бүхэн чамтай ярьж мэндчилж байхыг үзнэ. Магадгүй зарим хүн ингэж бодно: Бидний иддэг үр тариа болон ногоо бүгд

амьтай; гэрт бас ялаа шумуул байвал яах ёстой вэ? Зун цагт шумуул хазаад тун таагүй байдаг, хазуулаад зүгээр л суугаад байх уу, хоол унд дээр ялаа суугаад завааруулж байхыг харвал алж ч болохгүй. Би та бүгдэд хэлье, бид хамаагүй шалтгаангүйгээр амь хороож болохгүй. Гэхдээ бид бас юм болгонд хэт туйлширч болохгүй, үргэлж ялихгүй зүйлд анхаарч, алхахдаа хүртэл шоргоолжин дээр гишгэхээс болгоомжлон цовхорч явна. Би хэлье, чи тэгвэл их ядаргаатай амьдрах болно, энэ нь бас зууралдсан сэтгэл биш гэж үү? Чи цовхорч яваад шоргоолж гишгэж алаагүй байж болно, гэхдээ маш олон бичил организмыг гишгээд алсан байж болно. Бичил орчинд маш олон, бүр жижиг амь боднуд байдаг, мөөгөнцөр ба бактери мөн багтана, чи гишгээд тэдгээрээс зөндөө олныг алсан байж магадгүй, тэгвэл бид амьдрах аргагүй болно. Бид тийм байна гэсэн үг биш, тэгвэл бясалгах боломжгүй болно. Хүн юмыг өргөн хүрээнд харж, зөв зохистой, сүр жавхлантай байдлаар бясалгах хэрэгтэй.

Хүмүүс бид амьдрах эрхээ сахин хамгаалах эрхтэй, тиймээс бидний амьдрах орчин хүний амьдралын шаардлагад нийцсэн байх ёстой. Бид санаатайгаар амь хороож болохгүй, гэхдээ бас үл ялих зүйлд хэт болгоомжлоод байж болохгүй. Жишээлбэл бидний ургуулдаг ногоо, тарьсан үр тариа бүгд амьтай, эдгээр нь амьтай гээд бид юм идэж уухаасаа татгалзаж болохгүй, тэгвэл яаж бясалгах юм? Түүнээс цаадхыг харах хэрэгтэй. Жишээ нь чамайг явж байхад зарим шоргоолж, шавж чиний хөл доор өртөөд гишгүүлж үхнэ, тэдний үхэх цаг нь магадгүй болсон, яагаад гэвэл чи тэднийг санаатайгаар алаагүй. Амь амьтдын ертөнцөд, эсвэл бусад бичил биетийн хувьд бас экологийн тэнцвэрт байдлын асуудал байдаг,

хэтэрхий олширвол асуудал үүснэ, бид тийм учраас юмыг зүй зохистой сүр жавхлантай байдлаар бясалгах хэрэгтэй. Гэрт ялаа шумуул байвал бид хөөж гаргаж, эсвэл цонхондоо тор татаад оруулахгүй байж болно. Заримдаа хөөж гаргаж чадахгүй бол албал тэр л биз. Хүмүүсийн амьдардаг орон байранд хүн хазаад хор учруулж байвал тэднийг мэдээж хөөж гаргах хэрэгтэй, хөөж гаргах боломжгүй бол хүн хазахыг нь хараад зүгээр суугаад байж болохгүй. Чи бясалгагч хүн учраас дархлаатай айхгүй, танай гэрийнхэн бясалгадаггүй энгийн хүмүүс, мөн халдварт өвчний асуудал байдаг, хүүхдийн нүүрэн дээр шумуул хазаж байхад зүгээр хараад суугаад байж болохгүй.

Би та бүгдэд нэг жишээ хэлье, Шагжамүни-гийн эртний үеийн нэгэн түүх байдаг. Нэг өдөр Шагжамүни ой модонд усанд орохоор болж шавиа дуудан ваннаа цэвэрлүүлэхээр явуулсан. Түүний шавь очоод харахад ванн дотор энд тэндгүй зөндөө хорхой шавж явж байсан, ванныг цэвэрлэх юм бол хорхой шавжууд үрэгдэнэ. Шавь нь буцаж ирээд Шагжамүнид хэлсэн: “Ванн дотор зөндөө хорхой шавж байна.” Шагжамүни түүн рүү харалгүй хэлсэн: “Чи очоод ванныг цэвэрлэчих.” Тэр шавь нь ванна дэргэд буцаж очоод яаж цэвэрлэхээ мэдэхгүй байсан, цэвэрлэвэл хорхой шавж үхэх болно, тэр дахин Шагжамүнид эргэж ирээд хэлсэн: “Багшаа, ванн дотор дүүрэн хорхой шавж байна. Хэрэв цэвэрлэвэл хорхой шавж үхнэ.” Шагжамүни түүн рүү хараад хэлсэн: “Би чамд ванныг цэвэрлэ гэж л хэлсэн.” Шавь нь гэнэт ухаарч тэр даруй ванныг цэвэрлэсэн. Энэ нь нэг асуудлыг ойлгомжтой болгож өгч байна, бид хорхой шавжаас болоод усанд орохоо больж болохгүй; мөн шумуулаас болж өөр амьдрах газар хайж явж бас болохгүй; мөн үр

тариа болон ногоо бүгд амьтай учраас бид амаа таглаад идэж ухаа хорьж болохгүй. Ийм биш юм, бид энэ харилцааг зөв зохицуулж зохистой байдлаар бясалгах хэрэгтэй. Бид санаатайгаар амь хороохгүй байхад л болно. Мөн түүнчлэн хүмүүст амьдрах орчин, амьдрах нөхцөл байх хэрэгтэй, үүнийг бас сахин хамгаалах ёстой, хүн бас амиа авч явж, хэвийн амьдралыг сахих хэрэгтэй.

Урьд нь зарим хуурамч чийгон багш нар ингэж ярьдаг байсан: “Билгийн тооллын нэгэнд эсвэл арван таванд амь хороож болно.” Тэдний зарим нь хоёр хөлтэй амьтдыг хороож болно гэж хэлдэг. Хоёр хөлтэй нь амь биш юм шиг. Билгийн тооллын нэгэнд эсвэл арван таванд амь албал амь хороосонд тооцогдохгүй гэж үү? Энэ нь ямар шороо ухаж байгаатай адил уу? Зарим хуурамч чийгон багш нарыг үгнээс нь, үйлдлээс нь мөн юу ярьж байгаагаар нь эсвэл юу хүсдэгээр нь таньж болно. Аливаа иймэрхүү зүйл ярьдаг чийгон багш нарт ер нь сүнс эсвэл амьтан шүглэсэн байдаг. Биед нь үнэг шүглэсэн чийгон багшийг тахианы мах идэж байхыг нь хараарай, амаа олохгүй ясыг нь хүртэл үлдээх дургүй үмхлэн иднэ.

Амь хороох нь зөвхөн маш их нүгэл авчраад зогсохгүй мөн энэрэнгүй сэтгэлийн асуудалтай холбоотой. Бид бясалгаж байгаа хүний хувьд энэрэнгүй сэтгэлтэй байх ёстой биз дээ? Бидний энэрэнгүй сэтгэл гарахад магадгүй хамаг амьтан зовж байгааг, хүн бүр зовж явааг харна. Ийм байдал гарна.

## **Мах идэх асуудал**

Мах идэх нь бас нэг эмзэг асуудал, гэхдээ мах идэх бол амь хороож байгаа хэрэг биш. Та нар Фа-д суралцаад



өдний хугацаа өнгөрөхөд бид та нарыг мах идэхээ боль гэж шаардаагүй. Олон чийгөн багш чамайг ангид нь оронгуут одоогоос мах идэхээ боль гэж хэлдэг. Магадгүй чи ингэж бодно: Гэнэт мах идэхээ болино гэвэл сэтгэл санааны хувьд бэлэн болж амжаагүй байна. Магадгүй өнөөдөр гэрт нь хийсэн хоол нь шарсан тахиа эсвэл хайрсан загас байна, тэдгээр нь их сайхан үнэртэх боловч идэж болохгүй. Шашинд бясалгахад бас адилхан, хүчээр мах идүүлэхгүй. Ер нь Буддын системийн бясалгалд болон зарим Бумбын системийн бясалгалд бас ингэж хэлдэг, мах идэхийг хориглодог. Бид энд чамайг тийм бай гэж хэлэхгүй, гэхдээ бид бас энэ асуудлыг авч ярьдаг. Тэгвэл бид юу шаарддаг вэ? Манай энэ бясалгалд Фа хүнийг бясалгадаг. Фа хүнийг бясалгахад зарим байдал гон-оос гардаг, Фа-гаас илэрч гардаг. Бясалгалын явцад өөр өөр түвшинд өөр өөр байдал гарна. Тэгвэл аль нэг өдөр эсвэл өнөөдрийн миний хичээлийн дараа зарим хүн ийм байдалд орж магадгүй: Мах идэж чадахгүй болно, мах шинхэг муухай үнэртэнэ, идэх юм бол бөөлжмөөр болно. Та нар хэнээр ч албадуулаагүй, мөн та нар өөрсдийгөө ч мах идэхгүй гэж хүчлээгүй, харин энэ байдал бол чиний өөрийн сэтгэлээс гарна, энэ түвшинд хүрэхэд гон-оос гарсан нөлөө чамайг мах идэж чадахгүй байдалд оруулдаг, хэрэв чи мах залгивал үнэхээр бөөлжиж гаргана.

Манай хуучин сурагчид Фалунь Дафа-гийн бясалгалд ийм байдал гардгийг бүгд мэднэ, өөр өөр түвшинд өөр өөр байдлаар илэрдэг. Зарим сурагчид маханд их дуртай, их хүчтэй зууралдсан сэтгэлтэй байдаг, ер нь мах их иддэг. Бусад хүмүүст мах шинхэг үнэртэй байхад тэдэнд тэгж санагдахгүй, мах идсэн хэвээр л байна. Энэ сэтгэлийг нь арилгахын тулд яах хэрэгтэй

вэ? Тэр мах идвэл гэдэс нь өвдөнө, идэхгүй байвал өвдөхгүй, ийм байдал гарна, утга нь түүнийг мах идэж болохгүй гэсэн үг. Манай бясалгалд үүнээс хойш мах идэх асуудал байхгүй болно гэсэн үг үү? Тийм биш. Бид энэ асуудалд хэрхэн хандвал зохих вэ? Мах идэж чадахгүй байгаа байдал нь үнэн сэтгэлээсээ мах идэж чадахгүйгээс болно. Зорилго нь юу вэ? Сүм хийдэд бясалгахад чамайг албадлагаар мах идүүлдэггүй байдал ба манай бясалгалд илэрч буй мах идэж чадахгүй болдог байдал нь хоёулаа хүний мах идэх хүсэл ба зууралдсан сэтгэлийг орхиулах зорилготой юм.

Зарим хүний аяганд мах байхгүй бол хоол нь хоолойгоор нь давахгүй, энэ бол энгийн хүний хүсэл. Нэг өглөө би Чанчуны Шэнли цэцэрлэгийн хойд хаалганы хажуугаар өнгөрч явтал гурван хүн чанга хашхиралдсаар гарч ирсэн. Тэдний нэг нь: “Ямар гэгчийн чийгон бэ? Мах идэж ч болохгүй гэнэ, арван насаа хасуулсан ч хамаагүй би мах иднэ!” гэж ярьж байсан. Тийм хүчтэй хүсэлтэй. Та бүгд боддоо, ийм хүслийг орхих хэрэгтэй биш гэж үү? Заавал орхих ёстой. Бясалгалын явц бол хүний янз бүрийн хүсэл, зууралдсан сэтгэлийг орхих юм. Шууд хэлбэл, хэрэв мах идэх хүслээ орхиогүй бол, энэ зууралдсан сэтгэлээсээ салаагүй гэсэн үг биш үү? Бясалгал яаж үр дүнд хүрэх юм? Тиймээс зууралдсан сэтгэл байх л юм бол түүнийг орхих ёстой. Гэхдээ үүнээс хойш хэзээ ч мах идэхгүй гэсэн үг биш, мах идэхээ болих нь гол зорилго биш, зорилго нь чамаар энэ зууралдсан сэтгэлийг орхиулахад юм. Хэрэв чи мах идэж чадахгүй байгаа тэр хэсэг хугацаанд энэ зууралдсан сэтгэлээ орхивол дараа нь магадгүй дахин мах идэж чадна, мах шинхэг үнэртэхгүй, идэхэд муухай амтагдахгүй болно, тэр үед чи мах идэж болно, ямар ч асуудалгүй.

Чи дахин мах идэж чаддаг болоход чиний зууралдсан сэтгэл, мах идэх хүсэл аль хэдийн байхгүй болсон байна. Гэхдээ нэг том өөрчлөлт гарна, дараа мах идэхэд тийм ч амттай биш болно, гэрт чинь махтай хоол хийвэл хамт иднэ, хийхгүй бол бодогдохгүй, идвэл тийм амттай санагдахгүй, ийм байдал гарах болно. Гэхдээ энгийн хүмүүсийн дунд бясалгахад тун амаргүй, гэрт чинь үргэлж махтай хоол хийдэг бол яваандаа чамд мах идэхэд дахиад их амттай санагдах болно. Ирээдүйд энэ байдал давтагдана, бясалгалын бүхий л явцын туршид олон удаа давтагдах болно. Чи дахиад гэнэт мах идэж чадахгүй болж магад, чи идэж чадахгүй бол идэх хэрэггүй, үнэхээр идэж чадахгүй, идвэл бөөлжинө; дахиад мах идэж чадаж байвал ид, аясаараа л бол. Мах идэх идэхгүйдээ учир нь байгаа юм биш, гол зорилго нь тэр зууралдсан сэтгэлийг орхиход юм.

Манай Фалуны Дафа-гаар бясалгахад хурдан явцтай байдаг, чи шиньшин-ээ дээшлүүлээд л байвал түвшин болгоныг их хурдан нэвтэрнэ. Зарим хүн маханд угаасаа тийм их зууралддаггүй, хоолонд нь мах байсан байгаагүй хамаагүй байдаг. Ийм хүмүүс ганц хоёр долоо хоногт л мах идэх сэтгэлээ орхидог. Зарим хүний хувьд магадгүй нэг, хоёр эсвэл гурван сар, магадгүй хагас жил ч үргэлжилж болно, маш онцгой тохиолдлыг эс тооцвол нэг жил хүрэхгүй, дараа нь эргээд мах идэж чаддаг болно. Яагаад гэвэл мах бол хэдийнээс хүмүүсийн иддэг үндсэн хоол нь болсон. Гэхдээ сүм хийдэд шавилан сууж бясалгадаг хүмүүс мах идэж болдоггүй.

Буддын шашинд мах идэх асуудлыг хэрхэн авч үздэг талаар ярья. Хамгийн эртний Буддын шашинд мах

идэхийг хорьдоггүй байсан. Шагжамүни шавь нараа дагуулан ойд очиж хүнд нөхцөлд бясалгаж байх үед мах идэхийг хорьсон сахил санваар байгаагүй. Яагаад байгаагүй вэ? Учир нь Шагжамүни 2500 жилийн өмнө Дарма номоо зааж байх үед хүний нийгэм их дорой хөгжилтэй байсан, зарим бүс нутагт газар тариалан байхад заримд нь байгаагүй, тариалангийн талбай маш цөөн, ой мод хаа сайгүй байсан. Үр тариа хүрэлцээгүй их ховор байсан. Дөнгөж балар эртний нийгмээс гарч ирсэн хүмүүс голчлон ан гөрөө хийж амьдардаг, олонх газарт голдуу махан хоол зонхилдог байсан. Шагжамүни хүний зууралдсан сэтгэлийг хамгийн ихээр орхиулахын тулд шавь нараа ямар ч эд хөрөнгө, материаллаг зүйлстэй харьцахыг хориглодог байсан, тэр шавь нараа дагуулаад хоол гуйж бадар барина. Тэд хүмүүсийн юу өгснийг л иддэг байсан, бясалгагчдын хувьд хоолыг шилж сонгож болохгүй, өгсөн хоолонд нь магадгүй мах байна.

Эртний Буддын шашинд **хунь** хориг байсан. Иймээс **хунь** хориг нь эртний Буддын шашнаас гаралтай, гэхдээ одоо мах идэхийг **хунь** гэж хэлдэг болсон. Үнэндээ тэр үед мах **хунь**-д тооцогддоггүй байсан, харин сонгино, цагаан гаа, саримс гэх мэтийг хэлдэг байсан. Яагаад эдгээр зүйлийг **хунь** гэдэг байсан бэ? Одоогийн лам хуврагууд үүний учрыг тодорхой тайлбарлаж чаддаггүй, яагаад гэвэл тэдний ихэнх нь жинхэнэ бясалгаагүй, тэд олон зүйлийн талаар мэдэхгүй. Шагжамүни-гийн зааж байсан зүйлийг “сахил, самади, билиг ухаан” гэж нэрлэдэг байсан. Сахил нь энгийн хүний бүхий л хүслийг хориглох; самадид орох нь бясалгагч хүн гүн ховсдолын байдалд завилан сууж бясалгана, хүн гүн амгаланд бүрэн орох ёстой. Самади-д ороход болон бясалгахад саад болж байгаа бүх зүйлийг ноцтой

үймүүлэлд тооцдог, хэн нэгэн сонгино, цагаан гаа эсвэл саримс идвэл хурц үнэр ханхлуулна. Тэр үед лам хуврагууд голдуу ой модонд эсвэл агуйд байрлаж, долоо наймуулаа нэг тойрог болж сууна, бясалгахдаа олон тойрог болцгоодог байсан. Хэрэв хэн нэгэн эдгээрээс идсэн бол их хурц үнэр ханхлуулж хүнийг самади-д ороход нь саад болно, тэдний бясалгалыг ноцтой үймүүлдэг. Иймээс энэ журам тогтож ийм хүнсийг хориотой болгосон, идэхийг цээрлэсэн. Бясалгалаар хүний биед үүссэн маш олон амь бодь энэ хурц үнэрээс дайждаг. Сонгино, цагаан гаа, саримс бас хүний хүслийг өдөөдөг. Их идвэл амтанд нь ордог, тиймээс үүнийг **хунь** болгосон.

Урьдын олон лам хуврагууд маш өндөр түвшинд бясалгаж хүрсний дараа гон нь нээгдэхэд эсвэл гон нь хагас нээгдэх байдалд ороход бясалгалын явцад тэдгээр сахил нь тийм их чухал биш гэдгийг ойлгосон. Хэрэв энэ сэтгэлээ орхивол тухайн материалаг зүйл нь өөрөө ямар ч нөлөө үзүүлэхгүй, харин хүнийг жинхэнэ үймүүлдэг зүйл нь сэтгэл юм. Тиймээс үе үеийн хутагт дээд лам хуврагууд бас мах идэх идэхгүй нь гол асуудал биш гэдгийг олж мэдсэн, асуудлын гол гогцоо нь бол тэр сэтгэлээ орхиж чадах эсэхэд л байгаа юм, зууралдсан сэтгэл байхгүй бол юу ч идсэн болно, цадаж л байвал болоо. Хийдийн дотор ингэж л бясалгаж ирсэн болохоор хүмүүс тэр заншилд хэзээнээс дасчихсан байдаг. Өөрөөр хэлбэл энэ нь зүгээр нэг хориглосон сахил төдий байхаа больсон, мөн мах огт идэж болохгүй гэсэн хийдийн дотоод дүрэм болсон, тэгээд ингэж бясалгаад хэвшсэн байдаг. Жигон хуврагийн талаар ярьцгаая, тэр уран зохиолд их нэрд гарсан нэгэн, хувраг мах идэх ёсгүй, харин тэр мах идээд энэ асуудлыг их дуулиан болгосон. Үнэндээ

Жигон Линень хийдээс хөөгдсөний дараа, амь зогоох хоол хүнсний асуудал түүний хувьд маш чухал болсон. Гэдсээ цатгахын тулд тэр юу олдсон бүгдийг л иддэг байсан, ямар ч идэх юманд зууралдсан сэтгэлгүй, зөвхөн өлсөхгүй байхыг л бодсон, ийм байвал асуудалгүй. Тэрээр бясалгаад тодорхой түвшинд хүрээд энэ зарчмыг ойлгосон, үнэндээ Жигон зөвхөн ганц хоёр удаа л мах идсэн, мах иддэг хуврагийн тухай сонсоод зохиолчид их сонирхсон. Гарчиг нь хэчнээн сонирхол татахуйц байх тусам олон уншигчдыг татна, уран зохиолын бүтээл амьдралын эх сурвалжаас үүсэж гараад түүнээс хальдаг, тэгээд олон нийтэд энэ нь их дуулиан тарьсан. Үнэндээ зууралдсан сэтгэлээ үнэхээр орхиж чадвал гэдсээ цатгахын тулд юу идсэн ч болно.

Зүүн урд Азид болон Гуандунь, Гуанси зэрэг Хятадын урд хэсгийн мужуудаар зарим Буддын сүсэгтнүүд өөрсдийгөө Буддад бясалгадаг гэж ярьдаггүй, тэгж хэлэх нь хоцрогдсон юм шиг. Тэд мацаглаж байна эсвэл цагаан хоол иддэг гэж хэлдэг, түүний утга нь цагаан хоол идээд Буддад бясалгадаг гэсэн үг. Тэд Буддад бясалгахыг тийм амар зүйлд бодсон. Цагаан хоол идээд л Буддад бясалгаж болох юм уу? Мах идэх бол зөвхөн нэг төрлийн л зууралдсан сэтгэл, нэг л хүсэл гэдгийг та бүгд мэднэ, энэ бол зөвхөн ийм л нэг сэтгэл. Цагаан хоолтон болсноор зөвхөн энэ сэтгэлийг л орхино. Бас атаархах сэтгэл, тэмцэлдэх сэтгэл, баярлах сэтгэл, гайхуулах сэтгэл гээд янз бүрийн сэтгэл байдаг, хүний сэтгэл бол маш олон, эдгээр бүх сэтгэлийг, янз бүрийн хүслийг бүгдийг нь орхих ёстой, тэгж байж л бясалгалынхаа төгс төгөлдөрт хүрнэ. Харин зөвхөн мах идэх сэтгэлийг орхисноор Буддад бясалгасан болох юм уу? Энэ ойлголт бол буруу.

Хоолны асуудлын хувьд зөвхөн мах хамаатай юм биш, ямар ч идэх юманд зууралдаж болохгүй, бусад зүйлст ч мөн адил. Зарим хүн би үүнийг л идэх дуртай гэж хэлдэг, энэ нь бас л хүсэл. Бясалгадаг хүн нэг тодорхой хэмжээнд хүрэхэд ийм сэтгэл байхгүй болно. Мэдээж манай Фа маш өндөр түвшинд заагдаж байгаа, мөн янз бүрийн түвшнийг багтаан зааж байгаа, шууд энэ шатанд хүрнэ гэвэл боломжгүй. Чи ямар нэг зүйл идэх дуртай гэж хэлнэ, гэхдээ чи бясалгаад энэ сэтгэлээ орхих цаг нь болоход чи үүнийг идэж чадахгүй болно, чи идвэл амт нь өөр санагдана, ямар ч амттай байж магадгүй. Миний урьд нь ажилладаг байсан байгууллагын хоолны газар дандаа алдагдалд ордог байсан, тэгээд хаагдсан. Хаагдсаны дараа хүн болгон хоолоо гэрээсээ авчирдаг болсон. Өглөө болгон хоол бэлдэх нь төвөгтэй бас цаг давчуу. Заримдаа би хоёр мантуу, цуунд дүрсэн дүпү-тэй авдаг байсан. Уг нь бол ийм хөнгөн хоол идэхэд болно л доо, гэхдээ дандаа идэхэд бас болохгүй, энэ сэтгэлийг мөн орхиулна. Чи дүпү-г дахиад харахад дотор чинь муухай оргино, идье ч гэсэн идэж чадахгүй, зууралдсан сэтгэл гарах вий гэхээс бас эмээнэ. Мэдээж ийм байдал бясалгаад нэг тодорхой түвшинд хүрсний дараа гардаг, дөнгөж эхлэх үед ийм байдал гарахгүй.

Буддын системд архи уухыг хориглодог, чи гартаа лонхтой дарс барьсан Будда байхыг харсан уу? Байхгүй. Би дээр хэлсэн, хүн мах идэж чадахгүй болж болно, гэхдээ энгийн хүмүүсийн дунд бясалгахад зууралдсан сэтгэлээ орхисны дараа дахиад мах идвэл болохгүй юм байхгүй. Харин чи архи уухаа больсны дараа дахин ууж болохгүй. Бясалгагч хүний биен дээр гон байдаг биз дээ? Янз бүрийн хэлбэрийн гон болон зарим ер бусын чадварууд чиний биенийн гадаргуу дээр

илэрдэг, тэдгээр нь бүгд ариун. Чамайг архи уунгуут тэд чиний биеэс тэр дорхноо явна. Тэр агшин зуурт чиний бие дээр юу ч үлдэхгүй болно, тэд энэ үнэрээс зугтана. Чи тийм зуршилд автвал тун жигшмээр, архи ууснаас болж хүн өөрийн ухаанаа алдаж болно. Яагаад зарим Лугаа Бумбын бясалгалд архи уудаг вэ? Түүнийг учир нь тэд өөрийнхөө Эзэн сүнсийг бясалгадаггүй, архи ууж Эзэн сүнсийг мансуурууладаг.

Зарим хүн архинд донтодог, зарим нь архинд шунадаг, зарим нь аль хэдийн архины хордлогод орсон байдаг, уухгүй бол хоол нь орохгүй, уухгүй байж чадахгүй болчихсон. Бясалгагчдын хувьд бид ийм байж болохгүй. Архи уугаад байвал гарцаагүй автана, энэ бол хүсэл, мөн хүний донтолтыг өдөөдөг, уух тусам улам донгоно. Бодоод үз дээ, бясалгагч хүний хувьд бид энэ зууралдсан сэтгэлээс салах ёстой биш гэж үү? Үүнийг заавал хаях ёстой. Зарим хүн “Тэр бүтэхгүй яагаад гэвэл би зочин хүлээж авдаг ажилтай” эсвэл “Би бизнесийн уулзалт хийдэг, архи уухгүйгээр ажил бүтээх амаргүй” гэдэг. Би үүнийг тийм байх албагүй гэж хэлнэ, ер нь ажил төрлийн хэлцэл хийхэд, ялангуяа гадаадынхантай бизнесийн талаар ярихад мөн харилцахад чи ундаа авна, тэр рашаан ус авна, өөр нэг хүн пиво авна. Хэн ч чамайг архи уу гэж шахахгүй, чи өөрөө уух зүйлээ сонгож хүссэнээрээ уу, тэр тусмаа сэхээтэн хүмүүсийн дунд ийм асуудал бүр ч байхгүй, ер нь ийм л байдаг.

Тамхи татах бас зууралдсан сэтгэл, зарим хүн тамхи татахад толгой сэргэдэг гэж ярьдаг, харин би үүнийг өөрийгөө ч мэхэлж, бусдыг ч хуурч байна гэж хэлнэ. Зарим хүн ажил хийгээд эсвэл бичиг цаасны ажилтай зууралдаад ядрахдаа завсарлага авч тамхи татдаг,



тэдэнд тамхи татсаны дараа оюун ухаан нь сэргэсэн мэт болдог. Үнэндээ энэ нь тийм биш, тэд жаахан амарсандаа л учир нь байгаа юм. Хүний бодол хуурмаг мэдрэмжийг төрүүлж болно, бас хуурамч байдлыг ч үүсгэж болно. Сүүлдээ тамхи татахад сэтгэл сэргэсэн мэт болдог, тийм нэг төсөөлөл бий болно, ийм буруу ойлголт үүсдэг, үнэндээ огт тийм биш, тийм нөлөө байхгүй. Тамхи татах нь хүний биед ямар ч ашиггүй. Олон жил тамхи татдаг байсан хүний цогцост задлан шинжилгээ хийхэд амьсгалын хоолой, уушги доторх нь тэр чигтээ хар байдаг.

Бясаллагчид бид биеэ ариусгахыг ярьдаг биз дээ? Бид тасралтгүйгээр биеэ ариусгаж, тасралтгүйгээр дээ түвшин рүү ахина. Гэтэл чи түүгээр биеэ бохирдуулаад байвал бидний эсрэг зүг рүү явж байгаа юм биш үү? Түүнээс гадна энэ нь бас нэг хүчтэй хүсэл юм. Зарим хүн тамхи татах нь муу гэдгийг мэднэ, гэхдээ хаяж чаддаггүй. Би та нарт хэлэхэд, түүнд өөрийгөө удирдах зөв бодол байхгүй байна, энэ байдлаараа тамхинаас гарах амаргүй. Бясаллагч хүний хувьд чи өнөөдөр үүнийг зууралдсан сэтгэл гэж үзэн орхи, чи гарч чадах үгүйгээ үз. Би та бүгдэд зөвлөхөд, хэрэв чи үнэхээр бясалгахыг хүсэж байгаа бол одоогоос эхлэн тамхинаас гарах хэрэгтэй, чи тамхинаас гарч чадахын хувьд баталгаатай. Энэ танхимд тамхи татах бодол хэний ч толгойд орохгүй, чи гарах хүсэлтэй л байгаа бол чадна гэдэг нь баталгаатай, чи дахиад тамхи татвал амт нь өөр байх болно. Номын энэ лекцийг уншвал бас ийм нөлөөтэй байх болно. Мэдээж чи бясалгах хүсэлгүй байвал бид чамайг харж хандахгүй, чи бясалгаж байгаагийн хувьд тамхинаас гарах хэрэгтэй гэж би бодож байна. Би урьд нь ийм нэг жишээ хэлж байсан, чи аль нэг Будда эсвэл Бумба амандаа тамхи

зуугаад сууж байхыг харсан уу? Яаж ийм зүйл байж болох юм? Бясалгагч хүний хувьд чиний зорилго юу вэ? Үүнээс гарах хэрэгтэй биш гэж үү? Тиймээс чи бясалгах хүсэлтэй бол тамхинаас гарах хэрэгтэй гэж би хэлсэн. Энэ нь чиний биеийг хордуулдаг, бас нэг янзын хүсэл юм, бидний бясалгагч хүнд тавьдаг шаардлагад харшилж байна.

## **Атаархах сэтгэл**

Би Фа заахдаа байнга атаархах сэтгэлийн талаар ярьдаг. Яагаад вэ? Яагаад гэвэл атаархал бол Хятадад маш хурцаар илэрдэг, ийм хүчтэй байдал нь аль хэдийнээс хэвшмэл болсон, өөрсдөө ч үүнийг мэдрэхээ больсон. Яагаад Хятад хүмүүст атаархах сэтгэл тийм хүчтэй байдаг вэ? Энэ нь үндэслэлтэй юм. Хятад хүмүүст өмнө нь Күнзийн шашны сургаал их нөлөөлсөн учраас тэд харьцангуй дотогшоо зан чанартай болсон, тэд уурласан ч ил гаргадаггүй, баярласан ч ил гаргадаггүй, хүмүүжилтэй, тэвчээртэй байхыг эрхэмлэдэг. Ийм байдалд хүмүүс эртнээс дасчихсан учраас манай үндэстэн бүхэлдээ бүрэг, дотогшоо зантай болсон. Мэдээж үүнд сайн тал байгаа, дотоод сайн чанараа ил гаргадаггүй. Тэгэхдээ муу тал ч бас байдаг, мөн сөрөг үр дагавартай. Ялангуяа Дармагийн төгсгөлийн үед үүний муу тал нь улам давамгайлах болсон, мөн хүний атаархах сэтгэлийг гүнзгийрүүлэх дэм болсон. Хэн нэгэнд сайн зүйл гарвал бусад хүмүүс тэр дороо атаархана, ажлаасаа эсвэл өөр газраас шагнал урамшуулал авбал, эсвэл ямар нэгэн орлого олбол хүнд хэлэхээс айна, бусад хүмүүс мэдчихвэл тэдний сэтгэл тавгүй болно. Барууныхан үүнийг “Дорнын атаархал” эсвэл “Азийн атаархал” гэдэг. Азийн бүс нутаг даяар Хятадын Күнзийн шашин нэлээд нөлөөлсөн учраас

ийм байдал мөн их, бага хэмжээгээр илэрдэг, зөвхөн Хятадад энэ нь их хүчтэй илэрдэг.

Энэ атаархал нь бидний хуучин баримталдаг байсан туйлын тэгшитгэх үзэл (эгалитаризм)-тэй зарим талаараа холбоотой, тэнгэр хөмөрвөөс бүгд хамтдаа үхнэ; ямар нэгэн ашиг олбол бүгдэд тэнцүү хуваана; цалин нэмэхэд хүн болгонд тэгш хуваарилна гэнэ. Энэ үзэл бодлыг харахад шударга мэт санагдана, хүн болгонд адилхан хандана. Үнэндээ хүмүүс яаж адилхан байх юм? Тэдний хийж буй ажил нь өөр, түүнчлэн үүрэг хариуцлагаа биелүүлж байгаа байдал нь ч адилгүй. Энэ орчлон ертөнцөд “алдахгүй бол олохгүй” гэсэн зарчим байдаг, олбол алдах болно. Энгийн хүний ярьдаг хөдөлмөрлөхгүй бол олохгүй гэдэг, их ажиллавал их олдоно, бага ажиллавал бага олдоно, их зүтгэл гаргавал илүү ихийг олох ёстой. Хуучин туйлын тэгшитгэх үзэл (эгалитаризм) хэрэгжиж байх үед хүн болгон төрөхдөө адилхан, төрсний дараах амьдрал нь хүнийг өөрчилдөг гэж үздэг байсан. Би үүнийг хэт туйлширсан дүгнэлт гэнэ, ямар ч юм хэтэрхий туйлширвал буруутдаг. Яагаад зарим хүн эрэгтэй, зарим нь эмэгтэй төрдөг вэ? Яагаад хоорондоо адилхан харагддаггүй вэ? Хүмүүс төрөхдөө зарим хүн өвчтэй, эсвэл эрэмдэг зэрэмдэг төрдөг, адилгүй байдаг. Бид дээд түвшнээс харахад хүний бүхий л амьдрал өөр орон зайд оршиж байдаг. Яаж ижилхэн байх юм? Бүгд нэг ижил байхыг хүсдэг, гэвч түүний энэ насны амьдралд байхгүй бол яаж ижил байх юм? Адилгүй байдаг.

Барууны орнуудын хүмүүсийн зан ааш нь харьцангуй ил байдаг, баярлаж байгаа нь ил харагдана, уурлаж байгаа нь ч бас ил харагдана. Үүнд сайн тал ч бий,

гэхдээ бас муу тал ч байдаг, энэ нь тэвчээр муу. Энэ хоёр зан төлөв болон сэтгэлгээ нь өөр учраас аливаа зүйл хийхэд гарах үр дагавар нь мөн адилгүй байдаг. Хятад хүн даргадаа магтуулбал эсвэл урамшуулал авбал бусдынх нь сэтгэл таагүй болдог. Хэрэв тэр арай илүү мөнгөн шагнал авбал бусдад мэдэгдэхгүйн тулд халаасандаа сэмхэн шиг хийчихнэ. Одоо үед тэргүүний ажилтан байх ч хэцүү болсон: “Чи хөдөлмөрийн гавшгайч, мундаг юм аа, чи ажилдаа эрт ирж орой бууж бай, чи сайн хийдгээрээ бүх ажлыг хийчих, бид ямар чадах биш” гэж хөшигнөн ёжило, сайн хүн байхад ч хэцүү болсон.

Гадаадад бол асуудал огт өөр. Дарга нь энэ ажилтныг өнөөдөр ажлаа сайн хийснийг нь хараад нэмэгдэл цалин урамшуулал өгнө. Тэр мөнгөө бусдын өмнө нэг нэгээр нь баяртайгаар тоолно: “Хөөх, дарга өнөөдөр надад ийм их мөнгө өглөө.” Тэр энэ тухай бусдад хөөртэйгөөр чөлөөтэй ярина, ямар ч асуудалгүй. Хятадад хэрвээ хэн нэгэн хүн нэмэгдэл урамшуулал авбал дарга нь хүртэл түүнд бушуу далд хий, бусдад битгий харуул гэж хэлнэ. Хэрэв гадаадад хүүхэд сургуульдаа зуун оноо авсан бол гэр лүүгээ хөгжилтэй хашхиран гүйнэ: “Би өнөөдөр зуун оноо авсан! Би зуун оноо авсан!” Тэр хүүхэд сургуулиасаа гүйсээр гэртээ ирнэ. Нэг хөрш нь хаалгаа онгойлгоод, “Хөөе Том, сайн хүү” гэнэ. Өөр нэг хөрш нь магадгүй цонхоо онгойлгоод, “Хөөе Жайк, мундаг байна” гэнэ. Хятадад ийм явдал болбол байдал эсрэгээр эргэнэ: “Би зуун оноо авсан, би зуун оноо авсан!” Энэ хүүхэд сургуулиасаа гэр хүртлээ гүйгээд харина. Хаалгандаа хүрч амжаагүй байхад хөрш нь гэр дотроосоо загнана: “Юундаа гайхуулаад байгаа юм, зуун оноо аваа л биз, онгирах юу байгаа юм! Зуун оноо авч үзээгүй хэн

байгаа юм!” Ийм хоёр өөр сэтгэлгээ нь өөр өөр нөлөө үзүүлдэг. Энэ нь хүмүүст атаархлыг төрүүлдэг, хэрэв өөр хүн сайн явбал түүнд баяртай байхын оронд харин сэтгэл нь тавгүй болдог, ийм асуудал гардаг.

Хэдэн жилийн өмнө туйлын тэгшитгэх үзэл (эгалитаризм)-ийг хэрэгжүүлсэн бөгөөд энэ нь хүмүүсийн үзэл бодол, сэтгэхүйг шууд гажуудуулсан. Тодорхой жишээ хэлье. Ажлын газарт нэг хүн өөрийгөө бусдаас илүү чадвартай гэж бодно, тэр ямар ч ажлыг хийж чадна, өөрийгөө үнэхээр гарамгай гэдэгт итгэлтэй. Тэр дотроо: “намайг үйлдвэрийн дарга эсвэл менежер болгосон ч би хийж чадна; түүнээс дээгүүр албан тушаалд тавьсан ч би хийж чадна; ерөнхий сайд болгосон ч хийж дөнгөнө” гэж бодно. Дарга нь бас түүнийг их чадвартай хүн, юу ч хийсэн чадна гэж ярина. Хамт олон нь бас түүнийг ёстой чадвартай, их авьяастай гэж хэлнэ. Гэтэл түүнтэй нэг ажлын хэсэгт эсвэл албан тасалгаанд цуг ажилладаг нэг хүн ямар ч юм хийх чадваргүй, юу ч хийсэн сайнгүй байж мэднэ. Нэг өдөр энэ чадваргүй хүн дэвшиж дарга болсон, харин түүнийг болгоогүй, бүр түүний дарга нь болсон. Тэр үүнийг шударга бус байна гэж үзэн уурлаж бухимдана, атаархаад байж ядна.

Би та нарт энгийн хүний ойлгодоггүй ийм нэг зарчмыг хэлж өгье: Чи өөрийгөө бүх юманд чадвартай гэж бодно, гэтэл чиний хувь тавиланд энэ нь байхгүй; тэр хүн юу ч чадахгүй, харин түүний хувь тавиланд байгаа учраас тэр дарга болно. Энгийн хүн юу гэж бодох нь хамаагүй, тэр бол энгийн хүний л бодол. Дээд амь бодийн түвшнээс харахад, хүн төрөлхтний нийгмийн хөгжил нь тодорхой зүй тогтлын дагуу явагддаг, иймээс хүний нэг насандаа юу хийх нь түүний чадварт

тохируулан зохицуулагддаггүй юм. Буддын шашинд үйлийн үрийг төлөх тухай ярьдаг, хүний амьдралын зам түүний үйлийн үрийнх нь дагуу зохицуулагддаг, чи ямар ч их чадвартай байсан Дэ (буян) байхгүй бол магадгүй чиний энэ насанд юу ч байхгүй. Чи тэр хүнийг юу ч чадахгүй гэж боддог, гэтэл түүний Дэ их. Тэр дээгүүр албаны дарга болно, эсвэл их баян болно. Энгийн хүн үүнийг харж чадахгүй, тэр үргэлж өөрийнхөө чадварт таарсан зүйлийг хийх ёстой гэж үздэг. Иймээс тэр амьдралынхаа туршид өрсөлдөнө, тэмцэлдэнэ, сэтгэл нь ихээр шархална, түүнд юм бүхэн их зовлонтой санагдана, их ядарна, сэтгэл нь үргэлж тайван биш байна. Сайн идэж ч чадахгүй, сайн унтаж ч чадахгүй, сэтгэл санаа нь цөхөрнө, хөгшрөхөөрөө олон янзын өвчинд баригдаж бие нь муудна.

Тэгвэл бидний бясалгагчид бүр ч ийм байж болохгүй, бясалгагч хүн байгалийн жамыг дагах хэрэгтэй, чиний зүйл мөн л бол чи түүнийг алдахгүй, чинийх биш бол чи тэмцээд ч олж авч чадахгүй. Мэдээж энэ нь туйлын биш. Хэрэв бүгд туйлын байвал хүн муу зүйл хийх асуудал байхгүй болно, өөрөөр хэлбэл зарим тогтвортой биш хүчин зүйлс байж болно. Гэхдээ бясалгаж байгаа хүний хувьд угаас багшийн Фашэнь-аар зохицуулагдсан байдаг болохоор өөр хүн чиний юмыг авъя гэсэн ч авч чадахгүй. Иймээс бид байгалийн жамыг дагана гэж ярьдаг, заримдаа чамд ямар нэгэн зүйл чинийх юм шиг санагдана, бусад хүмүүс ч бас энэ чинийх гэж хэлнэ, үнэндээ тэр чинийх биш байдаг. Чи магадгүй өөрийнхөө зүйл гэж бодно, эцэст нь тэр чинийх биш болно, ийм байдалд чамайг энэ зүйлээ орхиж чадах эсэхийг харна, чи орхиж чадахгүй бол энэ нь зууралдсан сэтгэл, энэ аргаар ашиг сонирхолд зууралдсан сэтгэлийг чинь орхиулна, энэ бол ийм

л асуудал юм. Энгийн хүн энэ зарчмыг ухамсарлаж чадахгүй учраас ашиг хонжоон дээр өрсөлдөнө, тэмцэлдэнэ.

Атаархах сэтгэл энгийн хүмүүсийн дунд маш хүчтэй илэрдэг, мөн бясалгагчдын хүрээнд ч нэлээд цухуйх хандлагатай байдаг. Янз бүрийн чийгон бясалгалуудын хооронд нэг нэгнийгээ үл ойшоох явдал гардаг, “чиний чийгон сайн” эсвэл “түүний чийгон сайн” гэж сайн, муугаар нь дуудна, минийхээр бол тэд бүгдээрээ өвчин эдгээх бие сайжруулах тэр түвшинд харьяалагдана. Хоорондоо маргалдаж нэг нэгэнтэйгээ сөргөлдөж байгаагийн ихэнх нь шүглэсэн сүнс эсвэл амьтны авчирсан замбараагүй чийгон байдаг, тэд шиньшинийг үл ойшооно. Хэн нэгэн хүн хорь гаруй жил хичээллээд ямар ч ер бусын чадвар гараагүй байхад өөр нэг хүн дөнгөж хичээллээд л ер бусын чадвартай болсон, тэр хүн сэтгэлдээ шударга бус байна гэж үзэн: “Би хорь гаруй жил бясалгасан байхад надад ер бусын чадвар гараагүй, түүнд гарчихлаа гэж үү, түүнээс ямар юмных нь ер бусын чадвар гардаг юм?” Тэр сэтгэлдээ бухимдан: “Түүнд сүнс шүглэсэн, бясалгалын солиоролд автсан!” гэнэ. Хэн нэгэн аль нэг чийгон багшийн хичээлд суугаад үл тоомсорлоно: “За, энэ ямар юмных нь чийгон багш байдаг юм, түүний ярьж байгаа нь надад огтхон ч сонирхолтой биш байна” гэнэ. Тэр чийгон багш энэ хүн шиг сайн ярьж чадахгүй байж болно, гэхдээ тэр чийгон багшийн ярьж байгаа нь түүний өөрийнх нь бясалгалын зүйл шүү дээ. Энэ хүн юм болгоныг сурна, зөндөө олон төгсөлтийн гэрчилгээтэй, чийгон багш болгоны ангид суудаг, тэр үнэхээр их мэднэ, тэр чийгон багшаас ч илүү зүйл мэднэ. Гэхдээ тэр нь ямар хэрэгтэй юм? Бүгд өвчин эдгээх бие сайжруулах талын л зүйлүүд, иймэрхүү

зүйл их сурах тусам түүний биен дэх мэдээлэл нь улам замбараагүй, улам төвөгтэй болно, бясалгахад улам хэцүү болно, бүгд холилдож замбараагүйтнэ. Жинхэнэ бясалгал бол зөвхөн нэг номоор тууштай бясалгах, замаасаа хазайхгүй байх юм. Жинхэнэ бясалгагчдын дунд ч гэсэн бас илэрдэг, нэг нэгнийгээ үл хүндэтгэдэг, өрсөлдөх сэтгэлээсээ салаагүй бол атаархах сэтгэл амархан гардаг.

Би нэг домог ярья: “Бурхдад хэргэм зэрэг өргөмжилсөн нь” гэдэг томоохон туужид Шэнь Гонбао, Жиан Зияа-г хөгшин бас чадваргүй гэж боддог, гэтэл Тэнгэрийн анхдагч бурхан, Жиан Зияагаар Бурхдад хэргэм зэрэг олгуулахаар болсон. Шэнь Гонбао-д энэ нь шударга бус санагдсан: “яагаад түүгээр Бурхдад хэргэм зэрэг олгуулж байгаа юм? Миний ямар чадвартайг хар даа, би толгойгоо цавчуулаад буцаагаад мөрөн дээрээ тавьж чадна, яагаад налаар хийлгүүлдэггүй юм?” Тэр Жиан Зияа-д атаархаж түүнд байнга төвөг удах болсон.

Шагжамүни-гийн үеийн эртний Буддын шашинд ер бусын чадварыг ярьдаг байсан, одоогийн Буддын шашинд ер бусын чадварын талаар хэн ч дурсаж зүрхлэхээ больсон. Хэрэв чи ер бусын чадварыг ярих юм бол тэд чамайг бясалгалын солиотой гэнэ. Юун ер бусын чадвар? Тэд үүнийг хүлээн зөвшөөрөхгүй. Яагаад вэ? Одоогийн лам хуврагууд тэдгээрийг ямар учиртайг нь огт мэдэхгүй. Шагжамүнид арван их шавь байсан, тэднээс Мужжанлиан ер бусын чадвараар нэгд орно гэж тэр хэлсэн. Шагжамүнид бас эмэгтэй шавь нар байсан, тэдний дотроос Лянхуасэ ер бусын чадвараараа нэгд ордог байсан. Буддын шашин Хятадад орж ирсний дараа мөн адилхан байдал гарсан, түүхийн үеэс үед



олон том хутагт хувилгаад лам хуврагууд байсан. Бодьдарма Хятадад ирэхдээ нэг зэгсээр мөрнийг гаталсан байдаг. Гэхдээ түүхийн хөгжлийн явцад ер бусын чадварыг улам үгүйсгэх болсон. Түүний гол учир нь хийдийн ахмад лам, тэргүүн лам эсвэл хамба лам гэх мэт хүмүүс төрөлхийн аугаа суурьтай байх албагүй, хэдийгээр тэд хамба лам юм уу ахмад лам байлаа ч энэ нь зөвхөн энгийн хүмүүсийн дундах хэргэм зэрэг юм. Тэд ч гэсэн бясалгаж байгаа хүмүүс, зүгээр л мэргэжлийн бясалгагчид. Чи сайн дураараа гэртээ бясалгадаг. Хүн бясалгаж үр дүнд хүрэх үгүй нь сэтгэл зүрхээ яаж бясалгаснаас л шалтгаална, энэ нь хүн бүрийн хувьд адил тэгш байдаг, жаахан ч гэсэн аутуудуулж болохгүй. Гэтэл гал тогоонд хоол хийдэг нэгэн залуу хуврагийн төрөлхийн суурь муугүй байж болно. Залуу хувраг улам их зовлон зүүр амсах тусам гон нээгдэх байдалд хүрэх нь улам дөхөм. Ахлах лам хэр их тав тухтай байна тэр тусам түүний гон нь нээгдэхэд хэцүү, учир нь үнд нүгэл хувирах асуудал байдаг. Залуу хувраг үргэлж ядарч зовно, тэр нүглээ хурдан төлж илүү хурдан гэгээрэлд хүрнэ, магадгүй нэг өдөр гэнэт гон нь нээгдэнэ. Гон нь нээгдэхэд, гэгээрэхэд эсвэл хагас гэгээрэхэд ер бусын чадвар нь гарна, хийдийн лам нар ирж түүнээс юм асууна, бүгд түүнийг биширнэ. Гэвч хамба үүнийг тэвчихгүй: “Би яаж хамба хэвээр байх болж байна? Юуных нь гэгээрэл? Тэр бясалгалын солиоролд автсан байна, түүнийг эндээс зайлуул.” Тэгээд залуу лам хийдээс хөөгдсөн. Яваандаа Хятадын Буддын шашинд ер бусын чадварын талаар ярьж зүрхлэх хүнгүй болсон. Жигоныг ямар хүчирхэг ер бусын чадвартай байсныг та нар мэднэ, тэрээр Эмэй уулнаас гуалин моднуудыг

зөөж авчраад худгаас нэг нэгээр нь шидэн гаргаж ирж байсан. Гэхдээ эцэст нь тэр Линень хийдээс хөөгдсөн.

Атаархах сэтгэлийн энэ асуудал маш ноцтой байдаг, яагаад гэвэл үүнээс бидний бясалгал төгс үр дүнд хүрч чадах эсэх нь шууд хамаарна. Атаархах сэтгэлээ орхихгүй бол хүний бясалгасан бүх сэтгэл маш хэврэг болно. Ийм нэг дүрэм байдаг: Хүн бясалгалын явцад атаархлыг арилгахгүй бол гэгээрлийн хутагт хүрч чадахгүй, гэгээрлийн хутагт огт хүрч чадахгүй. Будда Амитаба, диваажинд нүгэлтэй очих тухай ярьж байсныг та нар урьд нь сонссон байх, гэвч атаархах сэтгэлээ орхихгүй бол үүнийг хэрхэвч зөвшөөрөхгүй. Бусад тал дээр бага зэрэг дутагдалтай байвал диваажинд нүгэлтэй очиж цааш үргэлжлүүлэн бясалгахыг зөвшөөрч болох ч, атаархлыг орхиогүй бол үүнийг туйлаас зөвшөөрөхгүй. Өнөөдөр би бясалгагчдад хэлж өгч байна, чи биттий төөрөгдөлдөө зууралдаад ухамсарлахгүй байгаад бай, чи дээд түвшин рүү бясалгахыг зорьж байгаа л юм бол атаархах сэтгэлээ завал орхих ёстой. Тиймээс би энэ асуудлыг онцолж ярилаа.

## **Өвчин эдгээх асуудал**

Өвчин эдгээхийн тухайд, би чамд өвчин эдгээхийг заах гэж байгаа юм биш. Фалунь Дафа-гаар жинхэнэ бясалгадаг шавь нараас хэн нь ч бусдын өвчнийг эдгээж өгч болохгүй, чамайг өвчин эдгээх л юм бол чиний биед байгаа Фалунь Дафа-гийн бүх зүйлүүдийг миний Фанэнь буцаагаад хурааж авна. Яагаад энэ асуудлыг ийм ноцтойд авч үздэг вэ? Учир нь энэ бол Дафа-г эвдэж байгаа хэрэг. Чи өөрийнхөө биеийг хохироохоос гадна, зарим хүн хэзээ нэгэн цагт хүний өвчнийг эдгээдэг болбол гар нь загатнана, тэр хэнийг

ч хамаагүй авчраад өвчнийг нь эдгээж өөрийгөө гайхуулна, энэ нь зууралдсан сэтгэл биш гэж үү? Энэ нь хүний бясалгалд ноцтой саад учруулааг.

Олон хуурамч чийгон багш нар энгийн хүмүүсийн чийгон заалгаад өвчнийг эдгээдэг болох гэсэн хүслийг нь ашиглаж энэ зүйлийг заадаг. Чий гаргаад өвчнийг эдгээж чаддаг болно гэдэг, энэ нь инээдтэй биш гэж үү? Чамд ч чий байгаа, түүнд ч мөн чий байгаа, чи хүнийг өөрийнхөө чий-гээр яаж эдгээх юм? Магадгүй түүний чий чинийхээс давамгай! Чий хооронд ямар ч хязгаарлалт байхгүй. Хүн дээд түвшинд бясалгахад гон гардаг, гаргасан нь дээд энергийн бие бодь бөгөөд үнэхээр өвчнийг эдгээж, намдааж бас дарж чаддаг, гэхдээ үндсээр нь арилгаж чадахгүй. Иймээс өвчнийг үнэхээр бүрмөсөн эдгээе гэвэл ер бусын чадвартай байх ёстой. Тухайн өвчин болгоныг эдгээхэд зориулагдсан тодорхой нэг ер бусын чадвар байдаг, өвчнийг эдгээх ер бусын чадваруудын хувьд мянга гаруй байдаг гэж би хэлнэ, хэдэн төрлийн өвчин байна тэр хэмжээний ер бусын чадвар байдаг. Эдгээр ер бусын чадваргүйгээр чиний эмчилгээний арга ямар сайн байгаад ч нэмэргүй.

Сүүлийн жилүүдэд зарим хүмүүс бясалгалын хүрээнд их будилаан тарьсан. Жинхэнэ утгаараа хүмүүсийн өвчнийг эдгээж биеийг нь сайжруулах гэж гарч ирсэн тэдгээр чийгон багш нараас, эсвэл хамгийн анх чийгон-ы эхлэлийг тавьсан багш нараас бусдын өвчнийг эдгээхийг хэн нь зааж байсан гэж? Тэд чиний өвчнийг эдгээж өгч байсан эсвэл яаж бясалгах, яаж биеэ сайжруулах бясалгалын нэг цогц арга чамд заадаг байсан, чи тэр дасгалаар өөрийнхөө өвчнийг эдгээж болно. Дараа нь хуурамч чийгон багш нар гарч ирэн будилаантуулсан, чийгон-оор хүний өвчнийг эдгээхийг

хүссэн хэн боловч өөртөө сүнс даллаж ирүүлнэ, ийм байх нь ойлгомжтой. Тэр үеийн нөхцөл байдлын улмаас зарим чийгон багш нар өвчтөнийг үзэж, эдгээж өгдөг байсан, энэ нь тухайн үеийн тэнгэрийн байдалд нийцэхийн тулд гарсан юм. Гэхдээ чийгон бол энгийн хүмүүсийн дунд байх чадвар биш, үүрд хадгалагдан үлдэхгүй, энэ нь тухайн цаг үеийн тэнгэрийн байдлын өөрчлөлтөөс үүдэн гарсан зөвхөн тэр үеийн л зүйл юм. Дараа нь зарим хүн өвчин эдгээх зорилгоор бусдад заах болсон, ингэснээр их замбараагүй байдал үүсгэсэн. Нэг энгийн хүн гурваас таван өдөр сураад л өвчнийг эдгээж чаддаг болох юм уу? Зарим хүн, би энэ өвчнийг эсвэл тэр өвчнийг эдгээж чадна гэж ярьдаг. Би та нарт хэлэхэд аливаа ингэж ярьдаг хүмүүс бүгд шүглэсэн сүнс тээж явдаг, тэд нуруунд нь юу зүүгдэж явааг мэдэх болов уу? Түүнд шүглэсэн сүнс байгаа, гэвч тэр үүнийг мэдрэх ч үгүй мэдэх ч үгүй. Түүнд нэлээд дажгүй санагдана, өөрийгөө чадвартай гэж боддог.

Жинхэнэ чийгон багш нар олон жилээр шаргуу бясалгаж байж, бэрхшээлийг туулж байж энэ зорилгодоо хүрдэг. Чи хүнийг эдгээхдээ тэр хүний нүглийг арилгаж чадах тийм хүчирхэг ер бусын чадвар чамд байгаа эсэхийг бодож үзсэн үү? Чи жинхэнэ уламжилж авсан юм уу үгүй юу? Чи хоёр гурван өдрийн дотор сураад өвчнийг эдгээж чадна гэж үү? Чи энгийн хүний гараар өвчнийг эдгээж чадна гэж үү? Гэхдээ тэдгээр хуурамч чийгон багш нар чиний сул тал болон хүний зууралдсан сэтгэлийг чинь ашигладаг, чи өвчин эдгээдэг болохыг хүссэн биз дээ? Тэр тэгвэл эмчилгээний сургалт зохион байгуулж чамд зүү тавих чий-н эмчилгээ, гэрлээр эмчлэх арга, өвчний чий-г гадагшлуулах, чий нөхөх, цэгийн даралт болон гараар шүүрэх гэх мэт өвчин эдгээх арга барилыг

зориуд заана, олон төрлийн аргууд байдаг, энэ бүгд бол чиний мөнгийг авахын тулд юм.

Бид гараар шүүрэх аргын талаар ярья. Бид ийм нэг байдлыг харсан: Хүн яагаад өвчилдөг вэ? Хүний өвчтэй байх, гай зовлон учрахын бүх үндсэн шалтгаан нь муу үйлийн үр буюу хар биет нүглийн орноос үүддэг. Энэ нь билиг шинжтэй ба муу зүйлд харьяалагддаг. Тэдгээр муу амь боднуд бас билиг шинжтэй байдаг, тэд бүгдээрээ хар, тиймээс ийм орчин тэдэнд тохиромжтой учраас биед нь орно. Тэдгээр нь өвчин үүсдэгийн үндсэн шалтгаан бөгөөд хүний өвчний хамгийн гол эх сурвалж нь юм. Мэдээж өөр бас хоёр төрлийн хэлбэр байдаг: Нэг нь бол багц нүгэлтэй адил өндөр нягтралтай маш бичил амь боднуд байдаг; өөр нэг нь бол дамжуулах хоолойгоор ирэхтэй адил боловч энэ нь их ховор үзэгддэг, энэ бол бүгд өвөг дээдсээс хуримтлагдаж ирдэг нүгэл юм. Ийм тохиолдол ч бас байдаг.

Хамгийн түгээмэл байдаг өвчний талаар ярилцъя, хүний биеийн хаа нэгтээ хавдар, ямар нэгэн үрэвсэл, яс ургах гэх мэт үүсэхэд өөр орон зайн яг тэр газарт нэг амь бодь сууж байдаг, энэ амь бодь маш гүн орон зайд байдаг. Жирийн чийгон багш харж чадахгүй, мөн энгийн ер бусын чадвараар түүнийг харж чадахгүй, тэд зөвхөн хүний биед хар чий байгааг л харна. Хаана хар чий байна, тэнд өвчин байна гэж хэлдэг нь зөв. Гэхдээ хар чий бол өвчин үүсгэсэн гол шалтгаан нь биш, харин нэлээд гүн нэгэн орон зайд тийм нэг амь бодь байдаг, тэр энэ орныг үүсгэдэг. Иймээс зарим хүн хар чий-г гадагшлуулах мөн авч хаях талаар ярьдаг. Чи түүнийг гадагшлуулах гээд үз дээ! Хэсэг хугацааны дараа, энэ нь дахиад л үүснэ, зарим нь их хүчирхэг

тул дөнгөж авч хаянгуут буцаад татаж ирүүлдэг, тэд өөрсдөө сэргэж чаддаг, чи эдгээх гэж яаж ч оролдсон үр дүн гарахгүй.

Ер бусын чадвартай хүний харснаар бол биед хаана хар чий байна тэнд өвчний чий байна гэж үздэг; Хятад уламжлалт эмчилгээгээр яривал тэр газарт судал бөглөрсөн, чий болон цусны эргэлт түгжирсэн, энергийн сувгууд бөглөрсөн гэж үздэг; Барууны анагаах ухааны үүднээс харвал тэр газарт шархлаа, хавдар үүссэн, яс ургасан, эсвэл үрэвслийн гэх мэт шинж байдал харагддаг, бидний орон зайд ийм хэлбэрээр илэрдэг. Тэр амь бодийг авч хаясны дараа энэ орон зайн биед юу ч байхгүй болно. Энэ нь нурууны үений зөөлөн эдийн гэмтэл байна уу, ясны үрэвсэл ч байна уу тэр зүйлийг авч зайлуулсны дараа, тэр орныг арилгасны дараа чи тэр дорхноо зүгээр болно. Чи дахиад рентген зураг авхуулбал ясны үрэвсэл алга болсныг харна, үндсэн шалтгаан нь бол тэр амь бодь л ийм нөлөө гаргасных юм.

Зарим хүн чамд гараар шүүрэх аргыг заагаад гурваас тав хоногийн дотор чамайг өвчин эдгээж чаддаг болно гэдэг. Чи яаж шүүрэхээ надад харуул даа! Хүн бол хамгийн сул дорой нь байдаг, харин тэдгээр амь бодь их айхтар. Тэр чиний бодлыг захирч чамайг хүссэнээрээ удирдаж чадна, тэр ч байтугай чиний амийг амархан хөнөөж чадна. Чи түүнийг шүүрнэ гэнэ, яаж шүүрэх гэж байгаа юм? Чи энгийн хүний гараар түүнд хүрч ч чадахгүй, чи таамгаар шүүрэх гэж оролдож магад, тэр чамайг тоохгүй ард чинь чамайг шоолно, таамгаар шүүрэх гээд байгаа нь их инээдтэй харагдана, үнэхээр чи түүнд хүрч чадвал чиний гарыг тэр дор нь гэмтээнэ, чи жинхэнэ гэмтэнэ! Би урьд

нь ийм хүмүүсийг харж байсан, тэдний хоёр гар нь шинжилгээгээр ямар ч гэмтэлгүй гардаг, тэдний биед болон гарт нь ямар ч өвчин байхгүй, гэхдээ гараа өргөж чадахгүй, гар нь доошоо сул унжаастай, би ийм өвчтөнтэй тааралдаж байсан. Түүний өөр орон зай дахь бие нь гэмтсэн тул үнэхээр зэрэмдэг болсон байсан. Чиний тэр бие гэмтвэл чи жинхэнэ зэрэмдэг болсон биш гэж үү? Зарим хүн надаас: “Багшаа, би үргүй болох мэс засал хийлгэсэн” эсвэл “би хагалгаа хийлгэж ямар нэг эрхтнээ авхуулсан, тэгвэл би чийгон-оор хичээллэж болох уу?” гэж асуудаг. Би тэдэнд, энэ нь хамаагүй, яагаад гэвэл өөр орон зайд байгаа чиний биед хагалгаа хийгдээгүй, чийгон бясалгал тэр биед үйлчилдэг гэж хэлдэг. Иймээс би саяхан хэллээ, чи түүнийг шүүрэх гэж оролдоод хүрч чадахгүй бол тэр чамайг үл тооно; харин чи түүнд хүрвэл тэр чиний гарыг гэмтээж мэднэ.

Орон даяарх чийгон-ыг сурталчлах хөдөлгөөнийг дэмжих зорилгоор би зарим шавь нараа дагуулан Бээжинд болсон Дорнын эрүүл мэндийн сурталчилгааны үзэсгэлэнд оролцсон. Хоёр удаагийн тэрхүү арга хэмжээнд бид тэргүүлсэн. Эхний удаад манай Фалунь Дафа нь “Од чийгон” нэр хүртсэн; дараагийн арга хэмжээнд манай талбайд маш их хүн цугларч зохицуулахад бэрх байсан. Үзэсгэлэнгийн бусад хэсэгт цөөн хүнтэй байхад бидний эргэн тойронд бөөгнөрсөн их хүнтэй байсан. Гурван эгнээгээр дугаарлаж зогссон байсан, эхний эгнээнд өвчнөө үзүүлэх өглөөний ээлжийн дугаар авсан хүмүүс; хоёр дахь эгнээнд үдээс хойших дугаар авахаар хүлээсэн хүмүүс; гурав дахь эгнээнд миний гарын үсгийг авах гэж хүлээсэн хүмүүс байсан. Бид өвчин эмчилдэггүй, яагаад үүнийг хийсэн бэ? Учир нь бид

орон даяарх чийгон-ы хөдөлгөөнийг дэмжиж хувь нэмрээ оруулахын тулд энэ арга хэмжээнд оролцсон юм.

Би дагуулж ирсэн шавь нартаа гон-оосоо хувааж өгсөн, хүн бүрд нэг хувь гон өгсөн, тус бүр нь зуу гаруй ер бусын чадвар багтсан энергийн багц байсан юм. Би тэдний гарыг гон-оор битүүмжлэн боосон, тэгсэн ч гэсэн заримынх нь гар хазуулаад, гэмтээд цэврүүтсэн, эсвэл цус гарсан байсан, ийм байдал нэлээд гарсан. Тэдгээр амь бодь тийм айхтар, чи боддоо, энгийн хүний гараар түүнд хүрч зүрхлэх юм уу? Тэгээд ч чи түүнийг шүүрч чадахгүй, тусгай ер бусын чадваргүйгээр яаж ч чадахгүй. Яагаад гэвэл чиний бодол гарахад л өөр орон зайнаас тэр чиний юу хийх гэж байгааг мэдчихнэ, чи түүнийг шүүрэх гэвэл тэр аль хэдийн зугтчихсан байна. Өвчтөн үүдээр гарангуут тэр дахин биед нь буцаад орно, тэгээд өвчин дахин хөдөлнө. Үнэхээр түүнийг барья гэвэл гараа сунгаад тэнд нь хөшингө болгох ер бусын чадвар хэрэгтэй. Хөдөлгөхгүй болгосны дараа бид бас өөр нэг ер бусын чадвар хэрэглэнэ, урьд нь үүнийг “Сүнс шүүрэх агуу арга” гэдэг байсан, энэ ер бусын чадвар нь бүр ч хүчирхэг, үүгээр хүний биеэс сүнсийг нь татан гаргаж болно, тэгэхэд хүн тэр дороо хөдөлж чадахгүй болж хөшнө. Энэхүү ер бусын чадвар нь тодорхой чиглэсэн зорилготой ч, бид тэр зүйлийг шүүрэхэд хэрэглэдэг. Рулай Будда гартаа барьсан тагшаа ашиглан тийм том Сүнь Укун руу нэг тусгахад, тэр даруй өчүүхэн жижиг болгосныг та бүхэн мэднэ. Энэ ер бусын чадвар ийм нөлөө гаргадаг. Тэр амь бодь хэр том, жижиг байх нь хамаагүй гарт агшин зуурт баригдахад маш өчүүхэн болдог.



Үүнээс гадна, гараа өвчтөний махан биед оруулаад шүүрч гаргаж ирж болохгүй. Тэгвэл энгийн хүний нийгэмд хүний сэтгэхүйг үймүүлнэ, үүнийг туйлаас зөвшөөрөхгүй, тэгж хийж болох ч ийм аргаар хийж болохгүй. Биед оруулж байгаа гар нь өөр орон зайд байгаа гар юм. Зүрхний өвчтэй хүн байлаа гэхэд энэ гарыг түүний зүрхэн тус газар луу сунгахад өөр орон зайд байгаа тэр гар орно. Алшин зуурт маш түргэн шүүрсний дараа чи гадна талын бодит гараа базахад хоёр гар нийлж түүнийг барьж авна. Тэр маш их айхтар, заримдаа гарт чинь тийчгэнэн хөдөлнө, лотогш өрөмдөнө, заримдаа хазна, заримдаа бас орилно. Чиний гарт байхдаа их жижиг боловч гараасаа суллахад маш том болж хувирна. Энэ нь хэн ч хамаагүй хүрч чадах зүйл биш. Тийм ер бусын чадваргүйгээр түүнд хүрч огтхон ч чадахгүй, энэ нь хүмүүсийн бодож байгаа шиг тийм амар зүйл огт биш.

Мэдээж ирээдүйд чийгон-оор өвчин эдгээх ийм хэлбэрийг байлгаж магадгүй, энэ нь урьд өмнө үргэлж байдаг байсан. Гэхдээ нэг нөхцөлтэй, энэ хүн заавал бясалгагч байх ёстой, бясалгалын явцад тэр энэрэнгүй сэтгэлийн үүднээс цөөн тооны сайн хүмүүст ийм зүйл хийж өгч болно. Гэхдээ түүнд хангалттай хүчирхэг Дэ байхгүй учраас тэдний нүглийг бүрмөсөн арилгаж чадахгүй, тиймээс гай зовлон байсаар байна, гэхдээ тухайн өвчин нь эдгэрнэ. Жирийн чийгон багш бол бясалгаад Бумбад хүрсэн хүн биш, тэр зөвхөн хүний өвчнийг хойшлуулж чадна; бас магадгүй хувиргаж чадна, эсвэл магадгүй өөр гай зовлонд хувиргадаг. Гэхдээ хойшлуулж байгаа явдлыг тэр өөрөө магадгүй мэдэхгүй, хэрэв Дэ бодлоор бясалгадаг чийгон бол түүний Дэ бодол нь үүнийг үйлдэж байгаа юм. Зарим чийгон-оор бясалгагчид их нэр цуутай байдаг, тэдгээр

олон алдартай чийгон багш нарт гон байдаггүй, гон нь Дэд сүнсний биед байдаг. Өөрөөр хэлбэл бясалгалын явцад ийм зүйл хийхийг зөвшөөрдөг, яагаад гэвэл эдгээр хүмүүс энэ түвшиндээ үргэлжлэн бясалгасаар л байдаг, арав гаруй жил, хэдэн арван жилээр бясалгасан ч энэ түвшнээсээ цааш ахиж чаддаггүй, тиймээс амьдралынхаа туршид үргэлж хүний өвчнийг үзэж өгдөг. Тэд энэ түвшинд байгаа учраас үүнийг хийхийг тэдэнд зөвшөөрдөг. Фалунь Дафа-гаар бясалгадаг шавь нарт өвчин эдгээхийг туйлаас зөвшөөрөхгүй. Чи өвчтэй хүнд энэ номыг уншиж өгч болно, хэрвээ тэр хүн үүнийг хүлээж авбал өвчин нь эдгэрч болно, гэхдээ тухайн хүний нүглийн их багаас шалтгаалж үр дүн нь ялгаатай байна.

### **Эмнэлгийн эмчилгээ ба чийгон эмчилгээ**

Бид эмнэлгийн эмчилгээ ба чийгон эмчилгээ хоорондын харилцан холбоог ярья. Зарим барууны эмчилгээний эмч нар чийгон-ыг хүлээн зөвшөөрдөггүй, тэдний ихэнх нь ийм хандлагатай байдаг гэж хэлж болно. Тэдний ярьдгаар бол, чийгон өвчнийг эдгээдэг юм бол бидэнд эмнэлэг байх хэрэг байна уу? Та нар бидний эмнэлгийг орлохих! Та нарын чийгон өвчнийг гараараа эдгээдэг болохоор тарна хийх, эм уух, бас эмнэлэгт хэвтэх шаардлагагүй болно, манай эмнэлгийг орловол сайн хэрэг болох юм биш үү? гэдэг. Энэ үг их ёс зүйгүй, бас учир утгагүй. Зарим хүн чийгон-ыг ойлгодоггүй, үнэндээ чийгон эмчилгээг энгийн хүний эмчилгээний аргатай адилтан үзэж болохгүй, энэ нь энгийн хүний мэргэжил чадвар биш, энэ нь ер бусын зүйл юм. Тэгвэл ер бусын зүйлийг өргөнөөр хэрэглэж энгийн хүний нийгмийг үймүүлбэл зөвшөөрөх юм уу? Будда ямар аугаа их чадвартай гээч, аль нэгэн Будда

гараа ганц даллахад л бүх хүн төрөлхтний өвчнийг арилгаж чадна. Тэр яагаад үүнийг хийдэггүй вэ? Тэр тусмаа тийм их олон Будда байдаг атал, тэд яагаад нигүүлсэнгүй сэтгэл гаргаж чиний өвчнийг эдгээж өгдөггүй вэ? Яагаад гэвэл энгийн хүний нийгэм ийм л байдаг. Төрөх, хөгшрөх, өвчлөх, үхэх бол ийм л байдалтай юм, бүгд үйлийн үртэй холбоотой, бүгд үйлийн үрээс үүдэн гардаг, чи өртэй бол төлөх ёстой.

Хэрэв чи хүний өвчнийг эдгээвэл тэр зарчмыг эвдсэнтэй адил, хүн муу зүйл хийснийхээ хариуг төлөхгүй байж болно гэсэнтэй адил болно, үүнийг яаж зөвшөөрч болох юм? Бясалгаж байгаа хүний хувьд, чамд энэ асуудлыг бүрэн шийдэж чадах хүчирхэг чадвар байхгүй бол энэрэнгүй сэтгэлээр өвчин эдгээж өгөхийг зөвшөөрнө, яагаад гэвэл чамаас энэрэнгүй сэтгэл гарсан болохоор ингэж хийхийг зөвшөөрнө. Гэхдээ чи энэ асуудлыг бүрэн шийдэж чадах чадвартай бол өргөн хэмжээнд үүнийг хийхийг зөвшөөрөхгүй. Тэгэх юм бол чи энгийн хүний нийгмийн байдлыг ноцтойгоор эвдэнэ, үүнийг зөвшөөрөхгүй. Иймээс энгийн хүний эмнэлгийг чийгон-оор орлоно гэвэл ерөөсөө байж болшгүй, учир нь чийгон бол ер бусын Фа.

Хэрэв Хятадад чийгон эмнэлгүүд байгуулагдавал, ингэхийг зөвшөөрвөл, олон нэртэй чийгон багш нар гарч ирээд эмчилгээ хийвэл, чи ямар байдал гарна гэж бодож байна? Ингэхийг зөвшөөрөхгүй, учир нь бүгд энгийн хүний нийгмийн байдлыг сахин хамгаалж байгаа. Хэрэв чийгон-ы эмнэлгүүд, чийгон-ы клиникүүд, эрүүл мэндийн төвүүд, мөн эмчилгээ сувиллын газрууд байгуулагдавал чийгон багш нарын эмчилгээний хүч нөлөө нь шууд суларна,

эмчилгээний үр дүн дорхноо унана. Яагаад вэ? Тэд энгийн хүмүүсийн дунд ийм зүйл хийж байгаа учраас, тэдний Фа энгийн хүмүүсийнхтэй заавал адил өндөрт байх ёстой, энгийн хүмүүсийн байдалтай ижил түвшинд байх ёстой, тэдний эмчилгээний үр нөлөө нь эмнэлгийнхтэй адилхан байх ёстой. Иймээс тэдний эмчилгээ тийм сайн үйлчлэхгүй, өвчнийг эдгээхийн тулд мөн адил хэдэн курс эмчилгээ хийх хэрэгтэй гэнэ, ер нь ийм л байдаг.

Чийгон эмнэлэг байсан байгаагүй чийгон өвчнийг эдгээж чадахыг хэн ч үгүйсгэхгүй. Чийгон нийгэмд дэлгэрээд олон жил болж байна, маш олон хүн чийгон-оор хичээллээд үнэхээр өвчнөө эдгээж, биеэ сайжруулах зорилгодоо хүрч чадсан. Тэр чийгон багш өвчнийг хойшлуулсан ч бай, яаж эмчилсэн ч бай, ямар боловч энэ өвчин одоо байхгүй болсон, өөрөөр хэлбэл чийгон өвчнийг эдгээж чадна, үүнийг хэн ч үгүйсгэж чадахгүй. Чийгон багшид хандаж өвчнөө эмчлүүлж байгаа хүмүүсийн ихэнх нь эдгэршгүй өвчтэй, эмнэлгээр яваад ч эмчлэгдэхгүй болсон хүмүүс байдаг, тэд азаа үзэн чийгон багш дээр очдог, тэгээд эцэст нь өвчин нь эдгэрдэг. Хэрэв эмнэлэгт эдгээж чаддаг байсан бол хэн ч чийгон багш дээр очихгүй, ялангуяа эхэндээ хүмүүс ингэж боддог байсан, тиймээс чийгон өвчнийг эдгээж чаддаг. Гэхдээ үүнийг энгийн хүний нийгэмд хийдэг бусад зүйлтэй адил хийж болохгүй. Өргөн хэмжээнд хийж үймүүлэхийг туйлаас зөвшөөрөхгүй, бага хүрээнд юм уу их нөлөө дуулиангүйгээр хийхэд бол болно, гэхдээ энэ нь өвчнийг бүрмөсөн эдгээж чадахгүй, энэ бол дамжиггүй. Өөрөө чийгон-оор хичээллээд өвчнөө эдгээх нь хамгийн зөв зам юм.

Бас зарим чийгон багш эмнэлэг өвчнийг эмчилж чаддаггүй, эмнэлгийн эмчилгээний үр дүн нь ийм тийм гэж ярьдаг. Юу ч гэмээр юм бэ дээ? Мэдээж энэ нь олон талын учир шалтгаантай. Миний бодлоор гол шалтгаан нь бол хүн төрөлхтний ёс суртахууны хэм хэмжээ доод цэгтээ хүрсэн явдал юм, иймээс эмнэлгээр эмчлэгдэшгүй янз бүрийн хачин өвчнүүд үүссэн, эм уусан ч нэмэр болохгүй, хуурамч эмүүд ч мөн олширсон, энэ бүгд бол хүн нийгмийг ийм хэмжээнд хүртэл нь доройтуулснаас болсон юм. Үүнд хэн байсан ч бусдыг буруутгах хэрэггүй, хүн болгон гал дээр тос нэмсэн, тиймээс бясалгахад хүн болгонд зовлон бэрхшээл тулгарах болно.

Эмнэлэг зарим өвчнийг шинжилгээгээр илрүүлж чаддаггүй, гэхдээ үнэхээр өвчин байна. Зарим хүний өвчнийг шинжилгээгээр илрүүлсэн ч хэлж мэдэхгүй, урьд өмнө үзэгдэж байгаагүй тул эмнэлэгт үүнийг ерөнхийд нь “Орчин үеийн өвчин” гэж нэрлэдэг. Эмнэлэгт өвчнийг эмчилж чадах уу? Мэдээж чадна. Хэрэв эмнэлэгт өвчнийг эмчилж чаддаггүй байсан бол хүмүүс юунд итгэж эмчлүүлэхээр тэнд очих юм? Эмнэлэгт өвчнийг эмчилж чаддаг ч эмчилгээний арга нь зөвхөн энгийн хүний түвшинд байдаг, харин тэр өвчин бол энгийн бус, зарим өвчин маш ноцтой байдаг. Иймээс өвчтэй бол эмнэлэгт эртхэн эмчлүүл гэж хэлдэг, хүндрүүлбэл эмнэлэгт эмчилж чадахгүйд хүрнэ, хэт их тунгаар эм өгвөл хүн хордоно. Өнөөгийн анагаах ухааны эмчилгээ нь бидний шинжлэх ухаан технологийн төвшинтэй адилхан, бүгд энгийн хүний түвшинд байгаа болохоор эмчилгээний үр нөлөө нь зөвхөн тэр л хэмжээнд байна. Тодруулах хэрэгтэй нэг асуудал бол, жирийн чийгон эмчилгээ ба эмнэлгийн эмчилгээ нь зөвхөн өвчнийг үүсгэсэн үндсэн шалтгаан

болох гай барцдыг хүний үлдсэн амьдралд нь эсвэл түүнээс цааш хойшлуулдагт байгаа юм, харин нүгэл огт арилдаггүй.

Бид Хятадын уламжлалт эмчилгээний талаар ярьж. Хятадын уламжлалт эмчилгээ нь чийгон эмчилгээтэй их ойролцоо юм. Эртний Хятадад уламжлалт эмчилгээний бараг ихэнх эмч нар ер бусын чадвартай байсан. Жишээлбэл Сунь Симиао, Хуа Туо, Ли Шижень мөн Биань Чүэ гэх мэт анагаах ухааны их эрдэмтдийг дурдаж болно, тэд бүгд ер бусын чадвартай байсныг эмчилгээний сурах бичгүүдэд тэмдэглэсэн байдаг. Гэхдээ одоо эдгээр үнэт зүйлс нь үргэлж шүүмжлэлд өртдөг, Хятад эмчилгээнээс уламжлагдаж үлдсэн нь бол зөвхөн тэдгээр эмийн жор эсвэл судалгаанаас үлдсэн туршлага л юм. Эртний Хятадын эмчилгээ их дэвшингүй байсан бөгөөд одоогийн анагаах ухааны хөгжлөөс хавьгүй давуу байсан. Зарим хүн орчин үеийн анагаах ухаан их хөгжсөн шүү дээ, компьютер томографын төхөөрөмжөөр дотор эд эрхтнийг хардаг, түүнчлэн Эхо оношилгоо, гэрэл зураг авах, рентгенээр харах гэх мэт байдаг гэж боддог. Хэдийгээр одоогийн тоног төхөөрөмж хөгжингүй мэт байвч миний хувьд бол Хятадын эртний анагаах ухааныг явч гүйцэхгүй.

Хуа Туо, Цао Цаогийн тархинд хавдар байгааг нь хараад түүний толгойд хагалгаа хийх хэрэгтэй гэсэн. Цао Цао үүнийг сонсоод Хуа Туо түүнийг алах санаатай байна гэж бодсон, тэгээд Хуа Туог баривчлуулж шоронд хийлгэсэн, эцэст нь Хуа Туо шоронд нас барсан. Цао Цаогийн өвчин сэдэрхэд Хуа Туо санаанд нь орсон, тэгээд Хуа Туог хайлгахад тэр аль хэдийн нас барсан байсан. Дараа нь Цао Цао

үнэхээр энэ өвчнөөр нас барсан. Хуо Туо үүнийг яаж мэдсэн бэ? Тэр харсан, энэ бол хүний ер бусын чадвар, өнгөрсөн үеийн анагаахын томоохон эрдэмтэд бүгд ийм чадвартай байсан. Тэнгэрийн мэлмий нээгдсэний дараа нэг талаас хүний биений дөрвөн талыг зэрэг харж чаддаг; урлаас харахдаа хүний ар тал, зүүн бас баруун талыг нь зэрэг хардаг; мөн хөндлөн огтлолоор үе давхаргаар нь харж чаддаг; бас энэ орон зайг нэвтэрч өвчин үүсгэсэн үндсэн шалтгаан юу болохыг нь харж чадна. Одоогийн эмчилгээний аргаар ингэж чадах уу? Үүнээс тун хол байна, дахиад мянган жил ч болж болно! КТ, Эхо, мөн рентген туяагаар хүний биений дотрыг хардаг, гэхдээ тоног төхөөрөмж нь хэт нүсэр, биедээ авч явах боломжгүй, цахилгаангүй бол бас ажиллахгүй. Харин энэ тэнгэрийн мэлмий бол хаана ч явсан хамт, бас эрчим хүчний хэрэг байхгүй, тэдгээртэй яаж харьцуулж болох юм!

Зарим хүн орчин үеийн эмийг их сайн гэж ярьдаг. Би тийм биш гэнэ, эртний Хятадын ургамлын бэлдмэлүүдийг хэрэглэхэд өвчнийг үнэхээр анагааж чаддаг байсан. Маш олон зүйлс уламжлагдаж үлдээгүй; гэхдээ бас өөр олон зүйлс гээгдээгүй, ард түмний дунд хэрэглэгдсээр ирсэн. Би Чичихар хотод лекц уншиж байхад гудамжинд нэг хүн хүмүүсийн шүдийг авч өгч байхыг харсан. Түүнийг харахад урд зүгээс ирсэн хүн гэдгийг хэлэхэд амархан байлаа, зүүн хойд нутгийн хүн шиг хувцаслаагүй байсан. Түүн дээр хэн ч ирсэн татгалзахгүй, ирсэн бүгдийн өвчтэй шүдийг авч өгнө, авсан шүднүүдээ тэнд овоолсон байсан. Түүнд хүмүүсийн шүдийг авч өгөх нь гол зорилго байгаагүй, харин эмийн уусмалаа зарахын тулд байсан. Уг эмийн уусмалаас их өтгөн шар уур гарч байсан. Шүдийг нь авахдаа тэр эмтэй шилний тагийг

онгойлоод хүний өвчтэй шүд талын хацарт барина, тэгээд шүдээ авхуулах хүнийг тэр шар уусмалын уураас сор гэж хэлнэ, тэгэхэд эм нь бараг хорогдохгүй, тэгээд таглаад цааш нь тавина. Тэр халааснаасаа чүдэнзний мод гаргаж ирээд эмийнхээ талаар ярингаа чүдэнзний модоор муу шүдийг нь түлхээд л унагачихна, тэгэхэд өвдөхгүй, шүдэнд ялыгүй цусны судалтай гэхдээ буйлнаас нь цус гарахгүй. Та бүгд боддоо, хүчилбэл чүдэнзний мод дорхноо хугарчихна биз дээ, гэхдээ тэр үүгээр шүдийг жаахан хөшөөд л унагачихсан.

Хятадын эртний зарим зүйлүүд ард түмний дунд уламжлагдан үлдсэн байдаг, харин барууны эмчилгээний тоног төхөөрөмж түүнийг гүйцэхгүй гэж би хэлсэн, алиных нь үр дүн сайн болохыг хар даа, тэр хүн чүдэнзний модоор шүдийг авч чадна. Барууны эмчилгээнд шүд авахдаа эхлээд мэдээ алдуулах тариа хийнэ, энд тэнд нь хатгана, тарианы зүүгээр хатгуулахад их өвдөнө, тэгээд мэдээ алдуулах эм үйлчилж эхэлтэл хүлээх хэрэгтэй, дараа нь эмч бахиар шүдийг сугалж авна. Их цаг хүч зарцуулсны эцэст авна, болгоомжгүй хийвэл шүдний ёзоор буйланд хугараад үлдэнэ. Тэгвэл алх цүүц бариад ухаж эхэлнэ, ингэхэд өвчтөн айснаас болоод дагжин чичирнэ. Дараа нь нарийн төхөөрөмжөөр өрөмдөнө. Зарим хүн өрөмдөх өвдөлтөөс болоод байж сууж ядна. Их ч өвдөнө, их ч цус гарна. Чи аль эмчилгээг нь дээр гэж хэлэх вэ? Хэнийх нь илүү дэвшингүй байна? Бид зөвхөн тоног төхөөрөмжийн талаас нь харж болохгүй харин үр дүнг нь харах хэрэгтэй. Хятадын эртний эмчилгээ их өндөр хөгжилтэй байсан, одоогийн барууны анагаах ухаан хэчнээн жил болсон ч түүнийг гүйцэхгүй.



Эртний Хятадын шинжлэх ухаан бидний баруунаас сурсан одоогийн шинжлэх ухаантай адилгүй, тэр нь өөр замаар явсан, өөр байдалд хүргэж болох байсан. Тиймээс бид эртний Хятадын шинжлэх ухаан, технологийг өөрсдийн одоогийн танин мэдэхүйн аргаар ойлгож болохгүй, яагаад гэвэл эртний Хятадын шинжлэх ухаан хүний бие, амь, орчлон ертөнц рүү чиглэж эдгээр зүйлийг шууд судалдаг байсан, иймээс өөр арга замаар явсан. Тэр үеийн сургуулийн сурагчид завилж эгц зөв суухыг эрхэмлэдэг байсан, тэд бийрээ бариад бичихдээ амьсгалаа зөв авах, чий-гээ гүйлгэхэд анхаардаг байсан, бүх төрлийн ажил төрөл хийхдээ сэтгэлээ ариусгах, амьсгалаа зохицуулахыг эрхэмлэдэг байсан, нийгэм бүхэлдээ ийм байдалтай байсан.

Зарим хүн ингэж хэлдэг: “Эртний Хятадын шинжлэх ухааны дагуу явсан бол өнөөгийн машин, галт тэрэг байх байсан уу? Бид өнөөдрийн орчин үеийн хөгжилтэй байх байсан уу?” Чи энэ орчноос өөр байдлыг танин мэдэж болохгүй, чи сэтгэлгээний үзэл баримтлалдаа хувьсал хийх хэрэгтэй гэж би хэлмээр байна. Телевиз байхгүй ч гэсэн хүний духанд тийм нэг зүйл байдаг, түүгээр юу хүссэнээ харж болно, мөн ер бусын чадвартай байдаг. Галт тэрэг, машин байхгүй ч гэсэн хүн сууж байсан газраасаа шууд хөөрч чадна, цахилгаан шатны ч хэрэг байхгүй. Энэ нь нийгмийн хөгжилд өөр төлөв байдлыг бий болгох бөгөөд зөвхөн энэ хүрээнд хязгаарлагдахгүй. Харь гаригийнхны “нисдэг таваг” нааш цааш санаанд багтамгүй хурдтайгаар ирж, явж чаддаг, мөн том жижиг болж өөрчлөгддөг. Тэд хөгжлийн огт өөр замыг баримталсан, энэ нь шинжлэх ухааны өөр нэгэн арга зам юм.

# Наймдугаар лекц

## Бигү мацаг

Зарим хүн бигү мацгийн талаар ярьдаг. Бигү мацгийн энэ байдал оршдог, бясалгалын хүрээнд байдаг төдийгүй бидний бүхий л хүн төрөлхтний нийгмийн дунд цөөнгүй хүмүүст ийм байдал гарч байсан. Зарим хүн хэдэн жилээр эсвэл арав гаруй жилээр идэж уудаггүй, гэхдээ тэд дажгүй сайн амьдардаг. Зарим хүн бигү мацгийг тодорхой нэг түвшний илрэл гэж ярьдаг; зарим нь үүнийг биеийн ариуслын илрэл гэж үздэг; зарим нь дээд түвшин дэх бясалгалын явц гэдэг.

Үнэн хэрэгтээ энэ нь эдгээрийн аль нь ч биш. Тэгвэл ямар учиртай вэ? Бигү мацаг бол үнэндээ тодорхой нэг орчинд бясалгах онцгой бясалгалын арга юм. Ямар онцгой орчинд үүнийг хэрэглэдэг вэ? Хятадад эрт дээр үед, ялангуяа шашин үүсэхээс өмнө олон бясалгагч нууцаар бясалгах, ганцаар бясалгах аргуудыг хэрэглэж алс бөглүү ууланд, эсвэл агуйд хүмүүсээс зайдуу бясалгадаг байсан. Тэд энэ хэлбэрийг сонгоход хоол хүнсний асуудалтай тулгардаг. Хэрэв тэр бигү мацгийн аргыг хэрэглэхгүй бол бясалгаж огт чадахгүй, тэндээ өлсөж цангаад үхнэ. Би Фа заахаар Чончингоос Ухань руу усан онгоцонд сууж Хөх мөрнөөр зүүн зүгт явж байхдаа “Гурван хавцал”-ын хоёр талд, уулсын дунд хэсэгт байдаг хадан агуйнуудыг харсан, их олон нэртэй ууланд бүгдэд нь ийм агуй байдаг. Урьд өмнө бясалгагч хүн олсоор авирч агуйд орсны дараа олсоо тасалж агуйдаа бясалгадаг байсан, бясалгал нь амжилтгүй болбол агуй дотор үхнэ. Ус хоолгүй тийм нэг онцгой нөхцөлд ийм нэг өвөрмөц бясалгах аргыг хэрэглэдэг байсан.

Их олон бясалгал ингэж уламжлагдаж ирсэн учраас бигү мацаг байдаг; их олон бясалгалд бас бигү мацаг байдаггүй, өнөөдөр нийгэд тархсан ихэнх бясалгалд бигү мацаг байдаггүй. Бид нэг бясалгалдаа тууштай байх хэрэгтэй гэж хэлсэн, чи дураараа юу ч хамаагүй хийж болохгүй. Чи бигү мацгийг сайн гэж бодон мацаг барихыг хүсэж магад, чи бигү мацаг хийж яах юм? Зарим хүнд энэ нь сайн юм шиг санагддаг, сонниучирхана, эсвэл өөрийгөө их чадвартай гэж бодно, гайхуулна, янз бүрийн бодол санаатай хүмүүс байдаг. Энэ аргыг хэрэглээд бясалгавал бие махбодоо тэтгэхийн тулд өөрийнхөө энергийг зарцуулах шаардлагатай болдог, иймээс олз нь бага, гарз нь их юм. Та бүгд мэднэ, ялангуяа шашин үүссэнээс хойш сүм хийдэд ховсдолын байдалд бясалгаж суухад эсвэл тэндээс гарахгүй бясалгахад цай хоолоор хангагдана, бигү мацгийн асуудал байхгүй. Ялангуяа бид энгийн хүний нийгэмд бясалгаж байгаа, чамд энэ аргыг хэрэглэх ямар ч шаардлага байхгүй, түүнчлэн чиний бясалгалын номд байдаггүй л бол дураараа хийж болохгүй. Гэхдээ чи үнэхээр бигү мацаг хийхийг хүсээд байвал хий. Миний мэдэхээр, гол төлөв дээд түвшинд бясалгал заахад, шавьд жинхэнэ уламжлахад, тухайн бясалгалын аргад бигү мацаг байдаг бол ийм байдал гарч болно, гэхдээ нийгэд дэлгэрүүлж болохгүй, гол төлөв шавийг нууцаар бясалгуулахаар авч явдаг, эсвэл ганцаараа бясалгадаг.

Одоо бас зарим чийгон багш бигү мацаг заадаг болсон. Бигү мацаг барьж чадсан уу? Эцэст нь үгүй, хэн үүнд хүрч чадсан бэ? Миний харснаар олон хүн эмнэлэгт хэвтсэн, мөн цөөнгүй хүмүүсийн амь нас нь дэнсэн дээр байгаа. Тэгвэл яагаад ийм байдал гарах болов? Бигү мацаг байдаггүй гэж үү? Байдаг. Гэхдээ нэг

зүйл бий, энгийн хүний нийгмийн байдлыг дураараа үймүүлэхийг хэнд ч зөвшөөрөхгүй, үүнийг эвдэхийг зөвшөөрөхгүй. Орон даяар хэчнээн хүн бясалгаад юм идэж уухгүй байхыг ярихаа больё, зөвхөн Чанчунь хавийн хүмүүс идэж уухгүй болбол маш их зүйлийг хөнгөвчилнө гэж би хэлнэ! Бид хоол унд бэлдэх гэж санаа зовох хэрэггүй болно. Тариачид талбай дээр их зовж зүдэрч ажилладаг, бүтд хоол идэхгүй болбол ёстой амар болно, зөвхөн ажил хийнэ, хоол идэхгүй. Ийм байж болох уу? Үүнийг хүн төрөлхтний нийгэм гэх үү? Ингэж болохгүй нь ойлгомжтой, ийм зүйлээр энгийн хүний нийгмийг өргөн хэмжээнд үймүүлэхийг зөвшөөрөхгүй.

Зарим чийгон багш бигү мацаг барихыг зааж байхад их олон аюултай байдал гарсан. Зарим хүн бигү мацгийн хойноос их хөөцөлддөг ч, тэд зууралдсан сэтгэлээсээ салаагүй, энгийн хүний элдэв сэтгэлээ орхиогүй байдаг, ямар нэгэн амттай хоол хараад л хорхой нь хүрнэ, энэ хүсэл гарангуут барьж чадахаа болино. Тэр юм идэх гэж яарна, хоолны дуршил нь оргилоход идэхийг хүснэ, юм идэхгүй бол өлсөх мэдрэмж төрнө. Гэхдээ идвэл бөөлжинө, хоол орохгүй, түүний сэтгэл нь бухимдана, их айна. Их олон хүн эмнэлэгт хэвтсэн, үнэндээ их олон хүний амь насанд аюул учирсан. Хүмүүс намайг хайж ирээд эдгээр замбараагүй зүйлийг зохицуулж өгөхийг гуйдаг байсан, би ийм зүйлтэй зууралдах дургүй. Зарим чийгон багш юманд тун хариуцлагагүй ханддаг, хэн ч тэдний гарьсан эдгээр замбараагүй зүйлийг зохицуулж өгөхийг хүсэхгүй.

Түүнээс гадна, хэрэв чи бигү мацаг бариад асуудал гарвал энэ нь чиний өөрийн хүслээс болсон биш

гэж үү? Бид ийм байдал байдаг гэж хэлсэн, гэхдээ энэ нь ямар ч дээд түвшинд гардаг байдал биш, бас ямар нэг онцгой илрэл ч биш, тэр бол зөвхөн онцгой нөхцөл байдалд хэрэглэдэг нэг төрлийн бясалгах арга юм, гэхдээ үүнийг өргөнөөр дэлгэрүүлж болохгүй. Цөөнгүй хүн бигү мацаг барихыг хөөцөлддөг, тэд үүнийг бүтэн бигү, хагас бигү гэж нэрлэдэг, бас ингэж хуваадаг, зарим хүн зөвхөн ус уудаг гэж ярина, зарим нь зөвхөн жимс иддэг гэнэ, тэд бүгд хуурамч бигү мацаг юм, яваандаа болохгүй болох нь гарцаагүй. Жинхэнэ бясалгадаг хүн агуй дотор идэж уухгүйгээр бясалгавал тэр бол жинхэнэ бигү мацаг юм.

### **Чий хулгайлах**

Чий хулгайлахыг ярихад зарим хүнд энэ нь их аймшигтай сонсогддог, айснаасаа болоод чийгон-оор хичээллэж зүрхэлдэггүй. Бясалгагчдын хүрээнд зарим хүн бясалгалын солнорол, чий хулгайлах гэх мэтийн талаар цуу яриа их дэгдээснээс болж маш олон хүн ихэд айж чийгон-оор хичээллэхээс татгалздаг болсон, харьцахаас ч зүрхшээдэг болсон. Хэрвээ эдгээр яриа гараагүй байсан бол чийгон-оор хичээллэдэг хүмүүс магадгүй бүр олон байх байсан. Гэтэл зарим шиньшин муутай чийгон багш нар зориуд эдгээр зүйлийг заадаг, ингэснээр бясалгагчдын хүрээнд маш замбараагүй байдлыг бий болгосон, үнэндээ энэ бүгд нь тэдний ярьсан шиг тийм аймаар биш. Тэд бас холимог анхдагч чий, ийм ч чий тийм ч чий гэж нэрлэдэг ч бидний хувьд чий л бол чий юм. Хүний биед чий байхад л тэр хүн өвчин эдгээх бие сайжруулах түвшинд байгаа гэсэн үг, иймээс бясалгадаг хүний тоонд орохгүй. Биед нь чий байгаа л бол тэр хүний бие дээд хэмжээнд хүртэл цэвэршээгүй, мөн өвчний чий бас л байна гэсэн

үг, энэ бол гарцаагүй. Чий хулгайлдаг хүн бас чий-н түвшинд л байдаг, манай бясалгагчдаас хэн тэр бохир чий-г хүсэх юм? Бясалгадаггүй хүний биесийн чий их бохир байдаг, чийгон-оор хичээллэсний дараа энэ нь тунгалаг болно. Өвчин байгаа газарт их том, маш нягт бөөгнөрсөн хар бие бодь харагддаг. Үргэлжлүүлэн бясалгасаар өвчин нь үнэхээр эдгэж бие нь сайжрах үед түүний чий аажмаар шардуу өнгөтэй болно. Цаашид үргэлжлүүлэн бясалгасаар байвал өвчин нь жинхэнэ арилна, мөн чий ч байхгүй болно, сүүн цагаан биесийн байдалд орно.

Өөрөөр хэлбэл чий л байвал өвчин байна гэсэн үг. Бид бол бясалгагчид, бясалгана гэвэл чий-гээр яах юм? Өөрийнхөө биесийг цэвэршүүлэх хэрэгтэй байтал тэр бохир чий-г авах ямар хэрэгтэй юм? Авахгүй нь мэдээж. Чий хүсдэг хүн мөн чий-н түвшинд байдаг, чий-н түвшинд байгаа хүн сайн чий-г муу чий-гээс ялгаж чадахгүй, тийм чадвар байхгүй. Чиний биесийн дань-тиань-д байгаа жинхэнэ амин чий-г тэр хөдөлгөж чадахгүй, тэр амин чий-г зөвхөн дээд түвшний чадвартай хүн л хөдөлгөж чадна. Чиний бие дэх бохир чий-г тэр хүсвэл хулгайлаг, ямар ч сүйдтэй юм болохгүй. Би дасгал хийхдээ, хэрэв чий-г өөртөө оруулья гэж хүсвэл, ингэж бодонгуут л миний гэдэс дорхноо чий-гээр дүүрнэ.

Бумбын системд тианьзи багана зогсолт гэж ярьдаг, Буддын системд чий-г толгойн оройгоор оруулахыг заадаг. Орчлон ертөнц чий-гээр арвин, чи өдөр болгон өөртөө дүүргэн авч болно. Лаогон сүв болон Байхуй сүвүүд нээгдэхэд чий-г оруул, дань-тиань дээрээ бодлоо төвлөрүүлж байгаад гараараа хураан авахад хэсэг хугацааны дотор чамд чий дүүрнэ. Чий-

гээр яаж ч биеэ дүүргэсэн ямар хэрэгтэй юм? Зарим хүн чий-гээр их хичээллэхэд хурууны өндөгнүүд болон бие нь хөөсөн мэт болдог. Бусад хүн түүнд ойртоход эргэн тойронд нь нэг хүрээ байгааг мэдэрдэг. “Пөөх, чи үнэхээр сайн хичээллэсэн байна” гэнэ. Би үүнийг юу ч биш гэж хэлнэ. Гон хаана байна вэ? Энэ бол ердөө л чий-н дасгал, хэчнээн их чий байсан ч энэ нь гон-ыг орлож чадахгүй. Чий-гээр хичээллэх зорилго нь гаднын сайн чий-гээр биен доторх муу чий-г солих, биеэ цэвэршүүлэх л явдал юм, чий-г хураагаад яах юм? Энэ түвшинд, ямар нэгэн үндсэн өөрчлөлт гараагүй байхад чий нь гон биш хэвээр байна. Чи хэр их хулгайлсан ч зөвхөн нэг том чий-н уут л гэсэн үг. Тэгэхээр ямар хэрэгтэй юм? Энэ нь дээд энергийн бие бодид хувираа ч үгүй байна. Тиймээс чамд айх хэрэг байна уу? Тэр үнэхээр чий хулгайлахыг хүсээд байвал хулгайлаг.

Та бүхэн бодоод үз дээ, чиний биед чий байвал өвчин байна гэсэн үг. Тэгвэл тэр хулгайлахдаа чиний өвчтэй чий-тэй хамт хулгайлсан биш гэж үү? Тэр үндсэндээ эдгээр зүйлийг ялгаж огт чадахгүй, яагаад гэвэл чий авдаг хүн бас чий-н түвшинд байдаг, түүнд ямар ч чадвар байхгүй. Гон-той хүн чий-г авахгүй, энэ бол гарцаагүй. Үнэмшихгүй бол бид туршиж үзье, хэн нэгэн чиний чий-г үнэхээр хулгайлахыг хүсвэл чи тэндээ зогсож бай, тэр хулгайлаг. Тэр чиний ард чий-г чинь хулгайлж байхад чи энд зогсоод бодлоороо орчлон ертөнцөөс чий-г дотогшоо оруул, энэ нь ямар сайн хэрэг болохыг хардаа, чиний бие цэвэршихийг хурдасгаж байна, чамд чий-г оруулах, гаргах гэснийг шаардлагагүй болж байна. Түүнээс гарсан сэтгэл нь муу учраас хүний юмыг хулгайлсан. Авсан зүйл нь муу ч гэсэн тэр Дэ (буян)-гээ алдах үйл хийсэн, иймээс тэр

чамд Дэ (буян)-гээ өгнө. Энэ нь ийм нэгэн солилцоо үүсгэдэг, тэр энд чиний чий-г авахад нөгөө талд чамд Дэ өгч байдаг. Чий хулгайлж байгаа хүн үүнийг мэддэггүй, тэр мэдвэл ингэж хийж зүрхлэхгүй!

Аливаа чий хулгайлдаг хүний царай бараан харагддаг, бүгд ийм байдаг. Цэцэрлэгт хүрээлэнд очиж чийгон-оор хичээллэдэг хүмүүсийн ихэнх нь өвчнөө эдгээх зорилготой байдаг, тэд янз бүрийн өвчин хуучтай байдаг. Хүн өвчнөө эдгээхийн тулд өвчний чий-г гадагшлуулах ёстой, гэтэл чий-г хулгайлдаг хүн үүнийг гадагшлуулдаггүй харин төрөл бүрийн өвчний чий-г бүх биедээ хуримтлуулаад л байдаг, энэ нь түүний бие доторхыг нь хүртэл хар болгодог. Тэр үргэлж Дэ-гээ алдаж байдаг болохоор гаднах төрх нь бүхэлдээ бараан харагддаг, нүглийн хүрээ нь томорч бас Дэ-гээ ихээр алдсанаас, гадна дотногүй харлана. Чий хулгайлдаг хүн өөртөө ийм өөрчлөлт гарсныг мэдвэл, тэр Дэ-гээ алдах ийм тэнэг зүйл хийж байгаагаа мэдвэл хэрхэвч үүнийг хийхгүй.

Зарим хүн чий-г их учир битүүлгээр ярьдаг: “Чи Америкт байхад миний энд гаргасан чий-г хүлээж авч чадна; чи хананы цаана зогсож бай, тэгээд миний дамжуулах чий-г хүлээж авна.” Зарим хүн их мэдрэмтгий байдаг, чий гаргахад хүлээн авдаг. Гэхдээ чий энэ орон зайд дамждаггүй, өөр орон зайд явдаг. Өөр орон зайн энэ газарт хана байхгүй. Тэгвэл яагаад зарим чийгон багш задгай газар чий-г дамжуулахад чамд юу ч мэдрэгддэггүй вэ? Учир нь өөр орон зайн тэр газарт хаалт байгаа, иймээс чий нь хүмүүсийн ярьдаг шиг тийм их нэвтрэх чадалтай биш.

Жинхэнэ нөлөө гаргадаг нь гон юм. Бясалгагч хүн гон гаргаж чаддаг болоход түүнд аль хэдийн чий



байхгүй болсон байна, гаргасан нь нэг төрлийн дээд энергийн бие бодь, тэнгэрийн мэлмийгээр харахад энэ нь нэг төрлийн туяа байдаг. Хүний биед хүрэхэд халуун дулаан мэдрэмж төрүүлдэг, энгийн хүнд шууд нөлөөлж чадна. Гэхдээ өвчнийг бүрмөсөн эдгээж чадахгүй, зөвхөн намжаах нөлөөтэй. Өвчнийг үндсээр нь арилгахын тулд ер бусын чадвар байх хэрэгтэй, өвчин болгонд зорнулагдсан өөр өөр ер бусын чадвар байдаг. Маш бичил түвшинд гон-ы ширхэг бүр нь чиний өөрийн дүр төрхтэй адилхан байдаг. Тэр нь хүнийг таньдаг, тэд бүгд оюун сэтгэхүйтэй ба дээд энергийн бие бодь юм. Өөр хүн хулгайлах гэвэл тэндээ байх юм уу, тэр хүний өөрийн зүйл биш учраас тэнд байхгүй, үүнийг тогтоон барья ч гэсэн боломжгүй. Аливаа жинхэнэ бясалгадаг хүнд гон гарсны дараа тэд багшийнхаа хяналт дор байдаг, чиний юу хийж байгааг багш чинь харж байдаг, чи өөр хүний зүйлийг авахыг оролдвол түүний багш ч зөвшөөрөхгүй.

## **Чий хураах**

Бид дээд түвшинд бясалгал заахдаа та бүгдэд чий хулгайлах ба чий хураах асуудлыг шийдэж өгөх гэж байгаа юм биш. Яагаад гэвэл би бясалгалын нэрийг цэвэрлэх, мөн зарим тустай зүйл хийх зорилготой, би урьд өмнө хэн ч ярьж байгаагүй эдгээр муу үзэгдлийг илчлэн ярина. Та бүхэнд үүнийг ойлгуулна, тэгвэл зарим хүн үргэлж муу зүйл хийдгээ болино, чийгон-ы талаар ойлголтгүй хүмүүст энэ тухай ярихад үргэлж айж байдаг.

Энэ орчлон ертөнцөд хангалттай чий байгаа, зарим хүн тэнгэрийн арга чий, газрын билиг чий гэж ярьдаг. Чи ч гэсэн орчлон ертөнцийн нэг элемент, хүссэнээрээ чий-г хураан авч болно. Гэхдээ зарим хүн ертөнцийн

чий-г хурааж авдаггүй, тэд хүмүүст ургамлын чий-г хураан авахыг дагнан заадаг, бүр хуримтлуулсан туршлага байдаг: Улиас модны чий цагаан, нарс модны чий шар, яаж хурааж авах, ямар үед хурааж авах гээд. Бас нэг хүн ингэж хэлсэн: “Манай гэрийн үүдэнд нэг мод байсан, би энэ модны чий-г хурааж авснаас тэр мод үхсэн.” Үүнийг ямар янзын чадвар гэх юм? Энэ нь харин муу зүйл хийж байгаа хэрэг биш гэж үү? Та бүгд мэднэ, бид жинхэнэ бясалгаж байгаа, бид эерэг мэдээлэл хүсдэг, орчлон ертөнцийн мөн чанарт уусахыг эрхэмлэдэг, чи Шань (Нинжин)-г бясалгах ёстой биз дээ? Орчлон ертөнцийн мөн чанар болох Жэнь, Шань, Рэнь-д уусахын тулд Нинжинг эрхэмлэх ёстой. Чи үргэлж муу зүйл хийгээд байвал гон өсөх юм уу? Өвчин чинь эдгэрэх үү? Энэ нь манай бясалгагч хүнээс яг эсрэг болсон юм биш үү? Тэр нь бас амь хөнөөж муу үйл хийсэнд тооцогдоно! Магадгүй зарим хүн ингэж хэлнэ: “Таны яриа цаашлах тусам улам санаанд багтамгүй болох юм, амьтан албал амь хөнөөсөн гэсэн үг, мөн ургамлыг үхүүлбэл бас амийг алсан болох юм уу.” Үнэндээ бол тийм, Буддын шашинд самсара буюу зургаан замын тойргоор дахин төрөл олох тухай ярьдаг. Чи магадгүй зургаан замын тойрогт ургамал болж төрсөн байж болно, Буддын шашинд ингэж л ярьдаг. Бид энд ийм байдлаар ярихгүй, гэхдээ бид мод бас амьтай гэж та бүхэнд хэлнэ, тэд зөвхөн амьтай байгаад зогсохгүй бас өндөр түвшний сэтгэх чадвартай байдаг.

Нэг жишээ ярья: Америкт электроник судалгааны чиглэлээр мэргэшсэн нэг хүн байдаг, тэр худал хэлэхийг илрүүлдэг төхөөрөмжийг яаж ашиглахыг заадаг. Нэг өдөр түүний толгойд нэгэн санаа орж ирсэн, тэр энэ төхөөрөмжийн хоёр электрод залгуурыг

цахирмаа цэцэгт холбосны дараа үндэс рүү нь ус хийсэн. Тэгтэл уг төхөөрөмжийн бичигч электрон бал хоромхон зуур нэг муруй зурахыг харсан. Энэ муруй зураас нь маш богино хугацаанд хүний сэтгэл хөөрөх, баярлах үед тархинаас гардаг бичлэгтэй яг адилхан байсан. Энэ мөчид тэр маш их цочирдсон, ургамалд яаж ийм сэтгэл хөдлөл байдаг байна аа? Түүнд гудамжинд гүйж гараад ургамалд сэтгэл хөдлөл байдаг юм байна! гэж хашхирмаар санагдсан. Энэ явдлаас урамшиж энэ чиглэлээр судалгаагаа үргэлжлүүлэн олон туршилтуудыг хийсэн.

Нэгэн удаа тэрээр хоёр ургамлыг зэрэгцүүлж тавиад сурагчаараа нэгийг нь нөгөөгийнх нь дэргэд дэвслүүлж үхүүлсэн. Дараа нь тэр үлдсэн ургамлыг авч өөр өрөөнд оруулаад төхөөрөмждөө залгасан, тэр өөрийн таван сурагчаа гаднаас өрөө рүү нэг нэгээр нь оруулсан. Эхний дөрвөн сурагч өрөөнд орж ирэхэд ургамалд ямар ч өөрчлөлт гараагүй. Тав дахь сурагч буюу ургамлыг дэвсэлсэн сурагч өрөөнд орж ирэнгүүт түүнийг ургамлын дэргэд дөхөж ирээ ч үгүй байхад электрон бал маш хурдан нэгэн муруйг зурсан, энэ нь хүн айх үед гардаг бичлэгтэй адилхан байсан. Тэр маш их гайхсан! Энэ туршилт маш чухал асуудлыг тайлбарласан юм: Бид үргэлж хүнийг л аливаа зүйлийг ялган таних мэдрэхүйн чадвартай бас тархиндаа юмыг дүгнэж цэгнэж чаддаг дээд зэргийн амь бодь гэж үзсээр ирсэн. Ургамал юмыг яаж ялгаж таньж чадаж байна вэ? Энэ нь ургамалд мөн мэдрэхүй байдаг гэсэн үг биш гэж үү? Хэрэв урьд өмнө хэн нэгэн ургамал бол мэдрэхүйн эрхтэнтэй, сэтгэн боддог, сэтгэлийн хөдөлгөөнтэй, мөн хүнийг ялган таньж чаддаг гэж хэлбэл түүнийг мухар сүсэгтэй гэх байсан. Үүнээс гадна ургамал зарим

нэг талаараа манай өнөөгийн хүмүүсээс давуу ч юм шиг.

Нэг удаа уг мэдрэгч төхөөрөмжийг нэгэн ургамалд залгаад тэр ингэж бодсон, “одоо ямар туршилт хийх үү? Би энэ ургамлын навчийг нь шатааж ямар цочир өөрчлөлт гарахыг нь харъя.” Энэ бодол гарахад, навчийг шатаахаас өмнө бичигч электрон бал тэр даруй нэгэн муруй зураас зурсан. Энэ нь хүн “амь авраарай” гэж хашхирахад гардаг бичлэгтэй адил байсан. Үүнийг урьдчилан мэдэх чадвар гэдэг, мөн урьд нь үүнийг хүний бодлыг унших чадвар гэдэг байсан, энэ бол хүний далд увдис, зөн билиг юм. Гэхдээ өнөөдрийн хүн төрөлхтөн доройтсон, энэ чадварыг сэргээхийн тулд чи эхнээс нь бясалгах хэрэгтэй, улмаар өөрийнхөө үүссэн эх үндсэндээ буцаж үнэнд хүрэх, жинхэнэ төрөлх мөн чанартаа буцаж орох ёстой. Харин энэ чадвар нь ургамалд байдаг, тэр чиний юу бодож байгааг мэддэг. Үүнийг сонсоход санаанд багтамгүй мэт, гэхдээ энэ бол шинжлэх ухааны бодит туршилт байсан. Тэр холын зайнаас удирдах чадварыг турших гэх мэт янз бүрийн туршилтуудыг хийсэн. Түүний судалгааны талаарх илтгэл хэвлэгдэн гарахад дэлхий даяар шуугиан дэгдсэн.

Олон орны ургамал судлаачид болон манай орны ургамал судлаачид энэ чиглэлээр судалгаа шинжилгээ хийж эхэлсэн, энэ нь одоо мухар сүсэг гэж тооцогдохоо аль хэдийн больсон. Би дээр хэлэхдээ, өнөөдөр манай хүн төрөлхтөнд гарсан зүйлс, зохион бүтээсэн, нээн илрүүлсэн зүйлүүд нь манай өнөөгийн сурах бичгийг өөрчлөхөд хангалттай гэсэн. Гэсэн хэдий ч хэвшмэл сэтгэлгээний улмаас хүмүүс үүнийг хүлээн зөвшөөрөх

дургүй байдаг, мөн эдгээр зүйлсийг системтэй цэгцэлж ангилах хүн ч байхгүй байна.

Би зүүн хойд нутгийн нэг цэцэрлэгт хүрээлэнд байдаг хэсэг нарс моднууд үхсэн байсныг харсан. Зарим хүн юугаар хичээллэж байгаа нь ч мэдэгдэхгүй, газраар өнхөрнө, дараа нь хөлөөрөө болон гараараа модноос чий хураана, удалгүй тэр хэсгийн бүх нарс моднууд шарлаж үхсэн. Энэ нь сайн үйл үү, эсвэл муу үйл үү? Манай бясалгагч хүний өнцгөөс харахад энэ бол амь алж байгаа хэрэг. Чи бясалгаж байгаа хүний хувьд сайн хүн байх ёстой, орчлон ертөнцийн мөн чанарт аажмаар уусаж, өөрийнхөө муу зүйлүүдээс салах ёстой. Энгийн хүний нүдээр харсан ч энэ нь сайн үйл хэрхэвч биш, энэ бол нийтийн өмч хөрөнгийг сүйтгэж байна, цэцэрлэгжүүлэлт болон экологийн тэнцвэрт хор учруулсан хэрэг, аль ч талаас нь харсан энэ бол сайн хэрэг биш. Орчлон ертөнцөд хангалттай чий байгаа, чи хүссэн хэмжээгээрээ хураан авч болно. Зарим хүн их энергитэй байдаг, тэд дасгал сургуулилт хийсээр нэг тодорхой түвшинд хүрэхэд, үнэхээр гараараа нэг даллаад л их хэмжээний ургамлын чий-г нэг дор хураан авч чадна. Гэсэн ч тэр бол зөвхөн л чий. Хэчнээн ихээр хураасан ч тэр юунд хэрэгтэй юм? Зарим хүн цэцэрлэгт хүрээлэнд очоод үүнээс өөр зүйл хийдэггүй, нэг хүн ингэж хэлсэн: “Надад чийгон-оор хичээллэх хэрэг байхгүй, би тэрүүгээр алхаж байхдаа л чий-г гараараа хураагаад авчихна, тэгээд л дасгалаа хийсэн гэсэн үг.” Чий-г хурааж аваад л болоо гэж үү, тэд чий-г гон гэж ойлгодог. Хүмүүс тэр хүнд ойртоход түүний биеэс сэрүү татахыг мэдэрдэг. Ургамлын чий билгийн шинж чанартай биш гэж үү? Бясалгаж байгаа хүн арга билгийн тэнцвэрийг барьж байх ёстой,

түүний биеэс нарс модны тосны үнэр ханхалж байхад харин тэр өөрийгөө сайн хичээллэсэн гэж боддог.

### **Хэн бясалгана тэр гон олж авна**

Хэн бясалгана тэр гон олж авна гэдэг нь маш чухал асуудал юм. Хүмүүс надаас Фалунь Дафа-д ямар давуу тал байдаг вэ гэж асуухад Фалунь Дафа-д гон хүнийг бясалгадаг, бясалгах хугацааг богиносгож өгдөг гэж би хариулдаг; энэ нь дасгал хийх завгүй байсан ч гон үргэлж хүнийг бясалгаж байдаг, ийм асуудлыг шийдэж өгсөн. Үүний зэрэгцээ манай бясалгал бол жинхэнэ амь бие, сэтгэлийн хос бясалгал бөгөөд бидний энэ бодит биед маш том өөрчлөлт гарна. Фалунь Дафа-д бас нэг маш том давуу тал бий, урьд нь би хэлж байгаагүй, зөвхөн өнөөдөр л бид үүнийг ил гаргаж байна. Яагаад гэвэл энэ нь түүхийн эх сурвалж бүхий маш том асуудалтай холбоотой, мөн бясалгагчдын хүрээнд бас нэлээд хүчтэй нөлөөлдөг, түүхэнд хэн ч үүнийг задлахыг зүрхлээгүй, хэнд ч үүнийг илчлэхийг бас зөвшөөрөөгүй, гэхдээ би үүнийг хэлэхгүй бол бас болохгүй.

Зарим шавь нар ингэж хэлдэг: “Ли Хонжи багшийн хэлсэн үг болгон тэнгэрийн нууц, тэнгэрийн нууцыг задалж байна.” Гэхдээ бид хүмүүсийг жинхэнэ дээд түвшин рүү дагуулж байгаа, өөрөөр хэлбэл хүн аварч байна. Бид хүн бүрд хариуцлагатай хандах ёстой бөгөөд энэхүү хариуцлагаа дааж чадна, тиймээс энэ нь тэнгэрийн нууцыг задалсан хэрэг биш. Харин энэ талаар дураараа хариуцлагагүй ярих юм бол тэнгэрийн нууцыг задалсан болно. Өнөөдөр бид хэн бясалгана тэр гон олж авна гэсэн энэ асуудлыг авч ярья. Миний үзэж байгаагаар одоогийн бүх бясалгалын аргуудад, үе үеийн Буддын, Бумбын энэ хоёр система болон

Чимэнь бясалгалд хүний Дэд сүнс (Дэд бодо) бясалгаж ирсэн, бүгдэд нь Дэд сүнс гон олж авдаг. Бидний энд ярьж байгаа Эзэн сүнс гэдэг нь бидний өөрийн оюун ухааныг хэлж байгаа юм, өөрийнхөө юу бодож байгааг болон юу хийж байгаагаа мэдэж байх ёстой, тэгвэл энэ бол жинхэнэ чи өөрөө юм. Харин Дэд сүнсний юу хийж байгааг чи огт мэдэхгүй. Хэдийгээр тэр чамтай хамт нэгэн зэрэг төрсөн нэг нэртэй бас гадаад төрхөөрөө ижил, нэг биенийг эзэмшдэг ч гэсэн нарийн яривал энэ нь чи биш.

Энэ орчлон ертөнцөд нэг зарчим байдаг, хэн алдана тэр олно, хэн бясалгана тэр гон олно. Үе үеийн бүх бясалгалуудад хүн бясалгал хийж байхдаа ховсдолын байдалд орж юу ч бодохгүй байхыг заадаг, тэгээд эцэст нь гүн самадид орж юу ч мэдэхгүй болтлоо суудаг. Зарим хүнд магадгүй гурван цаг бясалгаж суусан ч түүнд зөвхөн хоромхон хугацаа өнгөрсөн мэт санагдана, бусад хүмүүс түүний самади хүчинд биширнэ. Үнэндээ тэр бясалгасан уу? Тэр өөрөө бол юу ч мэдэхгүй. Ялангуяа Бумбын системийн бясалгалд Шишэнь үхэж Юань-шэнь төрдөг гэж заадаг. Шишэнь гэж хэлж байгааг нь бид Эзэн сүнс гэдэг; Юань-шэнь гэдэг нь бидний хэлдгээр Дэд сүнс юм. Чиний Шишэнь үнэхээр үхвэл чи үнэн хэрэгтээ үхнэ, Эзэн сүнс гэж үнэхээр байхгүй болно. Өөр бясалгалаар хичээллэдэг хүн надад ингэж хэлсэн: “Багшаа, би хичээллэх үедээ гэрийнхээ хэнийг ч танихгүй болдог.” Бас өөр нэг хүн хэлэхдээ: “Би бусад хүмүүсийн адил өглөө эрт юм уу эсвэл шөнө дөлөөр хичээллэдэггүй, би гэртээ хариад буйдан дээр хэвтээд өөрөөсөө гараад бясалгадаг, хэвтэж байхдаа өөрийгөө хичээллэж байгааг хардаг.” Надад харамсалтай санагдсан, гэхдээ тийм ч харамсалтай бас биш.

Тэд яагаад Дэд сүнсийг авардаг вэ? Люй Донбин ингэж хэлсэн: “Хүн аварснаас амьтан аварсан нь дээр.” Жирийн хүмүүс энгийн хүний нийгэмд төөрөлдсөн учраас ухамсарлахад үнэхээр хэцүү байдаг, бодит ашиг сонирхлын өмнө энэ сэтгэлээсээ салж чаддаггүй. Чи үүнд итгэхгүй байвал харж болно, зарим хүн энэ лекцэд сууж гараад эргээд л энгийн хүн болдог, хэн нэгэн түүнийг өдөх юм уу түүнд халдвал тэр тэвчин өнгөрөөж чадахгүй. Хэсэг хугацаа өнгөрсний дараа тэр өөрийгөө бясалгаж байгаа хүн гэж үзэхээ бүүр болино. Түүхэнд Бумбад бясалгасан олон хүн, бүгд энэ байдлыг олж харсан, хүнийг аврахад тун хэцүү, хүний Эзэн сүнс нь хэт их төөрсөн байдаг. Зарим хүний ухамсар нь сайн, жаахан дохио сануулга өгөхөд дор нь ойлгодог. Зарим хүнд яаж ч ярьсан тэд итгэдэггүй. Тэд чамайг хэтрүүлж байна гэж боддог. Бид түүнд өөрийн шиньшин-ийг бясалгах талаар маш их ярьдаг боловч энгийн хүмүүсийн дунд орохоороо тэр бас л юу хүссэнээ хийдэг. Тэр хүрч барьж болох энгийн хүний материаллаг ашиг сонирхлыг жинхэнэ бодит гэж үздэг учраас тэдгээрийг л хүсдэг. Түүнд Багшийн заасан Фа ёс зүйтэй сонсогдсон ч тэр дагуу хэрэгжүүлж чаддаггүй. Хүний Эзэн сүнсийг аврахад хамгийн хэцүү, харин Дэд сүнс бол өөр орон зайн байдлыг харж чаддаг. Иймээс тэд ингэж боддог: “Би чиний Эзэн сүнсийг аварч яах юм? Дэд сүнс чинь бас л чи. Би түүнийг аварвал адилхан биш гэж үү? Хоёулаа л чи юм чинь, хэн нь ч олж авсан ялгаагүй чи олж авсантай адил.”

Би тэдний бясалгалын аргыг тодорхой тайлбарлая. Хэрэв хүнд далдыг харах чадвар байвал ийм нэг байдлыг магадгүй харна: Чи завилан суун бясалгахад, ховсдолын байдалд оронгуут, гэнэт чамтай адил төрхтэй хүн чиний биеэс гараад явна. Гэхдээ чи



ялгах гээд үз, чи өөрөө хаана байна вэ? Энд сууж байна. Тэр чиний биеэс гарч явсны дараа багш нь түүнийг дагуулан явж, хувирган гаргасан нэгэн орон зайд бясалгуулж байгаа нь харагдана, магадгүй өмнөх үеийн нийгмийн байдалтай, магадгүй одоогийн нийгмийн байдалтай эсвэл магадгүй өөр орон зайн нийгмийн байдалтай газарт түүнд бясалгал заана. Тэр их зовлон амсаж байж өдөр бүр нэгээс хоёр цагийн турш бясалгана. Тэр хичээллээд буцаж ирэхэд чи бас ховсдолоос гарна, энэ бол харж чаддаг хүмүүст гардаг байдал юм.

Хэрвээ хүн үүнийг харж чадахгүй бол бүр ч харамсалтай, дүйнгэ байдалд юу ч мэдэхгүй хоёр цаг сууж байгаад ховсдолоос гарна. Зарим хүн унтдаг, нэг унтахдаа хоёр гурван цагаар унтдаг, тэр үүнийг бясалгал хийсэнд тооцдог, хүнд өөрийгөө бүрэн өгдөг. Энэ бол шууд бус завсарлагатайгаар бясалгах арга юм, өдөр болгон тогтмол хугацаагаар гүн ховсдолоын байдалд бясалгаж суудаг. Бас зарим нь нэг мөсөн дуусгадаг, та бүгд магадгүй Бодьдарма есөн жил хана руу харж суусныг сонссон байх. Урьд өмнө хэдэн арван жилээр суудаг олон лам хувраг нар байсан, түүхэнд тэмдэглэгдсэн хамгийн удаан суусан хугацаа нь ер гаруй жил байдаг, түүнээс ч удаан суусан бас байдаг, тэдний зовхи нь зузаан тоосонд дарагдчихсан, бие дээр нь өвс ургачихсан тэндээ суусан хэвээр л байдаг. Бумбын системийн зарим бясалгалд бас үүнийг заадаг, ялангуяа Чимэний зарим бясалгалд унтдаг, нэг унтахдаа хэдэн арван жилээр гүн ховсдолоос гарахгүй, унтаад сэрдэггүй. Гэвч хэн бясалгасан бэ? Түүний Дэд сүнс гарч яваад бясалгасан, хэрвээ тэр үүнийг харж чадвал, багш нь Дэд сүнсийг дагуулан бясалгуулж байгааг харна. Дэд сүнс бас маш том нүглийн өртэй

байж болно, багш нь энэ бүх нүглийг нь арилгаж өгөх чадваргүй. Тиймээс багш нь түүнд хэлнэ: “Чи энд бясалгалаа сайн хийж бай, би явчхаад удахгүй буцаад ирнэ, намайг эндээ хүлээж бай.”

Багш нь түүнд ямар зүйл тохиолдохыг мэднэ, гэхдээ ингэж хийхээс өөр аргагүй. Удалгүй чөтгөр шулам ирж түүнийг айлгана, хөөрхөн бүсгүйн дүрд хувираад түүний толгойг эргүүлнэ, янз бүрийн байдал гарна. Түүний сэтгэл үнэхээр хөдлөхгүй, яагаад гэвэл Дэд сүнсэнд бясалгахад харьцангуй амар байдаг, тэр үнэн байдлыг мэддэг. Бүг чөтгөр аргаа бараад занал хорслоо тайлахын тулд түүнийг алахыг оролдоно, тэгээд үнэхээр ална, түүний бүх өр нэг мөсөн төлөгдөнө. Үхсэний дараа Дэд сүнс угаа шиг суунаглан гарна. Тэгээд нэг ядуу гэр бүлд дахин төрнө. Тэр хар багаасаа гашуун зовлон амсана, учраа мэддэг болоход багш нь ирнэ, мэдээж тэр танихгүй. Багш нь ер бусын чадвараараа түүний хадгалагдсан ой санамжийг сэргээнэ, тэгээд гэнэт санана, “миний багш уу даа?” Багш нь түүнд “одоо бясалгаж болно” гэж хэлнэ, тэгээд олон жил өнгөрсний дараа номоо уламжилна.

Номоо зааж дууссаны дараа багш нь түүнд хэлнэ: “Чамд орхих ёстой олон зууралдсан сэтгэл байна, чи явж бадарчлах хэрэгтэй.” Нийгмийн дунд орж бадарчлан явахад их зовох болно, хоол гуйна, янз бүрийн хүмүүстэй тааралдана, түүнийг шоолно, загнана зандарна, доромжилно дээрэлхэнэ, янз бүрийн зүйл тохиолдоно. Тэр өөрийгөө бясалгагч хүн гэж үзэн бусадтай эв зүйтэй харьцана, шиньшин-ээ барьж үргэлж дээшилнэ. Тэр энгийн хүний янз бүрийн ашиг сонирхолд сэтгэл нь хөдлөхгүй, олон жил бадарчилж явсны дараа тэр буцаж ирнэ. Багш нь хэлнэ: “Чи

Бумба-д хүрсэн, төгс гэгээрлээ. Чамд өөр хийх зүйл байхгүй бол юмаа цэгцлээд явахдаа бэлд; хэрэв энгийн хүмүүсийн дунд хийх зүйл бас үлдсэн бол тэр асуудлаа дуусгачих.” Ингээд олон жил өнгөрсний дараа Дэд сүнс буцаж ирнэ, түүнийг буцаж ирэхэд Эзэн сүнс бас гүн ховсдолын байдлаас гарч Эзэн бодол нь сэрдэг.

Гэхдээ тэр үнэн хэрэгтээ бясалгаагүй, Дэд сүнс нь бясалгасан, иймээс Дэд сүнс нь гон олно. Гэхдээ Эзэн сүнс бас зовлон амссан, тэр бүхэл залуу насаараа энд суусан, энгийн хүний амьдралын он жилүүд нь ингээд л өнгөрсөн. Тэгвэл яах вэ? Тэр хүн ховсдолоос гарахдаа өөрөө бясалгаад гон-той болсон, мөн ер бусын чадвартай болсон гэж мэдэрнэ, хэрэв тэр өвчтөнийг эдгээх, эсвэл ямар нэгэн зүйл хийхийг хүсвэл хийж чадна, Дэд сүнс түүний хүслийг хангана. Яагаад гэвэл тэр ямар боловч Эзэн сүнс юм, Эзэн сүнс нь биеэ эзэмшдэг, мөн түүний үгээр л болдог. Тэгээд ч ийм олон жил тэр энд сууж хамаг амьдралаа зорнулсан. Энэ хүн нас барахад Дэд сүнс гараад явна, өөр өөрийнхөө замаар явна. Буддын шашнаар бол тэр хүн бас л зургаан замын тойрогт орно. Түүний биеэс нэг аугаа гэгээрэгч бясалгаж гарсан учраас энэ хүн их хэмжээний Дэ хураасан байдаг, тэгвэл яах вэ? Тэр дараачийн амьдралдаа магадгүй өндөр албан тушаалын дарга болно, эсвэл их баян хүн болно. Зөвхөн ийм л болж чадна. Тэр үр дүнгүй бясалгасан биш гэж үү?

Энэ асуудлыг гаргаж ярихын тулд бид маш их чармайлт гаргасан. Би мөнхийн нууцыг задаллаа, энэ бол хэрхэвч задалж болохгүй нууцын нууц байсан юм. Би бүх түүхийн турш дахь янз бүрийн бясалгалуудын бясалгах аргын үндсийг илчиллээ. Би түүхийн гүн эх сурвалжтай холбоотой гэж хэлсэн биз дээ? Ийм

л учиртай юм. Үүнийг бодоод үз, аль ч системд, аль ч номын үүдэнд бүгд ингэж бясалгаж ирсэн биш гэж үү? Чи бясалгаад л байдаг, гэвч гон олж авахгүй, чамд харамсалтай юм биш үү! Үүнд хэнийг буруутгах юм? Хүн ингэж их төөрсөн байдаг, яасан ч ухамсарлахгүй, яаж сануулсан ч ойлгохгүй. Дээд хэмжээнд ярихад тэдний санаанд багтахгүй, доод хэмжээнд ярихад дээшээ ухамсарлаж чадахгүй. Би ингэж ярьж байхад зарим хүн надаар бас л өвчнөө эдгэрүүлэх гэсэн хэвээр. Би үнэхээр түүнд юу хэлэх вэ дээ. Бид бясалгал зааж байна, дээд түвшин рүү бясалгаж байгаа хүмүүсийг л харж хандана.

Манай бясалгалд Эзэн бодол гон олж авна, тэгвэл Эзэн бодол гон олно гээд л чиний хэлснээр болох юм уу? Хэн зөвшөөрөл өгөх юм? Ийм байдаггүй, үүнд заавал урьдчилсан нөхцөл байх ёстой. Та бүгд манай бясалгалын номд энгийн хүний нийгмээс холдолгүй бясалгадаг гэдгийг мэднэ, мөн зөрчилдөөнөөс зайлсхийдэггүй, зугтдаггүй; энгийн хүний энэ төвөгтэй орчинд чи саруул ухаантайгаар, бодит ашиг сонирхол дээр ил тодоор хохирол амсана, бусдад эрх ашгаа алдахад энгийн хүнтэй адил тэмцэлдэн булаацалдахгүй; янз бүрийн шиньшин-ий үймүүлэлд чи хохирол амсана; чи ийм хэцүү зовлонтой орчинд сэтгэл санаагаа хатуужуулж, шиньшин-ээ дээшлүүлж, энгийн хүмүүсийн янз бүрийн муу санаа бодлын нөлөөллөөс ангижирч байж л дээш гарч чадна.

Та бүгд боддоо, ил тодоор зовлон эдэлж байгаа нь чи биш гэж үү? Өөрийгөө зориулсан нь чиний Эзэн сүнс биш гэж үү? Энгийн хүмүүсийн дунд алдсан зүйл нь чиний ил тодоор хүлээсэн хохирол биш гэж үү? Тэгвэл энэ гон чамд очих ёстой, хэн алдана, тэр олно.

Тиймээс манай бясалгалд, бид энгийн хүний төвөгтэй орчноос зайлсхийхгүй бясалгадгийн учир нь энэ юм. Бид яагаад энгийн хүний зөрчил дунд бясалгадаг вэ? Учир нь бид өөрсдөө гон олж авна. Ирээдүйд сүм хийдэд бясалгадаг мэргэшсэн шавь нар энгийн хүмүүсийн дунд орж бадарчлах болно.

Зарим хүн, “Одоо энгийн хүмүүсийн дунд хичээллэдэг өөр бясалгалууд бас байдаг биз дээ?” гэж асуудаг. Гэхдээ тэдгээр нь бүгд өвчин эдгээх, бие сайжруулах аргыг л дэлгэрүүлж байгаа, жинхэнэ дээд түвшний бясалгал заахад зөвхөн ганц шавьдаа уламжилж заадаг байснаас биш нийтэд хэн ч зааж байгаагүй. Жинхэнэ уламжлан зааж байгаа нь шавь нараа аль хэдийн авч явсан, тэд нууцаар заадаг. Энэ олон жил өнгөрөхөд хэн ийм зүйлийг нийтэд ярьж байсан бэ? Хэн ч хийгээгүй. Манай бясалгалд үүнийг ярьдаг, яагаад гэвэл бид энэ замаар л бясалгана, ингэж л гон олж авна. Мөн түүнчлэн манай бясалгалаар чамд мянга мянган, түүнээс ч олон зүйлийг чиний Эзэн сүнсэнд суулгаж өгнө, чамаар өөрөөр чинь гон олуулна. Би урьд өмнө хэн ч, хэзээ ч хийж байгаагүй зүйлийг хийж байгаа гэж хэлсэн, мөн хамгийн өргөн үүдийг нээж өгсөн. Зарим хүн миний хэлснийг ойлгосон, би үнэхээр тийм санаанд багтамгүй зүйл яриагүй. Би ийм нэг зуршилтай хүн, хэрэв надад нэг алд байвал би зөвхөн нэг ямх дайны зүйлийг л ярьдаг, чи намайг онгирч байна гэж хэлсэн ч болно. Би үнэндээ өчүүхэн төдий л зүйл ярьсан. Дафа-гийн бүр дээд, гүнзгий агуулгын тухайд, асар их түвшний ялгаа байгаа учраас би та нарт энэ талаар жаахан ч ярьж болохгүй.

Манай номд ингэж л бясалгана, чамаар өөрөөр чинь жинхэнэ гон олуулна, энэ нь тэнгэр газар үүссэнээс хойш анхны удаа юм, чи түүхээс хайж үзэж болно. Чи өөрөө гон олж авч байгаа болохоор энэ нь манай бясалгалын сайн тал, гэхдээ бас их хэцүү. Энгийн хүний төвөгтэй орчинд, хүн хүний хоорондын шиньшин-ий зөрчилдөөн дунд чи дээш сугаран гарна гэвэл хамгийн хэцүү. Үүний хэцүү нь гэвэл чи энгийн хүмүүсийн дунд ашиг сонирхол дээр бодитгоор хохирол амсаж байгаа юм. Бодит ашгин дээр сэтгэл чинь хөдлөхгүй байж чадах уу, үгүй юу; хүн хүний хооронд бие биесээ чадахад чиний сэтгэл хөдлөх үү, үгүй юу; чиний гэр бүл, ойр дотнын хүмүүст гай зовлон учрахад чиний сэтгэл хөдлөх үү, үгүй юу; чи эдгээрийг яаж цэгнэх вэ? Бясалгагч хүн байх ийм л хэцүү! Нэг хүн надад ингэж хэлсэн: “Багшаа, энгийн хүмүүсийн дунд сайн хүн байхад л болоо. Хэн дээш бясалгаж чадах юм?” Ингэж хэлэхийг сонсоод миний сэтгэл үнэхээр гонсойсон! Би түүнд нэг ч үг дугараагүй. Янз бүрийн шиньшин-тэй хүмүүс байдаг, тэр хэр өндөр ухамсарлаж чадна тэр хэмжээндээ л олно. Хэн ухамсарлана тэр олно.

Лаози ингэж хэлсэн: “Дао бол дагаж болох ном ч, энгийн ном биш.” Хэрэв үүнийг хаа сайгүй олж болдог, бясалгаад дороо үр дүнд хүрдэг бол энэ нь нандин биш болно. Бидний номын үүд бол чамайг зөрчлийн дунд гон олуулна, иймээс бид энгийн хүмүүсийн нөхцөл байдалд боломжийн хэрээр нийцэж байх хэрэгтэй, эд материалын хувьд чамайг үнэндээ алдуулах гээд байгаа юм биш. Гэхдээ энэ материаллаг орчинд чи шиньшин-ээ дээшлүүлэх ёстой. Манай номын үүд бол хамгийн тохиромжтой нь юм, яагаад тохиромжтой вэ гэвэл энгийн хүмүүсийн дунд бясалгаж болно, лам эсвэл гэлэнмаа болох шаардлагагүй. Хамгийн хэцүү нь

гэвэл бас энгийн хүний энэ хамгийн ээдрээтэй орчинд бясалгах болно. Гэхдээ хамгийн сайн тал нь бол чамаар өөрөөр чинь гон олж авхуулдаг, энэ нь манай бясалгалын хамгийн чухал зүйл юм, өнөөдөр би та бүгдэд үүнийг илчиллээ. Мэдээж Эзэн сүнс гон олоход Дэд сүнс бас гон олно, яагаад вэ? Чиний биеийн бүх мэдээллүүд, амь боднуд, мөн эс болгонд чинь, бүгдэд нь гон өснө, мэдээж Дэд сүнсэнд ч гон өснө. Гэхдээ түүний гон хэзээ ч чинийхээс өндөр байхгүй, чи бол Эзэн, тэр бол Фа сахиулагч.

Энэ талаар ярингаа нэмж хэлэхэд, бясалгагчдын хүрээнд олон хүн үргэлж дээд түвшин рүү бясалгахыг хүсдэг. Тэд Фа-г олохын тулд хаа сайгүй явж их мөнгөө үрсэн, уулсыг давж усыг гатлан хайгаад ч нэртэй багшийг олоогүй. Нэр цуутай байлаа ч энэ нь тэр болгон жинхэнэ мэдлэгтэй гэсэн үг биш. Нааш цааш явж их мөнгө, хүчээ үрээд эцэст нь юу ч олоогүй. Өнөөдөр бид энэ сайн бясалгалыг дэлгэрүүлээ, чамд гардуулж өглөө, би үүнийг чиний гэрийн үүдэнд хүргэж өглөө. Чиний бясалгах эсэх нь, чадах чадахгүй нь чамаас өөрөөс чинь шалтгаална. Чи чадаж байвал бясалгалаа цааш үргэлжлүүлнэ; бясалгаж чадахгүй бол үүнээс хойш бясалгах талаар бодсоны ч хэрэггүй. Буг чөтгөр чамайг залилахаас өөр хэн ч чамд заахгүй, дараа нь бясалгах гээд ч хэрэггүй. Би чамайг аварч чадахгүй бол өөр хэн ч чамайг аварч чадахгүй. Үнэндээ одоо ариун номын жинхэнэ багшийг олж заалгах нь тэнгэрт авирахаас ч хэцүү болсон, үндсэндээ харж хандах хэн ч байхгүй болсон. Дарма-гийн төгсгөлийн үед энгийн хүмүүсийг харж хандах хэн нэгэн битгий хэл, маш өндөр түвшнүүд ч бүгд төгсгөлийн сүйрэлд байгаа. Энэ бол хамгийн тохиромжтой бясалгалын зам юм, мөн шууд орчлон ертөнцийн мөн чанарын дагуу

бясалгадаг. Энэ бол хамгийн хурдан бөгөөд шулуун замын бясалгал, шууд хүний сэтгэл зүрх рүү чиглэдэг.

## **Тэнгэрийн эргүүлэг**

Бумбын системд их, бага тэнгэрийн эргүүлгийг ярьдаг, бид тэнгэрийн эргүүлэг гэж юу болохыг тайлбарлая. Бидний ерөнхийд нь ярьдаг тэнгэрийн эргүүлэг бол “Рэнь, Дү” гэсэн хоёр энергийн суваг холбогдохыг хэлдэг, энэ тэнгэрийн эргүүлэг бол арьс шиг өнгөцхөн зүйл, зөвхөн өвчнийг арилгах бие сайжруулахаас өөр ач холбогдолгүй, үүнийг бага тэнгэрийн эргүүлэг гэдэг. Бас өөр нэг тэнгэрийн эргүүлэг байдаг, түүнийг бага тэнгэрийн эргүүлэг ч гэдэггүй, мөн их тэнгэрийн эргүүлэг ч гэдэггүй, энэ бол гүн амгаланд сууж бясалгадаг тэнгэрийн эргүүлгийн нэг хэлбэр юм. Энэ нь биеийн дотроос эхлээд ниваныг тойрон бууж ирнэ, биеийн дотуур дань-тиань-ийг нэг тойроод буцаад дээшээ явна, энэ дотуур эргэлт бол жинхэнэ гүн амгаланд сууж бясалгах тэнгэрийн эргүүлэг юм. Тэнгэрийн эргүүлэг үүссэний дараа энэ нь их хүчтэй энергийн урсгал болж улмаар нэг энергийн сувгаар дамжуулж зуу зуун энергийн сувгийг, бусад бүх энергийн сувгийг дагуулж нээнэ. Бумбад тэнгэрийн эргүүлэг гэж ярьдаг, харин Буддын шашинд тэнгэрийн эргүүлэг гэж ярьдаггүй. Буддын шашинд юу гэж ярьдаг вэ? Шагжамүни өөрийнхөө Дарма номыг зааж байхдаа гон-ы талаар яриагүй, энэ талаар заагаагүй, гэхдээ түүний номд бас бясалгалаар хувирах өөрийн гэсэн хэлбэр байдаг. Буддын шашинд энерги судлаар яаж гүйдэг вэ? Байхуй цэгийг нээгээд эндээс эхлээд мушгирсан хэлбэрээр толгойн оройгоос биеийн доош бууна. Эцэст нь энэ хэлбэрээр зуу зуун энергийн сувгуудыг дагуулж нээдэг.



Тантрын шашинд ярьдаг энергийн гол суваг бас ийм зорилготой. Зарим хүн энергийн гол суваг байдаггүй гэж ярьдаг, тэгвэл Тантрын шашинд бясалгалаар энэ энергийн гол сувгийг яаж үүсгэдэг вэ? Үнэндээ, хэрэв хүний бие дэх бүх энергийн сувгуудыг нэгтгэн авч үзвэл тэдгээр нь хэдэн арван мянгаас ч илүү байдаг, мөн судастай адил хөндлөн гулд сүлжилдсэн байдаг ба судасны тооноос ч олон. Дотор эрхтнүүдийн хооронд судас байдаггүй, харин энергийн сувгууд байдаг. Тэдгээр нь толгойн оройноос биеийн бүх хэсгүүд рүү мөн хөндлөн гулд холбогдсон байдаг, эхэндээ тэдгээр нь шулуун биш байж болно, гэхдээ хоорондоо холбогдож нээгдэнэ. Дараа нь аажимдаа өргөссөөр, яваандаа энергийн шулуун суваг үүсдэг. Энэ суваг нь өөрийгөө тэнхлэг болгон ашиглах бөгөөд өөрөө эргэнэ, хэвтээ эргэлтээр хэд хэдэн төсөөллийн хүрдийг дагуулан эргэлтэд оруулна, зорилго нь биеийн бүх энергийн сувгуудыг нээхэд оршино.

Манай Фалунь Дафа-гийн бясалгалд нэг энергийн сувгаар зуу зуун энергийн сувгуудыг идэвхжүүлж эргэлтэд оруулдаг энэ хэлбэрээс зайлсхийдэг, бид эхнээсээ л зуу зуун энергийн сувгуудыг зэрэг нээж зэрэг эргэлтэд орохыг шаарддаг. Бид шууд маш өндөр түвшнээс хичээллэж эхэлдэг, доод түвшний зүйлийг алгасна. Зарим хүний хувьд нэг энергийн сувгаар дамжуулж бүх энергийн сувгуудыг нээе гэвэл магадгүй бүх нас нь ч хүрэлцэхгүй; зарим хүний хувьд хэдэн арван жилээр бясалгах шаардлагатай байдаг, маш хэцүү. Их олон бясалгалын аргуудад нэг насаараа бясалгаад үр дүнд хүрэхгүй гэж ярьдаг, гэхдээ дээд түвшний бясалгалын олон бясалгагчид амь насаа уртасгаж чаддаг, тэд амь биеийг бясалгахыг ярьдаггүй

гэж үү? Тэд бясалгахын тулд амь насаа уртасгаж чаддаг, энэ нь маш удаан хугацаа шаардагдана.

Бага тэнгэрийн эргүүлэг нь үндсэндээ өвчин эдгээх, бие сайжруулах зорилготой юм, харин их тэнгэрийн эргүүлэг бол гон-ыг бясалгана, өөрөөр хэлбэл хүн жинхэнэ бясалгана гэсэн үг. Бумбын системд ярьдаг их тэнгэрийн эргүүлэг нь манай зуу зуун энергийн сувгийг нэгэн зэрэг нээдэг шиг хүчтэй биш. Тэр бол зөвхөн хэдхэн энергийн сувгийн эргэлт юм, гарын Гурван билиг (инь), Гурван арга (ян) сувгуудаас хөлийн ул хүртэл, хоёр хөлөөс үс хүртэл бүх биеэр гүйж нэг эргэлт болдог, үүнийг их тэнгэрийн эргүүлэг гэж нэрлэдэг. Их тэнгэрийн эргүүлэг хөдөлгөөнд ормогц жинхэнэ бясалгал эхэлдэг, тиймээс зарим чийгон багш их тэнгэрийн эргүүлгийг заадаггүй, тэдний заадаг зүйл нь зөвхөн өвчин эдгээх бие сайжруулах талын л зүйлс байдаг. Зарим хүн их тэнгэрийн эргүүлгийн талаар бас ярьдаг, гэхдээ тэд чиний биед юу ч суулгаж өгдөггүй, чи өөрөө ч нээж чадахгүй. Чамд юу ч суулгаж өгөхгүй бол чи өөрийнхөө бодлоор үүнийг тийм амархан нээчихнэ гэж үү? Чи үүнийг гимнастик хийж байгаатай адил хийгээд л нээж чадна гэж үү? Бясалгал өөрөөс шалтгаалдаг, гон багшаас шалтгаалдаг, чамд “дотоод механизм”-ыг бүрэн суулгаж өгсний дараа л ийм үр нөлөө гарна.

Үеэс үед Бумбын системд хүний биеийг нэг жижиг орчлон ертөнц гэж үзэж ирсэн, энэ орчлон ертөнцийн гадна тал нь хэр уудам байна, дотор тал нь тэр хэрээр уудам, гадна талын харагдах байдал нь ямар байна, дотор тал нь мөн тийм гэж үздэг. Үүнийг ярихад санаанд багтамгүй бөгөөд ойлгоход амаргүй санагдаж магад. Энэ орчлон ертөнц ийм аугаа том,

үүнийг хүний биетэй яаж зүйрлэж болох юм? Бид ийм тайлбар хийе, манай өнөөгийн физикийн ухаанд бие бодийн бүтцийг молекулаас авхуулаад атом, электрон, протон, кварк гээд нейтрино хүртэл судалж байна, харин цааш үргэлжлүүлбэл ямар хэмжээний байх вэ? Тэр хэмжээнд микроскопоор харж чадахгүй, тэгвэл түүнээс бүр цааш бичил ширхэг нь юу байдаг вэ? Энэ нь мэдэгдэшгүй. Үнэндээ одоогийн бидний физик судлалд таньж мэдсэн нь орчлон ертөнцийн хамгийн бичил ширхэгтэй харьцуулбал маш хол зайтай юм. Хүн энэ махан биегүй бол нүдээрээ юмсыг томруулж харж чадна, бичил түвшний зүйлсийг харах боломжтой болно. Түвшин өндөр байх тусам улам бичил түвшнийг харж чадна.

Шагжамүни өөрийнхөө түвшинд гурван мянган хорвоо ертөнцийн тухай номлол ярьсан, тухайлбал энэ Тэнгэрийн заадас галактикт манай хүн төрөлхтөн шиг бие махбодтой хүмүүс оршдог. Мөн нэг ширхэг элсэн дотор гурван мянган хорвоо ертөнц агуулагддаг гэж хэлсэн, энэ нь бидний орчин үеийн физикийн ойлголттой нийцэж байгаа юм. Электрон атомын цөмийг тойрч эргэдэг хэлбэр нь дэлхий нарыг тойрон эргэдэгтэй ямар ялгаа байгаа юм? Иймээс Шагжамүни бичил түвшинд элсний ширхэг дотор гурван мянган хорвоо ертөнц байдаг гэж хэлсэн, энэ нь яг орчлон ертөнцтэй адил, дотор нь амь бодь болон бие бодь оршдог. Хэрэв энэ нь үнэн байвал бодоод үз дээ, элсний ширхэг доторх тэр хорвоо ертөнцөд бас элс байна биз дээ? Тэр элсний ширхэг доторх элсэнд бас л гурван мянган хорвоо ертөнц байна биз дээ? Тэгвэл тэр элсэн доторх элсэн дэх гурван мянган хорвоо ертөнцөд бас л элс байна биз дээ? Ингэж үргэлжлүүлэн доош хөөвөл энэ нь хязгааргүй. Иймээс

Шагжамүни Рулай (Татагата) түвшинд хүрсэн ч гэсэн ийм нэг үг хэлсэн: “Гадаргуу нь хязгаар үгүй уудам, доторх нь хязгаар үгүй бичил.” Том нь, орчлон ертөнцийн хязгаар нь харагдашгүй; жижиг нь, түүний эх сурвалж болох бие бодийн хамгийн бичил ширхэг нь юу болох нь үзэгдэшгүй гэсэн.

Зарим нэг чийгон багш арьсан дахь хөлсний нүхэнд хот байдаг, дотор нь галт тэрэг, машин явдаг гэж хэлсэн. Сонсоход төсөөлөхийн аргагүй, гэхдээ бид үүнийг шинжлэх ухааны үүднээс үнэхээр судалж бас ойлгох юм бол тэр хэлсэн нь санаанд багтамгүй зүйл биш юм. Би урьд нь тэнгэрийн мэлмий нээгдэх талаар ярихад олон хүний тэнгэрийн мэлмий нээгдэж ийм дүр зургийг харсан: Тэд духан дахь сувгаар гадагш гүйж байсан, гэхдээ хэзээ ч эцэст нь хүрч чадашгүй мэт байсан. Өдөр болгон бясалгал хийх үед хоёр талаар нь уултай устай, энэ өргөн замаар гадагш хурдалж байгаагаа мэдэрдэг, гүйж явахдаа тэд хотуудаар дайрч өнгөрөхөд нэлээд олон хүмүүс харагддаг. Үүнийг тэд хий үзэгдэл гэж бодож магадгүй. Ямар учиртай вэ? Харсан зүйлүүд нь маш тодорхой, хий үзэгдэл биш юм. Хэрэв хүний бие бичил түвшинд үнэхээр тийм энгүй уудам юм бол, энэ нь хий үзэгдэл биш гэж би хэлнэ. Яагаад гэвэл Бумбын системийн бясалгалд хүний биенийг нэг орчлон ертөнц гэж үзсээр ирсэн, хэрэв энэ нь үнэхээр нэгэн орчлон ертөнц юм бол духнаас булцуут булчирхай хүртэл 108 мянган “ли”-гээс ч хол байх болно. Чи гадагшаа гарах гээд тэмүүлээд үзсэн ч энэ нь маш хол зай юм.

Хэрэв бясалгалын явцад их тэнгэрийн эргүүлэг бүрэн нээгдвэл бясалгаж байгаа хүнд нэг ер бусын чадвар гарна, ямар ер бусын чадвар вэ? Та нар их

тэнгэрийн эргүүлгийг бас Голч (меридиан) тэнгэрийн эргүүлэг, “Тэнгэр газрын эргэлт” эсвэл “Хөчэ эргэлт” гэж нэрлэдгийг мэднэ. Их доод түвшинд их тэнгэрийн эргүүлэг нь энергийн урсгал үүсгэдэг бөгөөд тэр нь аажмаар нягтаршиж дээд түвшин рүү хувирна, улмаар маш нягт энергийн том бүслүүр болдог. Энэ энергийн бүслүүр нь эргэх хөдөлгөөнтэй, үүний эргэх явцыг их доогуур түвшинд тэнгэрийн мэлмийгээр харахад тэр нь бие доторх чий-н байршлыг өөрчилдөг болохыг ажиглаж болно: Зүрхний чий гэдэс рүү шилжинэ; элэгний чий ходоод руу очно... Хэрэв бичил түвшинд харвал энергийн бүслүүр нь их том зүйлсийг зөөж байдаг, хэрэв энэ энергийн бүслүүрийг биеийн гадна гаргавал юмыг зайнаас хөдөлгөх, зөөх ер бусын чадвар болно. Маш хүчтэй гон энергитэй хүн ямар нэгэн том зүйлийг зайнаас зөөж чаддаг, үүнийг том зөөлт гэдэг. Сулавтар гон хүчтэй хүн жижиг зүйлийг зайнаас хөдөлгөж, зөөж чаддаг, үүнийг жижиг зөөлт гэнэ. Энэ бол биетийг зайнаас хөдөлгөх, зөөх ер бусын чадварын хэлбэрүүд ба түүний үүсэл нь юм.

Их тэнгэрийн эргүүлэг бол гон-ыг бясалгадаг, тиймээс энэ нь янз бүрийн төлөв байдал ба гон хэлбэрийг бий болгодог, мөн бидэнд маш онцгой байдлыг авчрах болно. Ямар байдал вэ? Та бүхэн магадгүй Бурханы намтар, Данжин (Үрлийн судар), Даозан (Бумбын жаяг) ба Шиньмин Гүйжи (Дотоод чанар ба амь насны судар) зэрэг эртний номд “гэгээн цагаан өдрөөр хөөрөх” (байри фэйшэнь) гэсэн хэллэг байдгийг уншсан байх, энэ нь гэгээн цагаан өдөр хүн агаарт хөөрнө гэсэн үг. Үнэндээ би та бүгдэд хэлье, их тэнгэрийн эргүүлэг нээгдэхэд хүн хөөрч чаддаг, ийм л энгийн юм. Зарим хүн ингэж бодно, энэ олон жил бясалгаж байхад их тэнгэрийн эргүүлэг нь нээгдсэн

хүн цөөнгүй байх учиртай. Би үүнийг бүр хэдэн арван мянган хүн энэ түвшинд хүрсэн гэхэд итгэмээргүй зүйл биш гэж хэлнэ, яагаад гэвэл их тэнгэрийн эргүүлэг бол бясалгалын дөнгөж эхний шат юм.

Тэгвэл яагаад эдгээр хүмүүсийн газраас хөндийрч эсвэл агаарт хөөрч байгаа нь бидэнд харагдахгүй байна вэ? Яагаад гэвэл энгийн хүний нийгмийн байдлыг үймүүлж болохгүй, мөн энгийн хүний нийгмийн хэлбэрийг хамаагүй эвдэж, өөрчилж болохгүй. Хүн болгон тэнгэрт нисээд байвал юу болох юм? Түүнийг энгийн хүний нийгэм гэх үү? Энэ бол гол учир нь юм; нөгөө талаас нь авч үзэхэд, хүн энгийн хүмүүсийн дунд хүн байхын тулд амьдардаггүй, харин өөрийн үүссэн эх үндсэндээ буцаж үнэнд хүрэхийн төлөө юм, иймээс ухамсарын асуудал байдаг. Маш олон хүн үнэхээр агаарт хөөрч байхыг харсан хүн бас бясалгахыг хүснэ, тэгвэл ухамсарлах асуудал байхгүй болно. Иймээс чи бясалгаад ямар ч чадвартай болсон бай, бусдад хамаагүй үзүүлж болохгүй, хүмүүст үүнийг ил гаргаж болохгүй, тэд ч бас бясалгах хэрэгтэй. Тийм болохоор чиний их тэнгэрийн эргүүлэг нээгдсэний дараа хурууны үзүүр, хөлийн хурууны үзүүр эсвэл биеийн чинь аль нэг хэсгийг түгжвэл чи хөөрч чадахгүй болно.

Бидний их тэнгэрийн эргүүлэг нээгдэх үед ийм байдал гардаг, зарим хүн завиан суугаад бясалгахад бие нь урагш бөхийдөг. Тэр хүний ар тал нь арай сайн нээгдсэн учраас нуруу тал нь их хөнгөрсөн байхад биеийнх нь урд тал нь хүнд мэдрэгдэнэ; зарим хүн хойш гэдийнэ, тэдний ар тал нь хүнд мэдрэгдэж байхад урд тал нь хөнгөн байдаг. Хэрэв чиний бүх тал жигд сайн нээгдвэл чамд донслох мэт, дээшээ өргөгдөж байгаа мэт, газраас хөндийрч байгаа мэт

мэдрэмж төрнө. Хэрвээ чи үнэхээр хөөрч чаддаг болбол чамайг хөөргөхгүй, гэхдээ огт хөөргөхгүй гэж байгаа юм биш. Ер бусын чадвар гол төлөв насны хоёр хязгаарын хүмүүст гардаг. Хүүхдэд зууралдсан сэтгэл байдаггүй, настай хүмүүст, ялангуяа настай эмэгтэйчүүдэд зууралдсан сэтгэл байдаггүй, тэдэнд ер бусын чадвар амархан гардаг ба хадгалагдан үлддэг. Эрэгтэй хүнд, ялангуяа залуучуудад ер бусын чадвар гарахад өөрийгөө гайхуулах сэтгэлээ барьж чаддаггүй, түүнчлэн тэд энэ чадварыг энгийн хүмүүсийн дунд өрсөлдөх аргаа болгон ашиглаж магадгүй. Иймээс түүнд ер бусын чадвар гарахыг зөвшөөрөхгүй, бясалгалаар гарсан ч түүнийг түгждэг. Хүний аль нэг хэсгийг нь түгжвэл газраас хөөрч чадахгүй. Гэхдээ чамд ийм байдал гарахыг бүрмөсөн хорино гэсэн үг биш, чамд магадгүй туршиж үзэхийг зөвшөөрнө, зарим хүнд энэ чадвар нь хадгалагдаж үлддэг.

Ийм байдал миний лекц заасан газар болгонд гарч байсан. Намайг Шандон мужид лекц уншиж байхад тэнд Жинань бас Бээжин хотуудаас ирсэн сурагчдад бүгдэд нь ийм байдал гарч байсан. Тэдний нэг нь надаас асуусан: “Багшаа, энэ юу болоод байна аа? Алхаж байхад надад газраас хөндийрөөд байх шиг санагдах юм, гэртээ унтаж байхад бас хөөрч байгаа мэт болоод байх юм, миний хөнжил ч бас хамт дээш хөөрөөд, яг л агаарын бөмбөлөг шиг дээш хөөрөөд байх юм.” Намайг Гүйянь хотод лекц уншиж байхад Гүйжоу-гийн хуучин сурагч болох нэгэн настай эмэгтэй байсан. Тэр эмэгтэй өрөөндөө хоёр ортой байсан, нэг ор нь нэг талын хана дагуу нөгөө ор нь эсрэг талын хана дагуу байрласан байсан. Тэр орон дээрээ бясалган сууж байтал дээш хөөрөх мэдрэгдсэн, тэгээд нүдээ нээгээд хартал нөгөө талын орон дээр

хөөрөөд очсон байсан; тэр ор луугаа буцах хэрэгтэй гэж бодонгуут эргээд өөрийнхөө орон дээр ирсэн.

Чиндао хотын нэг сурагч байсан, өдрийн цайны цагаар ажлын өрөөнд нь хэн ч байхгүй байхад орон дээр суугаад бясалгал хийсэн, тэр дөнгөж хийж эхэлтэл нэг метр орчим өндөрт дээш хөөрч доош огцом хүчтэй унасан. Улмаар дахин дээш хөөрөх, доош буух давтагдсан, хөнжил нь хүртэл ойж шалан дээр унасан. Түүний сэтгэл бага зэрэг хөөрсөн бас жаахан айсан, ингэж дээш хөөрөх, доош буух байдал өдрийн завсарлага турш үргэлжилсэн. Эцэст нь ажил эхлэх хонх дугарахад тэр ингэж бодсон: “Би үүнийг хүнд үзүүлж болохгүй, тэд юу болоод байна аа гээд гайхна, хурдхан больё.” Тэрээр зогсоосон. Ийм учраас л настай хүн өөрийгөө барьж чаддаг нь энэ юм. Хэрэв залуу хүнд ийм зүйл тохиолдсон бол, ажилд гарах хонх дугарахад, “Бүгдээрээ энд ирээд миний хөөрөхийг хардаа” гэж мэдэх байсан. Хүн өөрийнхөө гайхуулах сэтгэлийг барихад амаргүй байдаг нь энэ юм: “Миний ямар сайн бясалгасныг хар даа, би хөөрч чадаж байна.” Тэр ингэж нэг гайхуулангуут энэ чадвар нь алга болно, ийм байхыг зөвшөөрөхгүй, энд тэндхийн сурагчдын дунд ийм тохиолдол их гардаг.

Бид эхнээсээ л зуу зуун энергийн сувгийг бүгдийг нээхийг шаарддаг. Одоо манай сурагчдын 80-90 хувь нь бүх бие нь хөнгөрч ямар ч өвчингүй байдалд хүрсэн. Мөн түүнчлэн бид хэлсэн, энэ ангид чамайг ийм нэг байдалд түлхэж хүргэнэ, чиний биенийг бүрэн ариусгаад зогсохгүй бас маш олон зүйлийг чамд суулгаж өгнө, чамд энэ лекцэд гон гаргуулна, би чамайг дээш өргөөд цааш явуулахтай адил юм. Би энэ лекцэд та нарт Фа зааж байна, мөн та бүгдийн шиньшин-д



тасралтгүй өөрчлөлт гарч байна. Та нарын ихэнх нь энэ танхимаас гараад өөрийгөө өөр хүн болсныг мэдрэх болно, чиний ертөнцийг үзэх үзэлд өөрчлөлт гарах нь дамжиггүй, ирээдүйд чи өөрийгөө хэрхэн авч явбал зохистойг мэдэх болно, хойшид урьдынх шигээ болчимгүй зүйл хийж явахаа болино, ийм байдалд хүрэх нь дамжиггүй, тиймээс та нарын шиньшин аль хэдийн дагаад дээшилсэн.

Их тэнгэрийн эргүүлэг нээгдсэний дараа чамайг дээш хөөрөхийг зөвшөөрөхгүй ч гэсэн бие чинь хөнгөрсөн болохыг мэдэрнэ, алхахдаа салхи татуулна. Урьд нь хэд алхаад л ядардаг байсан бол одоо чамд хэр хол алхсан ч биеийнхээ хөнгөнийг мэдрэх болно. Дугуй унасан ч араас чинь хүн түлхэж байгаа юм шиг, шагаар дээш хэчнээн өндөрт гарсан ч ядрахгүй, ийм байхыг батална. Энэ номыг уншаад бие даан бясалгаж байгаа хүн мөн адил хүрэх ёстой төлөв байдалдаа хүрч чадна. Би ярихыг хүсээгүй зүйлээ ярьдаггүй хүн, гэхдээ ярьсан бол миний ярьсан үг үнэн байх ёстой. Ялангуяа энэ тохиолдолд, хэрэв би Фа заахдаа үнэнийг хэлэхгүй бол, хэрэв би учир битүүлэг зүйл яривал, эсвэл оновчтой бус хамаагүй яривал, би буруу ном заасан болно. Надад энэ зүйлийг хийхэд бас амаргүй байдаг, бүхий л орчлон ертөнц даяар үүнийг ажиглаж байна, хазайж болохгүй.

Жирийн хүн зөвхөн ийм нэг тэнгэрийн эргүүлэг байдгийг л мэднэ, тэгээд л болоо, үнэндээ энэ бол хангалтгүй. Хүний биеийг аль болох хурдан дээд энергийн бие бодиор бүрэн солих, хувиргахын тулд бас өөр нэг төрлийн тэнгэрийн эргүүлэг байх ёстой, энэ нь чиний биеийн бүх энергийн сувгуудыг дагуулж хөдөлгөөнд оруулна, үүнийг Мао-ю тэнгэрийн

эргүүлэг гэж нэрлэдэг, маш цөөхөн хүн л мэдэж магадгүй. Ийм нэр хэллэгийг номд хааяа нэг дурдсан байдаг, гэхдээ үүнийг хэн ч тайлбарлаж байгаагүй, чамд энэ талаар хэлэх ч үгүй. Энэ нь нууцын нууц учраас бүгд үүнийг тойруулан зөвхөн онолын хүрээнд л ярьдаг. Бид энэ бүгдийг чамд хэлж өгье: энэ эргэлт нь Байхуй сүвээс эхэлнэ (эсвэл Хуйень сүв), эндээс гараад арга билиг талуудын заагаар явдаг, энэ нь чихнээс буун мөрөөр дамжин доош явна. Хуруу болгоны завсраар өнгөрнө. Дараа нь биеийн хажуугаар яван хөлийн улаар хөндлөн гарч гуяны дотор талаар дээш өгсөнө. Тэгээд нөгөө гуяны дотор талаар доош бугаад хөлийн улаар хөндлөн гарч биеийн нөгөө талаар дээш өгсөнө. Мөн нөгөө гарын хуруу болгоны завсраар өнгөрсний дараа толгойн оройд хүрч нэг бүтэн эргэлт болно, энэ бол Мао-ю тэнгэрийн эргүүлэг юм. Хүмүүс энэ талаар бүтэн ном бичиж болно, би үүнийг хэдхэн үгээр л хэллээ. Би үүнийг тэнгэрийн нууцад тооцох ёсгүй гэж боддог, харин бусад хүмүүс үүнийг маш нандин зүйл гэж үздэг, үндсэндээ ярьдаггүй, гагцхүү шавьдаа жинхэнэ уламжлан заахдаа л Мао-ю тэнгэрийн эргүүлгийг ярьдаг. Хэдийгээр би үүнийг ил гаргасан ч хэн ч үүнийг бодлоор удирдах гэж оролдож болохгүй, хэрвээ чи ингэж хийвэл манай Фалунь Дафа-гийн бясалгал биш болно. Жинхэнэ дээд түвшин рүү бясалгахад үйлгүй байдаг, ямар ч бодлын хөдөлгөөн байхгүй, бүгдийг чамд бэлнээр суулгаж өгсөн. Бүгд автоматаар үүсдэг, эдгээр дотоод механизм нь чамайг бясалгана, цаг нь болоход тэд өөрсдөө эргэлтэд орно. Нэг өдөр чамайг дасгалаа хийж байхад толгой чинь хоёр тийшээ ганхаж магадгүй, толгой чинь энэ тал руу хазайвал тэр нь энэ зүг рүү эргэж байдаг; толгой нөгөө

тал руу хазайвал тэр зүг рүү эргэж байдаг, хоёр тал руу эргэдэг.

Их, бага тэнгэрийн эргүүлэг нээгдсэний дараа бясалгаад сууж байхад толгой дохино, энэ бол энерги дамжин өнгөрч байгаа шинж юм. Бидний хийдэг “Фалунь тэнгэрийн эргүүлэг” гэдэг дасгал ч гэсэн мөн адилхан, бид ингэж л хичээллэж ирсэн, үнэндээ чамайг дасгалаа хийгээгүй байхад ч тэр өөрөө эргэж байдаг. Хэзээд ч байнга эргэж байх болно, дасгал хийснээр энэ механизмыг эрчимжүүлдэг. Бид Фа хүнийг бясалгадаг гэж ярьсан биз дээ? Жирийн үед ч тэнгэрийн эргүүлэг зогсолтгүй эргэж байдгийг чи мэдэрч болно, чамайг дасгалаа хийгээгүй байхад ч чиний биенийн гадуур суулгасан энергийн механизм, өөрөөр хэлбэл гадаргуун том суваг чиний биенийг дагуулж бясалгадаг, бүгд автоматаар явагддаг. Энэ нь бас буцаж эргэнэ, хоёр тийшээ эргэж чиний энергийн сувгуудыг үргэлж нээж өгч байдаг.

Тэгвэл тэнгэрийн эргүүлгийг нээх зорилго нь юу вэ? Тэнгэрийн эргүүлгийг нээх нь дасгалын гол зорилго биш. Чиний тэнгэрийн эргүүлэг нээгдсэн ч, би үүнийг юу ч биш гэж хэлнэ. Цаашид үргэлжлүүлэн бясалгаж тэнгэрийн эргүүлгийн аргаар нэг энергийн сувгаар дамжуулж зуу зуун энергийн сувгийг, бие дэх бүх энергийн сувгуудыг нээх зорилготой. Бид аль хэдийн үүнийг хийж эхэлсэн. Цаашид бясалгахад, зарим хүн их тэнгэрийн эргүүлгийн эргэлтээр энергийн сувгууд хуруу шиг бүдүүрч дотроо их өргөн болсныг олж мэднэ. Яагаад гэвэл энерги их хүчтэй болдог, энергийн урсгал үүссэний дараа энэ нь их өргөсөж бас гэрэлтэж эхэлнэ. Энэ нь бас л юу ч биш. Тэгвэл ямар хэмжээнд хүртэл дасгал хийхэд хангалттай вэ? Хүний биений

зуу зуун энергийн сувгууд аажмаар өргөснө, энерги нь улам хүчтэй болж улам тод гэрэлтэх болно. Эцэст нь мянга мянган энергийн сувгууд хоорондоо нийлж нэг бүхэл болсноор хүний бие энергийн суваггүй, сүвгүй байдалд хүрч бүхэл болж нэгдэнэ, энэ бол энергийн сувгуудыг нээхийн эцсийн зорилго. Үүний зорилго нь хүний биеийг дээд энергийн бие бодиор бүрэн хувиргах явдал юм.

Энэ хэмжээнд хүрэхэд хүний бие ерөнхийдөө дээд энергийн бие бодиор хувирдаг, өөрөөр хэлбэл Гурамсан ертөнцийн Фа бясалгалын хамгийн дээд түвшинд хүрсэн юм, мөн хүний махан бие нь бясалгагдаж оргилдоо хүрсэн гэсэн үг юм. Энэ үе шатанд хүнд бас өөр нэг байдал гардаг, ямар байдал гардаг вэ? Гаргасан гон нь маш баялаг болно. Энгийн хүний биеийн бясалгал, өөрөөр хэлбэл Гурамсан ертөнцийн Фа бясалгалын явцад хүний бүх ер бусын чадварууд (далдын чадварууд) бүгд гарч ирдэг, гэхдээ энгийн хүмүүсийн дунд бясалгахад эдгээрийн ихэнх нь түгжигддэг. Мөн түүний гон багана аль хэдийн маш өндөрт хүрсэн байх болно, бүх төрлийн гон хэлбэрүүд хүчирхэг гон-оор адислагдаж нэлээд хүчтэй болсон байдаг. Гэхдээ тэдгээр нь зөвхөн бидний энэ орон зайд л нөлөөлж чадна, энэ нь жирийн хүний махан бие бодиор бясалгаж гаргасан ер бусын чадвар учраас бусад орон зайд үйлчилж чадахгүй. Тийм ч гэсэн тэдгээр нь аль хэдийн их баялаг болсон, орон зай болгонд, янз бүрийн орон зайд орших биесийн оршин тогтнох төрөл бүрийн хэлбэрт ихээхэн өөрчлөлт гарсан. Тэдгээр биест байгаа зүйлс нь, орон зай болгонд орших биест агуулагдах зүйлс нь маш баялаг бөгөөд их сүрдмээр харагдана. Зарим хүн биен дээрээ энд тэндгүй нүдтэй байдаг, бүх хөлсний сүвнүүд

нь бүгд нүд байдаг. Түүний бүхий л орон зайн хүрээн дотор нүднүүд байна. Буддын системийн гон учраас зарим хүн бүх биеэрээ Бодьсадва, Буддын дүрсээр дүүрэн байдаг. Янз бүрийн Гон хэлбэрүүд нь их баялаг болох бөгөөд маш олон амь боднуд илэрч гарч болно.

Энэ үед хүрэхэд түүнд бас нэг байдал гарна, үүнийг “Толгойн оройд гурван цэцэг цуглах” гэдэг. Энэ бол их нүд булаам ил тод төлөв байдал юм, тэнгэрийн мэлмийн түвшин нь доогуур байгаа хүнд ч бас харагдана. Толгойн дээр гурван цэцэг гарч ирнэ, тэдний нэг нь бадамлянхуа цэцэг, гэхдээ тэр бол бидний энэ материаллаг орон зайд байдаг бадамлянхуа цэцэг биш, нөгөө хоёр цэцэг нь бас өөр орон зайн цэцгүүд бөгөөд маш үзэсгэлэнтэй. Гурван цэцэг толгой дээр ээлжлэн эргэнэ, тэд цагийн зүүний дагуу эсвэл эсрэгээр эргэнэ, цэцэг болгон бас өөрөө эргэлдэнэ. Цэцэг болгон том баганатай байдаг, багана нь цэцгийн диаметртай адил өргөнтэй. Гурван өндөр багана тэнгэр өөд цойлсон байдаг, гэхдээ тэдгээр нь гон багана биш тийм л нэг хэлбэртэй бөгөөд ер бусын гайхамшигтай, чи өөрөө харж чадвал мэлрэн цочирдох болно. Энэ түвшинд бясалгаад хүрэхэд, бие нь сүүн цагаан ариун, арьс нь цайвар зөөлөн болдог. Энэ үе шатанд хүрэхэд хүн Гурамсан ертөнцийн Фа бясалгалын хамгийн дээд хэлбэрт хүрсэн юм. Гэхдээ энэ нь эцсийн төгсгөл биш, цааш үргэлжлүүлэн бясалгаж улам дээш ахих хэрэгтэй.

Цааш урагшлан бясалгахад Гурамсан ертөнцийн Фа болон Гурамсан ертөнцөөс гарсан Фа-гийн дундах шилжилтийн түвшинд орно, энэ биеийг ариун цагаан бие (мөн болор цагаан бие)-ийн төлөв гэдэг. Хүний бие бясалгагдаад Гурамсан ертөнцийн Фа-гийн хамгийн дээд хэлбэрт хүрэхэд, энэ нь зөвхөн хүний махан бие

хамгийн дээд хэлбэрт хувирсан гэсэн үг юм. Жинхэнэ тэр хэлбэрт хүрэхэд хүний бүх бие дээд энергийн бие боднос бүрэн бүрддэг. Яагаад үүнийг ариун-цагаан бие гэж нэрлэдэг вэ? Яагаад гэвэл энэ бие аль хэдийн туйлын цэвэр ариун байдалд хүрсэн юм. Тэнгэрийн мэлмийгээр харахад бүх бие нь тунгалаг, шил шиг, харахад юу ч байхгүй тийм нэг байдал илэрдэг, шуудхан хэлбэл энэ бол Будда-бие. Яагаад гэвэл дээд энергийн бие боднос бүрсэн бие нь бидний энэ төрөлх биетэй аль хэдийн адилгүй болсон. Энэ шатанд хүрэхэд биед гарсан бүх ер бусын чадварууд болон увдист зүйлс бүгд нэн даруй хаягдана, тэдгээрийг маш гүн нэг орон зайд орхидог, хэрэгцээгүй болдог, үүнээс хойш ямар ч үр нөлөөгүй болно. Чинний бясалгал дуусаж Бумбад хүрэх тэр өдөр өөрийнхөө бясалгалын явцыг эргэн харахыг хүсвэл тэдгээрийг гарган ирж үзэж болно. Энэ үед зөвхөн хоёр зүйл л үлдэнэ: Гон багана байсаар байна, мөн бясалгалаар гарсан Юань-инь өсөж аль хэдийн их том болсон байна. Гэхдээ энэ хоёр зүйл бүгд маш гүн орон зайд оршдог, хүний тэнгэрийн мэлмийн түвшин өндөр биш бол харагдахгүй, зөвхөн энэ хүний бие тунгалаг болох нь л харагдана.

Ариун цагаан биений байдал бол зөвхөн шилжилтийн түвшин учраас цааш бясалгахад, Гурамсан ертөнцөөс гарсан Фа-гийн бясалгалд орно, үүнийг мөн Буддын биений бясалгал гэдэг. Бүх бие нь гон-оос бүтнэ, энэ үед хүний шиньшин тогтвортой болсон байна. Бүхнийг шинээр бясалгаж эхэлнэ, шинээр ер бусын чадвар гарна, гэхдээ үүнийг ер бусын чадвар гэж хэлэхгүй харин “Буддын Фа-гийн ер бусын чадвар” гэж хэлэх нь зүйтэй, энэ нь бүх орон зайд үйлчилж чадна, сүр хүч нь зүйрлэшгүй их. Чи үргэлжлүүлэн бясалгаад байвал ирээдүйд бүр дээд

түвшний зүйлсийг, яаж бясалгах, бясалгалын ямар хэлбэрүүд байдаг зэргийг өөрөө мэдэх болно.

## **Баярлах сэтгэл**

Би баярлах сэтгэлтэй холбоотой нэг асуудлыг ярья. Маш олон хүн урт удаан хугацааны турш чийгон-оор хичээллэсэн байдаг, мөн чийгон-оор хэзээ ч хичээллэж үзээгүй ч хүн бас байдаг, гэхдээ тэд энэ насандаа үнэнийг мэдэх, амьдралын утга учрыг ойлгох гэж эрэлхийлдэг, эргэцүүлэн боддог. Тийм хүн манай Фалунь Дафа-гаар хичээллэсний дараа амьдралдаа мэдэхийг хүссэн ч мэдэж чадаагүй олон асуултынхаа хариултыг шууд ойлгодог. Тэдний үзэл бодол дээшлэхийн зэрэгцээ сэтгэл нь их хөдөлдөг, энэ бол гарцаагүй. Жинхэнэ бясалгагч хүн үүний үнэ цэнийг ойлгоно, тэгээд нандигнан үздэг гэдгийг би мэднэ. Гэхдээ ийм нэг асуудал байнга гардаг, хүн их баярласны улмаас хэрэгцээгүй баярлах сэтгэл амархан гардаг, энэ нь хүнийг энгийн хүний нийгэмд хүн хүний хоорондын харьцаанд орохдоо, энгийн хүний нийгмийн орчинд биеэ авч явахдаа хэвийн бус зан байдал гаргахад хүргэдэг. Би тийм байж болохгүй гэж хэлье.

Манай бясалгалаар ихэнх хүн энгийн хүний нийгэмд бясалгана, чи өөрийгөө энгийн хүний нийгмээс тусгаарлаж болохгүй, мөн саруул ухаантай бясалгах хэрэгтэй. Хүн хүний хооронд хэвийн харьцаа байх ёстой, мэдээж чиний шиньшин их өндөр, сэтгэл чинь зөв байна, чи өөрийнхөө шиньшин-ийг дээшлүүлнэ, түвшнээ ахиулна, муу зүйл хийхгүй, сайн үйл хийнэ, чи зөвхөн ийм л байдалтай байна. Зарим хүн өөрийгөө сэтгэл мэдрэл нь хэвийн бус гэж харагдамаар авч явдаг, энгийн хүний бүх зүйлийг нэвтэрхий мэддэг

мэт ханддаг, юм ярьсан ч хүнд ойлгогдохгүй. Хүмүүс ингэж хэлнэ, “Фалунь Дафа-г сурсан хүн яагаад ийм болдог байна аа? Сэтгэл мэдрэлийн согогтой юм шиг.” Үнэндээ тийм биш юм, тэр зүгээр л маш их догдолсноос зүй зохисгүй, энгийн ёсонд нийцэхгүй байдал гаргасан. Та бүгд боддоо, ийм байвал бас буруу, чи хэт туйлшраад явчихлаа, энэ бас зууралдсан сэтгэл. Чи үүнийг орхих ёстой, энгийн хүмүүсийн дунд бусдын адил хэвийн амьдарч бясалгах хэрэгтэй. Энгийн хүмүүсийн дунд хүн болгон чамайг ухаан санаа нь согогтой гэж харвал, тэд чамтай харьцахгүй чамаас зайгаа барина, хэн ч чамд шиньшин-ээ дээшлүүлэх боломж олгохгүй, хэн ч чамайг эрүүл ухаантай гэж үзэхгүй. Би хэлье, энэ бол буруу! Тиймээс та бүгд заавал энэ асуудалд анхаарах хэрэгтэй, мөн өөрийгөө сайн барьж байх хэрэгтэй.

Манай бясалгал бол гүн ховсролд орж ухаан санаагаа эзэнгүй орхидог, хэвийн бус байдалд ордог жирийн бясалгалуудтай адилгүй. Манай бясалгалд чамайг өөрөө бүрэн сэргэг ухаантай бясалгахыг шаарддаг. Зарим хүн үргэлж ингэж хэлдэг: “Багшаа, би нүдээ анингуут найгаад байх юм.” Би тийм байх албагүй гэж хэлмээр байна, чи аль хэдийн өөрийнхөө эзэн бодлыг сул орхидог байдалд ороод дасчихсан байна, чи нүдээ аниад л өөрийнхөө Эзэн бодлыг сул тавьдаг, алга болдог байдалд аль хэдийн дасчихсан юм. Чи энд сууж байхад найгахгүй л байгаа биз дээ? Чи нүдээ нээлттэй байхдаа байдаг шигээ нүдээ хөнгөн анихад бие чинь найгах юм уу? Ердөө тэгэхгүй. Чи чийгон-оор хичээллэхдээ ингэж хийх ёстой гэж боддог учраас чамд тийм төсөөлөл бий болсон, чи нүдээ аниад л замхардаг, өөрийгөө хаана байгааг ч мэдэхээ больдог. Бид чиний Эзэн бодол заавал өөрийн ухаантай байх



ёстой гэж хэлсэн, яагаад гэвэл энэ бясалгал чамайг өөрийг чинь бясалгуулдаг, чи эрүүл саруул бодолтой байж дээшлэх ёстой. Бидэнд бас гүн амгаланд орж хийх дасгал байдаг, бидний энэ гүн амгаланд орох дасгалыг яаж хийдэг вэ? Та бүгд ямар ч гүн амгаланд орсон бай, өөрийгөө энд бясалгаж байгаагаа мэдэж байхыг бид шаардана, чамайг гүн ховсдолын байдалд орж юугаа ч мэдэхгүй байдалд орохыг туйлаас зөвшөөрөхгүй. Тэгвэл ямар тодорхой байдал гарах вэ? Тэнд сууж байхад чамд өндөгний хальсан бүрхүүл дотор сууж байгаа мэт тааламжтай сайхан, бас тухтай мэдрэмж төрнө, чи дасгал хийж байгаагаа мэдэж байгаа ч бие чинь хөдөлж чадахгүй болсон мэт мэдрэмж төрдөг. Ийм байдал манай бясалгалд заавал гардаг. Бас өөр нэг байдал байдаг, энэ нь хэсэг хугацаанд суусны дараа хөл нь байхгүй болсон мэт болдог, хаана байгаа нь мэдэгдэхгүй, бие нь бас алга болно, гар нь байхгүй болно, зөвхөн толгой л үлдсэн мэт санагдана. Үргэлжлүүлэн бясалгахад толгой ч бас алга болсон мэт болно, өөрөө энд бясалгаж байгаа гэсэн өчүүхэн бодол л үлддэг. Бид ийм байдалд хүрвэл хангалттай. Яагаад вэ? Хүн ийм байдалд бясалгахад биед нь хувиралт бүрэн хэмжээгээр явагддаг, энэ бол хамгийн сайн төлөв байдал юм. Тиймээс бид чамайг бясалган суухдаа ийм гүн амгалан байдалд орохыг шаардана. Гэхдээ чи унтаж юм уу ухаанаа алдаж болохгүй, тэгвэл магадгүй сайн зүйлээ өөр хэн нэгэнд бясалгуулчихна.

Манай бүх бясалгагчид энгийн хүмүүсийн дунд хэзээ ч хэвийн бус байдал гаргаж болохгүй гэдгийг заавал анхаарах хэрэгтэй. Чи энгийн хүмүүст муу үлгэр дуурайлал үзүүлбэл тэд “Фалунь Дафа-г сурч байгаа хүн яагаад ийм болдог байна аа?” гэж ярина, энэ нь Фалунь Дафа-гийн нэр хүндийг унагаж байгаатай

адил, тэгэхээр энэ асуудал дээр анхааралтай байх хэрэгтэй. Бясалгалын явцад болон бусад тал дээр баярлах сэтгэлд автахгүй байхыг анхаар, ийм сэтгэлийг буг чөтгөр амархан ашигладаг.

## **Үг яриагаа бясалгах**

Урьд өмнө шашинд бас үг яриагаа бясалгахыг ярьдаг байсан. Гэхдээ шашинд яригддаг байсан үг яриагаа бясалгах гэдэг нь гол төлөв зарим мэргэжлийн бясалгагчид болох лам хуврагууд болон Бумбын бясалгагчид амаа жимхийгээд юм ярьдаггүй байсныг хэлдэг. Учир нь тэд мэргэшсэн бясалгагчид, дээд хэмжээгээр хүний зууралдсан сэтгэлээс салах зорилготой юм, хүний бодол гарахад л үйлийн үр бий болно гэж үздэг. Шашинд үйлийн үрийг сайн ба муу үйлийн үр гэж хуваадаг, сайн үйлийн үр байна уу муу үйлийн үр байна уу ялгаагүй Буддын системийн хоосон чанараар болон Бумбын системийн үл оршихуйн дагуу алийг нь ч үүсгэх ёсгүй, тиймээс тэд ямар ч зүйл хийхгүй гэдэг. Тэд хэрэг явдлын шалтгаан ба үйлийн үрийн харилцааг харж чадахгүй, өөрөөр хэлбэл тэдгээр зүйлсийг сайн эсвэл муу болохыг, ямар үйлийн үрийн холбоотой болохыг мэдэхгүй. Дээд түвшинд хүрээгүй энгийн бясалгагчид тэдгээр зүйлсийг харж чадахгүй учраас гаднаас нь харахад сайн мэт боловч хийвэл муу зүйл болж магадгүй гэхээс айдаг. Иймээс тэд аль болох үйлгүй (вүвэй) байхыг чухалчилдаг, дахин үйлийн үр үүсгэхээс зайлахын тулд юу ч хийдэггүй. Учир нь үйлийн үр үүсвэл түүнийг арилгах ёстой, тэгэхийн тулд зовлон амсах болно. Жишээлбэл манай бясалгагчдын хувьд ямар үе шатандаа гон нь нээгдэхийг урьдчилан тогтоосон байдаг, чи тэр дунд ямар нэгэн зүйлийг хамаагүй оруулбал энэ нь бүх бясалгалын явцад

хүндэрэл учруулна, иймээс тэд үйлгүй (вүвэй) байхыг чухалчилдаг.

Буддын системд үг яриагаа бясалгах гэдэг нь, тухайлбал хүн яриагаа өөрийн бодлоор удирддаг, тэгвэл энэ бодол санаа нь үйлтэй гэсэн үг. Хүний бодол нэг гарахад, ямар нэгэн юм ярина, ямар нэгэн зүйл хийнэ, бодол нь мэдрэхүйн эрхтэн болон дөрвөн мөчөө удирдаж хийлгэдэг, тэр нь энгийн хүний зууралдсан сэтгэл болж магадгүй юм. Жишээ нь хүн хүний хооронд зөрчил байдаг, “чи сайн, харин тэр муу”, “чи сайн бясалгасан, тэр муу бясалгасан” гэх мэт, эдгээр нь угаасаа зөрчил юм. Бид энгийн жишээ авъя, “Би ингэмээр байна, тэгмээр байна” эсвэл “одоо энэ зүйлийг ингэж, тэгж хийх хэрэгтэй” гэх мэт нь хэн нэгнийг санаандгүй гомдоож мэднэ. Яагаад гэвэл хүн хүний хоорондын зөрчил их нарийн төвөгтэй, магадгүй санаандгүйгээр үйлийн үр үүсгэнэ. Иймээс тэр амаа хамхиад юу ч ярьдаггүй. Урьд өмнө шашинд үг яриагаа бясалгахыг маш чухалд авч үздэг байсан, энэ бол шашинд заадаг байсан зүйл.

Манай Фалунь Дафа-гийн ихэнх бясаллагчид (мэргэжлийн бясаллагчдаас бусад нь) энгийн хүмүүсийн дунд бясалгадаг, тиймээс энгийн хүний нийгэмд хэвийн амьдралаар амьдрах, олон түмэнтэй харьцах нь зайлшгүй юм. Хүн болгон ажил төрөлтэй, мөн ажлаа сайн хийх хэрэгтэй; зарим хүн ярьж хийдэг ажилтай, тэгвэл энэ нь харшлах уу? Харшлахгүй. Яагаад харшлахгүй вэ? Бидний авч үзэж байгаа үг яриагаа бясалгах нь шашны үзлээс тэс өөр юм. Учир нь бясалгах аргын ялгаанаас шалтгаалж тавигдах шаардлага нь бас өөр өөр байдаг. Бид бүгдээрээ бясаллагч хүний шиньшин-ий дагуу ярих хэрэгтэй,

хов жив ярихгүй, зохисгүй болон муу юм ярихгүй. Бясалгагч хүний хувьд бид Фа шалгуурын дагуу өөрийгөө цэгнэж тухайн зүйлийг ярих, ярихгүйгээ хянаж байх хэрэгтэй. Хэлж байгаа үгээ Фа дагуу цэгнэж, бясалгагч хүний шиньшин-ий жишигт нийцэж байвал асуудалгүй, бид Фа-г ярьж олны хүртээл болгох ёстой, иймээс юм ярихгүй байх аргагүй. Бид үг яриагаа бясалгах тухайд ярьдаг зүйлд энгийн хүний салж чадаагүй алдар нэр, ашиг хонжоо орно, тухайн нийгэмд бясалгагч хүний эрхэлж буй ажил үйлст ямар ч ач холбогдолгүй яриа; эсвэл нэг бясалгалын шавь нар хоорондын хэрэгцээгүй яриа; эсвэл зууралдсан сэтгэлээс болж өөрийгөө гайхуулах; эсвэл дам үг болон цуу яриа тараах; эсвэл нийгмийн ямар нэгэн үйл явдалд автан сэтгэл хөөрч ярих зэрэг орно, миний эдгээр дурдсан бол бүгд энгийн хүний зууралдсан сэтгэл юм. Эдгээр тал дээр бид яриагаа бясалгах хэрэгтэй гэж би бодож байна, энэ бол бидний ярьж байгаа үг яриагаа бясалгах юм. Хүний бодол гарахад үйлийн үр үүсдэг гэж үздэг учраас урьдын лам хуврагууд эдгээр зүйлст их нухацтай ханддаг байсан. Тиймээс тэд “Бие, Үг яриа, Бодол” гэж ярьдаг байсан. Тэдний ярьдаг Биеэ бясалгах гэдэг нь муу үйл хийхгүй байх; үг яриагаа бясалгах гэдэг нь юм ярихгүй байх. Бодлоо бясалгах гэдэг нь юу ч бодохгүй байх юм. Урьд өмнө сүм хийдийн мэргэжлийн бясалгагчдад энэ тал дээр хатуу шаардлага тавьдаг байсан. Бид өөрсдийгөө бясалгагч хүний шиньшин-ий шалгуурын дагуу шаардаж юуг ярьж болох юуг ярьж болохгүйгээ мэдэж байхад л болно.



# Есдүгээр лекц

## Чийгон ба биеийн тамир

Энгийн түвшинд хүмүүс чийгон-ыг биеийн тамирын дасгалтай шууд холбоотой гэж үздэг. Мэдээж доод түвшинд чийгон ба биеийн тамирын дасгал нь эрүүл биетэй байхын тухайд адилхан байдаг. Гэхдээ үүний дасгалын тусгай арга болон ашигладаг арга барил нь биеийн тамирын дасгалаас эрс ялгаатай. Биеийн тамираар хичээллээд эрүүл биетэй болохын тулд дасгалын хэмжээг нэмэгдүүлэх, биеийн тамирын дасгал, бэлтгэл сургуулилтаа улам эрчимжүүлэх ёстой байдаг; харин чийгон бялгалын хувьд бол яг эсрэгээр, хөдөлгөөн шаарддаггүй, хөдөлгөөн хийсэн ч энэ нь зөөлөн, удаан бас дугуйрсан хэлбэртэй байдаг, тэр ч байтугай огт хөдөлгөөнгүй байдалд хийдэг. Энэ нь биеийн тамирын дасгалаас хэлбэрийн хувьд маш их ялгаатай. Дээд түвшнээс авч үзэхэд чийгон бол зөвхөн өвчин эдгээх бие эрүүлжүүлэхээр хязгаарлагдахгүй, бас дээд түвшний зүйлсийг багтаадаг ба гүн агуулгатай байдаг. Чийгон бол энгийн хүний түвшин дэх тэр өнгөцхөн зүйлс биш. Тэр бол ер бусын бөгөөд өөр өөр түвшинд өөр өөрөөр илэрдэг, энэ нь энгийн хүнийхээс маш хол давсан зүйл юм.

Дасгалын мөн чанарыг авч үзэхэд тэдгээр нь бас их ялгаатай. Тамирчид, ялангуяа одоогийн тамирчид орчин үеийн спортын тэмцээний түвшинд биеэ бэлтгэх мөн тэр шаардлагад нийцэхийн тулд дасгал сургуулилтаа нэмэгдүүлэх шаардлагатай болдог, тиймээс бие махбодоо үргэлж дээд хэмжээнд байлгах ёстой. Энэ зорилгодоо хүрэхийн тулд дасгал сургуулиалтын ачааллыг нэмэгдүүлж биеийн цусны

эргэлтийг сайжруулах, улмаар бодисын солилцоог хурдасгаж бие организмээ үргэлж дээд хэмжээнд байлгах хэрэгтэй. Яагаад бодисын солилцоог сайжруулах хэрэгтэй вэ? Учир нь тамирчин биеэ үргэлж хөгжүүлж тэмцээнд орох хамгийн дээд хэмжээнд байх хэрэгтэй. Хүний бие тоологдошгүй олон эсээс бүтдэг, тэдгээр нь бүгд ийм нэг явцтай байдаг: Дөнгөж хуваагдсан эсийн амьдрах чадвар маш эрчимтэй, дээш хөгжих идэвхтэй байдалд байдаг. Туйлдаа хүрэхэд эс нь цааш өсөхгүй болж зөвхөн доош уруудаж эхэлнэ, хамгийн доод хэмжээнд хүртлээ унахад шинэ эс түүнийг орлоно. Үүнийг өдрийн 12 цагаар жишээ болгон тайлбарлавал, өглөөний 6:00 цагт эс хуваагдана гэж үзье, тэгээд өсөлтийн үедээ ордог, 8:00, 9:00 мөн 10:00 цаг бол бүгд маш сайн үе нь юм. Үд дунд болоход дахин дээшээ ахиж чадахгүй болно, зөвхөн доош уруудаж эхэлнэ. Энэ үед эсийн амьдрах хугацааны тал нь үлдсэн байдаг, гэхдээ энэ үлдсэн тал үе нь тэмцээнд орох тамирчны шаардлагад нийцэхгүй болно.

Тэгвэл яах хэрэгтэй вэ? Тэр хүн бэлтгэл сургуулилтаа нэмэгдүүлж цусны эргэлтээ сайжруулах хэрэгтэй, шинэ хуваагдсан эсүүд нь хуучин эсүүдийг орлоно, тэр ийм замаар явдаг. Өөрөөр хэлбэл эсийн амьдрах бүх явц нь дуусаагүй байхад дөнгөж тал амьдрах хугацаа өнгөрөнгүүт солигддог, иймээс бие нь үргэлж хүчтэй ахицтай байдаг. Гэхдээ хүний эс ингэж хязгааргүй хуваагдаж чадахгүй, эсийн хуваагдал нь хязгаартай. Жишээлбэл хүний нэг насанд эс нь зуун удаа л хуваагдана гэж үзье, үнэндээ нэг саяас ч олон удаа хуваагддаг. Энгийн хүний эс нь зуун удаа хуваагдахад тэр хүн зуу насална гэж бодъё, гэтэл одоо энэ эс зөвхөн тал хугацаандаа л амьдарсан, тэгэхээр тэр хүн зөвхөн

тавь насалж чадна. Гэхдээ бид тамирчдад ийм ноцтой байдал гарахыг хараагүй, яагаад гэвэл өнөөгийн тамирчид гучин нас хүрэхээс өмнө тэмцээнээс гардаг. Ялангуяа одоогийн тэмцээний шаардлага их өндөр, шигшигдэж хасагдсан тамирчдын тоо бас их байдаг, тэгээд тамирчин хүн хэвийн амьдралдаа буцаж орно, тийм их өөрчлөлт гарсан харагдахгүй. Онолын хувьд үүний мөн чанар нь ийм байдаг, биеийн тамирын дасгал хүнд биеэ эрүүл чийрэг байлгах боломж өгдөг ч нөгөө талаар хүний насыг богиносгодог. Гаднаас нь харахад арван хэдэн настай тамирчин хорин хэдэн настай хүн шиг, хорин хэдэн настай тамирчин гучин хэдтэй юм шиг харагддаг. Тамирчин хүн ихэвчлэн наснаасаа илүү овортой харагддаг. Хэрэв юманд давуу тал байдаг бол бас сул тал ч байдаг, диалектикийн үүднээс харахад үнэндээ ийм л замаар явдаг.

Чийгон бясалгал бол биеийн тамирын дасгал сургуулиалтын яг эсрэг юм, эрчимтэй хөдөлгөөн шаарддаггүй. Хөдөлгөөн хийсэн ч тэр нь зөөлөн, удаан мөн дутуйрсан хэлбэртэй, их зөөлөн аажмаар хийдэг, тэр ч байтугай хөдлөхгүй буюу бүрэн хөдөлгөөнгүй байдалд ордог. Гүн ховсдолд орж бясалгах аргад хөдөлгөөнгүй байдалд суух шаардлагатайг та бүгд мэднэ. Зүрхний цохилт удааширдаг, цусны эргэлт болон бүх зүйлс удааширдаг. Энэтхэгт усан дотор юм уу эсвэл шороонд булуулж хэдэн өдрөөр сууж чаддаг иогийн олон мастерууд байдаг. Тэд өөрсдийгөө бүрэн хөдөлгөөнгүй болгодог, түүнчлэн зүрхний цохилтоо хүртэл удирдаж чаддаг. Хүний эс өдөрт нэг удаа хуваагддаг гэж бодъё. Тэгвэл бясалгадаг хүн эсээ хоёр өдөрт нэг удаа, долоо хоногт нэг удаа, хагас сард нэг удаа эсвэл түүнээс ч урт хугацаанд нэг удаа хуваагддаг болгож чадна, тэгвэл тэр аль хэдийн өөрийнхөө насыг



уртасгасан болно. Энэ бол зөвхөн сэтгэлээ бясалгадаг, амь биеэ бясалгадаггүй аргын хувьд ийм хэмжээнд хүрч чадна, бас өөрийнхөө насыг уртасгаж болно. Зарим хүн ингэж бодож магад: “хүний амьдрал ба амьдрах нас нь урьдаас тогтоогдсон байдаг биш гэж үү? Хүн амь биеэ бясалгахгүйгээр яаж удаан насалж чадах юм?” Тийм, гэхдээ бясалгагч хүний түвшин Гурамсан ертөнцийг давах юм бол түүний нас уртсаж болно, гэхдээ тэр маш их хөгшин харагдана.

Жинхэнэ амь биеийн бясалгалд цуглуулсан дээд энергийн бие бодь нь биеийн эсүүдэд тасралтгүйгээр хуримтлагддаг, түүний нягтрал нь тасралтгүй нэмэгдэнэ, яваандаа энгийн хүний эсийг хязгаарлана, мөн аажмаар энгийн хүний эсийг орлоно. Тэр үед чанарын өөрчлөлт гарна, энэ хүн үүрд залуугаараа үлдэнэ. Мэдээж бясалгалын явц бол маш удаан бөгөөд аажим, мөн хүнээс өөрийгөө маш ихээр зориулахыг шаарддаг. Бие сэтгэлийн зовлонг тэсвэрлэн туулахад амаргүй. Хүн хүний хоорондох шиньшин-ий зөрчилд сэтгэлээ хөдөлгөхгүй байж чадах уу? Хувийн ашиг сонирхолд татагдахгүй байж чадах уу? Үүнийг хийхэд тун хэцүү, ийм зорилгод хүрье гээд л хүрчихдэг зүйл биш. Бясалгалаар хүний шиньшин болон Дэ дээшилсэн цагт л энэ зорилгодоо хүрч чадна.

Олон хүн чийгон-ыг жирийн биеийн тамирын дасгалтай адилхан үздэг, үнэндээ энэ нь маш том ялгаатай, огт ижил зүйл биш байдаг. Гагцхүү өвчнөө арилгах биеэ сайжруулах, эрүүл биетэй байхын тулд хамгийн доод түвшинд чий-гээр хичээллэхэд энэ доод түвшний зорилго нь биеийн тамирын дасгалтай төстэй байдаг. Харин дээд түвшинд огт адилгүй. Чийгон-д биеийг арнуулах нь бас зорилготой, мөн бясалгагчийг

ер бусын зарчмын дагуу шаарддаг, энгийн хүний зарчмаар шаардаж болохгүй. Харин биенийн тамирын дасгал бол зөвхөн энгийн хүний л зүйл юм.

## Бодол

Бодол гэдэг нь хүний сэтгэхүйн үйл ажиллагаа юм. Бясалгагчдын хүрээнд хүний бодлыг тархины үйл ажиллагаатай холбон хэрхэн авч үздэг вэ? Хүний сэтгэхүй (бодол)-н янз бүрийн хэлбэрийг яаж авч үздэг вэ? Мөн эдгээр хэлбэрүүд нь яаж илэрдэг вэ? Орчин үеийн анагаах ухаан хүний тархийг судлаад их олон асуултад хариулж чадахгүй хэвээр байна, яагаад гэвэл энэ нь бидний биенийн гадаргууг судалдаг шиг амар зүйл биш. Гүн түвшинд, өөр өөр орон зайд бүгд янз бүрийн хэлбэртэй байдаг. Гэхдээ энэ нь бас зарим чийгон багш нарын ярьсангай адилгүй. Зарим чийгон багш нар өөрсдөө ч ямар учиртайг нь мэдэхгүй, үүнийг тодорхой ч тайлбарлаж чадахгүй. Тэр тархины нөлөөгөөр үүссэн бодол ямар нэгэн зүйл хийж чаддаг гэж үздэг, түүний санаагаар эсвэл түүний бодлын нөлөөгөөр хийгддэг гэдэг. Үнэн хэрэгтээ тэр ер бодлоороо хийсэн юм биш.

Бид эхлээд хүний бодол хаанаас үүсдэг талаар ярья, эртний Хятадад “сэтгэл зүрхний бодол” гэсэн үг байдаг. Яагаад сэтгэл зүрхний бодол гэдэг вэ? Хятадын эртний шинжлэх ухаан маш өндөр хөгжилтэй байсан, учир нь хүний бие, амь болон орчлон ертөнц гэх мэт эдгээр зүйл рүү шууд чиглэн судалдаг байсан. Зарим хүн үнэхээр тэдний сэтгэл зүрх нь юм бодож байх шиг мэдэрдэг, харин заримд нь тэдний тархи нь юм бодож байгаа мэт мэдрэгддэг. Яагаад ийм байдал гардаг вэ? Түүний хэлдэг сэтгэл зүрхний бодол гэдэг нь бас үндэслэлгүй зүйл биш юм, яагаад гэвэл бидэнд жирийн

хүний Эзэн сүнс нь маш жижигхэн байгаа нь харагддаг, хүний тархинаас гардаг бодит мэдээлэл нь тархины өөрийн үйл ажиллагаанаас үүсдэггүй, тэдгээрийг тархи гаргадаггүй, харин Эзэн сүнс гаргадаг. Хүний Эзэн сүнс зөвхөн ниван ордонд оршдоггүй. Бумбын система ярьдаг ниван ордон бол бидний орчин үеийн анагаах ухаанд илрүүлсэн тархины булцуут булчирхай юм. Хэрэв Эзэн сүнс ниван ордонд байрлаж байвал хүн үнэхээр тархи юм бодож байна, мэдээлэл гаргаж байна гэж мэдэрнэ, хэрэв энэ нь зүрхэнд байвал, хүн үнэхээр зүрх нь юм бодож байна гэж мэдэрнэ.

Хүний бие бол нэг жижиг орчлон ертөнц юм, бясалгагч хүний биед маш олон амь бодь байршлаа сольж байж болно. Хэрэв Эзэн сүнс байраа сольж гэдсэнд очвол, үнэхээр гэдэс юм бодож байгаа мэт санагдана; хэрэв Эзэн сүнс хөлийн булчинд эсвэл өсгийд очвол, хөлийн булчин эсвэл өсгий юм бодож байх шиг санагдана, ийм байх нь баталгаатай, сонсоход их учир битүүлэг байдаг. Чиний бясалгалын түвшин тийм өндөр биш байхад ч ийм байдлыг мэдэрч болно. Хүний биед сүнс, зан чанар, зан төлөв болон хувийн мөн чанар гэх зүйлс байхгүй бол энэ нь зүгээр л нэг хэсэг мах юм, өөрийн гэсэн өвөрмөц шинжтэй бүхэл бүтэн хүн болж чадахгүй. Тэгвэл хүний тархи ямар үүрэг гүйцэтгэдэг вэ? Миний харж байгаагаар хүний тархи бол энэ материалаг орон зайд зөвхөн боловсруулалт хийдэг үйлдвэр юм. Жинхэнэ мэдээлэл нь Эзэн сүнснээс гардаг, гэхдээ тэр гардаг нь үг хэл биш, харин тодорхой утга санааг илэрхийлсэн орчлон ертөнцийн мэдээлэл байдаг. Бидний тархи ийм тушаал, мэдээллийг хүлээж авсны дараа түүнийг бидний энэ үг яриа, ийм илэрхийлэх хэлбэр болгон боловсруулдаг. Бид үүнийг дохио зангаа, нүдний харцаар болон бүхэл

бүтэн хөдөлгөөнөөр илэрхийлдэг, тархи зөвхөн ийм л үүрэг гүйцэтгэдэг. Жинхэнэ тушаал, жинхэнэ бодол нь хүний Эзэн сүнснээс гардаг. Хүмүүс үүнийг үргэлж тархины шууд бөгөөд бие даасан үйл ажиллагаа гэж ойлгодог, үнэн хэрэгтээ Эзэн сүнс заримдаа зүрхэнд байхад хүн үнэхээр зүрх нь юм бодож байна гэж мэдэрдэг.

Одоо хүний бие шинжлэн судлаачид хүний тархи цахилгаан долгион хэлбэрийн зүйл цацруулдаг гэж үздэг, энэ нь яг юу цацруулдаг талаар бид ярихгүй, гэхдээ тэд үүнийг материалаг оршихуйтай болохыг хүлээн зөвшөөрсөн, тиймээс энэ бол мухар сүсэг биш юм. Энэ цацруулсан зүйл нь ямар нөлөөтэй байдаг вэ? Зарим чийгон багш, “Би бодлоороо юм зөөж, бодлоороо чиний тэнгэрийн мэлмийг нээж, бодлоороо өвчнийг чинь эдгээж чадна” гэх мэтийн зүйл ярьдаг. Үнэндээ зарим чийгон багш өөрсдийгөө ямар ер бусын чадвартайгаа мэддэггүй, бас ойлгодоггүй. Тэд юу хийхийг хүснэ, түүнийгээ нэг бодоход л хийж чаддаг гэж ойлгодог. Үнэндээ бол түүний бодол идэвхтэй ажиллаж байдаг, ер бусын чадвар нь бодлоор нь удирдагддаг, бодлын удирдлага дор тодорхой зүйлийг хийдэг, харин бодол өөрөө юу ч хийж чадахгүй. Бясалгагч хүн ямар нэг зүйлийг тодорхой байдлаар хийх үед түүний ер бусын чадвар нь үүрэг гүйцэтгэдэг.

Ер бусын чадвар бол хүний биеийн далдын чадвар юм. Бидний хүний нийгэм хөгжихийн хэрээр хүний тархины бодол улам бүр нарийн төвөгтэй болж ирсэн, бодит байдалд анхаарлаа улам хандуулах болж, орчин үеийн гэгдэх багаж хэрэгсэлд улам найдах болсон, үүний улмаас хүний төрөлхийн чадварууд нь улам бүр

байхгүй болсон. Бумбын системд үүссэн эх үндсэндээ буцаж үнэнд хүрэхийг заадаг, бясалгалын явцад чи үнэнд тэмүүлэх ёстой, эцэст нь үүссэн эх үндсэндээ буцаж үнэнд хүрнэ, төрөлх мөн чанартаа буцна, ингэснээр л чи өөрийнхөө эдгээр төрөлх чадварыг илрүүлж болно. Одоо бид үүнийг ер бусын чадвар гэж нэрлэдэг, үнэндээ эдгээр нь бүгд хүний төрөлх чадвар юм. Хүний нийгэм дэвшингүй болж байгаа мэт харагдавч үнэн хэрэгтээ уруудаж байна, бидний орчлон ертөнцийн мөн чанараас улам холдож байна. Урьд нь би Жан Гуолао хойшоо харж илжгээ унадаг байсан тухай ярьсан, хүмүүс үүнийг ямар учиртайг нь магадгүй ойлгоогүй байх. Тэрээр урагшлах нь ухрах гэсэн үг, хүн орчлон ертөнцийн мөн чанараас улам бүр холдсоор байгааг олж мэдсэн. Орчлон ертөнцийн хувьслын явцад, ялангуяа одоогийн зах зээлийн эдийн засгийн том давалгаанд орсноос хойш маш олон хүний ёс суртахуун их эвдэрсэн, тэд орчлон ертөнцийн мөн чанар болох Жэнь, Шань, Рэнь-ээс улам бүр холдсоор байна. Энгийн хүмүүсийн тэр урсгалаар яваа хүмүүс хүн төрөлхтний ёс суртахуун ямар хэмжээнд хүртэл доройтсоныг мэдрэхгүй, зарим хүн бүх зүйлс сайн байна гэж боддог, зөвхөн бясалгалаар шиньшин нь дээшилсэн хүн эргэж харахад хүн төрөлхтний ёс суртахуун ийм аймшигтай түвшинд хүртлээ доройтсоныг ойлгох болно.

Зарим чийгон багш, “би чиний ер бусын чадварыг нээж өгье” гэж ярьдаг. Тэр чамд ямар ер бусын чадварыг нээж өгөх гэж? Энергигүй бол чиний ер бусын чадвар ажиллахгүй, үүнгүйгээр тэр яаж нээж өгч чадах юм? Хүний ер бусын чадвар өөрийнх нь энергиэр адислагдаж гараагүй байхад тэр үүнийг нээж өгч чадна гэж үү? Огт боломжгүй. Тэдний ярьж байгаа

ер бусын чадварыг нээж өгөх гэдэг нь зөвхөн аль хэдийн чамд үүссэн ер бусын чадварыг чиний бодлоор удирдуулахын тулд тархигтай чинь холбож өгдөг, үүнийг тэд ер бусын чадвар нээж өгсөнд тооцдог, үнэндээ тэд ямар ч ер бусын чадвар чамд нээж өгөөгүй, зөвхөн ийм л нэг багахан зүйл хийсэн.

Бясалгагч хүний хувьд бодлоороо өөрийн ер бусын чадварыг удирдаж ямар нэгэн үйл хийдэг; харин энгийн хүний хувьд бодол нь дөрвөн мөч, мэдрэхүйгээ удирдан үйл хийдэг, энэ нь яг үйлдвэрийн контортой адил юм, захирлын албан тасалгаанаас үүрэг даалгавар өгч бодит ажлыг цех тасгууд хийж биелүүлэхтэй адил. Мөн цэргийн удирдлагын төв шиг, командын штаб тушаал өгч бүх армийг захиран үүрэг гүйцэтгэхтэй адил. Би өөр газруудаар явж лекц уншиж байхдаа орон нутгийн чийгон судлалын нийгэмлэгийн удирдагчидтай энэ асуудлаар байнга ярьдаг байсан. Тэд бүгд их гайхширдаг байсан: “Бид хүний оюун ухаанд ямар их боломжит энерги, далд чадвар байгааг судалсаар ирсэн” гэдэг. Үнэн хэрэгтээ энэ нь тийм биш, тэд эхнээсээ л замаасаа хазайсан юм. Хүний биеийн шинжлэх ухааныг судалъя гэвэл хүн бодол сэтгэхүйдээ хувьсал хийх хэрэгтэй, энгийн хүний таамаглах аргаар, эсвэл асуудлыг танин мэдэх аргаар ер бусын зүйлсийг ойлгож болохгүй.

Бодлын тухайд бас өөр хэдэн хэлбэр байдаг. Жишээлбэл зарим хүн далд ухамсар, дотоод ухамсар, онгод, зүүд гэх мэтийг ярьдаг. Зүүдний талаар ярихад үүнийг аль ч чийгон багш тайлбарлахыг хүсдэггүй. Яагаад гэвэл чи төрөхдөө орчлон ертөнцийн маш олон орон зайнуудад бас нэгэн зэрэг төрдөг, чи болон чиний бусдууд бүгдээрээ хамтдаа нэгдмэл нэг бүхэл

бөгөөд бүгд хоорондоо уялдаа холбоотой байдаг, оюун бодлоороо ч хоорондоо холбоотой. Түүнээс гадна, чамд өөрт чинь Эзэн сүнс, Дэд сүнс байдаг, мөн бусад олон төрлийн амь бодидын янз бүрийн дүрс хэлбэрүүд чиний биед оршдог, түүнчлэн эс болгонд болон бүх дотоод эрхтнүүдэд бусад орон зайд орших чиний дүр төрх, мэдээллийн хэлбэрүүд агуулагддаг, тиймээс маш нарийн төвөгтэй. Зүүдэнд магадгүй зарим зүйл нэг хоромд ийм янзтай байснаа дараагийн хоромд өөр байдалтай болдог, ер нь тэдгээр нь хаанаас ирдэг вэ? Анагаах ухаанд үүнийг хүний тархины бор давхаргад өөрчлөлт гарснаас болдог гэж үздэг. Энэ бол бодит хэлбэрээр илэрдэг харин үйлдэл боловч өөр орон зайнаас мэдээлэл хүлээж авсны дүнд гардаг. Тиймээс чи зүүд зүүдлэхдээ самуурсан ухаантай юм шиг байдаг, энэ бүгд чамтай ямар ч хамаа байхгүй, чи үүнд анхаарлаа хандуулах хэрэггүй. Чамтай шууд хамааралтай зүүдний нэг хэлбэр байдаг, бид ийм зүүдийг “зүүд” гэж хэлж болохгүй. Чиний Эзэн бодол, өөрөөр хэлбэл Эзэн сүнс зүүдэндээ магадгүй чиний гэр бүлийн хэн нэгэн чам дээр ирсэн гэж зүүдэлсэн; эсвэл үнэхээр ямар нэгэн зүйлийг мэдэрсэн, ямар нэгэн зүйлийг харсан эсвэл хийсэн гэж зүүдэлж болно. Тэгвэл энэ нь чиний Эзэн сүнс үнэхээр өөр орон зайд ямар нэгэн зүйл хийсэн, ямар нэгэн зүйл харсан бас үйлдсэн, бодол нь тов тодорхой бас бодитой байдаг, ийм зүйлс үнэхээр оршдог, гэхдээ энэ нь өөр материаллаг орон зайд болдог, өөр цаг хугацааны орон зайд хийгддэг. Чи үүнийг зүүд гэж хэлж болох уу? Болохгүй. Чиний бодит бие энд үнэхээр унтаж байгаа болохоор үүнийг зүүд гэж л хэлэхээс, зөвхөн ийм зүүд л чамтай шууд хамаатай байдаг.

Хүний онгод, далд ухамсар, дотоод ухамсар гэх мэт нэрсийг эрдэмтэд сэдсэн юм биш, харин зохиолчид энгийн хүний заншил дээр тулгуурлан өгсөн нэр үг юм, шинжлэх ухааны мөн чанаргүй гэж би хэлнэ. Хүмүүсийн ярьдаг далд ухамсар гэж чухам юу вэ? Үүнийг тодорхой ярихад хэцүү, бүрхэг. Учир нь хүний янз бүрийн мэдээлэл нь маш нарийн төвөгтэй, бүдэг бадаг жаахан ой санамж байгаатай адил байдаг. Хүмүүсийн ярьдаг дотоод ухамсрын талаар тайлбарлахад амархан. Дотоод ухамсар гэдгийг тайлбарлахад ер нь хүн ямар нэгэн зүйлийг өөрийн мэдэлгүйгээр хийхийг хэлдэг, хүмүүс үүнийг дандаа санаандгүйгээр хийсэн, зориндаар хийгээгүй гэж ярьдаг. Энэ дотоод ухамсар гэдэг нь бидний ярьсан Дэд бодолтой адил. Хүний Эзэн бодол (Жу-иши) суларсан үед буюу тархийг удирдаагүй байхад хүн унтаа мэт өөрийн ухаангүй байдаг, зүүдэндээ эсвэл өөрийн ухаангүй байдалд байхдаа Дэд бодлоор (Фу-иши) өөрөөр хэлбэл Дэд сүнс (Фу Юань-шэнь)-д амархан эзэмдүүлдэг. Энэ үед Дэд бодол зарим зүйлийг хийж чадааг, өөрөөр хэлбэл чи санаандгүй байдалд хийсэн гэсэн үг. Гэхдээ эдгээр хийгдсэн зүйлүүд нь ихэвчлэн муу болдоггүй, яагаад гэвэл Дэд сүнс өөр орон зайнаас асуудлын мөн чанарыг хардаг, манай энгийн хүний нийгэмд төөрдөггүй. Дараа нь тэр хийсэн зүйлээ эргэж хараад, “Би үүнийг ямар муу хийгээ вэ? Би өөрийн ухаантай байсан бол ингэж хийхгүй байсан” гэнэ. Гэхдээ одоо чи үүнийг муу хийсэн гэж хэлж байвч, арав хоногийн дараа эсвэл хагас сарын дараа эргэж харвал “Хөөх, үүнийг ямар сайн хийгээ вэ! Би тэр үед яаж ингэж хийж чадав аа?” гэдэг. Ер нь ийм асуудал гардаг. Учир нь Дэд бодол тухайн үед ямар үр дүн үзүүлэхийг чухалчилдаггүй, гэхдээ ирээдүйд энэ нь сайн үр дүн



харуулна. Гэхдээ зарим зүйлүүд нь ирээдүйд ямар ч ач холбогдолгүй зөвхөн тэр үедээ л нөлөө үзүүлдэг. Дэд бодол эдгээр зүйлийг хийвэл магадгүй тэр дор нь маш сайн хийнэ.

Бас өөр нэг хэлбэр байдаг, энэ нь зарим маш сайн төрөлхийн суурьтай хүн дээд амь боднор амархан удирдагдаж зарим зүйлийг хийдэг. Мэдээж энэ бол өөр асуудал, энд ярихгүй, бид хүний өөрөөс нь гардаг бодлын талаар голчлон ярилцана.

Онгодын хувьд гэвэл энэ нь бас бичгийн хүмүүсийн гаргасан хэллэг. Ихэнх хүмүүс онгод гэдгийг хүн амьдралынхаа туршид хуримтлуулсан мэдлэг боловсрол нь хоромхон зуур гарахыг хэлдэг. Материализмын үүднээс харвал хүн амьдралдаа хэчнээн их мэдлэг хуримтлуулна, тархи ухаанаа хэр сайн ашиглана, тэр хэмжээгээр улам хурц ухаантай болдог гэж би хэлмээр байна. Хүн тархи ухаанаа ажиллуулж байхад өөрийн мэдлэг тасралтгүйгээр гарах ёстой, онгод орох гэсэн асуудал байх учиргүй. Аливаа онгод гэдэг нь, эсвэл онгод ороход ийм байдлаар гардаггүй. Ер нь хүн тархиа ажиллуулахдаа мэдлэг ухаанаа шавхтал хэрэглэвэл эцсийн мухардалд орсон мэт болдог, бичиг цаасаа цааш нь үргэлжлүүлж чадахгүйд хүрнэ; эсвэл нэг хөгжмийн ая зохиоход шинэ санаа орж ирэхгүй; эсвэл ямар нэгэн судалгаа шинжилгээний төсөл дээр ажиллаад үргэлжлүүлж чадахгүйд хүрдэг. Ийм үед хүн ихэнхдээ ядарна, тамхины иш шалаар нэг хөглөрнө, бухимдаад толгой нь өвдөнө бас юу ч толгойд нь орохоо болино. Эцэст нь ямар нөхцөлд онгод ордог вэ? Тэр хүн их ядраад ингэж бодно, “За больё, жаахан амраадахъя.” Учир нь Эзэн бодол тархийг хэр их эзэмдэнэ төдий чинээ өөр

амь бодь оролцож чадахгүй. Тэр завсарлага авч тархиа амраагаад энэ талаар бодохоо болиход, гэнэт түүний толгойд нь ямар нэгэн зүйл санаандгүй орж ирдэг. Ихэнхдээ онгод ингэж ирдэг.

Тэгвэл яагаад энэ үед онгод ордог вэ? Учир нь хүний тархи Эзэн бодлын нөлөөн дор байхад, хүн толгойгоо улам ажиллуулах тусам Эзэн бодол тархийг улам эзэмддэг, тиймээс Дэд бодол орж чадахгүй. Хүн толгойгоо өвдтөл юм бодож санаанд нь юу ч орж ирэхгүй тавгүй байхад, Дэд бодол энэ биеийн нэг хэсэг, нэг эхийн хэвлийгээс зэрэг төрсний хувьд энэ биеийн зарим хэсгийг удирддаг, тэр бас дагаж тавгүй болно, толгой нь өвдөнө, их өвдөнө. Эзэн бодол суларсан үед Дэд бодол өөрийнхөө мэддэг зүйлээ тархинд тусгадаг. Яагаад гэвэл тэр өөр орон зайд хэргийн мөн чанарыг харж чаддаг, тиймээс хүн үүний дагуу зохиодог, бичдэг, бүтээдэг.

Зарим хүн “Тэгвэл бид Дэд бодлыг ашиглая” гэнэ. Дөнгөж саяхан нэг хүн бичгээр: “Хэрхэн Дэд бодолтой холбогдох вэ?” гэж асуусан. Чи дөнгөж бясалгаж эхэлж байгаа, мөн чамд одоохондоо ямар ч чадвар байхгүй учраас холбогдож чадахгүй, чи холбогдохгүй байсан нь дээр, санаа зорилго чинь зууралдсан сэтгэл гэдэг нь гарцаагүй. Зарим хүн ингэж бодож магад, “Бид Дэд бодлыг хэрэглээд өөрсдийнхөө эд баялгийг өсгөж мөн хүн төрөлхтний нийгмийн хөгжлийг хурдасгаж болох юм биш үү?” Болохгүй! Яагаад вэ? Учир нь чиний Дэд бодлын мэдэж байгаа зүйл их хязгаарлагдмал. Орон зайнууд их нарийн бөгөөд маш олон түвшин оршдог тул орчлон ертөнцийн бүтэц зохион байгуулалт нь тун нарийн байдаг. Дэд бодол зөвхөн өөрийн байгаа орон зайн зүйлийг л мэднэ, түүний орон зайнаас

гарсан зүйлийг тэр мэдэхгүй. Түүнээс гадна маш олон босоо түвшний янз бүрийн орон зайнууд байдаг, хүн төрөлхтний хөгжлийг зөвхөн дээд зэргийн амь боднуд маш өндөр түвшнээс удирддаг, мөн энэ нь хөгжлийн зүй тогтлын дагуу явагддаг.

Бидний энгийн хүний нийгэм түүхийн зүй тогтлын дагуу хөгждөг, та нар үүнийг тодорхой замаар хөгжүүлж тодорхой зорилгод хүргэхийг хүсэж магадгүй, гэвч тэдгээр дээд амь боднуд ингэж боддоггүй. Дээр үеийн хүмүүс өнөөгийн нисэх онгоц, галт тэрэг болон унадаг дугуйн талаар бодож байгаагүй гэж үү? Би хэлбэл, тэд энэ талаар бодсон байж магадгүй юм. Түүх тэр шатанд хүртэл хөгжөөгүй учраас тэд бүтээж чадаагүй. Үүнийг гаднаас нь энгийн хүний онолоор юм уу одоогийн хүн төрөлхтний мэдлэгийн хүрээнээс авч үзвэл тухайн үеийн шинжлэх ухаан тэр түвшинд хүрээгүй байсан учраас тэдгээрийг бүтээж чадаагүй гэж тайлбарлана. Үнэндээ хүн төрөлхтний шинжлэх ухаан хэрхэн хөгждөг нь түүхийн зохицуулалтын хөгжлийн дагуу явагддаг, хэрэв чи тодорхой нэг зорилгодоо хүний хүслээр хүрэх гэвэл, чи хүрч чадахгүй. Мэдээж зарим хүнд Дэд бодол нь амархан нөлөөлдөг. Нэгэн зохиолч хэлэхдээ: “Би ном бичихдээ өдөрт хэдэн арван мянган үгс бичиж чадна, ердөө ч ядардаггүй, хэрэв би хүсвэл үүнийг маш хурдан бичиж чадна, хүмүүс уншиж үзээд их сайн болж гэдэг.” Яагаад тийм байдаг вэ? Энэ бол түүний Эзэн бодол, Дэд бодол хамт оролцсоны үр дүн юм, түүний Дэд бодол нь тал үүргийг гүйцэтгэсэн. Гэхдээ үргэлж ийм байхгүй, ихэнх Дэд бодол огт оролцдоггүй. Чи түүгээр юм хийлгэх бодолтой байвал энэ нь сайнаар эргэхгүй, харин ч эсрэгээр нөлөөлнө.

## Цэвэр ариун сэтгэл

Олон хүн дасгалаа хийж байхдаа амгалан байдалд орж чаддаггүй, энд тэнд чийгон багш хайж очоод ингэж асуудаг: “Багшаа, би бясалгахдаа яагаад амгаланд орж чадахгүй байна вэ, бясалгахаар суунгуул л толгойд элдвийн бодол, санаа орж гарах юм.” Энэ нь яг гол мөрнийг орвонгоор нь эргүүлсэн мэт бүх зүйл бужигнаж байхад чи амгаланд орж ердөө ч чадахгүй. Яагаад амгаланд орж чаддаггүй вэ? Зарим хүн үүнийг ойлгодоггүй, ямар нэгэн нууц арга байх ёстой гэж үздэг, тэд нэртэй Багшийг олж очоод гуйна: “Надад амгаланд оруулдаг ямар нэгэн мэргэн арга зааж өгөөч” гэнэ. Минийхээр бол энэ нь гаднаас хүсэж байна. Чи өөрийгөө дээшлүүлэх бодолтой байвал дотроосоо хайх хэрэгтэй, зүрх сэтгэлтэйгээ шаргуу ажилла. Зөвхөн тэгж чадвал чи жинхэнэ дээшилнэ, мөн бясалган суухдаа амгаланд орж чадна. Амгаланд орох чадвар бол гон юм, хэр гүн амгалан (дин)-д орж чадахаас тэр хүний түвшин харагдана.

Энгийн хүн санааныхаа зоргоор яаж амгалан байдалд орж чадах юм? Төрөлхийн маш сайн суурьтай хүн биш л бол амгаланд орж огтхон ч чадахгүй. Өөрөөр хэлбэл хүн амгалан байдалд орж чаддаггүйн үндсэн шалтгаан нь ямар нэгэн арга барилын асуудал биш, ямар нэгэн онцгой аргад байгаа юм биш, харин энэ бол чиний бодол, чиний зүрх сэтгэл цэвэр ариун биш учраас тэр юм. Чи энгийн хүний нийгэмд хүн хүний хоорондын зөрчил дунд хувийн ашиг сонирхол, хүний элдэв зууралдсан сэтгэл, хүслийнхээ төлөө бусадтай тэмцэлдэнэ, булаацалдана. Чи эдгээр зүйлээс өөрийгөө чөлөөлж чаддаггүй, үүнд хөнгөн хандаж чадахгүйгээр амгаланд орохыг хүсвэл тийм амар гэж үү? Зарим хүн чийгон-оор хичээллэхдээ, “Би үүнд

итгэхгүй байна, би элдвийн юм бодохгүйгээр амгаланд орчихно” гэдэг. Дөнгөж ингэж бодож дуустал түүний бодол нь оволзоод гарч ирнэ. Энэ нь чиний зүрх сэтгэл цэвэр ариун биш учраас амгаланд орж чадахгүй.

Зарим хүн миний үзэл бодолтой санал нийлэхгүй байж магадгүй: “Зарим чийгон багш хүмүүст ямар нэгэн арга барил хэрэглэхийг заадаг биз дээ? Бодлоо төвлөрүүлэх, төсөөлөх, анхаарлаа дань-тиань дээрээ төвлөрүүлэх, дотогшоо дань-тиань руугаа харах, эсвэл Буддын нэрийг унших гэх мэт байдаг” гэнэ. Энэ бүгд бол нэг төрлийн арга, гэхдээ зөвхөн арга барилын төдий зүйлс биш, харин хүний чадварын илрэл юм. Тэгэхээр энэ чадвар нь бидний бясалгаж байгаа шиньшин болон бидний дээшилж байгаа түвшинтэй шууд холбоотой, зөвхөн иймэрхүү арга барил хэрэглээд амгаланд орчихдог юм биш. Чи итгэхгүй байвал туршаад үз, чиний янз бүрийн хүсэл, зууралдсан сэтгэл маш хүчтэй байгаа, юуг ч орхиж чадахгүй байхад амгаланд орж чадах эсэхээ үзэж болно. Зарим хүн Буддын нэрийг уншихад үйлчилдэг гэдэг, Буддын нэрийг уншаад л чи амгаланд орж чадна гэж үү? Зарим хүн ингэж хэлдэг: “Будда Амитаба-гийн бясалгалын номоор хичээллэхэд амархан, Буддын нэрийг уншаад байхад л болно.” Чи уншаад үз дээ? Би үүнийг чадвар гэнэ. Чи үүнийг амархан гэж хэлж байна, харин би үүнийг амаргүй гэж хэлнэ, аль ч номын бясалгал амаргүй байдаг.

Та бүгд Шагжамүни “самадид орох” гэж заасныг мэднэ. Самадид орохын өмнө тэр юу заасан бэ? Тэр цээрлэх дэгийг заасан, бүх дур хүсэл, автах сэтгэлийг юу ч үлдээлгүй бүгдийг нь орхино, тэгж байж л самадид орж чадна. Ийм зарчимтай биш гэж үү? Гэхдээ самадид

орох бол бас нэгэн чадвар юм, чи шууд “цээрлэх” дэг жаягт бүрэн дүүрэн хүрч чадахгүй, чи аажмаар аливаа муу зүйлээ орхисны дараа саманд орох чадвар чинь гүехнээс гүн рүү орох болно. Хүн Буддын нэрийг нэг сэтгэлээр төвлөрөн уншина, өөр юу ч бодохгүй, тархиныхаа бусад хэсгийг мэдээ алдтал, мэдрэмжгүй болтол нь уншина, нэг бодол мянга мянган бодлыг орлол уншина, “Будда Амитаба”-гийн үсэг бүр нь нүдний өмнө харагдал уншина. Энэ нь чадвар биш гэж үү? Ийм хэмжээнд шууд хүрч чадна гэж үү? Чадахгүй. Ингэж хийж чадахгүй бол амгаланд орж чадахгүй нь мэдээж, үнэмшихгүй бол туршаад үз. Амандаа давтан уншаад л байна, гэхдээ сэтгэлдээ элдвийг бодно: “Манай ажлын газрын дарга яагаад надад дургүй байдаг юм бол? Миний энэ сарын нэмэгдэл цалин ямар ч бага гарав даа.” Энэ талаар бодох тусам уур нь улам хүрнэ, энэ хооронд амандаа Буддын нэрийг бас давтан уншсаар л байна, үүнийг чи бясалгаж байна гэж хэлэх үү? Энэ нь чадвартай холбоотой асуудал биш гэж үү? Энэ нь чиний сэтгэл цэвэр ариун бус байгаа хэрэг биш гэж үү? Зарим хүний тэнгэрийн мэлмий нээгдсэн байдаг, дотогшоо дань-тиань руугаа харж чадна. Хэвлийн доод хэсэгт хуримтлагддаг дань болох энэхүү энергийн бие бодь улам ариусах тусам улам гэрэлтдэг болно, харин цэвэр ариун биш байх тусам улам хар бараан байдаг. Чи дань-тиань дахь дань (үрэл) руугаа хараад л амгаланд орж чадна гэж үү? Амгаланд орж чадахгүй, энэ нь арга барилаар хийдэг зүйл биш. Гол учир нь хүний бодол санаа цэвэр ариун бишээс юм. Чи дотогшоо дань-тиань руугаа харахад дань гэрэлтсэн гоё харагдана, хормын дараа энэ дань орон сууцны байр болж хувирна. “Энэ өрөөнд манай хүү гэрлэхдээ орно, тэр өрөөнд манай охин сууна,

нөгөө өрөөнд хөгшин бид хоёр амьдарна, дунд талын өрөөг зочны өрөө болгоно, тэгвэл ямар сайхан бэ! Энэ байрыг надад хуваарилах болов уу? Би үүнийг ямар аргаар авахаа бодох хэрэгтэй, яах хэрэгтэй вэ?” Хүн нийм зүйлд л зууралддаг, нийм байвал чи амгаланд орж чадна гэж бодож байна уу? Ийм нэг үг байдаг, “Би энэ энгийн хүний нийгэмд ирэхэд зочид буудалд хэдхэн өдөр буухтай л адил, тэгээд яаран буцна.” Зарим хүн энэ газарт хоргодоод өөрийн жинхэнэ гэр орноо ч мартчихдаг.

Жинхэнэ бясалгалд хүн сэтгэл зүрхээ, өөрийн дотор луугаа чиглэн бясалгах ёстой, гаднаас хайхын оронд дотроосоо эрэлхийл. Зарим бясалгалын номд Будда өөрийн сэтгэл зүрхэнд оршдог гэдэг нь бас учир зүйтэй. Зарим хүн энэ үгийг буруу ойлгодог, Будда сэтгэл зүрхэнд оршдог гэхээр, өөрийгөө Будда мэт, эсвэл үнэхээр сэтгэлд нь нэг Будда байгаа юм шиг боддог. Түүний ингэж ойлгох нь буруу биш гэж үү? Яаж ингэж ойлгож болох юм. Утга нь, чи сэтгэл зүрхээ бясалгах ёстой, зөвхөн тэгж байж л бясалгалын үр дүнд хүрч болно, энэ зарчмыг л хэлээд байгаа юм. Чиний биед Будда яаж байх юм? Чи өөрөө бясалгаж үр дүнд хүрэх ёстой.

Чиний амгалан байдалд орж чадахгүй байгаа шалтгаан нь бодол санаагаа хоосолж чадахгүй байгаагаас, мөн тийм өндөр түвшинд хүрээгүй учраас юм, үүнд гүехнээс гүн рүү орж байж хүрнэ, чиний түвшин дээшлэхтэй уялдан явагдана. Чи зууралдсан сэтгэлээсээ салахад чиний түвшин өснө, мөн чиний гүн амгаланд орох чадвар ч бас гүнзгийрдэг. Хэрэв чи ямар нэгэн арга барил хэрэглэж амгаланд орохыг хүсвэл би үүнийг гаднаас хүсэж байна гэж хэлнэ. Гэвч

чийгон бясалгалд замаасаа хазайх, буруу зам руу орох гэдгийг хүн гаднаас хүсэхийг хэлдэг. Ялангуяа Буддын шашинд чи гаднаас хүсвэл чамайг буг чөтгөрийн замаар орсон гэж хэлнэ. Жинхэнэ бясалгалд хүн сэтгэл зүрхээ бясалгах ёстой, зөвхөн өөрийнхөө шиньшинийг дээшлүүлсэн цагт л чиний сэтгэл ариун тунгалаг, үйлгүй (вүвэй) байдалд хүрнэ; чи зөвхөн шиньшин-ээ дээшлүүлснээр л манай энэ орчлон ертөнцийн мөн чанарт уусаж, хүний янз бүрийн дур хүсэл, зууралдсан сэтгэл болон бусад муу зүйлүүдээсээ салж чадна, чи өөрт байгаа муу бүхнээ хаяж байж л дээшилж чадна. Орчлон ертөнцийн мөн чанарт хязгаарлагдахгүй болоход чиний Дэ гэх энэ бие бодь гон болж хувирна, энэ нь ийм уялдаа холбоотой биш гэж үү? Энэ бол зарчим!

Энэ нь субъектив талаасаа бясалгагч хүний шалгуурын шаардлагад хүрч чадахгүй байгаагаас амгалан байдалд орж чадахгүй байгаагийн шалтгаан нь юм. Одоогийн нөхцөлд дээд түвшин рүү бясалгахад ноцтой саад учруулдаг гадаад хүчин зүйлс байдаг, тэдгээр нь бясалгагчдад ноцтой нөлөөлж байна. Шинэчлэл өөрчлөлт, нээлттэй байдал гарснаар эдийн засаг чөлөөтэй болж, улс төрийн бодлого ч хязгаарлалтаа багасгаж байгааг та бүгд мэднэ. Шинэ технологи маш ихээр нэвтрэн орж ирж, хүний амьдралын түвшин дээшилсэн, энгийн хүн бүгд үүнийг сайн зүйл гэж боддог. Гэхдээ үүнийг диалектикийн үүднээс хоёр талаас нь авч үзэхэд шинэчлэл өөрчлөлт, нээлттэй байдлын хажуугаар янз бүрийн муу зүйлс бас дагаж орж ирсэн. Уран зохиолын бүтээлд жаахан садар самуун зүйл бичихгүй бол тэр ном зарагдахгүй янзтай, учир нь борлуулалтын хэмжээг ярьдаг; кинонд болон телевизийн нэвтрүүлэгт жаахан эротик үзэгдэл



гаргахгүй бол үзэгчидгүй болчих юм шиг үзэгчдийн тооны асуудал яригддаг; урлагийн бүтээлийн хувьд жинхэнэ урлаг юм уу эсвэл юу хийгээд байгаа нь ч мэдэгдэхгүй болсон, эртний Хятадын үндэсний урлаг ийм зүйлс байгаагүй. Түүнчлэн Хятад үндэстний уламжлал нь хэн нэгэн хүний үүсгэсэн зүйл биш, хэн нэгнээр бүтээгдсэн юм биш. Би түүхийн өмнөх үеийн соёлыг ярихдаа юм бүхэнд өөрийн эх сурвалж байдаг гэж хэлсэн. Хүн төрөлхтний ёс суртахууны хэм хэмжээ гажуудсан, өөрчлөлт гарсан, сайн мууг цэгнэдэг шалгуур бүгд өөрчлөгдсөн, энэ бол энгийн хүмүүсийн асуудал. Энэ орчлон ертөнцийн мөн чанар болох Жэнь, Шань, Рэнь бол сайн муу хүнийг цэгнэдэг цорын ганц шалгуур юм, энэ бол өөрчлөгдөхгүй. Бясалгагч хүний хувьд чи дээш сугарч гарах хүсэлтэй бол энэ шалгуураар л цэгнэх ёстой, энгийн хүний шалгуураар цэгнэж болохгүй, иймээс бодит байдал дээр ийм нэг төрлийн гаднын үймүүлэл байдаг. Үүгээр зогсохгүй бас ижил хүйстэн болох, чөлөөт секс, хар тамхи хэрэглэх гэх мэтийн замбараагүй зүйлс бүгд гарч ирсэн.

Хүн төрөлхтний нийгмийн хөгжил өнөөдөр ийм хэмжээнд хүрсэн, бодоод үз дээ, энэ янзаараа цааш үргэлжилбэл юу болох бол? Үргэлж ингээд байлгаад байх уу? Хүн өөрөө засахгүй бол тэнгэр засна. Хүн төрөлхтөнд сүйрэл, гай гамшиг тохиолдох бүрд үргэлж ийм байдалд байсан. Би энэ олон лекц заахдаа хүн төрөлхтний том сүйрлийн талаар ярьж байгаагүй. Энэ халуун сэдвийн талаар шашинд болон хүмүүсийн дунд яригдсаар ирсэн. Би та бүгдэд ийм нэг асуудлыг хэлж өгье, та бүгд энэ талаар боддоо, бидний энгийн хүний нийгэмд хүний ёс суртахууны хэм хэмжээ ийм болтлоо өөрчлөгдсөн байна! Хүн хүний хоорондын зөрчил

ийм цэгтээ хүрсэн! Бодоод үз, энэ нь туйлын аюултай байдалд хүрсэн биш гэж үү? Тиймээс одоогийн энэ бодит орчин байдал нь манай бясалгагчдыг дээд түвшин рүү бясалгахад ноцтой үймүүлдэг. Гудамжны голд нүцгэн шалдан зургууд өлгөөстэй, толгойгоо жаахан өндийлгөхөд л харагдана.

Лаози ийм нэгэн үг хэлсэн: “Ухаантай хүн Дао-г сонсонгуугаа шаргуу хичээллэнэ.” Ухаантай хүн Дао-г сонсвол ингэж бодно, “Арай гэж ариун бясалгал олж авлаа, өнөөдөр бясалгахгүй бол хэзээ бясалгах юм?” Миний бодлоор хэцүү төвөгтэй орчинд бясалгахад харин ч сайн, улам хэцүү төвөгтэй байх тусам улам аугаа хүн гардаг, хэрэв эндээс сугаран гарч чадвал ийм хүний бясалгал хамгийн бат бөх байх болно.

Жинхэнэ бясалгахаар шийдсэн хүний хувьд энэ нь харин ч сайн зүйл гэж би хэлмээр байна. Ямар ч зөрчил гарахгүй бас чамд шиньшин-ээ сайжруулах боломж олдохгүй бол чи дээшлэхгүй. Чи ч сайн би ч сайн байвал яаж бясалгах юм? Жирийн нэг бясалгагч “Бумбыг сонссон дундаж хүн”-д харьяалагддаг, бясалгасан ч болно, бясалгахгүй байсан ч болно гэдэг, ийм хүн бясалгах магадлал багатай. Энд байгаа зарим хүн багшийн ярьж байгааг сонсоод учир зүйтэй гэж боддог ч энгийн хүний нийгэмд буцаж орохоороо тэдгээр бодит ашгийг илүүд үздэг. Тиймээ, тэдгээр нь үнэн бодитой зүйл. Зөвхөн чи ч биш, мөн барууны олон саятнууд, чинээлэг хүмүүс ч бас нас барахад юу ч үлддэггүй болохыг ойлгодог, материалаг баялаг төрөхөд хамт ирэхгүй, үхэхэд дагаад хамт явахгүй хоосон зүйл юм. Харин гон яагаад ийм нандин байдаг вэ? Яагаад гэвэл энэ нь чиний Эзэн сүнсний биед байдаг, төрөхөд цуг ирнэ, нас барахад хамт явна.

Бид Эзэн сүнс устдаггүй гэж хэлсэн, энэ бол мухар сүсэг биш. Бидний энэ махан бие бодийн эсүүд салж мөхөхөд бусад материалаг орон зайнуудад орших бүр жижиг молекулуудын бүрэлдэхүүн хэсгүүд устдаггүй. Зөвхөн гадар бүрхүүд нь хаягддаг.

Миний саяны ярьсан бүгд хүний шиньшин-ий асуудлууд юм. Шагжамүни ингэж ярьж байсан, Бодьдарма ч бас ингэж ярьж байсан: “Энэ дорнын Хятад орон бол аугаа буянтай хүмүүс төрдөг газар.” Хятадын үе үеийн их олон лам хуврагууд, олон хятад хүмүүс үүгээрээ их бахархаж ирсэн. Утга нь, дээд түвшний гон бясалгаж чаддаг гэсэн үг юм, иймээс маш олон хүн үүнд сэтгэл хангалуун байдаг, омогшин хөөрдөг: Манай Хятад үндэстнээс, Хятадын газар нутгаас аугаа төрөлхийн суурьтай хүн, аугаа буянтай хүн их төрдөг гэдэг. Үнэндээ маш олон хүн үүний цаад утгыг нь ойлгодоггүй. Яагаад Хятадын энэ газар нутгаас аугаа Дэ болон өндөр түвшний гон-той хүмүүс гардаг вэ? Олон хүн тэдгээр дээд түвшний хүмүүсийн хэлсэн үгний жинхэнэ утгыг мэдэхгүй, мөн дээд түвшний болон өндөр хүрээний тэдгээр хүмүүсийн бодлын цар хүрээ, бодлын төлөв байдлыг бүр ч ойлгохгүй. Мэдээж бид тэр үгний ямар утгатай болохыг нарийн хэлэхгүй. Та бүгд боддоо, зөвхөн хамгийн төвөгтэй хүмүүсийн дунд мөн хамгийн хэцүү орчинд л өндөр түвшний гон-ыг бясалган гаргаж болдог. Ийм л утгатай юм.

## **Төрөлхийн суурь**

Төрөлхийн суурь нь хүний өөр орон зайд байгаа биен дэх Дэ-гийн их, багаар тодорхойлогддог. Дэ нь бага бол хар бие бодь их, нүглийн хүрээ нь том байдаг, ийм байвал төрөлхийн суурь мууд ордог; Дэ нь их, цагаан бие бодь нь их байх тусам нүглийн хүрээ

бага байна, ийм байвал төрөлхийн суурь сайнд ордог. Хүний цагаан бие бодь, хар бие бодь хоорондоо нэг нь нөгөөдөө хувирч болдог, яаж хувирдаг вэ? Сайн үйл хийвэл цагаан бие бодь үүсдэг. Цагаан бие бодийг зовлон зүдүүр амсаж бэрхшээлийг даван туулснаар, сайн үйл хийснээр олж авдаг. Харин хар бие бодь бол муу зүйл хийснээс, муу хэрэг үйлдсэнээс үүсдэг, тэр бол нүгэл. Тэр нь ийм хувирах явцтай байдаг, мөн түүнд бас дагаж явах холбоо байдаг. Учир нь тэр Эзэн сүнсийг шууд дагаж явдаг, зөвхөн нэг амьдралын насны зүйл биш юм, өнө эртний үеэс хуримтлагдан ирдэг. Иймээс бид нүгэл хураах, Дэ (буян) хураах гэж ярьдаг, бас өвөг дээдсээс дамжиж болно. Заримдаа эртний Хятад хүмүүсийн болон настай хүмүүсийн хэлдэг байсан “Өвөг дээдсийн хураасан Дэ (буян), Дэ хураах эсвэл Дэ-гээ алдах” гэсэн үгс санаанд минь ордог. Энэ бол маш үнэн үг! Үнэхээр тун зөв.

Хүний сайн эсвэл муу төрөлхийн сууриар нь түүний ухамсар сайн муу эсэхийг нь тодорхойлж болно. Төрөлхийн суурь муутай хүний ухамсар бас муу байдаг. Яагаад вэ? Учир нь төрөлхийн суурь сайтай хүнд цагаан бие бодь их байдаг, энэ цагаан бие бодь манай орчлон ертөнцөд нийцдэг, орчлон ертөнцийн Жэнь, Шань, Рэнь мөн чанарт ууссан байдаг, ямар ч тусгаарлалт байхгүй. Орчлон ертөнцийн мөн чанар шууд чиний биед илэрнэ, шууд чиний биетэй холбогддог. Харин хар бие бодь бол яг эсрэг, муу үйл хийснээс үүсдэг учраас манай орчлон ертөнцийн мөн чанарын эсрэг байдаг, тиймээс энэ хар бие бодь орчлон ертөнцийн мөн чанараас тусгаарлагддаг. Хэрэв энэ хар бие бодь их хэмжээтэй байвал тэр хүний биеийн эргэн тойронд нэг хүрээ үүсдэг, хүнийг бүрхдэг. Тэр хүрээ нь том байх тусам нягтрал нь улам

их, улам зузаан, үүнээс болж энэ хүний ухамсар улам муу болдог. Яагаад гэвэл орчлон ертөнцийн Жэнь, Шань, Рэнь гэсэн мөн чанарыг хүлээн авч чадахгүй, тэр муу үйл хийснээс болж хар бие бодь олж авсан. Ер нь ийм хүн бясалгалд итгэхгүй, ухамсар нь муу байх тусам нүглийн саад улам их; зовлон бэрхшээл их амсах тусам улам итгэхгүй болно, бясалгахад ч хэцүү болно.

Цагаан бие бодь ихтэй хүн бясалгахад дөхөм байдаг, яагаад гэвэл бясалгалын явцад тэр зөвхөн орчлон ертөнцийн мөн чанарт уусвал түүний шиньшин дээшилнэ, түүний Дэ шууд гон болж хувирна. Харин хар бие бодь ихтэй хүнд үйлдвэрт бүтээгдэхүүн гардаг шиг нэмэлт дамжлага хэрэгтэй, бусад хүнд бэлэн материал ирж байхад түүнд түүхий эд ирдэг, эхлээд боловсруулах хэрэгтэй, ийм нэг явц байдаг. Иймээс тэр эхлээд бэрхшээл зовлон туулж нүглээ арилгаад үүнийг цагаан бие бодь болгон хувиргана, Дэ энэ бие бодь үүссэний дараа түүнд өндөр түвшний гон гарч болно. Гэхдээ ер нь ийм хүний ухамсар угаасаа муу, чи түүнийг илүү их зовлон туул гэвэл тэр бүр ч итгэхгүй, бүр ч тэсэхгүй, иймээс хар бие бодь ихтэй хүн бясалгахад хэцүү байдаг. Урьд нь Бумбын системд юм уу эсвэл зөвхөн ганц шавьд уламжилдаг бясалгалд багш нь шавийг хайдаг, шавь багшийг хайдаггүй гэж ярьдаг байсан, учир нь тэр хүний биед байгаа эдгээр зүйлс хэр их байгаагаас шалтгаалдаг.

Төрөлхийн суурь хүний ухамсрыг тодорхойлдог, гэхдээ туйлаас биш. Зарим хүн төрөлхийн суурь муутай байдаг, гэхдээ гэр бүлийн орчин нь их сайн, олон хүн бясалгадаг, зарим нь бас шашин шүтдэг, мөн бясалгалд их үнэмшилтэй. Ийм орчин бас түүний итгэл үнэмшил, ухамсрыг сайн болгодог, иймээс

туйлаас биш юм. Зарим хүний төрөлхийн суурь их сайн, гэхдээ манай энэ бодит нийгмийн хүмүүжилд олж авсан тэр өчүүхэн мэдлэг боловсрол, ялангуяа урьд хэдэн жилийн өмнөх туйлшрах үзэл сурталын хүмүүжилийн арга нь хүний бодлыг их явцуу болгосон, өөрсдийн мэдлэгээс давсан бүх зүйлд итгэхээ больсон, энэ байдал бас тэдний ухамсарт ноцтой саад учруулдаг.

Нэг жишээ хэлье, би лекцийнхээ хоёр дахь өдөр тэнгэрийн мэлмий нээгдэх талаар ярьсан. Төрөлхийн суурь сайтай нэг хүний тэнгэрийн мэлмийг шууд маш өндөр түвшинд нээж өгсөн, тэр бусад хүний харж чадаагүй маш олон зүйлсийг харсан. Тэдэнд тэр хэлсэн: “Хөөх, би энэ лекцийн танхим даяар Фалунь цасан ширхэг шиг хүмүүс дээр бууж байхыг харлаа; би Ли Багшийн жинхэнэ бие ямар болохыг, Ли Багшийн гэрэлт хүрээг, Фалунь ямар дүрстэй байдгийг, хэр олон Фашэнь байгааг харсан.” Тэрээр мөн өөр өөр түвшинд Ли Багш Фа ярьж байхыг харсан, бас Фалунь сурагчдын биеийг хэрхэн засаж өгч байгааг харсан. Бас лекцийн явцад Багшийн гон бие (гоншэнь) өөр өөр түвшинд Фа зааж байхыг, мөн тэнгэрийн дагинас цэцэг тараан шидэж байсан зэргийг харсан гэсэн. Тэр эдгээр гайхамшигтай зүйлсийг харсан нь түүний төрөлхийн суурь их сайн болохыг харуулж байна. Тэр ярьж, ярьж байснаа эцэст нь “Би ийм зүйлст итгэдэггүй” гэсэн. Эдгээрээс зарим зүйлүүд нь аль хэдийн шинжлэх ухаанд нотлогдсон, мөн маш олон зүйлийг одоогийн шинжлэх ухаанаар тайлбарлаж болно, бид заримаас нь бас авч ярьсан. Учир нь чийгон-оор танин мэдсэн зүйлүүд нь үнэхээр орчин үеийн шинжлэх ухааны олж мэдсэнээс хол давсан юм, энэ бол дамжиггүй. Үүнээс үзэхэд хүний төрөлхийн суурь нь хүний ухамсрыг бүрэн тодорхойлдоггүй болохыг харуулж байна.

## Ухамсар

“Ухамсар” гэж юу вэ? “Ухамсар” гэдэг нь шагнаас үүсэлтэй үг юм. Буддын шашинад ухамсар гэдгийг бясалгагч хүн Буддын Дарма-г ойлгох байдал, мөн танин мэдэхүйн ухамсар ба төгс ухамсрыг хэлдэг, энэ нь оюун санааны гэгээрэл гэсэн үг юм. Гэхдээ үүнийг одоогийн энгийн хүмүүс авч хэрэглэдэг болсон, энэ хүн их сэргэлэн ухаантай, даргынхаа юу бодож байгааг нь дор нь гадарладаг, даргынхаа аргыг яаж олохоо мэддэг гэдэг. Хүмүүс ийм хүнийг ухамсар сайтай гэж хэлдэг, ер нь ингэж л ойлгодог болсон. Хэрэв чи энгийн хүмүүсийн түвшнээс бага зэрэг дээш гарч арай өндөр түвшнээс харвал, энгийн хүмүүсийн ойлгодог энэ түвшний зарчмууд нь ихэвчлэн буруу байдгийг олж мэднэ. Бидний ярьдаг ухамсар бол ийм ухамсар огт биш. Овжин хүний ухамсар нь харин ч эсрэгээрээ муу юм, яагаад гэвэл хэт овсгоотой хүн зөвхөн өнгөцхөн төдий ажил хийж удирдагч, дарга нарынхаа үнэлгээг авдаг. Тэгвэл жинхэнэ ажлыг өөр хүн хийж байгаа юм биш үү? Тиймээс энэ хүн бусдад өртэй болно; тэр сэргэлэн овсгоотой, бусдын аргыг яаж олохоо мэддэг учраас илүү их ашиг олж авна, харин бусад нь илүү хохирол амсах болно; тэр овсгоотой сэргэлэн болохоор хохирол амсахгүй, юугаа ч тийм амархан алдахгүй, тэгвэл бусад нь зовох ёстой болно. Тэр энэ өчүүхэн ашиг хонжооныхоо хойноос хөөцөлдөх тусам улам явцуу сэтгэлтэй болно, энгийн хүмүүсийн материаллаг ашгийг орхино гэвэл санаанд нь багтахгүй, тиймээс тэр өөрийгөө бодитой хүн гэж үздэг, тэр ямар ч хохирол амсахгүй.

Зарим хүн ийм хүнээр бүр бахархдаг! Би чамд хэлье, түүгээр бүү бахарх. Чи түүнийг ямар их шаналгаатай амьдардгийг нь мэдэхгүй, тэр сайн идэж

уж ч чадахгүй, сайн унтаж амарч ч чадахгүй, тэр зүүдэндээ хүртэл хувийн ашгаа алдахаас айдаг. Хувийн ашгийнхаа төлөө эцсээ хүртэл зүтгэнэ, чи түүнийг хэцүү амьдардаг гэж хэлэхгүй гэж үү? Тэр бүх насаа үүнд л зорнулна. Зөрчил тулгарахад нэг алхам ухарваас тэнгис далай, тэнгэр огторгуй хязгааргүй уудам болохыг мэдэрнэ гэж бид хэлдэг, өөр нэг байдал гарах нь дамжиггүй. Харин тийм хүн бол буулт хийхийг хүсдэггүй, тэгээд ядарч амьдрах болно, чи түүнээс бүү суралц. Бясалгагчдын хүрээнд ингэж ярьдаг: Ийм хүн бол гүн төөрөлдсөн, тэр материалаг ашгийн төлөө энгийн хүмүүсийн дунд бүрмөсөн төөрсөн. Түүнд Дэ (буян)-гээ бүү алд гэж хэлбэл, ёстой амар биш! Чи түүнд бясалгал хийхийг зөвлөвөл тэр чамд итгэхгүй: Бясалгах аа? Та нар бясалгагч учраас хүнд зодуулсан ч хариу цохихгүй, загнуулсан ч урдаас нь хэрэлдэхгүй. Хүмүүс чамайг дээрэлхэж байхад тэдэнтэй адилхан үзэлцэхийн оронд харин чи тэдэнд дотроо баярладаг. Та нар бүгдээрээ А-Кю-тай адил болцгоочихсон! Бүгд сэтгэцийн өвчтэй! гэнэ. Ийм хүн бясалгал ойлгох ямар ч арга байхгүй. Тэр чамайг байж болшгүй тэнэг гэнэ. Чи хэлдээ, түүнийг аврахад хэцүү биз дээ?

Бидний ярьдаг ухамсар бол ийм ухамсар биш. Харин яг энэ хүний ярьсан шиг, хувийн ашиг сонирхлын хувьд жаахан “тэнэг” байх нь бидний яриад байгаа ухамсар юм. Мэдээж, үнэн хэрэг дээрээ тэнэг биш, бид зөвхөн л хувийн ашиг сонирхол гэх мэтийн асуудлыг хөнгөн авч үздэг, гэхдээ бусад тал дээр бид ухаалаг ханддаг. Эрдэм шинжилгээний төсөл дээр ажиллахдаа ч юм уу эсвэл даргын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, бусад ажил төрөл хийхдээ бид их саруул ухаантай, маш сайн гүйцэтгэдэг. Зөвхөн хувийн ашиг сонирхол дээр, хүмүүс хоорондын зөрчлийн дунд бид хөнгөн



ханддаг. Хэн чамайг тэнэг гэх юм? Хэн ч чамайг тэнэг гэж хэлэхгүй, энэ бол баталгаатай.

Бид жинхэнэ тэнэг хүнийг авч ярья. Дээд түвшний зарчмаар авч үзвэл бүгд яг эсрэгээрээ байдаг. Тэнэг хүн энгийн хүмүүсийн дунд том муу зүйл хийх магадлал байхгүй, бас өөрийн ашиг сонирхлын төлөө тэмцэлдэж өрсөлдөхгүй, нэр хүнд хөөцөлдөхгүй, тэр Дэ-гээ алдахгүй. Харин бусад хүн түүнд Дэ-гээ өгнө, түүнийг зодох, загнахад түүнд бүгд Дэ-гээ өгнө, харин энэ бие бодь бол тун нандин юм. Манай энэ орчлон ертөнцөд ийм нэг зарчим байдаг: “Алдахгүй бол олодохгүй. Олдовол алдана.” Хүмүүс тэр тэнэгийг харахаараа бүгд түүнийг загнана, “Чи ёстой усан тэнэг.” Ингэж хэл амаар доромжлоход хэсэг Дэ түүн рүү шидэгдэнэ. Чи түүнийг дарласан болохоор олсон тал, тэгэхээр чи алдах ёстой. Түүнийг очиж өшиглөөд “Чи шал тэнэг амьтан” гэхэд дахиад нэг хэсэг Дэ түүн дээр бууна. Хэн түүнийг дээрэлхэнэ, хэн түүнийг өшиглөнө тэр инээмсэглэн: “Тэгээ тэг, надад Дэ-гээ өгч байгаа юм бол өчүүхэн ч татгалзахгүй!” Тэгвэл дээд түвшний зарчмаар үүнийг бодоод үз, хэн нь овжин байна? Тэр овжин биш гэж үү? Тэр хамгийн овжин нь юм. Тэр жаахан ч Дэ алдахгүй, чи түүнд Дэ шидэж өгөхөд тэр огтхон ч буцааж түлхэхгүй, бүгдийг нь авна, баяртайгаар хүлээн авна. Тэр энэ насандаа тэнэг байж болно, харин хойд насандаа тийм биш, Эзэн сүнс нь тэнэг биш. Шашинд хэлэхдээ, хүнд их Дэ байвал хойд насандаа өндөр албан тушаалын хүн, эсвэл их баян чинээлэг хүн болно гэдэг, энэ бүгдийг Дэ-гээрээ солилцдог.

Бид Дэ шууд гон-д хувирч болдог гэж хэлсэн. Чиний хэр өндөр бясалгаж чадах нь Дэ-гийн хувиралтаас

болдог биш гэж үү? Энэ нь шууд гон болж хувирч болдог. Хүний түвшний өндөр нам, гон хүчний их багыг тодорхойлдог гон нь энэ Дэ бие бодиос хувиран гардаггүй гэж үү? Чи үүнийг нандин гэж үзэхгүй гэж үү? Энэ нь төрөхөд хамт ирнэ, үхэхэд дагаж явна. Буддын шапинд чиний хэр өндөрт бясалгах нь чиний хүрэх бүтээлийн орон гэдэг. Чи хэр их зориулна тэр хэмжээгээр олно, энэ бол зарчим. Шапинд Дэ байвал хойд насандаа дээд албан тушаалын хүн, эсвэл их баян чинээлэг хүн болно гэдэг. Бага Дэ-тэй бол тэр хүн хоол гуйсан ч амар олдохгүй, учир нь солнх Дэ байхгүй, алдахгүй бол олдохгүй! Жаахан ч Дэ байхгүй бол бие сүнс нь хоёулаа устах болно, тэр бол жинхэнэ үхэл.

Урьд өмнө нэг чийгон багш байсан, нийтийн дунд анх гарч ирэхдээ түүний түвшин их өндөр байсан, дараа нь тэр чийгон багш нэр хүнд, хувийн ашиг сонирхолд автсан. Тэгээд Багш нь түүний Дэ сүнсийг дагуулаад явсан, учир нь тэр Дэ сүнсийг бясалгадаг бясалгалд харьяалагддаг байсан. Түүний Дэ сүнс нь байх үед тэр Дэ сүнсэндээ удирдуулдаг байсан. Нэг жишээ ярья, нэг өдөр түүний ажлын газар орон сууцны байр хуваарилах болж дарга нь хэлсэн: “Байргүй хүмүүс энд ирээд нөхцөл байдлаа танилцуул, яагаад байранд орох хэрэгтэй байгаа шалтгаанаа тайлбарла.” Хүн болгон өөрсдийнхөө байдлыг танилцуулсан, тэр хүн л юу ч дугараагүй. Эцэст нь дарга нь түүнийг бусдаас илүү хүнд байдалтай гэж үзэн байрыг түүнд өгөх ёстой гэсэн. Нэг нь хэлсэн: “Үгүй, байрыг түүнд битгий өг, надад өг, би хэн бүхнээс илүү байрны гачигдалтай байна.” Тэр хэлсэн: “Тэгвэл чи ав ав.” Энгийн хүнд бол тэр тэнэг харагдана. Зарим хүн түүнийг бясалгадаг гэдгийг нь мэддэг, тэгээд ингэж асуусан: “Чи бясалгадаг

болохоор юу ч авахгүй, тэгвэл чамд юу хэрэгтэй юм?” Тэр хариулсан: “Бусад хүмүүс юу авахгүй байна, би тэрийг нь авна.” Үнэндээ тэр бол огтхон ч тэнэг биш, харин ч их ухаалаг. Зөвхөн хувийн ашиг сонирхол дээр ингэж хандана, тэр жам ёсыг дага гэдэгт итгэдэг. Өөр нэг хүн түүнээс асуусан: “Одоогийн хүмүүст авахгүй зүйл гэж байх юм уу?” Тэр ингэж хариулсан: “Газар дээр хүний хөлд ийш тийш өшиглөгдөн хэвтэх чулууг хэн ч авахгүй, тэгвэл би тэр чулууг түүж авна.” Энэ нь энгийн хүмүүсийн ухаанд багтахгүй, энгийн хүмүүс бясалгагч хүнийг ойлгохгүй, ойлгох ч арга байхгүй, тэдний үзэл санаа маш их ялгаатай байдаг, мөн тэдний түвшин хэтэрхий хол зөрөөтэй. Тэр мэдээж чулуу түүхгүй, тэр энгийн хүний ухамсарлахгүй зарчмыг л хэлсэн юм, “Би энгийн хүний зүйлээр хөөцөлдөхгүй.” Энэ чулууны талаар ярья, Буддын сударт Сухавати диваажинд мод нь алтан, газар нь алтан, шувууд нь алтан, цэцгүүд нь алтан, байшин нь алтан, мөн Буддын бие нь хүртэл алтлаг гялалзсан гэж бичсэн байдгийг та бүгд мэднэ. Тэнд ширхэг чулуу ч олдохгүй, хэрэглэдэг мөнгө нь чулуу гэгддэг. Тэр мэдээж чулуу авч тэнд очихгүй, харин энгийн хүмүүсийн ойлгодоггүй энэ зарчмыг л хэлсэн юм. Үнэндээ бясалгадаг хүн ингэж хэлдэг: “Энгийн хүнд энгийн хүний хөөцөлддөг зүйл байдаг, бид түүгээр хөөцөлдөхгүй; энгийн хүнд байдаг зүйлийг бид ч сонирхохгүй; харин бидэнд байдаг зүйлийг энгийн хүн хүссэн ч олж авч чадахгүй.”

Үнэндээ бидний саяны ярьсан ухамсар бол энгийн хүмүүсийн дунд байдаг ухамсраас яг эсрэгээр юм, энэ нь бясалгалын явц дахь ухамсарт хамаарагдана. Бидний ярьж байгаа ухамсар бол бясалгалын явцад Багшийн ярьсан Фа-г, Бумбын системийн багшийн ярьсан Дао-г, бясалгах явцад бэрхшээлтэй учрахдаа өөрийгөө

бясалгагч хүн гэж ухамсарлаж чадах чадахгүйн асуудал, үүнийг ойлгож чадах чадахгүйн асуудал, хүлээн авч чадах чадахгүйн асуудал, мөн бясалгаж байх явцдаа Фагийн дагуу мөрдөж чадах чадахгүйн асуудал юм. Зарим хүнд яаж ч ярьсан тэр итгэхгүй, энгийн хүний зүйлийг илүү бодит гэж үзсээр байх болно. Тэд гөжүүд үзэл бодолдоо зууралдаад орхиж чаддаггүй, энэ нь тэднийг итгэж үнэмшихгүй байдалд хүргэнэ. Зарим хүн зөвхөн өвчнөө эдгээх тухай л боддог, намайг чийгон бол үндсэндээ өвчин эдгээх зорилготой биш гэж хэлэнгүүг тэд дотроо дургүйцдэг, тэгээд цааш миний ярьсан зүйлд итгэхгүй болдог.

Зарим хүний ухамсар нь яагаад ч дээшилдэггүй, тэд миний ном дээр хамаагүй зурна, тэмдэглэгээ хийнэ. Манай тэнгэрийн мэлхий нээгдсэн хүн болгонд энэ ном их өнгөлөг, алтлаг гялалзан харагддаг, үг бүр нь миний Фашэнь-ий дүрстэй байдаг. Би худал хэлбэл та бүгдийг хуурч мэхэлсэн болно, чиний зурсан тэр зураас тэмдэглэгээ хав хар харагддаг, чи үүн дээр хамаагүй зурж зүрхэлнэ гэж үү? Бид энд юу хийж байгаа вэ? Чамайг дагуулан дээш бясалгуулж байгаа биш гэж үү? Зарим зүйлийг чи бас бодох хэрэгтэй, энэ ном чиний бясалгалыг удирдаж чадна, чи үүнийг нандин гэж бодохгүй байна уу? Чи Будда-д мөргөснөөр жинхэнэ бясалгаж чадах юм уу? Чи тэр Буддын хөрөг, барималд маш их сүжигтэй, зөөлөн ч хүрч зүрхэлдэггүй, өдөр болгон урд нь хүж өргөнө, харин чиний бясалгалыг жинхэнэ удирдаж чадах Дафа-г бохирдуулж зүрхэлнэ гэж үү.

Хүний ухамсрын тухайд гэвэл энэ нь бясалгалын явцад янз бүрийн түвшинд гарч ирсэн зүйлс, эсвэл багшийн заасан тодорхой нэг Фагийн талаарх

чиний ойлголт юм. Гэхдээ энэ нь бидний ярьдаг үндсэн гэгээрэл бас биш, бидний ярьдаг үндсэн гэгээрэл бол хүн энэ насандаа бясалгалын эхнээс тасралтгүйгээр дээш ахих, тасралтгүйгээр хүний зууралдсан сэтгэл янз бүрийн хүслээс ангижрах, мөн бясалгалын хамгийн сүүлчийн алхам хүртэл гон нь тасралтгүй дээш өсөх явц юм. Дэ энэ бие бодь гон болж бүрэн хувирч, багшийн төлөвлөсөн бясалгалын зам төгсгөлдөө хүрэх тэр агшинд “пад” гээд бүх түгжээнүүд дэлбэрч нээгдэнэ. Тэнгэрийн мэлмий нь түүний байгаа түвшний хамгийн дээд цэгт хүрнэ, тэр өөрийнхөө түвшинд орон зай болгоны үнэн байдлыг, цаг хугацааны орон зай болгонд байгаа янз бүрийн амь бодийн орших хэлбэр, цаг хугацааны орон зай болгоны бие бодийн орших хэлбэр, бидний орчлон ертөнцийн үнэнийг харна. Түүний бурханлаг ер бусын чадвар гарч ирнэ, мөн төрөл бүрийн амь бодитой харьцаж чадна. Ийм хэмжээнд хүрвэл аугаа гэгээрэгч биш гэж үү? Бясалгалаар гэгээрсэн хүн биш гэж үү? Энэ нь эртний Энэтхэг хэлээр бол—Будда.

Бидний ярьж байгаа энэ гэгээрэл бол гэнэт гэгээрэх хэлбэрт харьяалагдана. Гэнэт гэгээрэх гэдэг нь хүн амьдралынхаа турш бясалгахдаа түгжээтэй байдаг, тэр өөрийнхөө гон-ыг хэр өндөрт хүрснийг болон түүний бясалгаж гаргасан гон ямар хэлбэртэйг мэдэхгүй, үндсэндээ юу ч мэдрэхгүй, тэр ч байтугай түүний биеийн эсүүд нь хүртэл бүгд түгжээтэй байдаг. Бясалгаж гаргасан гон бүгд түгжээтэй байдаг, бясалгаад эцэст нь хүрэхэд нээгдэнэ. Үүнийг зөвхөн аугаа төрөлхийн суурьтай хүн л хийж чадна, ингэж бясалгахад маш их хэцүү. Сайн хүн болохоос эхэлж хийнэ, өөрийн шиньшин-ийг байнга дээшлүүлэх хэрэгтэй, үргэлж зовлон бэрхшээл амсана, бясалгалдаа

тасралтгүйгээр дээшилнэ, шиньшин-ээ сайжруулахыг үргэлж эрэлхийлдэг, гэхдээ өөрийнхөө гон-ыг харж чадахгүй. Ийм хүн бясалгахад хамгийн хэцүү байдаг, аугаа төрөлхийн суурьтай хүн байх ёстой, олон жилийн турш юу ч мэдэхгүйгээр бясалгана.

Бас өөр нэг төрлийн аажмаар гэгээрэх хэлбэр байдаг. Анх эхлэхдээ л их олон хүн Фалунь эргэлдэж байхыг мэдэрсэн, мөн түүнчлэн би та бүгдэд тэнгэрийн мэлмийг нээж өгнө. Зарим хүн одоо янз бүрийн шалтгаанаас болж харж чадахгүй бол ирээдүйд хардаг болно, юмыг бүдэг хардаг байснаа тод хардаг болно, хэрэглэж чаддаггүй байснаа яаж хэрэглэхийг мэддэг болно, түвшин нь тасралтгүй дээшилнэ. Чиний шиньшин дээшлэхийн хамт янз бүрийн зууралдсан сэтгэлээсээ салахад янз бүрийн ер бусын чадвар гарч ирнэ. Бясалгалын бүхий л хувьсах явц ба бие махбодын хувирах явц нь бүгд чамд харагдах эсвэл мэдрэгдэх байдлаар явагдана, өөрчлөлтүүд гарсаар л байх болно. Ингээд эцсийн алхамд хүрэхэд орчлон ертөнцийн үнэнийг бүрэн ойлгоно, чиний бясалгах ёстой түвшин хамгийн дээд оргилдоо хүрнэ. Бие (бэньти)- ийн хувиралт болон ер бусын чадварын адислал тодорхой хэмжээнд хүрэх бөгөөд энэ зорилгодоо аажмаар хүрнэ. Энэ бол аажим гэгээрэхэд харьяалагдана. Энэ аажмаар гэгээрэх бясалгалын арга нь бас тийм амар биш, ер бусын чадвартай болсны дараа зарим хүн зууралдсан сэтгэлээсээ салж чадахгүйгээс гайхуулна, амархан муу зүйл хийнэ. Ингэснээр чиний гон доош унана, бясалгал чинь ямар ч үр дүнгүй болно, эцэст нь сүйрнэ. Зарим хүн янз бүрийн түвшин дэх төрөл бүрийн амь бодийн илрэх байдлыг харж чаддаг, нэг нь чамайг ийм тийм зүйл хий гэж турхирч магад, тэр чамайг өөрийнх нь зүйлийг бясалга, чамайг шавиа болгон авъя гэж

чангааж магад, гэвч тэр чамайг гэгээрлийн хутагт хүргэж чадахгүй, яагаад гэвэл тэр өөрөө ч гэгээрлийн хутгийг олоогүй.

Түүнээс гадна дээд орон зайнуудын хүмүүс бүгд бурхад байдаг, маш том болж хувирч, эгнэшгүй ер бусын чадвар гаргаж чадна, сэтгэл чинь зөв биш бол чи тэднийг дагаад явчихгүй гэж үү? Тэднийг дагаад явмагц чиний бясалгал тэр дороо үр дүнгүй дуусна. Тэр амь бодь жинхэнэ Будда эсвэл жинхэнэ Бумба байсан ч гэсэн чи дахиад бүр эхнээс нь бясалгах ёстой болно. Тэнгэрийн аль ч давхаргын хүн байсан, тэд бүгд бурхан биш гэж үү? Гагцхүү бясалгаад маш өндөр түвшинд хүрэх буюу зорилгодоо хүрсэн цагт л чи бүрмөсөн сугаран гарч чадна. Гэхдээ тэдгээр бурхад энгийн хүний нүдэнд үнэхээр өндөр, агуу том бас их чадвартай харагдах боловч тэд гэгээрлийн хутагт хүрч чадаагүй байж болно. Янз бүрийн мэдээлэл үймүүллийн дор, янз бүрийн үзэгдэл байдалд сатааран татагдахад чиний сэтгэл хөдлөхгүй байж чадах уу? Иймээс тэнгэрийн мэлмий нээлттэй бясалгахад бас их хэцүү байдаг, мөн шиньшин-ээ барихад бүр ч хэцүү. Гэхдээ завшаантай нь, бясалгалын явц дунд манай зарим сурагчдын ер бусын чадвар нээгдэнэ, улмаар аажим гэгээрэх байдалд орно. Тэнгэрийн мэлмийг хүн болгонд нээж өгнө, гэхдээ маш олон хүнд ер бусын чадвар гаргуулахгүй. Чиний шиньшин аажмаар дээшлээд нэг тодорхой түвшинд хүрэхэд, сэтгэл санаа чинь тогтворжиход, чи өөрийгөө сайн барьж чаддаг болоход бүх түгжээг чамд нэг дор дэлбэлж нээж өгнө. Ямар нэг түвшинд чамайг аажим гэгээрэх байдалд оруулна, тэр үед чамд өөрийгөө барихад нэлээд амархан байх болно, янз бүрийн ер бусын чадвар бүгд гарч ирнэ, чи өөрөө бясалгаж дээшилснээр эцэст нь бүгд бүрэн нээгдэнэ.

Бясалгалын явц дунд чамд тэдгээрийг гаргуулна, манай олон хүн энэ харьяалалд багтана, тэгэхээр чи юм харах гэж битгий яар.

Та нар магадгүй Зэн Буддизмд гэнэт гэгээрэх, аажим гэгээрэхийн талаар ярьдгийг дуулсан байх. Зэн Буддизмын зургаа дахь хамба Хүйнэн гэнэт гэгээрэхийг номлосон, харин Зэн Буддизмын Хойд бүлгийн Шэньшину аажмаар гэгээрэхийг номлосон. Түүхэнд тэр хоёрын Буддын номлолын маргаан удаан хугацааны турш үргэлжилсэн, нааш цааш маргалдсаар л байсан. Би энэ маргааныг утга учиргүй гэж хэлнэ. Яагаад вэ? Учир нь тэдний ярьж байгаа нь бясалгалын явц дахь ямар нэгэн зарчмыг хэрхэн ойлгох л асуудал юм. Зарим хүн энэ зарчмыг тэр дор нь ухамсарладаг бол зарим нь аажмаар ухамсарлаж ойлгодог. Яаж ухамсарласан ч болох юм биш үү? Шууд ухамсарлавал бүр сайн, аажмаар ухамсарласан ч бас болно. Аль нь ч ялгаагүй гэгээрэл биз дээ? Хоёулаа л гэгээрэл, иймээс аль нь ч буруу биш.

### **Аугаа төрөлхийн суурьтай хүн**

Аугаа төрөлхийн суурьтай хүн гэж ямар хүнийг хэлдэг вэ? Аугаа төрөлхийн суурьтай хүн гэдэг нь төрөлхийн суурь нь сайн, эсвэл суурь нь муу хүнээс ялгаатай байдаг. Аугаа төрөлхийн суурьтай хүнийг олоход маш хэцүү, түүхийн маш урт хугацаанд нэг л ийм хүн төрдөг. Мэдээж аугаа төрөлхийн суурьтай хүнд юуны түрүүнд заавал маш их Дэ байх ёстой, энэ цагаан бие бодийн хүрээ нь их том байдаг, энэ бол гарцаагүй. Түүнчлэн ийм хүн зовлон дундын зовлонг дааж чаддаг, бас сэтгэл санааны агуу их тэвчээртэй, юугаа ч зорнулж чаддаг, мөн Дэ-гээ сахиж чаддаг, ухамсар сайтай гэх мэт байх ёстой.



Зовлон дундын зовлон гэж юу вэ? Буддын шашинд, хүн байх нь зовлонтой гэж үздэг, чи хүн л байгаа цагт зовох болно. Бусад бүх орон зайн амь бодигдаа бидний энгийн хүний ийм бие махбод байдаггүй гэж үздэг, иймээс тэд өвчин тусахгүй, мөн төрөх, хөгшрөх, өвчлөх, үхэх асуудал байхгүй болохоор ийм зовлон байдаггүй. Өөр орон зайны хүн нисэж чадна, жингүй, их гайхамшигтай сайхан. Энгийн хүн ийм биетэй учраас асуудал гардаг: даарч, халууцаж, цангаж, өлсөж, бас ядарч чадахгүй, түүнээс гадна төрөх, хөгшрөх, өвчлөх, мөн үхэх асуудал байдаг, ямар ч байсан чамд таатай байхгүй.

Би нэг сонин дээрээс Таншаньд болсон газар хөдлөлтийн үеэр олон хүн нас барсан, бас зарим нь аврагдаж амь орсон тухай уншсан. Энэ хэсэг хүмүүсийн дунд нийтийн тусгай судалгааны асуулга явуулсан: Тэднээс үхлийн байдалд ороход ямар мэдрэмж төрсөн бэ? гэж асуусан. Гэтэл хачирхалтай нь, тэдгээр хүмүүс бүгд нэг онцгой байдлын талаар санаа нэгтэй ярьцгаасан. Энэ нь үхэх яг тэр мөчид тэдэнд айх мэдрэмж төрөөгүй, харин эсрэгээр гэнэт нэг ангижрах мэдрэмж төрсөн бөгөөд сэтгэлийн хөөрлийг мэдэрсэн; зарим хүн бие махбодынхоо хүлээснээс чөлөөлөгдсөнөө мэдэрсэн, мөн гайхалтай хөнгөхөн хөөрч чадаж байсан төдийгүй өөрсдийнхөө биеийг харж болж байсан; зарим нь бас өөр орон зайн амь бодийг харсан; зарим хүн бүр хаа нэгтээ очиж үзсэн байсан. Бүгд яг тэр агшинд нэгэн ангижрах байдал мэдэрсэн ба өвдөлт байхгүй, харин сэтгэлийн хөөрөл төрсөн гэж ярьцгаасан. Өөрөөр хэлбэл хүн энэ махан биетэй байхад зовлонтой байдаг гэсэн үг юм, гэвч хүн болгон эхийн хэвлийгээс ингэж төрдөг болохоор хэн ч үүнийг зовлон гэж мэддэггүй.

Хүн зовлон дундын зовлонг даадаг байх ёстой гэж би хэлнэ. Хүн төрөлхтний энэ цаг хугацааны орон зайн ухагдахуун бусад том хэмжээний цаг хугацааны орон зайн ухагдахуунаас ялгаатай гэж дээр хэлсэн, манай энд нэг шичэнь хоёр цагтай тэнцдэг, харин тэр орон зайд бол нэг жил юм. Хүн ийм хэцүү орчинд бясалгахад түүнийг үнэхээр гайхалтай гэнэ; энэ хүн Бумбыг эрэлхийлэх сэтгэлтэй, бясалгах хүсэлтэй байвал энэ хүн үнэхээр гайхалтай гэнэ. Энэ хэцүү зовлон дунд тэр хүн өөрийнхөө төрөлх мөн чанараа алдаагүй, мөн бясалгаад буцаж харихыг хүсэж байна. Яагаад бясалгаж байгаа хүнд болзол нөхцөлгүйгээр тусалж болдог вэ? Энэ бол учир нь юм. Энэ хүн энгийн хүний орон зайд шөнөжин бясалгаж суухад, тэндээс түүнийг хараад үнэхээр гайхалтай, тэр тэнд зургаан жил бясалган суучихлаа гэж ярина. Яагаад гэвэл манай нэг шичэнь тэндхийн нэг жилтэй тэнцэнэ. Бидний хүн төрөлхтний орон зай бол маш онцгой орон зай юм.

Яаж зовлон дундын зовлонг даах вэ? Нэг жишээ ярья, нэг өдөр энэ хүн ажилдаа явсан. Ажлын газар нь сайнгүй байв, хүмүүс ажлаа хийх сэтгэлгүй болсон учраас энэ байдал удаан үргэлжлэх боломжгүй болсон, ажлын газар нь шинэчлэл хийж гэрээт гүйцэтгэгч авч ажиллуулахаар болсон, илүүдэл ажилчдыг цомхотгосон, энэ хүн бас цомхотгогдсон хүний тоонд орсон, идэх хоолноосоо гэнэт салсан. Түүний сэтгэл санаа ямар байх вэ? Өөр орлого олох газар байхгүй. Яаж амьдралаа залгуулах уу? Өөр зүйл хийе гэсэн ч чадахгүй, гунигтайгаар гэртээ харьсан. Дөнгөж гэртээ орж иртэл гэрийнх нь настай хөгшин өвдчихсөн хүнд байдалтай байсан, тэр сандран хөгшнийг эмнэлэгт хүргэж өгөх гэж яарна, тэр арай гэж мөнгө зээлдэж түүнийг эмнэлэгт хэвтүүлсэн. Дараа нь настай

хөгшинд ойр зуурын юм бэлдэхээр гэртээ харьсан, дөнгөж гэртээ ирээд байж байтал сургуулийн багш хаалгыг нь тогшсон: “Танай хүү зодоон хийгээд нэг хүүхдийг гэмтээчихлээ, хурдан очиж юу болсныг нь хар.” Дөнгөж энэ хэргийг зохицуулж дуусаад гэртээ орж ирээд сууж байтал утас нь дуугарсан: “Танай эхнэр өөр хүнтэй болчхож” гэнэ. Мэдээж та бүгдэд ийм байдал тохиолдохгүй. Жирийн хүн ийм зовлонг дааж чадахгүй ингэж бодно: “Би юуны төлөө амьдраад байгаа юм бэ? Олс олоод өөрийгөө дүүжилчихвэл бүх зүйл дуусаж амар болох юм биш үү!” гэнэ. Хүн бол зовлон дундын зовлонг дааж чаддаг байх ёстой гэж би хэлнэ, мэдээж ийм хэлбэрээр байх албагүй. Тэгвэл хүмүүс хоорондын зөрчил, чиний шиньшинийг сорьсон зөрчилдөөн, мөн хувийн ашиг хонжооны төлөөх тэмцэл нь эдгээр асуудлаас бүр амаргүй. Олон хүн, хүний дор орохгүйн төлөө амьдардаг, тэгээд санаснаар нь бүтэхгүй бол өөрсдийгөө боож үхдэг. Тиймээс бид ийм хэцүү төвөгтэй орчинд бясалгаж, зовлон дундын зовлонг даван туулах ёстой, үүний зэрэгцээ аугаа их сэтгэлийн тэвчээртэй байх ёстой.

Аугаа их сэтгэлийн тэвчээр гэж юу вэ? Бясалгаж байгаа хүний хувьд юуны түрүүнд цохиулсан ч хариу цохихгүй, загнуулсан ч хариу хэрэлдэхгүй байж чаддаг байх хэрэгтэй, тэвчих ёстой. Тэгэхгүй бол, чамайг ямар бясалгагч хүн гэх юм? Зарим хүн ингэж ярьдаг: “Тэвчээртэй байх үнэхээр хэцүү байдаг, би түргэн ааштай.” Зан ааш муу бол түүнийгээ засах хэрэгтэй, бясалгагч хүн заавал тэвчээртэй байх ёстой. Зарим хүн хүүхдээ хүмүүжүүлэхдээ уурлана, хашхирна зандарна, сүйд болгодог, та нар хүүхдээ хүмүүжүүлэхдээ ийм байж болохгүй, бас өөрийгөө ч тэгтлээ бухимдуулах хэрэггүй, та нар хүүхдүүдээ учир зүйг нь ойлгуулж

зөв харьцвал хүүхдийн хүмүүжилд жинхэнэ сайн нөлөө үзүүлнэ. Ялихгүй зүйлийг ч тэвчиж чадахгүй амархан уурлаад байвал гон чинь яаж өсөх юм? Зарим хүн, “Хэрэв гудамжинд явж байхад хэн нэгэн намайг өшиглөхөд эргэн тойронд таньдаг хүн байхгүй бол би тэвчиж чадна” гэдэг. Би үүнийг хангалтгүй гэж хэлнэ, магадгүй чи ирээдүйд ичгэвтэр харагдахаас эмээдэг хүнийхээ өмнө хоёр хацартаа алгадуулж харагдвал нүүрээ хийх газаргүй болно, чамайг ийм асуудалд яаж хандахыг чинь харна, тэвчиж чадах үгүйг чинь харна. Чи тэвчиж өнгөрөөсөн ч дотроо тайван байж чадахгүй бол бас л хангалтгүй. Та бүгд мэднэ, Архад түвшинд хүрэхэд ямар ч зүйл тохиолдсон сэтгэлдээ хүлээн авдаггүй, тэр сэтгэлдээ ямар ч энгийн хүний асуудлыг хадгалдаггүй, үргэлж инээмсэглэн сэтгэл өөдрөг байдаг. Тэр хэчнээн их хохирол амссан ч сэтгэл нь өөдрөг хэвээр байдаг, тоодоггүй. Үнэхээр чи тийм байж чадвал аль хэдийн Архадын анхан шатны бүтээлийн оронд хүрсэн гэсэн үг юм.

Зарим хүн ингэж ярьдаг, “Ийм хэмжээнд хүртэл тэвчвэл энгийн хүмүүс биднийг хулчгар гэнэ, амархан дээрэлхүүлнэ.” Би үүнийг хулчгар гэж хэлэхгүй. Та бүгд боддоо, энгийн хүмүүсийн дунд зарим ахмад настай, өндөр боловсролтой хүмүүс хүртэл биеэ барихыг чухалчилдаг, бусадтай хэрэлдэхийг цээрлэдэг. Тэгвэл манай бясалгагчдын хувьд бүр ч илүү байх ёстой биш гэж үү? Үүнийг яаж хулчгар гэж үзэж болох юм? Энэ бол агуу тэвчээрийн илрэл, мөн хүчирхэг сэтгэлийн тэнхээний илрэл гэж би хэлнэ, зөвхөн бясалгадаг хүн л ийм аугаа тэвчээртэй байж чадна. Ийм нэг үг байдаг: Жирийн хүн доромжлуулбал сэлмээ сугалаад үзэлцэнэ. Энгийн хүн мэдээж, чи намайг загнавал би чамтай хэрэлдэнэ, чи намайг цохивол би чамайг бас

эргүүлээд цохино гэдэг. Тэр бол зүгээр л нэг энгийн хүн, түүнийг бясалгагч гэж хэлж болох уу? Бясалгагч хүний хувьд, хэрэв чамд сэтгэлийн тэнхээ дутвал, чи өөрийгөө барьж чадахгүй байвал тийм тэвчээрт хүрч чадахгүй.

Дээр үед Хан Шин гэдэг хүн байсныг бид бүгд мэднэ, тэр Лиу Бан жанжны тэргүүн генерал, улсын ноён нуруу, их чадвартай нэгэн байсан. Тэр яаж ийм том хариуцлагатай албанд хүрч чадсан бэ? Хан Шин-ыг бүр хүүхэд байхаасаа л жирийн хүн байгаагүй гэж ярьдаг. Хан Шин нэг хүний салтаа доогуур мөлхөж гарч доромжлуулсан тухай түүх байдаг. Хан Шин бага наснаасаа ушу-гаар хичээллэдэг байсан, ушу-гаар хичээллэдэг хүн үргэлж сэлэм зүүж явна. Нэг өдөр түүнийг гудамжаар явж байтал тэндхийн нэг танхай эр хоёр гараа ташаандаа тулан замыг нь хааж зогсоод хэлсэн: “Чи ямар хэрэгтэй гэж сэлэм зүүж явдаг юм? Чи хүн алж зүрхлэх үү? Чи хүн алж зүрхэлбэл миний толгойг цавччих” гээд хүзүүгээ сунгаж өгсөн. Хан Шин бодсон: “Надад чиний толгойг авах ямар хэрэг байгаа юм?” Тэр үед хүн албал шүүхээр орж амнараа төлдөг байсан. Хэн нэгнийг хамаагүй алж болох юм уу? Тэр эр Хан Шин түүнийг алж зүрхлэхгүйг нь хараад “Чи намайг алж зүрхлэхгүй бол миний салтаа доогуур мөлхөж гар” гэсэн. Хан Шин үнэхээр түүний салтаа доогуур мөлхөж гарсан. Энэ нь Хан Шин аугаа их сэтгэлийн тэвчээртэй хүн байсныг харуулж байна. Тэр энгийн хүнтэй адилгүй байсан учраас түүхэн том үйл хэргийг хийж чадсан. Хүний дор орохгүй амьдрах гэдэг нь энгийн хүний зан юм. Та бүгд боддоо, хүний дор орохгүйн төлөө амьдрах нь ядаргаатай биш гэж үү? Зовлонтой биш гэж үү? Үнэ цэнтэй гэж үү? Хан Шин ямар ч байлаа гэсэн энгийн л хүн байсан. Бясалгагч

хүний хувьд бид түүнээс хавьгүй дээр байх ёстой бус уу. Бидний зорилго бол энгийн хүний түвшнээс гарах, бүр дээд түвшинд хүрэх явдал юм. Бидэнд ийм тохиолдол гарахгүй. Гэхдээ бясалгагч хүний энгийн хүмүүсийн дунд доромжлуулж, ичгүүртэй байдал орох нь магадгүй энэ тохиолдлоос ч дор байж болно. Хүн хүний хоорондын шиньшин-ий мөргөлдөөн нь үүнээс дутахгүй, бүр ч дор байж магад, энэ нь бас нэлээд хэцүү гэж би хэлнэ.

Түүнчлэн бясалгаж байгаа хүн юугаа ч зориулж чаддаг, энгийн хүний янз бүрийн зууралдсан сэтгэл, хүслээ орхиж чаддаг байх ёстой. Тэр дороо үүнд хүрч чадахгүй, бид аажмаар хийнэ. Чи өнөөдөр бүгдийг нэг дор хийж чадвал, чи өнөөдөр Будда болчихно гэсэн үг. Бясалгахад цаг хугацаа орно, гэхдээ чи өөрийгөө сул тавьж болохгүй. Чи ингэж хэлнэ: Багш бясалгахад цаг хугацаа орно гэж хэлсэн, тэгэхээр аажмаар хийе. Тэгж болохгүй! Чи өөртөө хатуу шаардлагатай байх ёстой, Буддын Фа-гийн бясалгаад эрч хүчтэйгээр, шаргуу урагшлах хэрэгтэй.

Мөн Дэ-гээ сахиж, шиньшин-ээ барих ёстой, хөнгөн хуумгай байж болохгүй. Чи хүссэн болгоноо хамаагүй хийж болохгүй, мөн өөрийнхөө шиньшин-ийг барьж чаддаг байх ёстой. Энгийн хүмүүсийн дунд ийм үг их сонсогддог: “Сайн үйл хийвэл буян хураана”. Бясалгаж байгаа хүн буян хураахыг чухалчилдаггүй, харин бид Дэ (буян)-гээ хадгалахыг эрхэмлэдэг. Яагаад бид Дэ (буян)-гээ хадгалахыг эрхэмлэдэг вэ? Учир нь бид ийм нэг байдлыг харсан: Буян хураахыг энгийн хүмүүсийн дунд ярьдаг, тэд сайн үйл хийж буян хураавал хойд насандаа сайхан амьдарна гэдэг. Харин бидэнд тийм асуудал байхгүй, чи төгс бясалгаад Бумбад хүрвэл хойд

насны асуудал гэж байхгүй болно. Бид энд буянаа хадгалах гэж ярьж байгаа нь өөр далд утгатай юм, өөрөөр хэлбэл бидний бие дээр байдаг хар, цагаан хоёр бие бодь бол амьдралын нэг насанд хуримтлагддаггүй, харин урт удаан хугацааны туршид хуримтлагдаж ирдэг. Чи дугуй унаад хотыг бүтэн тойрсон ч магадгүй хийх буянтай үйл олдохгүй. Өдөр болгон ингэж явсан ч чамд тийм боломж тааралдахгүй байж магад.

Бас өөр нэг утга учир бий, Дэ (буян) хураахын тулд чи ямар нэгэн зүйлийг сайн үйл гэж бодно, гэхдээ чи хийвэл магадгүй тэр нь муу үйл хийсэн болно; чи ямар нэгэн зүйлийг муу үйл гэж бодон үүнд оролцвол тэр нь магадгүй сайн үйл болж болно. Яагаад вэ? Учир нь чи түүний үйлийн үрийн барилдлагыг харж чадахгүй. Хуулиар энгийн хүний хэрэг явдлыг зохицуулдаг, энэ бол асуудалгүй. Бясалгагч хүн байх нь ер бусын, чи ер бусын хүний хувьд чамайг ер бусын зарчмаар шаардах ёстой, харин энгийн хүний зарчмаар цэгнэж болохгүй. Чи аливаа зүйлийн үйлийн үрийн барилдлагыг мэдэхгүй бол буруу зүйл хийхэд амархан байдаг. Тиймээс бид үйлгүй (вүвэй) байхад сургадаг, чи хүссэн зоргоороо ямар нэгэн зүйлийг хамаагүй хийж болохгүй. Зарим хүн ингэж ярьдаг: Би болдоггүй хүмүүсийг хүмүүжүүлэхийг хүсдэг. Тэгвэл би чамд цагдаа болбол дээр гэж хэлье. Гэхдээ бид чамайг хүн амины хэрэг, гал түймэр тавьж байхтай тааралдвал ийм зүйлээс хол бай гэж байгаа юм биш. Миний хэлж байгаа бол хүн хүний хоорондын зөрчил гарахад, нэг нь нөгөөгөө өшиглөх юм уу цохиход энэ нь магадгүй тэд урьд нь хоорондоо өгөө аваатай байсных, тэгээд тооцоогоо цайруулж байгаа хэрэг юм. Чи дундуур нь оролцвол тэдний хоорондын тооцоо дуусахгүй, тэд дараа дахин үргэлжлүүлэх хэрэгтэй болно. Энэ нь чи

үйлийн үрийн барилдлагыг харахгүй бол амархан муу зүйл хийж улмаар Дэ-гээ алдана гэсэн үг.

Энгийн хүн, энгийн хүн хоорондын асуудалд хөндлөнгөөс оролцвол өөр хэрэг, тэр зөвхөн энгийн хүний зарчмаар юмыг цэгнэнэ. Чи бол ер бусын зарчмаар юманд хандах ёстой. Гэхдээ чи хүн алах, эсвэл гал түймэр тавих гэж байхыг харчхаад тоохгүй байвал энэ нь шиньшин-ий асуудал болно, тэгвэл чи өөрийгөө сайн хүн гэж юугаар харуулах юм? Чи хүн алах, эсвэл гал түймэр тавих гэж байхыг харчхаад болнулахад оролцохгүй бол өөр юунд оролцох юм? Гэхдээ нэг зүйл бий, эдгээр зүйлүүд нь манай бясалгагчдад ямар ч хамаа байхгүй. Чамд ийм явдал тохиолдохыг магадгүй гаргуулахгүй, чамд ийм зүйл тааралдахаар магадгүй зохицуулахгүй. Бид Дэ-гээ сахих гэж ярьдаг, энэ нь чамайг муу зүйл хийхээс зайлуулж байгаа юм, магадгүй зарим нэг багахан зүйлд оролцоход чи муу зүйл хийсэн болчихно, тэгвэл чи Дэ-гээ алдана. Чи Дэ-гээ алдаад байвал, яаж түвшнээ дээшлүүлэх юм? Чи өөрийнхөө эцсийн зорилгод яаж хүрч чадах юм? Үүнд ийм асуудал байдаг. Үүнээс гадна, ухамсарлах чадвар сайн байх ёстой, төрөлхийн суурь сайтай хүний магадгүй ухамсар нь ч сайн, орчин ч бас нөлөө үзүүлдэг.

Бид бас ингэж ярьдаг, бидний хүн бүр өөрийн лотогш бясалгаж, хүн бүр өөрийнхөө шиньшин-д анхаарч, ямар нэгэн зүйлд алдаа гаргасан бол шалтгааныг өөрөөсөө хайж олоод дараагийн удаа сайн хийвэл, мөн аливаа зүйл хийхдээ бусдыг эхлээд боддог байвал хүний нийгэм сайнаар өөрчлөгдөж ёс суртахуун дахин дээшилнэ, мөн соён гэгээрэл сэргэнэ, тэгэхээр бас нийгтийн аюулгүй байдал дагаад сайжирна.



Магадгүй цагдаа ч байх шаардлагагүй болно. Хэн ч захиргаадуулах хэрэггүй болно, хүн бүр өөрийгөө анхаарна, хүн бүр өөрийнхөө дотрыг шинжинэ. Чи хэл дээ ийм байвал ямар сайхан байх вэ. Та бүгд одоогийн хууль дүрэм улам нарийн боловсронгуй болж байгааг мэднэ, гэтэл зарим хүн яагаад муу зүйл хийсээр байна вэ? Яагаад хуулийг дагахгүй байна? Үүний учир нь бол түүний сэтгэлийг захирч чадахгүй, хүн хараагүй үед тэр бас л далдуур муу зүйл хийнэ. Хэрэв хүн болгон сэтгэлээ бясалгавал, энэ байдал эрс өөрчлөгдөнө. Чамд шударга ёсны төлөө зүтгэх хэрэг байхгүй болно.

Фа-г зөвхөн энэ түвшин хүртэл л зааж болно, үүнээс дээш хэр өндөрт хүрэх нь чиний өөрийн бясалгалаас шалтгаална. Зарим хүний тавьсан асуулт улам бүр тодорхой зүйлийн талаар байна, би чиний өдөр тутмын амьдралын бүх асуудлыг тайлбарлаж өгөөд байвал чи юуг бясалгах юм?! Чи өөрөө бясалгах ёстой, өөрөө ухамсарлах ёстой, би чамд бүх зүйлийг хэлж өгөөд байвал чамд бясалгах зүйл үлдэхгүй болно. Завшаантай нь, Дафа аль хэдийн нийтийн дунд дэлгэрлээ, чи Дафа-гийн дагуу хийж болохоор боллоо.

Миний Фа заах хугацаа үндсэндээ дуусах гэж байна, иймээс жинхэнэ зүйлээ та бүгдэд үлдээхийг хүсэж байна, үүнээс хойш бясалгахдаа та бүгд удирдуулах Фа-тай боллоо. Фа заах бүхий л явцад би та бүхэнд болон нийгэмд хариуцлагатай хандаж ирсэн, бодит байдал дээр бид энэ зарчмыг баримталсан. Үр дүнгийн хувьд би ярихгүй, үүнийг бол нийтийн санал мэднэ. Миний зорилт бол Дафа-г олон түмний хүртээл болгож олон хүн үүнээс ашиг тусыг хүртэх, жинхэнэ бясалгахыг хүссэн хүнд Фа дагуу бясалгаж дээшлэх боломж олгох явдал юм. Түүнчлэн бид Фа заах явцад хүн өөрийгөө

яаж авч явбал зохих ёсыг ярьсан, мөн энэ лекцийн дараа хэрэв чи Дафа дагуу бясалгаж чадахгүй байлаа ч чи наад зах нь сайн хүн байж чадна гэж найдаж байна, тэгвэл манай нийгэмд тустай. Үнэндээ чи яаж сайн хүн байхыг аль хэдийн ойлгосон, энэ лекцүүдийн дараа чи сайн хүн байх болно.

Фа-г заах явцад зарим ярвигтай зүйлс бас тохиолдсон, мөн тал талын үймүүлэл их хүчтэй байлаа. Зохион байгуулж байгаа газар болон янз бүрийн салбарын албаны хүмүүсийн тус дэмжлэг, ажлын хэсгийн шаргуу зүтгэлийн үр дүнд бидний лекцүүд нэлээд амжилттай явагдаж ирлээ.

Миний лекцүүдээр яригдсан эдгээр зүйлс бол та бүгдийг удирдаж дээд түвшин рүү бясалгуулах зүйлс юм, урьд өмнө эдгээр зүйлсийг заах хүн байгаагүй. Бидний заасан зүйлс бол маш тодорхой бөгөөд орчин үеийн шинжлэх ухаан болон өнөөгийн хүний бие судлалын шинжлэх ухаантай уялдуулж ярьсан, түүнчлэн заасан зүйлүүд маш өндөр түвшинд юм. Миний үндсэн санаа бол ирээдүйд хүнийг Фа-г жинхэнэ олж авах боломж олгож дээш бясалгуулах явдал юм. Фа болон гон заах явцад олон хүн энэ Фа-г сайн гэдгийг ойлгосон, гэхдээ дагаж хийхэд их хэцүү гэдэг. Үнэндээ энэ нь хэцүү байх үгүй нь хувь хүнээс хамаардаг гэж би хэлнэ, бясалгахыг хүсдэггүй энгийн хүнд бол бясалгал хэтэрхий хэцүү, санаанд багтамгүй эсвэл бясалгаад үр дүнд хүрэх боломжгүй санагдана. Тэр бол энгийн хүн, тэр бясалгахыг хүсэхгүй, тэр үүнийг маш хэцүү гэж үзнэ. Лаози ингэж хэлсэн: “Дээд хүн Дао-г сонсвол чармайн суралцана; дундаж ухамсартай хүн сонсвол яасан ч яах вэ гэнэ; ухамсар муутай хүн сонсвол шоолон инээд алдана; шоолон инээхгүй бол үүнийг

Дао гэж үзэхгүй.” Жинхэнэ бясалгадаг хүнд энэ нь тун амархан, хүрэхийн аргагүй хол зүйл биш гэж би хэлнэ. Үнэндээ энд сууж байгаа олон хуучин сурагчид болон энд ирээгүй хуучин сурагчид бясалгалаараа аль хэдийн их өндөр түвшинд хүрсэн. Би энэ талаар хэлээгүйн учир нь, чамд зууралдсан сэтгэл гаргуулахгүйн тулд, сэтгэлийг чинь ханаж омогших байдалд оруулахгүйн тулд юм, тэгвэл чиний гон хүчний өсөлтөд саад учрах болно. Жинхэнэ тууштай бясалгахаар зорьсон хүн юуг ч тэвчиж чаддаг, мөн янз бүрийн хувийн ашиг сонирхол, зууралдсан сэтгэлийг орхиж чадна, түүнийг хөнгөн авч үзэж чадна. Ийм байж чадвал хэцүү биш. Хэцүү гэж хэлдэг хүн бол эдгээр зүйлийг орхиж чаддаггүй хүн. Бясалгал бол угтаа хэцүү биш, өөрийнхөө түвшнийг дээшлүүлэх бас хэцүү биш. Зөвхөн хүний сэтгэлийг орхиж чадахгүйгээс тэр хэцүү гэж хэлдэг. Яагаад гэвэл бодит ашиг орлого өмнө нь байхад түүнээс татгалзахад их хэцүү байдаг. Энэ ашиг орлого яг энд байхад чи тэр сэтгэлээ яаж орхих юм? Үнэндээ ийм учраас энэ нь хэцүү санагддаг. Хүн хүний хооронд зөрчил гарахад чи уураа барьж чадахгүй, тэр ч байтугай асуудлыг шийдэхдээ өөрийгөө бясалгагч хүн гэж үзэж чадахгүй бол үүнийг хүлээн зөвшөөрөхгүй гэж би хэлнэ. Намайг урьд нь бясалгалаар хичээллэж байхад агуу суут олон Багш нар надад ийм үг хэлдэг байсан: “Тэвчихэд хэцүү байсан ч тэвчвэл чадна. Хийхэд хэцүү байсан ч хийвэл чадна.” Үнэндээ ийм л байдаг. Та нар хариад туршаад үз. Жинхэнэ гай зовлон саад бэрхшээлийн дунд байхдаа туршаад үз, тэвчихэд хэцүү байсан ч тэвчээд үз; харахад бүтэшгүй, хийхэд хэцүү байсан ч болох эсэхийг нь үзээд алд. Хэрэв чи үнэхээр ингэж хийж чадвал “Бургас модод ногоорсон,

өнгийн цэцгүүд алагласан өөр нэгэн тосгон өмнө чинь нээгдэхийг үзнэ!”

Би ийм их ярьсан болохоор та бүхэнд энэ бүгдийг тогтооход тун амаргүй. Би үндсэн хэдхэн шаардлага тавья: Та бүхэн цаашдын бясалгалдаа өөртөө бясалгагч хүний байр сууринаас хандаж жинхэнэ бясалгахыг хүсье. Би шинэ хуучин сурагчдадаа бүгдэд нь Дафагаар бясалгаад төгс гэгээрэлд хүрэхийг хүсье! Хариад хүн болгон цагаа шамдуулан жинхэнэ бясалгахыг хүсье.

“Жуань Фалунь” номын хэллэг өнгөн дээрээ тийм гоёмсог биш, тэр ч байтугай орчин үеийн хэл зүйд таарахгүй байж мэднэ. Гэхдээ, хэрвээ би орчин үеийн хэл зүйн байдлаар энэ Дафа номыг эмхэтгэвэл маш ноцтой асуудал гарна, номын хэл зүйн бүтэц болон дүрмийн хувьд хэвшмэл сайн болсон ч бүр гүн ухагдахууны зүйлийг багтааж чадахгүйд хүрнэ. Яагаад гэвэл орчин үеийн үгийн сан үндсэндээ Дафагийн бүр дээд янз бүрийн түвшин дэх удирдах нөлөө, түвшин болгонд илрэх Фа-г илтгэж чадахгүй, түүнчлэн сурагчийн бие (бэньти) болон гон-ы хувиралт, дээшлэх үндсэн өөрчлөлтүүдийг дагуулж чадахгүйд хүрнэ.

Ли Хонжи

1996 оны 1 сарын 5

# Тайлбар

<b>Архад:</b>	Буддын системд бясалгаад Гурамсан ертөнцөөс гарсан гэгээрлийн хугагт хүрсэн гэгээрэгч
<b>А-Кю:</b>	Лу Шунь-ий романд гардаг тэнэг (өөрийгөө тайвшруулж сэтгэл зүйгээ ялдаг) хүний дүр
<b>Байхуй:</b>	Толгойн оройд байрлах биологийн идэвхтэй цэг
<b>Бигү:</b>	Хоол, усгүйгээр байх гэсэн эртний үг
<b>Бүтээлийн орон:</b>	Буддын бясалгалын түвшин: Архад, Бодьсадва, Рулай гэх мэт
<b>Бэньти:</b>	Өөрийн махан бие махбодь болон бусад орон зайнууд дахь биес
<b>Гон:</b>	Бясалгалаар гардаг энерги
<b>Гуанинь:</b>	Авалокишвары, Жанрайсэг бурхан
<b>Гуаньдин:</b>	Энергийг адислах, таршийн пашинд эрх өргөмжлөх гэдэг
<b>Гурван билиг, Гурван арга:</b>	Гар хөлийн голч сувгууд
<b>Дарма:</b>	Шагжамүни Буддын ярьсан Ном
<b>Дафа:</b>	Аугаа Фа, Аугаа Хууль
<b>Даньжин, Даозань, Шиньмин Гүйжи:</b>	Хятадын эртний Бумбын судрууд
<b>Дэ:</b>	Буян, нэг төрлийн цагаан бие бодь
<b>Жан Гуолао: Жигон:</b>	Бумбын найман гэгээрэгчийн нэг Өмнөд Сон гүрний үед нэрд гарсан хувраг
<b>Жоуи:</b>	Хятадын эртний Жоу хаант гүрний төлөг үзэх ном (м.э.ө 1100-221 он)

<b>Жэнь, Шань, Рэнь:</b>	Үнэн, Нинжин, Тэвчээр Жэнь (үнэн байх, чин үнэн сэтгэл, үнэн зөв, жинхэнэ, зөв шударга), Шань (эслдэг байх, нинжин, энэрэнгүй, цагаан сэтгэл, уудам сэтгэл), Рэнь (өөрийгөө сахилга батжуулах, өөрийгөө барих, хязгаарлах, хүлцэнгүй байдал, тэвчээр, тэсвэр хатуужил, няцашгүй зориг, уучилж чаддаг байх, зовлон бэрхшээлийг дааж чаддаг байх)
<b>Лаози:</b>	Дао-г үндэслэгч, М.Э.Ө 5-4 зуунд Хятадад амьдарч номоо айлдаж байсан
<b>Лаогон:</b>	Гарын алганы голд байрлах биологийн идэвхтэй цэг
<b>Ли:</b>	Хятадын зайн нэгж (=0.5 км) “108 мянган ли” гэдэг нь Хятадаар их хол зайг илэрхийлдэг хэллэг
<b>Лунь Юй:</b>	Оршил
<b>Лиу Бан:</b>	Хан гүрнийг үүсгэн байгуулагч хаан
<b>Лэй Фэн:</b>	Жараад оны үеийн Хятадын ёс суртахууны үлгэрлэгч хүн
<b>Люй Донбин:</b>	Бумбын найман гэгээрэгчийн нэг
<b>Лянхуасэ:</b>	Будда Шагжамүни-гийн эмэгтэй арван шавийн нэг
<b>Маажон:</b>	Хятадын уламжлалт 4 хүний хөлгөн тоглоом
<b>Минмэнь:</b>	Ууц нуруунд байрлах биологийн идэвхтэй цэг
<b>Мин гүрэн:</b>	Хятадын 1368-1644 оны үе

<b>Ниван ордон:</b>	Буурцагт булчирхай
<b>Рулай (Татагата):</b>	Буддын системд гэгээрлийн хутаг олсон, Бодьсадва болон Архдаас дээш түвшинд хүрсэн гэгээрэгч
<b>Самади:</b>	Буддын шашинд гүн ховсдолтын байдалд орж бясалгах
<b>Сунь Укун:</b>	“Барууны оронд аялсан түүх” романы сармагчны хааны дүр
<b>Тайжи:</b>	Бумбын билэг тэмдэг, арга билагийн тэмдэг
<b>Тан гүрэн:</b>	Хятадын түүхэн дэх их хөгжингүй үе (618-907 оны үе)
<b>Таньжон:</b>	Цээжний голд орших биологийн идэвхтэй цэг
<b>Тианьзи:</b>	Бумбын систем дэх зогсоо дасгал
<b>Үрлийн ном, Бумбын жаяг:</b>	Эртний Хятадын бясалгах аргын сударууд
<b>Фа:</b>	Буддын системийн хууль ба зарчмууд, Буддын ном
<b>Фашэнь:</b>	Гон ба Фа-гаар бүтээгдсэн бодгаль, Номын бие
<b>Хуа Туо, Ли Шижэнь, Биань Чуэ:</b>	Хятадын түүхэнд байсан нэртэй эмч нар
<b>Хуйень:</b>	Хязанд байдаг биологийн идэвхтэй цэг
<b>Хэгү:</b>	Гарын алганы ард эрхий хуруу долоовор хурууны дунд орших цэг



<b>Хэгу, Луошу:</b>	Байгаль, хүн ба ертөнцийн хувьслын талаарх Хятадын өнө эртний үеийн уламжлалт нууц дүрс зураг
<b>Цао Цао:</b>	Гурван гүрний үеийн Вэй хаант төрийг үндэслэгч, захирагч (МЭ220-МЭ265)
<b>Чимэнь:</b>	Уламжлалт бус бясалгал
<b>Чин Хуй:</b>	Өмнөд Сон гүрний үед байсан хааны ордны хэрцгий түшмэл
<b>Шагжамүни:</b>	Түүхэн дэх Будда, Сиддарта Гаутама гэж бас нэрлэгддэг
<b>Шангэн:</b>	Хоёр нүдний дунд байрлах цэг
<b>Шиньшин:</b>	Зан чанар, ёс суртахууны мөн чанар, зүрх сэтгэлийн мөн чанар
<b>Шичэн:</b>	Хятадын цаг хугацааны нэгж, 2 цагтай тэнцэнэ
<b>Эмэй уул:</b>	Сичуань мужийн нэртэй уул, Линень хийдийн худгаас мянга орчим бээрийн зайтай оршдог
<b>Энергийн суваг:</b>	Хятад эмчилгээнд үүнийг энергийн сүлжээг бүрдүүлдэг чий дамжуулах суваг гэдэг
<b>Юань-шэнь:</b>	Сүнс. Сүнс дотроо хоёр хуваагддаг: Эзэн сүнс (Жу Юань-шэнь) мөн Дэд сүнс (Фу Юань-шэнь). Хятадын уламжлалт онолоор хүний биеийн янз бүрийн үйл ажиллагааг хариуцсан олон сүнс биед оршдог гэж үздэг
<b>Юүжэн:</b>	Дагзанд байдаг биологийн идэвхтэй цэг